

**Монгол Улсын Үндэсний  
Ажил, Мэргэжлийн  
Ангилал ба Тодорхойлолт**

# **ҮАМАТ-08**

**(ISCO - 08)**

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам

Улаанбаатар. 2010 он

DDC: 331.79

Б - 332

НХХЯ

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт: ҮАМАТ-08

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, 2010 он

/ҮАМАТ/, /Ажил, мэргэжлийн ангилал/ /Индекс, код/, /Ажил, мэргэжлийн тодорхойлолт/

Боловсруулж хянасан: ШИЙЛЭГИЙН БАТБАЯР  
ДУГАРСҮРЭНГИЙН ГАНХҮҮ



Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын санхүүжилтээр хэвлэв.

© Энэхүү номыг Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын зөвшөөрөлгүйгээр худалдаалах зорилгоор хувиран олшруулахыг хориглоно.

ISBN: 978-99962-0-111-0

Улаанбаатар-210646, Чингэлтэй дүүрэг,

Нэгдсэн Үндэсний гудамж-5

Засгийн газрын 2 дугаар байр,

Утас: 261973, Факс: 328634

<http://www.mswl.gov.mn>

[mswl@mongol.net](mailto:mswl@mongol.net)

# ГАРЧИГ

---

Хуудас

I. Удиртгал. . . . .	5
II. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын “Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаал. . . . .	11
III. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг хэрэглэх арга зүй, тайлбар, зөвлөмж . . . . .	13
IV. Үндсэн, дэд, бага, нэгж бүлгийн нэр . . . . .	19
V. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт “YAMAT-08”-ын ажил, мэргэжлийн тодорхойлолт (Хавсралт-1)	
Үндсэн бүлэг 1: Менежер . . . . .	37
Үндсэн бүлэг 2: Мэргэжилтэн . . . . .	79
Үндсэн бүлэг 3: Техникч болон туслах/дэд мэргэжилтэн . . . . .	193
Үндсэн бүлэг 4: Контор, үйлчилгээний ажилтан. . . . .	282
Үндсэн бүлэг 5: Худалдаа, үйлчилгээний ажилтан. . . . .	306
Үндсэн бүлэг 6: Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан . . . . .	348
Үндсэн бүлэг 7: Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан. . . . .	374
Үндсэн бүлэг 8: Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч . . . . .	450
Үндсэн бүлэг 9: Энгийн ажил, мэргэжил . . . . .	495
Үндсэн бүлэг 0: Зэвсэгт хүчний ажил, мэргэжил. . . . .	528
VI. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт “YAMAT-08”-ын ажил, мэргэжлийн индекс/код (Хавсралт-2) . . . . .	534



# I. УДИРТГАЛ

---

Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал (ISCO-88), түүний дагуу манай улсын Үндэсний Ажил, мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт (YAMAT-88) гарснаас хойш 10 гаруй жил өнгөрлөө.

Энэ хугацаанд эдгээр баримт бичгийн суурь зарчим, ач холбогдол, үндсэн бүтцийг ноцтой хөндсөн технологийн хувьсал гараагүй хэдий боловч, хөдөлмөрийн ертөнцөд улс орон бүрийн ажил, мэргэжлийн агуулга, нэр төрөлд бас ч нилээд өөрчлөлт гарсан нь тэдгээрийг харьцуулж судлах, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын чиглэлээр улс хооронд хамтран ажиллах, ажиллах хүч харилцан илгээх зэрэг, тэрчлэн адил агуулгатай ажил, мэргэжлээр мэдээлэл солилцоход бэрхшээл учруулах болсон учир Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал-88 (ISCO-88)-ыг шинэчлэн гаргах нь зүйтэй гэж үзээд ОУХБ гурван талт шинжээчийн бүлэг байгуулан ажил, мэргэжлийн шинэ ангилал боловсруулсныг хөдөлмөрийн статистикийн олон улсын 2007 оны бага хурлаар сайшааж, улмаар ОУХБ-ын Захиргааны зөвлөлөөр дэмжсэн байна.

Мөн энэ үеэр 10/10 жилийн давтамжтай явагддаг хүн амын тооллого дэлхий олон оронд болж байгаа тул НҮБ-ын Статистикийн комисс хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хуваарьт (ISCO-88)-ийг шинэчлэх шаардлага тавьсныг энд дурдууштай.

Ийнхүү улс орон бүрийн үндэсний Ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтын үндсэн загвар, суурь зарчим болсон (ISCO-88) шинэчлэгдсэн болохоор мөн 10-аад жилийн өмнө түүний агуулга, зарчимд үндэслэн боловсруулсан Монгол Улсын ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-88) даган шинэчлэгдэх нь нэг талаас, даяаршлын зүй тогтлоор ажиллах хүчний эрэлт, шилжилт эрчимтэй болж, адил агуулгатай, ижил мэргэжлийг жишигдэх түвшинд бэлтгэх, баталгаажуулах, хүлээн зөвшөөрөгдөх хэрэгцээ, нөгөө талаас, манай улсад 2010 онд явагдах хүн амын тооллогын ажилд энэ ангилал чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж хэрэглэгдэх шаардлага тавигдаж байна.

Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал-08 (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчимд дүйцүүлэн боловсруулсан, манай улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (цаашид “YAMAT-08” гэж товчлох)-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт батлах тухай” 16 дугаар тушаалаар батлан мөрдүүллээ.

“YAMAT-08”-ын үндсэн зорилго нь дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг ханган биелүүлэхэд чиглэсэн гурван зорилтыг агуулж байгаа болно.

Нэгдэх нь, мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажиллах хүчийг олон улсын хэмжээнд зөвшөөрөгдөх, хөрвөх түвшинд бэлтгэх, баталгаажуулах үүднээс орчин үеийн технологийн хувьслын агуулга, процесст дүйсэн нэр, агуулгаар ажил, мэргэжлийг ангилал,

Хоёрдахь нь, хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, хамгааллын холбогдолтой мэдээлэл цуглуулах, боловсруулах, шийдвэр гаргах шатуудад мэдээллийн бодит чанарыг хангах, олон улсын хэмжээнд судалж, харьцуулах боломжийг дээшлүүлэх,

Гуравдахь нь, хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг үнэн бодитой, чанартай явуулах үндсэн нэг үзүүлэлт болохын хувьд үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт чухал үүрэгтэй юм.

Энэ баримт бичгийн үзэл баримтлалын тухайд, олон улсын болоод үндэсний ангилал, тодорхойлолтод “ажил ба мэргэжил” гэсэн 2 чухал ухагдахууныг үндэс болгосон.

“Ажил”- гэж энэхүү ангиллын статистик нэгж болох ажлын нэг байр буюу нэг хүний хийж гүйцэтгэх зорилт даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл. Нэгж буюу нэг хүн гэдэгт ажил олгогч, ажилтан, хувиараа хөдөлмөрлөгч аль аль нь орно. Ажил (ажлын байр) гэдэгт албан тушаалыг хамруулан ойлгоно.

“Мэргэшил” (skills) гэж тухайн төрлийн үйл ажиллагааны хүрээнд тодорхой даалгавар, хариуцлагыг биелүүлэх ажилтны чадвар.

Үндсэн зорилт, даалгавар, үүрэг хариуцлага нь дээд зэргээр адилсах шинж чанар, агуулгатай болсон ажлын багц нь ажил мэргэжил (occupation) юм. Энэхүү багцыг ажилтны “мэргэшил” буюу ур чадвар гэж томъёолж байна.

“YAMAT-08”-д а) мэргэшлийн түвшин (skill level)

б) мэргэшлийн төрөлжилт (skill specialation)

гэсэн 2 хэмжигдэхүүнийг үндэслэн ажил, мэргэжлийг ангилж, төрөлжүүлсэн.

**мэргэшлийн түвшин** - нь гүйцэтгэж буй зорилт даалгавар, үүрэг хариуцлагын нарийн төвөгтэй байдал ба их, багын хэмжээгээр тодорхойлогдоно.

**мэргэшлийн төрөлжилт** - нь машин механизм, тоног төхөөрөмж, материал хэрэгсэлтэй ажиллах буюу ажил, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэдлэгийн тодорхой хэмжээ юм.

Олон Улсын боловсролын стандарт ангилал (ОУБСА)-д дурдсанаар бол ажлын даалгавар, хариуцлагыг биелүүлэхэд зайлшгүй чухал мэргэшлийг албан ёсны боловсролоор төдийгүй, албан бус сургалт, туршлага дадлагаар олгох ёстой байдаг. Чухамхүү манай “YAMAT-08”-д аливаа ажилтны албан боловсрол, сургалтын түвшинд бус, харин тодорхой даалгавар, хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах мэргэшил-чадварт илүү түшиглэсэн гэхэд болно.

Гэхдээ дээр дурдсан ОУБСА-ын боловсролын 4 түвшин манай улсын ажил, мэргэжлийн тодорхойлолтын мэргэшлийн аль түвшинд хамрахыг жишиг утгаар тодорхойлж болох юм. Учир нь ЕБС-ийн боловсролын тогтоцоо 12 жилд шилжсэнээр үндсэндээ европын жишигт тохирох болж байна. Үүнд:

- “YAMAT-08”-ын анхдагч түвшний мэргэжил нь: ОУБСА-ын ойролцоогоор 5 жил үргэлжилдэг анхан шат буюу 5-6 жилийн боловсрол шаардана.
- “YAMAT-08”-ын хоёр дахь түвшний мэргэжил нь: ОУБСА-ын ерөнхий боловсролын 1 ба 2 дахь ангиллын буюу нэгдэх нь 11-12 насныхан ойролцоогоор 3 жил үргэлжлэх, хоёрдахь нь 14-15 насныхан, мөн 3 жил үргэлжлэх боловсрол шаардахаар байна. Энэ бүлэгт мэргэжлийн сургалт, дагалдан сургалт, туршлага эзэмшилт байж болно.
- “YAMAT-08”-ын гурав дахь түвшний мэргэжил нь: ОУБСА-ын 5 дугаар ангиллын буюу 17-18 наснаас эхэлж, дээд боловсролын эхний шатнаас доогуур дипломын боловсрол эзэмшигчийг хамаарна.
- “YAMAT-08”-ын дөрөв дэх түвшний мэргэжил нь: ОУБСА-ын 6,7 дугаар ангилал буюу 3-5 жил үргэлжлээд их, дээд сургуулийн диплом олгодог боловсролын хэмжээнд дүйцэж байх жишээтэй.

#### **“YAMAT-08”-ийн бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Олон Улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал (ISCO-08)-ын үзэл баримтлал, суурь зарчим, бүтцийг авч боловсруулсан манай улсын “YAMAT-08” нь 10 үндсэн бүлэгтэй, тэдгээр нь 43 дэд бүлэг, 153 бага бүлэг, 421 нэгж бүлгээс бүрдэх шаталсан бүтэцтэй сац суварга мэт юм.

“YAMAT-08”-ын үндсэн, дэд, бага, нэгж бүлгийг мэргэжлийн зохих түвшингээр харуулвал:

**“YAMAT-08”–ын үндсэн, дэд, бага, нэгж бүлгийн тоо, мэргэшлийн түвшин**

Үндсэн бүлэг		Дэд бүлэг	Бага бүлэг	Нэгж бүлэг	Мэргэшлийн түвшин
1. Менежер		4	11	31	-
2. Мэргэжилтэн		6	27	92	4
3. Техникч болон туслах /дэд мэргэжилтэн		5	20	84	3
4. Контор, үйлчилгээний ажилтан		4	30	29	2
5. Худалдаа, үйлчилгээний ажилтан		4	13	40	2
6. Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан		3	9	18	2
7. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан		5	14	52	2
8. Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч		3	14	54	2
9. Энгийн ажил, мэргэжил		6	12	20	1
0. Зэвсэгт хүчний ажил, мэргэжил		3	3	1	-
Дүн	YAMAT-2008	43	153	421	-
	YAMAT-1988	28	116	390	-
Мэргэжлийн тоо	YAMAT-2008	-	-	3978	-
	YAMAT-1988	-	-	4263	-

Хүснэгтээс харахад 1 ба 0 дугаар үндсэн бүлгээс бусад нь мэргэжлийн зэрэглэлийн зохих түвшинд багтаж байна. Энэ 2 бүлэгт мэргэжлийн зэрэглэлийн түвшинд хамааруулах нь бэрхшээлтэй юм.

Ажил мэргэжлийн үндсэн, дэд, бага, нэгж бүлэгт хамаарах нэгжийн тоо абсолют утгаар тус тус өссөн нь харагдаж байгаа ч ачааллын харьцаа буюу дээд бүлгийн нэг нэгжид доод бүлгийн хэд хэдэн нэгж хамаарч орсон байна. Харин “YAMAT-88”-д 4263 ажил, мэргэжил байсан бол “YAMAT-08”-д 3978 ажил, мэргэжил орж буурсан болно.

Мэдээлэл, холбооны технолги үйл ажиллагааны (35 дугаар дэд бүлэг) мэргэжилтэн, компьютерийн хэрэглээний программ зохиогч, сүлжээний мэргэжилтэн, системийн шинжээч, веб мультимеда зохиогч, төрөл мэргэжлийн менежер, хөдөө аж ахуй, энгийн ажил, мэргэжил, зэвсэгт хүчний зэрэглэлийн зэрэг ажил мэргэжил шинээр орж байна. Түүнчлэн ажлын нэг байр буюу нэг хүний хийж гүйцэтгэх зорилт, даалгаврын жишгийг нэлээд нарийвчлан тодорхойлсон нь өмнөхөөс онцлог юм. Эндээс үзэхэд нилээд өөрчлөлт гарсныг харуулж байна.

“YAMAT-08” нь мэргэжлийн боловсролын болон хүмүүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, ажлын байрны зорилт, хариуцлага, нөхцөл,



хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний судалгаа-шинжилгээ хийх, ажил, мэргэжлээр ангилсан мэдээллийг цуглуулах, боловсруулах, солилцох, өөрийн онцлогт тохирсон ангилал, тодорхойлолтыг нарийвчлан (олон улсын болон үндэсний индекс/кодыг өөрчлөхгүйгээр) тогтоож, мөрдөхөд ашиглах үндэслэл, гарын авлага болно.

Энэхүү ангилал, тодорхойлолтыг боловсруулахад ажил хэрэгчээр оролцож, өөрийн салбар, үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагын хүрээнд шинээр бий болсон болон нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай ажил, мэргэжлийн талаар тодорхой санал ирүүлсэн яам, агентлаг, бусад байгууллагад талархал дэвшүүлье.

Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилалд шилжих, үндэсний хэмжээний ангиллыг боловсруулан сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн ОУХБ-ын Хятад, Монголын асуудал хариуцсан товчооны Захирал, хатагтай Констанс Томасд гүн хүндэтгэл илэрхийлье.

## НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ





НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

2010 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Үндэсний ажил мэргэжил, албан  
тушаалын жагсаалт, ангилал,  
тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08 (YAMAT-08)-ыг 1, 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.
2. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү Монгол Улсын Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолтын дагуу өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдөхийг зөвлөсүгэй.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт батлах тухай" 1998 оны А/315 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.ГАНДИ

C:\My documents\said\_tushaal\_doc

08 116



### **III. ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ БА ТОДОРХОЙЛОЛТЫГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙ, ТАЙЛБАР, ЗӨВЛӨМЖ**

---

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал-08(ISCO-08)-тай нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт-08 (цаашид “YAMAT-08” гэж товчлох)-ын үндсэн зорилго нь: мэргэшсэн ажиллах хүчнийг олон улсын зөвшөөрөгдөх түвшинд бэлтгэх, улс орнуудын ижилсгэх нэр, агуулгаар ажил, мэргэжлийг ангилах, ажиллах хүчинтэй холбогдох статистикийг цуглуулах, боловсруулах, мэдээллийн үнэн байдлыг хангах, үндэсний болоод олон улсын хэмжээнд ажил, мэргэжлийг судалж, харьцуулах, хүн ам ба орон сууцны ээлжит тооллогыг чанартай явуулах боломжийг дээшлүүлэх гол хэрэгсэл болгон ашиглахад оршино.

2. Үндэсний хэмжээнд болон төрөлжсөн үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагын түвшин (Тухайлбал, хөдөлмөрийн зах зээл, цалин хөлсний судалгаа, шинжилгээ хийх, боловсролын болон хүмүүний нөөцийн хэрэгцээг судлах, тооцох, төлөвлөх, хүн амын хөдөлмөр эрхлэлт ба ажилгүй хүнийг ажил, мэргэжил бүрээр тоолох, бүртгэх, ажилд зуучлах, түүнчлэн ажлын байрны гүйцэтгэх үүргийг боловсруулах)-д энэхүү “YAMAT-08”-ыг хэрэглэнэ.

3. “YAMAT-08”-ын 1 ба 2, 3 дугаар үндсэн бүлэгт их, дээд сургуулийн болон түүний дараах шатны боловсролын, түүнтэй адилтгах түвшин шаардагдах ажил мэргэжлийг, 4-8 дугаар үндсэн бүлэгт мэргэжлийн дунд шатны боловсрол шаардах ажил, мэргэжлийг, 9 дүгээр үндсэн бүлэгт бага, бүрэн бус дунд боловсролтой буюу мэргэжлийн анхан шатны боловсрол үл шаардах энгийн ажлыг, 0 дугаар үндсэн бүлэгт зэвсэгт хүчний зэрэглэлийн ажил, мэргэжлийг тус тус ангилсан болно.

#### **Хоёр. Ажил, мэргэжлийн оноосон нэр, индекс/кодыг хайхад баримтлах зарчим**

1. “YAMAT-08”-аас хэрэгцээтэй ажил, мэргэжлийн нэр, индекс/кодыг олохын тулд бүлгийн дарааллаар хайна. Үүнд:

Юуны өмнө энэ ангиллын бүтэц, бүлгийн зохион байгуулалтын дарааллыг сайн мэдвэл ажил, мэргэжлийн тохирох индекс/кодыг олоход дөхөм болно.

## “ҮАМАТ-08”-ын бүрэлдэхүүн, бүтцийн тухайд

Бүлгийг үндсэн, дэд, бага, нэгж гэж ангилав. Нэгж бүлгийн эхний 4 оронтой тоо нь тухайн ажил, мэргэжлийн олон улсын “индекс/код”-ыг харуулах ба түүний дараагийн 4 орон (зөвхөн “2310 Дээд боловсрол олгох багш” гэсэн нэгж бүлэгт “2310-100 багш, хүн судлалын” гэсэн мэргэжлээс эхлээд, “2310-128 Академич” хүртэл 4 оронтой индекс/кодтой, бусад нэгж бүлгийнх нь үндэсний код 3 оронтой байгаа)-той тоо нь Монгол Улсын үндэсний ажил, мэргэжлийн “индекс/код” болно. Олон улсын код нь тухайн ерөнхий мэргэжлээр нэг байгаа бөгөөд харин үндэсний индекс/код нь мэргэжил тус бүрээр ялгагдах онцлогтой. Ингэснээр ажил, мэргэжлийн эрэлт, нийлүүлэлтийг удирдахад хялбар болно.

Үүнийг “үндсэн бүлэг-2”-ын жишээгээр харуулъя.

**Үндсэн бүлэг - 2** “Мэргэжилтэн”  
**Дэд бүлэг - 23** “Багшлах мэргэжилтэн”  
**Бага бүлэг - 231** “Их, дээд сургуулийн дээд боловсрол олгох багш”  
**Нэгж бүлэг - 2310** “Багш, дээд боловсрол олгох”  
2310 - 100 Багш, хүн судлалын  
2310 - 101 Багш, япон хэлний  
2310 - 102 Багш, хүнсний технологийн гэх мэт  
**2310 - 128 Академич**

Ийнхүү нэгж бүлгийн мэргэжил нь төрөл мэргэжил тус бүрээр үндэсний индекс/кодоор задарч кодлогдсон болно.

2310 - 128 Академич, үүний:  
2310 - Олон улсын индекс/код  
128 - Монгол улсын үндэсний индекс/код

## “Түлхүүр үг”-ийг хайх тухайд

**Ажил мэргэжлийн үндсэн нэр /түлхүүр үг/-ийг тогтоох,**

2. “Түлхүүр үг” гэдэг нь хэрэгцээтэй буюу хайж байгаа ажил, мэргэжлийн үндсэн нэр гэж ойлгоно. Тухайлбал, “цахилгааны инженер” гэсэн мэргэжлийн түлхүүр үг нь “инженер”, түүнийг “мэргэжилтэн” буюу 2 дугаар үндсэн бүлгийн 21 дүгээр дэд бүлэг болох “шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн”-д хамаарна.

**Үндсэн нэр /түлхүүр үг/-д шууд хамаатай эхний тодорхойлогч үгийг олох,**

Энд авсан жишээнд түлхүүр үг “инженер”, үүний эхний тодорхойлогч үг нь “цахилгааны” гэсэн үг юм.

## **Үндсэн нэр, тодорхойлогч үг нь ямар үйлдвэрлэл, үйлчилгээнд хамаарч байгааг тогтоох,**

Цахилгаан, цахим технологийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хамаарч байна. Дээрх дэс дарааллыг баримтлан ажил, мэргэжлийг тодорхойлсны дараа “ҮАМАТ-08”-ын ажил, мэргэжлийн индекс/код” гэсэн 2 дугаар хавсралтаас холбогдох бүлэг, нэр, индекс/кодыг тогтооно.

Одоо аль нэг мэргэжлийн жишээн дээр авч үзье.

“Өргөх, татах төхөөрөмжийн жолооч” гэсэн мэргэжлийн индекс/кодыг олохын тулд холбогдох бүлгийг сонгоно.

Иймээс дээрх мэргэжлийг:

**Үндсэн бүлэг - 8** “Машин механизм, төхөөргийн операторч/угсрагч”

**Дэд бүлэг - 83** “Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч”

**Бага бүлэг - 834** “Зөөвөр төхөөргийн операторч”

**Нэгж бүлэг - 8344** “Операторч, бусад өргөх, татах төхөөрөмжийн”

гэсэн 8344 нэгж бүлгийг сонгоно. Уг мэргэжлийн үндсэн нэр буюу түлхүүр үгийг тодорхойлно. Энд түлхүүр үг нь жолооч юм. Түлхүүр үгэнд шууд хамаатай эхний тодорхойлогч нь “өргөх, татах төхөөрөмж” гэсэн үг байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл нь ачих, буулгах ажил болно.

Дээрх нэгж бүлгүүдийн дотроос үндэсний 2 оронтой тоо бүхий холбогдох индекс/кодыг авна.

8111-11 Операторч, өрөмдлөгийн машины /уурхайн

8344-21 Операторч, өргүүрийн

8344-16 Операторч, өргөх цамхагийн

**8344-24 Операторч, бусад өргөх, татах төхөөрөмжийн /уул уурхайн**

Дээрх жишээний хувьд 4 дэх индекс/код нь тохирч байна. Иймээс 8344-24 нь өргөх төхөөрөмжийн операторчийн индекс/код болно. Энэ ангилалд суурь машин, тоног төхөөрөмжийг ажиллуулдаг хүнийг “операторч” гэж нэршиж оруулсан. Энэ баримт бичигт орсон зарим өөр хэлний нэрийг авч хэрэглэхдээ, монгол хэлэнд хэрэглэж заншсан үг хэллэгтэй нийцүүлэхийг хичээсэн болой. Үүнд:

“**Фермер**” (farmers), “**Ферм**” (farm) гэсэн нэрийг (ферм+ч) **фермч**

“**Дизайнер**” (designers), “**дизайн**” (design) гэсэн нэрийг (дизайн+ч) **дизайнч**

“**Техник**” (technician) гэсэн нэрийг (техник+ч) **техникч**

“**Фотограф**” (photographers) гэсэн нэрийг (фотозураг+ч) **фотозурагч** гэх мэт.

3. Ажил, мэргэжлийн холбогдох бүлэг, индексийг тодорхойлохдоо уг ажил, мэргэжлийг гүйцэтгэхэд шаардагдаж буй а) мэдлэг мэргэшил,

боловсролын түвшин, б) ашиглаж буй технологи, техник, тоног төхөөрөмжийн хөгжлийн хүчин зүйлийг анхааран үзэх нь зүйтэй. Тухайлбал, багшлах, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын салбарын ижил төрлийн ажил, мэргэжлийг шаардагдаж буй мэргэшил боловсролын түвшингийн ялгааг харгалзан өндөр боловсрол мэдлэг шаардагдаж, илүү өргөн хүрээний судалгаа-шинжилгээ хийдэг, тухайн шинжлэх ухааны үзэл онолыг хөгжүүлэх, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий ажилтныг “Мэргэжилтэн” буюу 2 дугаар үндсэн бүлэгт, энэ салбарын техникийн шинж чанартай үүрэг гүйцэтгэдэг бусад ажилтныг “Техникч болон туслах/дэд мэргэжилтэн” (туслах мэргэжилтнийг “дэд мэргэжилтэн” гэж нэрших нь зохистой боловч нэгэнт “туслах” гэж нэрлэж хэвшсэн байх тул “/” гэсэн ташуу зураастай “туслах/дэд” гэж хоршин бичсэн болно) гэсэн 3 дугаар үндсэн бүлэгт ангилсан байх жишээтэй. Үүнийг жишээгээр дор харуулбал:

2221 - Сувилахуйн мэргэжилтэн

3221 - Сувилахуйн туслах/дэд мэргэжилтэн

2635 - Нийгмийн мэргэшсэн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн

3412 - Нийгмийн хамгааллын туслах/дэд мэргэжилтэн

4. “YAMAT-08”-ын үндсэн бүлэг 1-д дурдсан зарим менежерийн тухайд:

“**дарга (захирал)**” гэдэгт: эрхлэгч, ерөнхий захирал, ерөнхийлөгч, ректор,

“**дэд дарга (дэд захирал)**” гэдэгт: орлогч дарга, орлогч захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, тэргүүн дэд захирал, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч г.м тэдгээртэй адилтгах бусад удирдах албан тушаалыг,

“**Алба, хэлтэс, тасаг**” гэдэгт: хэсэг, товчоо, газар, групп, сектор, лаборатори, цех, ээлж болон тэдгээртэй адилтгах бусад нэгжийн менежерийг багтаан ойлгоно.

5. Тухайн ажил, мэргэжил нь үндсэн нэрийн хувьд ижил боловч ажил, үйлчилгээний чиглэл нь өөр өөр байгаагаас шалтгаалж зарим ажил, мэргэжил хэд хэдэн бүлэгт давхар бичигдсэнийг анхаарна уу.

Тухайлбал,

8342-27 Операторч, автогрейдерийн /газар, шороо, зам засварын/

8342-13 Операторч, бульдозерийн /газар, шороо, зам засварын/

8121-24 Операторч, бульдозерийн /төмөрлөгийн үйлдвэрийн/

8121-25 Операторч, автогрейдерийн /төмөрлөгийн үйлдвэрийн/ г.м

Түүнчлэн ажил мэргэжлийн холбогдох кодыг олохдоо уг ажил мэргэжилд шаардагдаж буй боловсролын түвшин, хэрэглэгдэж буй багаж



хэрэгслэл, машин тоног төхөөрөмжийн технологийн хөгжил зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзвэл зохино.

### **Гурав. Зөвлөмж**

1. “YAMAT-08”-ийн дагуу тухайн үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахдаа “YAMAT-08”-д дурдсан ажил, мэргэжлийн нэр, кодыг өөрчлөлгүйгээр олон улсын болон үндэсний нэршил, кодыг хэрэглэж хэвших,

2. “YAMAT-08”-ийн ажил, мэргэжлийн тодорхойлолтод дурдсан үүрэг, хариуцлагыг ханган биелүүлэх нөхцөл, шаардлагыг өөрийн онцлогт дүйцүүлэн гаргаж хэрэглэх. Энэхүү ангилалд тухайн салбар, үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, байгууллагын ажил, мэргэжил бүрийг хамруулах боломжгүй тул тухайн байгууллага нь шинээр бий болсон, эсхүл өөрчлөгдсөн ажил, мэргэжлийг хэрэглэхдээ энэхүү ангилалын аль болох адилтгах ажил, мэргэжлийн индекс/кодыг авч хэрэглэх нь зүйтэй,

3. Эрэлт, нийлүүлэлтээр удирдуулсан ажиллах хүчний чанар (мэргэжил), тоо (ажилтны хэрэгцээ)-ны хэрэгцээг ойрын ба хэтийн хугацаагаар тооцоолохдоо энд дурдсан агуулга, нэрийн дагуу гүйцэтгэж байх,

4. Боловсролын бүх төрөл, шатны байгууллага мэргэжилтэн бэлтгэхдээ мэргэжлийн нэр, тодорхойлолтыг энэхүү баримт бичгийн агуулга, индекс/кодтой нийцүүлэн зохицуулах,

5. Хүн ам, ажиллах хүчний тооллого, бүртгэл, мэдээллийг цуглуулах, боловсруулахдаа “YAMAT-08”-ыг мөрдөж ажиллах.

## **НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**



# IV. ҮНДСЭН, ДЭД, БАГА БА НЭГЖ БҮЛГИЙН НЭР

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 1 МЕНЕЖЕР

---

- 1 Менежер
  - 11 Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал
    - 111 Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан
      - 1111 Хууль тогтоогч**
      - 1112 Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан**
      - 1113 Өөрөө удирдах нутгийн байгууллагын Засаг дарга, Захирагч, бусад удирдах албан тушаалтан**
      - 1114 Тусгай сонирхол бүхий байгууллагын удирдах албан тушаалтан /улс төр, олон нийтийн, ТББ/**
    - 112 Захирал, гүйцэтгэх захирал
      - 1120 Захирал, гүйцэтгэх захирал**
      - 1121 Дэд захирал /дэд дарга, орлогч дарга/**
  - 12 Захиргаа, арилжааны менежер
    - 121 Бизнес, үйлчилгээ, захиргааны менежер
      - 1211 Санхүүгийн менежер**
      - 1212 Хүмүүний нөөцийн менежер**
      - 1213 Бодлого, төлөвлөлтийн менежер**
      - 1219 Бизнес үйлчилгээ, захиргааны менежер /өөр газар ангилагдаагүй/**
      - 1221 Борлуулалт, маркетингийн менежер**
      - 1222 Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах менежер**
      - 1223 Судалгаа, хөгжлийн менежер**
  - 13 Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер
    - 131 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын үйлдвэрлэлийн менежер
      - 1311 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын үйдвэрлэлийн менежер**
      - 1312 Усны амьтан үржүүлэгч, загасны аж ахуйн үйлдвэрлэлийн менежер**
    - 132 Үйлдвэр, уурхай, барилга угсралт, хангамж түгээлтийн менежер
      - 1321 Үйлдвэрийн менежер**
      - 1322 Уурхайн менежер**
      - 1323 Барилга угсралтын менежер**
      - 1324 Хангамж, түгээлт, холбогдох бусад менежер**
    - 133 Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер
      - 1330 Мэдээлэл холбооны технологи үйлчилгээний менежер**
    - 134 Мэргэшсэн үйлчилгээний менежер
      - 1341 Хүүхэд асрамжлах үйлчилгээний менежер**

- 1342 Эрүүл мэндийн үйлчилгээний менежер
  - 1343 Настанг асрамжлах үйлчилгээний менежер
  - 1344 Нийгмийн халамжийн менежер
  - 1345 Боловсролын менежер
  - 1346 Банк, санхүү, даатгалын үйлчилгээний менежер
  - 1349 Аль нэг ангилалд ороогүй мэргэшсэн үйлчилгээний бусад менежер
- 14 Зочид буудал, худалдаа, холбогдох бусад үйлчилгээний менежер
- 141 Зочид буудал, рестораны менежер
    - 1411 Зочид буудлын менежер
    - 1412 Рестораны менежер
  - 142 Жижиглэн болон бөөний худалдааны менежер
    - 1420 Жижиглэн болон бөөний худалдааны менежер
  - 143 Холбогдох бусад үйлчилгээний менежер
    - 1431 Соёл, спорт, амралтын төвийн менежер
    - 1439 Аль нэг ангилалд ороогүй холбогдох бусад үйлчилгээний менежер
- 

## ҮНДСЭН БҮЛЭГ 2

### МЭРГЭЖИЛТЭН

---

#### 2 Мэргэжилтэн

- 21 Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн
    - 211 Биет бодис/физик/, гео судлалын мэргэжилтэн
      - 2111 Физикч, одон орон судлаач
      - 2112 Цаг уурч
      - 2113 Химич
      - 2114 Геологич, геофизикч
    - 212 Математикч, актуарч, статистикч
      - 2120 Математикч, актуарч, статистикч
    - 213 Амьд байгалийн ухааны мэргэжилтэн
      - 2131 Биологич, ботаникч, амьтан судлаач, холбогдох бусад мэргэжилтэн
      - 2132 Фермч, ойн болон загасны аж ахуйн зөвлөгч
      - 2133 Байгаль хамгааллын мэргэжилтэн
    - 214 Инженер мэргэжилтэн (цахим-технологиос бусад)
      - 2141 Аж үйлдвэрийн инженер
      - 2142 Иргэний барилга байгууламжийн инженер
      - 2143 Байгаль орчны инженер
      - 2144 Механикч инженер
      - 2145 Химийн инженер
      - 2146 Уул уурхайн инженер, металлургич, холбогдох бусад мэргэжилтэн
      - 2149 Энэ ангилалд ороогүй инженер мэргэжилтэн
    - 215 Цахилгаан, цахим-технологийн инженер
-

- 2151 **Цахилгааны инженер**
- 2152 **Цахим зүйн инженер**
- 2153 **Телехолбооны инженер**
- 216 **Архитекторч, төлөвлөгч, зурагзүйч, байрзүйч, дизайнч**
  - 2161 **Барилгын архитекторч**
  - 2162 **Газар тохижуулалтын архитекторч**
  - 2163 **Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч**
  - 2164 **Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч**
  - 2165 **Зурагзүйч, байрзүйч**
  - 2166 **График, мультимедиа зохиомжийн дизайнч**
- 22 **Эрүүл мэндийн мэргэжилтэн**
  - 221 **Хүний их эмч**
    - 2211 **Ерөнхий мэргэжлийн их эмч**
    - 2212 **Нарийн (төрөлжсөн) мэргэжлийн их эмч**
  - 222 **Сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн**
    - 2221 **Сувилахуйн мэргэжилтэн**
    - 2222 **Эх барихуйн мэргэжилтэн**
  - 223 **Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн**
    - 2230 **Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн**
  - 224 **Яаралтай тусламжийн эмч, ажилтан**
    - 2240 **Яаралтай тусламжийн эмч**
  - 225 **Малын эмч**
    - 2250 **Малын эмч**
  - 226 **Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн**
    - 2261 **Нүүр амны эмч (Шүдний эмч)**
    - 2262 **Эм зүйч**
    - 2263 **Хүрээлэх орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн мэргэжилтэн**
    - 2264 **Нөхөн сэргээх эмчилгээний эмч**
    - 2265 **Хоол тэжээлийн мэргэжилтэн, хоолны арга зүйч**
    - 2266 **Сонсголын мэргэжилтэн, хэлний согог засалч**
    - 2267 **Хараа зүйч, хараа хэмжигч**
    - 2269 **Аль нэг ангилалд ороогүй эрүүл мэндийн бусад мэргэжилтэн**

### **Их, дээд сургууль, дээд боловсрол олгох багш**

- 23 **Багшлах мэргэжилтэн**
  - 231 **Их, дээд сургуулийн дээд боловсролын багш**
    - 2310 **Багш, дээд боловсрол олгох багш**
  - 232 **Техник мэргэжлийн боловсролын багш**
    - 2320 **Техник мэргэжлийн боловсролын багш**

### **Дунд боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч**

- 233 **Дунд боловсролын багш**
  - 2330 **Дунд боловсрол олгох багш**

## **Анхан шатны боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч**

- 234 Анхан шатны болон сургуулийн өмнөх боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч
  - 2341 Багш, анхан шатны боловсрол олгох
  - 2342 Сургуулийн өмнөх боловсрол олгох багш, сурган хүмүүжүүлэгч
- 235 Бусад багшлах мэргэжилтэн
  - 2351 Боловсролын арга зүйн мэргэжилтэн
  - 2352 Тусгай хэрэгцээт боловсролын багш
  - 2353 Өөр хэлний багш
  - 2354 Дуу хөгжмийн багш
  - 2355 Соёл, урлагын багш
  - 2356 Мэдээллийн технологийн сурагч
  - 2359 Аль нэг ангилалд ороогүй багшлах бусад мэргэжилтэн
- 24 Бизнес, захиргааны мэргэжилтэн
  - 241 Санхүүгийн мэргэжилтэн
    - 2411 Нягтлан бодогч
    - 2412 Санхүү хөрөнгө оруулалтын зөвлөх
    - 2413 Санхүүгийн шинжээч
  - 242 Захиргааны мэргэжилтэн
    - 2421 Удирдлага, байгууллагын задлан шинжээч
    - 2422 Бодлогын захиргааны мэргэжилтэн
    - 2423 Хүмүүний нөөц, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөгч мэргэжилтэн
    - 2424 Сургалтын болон боловсон хүчнийг хөгжүүлэх албаны мэргэжилтэн
  - 243 Борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн
    - 2431 Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн
    - 2432 Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн
    - 2433 Техникийн болон эмнэлгийн борлуулалтын мэргэжилтэн /мэдээлэл, холбооны технологиос бусад/
    - 2434 Мэдээлэл, холбооны технологи борлуулалтын мэргэжилтэн
- 25 Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн
  - 251 Программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч
    - 2511 Мэдээллийн системийн шинжээч
    - 2512 Программ зохиогч
    - 2513 Веб, мультимедиа зохиогч
    - 2514 Хэрэглээний программ зохиогч
    - 2519 Энэ ангилалд ороогүй бусад программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч
  - 252 Өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн
    - 2521 Өгөгдлийн сангийн дизайнч, эрхлэгч
    - 2522 Системийн эрхлэгч
    - 2523 Компьютерийн сүлжээний мэргэжилтэн
    - 2529 Энэ ангилалд ороогүй өгөгдлийн сан, сүлжээний бусад мэргэжилтэн

- 26 Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн
  - 261 Эрх зүйн мэргэжилтэн
    - 2611 Эрх зүйч, (Хуульч)
    - 2612 Шүүгч
    - 2619 Аль нэг ангилалд ороогүй эрх зүйн бусад мэргэжилтэн
  - 262 Номын санч, архивч, музейн харгалзагч
    - 2621 Архивч, музейн харгалзагч
    - 2622 Номын санч, холбогдох мэдээллийн бусад мэргэжилтэн
  - 263 Нийгэм, шашны мэргэжилтэн
    - 2631 Эдийн засагч
    - 2632 Социологич, антропологич, холбогдох бусад мэргэжилтэн
    - 2633 Философич, улс төр судлаач, түүхч
    - 2634 Сэтгэл зүйч
    - 2635 Нийгмийн (мэргэшсэн) ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн
    - 2636 Шашны мэргэжилтэн /мяндагтан/
  - 264 Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээч
    - 2641 Зохиолч, холбогдох бусад нийтлэлч
    - 2642 Сэтгүүлч
    - 2643 Орчуулагч, хэлмэрч, бусад хэл шинжлээч
  - 265 Уран бүтээлч, жүжигчин
    - 2651 Дүрслэх урлаач
    - 2652 Хөгжмийн зохиолч, хөгжимчин, дуучин
    - 2653 Бүжиг дэглэгч, бүжигчин
    - 2654 Кино тайз болон түүнд холбогдох найруулагч
    - 2655 Жүжигчин
    - 2656 Радио, телевиз, бусад мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлэгч
    - 2659 Аль нэг ангилалд ороогүй бусад уран бүтээлч, жүжигчин

---

## **ҮНДСЭН БҮЛЭГ 3**

### **ТЕХНИКЧ БОЛОН ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН**

- 3 Техникч болон туслах/дэд мэргэжилтэн
  - 31 Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн
    - 311 Инженерийн ухааны техникч
      - 3111 Химийн болон физикийн ухааны техникч
      - 3112 Иргэний барилгын инженерийн техникч
      - 3113 Цахилгаан инженерийн техникч
      - 3114 Цахим инженерийн техникч
      - 3115 Механик инженерийн техникч
      - 3116 Химийн инженерийн техникч
      - 3117 Уурхай, металлургийн техникч
      - 3118 Шугам зурагч, техникч
      - 3119 Энэ ангилалд ороогүй инженерийн ухааны бусад техникч

- 312 Уурхай, үйлдвэр, барилга угсралтын байцаагч
  - 3121 Уурхайн байцаагч, хянагч
  - 3122 Үйлдвэрийн байцаагч
  - 3123 Барилга угсралтын байцаагч
- 313 Технологи процесс, чанар шалгагч техникч
  - 3131 Цахилгаан үйлдвэрлэлийн төхөөрөгийн операторч
  - 3132 Шатаагч зуух, ус цэвэрлэх байгууламжийн операторч
  - 3133 Хими процессийн төхөөрөмжийн операторч
  - 3134 Нефть, хий цэвэрлэх төхөөргийн операторч
  - 3135 Металл үйлдвэрлэлийн процесс хянагч
  - 3139 Энэ ангилалд ороогүй процесс хяналтын техникч
- 314 Амьд байгалийн ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
  - 3141 Амьд байгалийн ухааны техникч (Анагаах ухаанаас бусад)
  - 3142 Хөдөө аж ахуйн техникч
  - 3143 Ойн аж ахуйн техникч
- 315 Усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч
  - 3151 Усан онгоцны инженер
  - 3152 Усан онгоцны тавцан дээрх ажилтан, чиглүүлэгч
  - 3153 Агаарын хөлгийн нисгэгч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
  - 3154 Агаарын хөдөлгөөн хянагч
  - 3155 Агаарын хөдөлгөөний аюулгүйн цахим техникч
- 32 Эрүүл мэндийн туслах/дэд мэргэжилтэн
  - 321 Анагаахын болон эм зүйн техникч
    - 3211 Эмчилгээ оншлогооны төхөөрөмжийн техникч
    - 3212 Эмчилгээ, эмгэг судлалын лабораторийн техникч
    - 3213 Эм зүйн техникч болон туслагч
    - 3214 Эмчилгээ, хиймэл шүдний техникч
  - 322 Сувилахуйн болон эх барихуйн туслах/дэд мэргэжилтэн
    - 3221 Сувилахуйн туслах/дэд мэргэжилтэн
    - 3222 Эх барихуйн туслах/дэд мэргэжилтэн
  - 323 Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд мэргэжилтэн
    - 3230 Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд мэргэжилтэн
  - 324 Мал эмнэлгийн техникч, туслах ажилтан
    - 3240 Мал эмнэлгийн техникч, туслах/дэд мэргэжилтэн
  - 325 Эрүүл мэндийн бусад туслах/дэд мэргэжилтэн
    - 3251 Нүүр амны эмчилгээний туслах, эмчлэгч
    - 3252 Эмчилгээний тэмдэглэл, эрүүл мэндийн мэдээллийн техникч
    - 3253 Өрхийн ба бүлгийн эрүүл мэндийн ажилтан
    - 3254 Харааны шилний мэргэжилтэн, шил олгогч
    - 3255 Нөхөн сэргээх эмчилгээний техникч, туслагч
    - 3256 Эмчилгээний туслах/дэд ажилтан
    - 3257 Хүрээлэх орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйн байцаагч, туслагч ажилтан



- 3258 Яаралтай тусламжийн ажилтан
    - 3259 Энэ ангилалд ороогүй эрүүл мэндийн туслах /дэд мэргэжилтэн
- 33 Бизнесийн болон захиргааны туслах/дэд мэргэжилтэн
  - 331 Санхүү, математик тооцооллын туслах/ дэд мэргэжилтэн
    - 3311 Үнэт цаас, санхүүгийн дилер, брокер
    - 3312 Зээл, зээллэгийн мэргэжилтэн
    - 3313 Нягтлан бодох бүртгэлийн туслах/дэд мэргэжилтэн
    - 3314 Статистик, математик тоцоолол, түүнтэй адилтгах бусад мэргэжилтэн
    - 3315 Эд баялагийн үнэлгээчин, хохирол тогтоогч
  - 332 Борлуулалт, худалдан авалтын агент, брокер
    - 3321 Актуарч
    - 3322 Арилжаа, борлуулалтын төлөөлөгч
    - 3323 Худалдан авагч
    - 3324 Борлуулалтын брокер
  - 333 Бизнес үйлчилгээний агент
    - 3331 Клирингийн, илгээмжийн агент
    - 3332 Хурал зөвлөгөөн зэрэг арга хэмжээ төлөвлөгч /зохион байгуулагч/
    - 3333 Хөдөлмөр эрхлэлтийн агент, ажилд зуучлагч
    - 3334 Үл хөдлөх хөрөнгийн агент, менежер
    - 3339 Аль нэг ангилалд ороогүй бизнес үйлчилгээний бусад агент
  - 334 Захиргаа, төрөл мэргэжлийн нарийн бичгийн дарга
    - 3341 Албаны зааварлагч
    - 3342 Хуулийн нарийн бичгийн дарга
    - 3343 Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга
    - 3344 Анагаахын нарийн бичгийн дарга
  - 335 Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан
    - 3351 Хил, гаалийн байцаагч
    - 3352 Улсын татвар, акцизын албаны ажилтан
    - 3353 Улсын нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн асуудал хариуцсан ажилтан
    - 3354 Тусгай зөвшөөрөл хариуцсан ажилтан
    - 3355 Цагдаагийн байцаагч, мөрдөн байцаагч
    - 3359 Аль нэг ангилалд ороогүй Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын холбогдох бусад ажилтан
- 34 Хууль, нийгэм, соёл, тэдгээрт холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
  - 341 Хууль, нийгэм, шашны ажилтан
    - 3411 Эрх зүйн болон холбогдох бусад ажилтан
    - 3412 Нийгмийн ажилтан холбогдох бусад ажилтан
    - 3413 Шашны болон холбогдох бусад ажилтан
  - 342 Биеийн тамир, спорт, фитнесийн ажилтан
    - 3421 Тамирчин, спортын тоглогч
    - 3422 Спортын дасгалжуулагч, зааварлагч
    - 3423 Фитнесс, чирэгжүүлэлтийн зааварлагч, хөтөлбөрийн удирдагч

- 343 Соёл, урлаг, хүнсний технологийн ажилтан
  - 3431 **Фото зурагч**
  - 3432 **Дотоод засал чимэглэлийн дизайнч, чимэглэгч**
  - 3433 **Галлерей, музей, номын сангийн техникч**
  - 3434 **Тогооч**
  - 3435 **Соёл, урлагийн бусад мэргэжилтэн**
- 35 Мэдээлэл, холбооны техникч
  - 351 Мэдээлэл, холбооны технологи ажиллагаа болон хэрэглэгчдэд туслах техникч
    - 3511 **Мэдээлэл, холбооны технологи ажиллагааны техникч**
    - 3512 **Мэдээлэл, холбооны технологи хэрэглэгчдэд туслах техникч**
    - 3513 **Компьютерийн сүлжээ, системийн техникч**
    - 3514 **Веб техникч**
  - 352 Телехолбоо, өргөн нэвтрүүлгийн техникч
    - 3521 **Өргөн нэвтрүүлэг, дуу, дүрс бичлэгийн техникч**
    - 3522 **Телехолбооны инженерийн техникч**

---

## **ҮНДСЭН БҮЛЭГ 4**

### **КОНТОР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

- 4 Контор, үйлчилгээний ажилтан
  - 41 Конторын үндсэн болон гүйцэтгэх ажилтан
    - 411 Конторын үндсэн ажилтан
      - 4110 **Конторын үндсэн ажилтан**
    - 412 Нарийн бичгийн дарга
      - 4120 **Нарийн бичгийн дарга**
    - 413 Компьютерийн операторч
      - 4131 **Бичээч**
      - 4132 **Баримт, мэдээлэл оруулагч операторч**
  - 42 Хэрэглэгчдэд үйлчлэх ажилтан
    - 421 Теллер, мөнгө хураагч, холбогдох бусад ажилтан
      - 4211 **Банкны теллер, холбогдох бусад ажилтан**
      - 4212 **Дилер, холбогдох тоглоомын газрын бусад ажилтан**
      - 4213 **Барьцаалан зээлдэгч, мөнгө зээлдүүлэгч**
      - 4214 **Өр барагдуулагч, холбогдох бусад ажилтан**
    - 422 Хэрэглэгчийг мэдээллээр хангах ажилтан
      - 4221 **Аялал жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан**
      - 4222 **Холбоо барих төвийн мэдээллийн ажилтан**
      - 4223 **Телефон холбоочин**
      - 4224 **Зочид буудлын хүлээн авагч**
      - 4225 **Лавлах ажилтан**
      - 4226 **Хүлээн авагч**
      - 4227 **Судлаач, зах зээл**

- 4229 Энэ ангилалд ороогүй хэрэглэгчийг мэдээллээр хангах бусад ажилтан
- 43 Тооцоолол, материал бүртгэлийн ажилтан
  - 431 Тооцооллын ажилтан
    - 4311 Нягтлан бодох, данс бүртгэлийн ажилтан
    - 4312 Статистикийн, санхүүгийн болон даатгалын ажилтан
    - 4313 Цалингийн бүртгэлийн ажилтан
  - 432 Материал бүртгэл, тээврийн ажилтан
    - 4321 Материалын нөөцийн ажилтан
    - 4322 Үйлдвэрлэлийн ажилтан
    - 4323 Тээврийн ажилтан /диспетчер/
- 44 Конторын бусад туслах ажилтан
  - 441 Конторын бусад туслах ажилтан
    - 4411 Номын сангийн ажилтан
    - 4412 Шуудан зөөгч, ангилагч ажилтан
    - 4413 Кодлогч, хянан тохируулагч болон холбогдох бусад ажилтан
    - 4414 Бичээч холбогдох бусад ажилтан
    - 4415 Файлдагч, олшруулагч ажилтан
    - 4416 Хүмүүний нөөцийн ажилтан
    - 4419 Энэ ангилалд ороогүй конторын бусад туслах ажилтан

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 5

### **ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

- 5 Худалдаа, үйлчилгээний ажилтан
  - 51 Хувийн үйлчилгээний ажилтан
    - 511 Аялал жуулчлалын үйлчлэх ажилтан, кондуктор, хөтөч
      - 5111 Аялал жуулчлалын үйлчлэх ажилтан, аялал жуулчлалын үйлчлэгч
      - 5112 Нийтийн тээврийн кондуктор
      - 5113 Аялал жуулчлалын хөтөч
    - 512 Тогооч
      - 5120 Тогооч
    - 513 Зөөгч, бармен
      - 5131 Зөөгч
      - 5132 Бармен
    - 514 Үсчин, гоо сайханч, холбогдох бусад ажилтан
      - 5141 Үсчин
      - 5142 Гоо сайханч, холбогдох бусад ажилтан
    - 515 Байр, байшин, гэр ахуйн үйлчилгээний ажилтан
      - 5151 Албан газар, зочид буудал зэрэг байгууллагын цэвэрлэгээ, ахуйн хариуцан хянагч
      - 5152 Гэр ахуй эрхлэгч
      - 5153 Байшин арчлагч

- 516 Хувь хүний үйлчилгээний бусад ажилтан
  - 5161 Зурхайч, мэргэч, холбогдох бусад ажилтан
  - 5162 Бараа бологч, зарц
  - 5163 Оршуулга зохион байгуулагч, занданшуулагч /шарил чандарлагч
  - 5164 Гэрийн тэжээвэр амьтан маллагч, тойлогч
  - 5165 Жолооны багш
  - 5169 Өөр ангилалд ороогүй хувь үйлчилгээний бусад ажилтан
- 52 Борлуулалтын ажилтан
  - 521 Гудамж, захын худалдаачин
    - 5211 Мухлаг, захын худалдаачин
    - 5212 Гудамжинд хоол, хүнс худалдаалагч
  - 522 Дэлгүүрийн худалдаачин
    - 5221 Дэлгүүр ажиллуулагч
    - 5222 Дэлгүүрийн эрхлэгч
    - 5223 Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан
  - 523 Кассчин, тасалбар олгогч
    - 5230 Кассчин, тасалбар олгогч
  - 524 Борлуулалтын бусад ажилтан
    - 5241 Загвар өмсөгч, жишиг үзүүлэгч
    - 5242 Бараа танилцуулан худалдаалагч
    - 5243 Захиалга, дуудлагаар хаалганаас хаалганд худалдаалагч
    - 5244 Утсаар захиалга авч худалдаалагч
    - 5245 Үйлчилгээний цэгийн ажилтан
    - 5246 Хүнсний лангууны худалдаачин
    - 5249 Аль нэг ангилалд ороогүй борлуулалтын бусад ажилтан
- 53 Хувь хүн асрамжлах үйлчилгээ
  - 531 Хүүхэд асрамжлах ажилтан, багшийн туслагч
    - 5311 Хүүхэд асаргааны ажилтан
    - 5312 Туслах багш
  - 532 Эмнэлгийн сувилгааны ажилтан
    - 5321 Эмнэлгийн сувилгааны туслах ажилтан
    - 5322 Гэрээр асрамжлах үйлчилгээний ажилтан
    - 5329 Энэ ангилалд ороогүй эмнэлгийн сувилгааны бусад ажилтан
- 54 Хамгаалах үйлчилгээний ажилтан
  - 541 Хамгаалах үйлчилгээний ажилтан
    - 5411 Аврагч
    - 5412 Цагдаагийн ажилтан
    - 5413 Шоронгийн хуяг
    - 5414 Хамгаалалтын албаны ажилтан
    - 5419 Аль нэг ангилалд ороогүй хамгаалах үйлчилгээний бусад ажилтан

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 6

### ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС АГНУУРЫН

### МЭРГЭШСЭН АЖИЛТАН

---

- 6 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан
  - 61 Зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан
    - 611 Зах зээлд чиглэсэн цэцэрлэгч, тариаланч
      - 6111 Тариаланч, ногоочин**
      - 6112 Мод, бут тарьж ургуулагч**
      - 6113 Цэцэрлэгч, цэцэрлэгт хүрээлэн, хүлэмжийн тариалагч**
      - 6114 Холимог ургамал тариалагч**
    - 612 Малчин, амьтан маллагч
      - 6121 Мал маллагч, сүү, цагаан идээ үйлдвэрлэгч**
      - 6122 Шувуу аж ахуйн ажилтан**
      - 6123 Зөгий үржүүлэгч**
      - 6129 Аль нэг ангилалд ороогүй бусад амьтан маллагч**
    - 613 Газар тариалан, мал амьтан хослон эрхлэгч
      - 6130 Тариалан, мал амьтан хослон эрхлэгч**
  - 62 Зах зээлд чиглэсэн ой, загасны аж ахуй, ан агнуур эрхлэгч
    - 621 Ойн аж ахуй, холбогдох бусад ажилтан
      - 6210 Ойн аж ахуй, холбогдох бусад ажилтан**
    - 622 Загасны аж ахуйн ажилтан, анчин, гөрөөчин
      - 6221 Усны ургамал ургуулагч, амьтан үржүүлэгч**
      - 6222 Нуурын болон эргийн усны загасны аж ахуйн ажилтан**
      - 6224 Анчин, урхичин**
  - 63 Өрхийн хэрэгцээт амь зуулгын фермч, загасчин, анчин, түүгч, хураагч
    - 631 Өрхийн хэрэгцээт газар тариалангийн фермч
      - 6310 Газар тариалангаар амь зуугч**
    - 632 Өрхийн хэрэгцээт мал аж ахуйн фермч
      - 6320 Мал аж ахуйгаар амь зуугч**
    - 633 Өрхийн хэрэгцээт тариалан, мал аж ахуйн холимог фермч
      - 6330 Тариалан, мал аж ахуй хосолсон фермч**
    - 634 Өрхийн хэрэгцээт загасчин, анчин, урхичин ба түүгч
      - 6340 Загасчин, түүгч /хураагч**

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 7

### ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА, ГАР УРЛАЛ, ХОЛБОГДОХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

---

- 7 Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан
- 71 Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан (цахилгаанчаас бусад)
- 711 Барилгын араг бүтээц, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан
- 7111 Барилгачин
- 7112 Өрлөгчин, холбогдох бусад ажилтан
- 7113 Чулуучин, чулуу зүсэгч, бутлагч, сийлбэрчин
- 7114 Бетончин, бетон гадаргуу өнгөлөгч, түүнтэй холбогдох мэргэжлийн ажилтан
- 7115 Барилга угсралтын мужаан
- 7119 Энэ ангилалд ороогүй барилгын араг бүтээц /яс мод/ угсрагч түүнтэй адилтгах бусад ажилтан
- 712 Барилгын гүйцэтгэгч болон түүнтэй адилтгах бусад ажил, мэргэжлийн ажилтан
- 7121 Дээвэрчин
- 7122 Шалчин, өнгөлгөөчин
- 7123 Шаварчин, засалчин
- 7124 Тусгаарлагч
- 7125 Шилчин /Шиллэгч
- 7126 Сантехникч, хоолой урсгагч
- 7127 Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч
- 713 Будагчин, барилгын цэвэрлэгээний болон холбогдох бусад ажил, мэргэжлийн ажилтан
- 7131 Будагчин, түүнтэй адилтгах бусад ажилтан
- 7132 Будаг шүршигч, лакдагч
- 7133 Барилгын бүтээцийн цэвэрлэгч
- 72 Металл, машин механизм, холбогдох ажил, мэргэжлийн ажилтан
- 721 Нимгэн төмөр, барилгын металл хийцийн мэргэжилтэн, хэв цутгагч холбогдох бусад ажилтан
- 7211 Хэв цутгагч
- 7212 Гагнуурчин
- 7213 Нимгэн төмөрчин
- 7214 Металл хийц бэлтгэгч, угсрагч
- 7215 Хүнд, овортой эдлэхүүн зөөгч, оосорлогч
- 722 Дархан, гараар давтах болон шахуургын дархан, холбогдох бусад ажил, мэргэжлийн ажилтан
- 7221 Дархан, гараар давтах болон шахуургын дархан
- 7222 Багажны дархан түүнтэй адилтгах бусад ажилтан
- 7223 Металлын машин механизм суурилуулагч /операторч/
- 7224 Металл зүлгэгч, өнгөлөгч, багаж ирлэгч
- 723 Машин, механизмын механикч, засварчин
- 7231 Моторт тээврийн хэрэгслийн механикч, тохируулагч
- 7232 Агаарын хөлгийн хөдөлгүүрийн механикч, тохируулагч

- 7233 **Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн машин механизмын механикч, тохируулагч**
- 7234 **Ундаг дугуйн засварчин**
- 73 Гар урлал, хэвлэлийн ажилтан
  - 731 Гар урлалын ажилтан
    - 7311 **Нарийн хийцтэй багаж үйлдвэрлэгч, засварчин**
    - 7312 **Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэгч, хөглөгч**
    - 7313 **Эрдэнийн чулуу, үнэт металлын ажилтан**
    - 7314 **Ваар, шавар эдлэлийн ажилтан**
    - 7315 **Шилэн эдлэл хийгч, зүсэгч, өнгөлөгч**
    - 7316 **Хаяг, зарлал, гоёл чимэглэлийн зураач, будагч, сийлбэрч, зураг хээ гаргагч**
    - 7317 **Модоор гар урлалын зүйл, сагс зэргийг хийгч**
    - 7318 **Давуу, арьс, бусад материалаар гар урлалын зүйлс хийгч**
    - 7319 **Энэ ангилалд ороогүй гар урлалын зүйл хийгч**
  - 732 Хэвлэлийн мэргэжлийн ажилтан
    - 7321 **Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч**
    - 7322 **Хэвлэгч**
    - 7323 **Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан**
- 74 Цахилгаан, цахим техникч
  - 741 Цахилгаан төхөөрөмж суурилуулагч, тохируулагч
    - 7411 **Барилгын болон бусад цахилгаанчин**
    - 7412 **Цахилгаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/**
    - 7413 **Цахилгаан шугам тавигч /тохируулагч/**
  - 742 Цахим техникч, телехолбооны механикч, тохируулагч
    - 7421 **Цахим механикч, засварчин /тохируулагч/**
    - 7422 **Мэдээлэл, холбооны технологийн сул хүчний шугамын хэрэгсэл тавигч /тохируулагч/**
- 75 Хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтан
  - 751 Хүнс үйлдвэрлэгч, холбогдох бусад ажил, мэргэжлийн ажилтан
    - 7511 **Мах, загасны худалдаачин, холбогдох бусад хоол, хүнс бэлтгэгч**
    - 7512 **Гурлин бүтээгдэхүүн, бал бурам, бусад амттан үйлдвэрлэгч**
    - 7513 **Сүү, цагаан идээ боловсруулагч**
    - 7514 **Жимс, жимсгэнэ, ногоо, хүнсний бусад зүйл даршлагч**
    - 7515 **Хүнсний зүйл, ундаа амтлагч, зэрэглэл тогтоогч**
    - 7516 **Тамхи үйлдвэрлэгч**
  - 752 Мод боловсруулагч нарийн мужаан, түүнд холбогдох ажил, мэргэжлийн ажилтан
    - 7521 **Мод боловсруулагч**
    - 7522 **Нарийн мужаан, холбогдох бусад ажилтан**
    - 7523 **Мод боловсруулах машин суурилуулагч, операторч**
  - 753 Хувцас оёх болон түүнд холбогдох ажил, мэргэжлийн ажилтан
    - 7531 **Загварчин, үслэг эдлэл, малгай хийгч**
    - 7532 **Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин**

- 7533 Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан
- 7534 Тавилганы бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан
- 7535 Ангийн үс, арьс шир боловсруулагч
- 7536 Гуталчин, холбогдох бусад ажилтан
- 754 Бусад үйлдвэрлэл, үйлчилгээ, урлалын зүйл хийгч, холбогдох ажилтан
  - 7541 Усан доорхи төхөөрөмж дээр ажиллагч
  - 7542 Тэсэлгээний ажилтан /тэсэлгээчин/
  - 7543 Бүтээгдэхүүн зэрэглэгч, шалгагч (хоол хүнс болон ундаанаас бусад)
  - 7544 Ариутгагч, хортон шавьж, хогийн ургамал устгагч
  - 7549 Энэ ангилалд ороогүй адилтгах бусад ажил, үйлчилгээний ажилтан

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 8 МАШИН МЕХАНИЗМ, ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ, УГСРАГЧ

---

- 8 Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч
  - 81 Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч
    - 811 Уурхай болон эрдэс боловсруулах суурь машины операторч
      - 8111 Далд ба ил уурхайчин
      - 8112 Операторч, эрдэс, чулуулаг боловсруулах төхөөргийн
      - 8113 Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан
      - 8114 Цемент, бусад эрдэс бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн машины операторч
    - 812 Металл боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний суурь машины операторч
      - 8121 Металл боловсруулах төхөөргийн операторч
      - 8122 Металл өнгөлөх, цайрдах, бүрэх машины операторч
    - 813 Химийн болон фото зургийн бүтээгдэхүүний машины операторч
      - 8131 Химийн бүтээгдэхүүний машины операторч
      - 8132 Фото зургийн машин ажиллуулагч
    - 814 Резин, хуванцар, цаасан бүтээгдэхүүний машины операторч
      - 8141 Резин бүтээгдэхүүний машины операторч
      - 8142 Хуванцар бүтээгдэхүүний машины операторч
      - 8143 Цаасан бүтээгдэхүүний машины операторч
    - 815 Нэхмэл, үслэг эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүний машины операторч
      - 8151 Утас бэлтгэх, томох, ээрэх машины операторч
      - 8152 Нэхэх, сүлжих машины операторч
      - 8153 Оёдлын машины операторч
      - 8154 Угаах, чанах, будах, цайруулах, сэгсрэх, цэвэрлэх, толбо арилгах, хатаах машины операторч



- 8155 **Үслэг эдлэл, арьс шир бэлтгэх машины операторч**
- 8156 **Гутал, бусад ижил төрлийн ажлын машины операторч**
- 8157 **Угаалгын машины операторч**
- 8159 **Энэ ангилалд ороогүй бусад ижил төрлийн үйлдвэрлэгч**
- 816 **Хоол хүнс, бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх машины операторч**
  - 8160 **Хоол хүнс, бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүний машины операторч**
  - 8161 **Үр тариа боловсруулах үйлдвэрлэлийн операторч /аппаратчин/**
- 817 **Мод боловсруулах, цаас үйлдвэрлэх машины операторч**
  - 8171 **Модны зутан, цаас үйлдвэрлэх төхөөргийн операторч**
  - 8172 **Мод боловсруулах төхөөрөгийн операторч**
- 818 **Бусад суурь машин, төхөөргийн операторч**
  - 8181 **Шил болон керамикийн зуухны операторч**
  - 8182 **Уурын хөдөлгүүр, уурын тогооны операторч**
  - 8183 **Савлах, юүлэх, хаяглах машины операторч**
  - 8189 **Энэ ангилалд ороогүй суурь машин, төхөөрөг ажиллуулагч бусад операторч**
- 82 **Угсрагч**
  - 821 **Угсрагч**
    - 8211 **Машин механизм угсрагч**
    - 8212 **Цахилгаан, цахим төхөөрөмж угсрагч**
    - 8219 **Энэ ангилалд ороогүй бусад угсрагч**
- 83 **Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч**
  - 831 **Зүтгүүрийн машинч, түүнд холбогдох ажилтан**
    - 8311 **Зүтгүүрийн машинч**
    - 8312 **Төмөр замын бэхэлгээчин, дохиочин, шилжүүлэгч**
  - 832 **Машин, тэргэнцэр, бүхээгт тэрэг, мотоциклийн жолооч**
    - 8321 **Мотоциклийн жолооч**
    - 8322 **Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч**
  - 833 **Хүнд даацын машин, автобусны жолооч**
    - 8331 **Автобус, троллейбус, трамвайны жолооч**
    - 8332 **Хүнд даацын машин, том тэрэгний жолооч**
    - 8341 **Зөөврийн ферм, ойн төхөөргийн операторч**
    - 8342 **Газр шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч**
    - 8343 **Операторч, кранч, өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины**
    - 8344 **Операторч, бусад өргөх, татах төхөөрөмжийн**
  - 835 **Усан онгоцны тавцангийн баг, түүнд холбогдох бусад ажилтан**
    - 8350 **Усан онгоцны тавцангийн баг, түүнд холбогдох бусад ажилтан**

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 9

### ЭНГИЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ

---

#### 9 Энгийн ажил, мэргэжил

##### 91 Цэвэрлэгч, туслагч

- 911 Гэр, зочид буудал, албан конторын цэвэрлэгээний ажил
  - 9111 Гэр ахуйн цэвэрлэгээний ажил эрхлэгч, туслагч
  - 9112 Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч, туслагч
- 912 Машин, цонх, хувцас угаалга, бусад гар цэвэрлэгээний ажил
  - 9121 Гар аргаар угаагч, индүүдэгч, хатаагч
  - 9122 Тээврийн хэрэгсэлийн цэвэрлэгч
  - 9123 Цонх цэвэрлэгч
  - 9129 Бусад цэвэрлэгээний ажилтан

##### 92 Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн ажил

- 921 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил
  - 9211 Үр тарианы фермийн ажилтан
  - 9212 Малын фермийн ажилтан
  - 9213 Мал, тариалан хосолсон фермийн ажилтан
  - 9214 Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжүүлэлтийн ажилтан
  - 9215 Ойн аж ахуйн ажилтан
  - 9216 Загасны болон усны аж ахуйн ажилтан

##### 93 Уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил

- 931 Уурхайн болон барилгын ажил
  - 9311 Уурхай, карьерийн ажилтан
  - 9312 Иргэний барилгын туслах ажилтан
  - 9313 Барилга угсралтын туслах ажилтан
- 932 Үйлдвэрийн ажил
  - 9321 Гараар савлах, баглах ажилтан
  - 9329 Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн бусад ажилтан
- 933 Тээвэр, агуулахын ажил
  - 9331 Дугуй, тэргэнцэр жолоодогч
  - 9332 Тэрэгчин, ердийн хөсөгч
  - 9333 Ачаа зөөгч
  - 9334 Тавиур дүүргэгч

##### 94 Хүнс бэлтгэлийн туслах ажил

- 941 Хүнс бэлтгэлийн туслах ажил
  - 9411 Түргэн хоол бэлтгэх ажилтан
  - 9412 Гал тогооны туслах ажилтан

##### 95 Гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил

- 951 Гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил
  - 9510 Гудамжин дахь худалдаа үйлчилгээний ажилтан
- 952 Гудамжинд мухлаг /лангуу ажиллуулагч (хоол хүнсээс бусад)
  - 9520 Гудамжинд мухлаг /лангуу ажиллуулагч (хоол хүнсээс бусад)

- 96 Бусад энгийн ажил
  - 961 Хог хаягдлаар ажиллагч
    - 9611 Хог хаягдлаар ажиллагч, болон дахин боловсруулах хаягдал цуглуулагч
    - 9612 Хог хаягдал ангилагч
    - 9613 Хог шүүрдэгч, адилтгах ажил эрхлэгч
  - 962 Бусад энгийн ажил
    - 9621 Илгээмж хүргэгч, зарлага, ачаа тээш зөөгч
    - 9622 Өвөрмөц /түр ажил/ ажил эрхлэгч
    - 9623 Тоолуурын заалт тэмдэглэгч, автомат мөнгө хураагчаас мөнгө цуглуулагч, бараа, бүтээгдэхүүн нэмж хийгч
    - 9624 Ус зөөгч, түлээ түүгч
    - 9629 Энэ ангилалд ороогүй бусад энгийн ажил, мэргэжил

---

## ҮНДСЭН БҮЛЭГ 0 ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЖИЛ, МЭРГЭЖИЛ

---

- 0 Зэвсэгт хүчний ажил, мэргэжил
  - 01 Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер
    - 011 Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер
      - 0110 **Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер**
        - а) Захирагч
        - б) Штабын дарга
        - в) Албад, тасгийн дарга
        - г) Зэвсэгт хүчний Жанжин штаб
  - 02 Зэвсэгт хүчний ахлагч
    - 021 Зэвсэгт хүчний ахлагч
      - 0210 **Зэвсэгт хүчний ахлагч**
        - а) Удирдах албан тушаалын ахлагч
        - б) Гүйцэтгэх албан тушаалын ахлагч
  - 03 Зэвсэгт хүчний зэрэглэлийн бусад ажил, мэргэжил
    - 031 Зэвсэгт хүчний зэрэглэлийн бусад ажил, мэргэжил
      - 0310 **Зэвсэгт хүчний зэрэглэлийн бусад ажил, мэргэжил**
        - а) Ерөнхий цэрэг
        - б) Инженер
        - в) Холбоо
        - г) Хими
        - д) Зэвсэг
        - е) Зенит
        - ж) Артиллер

- о - О - о -



## V. “ҮАМАТ-08”-ЫН АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

---

### ҮНДСЭН БҮЛЭГ 1 ХУУЛЬ ТОГТООГЧ, УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, МЕНЕЖЕР

---

#### 1 Менежер

Менежер нь засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина.

#### Гүйцэтгэх үүрэг:

Засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллагын зохион байгуулалтын нэгжийн бодлого, төсөв, журмыг боловсруулах, зөвлөгөө өгөх, зорилт тодорхойлж, стандарт тогтоох, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг боловсруулах, үнэлэх, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд эд материалын, хүн хүчний болон санхүүгийн нөөцийг зарцуулах зөвшөөрөл олгох, байгууллага, аж ахуйн нэгж, түүний ажилтны ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, ажилтныг сонгох буюу сонгосон ажилтныг ажилд томилох, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хурал цуглаан, бусад чуулга уулзалтанд засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага буюу түүний зохион байгуулалтын нэгжийг төлөөлөх, тэдгээрийн нэрийн өмнөөс хэлэлцээ хийх.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 11 **Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал**
- 12 **Захиргаа, арилжааны менежер**
- 13 **Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер**
- 14 **Зочид буудал, жижиглэн худалдаа, бусад үйлчилгээний менежер**

## **ДЭД БҮЛЭГ 11**

### **ХУУЛЬ ТОГТООГЧ, УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

---

Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал нь бусад менежерийн дэмжлэгтэйгээр засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх ба бодлого боловсруулж хянана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Хууль тогтоох байгууллага, захирлуудын зөвлөл, хороодын үйл ажиллагааг даргалах, үйл ажиллагаанд нь оролцох, аж ахуйн нэгж, засгийн газар, бусад байгууллагын бодлого, төсөв, хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах, зөвлөгөө өгөх, аж ахуйн нэгж, засгийн газрын харьяа агентлаг буюу газар, бусад байгууллагын зорилтыг тодорхойлох, бодлого, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх дүрэм, журмыг боловсруулах, үнэлэх, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд эд материалын, хүн хүчний болон санхүүгийн нөөцийг зарцуулах зөвшөөрөл олгох, байгууллага буюу аж ахуйн нэгжийн гүйцэтгэлийг хянах, үнэлэх, ахлах тушаалын албан хаагчийг сонгох буюу сонгосон албан хаагчийг томилох, ёслолын үүрэг гүйцэтгэх, албан ёсны үйл ажиллагаа, хурал, хэлэлцээ, цуглаан, олон нийтийн арга хэмжээнд засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, буюу хамт олныг төлөөлөх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**111 Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан**

**112 Захирал, гүйцэтгэх захирал**

## **БАГА БҮЛЭГ 111**

### **ХУУЛЬ ТОГТООГЧ, УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН**

---

Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан нь Засгийн газар болон аймаг, нийслэлийн, бүсийн, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нийгэмлэг, тусгай сонирхол бүхий байгууллагын бодлогыг тодорхойлох, зөвлөх ба бодлогын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх үйл ажиллагаа эрхэлнэ. Тэдгээр нь хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг

боловсруулах, батламжлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох, засгийн газрын агентлаг, газар, уламжлалт нийгэмлэг, тусгай сонирхол бүхий байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хянах, үнэлэх үйл ажиллагаа явуулна.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Хууль тогтоох байгууллага, төрийн захиргааны зөвлөл, хууль тогтоох чуулган, ороннутгийн нийгэмлэг, болон тусгай сонирхол бүхий байгууллагын үйл ажиллагааг удирдах буюу оролцох, төрийн захиргааны зөвлөл буюу албан ёсны хороодод орж ажиллах, нийтийн ашиг сонирхлын асуудлуудыг шалган судлах, сонгогчдын эрх ашгийг дэмжих, төрийн бодлого, төсөв, хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах, зөвлөх, байгууллагын зорилгыг тодорхойлох, бодлого, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх дүрэм журмыг боловсруулах, батлах, үнэлэх, өргөн барьсан баримт бичиг, товч мэдээлэл, илтгэл тайланг батлах, үнэлэх, хянах, зөвлөмж өгөх, төсвийг хянахын тулд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх, нийтийн эзэмшлийн газар, бусад нөөц баялгийг хуваарилах, ёслолын үүрэг гүйцэтгэх, албан ёсны үйл ажиллагаа, хурал, хэлэлцээ, цуглаан, олон нийтийн арга хэмжээнд засгийн газар, байгууллага, хамт олныг төлөөлөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1111 Хууль тогтоогч**

**1112 Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан**

**1113 Өөрөө удирдах нутгийн захиргааны байгууллагын  
Засаг дарга, Захирагч, бусад удирдах албан тушаалтан**

**1114 Тусгай сонирхол бүхий байгууллагын удирдах  
албан тушаалтан/ улс төр, олон нийтийн, ТББ/**

### **1111 ХУУЛЬ ТОГТООГЧ**

Хууль тогтоогч нь үндэсний болон аймаг, нийслэл, бүсийн ба орон нутгийн засаг захиргааны байгууллага, засгийн газар хоорондын бодлогыг тодорхойлох, боловсруулах, удирдан чиглүүлэх, мөн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг гаргах, батламжлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах ба хүчингүй болгох үйл ажиллагаа явуулна. Хууль тогтоогчдод парламент, зөвлөл, засгийн газрын сонгогдсон ба сонгогдоогүй гишүүд орно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хууль тогтоох байгууллага, засгийн газар болон аймаг, нийслэл, бүсийн, орон нутгийн засаг захиргааны зөвлөл, хууль тогтоох чуулганы хуралдааныг даргалах эсвэл түүнд оролцох,
- б) үндэсний болон аймаг, нийслэлийн, бүсийн, орон нутгийн засаг захиргаанаас баримтлах бодлогыг тодорхойлох, боловсруулах ба удирдан чиглүүлэх,
- в) үндсэн хуульд нийцүүлэн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг гаргах, батламжлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл хүчингүй болгох,
- г) төрийн захиргааны зөвлөл, албан ёсны хороодод орж ажиллах,
- д) нийтийн ашиг сонирхлын асуудлыг шалгаж судлах, өөрийн төлөөлж буй сонгогчдын ашиг сонирхлыг хамгаалах,
- е) олон нийтийн үйл ажиллагаа, хурал цуглаанд оролцох, олон нийтийн санаа бодлыг ойлгох, засгийн газрын төлөвлөгөөний талаар мэдээлэх,
- ж) ашиг сонирхлын зөрүүг ойртуулах, бодлого гаргах, тохиролцоонд хүрэх зорилгоор бусад хууль тогтоогчид, ашиг сонирхлын бүлгийн төлөөлөгчидтэй хэлэлцээ хийх,
- з) засгийн газрын гишүүний хувьд, засгийн газрын байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтан, ажилтанд засгийн газраас явуулж буй бодлогыг тайлбарлах, хэрэгжүүлэхэд нь чиглэл өгөх,
- и) холбогдох бусад үүргийг гүйцэтгэх.

**Энэ ангилалд хамаарах албан тушаалтны жишээ:**

- Аймаг, нийслэлийн хурлын дарга, төлөөлөгч
- Засгийн газрын гишүүн, сайд
- Аймаг, нийслэлийн засаг дарга, захирагч
- УИХ-ын гишүүн
- Улсын Ерөнхийлөгч

**1112 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН**

Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан нь засаг захиргааны байгууллагад бодлогын чанартай асуудлаар зөвлөгөө өгөх, засгийн газрын агентлаг болон холбогдох байгууллагын төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гадаад орнуудад улсаа төлөөлөх, эсвэл эдгээртэй ижил төстэй үүргийг засгийн газар хоорондын байгууллагад гүйцэтгэнэ. Мөн засгийн газар, хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль тогтоомж, бодлогод нийцүүлэн аймаг, нийслэлийн, орон нутгийн, бүс нутгийн засаг захиргааны болон Засгийн газар, түүний харьяа



байгууллага, зөвлөл, агентлаг буюу комиссийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хянах, үнэлэх үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) засгийн газар болон аймаг, нийслэлийн, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа, хууль тогтоогчдод бодлогын чанартай асуудлаар зөвлөгөө өгөх,
- б) засгийн газрын төсөв, хууль тогтоомж, тэдгээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах талаар зөвлөгөө өгөх,
- в) засгийн газрын байгууллага буюу агентлагын зорилтыг хууль тогтоомж, засгийн газрын бодлогод нийцүүлэн тодорхойлох,
- г) засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх журам, хөтөлбөрийг засгийн газартай зөвшилцөн боловсруулах, батлах, үнэлэх,
- д) дунд тушаалын менежер, ахлах ажилтнуудын өргөн барьсан баримт бичиг, товч мэдээлэл, илтгэл тайланг батлах, үнэлэх, хянах, зөвлөмж өгөх,
- е) төсвийн хяналтыг хэрэгжүүлэхэд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх,
- ж) төрийн байгууллагын бусад ахлах менежер, албан хаагчтай үйл ажиллагаагаа уялдуулах,
- з) хууль тогтоох болон засгийн газрын бусад хороодод бодлого, хөтөлбөр, төсвийн талаар танилцуулга хийх,
- и) засгийн газрын болон засаг захиргааны байгууллага, агентлагаас төрийн бодлого, хууль тогтоомжийг тайлбарлах, хэрэгжүүлэхэд хяналт тавих,
- к) холбогдох бусад үүргийг гүйцэтгэх.

**Энэ бүлэгт хамаарах албан тушаалтны жишээ:**

- Элчин сайд
- Хотын захирагч
- Төрийн албаны зөвлөлийн гишүүн
- Ерөнхий консул
- Дарга, засгийн газрын агентлагын
- Ерөнхий байцаагч, төрийн захиргааны байгууллагын
- Дарга, цагдаагийн газрын
- Төрийн нарийн бичгийн дарга, төрийн захиргааны байгууллагын

**Тайлбар:**

Төрийн өмчийн үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлыг 1120 дугаар нэгж бүлэг буюу “Захирал, гүйцэтгэх захирал” гэсэн бүлэгт хамруулсан.

### **1113 ӨӨРӨӨ УДИРДАХ НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГ ДАРГА, ЗАХИРАГЧ, БУСАД УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН**

Өөрөө удирдах нутгийн захиргааны байгууллагын Засаг дарга, захирагч нь уламжлалт ёс заншил болон орон нутгийн, бүсийн засаг захиргаа, Засгийн газрын эрх барих байгууллагын хоорондох эрх, үүрэг, хариуцлагын хуваарилалтаар тодорхойлогдсон хууль тогтоох, засаг захиргааны болон ёслолын үүрэг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тухайн орон нутаг буюу дүүрэг, сум, баг, хорооны өрх, иргэдэд нийтийн эзэмшлийн газар болон байгалийн бусад нөөц баялгийг ашиглуулахаар хуваарилах,
- б) тухайн орон нутаг, засаг захиргааны нэгжийн хэмжээнд үйлдвэрлэсэн нэмүү бүтээгдэхүүнийг цуглуулах ба хуваарилах,
- в) тухайн орон нутгийн оршин суугчдын хооронд гарсан маргааныг шийдвэрлэх,
- г) дүрэм, журам, ёс заншил зөрчсөн орон нутгийн иргэдэд хариуцлага ногдуулах,
- д) уламжлалт баярын үеэр ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах,
- е) орон нутаг буюу засаг захиргааг орон нутгийн болон бүс нутгийн зөвлөлд төлөөлөх,
- ж) өөрөө удирдах байгууллагын хүн ам, оршин суугчдад засгийн газраас явуулж буй бодлого, дүрэм журам, хууль тогтоомжийн талаар мэдээлэх,
- з) бусад ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих,
- и) холбогдох бусад үүрэг гүйцэтгэх.

#### **Энэ бүлэгт хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Орон нутгийн засаг дарга
- Хот, тосгоны захирагч

### **1114 ТУСГАЙ СОНИРХОЛ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН /УЛС ТӨР, ОЛОН НИЙТИЙН, ТББ/**

Тусгай сонирхол бүхий байгууллагын удирдах албан тушаалтан нь улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчийн байгууллага, худалдаа, аж үйлдвэрийн холбоо, хүмүүнлэгийн болон буяны байгууллага, спортын холбоо зэрэг тусгай сонирхол бүхий байгууллагын бодлогыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжилтийг нь удирдан чиглүүлэх, түүнийг төлөөлөх, нэрийн өмнөөс нь үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) байгууллагын бодлого, дүрэм журмыг тодорхойлох, боловсруулах,
- б) байгууллагын ерөнхий үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах,
- в) байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг захирлуудын болон удирдах зөвлөл, гишүүд, санхүүжүүлэгч байгууллагад тайлагнах,
- г) байгууллага, түүний гишүүд болон холбогдох тусгай сонирхол бүхий бүлгүүдийн өмнөөс хэлэлцээ хийх,
- д) хууль тогтоох байгууллага, засгийн газрын бодлого, хөтөлбөрийн талаар тусгай сонирхол бүхий бүлгийн ашиг сонирхлыг олон нийтийн өмнө илэрхийлэх,
- е) хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдан чиглүүлэх,
- ж) үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхэд тохирох тогтолцоо, журмыг боловсруулж хэрэгжүүлэх,
- з) нэгжийн зорилт, хариуцлагын гүйцэтгэлийг хянах, үнэлэх,
- и) албан ёсны үйл явдал, зөвлөлийн хурал, хэлэлцээ, цуглаан, олон нийтийн арга хэмжээ, чуулганд байгууллагаа төлөөлөх.

**Энэ бүлэгт хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Улс төрийн намын удирдах ажилтан
- Ажил олгогч, эздийн болон ажилтны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллага ба эдийн засгийн сонирхол бүхий бусад байгууллагын удирдах ажилтан
- Хүмүүнлэгийн болон тусгай сонирхол бүхий байгууллагын удирдах ажилтан

**БАГА БҮЛЭГ 112  
ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Захирал, гүйцэтгэх захирал нь үйл ажиллагаагаа хариуцан тайлагнадаг захирлуудын зөвлөл буюу удирдах зөвлөлөөс тогтоож өгсөн чиглэлийн хүрээнд бусад менежерийн туслалцаа дэмжлэгтэйгээр (тусгай сонирхол бүхий байгууллага болон засгийн газрын агентлагаас бусад) аж ахуйн нэгж, байгууллагын бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хянах, тэдгээрийн ерөнхий үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах болон үнэлэх үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг хянах,

захирлуудын зөвлөл буюу удирдах зөвлөлд тайлагнах, аж ахуйн нэгж, байгууллагын зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, байгууллагыг ерөнхий удирдлага, чиглэлээр хангах, төсөв батлах, удирдах, зардлыг хянах, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах, байгууллагын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд эд материал, хүн хүчний болон санхүүгийн нөөцийг зарцуулах, зорилт, бодлогын дагуу аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, зөвлөмж, тайланг судлах, албан ёсны үйл явдал, хэлэлцээ, хурал цуглаан, олон нийтийн арга хэмжээнд байгууллагаа төлөөлөх, ахлах ажилтныг сонгох, сонгосон ажилтныг томилох, байгууллага нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэхэд анхаарах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **1120 Захирал, гүйцэтгэх захирал**

#### **1120 ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

##### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах, үр дүнг хянах, захирлуудын зөвлөл буюу удирдах зөвлөлд тайлагнах,
- б) аж ахуйн нэгж, байгууллагын зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох,
- в) байгууллагыг ерөнхий удирдлага, чиглэлээр хангах,
- г) төсөв батлах, удирдах, зардлыг хянах, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- д) байгууллагын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд эд материал, хүн хүчний болон санхүүгийн нөөцийг зарцуулах,
- е) зорилт, бодлогын дагуу аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэлийг хянах, үнэлэх,
- ж) ахлах ажилтантай зөвлөж, зөвлөмж, тайланг судлах,
- з) албан ёсны үйл явдал, хэлэлцээ, олон нийтийн арга хэмжээ, хурал чуулганд байгууллагаа төлөөлөх,
- и) ажилтныг сонгох буюу сонгосон ажилтныг ажилд томилох,
- к) холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд анхаарах.

##### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ерөнхий захирал
- Гүйцэтгэх захирал
- Бүсийн менежер

**Тайлбар:**

Өөр өөр чиг үүрэг бүхий менежерүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж хянадаг бүсийн болон бусад Ерөнхий менежерийг 1120 дугаар нэгж бүлэг буюу “Захирал, гүйцэтгэх захирал” гэсэн нэгж бүлэгт ангилсан. Газар зүйн тодорхой бүсэд тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг менежерийг энэ нэгж бүлэгт оруулаагүй. Жишээлбэл, бүсийн борлуулалтын менежерийг 1221 дүгээр нэгж бүлэг буюу “Борлуулалт, маркетингийн менежер” гэсэн нэгж бүлэгт оруулсан болно. Нэг буюу хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын захирлуудын зөвлөлийн гишүүнээр давхар ажилладаг албан тушаалтныг түүнчлэн, төрийн өмчийн үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирлыг 1120 дугаар нэгж бүлэг буюу “Захирал, гүйцэтгэх захирал” гэсэн нэгж бүлэгт ангилсан болно.

**ДЭД БҮЛЭГ 12****ЗАХИРГАА, АРИЛЖААНЫ МЕНЕЖЕР**

Захиргаа, арилжааны менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, захиргаа, хүний нөөц, бодлого, төлөвлөлт, судалгаа, хөгжил, зар сурталчилгаа, олон нийтийн харилцаа, худалдаа, маркетингийн үйл ажиллагааг эрхлэхийн сацуу бусад нэгжид ийм үйлчилгээ үзүүлдэг нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдан чиглүүлэх, хянах ба зохицуулах үйл ажиллагаа явуулна.

Энэ дэд бүлэгт хамаарагдах ажилтны гүйцэтгэх үүрэгт ихэвчлэн дараах ажил, үүрэг багтана: бодлогын зөвлөгөө өгөх, стратегийн болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааны болон захиргааны дүрэм, журам гаргаж, удирдан чиглүүлэх, стратеги болон бодлогыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шинэ бүтээгдэхүүн, маркетинг, олон нийтийн харилцаа, зар сурталчилгааны ажлыг удирдах, борлуулалтын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний төрөл зүйл, үйлчилгээний стандарт тогтоох, удирдах, үнэ тогтоох, зээлийн хэлэлцээр, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах, боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих, төсөв боловсруулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэх захирал болон бусад газар, хэлтсийн менежерүүдтэй зөвлөлдөх, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах, хэлэлцээ, хурал, олон нийтийн арга хэмжээ, чуулганд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**121 Бизнес үйлчилгээ, захиргааны менежер**

**122 Борлуулалт, маркетинг, судалгаа-хөгжлийн менежер**

**БАГА БҮЛЭГ 121****БИЗНЕС ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАХИРГААНЫ МЕНЕЖЕР**

---

Бизнес үйлчилгээ, захиргааны менежер нь байгууллагын санхүү, захиргаа, хүний нөөц, бодлого, төлөвлөлт, судалгаа, зар сурталчилгаа, олон нийтийн харилцаа, худалдаа, маркетингийн үйл ажиллагаа болон бусад байгууллага, үйлдвэрийн газарт үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах, удирдах, хянан зохицуулах үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Бодлогын зөвлөгөө өгөх, стратегийн болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааны болон дүрэм, журам гаргах, удирдан чиглүүлэх, стратеги болон бодлогыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ахлах менежерүүд болон зөвлөлийн гишүүдэд санхүү, захиргаа, стратеги, бодлого, хөтөлбөр, хууль эрх зүйн асуудлаар зөвлөх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах, боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих, төсөв боловсруулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэх захирал болон бусад газар, хэлтсийн менежерүүдтэй зөвлөлдөх, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах, хэлэлцээ, хурал, олон нийтийн арга хэмжээ, чуулганд аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1211 Санхүүгийн менежер**

**1212 Хүмүүний нөөцийн менежер**

**1213 Бодлого, төлөвлөлтийн менежер**

**1219 Бизнес үйлчилгээ, захиргааны менежер (өөр газар ангилагдаагүй)**

**1211 САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР**

Санхүүгийн менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ахлах менежер, бусад газар, хэлтсийн менежерүүдтэй зөвлөлдөн төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

а) аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах,

- б) аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн байдлыг үнэлэх, төсөв боловсруулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих,
- в) гүйцэтгэх захирал болон бусад газар, хэлтсийн менежерүүдтэй зөвлөлдөх,
- г) төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- д) үйл ажиллагааны болон захиргааны журам тогтоож, удирдан чиглүүлэх,
- е) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- ж) боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих,
- з) бусад байгууллагатай харилцахад байгууллагаа төлөөлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Захиргааны менежер
- Компаний нарийн бичгийн дарга
- Санхүүгийн менежер

**Өөр газар ангилсан зарим холбогдох ажил, мэргэжил:**

- 1346 Санхүү, даатгалын үйлчилгээний менежер
- 2411 Нягтлан бодогч

**1212 ХҮМҮҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖЕР**

Хүмүүний нөөцийн менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын боловсон хүчний болон хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлогыг төлөвлөх, удирдан зохицуулах ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) аж ахуйн нэгж, байгууллагын боловсон хүчний болон хөдөлмөрийн харилцааны бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийг төлөвлөх, удирдах, зохицуулах,
- б) ажилтан ажилд авах, сургах, албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, ажлаас халах журам боловсруулах, зохион байгуулах,
- в) цалин хөлсний бүтэц болон түвшинг тогтоох хэлэлцээг төлөвлөх, зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийн талаар ажилтантай зөвлөлдөх журам боловсруулах, зохион байгуулах,
- г) аюулгүй байдал, эрүүл ахуйн, тэдгээртэй холбогдох хөтөлбөр, үйл ажиллагаанд хяналт тавих,
- д) төсөв зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- е) үйл ажиллагааны болон захиргааны журам тогтоох ба удирдах,
- ж) удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх, хэрэгжүүлэх ажилд хяналт тавих,

# 1 ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

- з) ажилтны хөдөлмөрлөх эрх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, тэгш боломж олгох, холбогдох стандарт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах,
- и) аж ахуйн нэгж, байгууллагын боловсон хүчний сонголт, сургалт түүний гүйцэтгэлд хяналт тавих,
- к) менежер, бусад холбогдох менежерүүдтэй зөвлөлдөх,
- л) бусад байгууллагатай харилцахад байгууллагаа төлөөлөх.

## **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хөдөлмөрийн харилцааны менежер
- Боловсон хүчний менежер
- Ажилтан элсүүлэх, сонгох менежер

## **1213 БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖЕР**

Бодлого, төлөвлөлтийн менежер нь төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын бодлогын зөвлөгөө, стратегийн төлөвлөлтийн үйл ажиллагааг эрхлэх, зохион байгуулах, удирдах, зохицуулах ба бодлого, стратегийн төлөвлөлтийн үйлчилгээ үзүүлдэг нэгжийн үйл ажиллагааг удирдана.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) зорилго, зорилт, ажлын стандартыг хангах стратегийн төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр, үйл явц, тогтолцоо болон журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах,
- б) бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд оролцох, тэдгээрийг хөгжүүлэх, удирдах,
- в) бодлогын хэрэгжилтийг зохицуулах,
- г) үйл ажиллагааны шалгуур, хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох,
- д) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- е) бодлого боловсруулах болон стратегийн төлөвлөлтийн ажилтныг удирдах, манлайлах,
- ж) боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих,
- з) хэлэлцээ, хурал, олон нийтийн арга хэмжээ, чуулганд байгууллагыг төлөөлөх.

## **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бодлогын менежер
- Стратегийн төлөвлөлтийн менежер
- Ерөнхий төлөвлөлтийн менежер



## **1219 БИЗНЕС ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАХИРГААНЫ МЕНЕЖЕР /ӨӨР ГАЗАР АНГИЛАГДААГҮЙ/**

Энэ нэгж бүлэгт 121 дүгээр бага бүлэг буюу “Бизнес үйлчилгээ, захиргааны менежер” гэсэн бүлэгт ороогүй бизнес үйлчилгээ, захиргааны менежер хамрагдана. Тухайлбал, эд аж ахуйн менежер, цэвэрлэгээ үйлчилгээний менежер, захиргаа, үйлчилгээний менежер зэрэг ажил, мэргэжил багтана.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) захиргаа, бизнес үйлчилгээний менежментийн асуудлаар бусад менежерүүдэд стратегийн төлөвлөлт, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, судалгаа, зөвлөгөөгөөр хангах,
- б) байгууллагын материаллаг нөөцийг хөгжүүлэх, удирдах,
- в) ажилтанд зориулсан захиргааны болон дэг журмын мэдэгдэл, зааврыг боловсруулж хэрэгжүүлэх,
- г) байгууллагын нөөцийн менежментийн цогц асуудалд дүн шинжилгээ хийх, холбогдох тайлан, бичиг баримтыг бэлтгэх,
- д) санхүүгийн тайлан, төсөв гаргахад мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх,
- е) ажилтны үйл ажиллагаагааг хэвийн явуулах болон үнэн бодьтой, цагаа үеийн мэдээллээр хангахад нь манлайлах, удирдах,
- ж) хэлэлцээ, хурал, олон нийтийн арга хэмжээ, чуулганд байгууллагаа төлөөлөх,
- з) төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- и) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- к) боловсон хүчний сонголт, сургалтын гүйцэтгэлд хяналт тавих.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Захиргаа, үйлчилгээний менежер
- Цэвэрлэгээ үйлчилгээний менежер
- Нийтлэг үйлчилгээний менежер
- Эд аж ахуйн менежер
- Худалдан авалтын менежер

## **БАГА БҮЛЭГ 122**

## **БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГ, СУДАЛГАА-ХӨГЖЛИЙН МЕНЕЖЕР**

Борлуулалт, маркетинг, судалгаа-хөгжлийн менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын зар сурталчилгаа, олон нийттэй харилцах, судалгаа ба

# 1 ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

хөгжил, борлуулалт, маркетингийн үйл ажиллагаа болон ийм үйлчилгээ үзүүлдэг бусад харъяа нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хянаж зохицуулах ажиллагаа явуулна.

## **Гүйцэтгэх үүрэг:**

Бусад менежертэй зөвлөлдөн зар сурталчилгаа, олон нийттэй харилцах, бүтээгдэхүүн шинээр гаргах, борлуулалт, маркетингийн бодлого, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, шинжлэх ухааны үндэстэй судалгааны санаачлагыг хөгжүүлэх ажлыг удирдан чиглүүлэх, маркетинг, олон нийтийн харилцаа, зар сурталчилгааны кампанит ажил, борлуулалтын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний төрөл зүйл, үйлчилгээний стандарт, борлуулалт-түгээлтийн бодлогыг тодорхойлох, удирдан чиглүүлэх, үнэ тогтоох, зээлийн хэлэлцээр, төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах, боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих, хурал, үзэсгэлэн худалдаа болон бусад чуулга уулзалтанд байгууллагаа төлөөлөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **1221 Борлуулалт, маркетингийн менежер**

### **1222 Сурталчилгаа, олон нийттэй харилцах менежер**

### **1223 Судалгаа-хөгжлийн менежер**

## **1221 БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР**

Борлуулалт, маркетингийн менежер нь байгууллагын борлуулалт, маркетингийн үйл ажиллагаа болон ийм үйлчилгээ үзүүлдэг харъяа нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах зохицуулах үүрэгтэй.

## **Гүйцэтгэх үүрэг:**

- а) борлуулалтын бүртгэл, зах зээлийн үнэлгээнд үндэслэн борлуулалтын болон маркетингийн тусгай хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах,
- б) үнийн жагсаалт, хямдрал, хүргэлтийн нөхцөл, борлуулалтыг урамшуулах төсөв, борлуулах арга, тусгай урамшил болон кампанит ажил зэргийг тодорхойлох,
- в) борлуулалт, маркетингийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны болон захиргааны журам тогтоох, удирдах,
- г) борлуулалт болон маркетингийн ажилтны үйл ажиллагааг удирдах, манлайлах,

- д) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- е) төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- ж) боловсон хүчний сонголт, сургалтын гүйцэтгэлд хяналт тавих,
- з) борлуулалт болон маркетингийн асуудлаарх хурал, үзэсгэлэн худалдаа, бусад чуулга уулзалтанд байгууллагаа төлөөлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Маркетингийн менежер
- Борлуулалтын менежер

**1222 ЗАР СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР**

Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын сурталчилгаа, олон нийтийн харилцаа, олон нийтийн мэдээллийн болон өөрийн бусад аж ахуйн нэгж, байгууллагад үүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) аж ахуйн нэгж, байгууллагын зар сурталчилгаа, олон нийттэй харилцах ажлыг төлөвлөх, удирдах, зохицуулах,
- б) үйлчлүүлэгч буюу сонин, радио, телевиз, спорт, соёлын байгууллагууд болон зар сурталчилгааны агентлагуудтай сурталчилгааны ажлын гэрээ хийх,
- в) аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөсөн зорилтын биелэлт, санал бодлын талаар хууль тогтоогч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон нийтэд хүргэх мэдээллийн хөтөлбөрийг төлөвлөх, удирдах,
- г) сурталчилгаа, олон нийттэй харилцах ажилтны үйл ажиллагааг удирдах, манлайлах,
- д) төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- е) үйл ажиллагааны болон захиргааны журам тогтоож, удирдан чиглүүлэх,
- ж) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- з) боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зар сурталчилгааны менежер
- Олон нийттэй харилцах менежер

### **1223 СУДАЛГАА-ХӨГЖЛИЙН МЕНЕЖЕР**

Судалгаа-хөгжлийн менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа, хөгжлийн асуудал, үүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг харъяа нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах ба зохицуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) технологийн процесс, шинэ бүтээгдэхүүн, мэдлэг, материалашиглалтыг сайжруулах зорилгоор дотоодын болон гадны байгууллагаар захиалан хийлгэж буй судалгаа, хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулах.
- б) аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа-хөгжлийн хөтөлбөрийг бүхэлд нь төлөвлөх, түүнд тавигдах зорилго болон төсвийн шаардлагуудыг тодорхойлох,
- в) судалгаа, хөгжлийн ажилтны үйл ажиллагааг удирдах, манлайлах,
- г) төсөв баталж, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- д) үйл ажиллагааны болон захиргааны журам тогтоох, удирдан чиглүүлэх,
- е) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах,
- ж) боловсон хүчний сонголт, сургалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих,
- з) хурал цуглаан, бусад уулзалтанд байгууллагаа төлөөлөх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бүтээгдэхүүний хөгжлийн менежер
- Судалгааны менежер

---

## **ДЭД БҮЛЭГ 13 ҮЙЛДВЭРЛЭЛ, ТӨРӨЛЖСӨН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

---

Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер нь аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тусгай мэргэжлийн ба техникийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах үүрэг хүлээнэ.

Тэд боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилга, мэдээлэл харилцааны технологи, хөдөө аж ахуй, ойн ба загасны аж ахуйн өргөн

цар хүрээтэй үйл ажиллагаа, түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, банк, даатгал, техникийн зэрэг төрөлжсөн үйлчилгээг хариуцна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, ажиллах хүчин зэргийг нарийвчлан төлөвлөх, стандарт тогтоох, зорилт, хариуцлагыг тодорхойлох, үйлдвэрийн үйл ажиллагаа, технологийн процесст хяналт тавих, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын баталгааг хангах, тендер болон гэрээний төсөл бэлтгэх, төсөв батлах, удирдах, өртөг зардлыг хянах, зардлыг бууруулахын тулд үйл ажиллагааны явц, нөөцийг тохируулан өөрчлөх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулахад хяналт тавих, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, стандарт, шаардлагын хэрэгжилтийг зохицуулах, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих, тайлан, төсөв, прогноз бэлтгэх ажлыг зохион байгуулах, хэлэлцээ хийх, хурал зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээ, чуулганд байгууллагаа төлөөлөх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 131 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын үйлдвэрлэлийн менежер**
- 132 Боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилгын болон хангамж, түгээлтийн менежер**
- 133 Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер**
- 134 Мэргэшлийн үйлчилгээний менежер**

**Тайлбар:**

Үндсэн 2 дугаар бүлэг буюу “Мэргэжилтэн”, үндсэн 3 дугаар бүлэг буюу “Техникч ба туслах/дэд мэргэжилтэн” гэсэн бүлэгт ангилсан ажил, мэргэжлийн хувьд ихэвчлэн тусгай мэргэшил, мэргэшлийн өндөр ур чадвар, туршлага шаардана.

**БАГА БҮЛЭГ 131  
ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС АГНУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
МЕНЕЖЕР**

Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын үйлдвэрлэлийн менежер нь тариа тарих, хураах, мал, загас, өсгөж үржүүлэх, загас барих, цуглуулах үйл ажиллагаа эрхэлдэг компани, хоршоо, тариалангийн болон бэлчээрийн аж ахуй зэрэг хөдөө аж ахуй, цэцэрлэгжүүлэлт, ойн, усны амьтан

үржүүлгийн ба загасны аж ахуйн томоохон хэмжээний үйл ажиллагааны үйлдвэрлэлийг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулна.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээний шаардлага болон зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг хангахын тулд үйлдвэрлэлийг төлөвлөх, төсөв баталж удирдах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг хянах, фермийн болон загасны аж ахуйн менежментийн үйл ажиллагаа зэрэг мэдээллийг цуглуулах, санхүүгийн тайлан бэлтгэх, үр тариа, загас, мал худалдах асуудлаар худалдан авагчтай хэлэлцээ хийх, үйлдвэрлэлийн менежментийн асуудлаар фермч, багийн ахлагч менежер болон бие даан эзэмшигчтэй гэрээ байгуулах, үйл ажиллагааны төрөл, эрчим, дэс дарааллыг төлөвлөх, машин, тоног төхөөрөмж, хангамжийн зүйлсийг худалдан авах, хүрээлэх орчныг хордуулагч бодис, зэрлэг ургамал, хортон шавьж, тэднээс гаралтай өвчнийг судлах, хяналт тавих, барилга, усан хангамжийн систем, тоног төхөөрөмжийг арчилж тордох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, ажилтан болон гэрээлэгчийн сонголт, сургалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1311 Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйлдвэрлэлийн менежер**

**1312 Усны амьтан үржүүлэг, загасны аж ахуйн үйлдвэрлэлийн менежер**

### **1311 ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕНЕЖЕР**

Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйлдвэрлэлийн менежер нь тариа тарих, мал өсгөж үржүүлэх, тариалангийн газар, мал аж ахуйн ферм, компани, хөдөө аж ахуйн хоршоолол зэрэг хөдөө аж ахуй, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн томоохон хэмжээний үйл ажиллагааны үйлдвэрлэлийг төлөвлөж, удирдан зохицуулна.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөө аж ахуйн ба ойн аж ахуйн зах зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээний шаардлагууд болон зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг хангахын тулд үйлдвэрлэлийг төлөвлөх,
- б) төсөв батлах, удирдах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг хянах, фермийн болон загасны аж ахуйн менежментийн үйл ажиллагаа зэрэг мэдээллийг бүртгэх, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан бэлтгэх,

- в) үр тариа, загас, мал худалдах асуудлаар худалдан авагчидтай хэлэлцээ хийх,
- г) бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн менежментийн асуудлаар фермер, багийн ахлагч менежер болон бие даан эзэмшигчтэй гэрээ байгуулах,
- д) аж ахуйн үйл ажиллагааны төрөл, эрчим, дэс дарааллыг төлөвлөх (тариа тарих, хор цацах, ургац хураах хамгийн тохиромжтой хугацааг тодорхойлох),
- е) бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардагдах бордооны төрөл, тоо хэмжээг тодорхойлохын тулд хөрсийг шинжлэх,
- ж) трактор, үр, бордоо, химийн бодис зэрэг машин, тоног төхөөрөмж, хангамжийн зүйлсийг худалдан авах,
- з) байгаль орчныг хордуулагч бодис, зэрлэг ургамал, хортон шавьж, өвчнийг таних, хяналт тавих,
- и) барилга, усан хангамжийн систем, тоног төхөөрөмжийг арчилж тордох зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах,
- к) тариалах, усжуулах, химийн бодис хэрэглэх, ургац хураах, ангилах зэрэг үйл ажиллагааг удирдах, зохицуулах,
- л) үр тариа боловсрох хугацааг тодорхойлох, цаг агаарын улмаас гарч болзошгүй үр тарианы эрсдлийг тооцоолохын тулд тариалангийн газар, талбайг шалгах,
- м) ажилтан болон гэрээлэгчдийн сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ойн аж ахуйн менежер
- Тариалангийн менежер
- Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн ба загасны аж ахуй, мал эмнэлэг, биотехнологийн үйлдвэрлэл, үйлчилгээний алба, хэлтэс, тасгийн менежер
- Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн ба загасны аж ахуй, мал эмнэлэг, биотехнологийн үйлдвэрлэлийн захиргааны алба, хэлтэс, тасгийн менежер
- Биотехнологийн үйлдвэрлэл, үйлчилгээний албаны дарга, ерөнхий технологич, ерөнхий инженер

**1312 УСНЫ АМЬТАН ҮРЖҮҮЛЭГЧ, ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕНЕЖЕР**

Усны амьтан, загасны аж ахуйн үйлдвэрлэлийн менежер нь загас барих, цуглуулах, загас өсгөж үржүүлэх, загасны аж ахуйн томоохон

хэмжээний үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) загасны аж ахуйн зах зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээний шаардлагууд болон зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэл, загас агнуурын үйл ажиллагааг төлөвлөх,
- б) төсөв батлах, удирдах, үйлдвэрлэлийн зардлыг хянах, загасны аж ахуйн менежмент зэрэг мэдээллийг цуглуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан бэлтгэх,
- в) бүтээгдэхүүн, барьсан загасаа худалдах асуудлаар худалдан авагчтай хэлэлцээ хийх,
- г) загас агнуурын болон үржүүлгийн аж ахуйн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн менежментийн асуудлаар хөлөг онгоцны ахмад буюу эзэмшигчтэй гэрээ байгуулах,
- д) өвчин, шимэгч хорхойг танихын тулд усны амьтан үржүүлгийн ба загасны аж ахуйн нөөцөд үзлэг хийх ажлыг удирдан явуулах, зохион байгуулах,
- е) загасны түрс шахах болон загасны үржлийг нэмэгдүүлэх, үржлийн орчныг өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх,
- ж) загасны амьдрах нөхцөлийг сайжруулахын тулд орчинд хяналт ажиглалт хийх,
- з) загас барих, түрс шахах, түрсийг бойжуулах, зулзаган загасыг өсгөх ажлыг удирдах, хяналт тавих, менежментийн мэдлэг болон загасны аж ахуйн арга барилыг хэрэглэх,
- и) түрс шахах загасны нөөцийг бүрдүүлж сонгох, арчилж тордох ажлыг зохицуулах,
- л) нас гүйцсэн загасыг нуур, цөөрөм, гол, нөөцлүүр саванд шилжүүлэх ажлыг удирдах, хяналт тавих,
- м) хөлөг онгоц, тор зэрэг тоног төхөөрөмж, хангамжийн зүйлсийг худалдан авах,
- н) хөлөг онгоц, завь, тоног төхөөрөмжийг арчилж тордох, засварлах үйл ажиллагааг зохион байгуулах,
- о) загасны аж ахуйн ажилтан, гэрээлэгчийн сонголт, сургалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Загасны үржүүлгийн аж ахуйн үйлдвэрийн менежер
- Загасны аж ахуйн үйл ажиллагааны менежер
- Загас агнуурын хөлөг онгоцны менежер



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

6221	Загасны фермч
6221	Загасны үржүүлгийн менежер
6222	Загас агнуурын хөлөг онгоцны ахмад (эрэг хавийн усны)
6223	Загас агнуурын мастер

**БАГА БҮЛЭГ 132****ҮЙЛДВЭР, УУРХАЙ, БАРИЛГА УГСРАЛТ, ХАНГАМЖ,  
ТҮГЭЭЛТИЙН МЕНЕЖЕР**

Үйлдвэр, уурхай, барилга угсралт, хангамж түгээлтийн менежер нь боловсруулах үйлдвэрлэл, ашигт малтмал олборлох, барилга, хангамж, хадгалалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүтээгдэхүүн, үйлчилгээий чанар, тоо хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, шаардагдах ажиллах хүч зэргээр нь нарийвчлан төлөвлөх, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөх, ажиллуулах цагийг тогтоох, хангалтыг шийдвэрлэх замаар үйлдвэрийн үйл ажиллагаа, чанарын горимд хяналт тавих, тендер болон гэрээний төсөл бэлтгэх, төсөв батлах, удирдах, өртөг зардлыг хянах, зардлыг бууруулахын тулд үйл ажиллагаа, нөөцийг тохируулан өөрчлөх, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулахад хяналт тавих, үйлдвэрлэлийн бүртгэл, тайланг бэлтгэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хянах, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, боловсон хүчний сонголт, сургалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих,

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1321 Боловсруулах үйлдвэрийн менежер**

**1322 Уурхайн менежер**

**1323 Барилгын менежер**

**1324 Хангамж, түгээлт, холбогдох бусад менежер**

### 1321 ҮЙЛДВЭРИЙН МЕНЕЖЕР

Үйлдвэрийн менежер нь томоохон аж ахуйн нэгжийн боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулна.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) үйлдвэрлэлийн стратегийн бодлого, төлөвлөгөөг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих,
- б) үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүтээгдэхүүн гаргалт, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, шаардагдах ажиллах хүчин зэргээр нь нарийвчлан төлөвлөх,
- в) тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөх, ажиллуулах цагийг тогтоох, сэлбэг, багаж хэрэгсэлийн хангалтыг шийдвэрлэх замаар үйлдвэрийн үйл ажиллагаа, чанарын горимд хяналт тавих,
- г) төсөв батлах, удирдах, өртөг зардлыг хянах, зардлыг бууруулахын тулд үйл ажиллагааны хэм хэмжээ, нөөцийг тохируулан өөрчлөх,
- д) үйлдвэрлэлийн асуудлаар бусад менежерүүдтэй зөвлөлдөх, мэдээлэл өгөх
- е) шинэ үйлдвэр, тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулахад хяналт тавих,
- ж) үйлдвэрлэлийн бүртгэл, тайланг бэлтгэх,
- з) хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангах, шинэ машин механизм, тоног төхөөрөмжийг суулгах, авахад хяналт тавих,
- и) бизнесийн нөөц боломжийг илрүүлж, үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг тодорхойлох,
- к) үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, орчин нөхцөлд нөлөөлөх хууль эрх зүйн болон зохицуулалтын стандартыг судлах, хэрэгжүүлэх,
- л) тусгай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үнийн санал гаргах, үйлчлүүлэгчид болон ханган нийлүүлэгчидтэй гэрээ байгуулах,
- м) боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Боловсруулах үйлдвэрийн эзэн
- Боловсруулах үйлдвэрлэлийн менежер
- Үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежер (боловсруулах үйлдвэрлэлийн)

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

3122 Үйлдвэрлэлийн дунд түвшний менежер (боловсруулах үйлдвэрлэлийн)

**1322 УУРХАЙН МЕНЕЖЕР**

Уурхайн менежер нь ил ба далд уурхайн олборлох үйл ажиллагаа, газрын тос, хий гаргаж авах үйл ажиллагааг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлдвэрлэлийн норм хэмжээг тогтоох, олборлолт явуулах талбайг төлөвлөх, түүхий эдийг салгаж авах бодлого боловсруулахын тулд бусад менежерүүдтэй зөвлөлдөх,
- б) боловсон хүчин, ашиглагдаж буй тоног төхөөрөмж, технологийн хангамжийг тодорхойлохын тулд үйлдвэрлэл явуулж буй талбайн үр ашгийг үнэлэх, шаардлагатай бол ажлын төлөвлөгөө буюу тоног төхөөрөмжийг өөрчлөх,
- в) үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүтээгдэхүүн гаргалт, үйлчилгээ хүргэлтийг чанар, тоо хэмжээ, өртөг зардал, цаг хугацаа, шаардагдах ажиллах хүчин зэргээр нь нарийвчлан төлөвлөх,
- г) тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөх, ажиллуулах цагийн горим тогтоох, хангалтыг шийдвэрлэх замаар үйлдвэрийн үйл ажиллагаа, чанарт хяналт тавих,
- д) төсөв батлах, удирдах, өртөг зардлыг хянах, зардлыг бууруулахын тулд үйл ажиллагаа, хэм хэмжээ, нөөцийг тохируулан өөрчлөх,
- е) үйлдвэрлэлийн асуудлаар бусад менежерүүдтэй зөвлөлдөх, мэдээлэл өгөх
- ж) шинэ үйлдвэр, тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулахад хяналт тавих,
- з) үйлдвэрлэлийн бүртгэл, тайланг бэлтгэх,
- и) хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг зохицуулах, шинэ машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, худалдаж авахад хяналт тавих,
- к) ашигт малтмал олборлох үйл ажиллагаа, орчин нөхцөлд нөлөөлөх хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагуудыг судлах, хэрэгжүүлэх,
- л) боловсон хүчний сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих.

**Энд ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Уурхайн менежер
- Үйлдвэрийн менежер (уурхайн)
- Үйлдвэрийн менежер (газрын тос, хий гаргаж авах)
- Үйлдвэрийн менежер (ил уурхайн)
- Ил уурхайн менежер

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3121	Уурхайн байцаагч
3121	Уурхайн хянагч
3121	Уурхайн туслах менежер
3121	Ил уурхайн олборлолтын хянагч

**1323 БАРИЛГА УГСРАЛТЫН МЕНЕЖЕР**

Барилга угсралтын менежер нь иргэний байгууламж, барилга, орон сууц барьж байгуулах ажлыг төлөвлөж, удирдан чиглүүлж зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) архитекторын зураг, тодорхойлолтыг унших, тайлбарлах,
- б) ажиллах хүчний нөөц, материал, машин механизм, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, хүргэлтийг зохицуулах,
- в) баталсан төсөв болон хугацаанд нь багтааж барилгыг дуусгахын тулд барилгын үйл явцад оролцож буй барилга захиалагч, үл хөдлөх хөрөнгийн зууч, туслан гүйцэтгэгчтэй хэлэлцээ хийх,
- г) тендер, гэрээний төсөл бэлтгэх,
- д) барилгын талбайн үйл ажиллагааг уялдуулсан хөтөлбөрийг ажиллуулах, хэрэгжүүлэх,
- е) барилгын хууль тогтоомж, ажлын гүйцэтгэл, чанар, өртөг, аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөх,
- ж) төлөвлөгөөг орон нутгийн захиргаанд танилцуулах ажлыг зохион байгуулах,
- з) гэрээгээр барих буюу барилгын төрөлжсөн үйлчилгээний байгууллагуудтай туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулах,
- и) холбогдох эрх бүхий байгууллагуудаар барилгад үзлэг шалгалт хийлгүүлэх,
- к) төсөв батлах, удирдах, зардлыг хянаж, нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах,
- л) боловсон хүчин, туслан гүйцэтгэгчийн сонголт, сургалт, гүйцэтгэлд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Барилга угсралтын менежер
- Төслийн барилгачин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3123	Барилга угсралтын байцаагч
71	Барилгачин

**1324 ХАНГАМЖ, ТҮГЭЭЛТ, ХОЛБОГДОХ БУСАД МЕНЕЖЕР**

Хангамж, түгээлтийн албаны адилтгах бусад менежер нь бараа таваарын хангамж, тээвэрлэлт, хадгалалт болон түгээлттэй холбоотой ажлыг төлөвлөх, удирдах, зохицуулах асуудлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бараа таваарын худалдан авалт, хадгалалт, хуваарилалтын стратегийн төлөвлөлтийн ажлыг эрхлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих
- б) хэрэгцээтэй барааны нийтүүлэлтийг хамгийн бага зардлаар авах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх
- в) худалдааны гэрээ байгуулах, худалдан авч буй бараа таваарын чанарыг шалгах, бараа нийлүүлэгчидтэй үнийн талаар харилцан тохирох
- г) хангамжийн шаардлагад нийцүүлж, эд хогшлын бүртгэлийн системийг хянаж шалгах
- д) нийт бараа таваарыг бүртгэх системийг тогтоож, дахин захиалах, хангах ажлыг боломжтой цагт хийх
- е) бараа таваарын тээвэрлэлтийн стандарт шаардлагатай холбоотой бусад хэлтэс болон үйлчлүүлэгчтэй харилцан холбоотой ажиллах
- ж) худалдан авах, хадгалалт болон хуваарилалтын ажлын бүртгэл хөтлөлт, түүнд хяналт тавих
- з) зардлын төсөв тогтоож хянах, нөөцийг зохистой ашиглах
- и) захиргаа, удирдлагатай холбогдох асуудлыг удирдан зохион байгуулах
- к) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах
- л) боловсон хүчний сонголт, сургалтын ажлын үүргийн биелэлтэнд хяналт тавих

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Логистикийн менежер
- Галт тэрэгний өртөөний мастер
- Хангамж, түгээлтийн менежер
- Хангамж, телехолбооны менежер
- Тээврийн компанийн менежер
- Агуулахын менежер

**БАГА БҮЛЭГ 133****МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

---

Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер нь компьютерийн болон харилцаа холбооны системийн засвар үйлчилгээ, ашиглалт, хэтийн хөгжлийг төлөвлөж, удирдана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Компьютерийн хэрэглээний болон системийн шаардлага, эдгээрийг хангахуйц технологийг тодорхойлох үүднээс хэрэглэгчид, удирдлага, нийлүүлэгчид, техникийн ажилтнуудтай зөвлөлдөх, мэдээлэл, холбооны технологийн (МХТ)-стратеги, бодлого, төлөвлөгөөг боловсруулах, чиглүүлэх, МХТ-ийн нөөцийг шилж сонгох, тавих, хэрэглэгчдэд сургалт явуулах, МХТ-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, ажиллагааны явцад дүн шинжилгээ хийх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, стандарт боловсруулж, биелэлтийн хугацаа товлох, МХТ-ийн системийн аюулгүй байдлыг хангах, системийн задлан шинжээч, программ зохиогч, компьютерийн чиглэлийн бусад ажилтанд ажил хуваарилах, хянах, манлайлах, байгууллагын технологийн хэрэглээ болон хэрэгцээнд үнэлгээ хийх, техник хангамж болон программ хангамжийг шинэчлэх талаар зөвлөмж гаргах, нөөцийн зохистой хэрэглээг хангах, зарлагад хяналт тавих, төсөв батлах, захиран зарцуулах, үйл ажиллагааны болон захиргааны заавар, журам батлах, чиглүүлэх, ажилтныг шалгаруулж авах, сургах, болон ажлынх нь гүйцэтгэлд хяналт тавих, МХТ-той холбоотой хурал, зөвлөгөөн, семинарт аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлөн оролцох.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

**1330 Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер****1330 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Мэдээлэл, холбооны технологи үйлчилгээний менежер нь компьютер, телехолбооны системийн засвар тордолт, ашиглалт, хөгжлийг төлөвлөх, чиглүүлэх, худалдан авах ажлыг зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) компьютерийн хэрэглээний болон системийн шаардлага, эдгээрийг хангахуйц технологийг тодорхойлох үүднээс хэрэглэгчид, удирдлага, нийлүүлэгчид, техникийн ажилтнуудтай зөвлөлдөх,

- б) мэдээлэл, холбооны технологийн (МХТ) стратеги, бодлого, төлөвлөгөөг боловсруулах, чиглүүлэх,
- в) МХТ-ийн нөөцийг сонгон авах, тавьж суурилуулах болон хэрэглэгчдэд сургалт явуулах ажлыг чиглүүлэх,
- г) МХТ-ийн үйл ажиллагааг чиглүүлэх, ажиллагааны явцад дүн шинжилгээ хийх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, стандарт боловсруулж, биелэлтийн хугацаа товлох,
- д) МХТ-ийн системийн аюулгүй байдлыг хангах,
- е) системийн задлан шинжээч, программч, компьютерийн чиглэлийн бусад ажилтны ажлыг хуваарилах, хянах, удирдан манлайлах,
- ж) байгууллагын технологийн ашиглалт, хэрэгцээнд үнэлгээ хийх, техник хангамж болон программ хангамжийг шинэчлэх талаар зөвлөмж гаргах,
- з) нөөцийн зохистой хэрэглээг хангах, зарлагад хяналт тавих, төсөв батлах, захиран зарцуулах,
- и) үйл ажиллагааны болон захиргааны заавар, журмыг батлах, чиглүүлэх,
- к) ажилтныг шалгаруулж авах, сургах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих,
- л) МХТ-той холбоотой хурал, зөвлөгөөн, семинарт аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлөн оролцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хэрэглээний программ хангамж боловсруулах менежер
- Мэдээллийн тэргүүлэх менежер
- Өгөгдлийн сангийн үйл ажиллагааны менежер
- Өгөгдлийн сангийн үйл явцын менежер
- МХТ боловсруулах менежер
- Мэдээллийн системийн захирал
- Мэдээллийн технологийн менежер (МТ-ийн менежер)
- Интернет үйлчилгээ үзүүлэгч
- Сүлжээний менежер

**БАГА БҮЛЭГ 134**

**МЭРГЭШСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Мэргэшсэн үйлчилгээний менежер нь хүүхдийн ясли цэцэрлэг, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсрол болон бусад мэргэшсэн үйлчилгээг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй бөгөөд банк, санхүүгийн болон даатгалын үйлчилгээ эрхэлдэг байгууллагын салбарыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлого боловсруулах, төлөвлөх, зорилт, хариуцлага, стандартын гүйцэтгэлийг тодорхойлох, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр боловсруулах, үйлчилгээ үзүүлэх, нөөцийн зохистой хуваарилалтыг зохицуулах, эцэг эх, удирдах зөвлөл болон санхүүжүүлэгч, олон нийтийн байгууллагын төлөөлөгчид зэрэг холбогдох байгууллагатай харилцах, хамтран ажиллах, зохицуулалт хийх талаар санал солилцох, зарлагад хяналт шинжилгээ хийх, хяналт тавих, ажилтны сонгон шалгаруулалт, сургалт, ажил, үүргийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан, төсөв, прогноз бэлтгэх, юмуу бэлдүүлэх, оролцогч болон бусад байгууллагатай харьцах үед хурал, зөвлөгөөн, гэрээ, хэлцэлд байгууллагаа төлөөлөн оролцох.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

**1341 Хүүхэд асрамжлах үйлчилгээний менежер**

**1342 Эрүүл мэндийн үйлчилгээний менежер**

**1343 Настанг асрамжлах үйлчилгээний менежер**

**1344 Нийгмийн халамжийн менежер**

**1345 Боловсролын менежер**

**1346 Санхүү, даатгалын үйлчилгээний менежер**

**1349 Аль нэг ангилалд ороогүй мэргэжсэн үйлчилгээний менежер**

**Тайлбар:**

Мэргэшсэн үйлчилгээний менежер нь нарийн мэргэжлийн болон техникийн үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй. “Мэргэжилтэн” гэсэн үндсэн бүлэг 2 болон “Техникч болон туслах/дэд мэргэжилтэн” гэсэн үндсэн бүлэг 3-т ангилсан ажил, мэргэжлийн хувьд нэг буюу хэд хэдэн мэргэжлээр тусгайлан мэргэшсэн, өргөн туршлагатай байх шаардлагатай.

**1341 ХҮҮХЭД АСРАМЖЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Хүүхэд асрамжлах үйлчилгээний менежер нь хичээлийн өмнөх, дараах, амралтын болон өдөр өнжүүлэх төвийн хүүхдийн асаргаа, хүмүүжлийн үйлчилгээг төлөвлөх, удирдах, зохицуулах үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

а) бага насны хүүхдийн биеийн болон нийгэм, сэтгэл санааны, тэрчлэн оюуны хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх,



- б) төсөв зохиох, хянах, ажилтанд зориулж материал нөөц, тоног төхөөрөмж, засвар тордолтод хөрөнгө хуваарилах,
- в) хичээлийн өмнөх, дараах, амралтын, өдөр өнжүүлэх төвийн хүүхдийн асаргаа, хүмүүжлийн үйлчилгээг хянах, зохицуулах,
- г) хүүхэд асрагч, хүмүүжүүлэгчээс бага насны хүүхдийг асрах, харж хандах ажиллагааг чиглүүлэх, зохицуулах,
- д) тоног төхөөрөмж, байшин барилга, хэрэгсэл, тоног нь тус төвийн хүүхэд, ажилтан, зочдод аюулгүй байдлыг хангах,
- е) төрийн хууль тогтоомж, холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэн (хүүхдийн өсөлт, хөгжилтийн аюулгүй байдалтай холбоотой) дотоод журам боловсруулж мөрдөх,
- ж) хүүхдүүдийн өсөлт, хөгжлийн явцад хяналт тавих, эцэг эх, асран хамгаалагч нартай зөвшилцөх,
- з) хүүхдийн цэцэрлэгийн данс бүртгэл, тооцоог хөтлөх,
- и) ажилтныг ажилд авах, мэргэжлийн ахиц дэвшлийг нь үнэлэх, зохицуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цэцэрлэгийн менежер, эрхлэгч

**1342 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Эрүүл мэндийн үйлчилгээний менежер нь эмнэлэг, нийтийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээг төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эмчилгээ, үйлчилгээний байгууллагыг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангах,
- б) эмчилгээ, сувилгаа, эмнэлгийн техник, бичиг хэргийн ба үйлчилгээ, арчилгаа тордлого хариуцсан болон бусад ажилтны ажил үйлдлийг чиглүүлэх, хянах, үнэлэх,
- в) удирдсан нэгжийнхээ зорилт, хариуцлагыг тодорхойлох, үнэлгээний болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тогтоох,
- г) ажилтанг шалгаруулж авах, сургаж дадлагажуулах ажиллагааг чиглүүлэх, зохион байгуулах,
- д) эмчилгээ, сувилгаа, техникийн болон захиргааны ажилтны журам, бодлого ба стандартын гүйцэтгэлийг гаргах, хэрэгжүүлэх, хянан шинжлэх,
- е) нөөцийн зохистой ашиглалтыг хангах үүднээс оношлох үйл ажиллагаа, хэвтэн эмчлүүлэгчийн ор, хангамж, ажилтны болон тоног төхөөрөмж, үйлчилгээний хэрэгцээг тодорхойлох,

- ж) төсвийн төлөвлөлт, тайлан, материал хангамж, тоног төхөөрөмж, үйлчилгээний зардал зэрэг асуудлаар захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих,
- з) үйлчилгээг зохицуулах үүднээс эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ эрхэлдэг бусад байгууллага, зөвлөл, хороо, санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах,
- и) эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хангамжийг сайжруулах асуудлаар засаг захиргааны байгууллагад зөвлөгөө өгөх,
- к) хурал, зөвлөгөөн, хэлэлцээрт байгууллагаа төлөөлөн оролцох.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмнэлгийн дарга, эрхлэгч
- Өрх, бүлгийн эрүүл мэндийн үйлчилгээ зохион байгуулагч
- Сувиллын захирал, дарга
- Эмнэлгийн зохион байгуулагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1343      Настанг асрамжлах үйлчилгээний менежер

### **1343 НАСТАНГ АСРАМЖЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Настанг асрамжлах үйлчилгээний менежер нь өндөр насласны улмаас зохих асрамжийн үйлчилгээ шаардлагатай болсон хувь хүн, айл өрхөд үзүүлж байгаа суурин ба хувь үйлчилгээг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах, бодлого, стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчилгээ, халамжийн байгууллагыг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангах,
- б) эмчилгээ, сувилгаа, техник, бичиг хэргийн үйлчилгээ, засвар арчилгаа тордлого, хариуцсан болон бусад ажилтны ажил үйлдлийг чиглүүлэх, хянах, үнэлэх,
- в) удирдсан нэгжийн зорилт, хариуцлагыг тодорхойлох, үнэлгээний болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох,
- г) ажилтанг шалгаруулж авах, сургаж дадлагажуулах ажиллагааг чиглүүлэх, зохион байгуулах,
- д) эмчилгээ, сувилгаа, техникийн болон захиргааны ажилтны мөрдөх журам гаргах, бодлого, стандартын гүйцэтгэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянан шинжлэх,
- е) настанд зориулсан халамж, асаргааны хөтөлбөрүүдийг зохицуулах, удирдах,

- ж) төсвийн төлөвлөлт, тайлан, материал хангамж, тоног төхөөрөмж, үйлчилгээний зардал зэрэг асуудлаар захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих,
- з) үйлчилгээг зохицуулах үүднээс эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ эрхэлдэг бусад байгууллага, зөвлөл, хороо, санхүүжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах,
- и) эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хангамжийг сайжруулах талаар засаг захиргааны байгууллагад зөвлөгөө өгөх,
- к) хурал, зөвлөгөөн, гэрээ, хэлэлцээрт байгууллагаа төлөөлөн оролцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Настны асрамжийн газрын дарга, захирал
- Настны асрамжийн үйлчилгээний зохион байгуулагч
- Настны сувиллын газрын дарга, эрхлэгч
- Сум, хорооны тэтгэврийн зохион байгуулагч, байцаагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1342 Эрүүл мэндийн үйлчилгээний менежер

**1344 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН МЕНЕЖЕР**

Нийгмийн халамжийн менежер нь нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүд, тухайлбал орлогын эх үүсвэр бүрдүүлэх, өрхөд туслалцаа үзүүлэх, хүүхдийн асаргаа, бусад олон нийтийн шинжтэй хөтөлбөр, үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлэх, зохицуулах, бодлого, стандартын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хангамж, үйлчилгээний төрийн бодлогыг хэрэгжүүлэх, нийгмийн халамж, үйлчилгээний төвийг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангах,
- б) ажилтны мөрдөх журам, нийгмийн халамжийн бодлого, стандартын гүйцэтгэлийг тодорхойлох, хэрэгжилтийг хянан шинжлэх,
- в) халамж, орон сууц, бусад нийгмийн үйлчилгээнд зориулагдсан нөөцийг хянан шинжлэх, үнэлэх,
- г) төсвийн төлөвлөгөө, тайлан, материал хангамж, тоног төхөөрөмж, үйлчилгээний зардал зэрэг асуудлаар захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих,
- д) эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээний хүрээнд хамтран ажиллах, зохицуулалт хийх үүднээс эрүүл мэнд, нийгмийн халамж

- үйлчилгээ эрхэлдэг бусад байгууллага, зөвлөл хороо, санхүүжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах,
- е) эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ, хангамжийг сайжруулах асуудлаар засаг захиргааны байгууллагад зөвлөгөө өгөх,
  - ж) төсөв батлах, захиран зарцуулах, зардлыг хянах, нөөцийг үр зохистой ашиглах явдлыг хангах,
  - з) үйл ажиллагааны болон захиргааны холбоотой дүрэм журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах,
  - и) ажилтанг шалгаруулж авах, сургах, гүйцэтгэх чадварыг нь ахиулах,
  - к) хурал, зөвлөгөөн, гэрээ, хэлэлцээрт байгууллагаа төлөөлөн оролцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Олон нийтийн төвийн менежер
- Гэр бүлийн үйлчилгээний менежер
- Орон сууцны үйлчилгээний менежер
- Халамжийн төвийн менежер

**1345 БОЛОВСРОЛЫН МЕНЕЖЕР**

Боловсролын менежер нь боловсролын үйлчилгээ үзүүлдэг бага болон дунд сургууль, коллеж, их, дээд сургуулийн салбар, тэнхим зэрэг боловсролын байгууллагын боловсролын үйлчилгээг төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) боловсролын агентлаг, захиргааны байгууллагаас гаргасан ерөнхий чиглэлд үндэслэн боловсролын хөтөлбөр боловсруулах,
- б) сургуулийн ажил хэрэг, оюутан, сурагчдын элсэлтэд хяналт тавих хяналтын систем, дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлэх,
- в) оюутан, сурагчдын элсэлт, боловсролын үйлчилгээ эрхэлдэг захиргаа, конторын үйл ажиллагааг зохион байгуулж удирдах,
- г) төсвийн төлөвлөлт, тайлан, сургалтын материал, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний зардал зэрэг асуудлаар захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих,
- д) багш болон академик, захиргааны ажилтан, оюутан сурагчдыг манлайлах, чиглүүлэх,
- е) сургалтын арга барилыг судлах, сургалтын материалуудыг хянах зэргээр багш, профессор багш нарын ажлыг үнэлэх,
- ж) боловсролын хөтөлбөрийг сурталчлах, байгууллага буюу сургалтын үйлчилгээг өргөн олон нийтэд таниулах,
- з) сургалтын материаллаг хэрэгслийн арчилгаа тордолгоог хянах,

- и) оюутан сурагч, багш сурган хүмүүжүүлэгч нарт аюулгүй, таатай орчин бүрдүүлэх үүднээс сахилгын ёс зүйн дүрмийг боловсруулж, мөрдөх,
- к) эцэг эх, олон нийт, хандивлагч байгууллагатай хамтран нэмэлт хөрөнгийн сан бий болгох арга хэмжээ зохион байгуулах, хэрэгжүүлэх,
- л) ажилтанг шалгаруулж авах, сургаж, дадлагажуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бүх шатны сургуулийн захирал
- Декан, факультетийн /их, дээд сургуулийн/
- Декан, факультетийн /коллежийн/
- Салбарын эрхлэгч, мэргэжлийн боловсролын
- Тэнхимийн эрхлэгч, дээд сургуулийн
- Тэнхимийн эрхлэгч, их сургуулийн
- Тэнхимийн эрхлэгч, коллежийн
- Хичээлийн эрхлэгч, дунд боловсролын сургуулийн

**1346 БАНК, САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Банк, санхүү, даатгалын үйлчилгээний менежер нь санхүүгийн болон даатгалын үйлчилгээ эрхэлдэг байгууллага, тухайлбал банк, банк, нийгэмлэг, зээлийн хоршоо, даатгалын компаний салбар байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй. Энэхүү менежер нь санхүү, даатгалын асуудлаар үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгч, туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) салбар байгууллагын ажилтны үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах,
- б) хувь хүн, бизнес хэрэглэгчидтэй харилцаа тогтоох,
- в) үйлчлүүлэгчдэд тэдний санхүү, даатгалын хэрэгцээ, хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт зэрэг хэрэглэгчтэй хамааралтай асуудлаар зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх,
- г) зээл ба даатгалын өргөдлийг шалгах, үнэлэх, шийдвэрлэх,
- д) зээл өргөтгөх, сунгах шийдвэрт хяналт тавих,
- е) санхүүгийн шалгалт судалгаа явуулах,
- ж) бэлэн мөнгө, санхүүгийн хэрэгсэл болон зохицуулалтын тайлан, мэдээллийг бэлтгэх явцад хяналт тавих,
- з) арилжааны, үл хөдлөх хөрөнгийн, хувь хүний авсан зээл, зээлийн шугамыг батлах, эсхүл татгалзах ажиллагааг зохицуулах,
- и) байгууллагаас бусад салбартай явуулах хамтын ажиллагааг зохицуулах,

# 1 ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

- к) төсөв батлах, захиран зарцуулах, зарцуулалтанд хяналт тавих, нөөцийн үр зохистой ашиглалтыг хангах,
- л) ажилтанг шалгаруулж авах, сургаж дадлагажуулах.

## Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Банкны менежер
- Барилгын нийгэмлэгийн менежер
- Зээлийн хоршооны менежер
- Даатгалын агентлагын менежер

## Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- 1211 Санхүүгийн менежер
- 3312 Зээлийн ажилтан
- 3321 Актуарч

## 1349 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ МЭРГЭШСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД МЕНЕЖЕР

Энэхүү нэгж бүлэгт “Захиргаа, арилжааны менежер” гэсэн дэд бүлэг 12, тэрчлэн “Төрөлжсөн үйлчилгээний менежер” гэсэн дэд бүлэг 13-ийн аль ч ангилалд багтаагүй төлөвлөх, зохицуулах үүрэгтэй менежерүүд орно. Жишээлбэл, энэ ангилалд стандартчилал, цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх, номын сан, хууль сахиулах болон гал унтраах зэрэг хүчний байгууллагын алба хариуцсан менежер ордог.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) үйлчилгээ, материал хангамж, хүчний байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн чиглэл, удирдлагаар хангах,
- б) журам, бодлого, стандартыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянан шинжлэх,
- в) техник, контор, үйлчилгээний болон, тордлого арчилгаа хариуцсан ажилтны ажил үйлдлийг чиглүүлэх, зохион байгуулах, үнэлэх,
- г) үйлчилгээ үзүүлэхэд зориулах нөөцийг хянан шинжлэх, үнэлэн дүгнэх,
- д) төсвийн төлөвлөлт, тайлан, материал хангамж, тоног төхөөрөмж худалдан авалт, үйлчилгээний зардал зэрэг асуудлаар захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих,
- е) үйлчилгээг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах,
- ж) ижил төстэй үйл ажиллагаатай өөрийн салбарын үйлчилгээний байгууллагын хамтын ажиллагааг зохицуулах,

- з) төсөв батлах, захиран зарцуулах, зардалд хяналт тавих, нөөцийн үр дүнтэй ашиглалтыг хангах,  
и) ажилтан шалгаруулж авах, сургаж дадлагажуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Архивын менежер
- Уран зургийн галерейн менежер
- Засан хүмүүжүүлэх газрын менежер
- Хуулийн үйлчилгээний байгууллагын менежер
- Номын сангийн менежер
- Музейн менежер
- Цагдаагийн захирагч
- Шоронгийн захирагч
- Стандартчилалын менежер

---

## **ДЭД БҮЛЭГ 14**

### **ЗОЧИД БУУДАЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД МЕНЕЖЕР**

---

Зочид буудал, худалдаа, холбогдох үйлчилгээний бусад менежер нь байр сууц, зочид буудал, жижиглэн худалдааны зэрэг үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Спортын тусгай арга хэмжээ, тоглоом, урлагын наадам цэнгээн зохион байгуулах, төрөлжсөн болон холимог бүтээгдэхүүний бүрдэл нөөцийн хэмжээ, үйлчилгээний стандартыг зохицуулах, төлөвлөх, худалдаа үйлчилгээг сурталчлан борлуулах, архи дарсаар үйлчлэх, тоглоом найдгай зохион явуулах болон эрүүл мэндийн, бусад хууль тогтоомжийг мөрдөх, хэрэглэгчтэй харилцах болон бараа үйлчилгээ хийхэд холбогдох бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хянан шинэчлэх, хурал зөвлөгөөн гэрээ хэлэлцээр, худалдаа яармагийн үеэр боломжит хэрэглэгчдэд зориулж, бараа, төхөөрөмж, түлш шатахуун, ачаа тээврийн таталт, хадгалалтыг зохион байгуулах, ажилтан шалгаруулж авах, сургаж дадлагажуулах.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**14 ЗОЧИД БУУДАЛ, РЕСТОРАНЫ МЕНЕЖЕР**

**142 ЖИЖИГЛЭН БОЛОН БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР**

**143 БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

**БАГА БҮЛЭГ 141**

**ЗОЧИД БУУДАЛ, РЕСТОРАНЫ МЕНЕЖЕР**

---

Зочид буудал, рестораны менежер нь байр сууц, хоол, ундаа зэрэг зочлох үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

Тусгай арга хэмжээ, спортын уралдаан тэмцээн тоглоом наадам болон соёл урлагийн арга хэмжээ төлөвлөж зохион байгуулах, захиалга хүлээн авах, хүлээн авахын үйлчилгээ, өрөө цэвэрлэгээ, орон байр харгалзах үйл ажиллагаа, архи дарсаар үйлчлэх, тоглоом наадгай зохиох, эрүүл мэндийн болон бусад хууль тогтоомжийг сахиулах, хоол бэлтгэх үйлчилгээтэй холбоотой бүхий л бэлтгэл үе шатанд чанарын хяналт шинжилгээ хийх, ажилтан шалгаруулж авах, сургаж дадлагажуулах ажиллагаанд хяналт тавих, үйлдвэрлэлийн эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар журмын биелэлтийг хангах.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1411 Зочид буудлын менежер**

**1412 Рестораны менежер**

**1411 ЗОЧИД БУУДЛЫН МЕНЕЖЕР**

Зочид буудлын менежер нь зочид буудал, дэн буудал зочдыг байрлуулах зэрэг ижил төстэй үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) захиалга хүлээн авах, хүлээн авахын үйлчилгээ, цэвэрлэгээ, орон байр харгалзах ажиллагааг зохион байгуулах,
- б) аюулгүй ажиллагаа, тохижилт, өмч хөрөнгө, хамгаалалтын хэрэгслийн бүрэн байдлыг хянах,



- в) баар, ресторан, тусгай арга хэмжээ, хурал зөвлөгөөний ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах,
- д) архи дарсаар үйлчлэх, тоглоом наадгай зохиох болон эрүүл ахуй, ариун цэврийн бусад хууль тогтоомжийг сахиулах,
- е) үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх, хянаж үзэх,
- ж) нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагааг зохион байгуулах,
- з) байгууллагын төсвийг хариуцах,
- и) ажилтан шалгаруулж авах, сургаж дадлагажуулахад хяналт тавих,
- к) эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдүүлэх,
- л) зочдыг орон нутгийн жуулчлалтай холбоотой мэдээллээр хангах, аялал, тээврийг зохицуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зочид буудлын менежер
- Дэн буудлын менежер
- Залуучуудын нийтийн байрны менежер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5152 Гэрийн үйлчлэгч

**1412 РЕСТОРАНЫ МЕНЕЖЕР**

Рестораны менежер нь кафе, ресторан, зоогийн газрын хоол хүнс бэлтгэх үйлчилгээ эрхэлдэг холбогдох байгууллагын үйл ажиллагааг төлөвлөж, удирдан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ахлах тогооч, тогооч нартай зөвлөлдөн хоолны цэс төлөвлөх,
- б) тусгай арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах,
- в) төсвийн дагуу бараа худалдан авах, үнэ тогтоохыг зохицуулах,
- д) материалын нөөц, санхүүгийн гүйлгээний тайлан, тооцоо хөтлөх,
- е) хоолны заал, гал тогоо, хүнсний агуулахыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн, цэвэр, үзэмжтэй байлгах,
- ж) хоол болон үйлчилгээний чанарыг үнэлэх, дүгнэх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн талаар тэдэнтэй харилцах зөвлөлдөх,
- з) зөөгч, гал тогооны ажилтан шалгаруулах, ажлын хуваарь тогтоох, сургах, дадлагажуулах,
- и) захиалга хүлээн авах, зочдыг угтах, хоолны захиалга хийхэд туслалцаа үзүүлэх,
- к) үйлчлүүлэгчтэй хэлэлцээ тохироо хийх,
- л) эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдүүлэх.

## **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Кафены менежер
- Рестораны менежер
- Зоогийн газрын менежер

## **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3434 Тогооч

## **БАГА БҮЛЭГ 142 ЖИЖИГЛЭН БОЛОН БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР**

---

Жижиглэн болон бөөний худалдааны менежер нь жижиглэнгээр юмуу бөөнөөр худалдаалах зарчмаар худалдаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй. Эдгээр менежер дэлгүүр болон доторхи тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулдаг нэгж хэсгийн төсөв, ажиллах хүчин, стратегийн болон шуурхай ажиллагааг хангана.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Бүтээгдэхүүний багц, материалын нөөц, үйлчилгээний стандартыг тогтоох, худалдан авалт, маркетингийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэ тогтоох, байгууллагын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан танилцуулах, материалын нөөц, санхүүгийн данс тооцоо хөтлөх, байгууллагынхаа төсвийг хариуцах, ажилтан шалгаруулах, сургалтын явцад хяналт тавих, үйлчилгээний эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар дүрмийг мөрдөх, сахиулах.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **1420 Жижиглэн болон бөөний худалдааны менежер**

#### **Тайлбар:**

Жижиглэн болон бөөний худалдааны менежер харьцангуй жижиг, удирдлагын шаталсан тогтолцоогүй байгууллагад ажилладаг. Жижиглэн худалдаа эрхэлдэг томоохон байгууллага, супермаркет, их дэлгүүрийн менежерийг “Менежер”, “Зааварлагч” зэрэг шаталсан удирдлагатай ч энэхүү бүлэгт мөн ангилан оруулна. Харин их дэлгүүр, супермаркетын сүлжээ зэрэг бүлэг байгууллагын “Ерөнхий менежер”-ийг нэгж бүлэг 1120 буюу “Захирал, гүйцэтгэх захирал” гэсэн ангилалд хамааруулна.

Ажилтныг удирдах, хянах ажил нэг их чухал биш, жижиг дэлгүүр ажиллуулдаг хүмүүсийг нэгж бүлэг 5221 буюу “Дэлгүүр ажиллуулагч” гэсэн гэсэн бүлэгт хамааруулна.

Туслах худалдагч, кассчин зэрэг ажилтны үйл ажиллагааг хянан зохицуулдаг боловч бүтээгдэхүүний багц, нөөц, үнэ тогтоох, төсөв, зардал батлах, олгох, ажилтны мэргэшлийн түвшин тодорхойлох, шалгаруулалтыг хариуцдаггүй ажилтанг нэгж бүлэг 5222 буюу “Дэлгүүрийн эрхлэгч”-д хамааруулна.

## **1420 ЖИЖИГЛЭН, БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР**

Жижиглэн, бөөний худалдааны менежер нь жижиглэн болон бөөны худалдаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах, дэлгүүрийн тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулдаг нэгж хэсгийн төсөв, ажиллах хүчин, стратегийн болон шуурхай ажиллагааг хариуцдаг.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) бүтээгдэхүүний багц, материалын нөөц, үйлчилгээний стандартыг тогтоох,
- б) худалдан авалт, маркетингийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэ тогтоох,
- в) бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан танилцуулах,
- г) материалын нөөц, санхүүгийн гүйлгээний данс тооцоо хөтлөх,
- д) байгууллагын төсвийг хариуцах,
- е) ажилтан шалгаруулах, сургах явцад хяналт тавих,
- ж) үйлдвэрлэлийн эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар дүрмийг сахин мөрдүүлэх.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Жижиглэн худалдааны менежер
- Супермаркетийн менежер
- Хүнсний дэлгүүрийн менежер
- Дэлгүүрийн менежер

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1221	Борлуулалт, маркетингийн менежер
5221	Дэлгүүр ажиллуулагч
5222	Дэлгүүрийн эрхлэгч
5223	Дэлгүүрийн борлуулалтын туслагч

## **БАГА БҮЛЭГ 143 БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

---

Бусад үйлчилгээний менежер спорт, соёл урлаг, амралтын болон, аялал жуулчлал, хэрэглэгчидтэй холбоо тогтоох зэрэг ая тухын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохицуулах үүрэгтэй.

### **Гүйцэтгэх үүрэгт:**

Үйлчилгээ, үйл ажиллагааны төрөл багцыг төлөвлөх, зохион байгуулах, үйлчилгээний хэрэгсэл, орчин шаардлага хангасан байхад анхаарал тавих, үйлчилгээг шинэ чиг хандлага, дэвшил хөгжилд нийцүүлэх, үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, олон нийтэд сурталчлан танилцуулах, бэлэн мөнгөний орлого зарлагын баримтыг шалгах, найдвартай байдлыг сахих, хангамжийн материалыг тогтмол шалгах, төсөв боловсруулах, захиран зарцуулах, зарлагад хяналт тавих, нөөцийн зохистой хэрэглээг хангахад хяналт тавих, өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, ажилтан шалгаруулах, сургах явцад нь хяналт тавих, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар, журмыг сахин мөрдүүлэх.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**1431 Соёл, спорт, амралтын төвийн менежер**

**1439 Аль нэг ангилалд ороогүй бусад үйлчилгээний менежер**

### **1431 СПОРТ, СОЁЛ, АМРАЛТЫН ТӨВИЙН МЕНЕЖЕР**

Спорт, соёл, амралтын төвийн менежер нь спорт, урлаг, театр, соёл амралтын үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) цэнгүүн, үзвэр, соёл, амралтын ажиллагаа, спорт, фитнесийн хөтөлбөрийн төрөл, багцыг төлөвлөх, зохион байгуулах,
- б) үйлчилгээний хэрэгсэл, орчин цэвэр, хэвийн байхад анхаарал тавих,
- в) үйлчилгээг шинэ чиг хандлага, дэшилтэй нийцүүлэх,
- г) үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, олон нийтэд сурталчлан танилцуулах,
- д) бэлэн мөнгөний орлого зарлагын баримтыг шалгах, найдвартай байдлыг хангах нэгтгэх, материал шалгалтыг тогтмол хийх,

- е) төсөв боловсруулах, захиран зарцуулах, зарлагад хяналт тавих, нөөцийн зохистой хэрэглээг хангахад хяналт тавих,
- ж) өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх,
- з) ажилтныг шалгаруулах, сургах явцад хяналт тавих,
- и) эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны заавар, журмыг сахин мөрдүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тоглоомын томоохон газар/паркийн/-ын менежер
- Биллиардын төвийн менежер
- Казино буюу мөрийтэй тоглоомын газрын менежер
- Кино театрын менежер
- Амралтын төвийн менежер
- Морин спортын төвийн менежер
- Спортын төвийн менежер
- Театрын менежер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 1349 Уран зургийн галлерейн менежер
- 1349 Музейн менежер
- 1349 Номын сангийн менежер

**1439 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЕНЕЖЕР**

Энэхүү бүлгийн менежер дэд бүлэг 13 “Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер”, мөн дэд бүлэг 14 “Зочид буудал, жижиглэн худалдаа, бусад үйлчилгээний менежер”-ийн ангилалд ороогүй үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, чиглүүлэх, зохицуулах үүрэгтэй. Энэхүү ангилалд аялал жуулчлалын компани, хурал зөвлөгөөн зохиох болон олон нийттэй харилцах төв, худалдааны төвийн менежер орох жишээтэй.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Аялал жуулчлалын компаний менежер
- Хурал зөвлөгөөн зохиох төвийн менежер
- Харилцах төвийн менежер
- Худалдааны төвийн менежер
- Жуулчны баазын менежер
- Аялалын паркийн менежер

**Тайлбар:**

Үндсэн бүлэг 2 буюу “Мэргэжилтэн” эсвэл үндсэн бүлэг 3 буюу “Техникч болон туслах/дэд мэргэжилтэн” гэсэн ангилалд орсон ажилтан нь мэргэшсэн техник үйлчилгээ явуулах бөгөөд нэг ба түүнээс дээш ажил, мэргэжилд холбогдох тусгай мэргэшил, дадлага туршлага эзэмшсэн байх шаардлагатай тул энэ нэгж бүлэгт орохгүй. Эдгээр ажилтан нь дэд бүлэг 12 буюу “Захиргаа, арилжааны менежер”, мөн дэд бүлэг 13 буюу “Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер” гэсэн аж ахуйн үйл ажиллагааны “Менежер”-ийн янз бүрийн нэгж бүлэгт ангилагдана.

## ҮНДСЭН БҮЛЭГ 2

# МЭРГЭЖИЛТЭН

---

Энэхүү ангиллын мэргэжлийн ажилтан нь мэдлэгийнхээ санг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан юмуу урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, эдгээрийг системчилсэн хэлбэрээр заан сургах буюу тус үйл ажиллагааны аливаа хослолыг мэргэшлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэдэг. Тиймээс энэ бүлгийн ихэнх ажил мэргэжил Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал болон Олон улсын ажил, мэргэжилийн стандарт (ISCO)-ын мэргэжлийн ур чадварын 4 дэх түвшинд хамаарна.

### Гүйцэтгэх үүрэг:

Шинжилгээ судалгаа хийх, үзэл баримтлал, онол, үйлдлийн арга барилыг боловсруулж хөгжүүлэх, математик, инженерчлэл, технологи зэрэг амьгүй байгалийн, анагаах, эрүүл мэндийн үйлчилгээ, тэрчлэн нийгэм ба хүмүүнлэгийн зэрэг амьд байгалийн ухааны мэдлэгийг хэрэглэх юмуу түүгээр зөвлөгөө өгөх, боловсролын төрөл бүрийн төвшинд нэг юмуу түүнээс дээш тооны хичээлээр онол, практик зааж багшлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сурган боловсруулах, төрөл бүрийн бизнес, хууль зүй, социал үйлчилгээ хийх, урлагын бүтээл туурвих, оюун санааны удирдамж өгөх, шинжилгээ судалгааны илтгэл, тайлан баримт бичиг бэлтгэх. Бусад ажилтныг удирдах үүрэг орж болно.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 21 Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн
- 22 Эрүүл мэндийн мэргэжилтэн
- 23 Багшлах мэргэжилтэн
- 24 Бизнес, захиргааны мэргэжилтэн
- 25 Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн
- 26 Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн

## ДЭД БҮЛЭГ 21

### **ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРИЙН МЭРГЭЖИЛТЭН**

---

Бодис зүй, математик, инженерийн ухааны мэргэжилтэн судалгаа хийх, үзэл баримтлал, онол ажиллагааны арга барилыг боловсруулж хөгжүүлэх, физик, одон орон, цаг уур судлал, хими, геофизик, геологи, математик, статистик, компьютер, архитектур, инженерчлэл болон технологийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг ажил хэрэгтээ ашиглана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Биет бодис, үзэгдлийн бүтэц, шинж чанар, төрөл бүрийн бодис, материал, бүтээгдэхүүний химийн шинж чанар, үйл явц, математик, статистик, компьютерийн зарчим, арга барилыг судлан олж авсан шинжлэх ухааны мэдлэгээ өргөжүүлэх, ажил хэрэгтээ ашиглах, түүгээр зөвлөгөө өгөх, судалгаа шинжилгээ хийх, барилга, хот байгуулалт, замын хөдөлгөөний систем юмуу иргэний барилга инженерчлэл, аж үйлдвэрийн цогцолбор мөн машин төхөөрөмжийн зураг төслийг боловсруулах, барилга угсралтын ажлыг удирдах, зөвлөх, уул уурхайн арга барил, тэдгээрийн оновчтой ашиглалтыг хангах талаар зөвлөгөө өгөх, ажилдаа хэрэглэх, газар, усны судалгаа хэмжилт явуулах, газрын зураг хийх, тодорхой материал, бүтээгдэхүүн, үйлдлийн технологи, үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөр зохион байгуулалтын асуудлаар судалгаа хийх, зөвлөгөө өгөх, шинжлэх ухааны холбогдолтой баримт бичиг, тайлан бэлтгэж боловсруулах. Бусад ажилтныг удирдах үүрэг орж болно.

Энэхүү дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 211 Биет бодис /физик/, гео судлалын мэргэжилтэн**
- 212 Математикч, актуарч, статистикч**
- 213 Амьд байгалийн ухааны мэргэжилтэн**
- 214 Цахилгаан технологийнхоос бусад инженер мэргэжилтэн**
- 215 Цахилгаан технологийн инженер**
- 216 Архитекторч, төлөвлөгч, газар хэмжигч, дизайнч**

## БАГА БҮЛЭГ 211

### **БИЕТ БОДИС /ФИЗИК/, ГЕОСУДЛАЛЫН МЭРГЭЖИЛТЭН**

---

Биет бодис, геосудлалын мэргэжилтэн нь үзэл баримтлал, онол, үйлдлийн барилыг боловсруулж, хөгжүүлэх, судалгаа хийх, физик, одон

---



орон, цаг уур судлал, хими, геофизик, геологийн талаарх мэдлэгээ ажилдаа хэрэглэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Механик, термодинамик, оптик, техникийн акустик, цахилгаан, соронзон, цөмийн физик, одон орон судал, химийн төрөл салбарууд, бөмбөрцөгийн агаар мандалын байдал, байгалийн төрөл байдалтай холбоотой судалгаа, туршилт хийн, олж авсан шинжлэх ухааны мэдлэгээ өргөжүүлэх, энэхүү мэдлэгээ үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, анагаах ухаан, навигаци, сансар судлал, газрын тос, хий, ус эрдэсийн эрэл хайгуул, телехолбоо, бусад үйлчилгээ болон барилгын инженерчлэл зэрэг салбарт хэрэглэх, эрдэм шинжилгээний баримт бичиг, тайланг бэлтгэж боловсруулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **2111 Физикч, одон орон судлаач**

#### **2112 Цаг уурч**

#### **2113 Химич**

#### **2114 Геологич, геофизикч**

### **2111 ФИЗИКЧ, ОДОН ОРОН СУДЛААЧ**

Физикч, одон орон судлаач нь матери, сансар, цаг хугацаа, энерги болон биет үзэгдэл хоорондын харилцан хамаарлын талаархи үзэл баримтлал, онол, үйлдлийн арга барил боловсруулан, хөгжүүлэх, судалгаа хийнэ. Тэд физик, одон орны талаархи мэдлэгээ аж үйлдвэр, анагаах, цэргийн зэрэг салбарт хэрэглэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) физик, одон орны холбогдолтой үзэл баримтлал, онол, программ хангамж, үйлдлийн арга барил боловсруулж, хөгжүүлэн судалгаа хийнэ,
- б) механик, термодинамик, электроник, харилцаа холбоо, эрчим үүсгүүр болон хуваарилагч, аэродинамик, оптик, лазер, алсын тандалт, анагаах, соронзон, техникийн акустик, цөмийн физикийн талаар туршилт явуулах, бодисын бүтэц, шинжээр сорил тавих, анализ хийх,
- в) судалгааны ажил, туршилтын дүнг математик арга техник, загвар ашиглан үнэлэн, дүгнэх,
- г) аж үйлдвэр, анагаах, цэргийн зэрэг салбарт физик, астрономийн зарчим, арга техник, үйлдлийг практик хэрэглээ болгон боловсруулах,

- д) эмч мэргэжилтний заавраар өвчтөн оношлох, эмчлэхэд цацраг туяа (ионжуулах ба ионжуулахгүйгээр)-г зөв зохистой, аюулгүй ашиглах явдлыг баталгаажуулах,
- е) эмчилгээ, шинжилгээнд хэрэглэх биет бодисын тоо хэмжээ, шинж чанарыг нямбай тогтоон хэрэглэх явдлыг хангах,
- ж) зураг авах, эмчилгээ хийх, эмийн тун хэмжээг тодорхойлоход ашигладаг тоног хэрэгслийг шалгах, баталгаажуулах, үнэлэх,
- з) цацраг туяаны ач холбогдолтой болон хортой үр нөлөөний талаар анагаахын эмч, мэргэжилтэн, бусад эрүүл мэндийн ажилтнуудтай зөвлөлдөх, зөвлөгөө өгөх,
- и) огторгуйн үзэгдлүүдийг ажиглах, дүн шинжилгээ хийх, тайлбар хийх, навигаци, сансрын холбоо, судлал, огторгуйн биет болон сансрын туяаны талаархи мэдлэгээ нэмэгдүүлэх үүднээс аргачлал, тоон загварчлал, арга техник боловсруулан, хөгжүүлэх,
- к) биет бодисыг судлан хэмжих, цөмийн технологийг аж үйлдвэрийн болон анагаахын салбарт ашиглах үүднээс стандарт, протокол боловсруулах, хэрэгжүүлэх, сахин биелүүлэх,
- л) эрдэм шинжилгээний тайлан, баримт бичиг бэлтгэн боловсруулах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Одон орон судлаач
- Эмчилгээний физик шинжээч
- Цөмийн физикч
- Физикч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2212	Нарийн /төрөлжсөн/ мэргэжлийн эмч (цөмийн анагаах)
2212	Цацраг туяаны /хорт хавдар судлаач/
2212	Рентген шинжээч
3211	Рентген зурагны техникч

#### **Тайлбар:**

Хэдийгээр эмчилгээний физик шинжээч нь бусад физикчидтэй хамт энэхүү бүлэгт ангилагдсан ч эрүүл мэндийн ажил үүрэгт буюу дэд бүлэг 22 “Эрүүл мэндийн мэргэжилтэн”, мөн үндсэн бүлэг 2 буюу “Мэргэжилтэн” гэсэн ангилалд хамаардаг болохыг энд тэмдэглүүштэй.

## **2112 ЦАГ УУРЧ**

Цаг уурч нь агаарын ба усан тээвэр, хөдөө аж ахуй, бусад салбарт ашиглагдах, мөн олон нийтэд мэдээлэх урт, богино хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээг гаргана. Тэд агаар мандлын нэгдэл, бүтэц, динамиктай холбоотой судалгаа хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) агаарын хөдөлгөөн, даралт, хэм, чийгшил, агаар бохирдуулагчийн биет болон химийн хувирал, мөн үүл бүрдэлт, хур тунадас, цахилгаан болон нарны туяа зэрэг байгалийн юмс үзэгдлийн хурд, чигийг шинжин судлах,
- б) цаг уурын станц, радарын болон сансрын зураг, компьютерийн модулиас гаргасан өгөгдлийг ашиглан цаг агаарын байдлыг урьдчилан тооцох,
- в) хар салхи, шуурга зэрэг цаг агаарын үзэгдэл, ард иргэд, өмч хөрөнгө зэрэгт аюул бүхий бусад үзэгдэлтэй холбоотой урт болон богино хугацааны цаг агаарын зураг, урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг бэлтгэн, радио, телевиз, хэвлэл болон интернет, төрөл бүрийн мэдээллийн бусад хэрэгсэлээр мэдээлэх,
- г) манан сарниулах, үүл буудах, бороо оруулах зэргээр цаг агаарт өөрчлөлт оруулах чиглэлийн турших хийх,
- д) цаг агаар, цаг ууртай холбоотой математик, компьютер загварчлалыг турших буюу ашиглах зорилгоор боловсруулах,
- е) цаг агаарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаанд оролцох,
- ж) аж үйлдвэрийн төсөл, хүний үйл ажиллагаанаас цаг уур, агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг судлан, нөлөөллийг даван туулах стратеги боловсруулах зорилгоор нийгмийн ухаан, инженерчлэл, эдийн засгийн хамт олонтой хамтран ажиллах,
- з) цаг агаарын мэдээ цуглуулах, алсаас тандах, шинэ төхөөрөмж, арга техник боловсруулах чиглэлээр ажиллах,
- и) агаар мандлын бүрдэл, бүтэц, динамиктэй холбоотой зарчим, онол, үйл ажиллагааны аргачлалыг боловсруулах, хөгжүүлэх чиглэлээр судалгаа хийх, энэхүү судалгааны үр дүнгээр шинжлэх ухааны өгүүлэл гаргах, тайлан боловсруулах,
- к) эрдэм шинжилгээний баримт бичиг, өгүүлэл, тайлан боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Уур амьсгал судлаач
- Агаарын чийгшил судлаач
- Цаг уурч
- Цаг агаарын урьдчилсан мэдээ боловсруулагч

**2113 ХИМИЧ**

Химич судалгаа шинжилгээ хийх, үзэл баримтлал, онол, үйлдлийн арга барил боловсруулах, хөгжүүлэх, химийн ухааны мэдлэгээ шинэ мэдлэг,

## 2 ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

бүтээгдэхүүн бий болгох чанарын болон үйлдвэрлэлийн процессийн хяналт тавихад ашиглах зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) химид холбогдох үзэл баримтлал онол, үйлдлийн арга барил, багаж хэрэглүүр хөгжүүлэх, судалгаа хийх,
- б) байгалийн болон синтетик төрөл бүрийн бодис, материал, бүтээгдэхүүний химийн найрлага, эрчим хүчний ба химийн өөрчлөлтийг шинжлэх үүднээс туршилт сорилт явуулах, шижилгээ хийх,
- в) байгаль орчны болон чанарын хяналт, үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй холбоотой бусад дэг журам боловсруулах,
- г) байгаль орчны хорт бодисын тоо хэмжээг тогтоох үүднээс дээж авах, тоо мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх хөтөлбөр хэрэгжүүлэх,
- д) биохимийн инженер, биологич, микробиологич, агрономич, геологич зэрэг мэргэжлийн хүмүүстэй хамтарсан судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх,
- е) бичил организмыг ашиглан бодисыг шинэ бүрдэлд хөрвүүлэх,
- ж) материал бэхжүүлэх, нийлэгжүүлэх арга зам эрэлхийлэх юмуу шинэ материал бүтээх,
- з) байгалийн гаралтай бодисыг үржүүлэх юмуу шинэ хиймэл бодис гаргаж авах,
- и) эрдэм шинжилгээний баримт бичиг, өгүүлэл, тайлан боловсруулах.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Химич

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

2131	Биохимич
2131	Биотехнологч
2131	Биофизикч
2131	Биохимич, ботаник, амьтан судлаач, холбогдох бусад мэргэжилтэн
2262	Эм зүйч

### 2114 ГЕОЛОГИЧ, ГЕОФИЗИКЧ

Геологич, геофизикч нь геологи болон геофизиктэй холбоотой үзэл баримтлал, онол, үйлдлийн аргачлал боловсруулах, хөгжүүлэх энэ чиглэлээр судалгаа хийх, газрын тос, хий эрдэс бодисын эрэл хайгуул, усны нөөц хадгалах, иргэний барилгын инженерчлэл, байгууламжийн инженерчлэл, телехолбоо, навигаци, хог боловсруулах болон хог хаягдлыг устгах төслийн байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, түүнийг даван

туулах зэрэг салбарт геологи болон геофизиктэй холбоотой мэдлэгээ ашиглана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) геологи, геофизиктэй холбоотой үзэл баримтлал, онол, үйлдлийн ажиллагааны арга барилыг боловсруулах, хөгжүүлэх энэ чиглэлээр судалгаа хийх,
- б) бөмбөрцгийн хөгжилд нөлөөлөгч үйл явц, амьдралын эволюци хувьслын зам мөр, геологи хэвшлийн уг гарал, хиронологийг тодорхойлохын тулд газрын гадаргуугын бүрдэл бүтцийг судлах, чулуулаг, эрдэс, малтмалын үлдэцийг шинжилж үзэх,
- в) судалгааны үр дүнгийн мэдээ баримтыг тайлах, геологийн тайлан, карт, диаграм бэлтгэх,
- г) геологийн мэдлэгээ иргэний барилга, гүүр, далан, нүхэн гарц, өндөр байшин барьж байгуулах, газрын хөрс сайжруулах, төсөл хэрэгжүүлэхэд ашиглах,
- д) алсаас тандалт явуулах төрөл бүрийн хөтөлбөрийн хүрээнд газар дэлхийд нөлөөлөх чичирхийлэл, татах хүч, цахилгаан, дулааны болон соронзон татлалцлын хүчний хэмжээг тогтоох, судлах,
- е) газрын массын жин, хэмжээ, бүрэлдэхүүн болон дотоод бүрэлдүүн бүтцийг тодорхойлох, галт уул, мөсдөлт, газар хөдлөлийн уг гарал, идэвхжил, урьдчилан таамаглах бололцоог судлах,
- ж) дэлхийн соронзон орны зураг гаргах, үүнийг цаг агаарын прогноз ба навигацид ашиглах,
- з) том нуур, гол мөрөн, агаар мандлын физик чанарыг болон тэдгээрийн дулааны эрчим солилцоо зэрэг харилцан шүтэлцээг судлах хэмжих,
- и) чичирхийлэл, татах хүч, цахилгаан, соронзон, радио хэмжлийн арга барил ашиглан газрын тос, эрдэс хатуулгийн нөөцийн орд, уг гарал хэмжээг тогтоон тодорхойлох,
- к) барилгын материалын нөөц орд илрүүлэх, тэдгээрийн шинж чанар болон нунтаглах, зам цардах зэрэг зориулалтаар ашиглахад тохиромжтой эсэхийг тогтоох,
- л) гүний болон гадаргуугийн усны хөдөлгөөн, хуваарилалт, физик шинж чанарыг судлах,
- м) хог хаягдал устгалын менежмент, бохирдсон цэгийг тогтоож, нөхөн сэргээх чиглэлээр зөвлөгөө өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нуур зүйч
- Геологич
- Геофизикч /нуурын/
- Геофизикч

**БАГА БҮЛЭГ 212****МАТЕМАТИКЧ, АКТУАРЧ, СТАТИСТИКЧ**

---

Математикч, актуарч, статистикч нь математик актуар тооцоолол, статистикийн үзэл баримтлал онол, үйлдлийн загвар, техник барилгыг боловсруулах, хөгжүүлэх судалгаа хийх, энэхүү мэдлэгээ инженерчлэл, бизнес, нийгмийн зэрэг ухааны талбарт төрөл бүрийн ажил үүрэг гүйцэтгэхэд ашиглана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Математик, актуар тооцоолол статистикийн үзэл баримтлал, онол, үйл техник арга барил боловсруулах, хөгжүүлэх, судалгаа хийх, математикийн зарчим, онол, загварчлал техникийг инженерчлэл, байгаль, нийгэм амьд бодисын шинжлэх ухааны талбарт төрөл бүрийн ажил үүрэг гүйцэтгэхэд ашиглах, удирдлагад тулгараад буй асуудалд логик шинжилгээ хийх, тухайлбал орц-гарцын үр ашгийн асуудалд компьютераар програмчлан шийдэл олох үүднээс асуудал бүрт тохирох математик загварыг томъёолох, амь нас, эрүүл мэнд, нийгмийн даатгал ижил төрлийн даатгалыг тэтгэврийн тогтолцоонд шилжүүлэх ажиллагааг боловсруулах, математик, статистик, магадлалын болон эрсдлийн онолыг ашиглан ирээдүйн үйл явдлын санхүүгийн үр дагаварыг тооцоолох, статистик судалгаа ажиглалт хийх ажлыг төлөвлөн зохион байгуулах асуулга бэлтгэх, статистикийн мэдээлэл цуглуулах, үнэлэх, шинжлэх, танилцуулах хэвлэлтэд бэлтгэх, бизнес юмуу эмчилгээнд тэрчлэн байгаль, нийгэм, амьд байгалийн ухааны салбарт ашиглах тоо мэдээ цуглуулах арга, статистик арга техникийг хэрэглэх, энэ талаар зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээний баримт бичиг, тайлан гаргах, математик актуар тооцоо, статистикийн туслах ажилтан, конторын статистик ажилтны ажил үүрэгт хяналт тавих.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2120 Математикч, актуарч, статистикч****2120 МАТЕМАТИКЧ, АКТУАРЧ, СТАТИСТИКЧ**

Математикч, актуарч, статистикч нь математик актуар тооцоолол статистикийн үзэл баримтлал онол, үйлдлийн загвар, техник барилгыг боловсруулах, хөгжүүлэх судалгаа хийх, энэхүү мэдлэгээ инженерчлэл, бизнес, нийгмийн зэрэг ухааны талбарт төрөл бүрийн ажил үүрэг гүйцэтгэхэд ашиглана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) математик, актуар тооцоолол, статистикийн үзэл баримтлал, онол, техник судлах, боловсруулах, хөгжүүлэх,
- б) математик зарчим, загвар, үйл техник арга барилыг инженерчлэл байгаль нийгэм, амьд бодисын шинжлэх ухааны салбарт төрөл бүрийн ажил үүрэг гүйцэтгэхэд ашиглах,
- в) удирдлагын асуудал, логик шинжилгээ хийх, тухайлбал орц-гарцын үр ашгийн асуудлыг компьютераар програмчлан шийдэл олохын тулд асуудал бүрт тохирсон математик загвар томъёолж боловсруулах,
- г) амь нас, эрүүл мэнд, нийгмийн даатгал болон ижил төрлийн даатгалын бүдүүвчийг тэтгэвэрийн тогтолцоонд шилжүүлэн боловсруулах,
- д) математик, статистик, магадлалын болон эрсдлийн онолыг ашиглан ирээдүйн санхүүгийн үр дагаварыг тооцоолох,
- е) статистик судалгаа хийх, статистик мэдээлэл цуглуулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах,
- ж) статистик тоо мэдээг үнэлэх, боловсруулах, судлах болон судалгааны асуулга бэлтгэх, танилцуулах, хэвлэлтэд бэлтгэх,
- з) бизнес болон эмчилгээ, тэрчлэн байгаль, нийгэм амьд бодисын ухаанд ашиглах төрөл бүрийн мэдээ баримт цуглуулах арга, статистик арга техник ашиглах энэ талаар мэдээ баримтын найдвартай байдлыг тодорхойлох зөвлөгөө өгөх,
- и) эрдэм шинжилгээний баримт бичиг, тайлан гаргах,
- к) математик, актуар тооцоо болон статистикийн туслах ажилтан, статистикийн конторын ажилтны ажил үүрэгт хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Актуарч
- Үйлдлийн шинжээч
- Хүн ам зүйч
- Математикч
- Статистикч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3314	Туслах актуарч
3314	Математикийн туслах ажилтан
3314	Статистикийн туслах ажилтан
4312	Даатгалын ажилтан
4312	Статистикийн ажилтан
2511	Системийн задлан шинжээч

**БАГА БҮЛЭГ 213****АМЬД БАЙГАЛИЙН УХААНЫ МЭРГЭЖИЛТЭН**

---

Амьд байгалийн ухааны мэргэжилтэн нь хүн, амьтан ургамлын амьдрал тэдгээрийн харилцан үйлчилгээний талаарх болон байгаль орчны мэдлэгээ сайжруулах, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэнд, байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Туршилтын болон хээрийн судалгааны мэдээ баримтыг цуглуулах, шинжлэх, үнэлэх, шинэ процесс арга техник тодорхойлох, боловсруулах үүднээс засаг захиргаа, байгууллага, бизнес эрхлэгчдэд байгалийн нөөцийн экологийн тогтвортой хөгжлийн талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2131 Биологич, ботаник, амьтан судлаач, холбогдох бусад мэргэжилтэн****2132 Фермч, ойн, загасны аж ахуйн зөвлөгч****2133 Байгаль хамгааллын мэргэжилтэн****2131 БИОЛОГИЧ, БОТАНИК, АМЬТАН СУДЛААЧ, ХОЛБОГДОХ БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Биологич, ботаникч, амьтан судлаач, холбогдох мэргэжилтэн нь амьд организм бие биентэйгээ болон байгаль орчинтой харилцан үйчлэлийг нь судлаж, олж авсан мэдлэгээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглана. Эдгээр мэргэжлийнхэн ботаник, амьтан судлал, экологи, нуур мөрний биологи, генетик, дархлаа судлал, эм зүй, хор судлал, физиологи, бактери болон нян судлалын төрөл бүрийн салбарт ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) амьд организм, ертөнцийн тухай мэдлэгээ дээшлүүлэх, шинэ мэдээлэл олж авах, таамаглалыг сорьж шалгах,
- б) байгаль орчин, хөдөө аж ахуй, хүний эрүүл мэндийн асуудал шийдвэрлэх, эм зүй, хөдөө аж ахуй, байгаль орчинд ашиглах шинэ



- бүтээгдэхүүн, процесс, арга техник боловсруулах үүднээс лаборатори болон хээрийн нөхцөлд судалгаа хийх,
- в) туршилт сорилт явуулах, ажлын бүдүүвч боловсруулж гүйцэтгэх,
- г) хүн, амьтан, шавьж, ургамлын эд эсийн дээж, мэдээ баримт цуглуулж, тэдгээрийн гарал үүсэл, хөгжил, хими физикийн хэлбэр, бүтэц, бүрдэл, амьдралын болон нөхөн үржихүйн явцыг судлах,
- д) тусгай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, цахим микроскоп, алсаас хэмжигч, глобаль байршил тодорхойлох систем, биотехнологи, сансрын зураг, генетикийн инженерчлэл, дижитал дүрс шинжилгээ, полимер гинжин урвал, компьютер загварчлал зэрэг техник технологи ашиглан амьд организмийг судлах,
- е) нарийн судалгаа, шинэ ололтын талаар эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл бичих, эдгээрийг шинжлэх ухааны салбарын ном сэтгүүл хурал зөвлөгөөнд хэлэлцүүлэх, мэтгэлцээн өрнүүлэх,
- ж) байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй үр дагаварын талаар байгаль орчны нөлөөллийн судалгаа явуулах,
- з) засаг захиргаа, байгууллага, бизнес эрхлэгчдэд байгалийн нөөцийг хадгалж хамгаалах, цаг уурын өөрчлөлтийн үр нөлөө болон орчны бохирдлын талаар зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Малын зан үйл судлаач
- Жижиг амьтан эмчлэгч
- Биологич
- Биотехнологич
- Ботаникч
- Эсийн генетикч
- Нуур усны биологич
- Микробиологич
- Молекулын биологич
- Молекулын генетикч
- Амьтан судлаач
- Биотехнологийн үйлдвэрлэлийн технологич
- Биохимич, биотехнологич
- Бактериологич, вирусологич
- Микробиологич, биофизикч
- Эсийн генетикч, генетикч
- Молекул генетикч, молекул биологич
- Жижиг амьтны эм зүйч,
- Чанарын хяналт шинжилгээний лабораторийн шинжээч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2133 Байгаль хамгааллын мэргэжилтэн

**2132 ФЕРМЧ, ОЙН БОЛОН ЗАГАСНЫ АЖ АХУЙН ЗӨВЛӨГЧ**

Фермч, ой, загасны аж ахуйн зөвлөгч нь фермийн, ойн болон загасны аж ахуйн менежмент, үүнд тариалалт, бордолт, хураалт, хөрсний эвдрэл, бүтэц, урьдчилан сэргийлэлт, хүнс тэжээл, ээлжлэн тариалалт, маркетингийн талаар судагаа хийж, зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн, бүтээмж дээшлүүлэх арга техник боловсруулж, газрын болон загас агнуурын талаар судлаж, төлөвлөгөө бодлого боловсруулна. Ургамлын үржлийн биологи, судалгааны ажлыг арга зүйн дагуу явуулах, шинэ таримал, шинэ сорт тариалах, сортыг бүтээх, үр үржүүлэх ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үржил, тэжээл, хөрс, усны чанар зэрэг ферм, ой, загасны үйлдвэрлэлд нөлөөлөгч хүчин зүйлийн талаар мэдээ, түүвэр цуглуулж шинжилгээ хийх,
- б) тариалан, мал аж ахуй, загас агнуур болон үйлдвэрлэлийн өөр зэрэгцээ хувилбарыг хөгжүүлэх арга арга техникийн талаар зөвлөгөө өгөх,
- в) мал, тарианы өвчин, хортон шавьж, шарилж устгах, хөрс сэргээх, мал арчилгаа тэжээлийн хөтөлбөрийн талаар зөвлөгөө өгөх,
- г) арилжааны зориулалтаар тариалан эрхлэх, бэлчээр арвижуулах, мал амьтан үржүүлэх ажиллагаа, загасны нөөц, ойн өсөлт, модны эрүүл байдалд нөлөөлөгч байгаль орчны хүчин зүйлсийг судлах,
- д) тариалалтын технологи, хөрсний байдал, хортон шавьж, янз бүрийн өвчлөл, загас агнуурын зөвшөөрөл олголтын байдал зэрэг нь мал, тариалан, ойн болон загасны өсөлт, ургацад үзүүлж буй нөлөөллийг судлах,
- е) загасны нүүдэл, өсөлт, тэжээл, түрс шахах, түрс цуглуулах, бордох, инкубаци хийх, дарах арга техник судлан боловсруулах,
- ж) хөрсний шинж чанар, үржил шим, ашиглалтын чадамжийг судлан, үр дүнгийг нь хөдөө аж ахуй, цэцэрлэгжүүлэлт болон ойн практикт ашиглах,
- з) хөдөө аж ахуйн асуудал бэрхшээлийг шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх арга техник боловсруулах,
- и) ойн болон загасны нөөцийг хямгадан, тэдгээрийн арилжаа, амралт цэнгээний болон байгаль орчны үр өгөөжийг урт хугацаанд хадгалах,
- к) ой модны үржил, өсөлтийг сайжруулах аргачлал, ой сийрэгжүүлэлтийн үр нөлөө зэргийг судлах,
- л) гал түймэр, үер ус, ган гачиг, хөрсний эвдрэл, хортон шавьж, өвчин зэрэгтэй тэмцэх үүднээс эрэл хайгуул хийх, төлөвлөх хэрэгжүүлэх, менежментийн дүрэм журам боловсруулах,

м) эрдэм шинжилгээний тайлан боловсруулж, ферм, ойн, загасны аж ахуй эрхлэгчдэд болон бусад бүлэгт мэдээллийн чанартай зөвлөх уулзалт зохион байгуулах, лекц яриа таниулга хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Загас агнуурын зөвлөгч
- Агрономич, үрийн, селекцийн
- Ой судлаач
- Ойн зөвлөгч
- Ойжуулалтын мэргэжилтэн
- Хөрс судлаач

**2133 БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН МЭРГЭЖИЛТЭН**

Байгаль хамгааллын мэргэжилтэн нь агаар, ус, дуу чимээний бохирдол, хөрсний доройтол, цаг уурын сөрөг өөрчлөлт, хортой хог хаягдал, байгалийн нөөц хомсдол зэрэг хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судлаж, үнэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) судалгаа хийх, сорилт тавих, түүвэр нэгж бүрдүүлэх, лабораторийн ба хээрийн шинжилгээ явуулах, байгаль орчны нөлөөнөөс сэргийлэх, тэдгээрийг хянах, сэргээн засах арга замыг зөвлөмж болгох,
- б) дэвшүүлж буй ажиллагаа, төсөл, арга хэмжээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, энэ талаар зөвлөмж гаргах,
- в) байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь байгаль орчинд хэрхэн нөлөөлж буйг тогтоох боломж олгох үүднээс байгаль орчны удирдлагын тогтолцоог бий болгох, зохицуулах, хэрэгжүүлэх,
- г) явуулж буй ажиллагаа, үйл явц, хог хаягдал, дуу чимээ, бодисын байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлд аудит хийх,
- д) байгаль орчны холбогдолтой төр захиргааны болон дотоод дүрэм журам, хууль тогтоомжийг байгууллагууд хэрхэн биелүүлж байгааг авч үзэх,
- е) байгаль орчин хохирч доройтох, санхүүгийн талаар учрах хохирлыг туйлын бага байлгах үүднээс байгууллагууд байгаль орчны холбогдолтой асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар техникийн зөвлөгөө, дэмжлэг өгөх,
- ж) хөрсний шинж чанар, үржил шим, ашиглалтын чадамжийг судлан, судалгааны үр дүнг нь хөдөө аж ахуй, цэцэрлэгжүүлэлт, ойн практикт ашиглах,
- з) байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын бохирдлын шинжээч
- Байгаль хамгааллын ажилтан
- Байгаль хамгааллын судлаач
- Экологич
- Байгаль орчны аудитор
- Байгаль орчны зөвлөгч
- Байгаль орчин судлаач эрдэм шинжилгээний ажилтан
- Байгаль орчны эрдэм шинжилгээний ажилтан
- Байгаль хамгаалагч
- Усны чанар шалгагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 2143 | Байгаль орчны инженер   |
| 3257 | Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагч |

**БАГА БҮЛЭГ 214****ИНЖЕНЕР МЭРГЭЖИЛТЭН (ЦАХИМ-ТЕХНОЛОГИОС БУСАД)**

---

Инженер мэргэжилтэн (цахим-технологиос бусад) нь инженерийн төслүүдийг аюулгүй, үр ашигтай хямд төсөр байлгах үүднээс барилга угсралт, машин механизм, үйлдвэрлэлийн систем тэдгээрийн бүрдэл хэсгийг суурилуулах, хамгаалах тордох, үйлдвэрлэлийн график, ажлын шат дарааллыг төлөвлөж, зохион байгуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Химийн процесс, иргэний барилгын инженер төсөл, механик тоног төхөөрөмж болон систем, уурхайн, өрөмдлөгийн үйлдэл зэрэг инженерчлэлийн төслийг төлөвлөх, зохион бүтээх, зураг төсөл, төлөвлөгөө боловсруулах, тайлбарлах, барилга барих арга барилыг тодорхойлох, бүтэц хэсэг, ус, хий хангамж, тээвэрлэлтийн систем угсрах, тоног төхөөрөмж, машин механизм төхөөрөг үйлдвэрлэлт, суурилуулалт, ажиллагаа, арчилгаа тордолтод хяналт тавих, төслийн ажил, материал, төхөөрөг, тоног төхөөрөмжийн хангамж, нийлүүлэлтийг удирдан зохион байгуулах, нийт өртөг тооцох, төсвийн хяналтын хэрэглүүр болгон зардлын нарийвчилсан төлөвлөгөө, тооцоо гаргах, инженерийн технологи ашиглан инженерийн төрөл бүрийн салбарын дизайн болон үйлдлийн асуудлыг шийдвэрлэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2141 Аж үйлдвэр, үйлдвэрлэлийн инженер**

**2142 Иргэний барилга, байгууламжийн инженер**

**2143 Байгаль орчны инженер**

**2144 Механикч инженер**

**2145 Химийн инженер**

**2146 Уул уурхайн инженер, металлургич, холбогдох мэргэжилтэн**

**2149 Энэ ангилалд ороогүй инженер мэргэжилтэн**

### **2141 АЖ ҮЙЛДВЭРИЙН ИНЖЕНЕР**

Аж үйлдвэрийн инженер нь үйлдвэрийн барилга угсрах, суурь төхөөрөг ажиллуулах, суурилуулах, арчилж тордох талаар судалгаа хийж, дизайн боловсруулж, хяналт тавьж зохион байгуулна. Тэд үйлдвэрийн ажиллагааг зохицуулах хөтөлбөр бий болгож, үр ашгийн өртөг зардал, аюулгүй байдлын үнэлгээ хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) нэгж, хэсгийн болон ажилтны зорилт даалгавар, үүрэг хариуцлагыг тодорхойлох, ажил үүргийн давхардлыг илрүүлэх зорилгоор ажлын хуваарь, зохион байгуулалтын карт, төслийн мэдээллийг судлах,
- б) хөдөлмөр ашиглалтын стандарт тогтоохын тулд хөдөлмөрийн норм хэмжээ боловсруулах, ажлын жишиг, жишээг шинжлэх,
- в) ажилтны ба тоног төхөөрөмжийн үр ашгийг оновчтой төвшинд тодорхойлохын тулд ажиллах хүчний ашиглалт, үйлдвэр, хөдөлмөрийн байрлал, зохион байгуулалт, шуурхай төлөвлөгөө, хуваарь, зардалд дүн шинжилгээ хийх,
- г) үйлдвэрийн техник нөхцөл, зааварчилгаа боловсруулах, шаардагдах материал, тоног төхөөрөмж, шугам хоолой, материалын шугам, хүчин чадал болон суурь төхөөрөг системийн байрлал, зохион байгуулалтыг тодорхойлох,
- д) ажиллах хүчний хуваарь, материал, механизм, суурин төхөөрөг, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлтийг удирдан зохион байгуулах,
- е) инженерчлэлийн зарчим, аюулгүйн заавар дүрэмд нийцүүлэн суурилуулга, шинэчлэл, чанарын хяналт, сорилт туршилт, хяналт шалгалт, арчилгаа тордлого хийх, стандарт, бодлогыг тогтоох,
- ж) үйлдвэрийн ажиллагааг хэвийн явуулах сайжруулах зорилгоор хяналт шалгалт хийж байх,

- з) үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг зохицуулах, шинэ дизайн, засвар үйлчилгээний шаардлагад нийцүүлэн хуваарь графикийг оновчтой болгох,
- и) үйлдвэрлэлийн шинэ арга, технологи, тоног төхөөрөмжийн талаар удирдлагыг зөвлөмжөөр хангах,
- к) материал хангамжийн хэвийн урсгалыг хангах үүднээс материал худалдан авах, агуулах болон хяналтын албатай холбоотой ажиллах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үйлдвэрийн үр ашгийн инженер
- Үйлдвэрийн инженер
- Үйлдвэрийн барилга байгууламжийн инженер
- Үйлдвэрлэлийн инженер

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1321 Үйлдвэрийн бүтээгдэхүүний менежер

### **2142 ИРГЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ИНЖЕНЕР**

Иргэний барилга байгууламжийн инженер нь барилгын дизайн шууд угсралтын талаар судалгаа хийх, зөвлөгөө өгөх, барилга байгууламжийн явц, засвар үйлчилгээг удирдах, тодорхой материал технологийн шинж чанарын асуудлаар судалгаа хийж, зөвлөгөө өгнө.

Түүнчлэн барилга угсралтын ажлын менежмент болон техник-эдийн засгийн үндэслэл, тооцоог эрхлэн гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилгын инженерчлэлд холбогдох шинэ, шинэчилсэн онол, арга барил боловсруулах, судалгаа явуулах,
- б) гүүр, далан, порт, зам, нисэх буудал, төмөр зам, суваг, шугам хоолой, хог хаягдал зайлуулах, үерийн ус урсгах систем, аж үйлдвэр, томоохон барилгын бүтээц, байгууламжийн дизайныг зохион бүтээх, энэ чиглэлээр зөвлөгөө өгөх,
- в) барилга барих арга, материал, чанарын стандартыг тогтоох, тодотгох, угсралтын ажлыг чиглүүлэх,
- г) бүтээц, байгууламжийн зохистой ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор хяналтын систем бүрдүүлэх,
- д) ашиглагдаж буй иргэний барилга, байгууламжийн инженерчлэлийн бүтээц, байгууламжийн арчилгаа засварын ажлыг удирдан зохион байгуулах,

- е) төлөвлөж буй бүтээц, байгууламжийн барилгад ашиглах хөрс, чулуулагт даралт өгөх аргаар шинжилгээ хийх, байгууламжийн суурийн зураг төслийг гаргах,
- ж) үйлдвэрийн ажиллагааг сайжруулах, хэвийн явуулах зорилгоор хяналт шалгалт явуулах,
- з) бүтээц, байгууламж бат бөх, тогтвортой эсэхэд шинжилгээ хийх, эдгээрт ашиглагдах материалын хувирал, бат бөхийг шалгах,
- и) барилгабайгууламжийн бүтээцийн (инженерийн) даацын тооцоог хийх, барилгын норм ба дүрэм, техникийн нөхцөл стандарт боловсруулах/ менежмент/,
- к) барилга байгууламжийн бүтээцийн зураг хийх, барилга байгууламжийг хариуцан бариулах, техникийн удирдлагаар хангах
- л) барилгын үйлдвэрлэлийн болон барилгын талбайн хөдөлмөр зохион байгуулалтыг төлөвлөх, удирдах,
- м) барилга барихтай холбогдсон техникийн болон эдийн засгийн баримт бичиг, актыг бичиж баталгаажуулах,
- н) хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах асуудлыг өөрийн эрхэлж байгаа ажлын хүрээнд хариуцан ажиллах,
- о) барилгын үйлдвэрлэлийг явуулах, хөгжүүлэх судалгаа хийж төлөвлөлт, зохион байгуулалт хийж удирдах /менежмент/,
- ө) барилгын эдийн засгийн тооцоо (цалин хөлс, материал, механизм, тээврийн зардал гэх мэт) хийх, барилга объектийн төсөв зохиоход хяналт тавих, удирдамжаар хангах/менежмент/,
- п) барилгын салбарын гадаад дотоод худалдааг төлөвлөн зохион байгуулах/менежмент/,
- р) барилгыг худалдан борлуулах үнийг тогтоох/менежмент/,
- с) барилгын хөдөлмөрийн биржийг удирдах, мэргэжилтэй ажилтан, ИТА бэлтгэх, ажиллах хүчний хэтийн болон ойрын төлөвлөлт хийнэ. /менежмент/.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Барилгын инженер
- Геотехникийн инженер
- Бүтээц байгууламжийн инженер
- Барилгын менежментийн инженер
- Барилгын бүтээц, эдлэлийн технологич инженер
- Барилгын усан хангамжийн инженер
- Ариутгах шахуургын инженер
- Дулаан хангамжийн инженер
- Агааржуулалт, агаар сэлгэлтийн инженер
- Гал түймэрийн улсын хяналтын байцаагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1323	Барилга угсралтын менежер
2114	Геологич, геофизикч
2146	Уул уурхайн инженер
2146	Металлургич
2164	Хотын байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч

**2143 БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР**

Байгаль орчны инженер нь төрөл бүрийн инженерийн ухааныг ашиглан хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулах сөрөг үр дагавараас сэргийлэх, хяналт тавих, байгаль орчныг сэргээх шийдлийн хэрэгжилтийг үзэх, зохион бүтээх, зөвлөх, удирдах үүрэгтэй. Тэд барилга угсралт, барилгын инженерчлэлийн төслийн байгаль орчны үнэлгээ судалгаа хийх, бохирдолд тавих хяналт, дахин боловсруулалт, хог хаягдлын устгалд инженерчлэлийн зарчмыг ашигладаг.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) одоо байгаа, шинээр төлөвлөгдөж буй барилга угсралт, инженерчлэлийн зэрэг үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судлах, үнэлэх, тайлагнах,
- б) аж үйлдвэрийн, орон нутгийн барилга байгууламж, хөтөлбөр, үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх, байгаль орчны дүрэм журамтай нийцэж байгаа эсэхэд хяналт тавих,
- в) ус, агаар, хөрсний чанарыг хянан удирдах, нөхөн сэргээлтийн систем, үйл явц, тоног төхөөрөмжийн дизайныг боловсруулах, зохиох үйл явцыг удирдах,
- г) сүлжээний шинжилгээ, зохицуулалтын шинжилгээ, өгөгдлийн баазыг төлөвлөх, хянан үзэхэд байгаль орчны инженерчлэлийн туслалцаа үзүүлэх,
- д) төлөвлөгөө, зөвшөөрөл, ажиллагааны норм стандартыг бүрдүүлэх, шинэчлэх сахин мөрдөх,
- е) байгаль орчныг нөхөн сэргээх, гомдол зарга шийдвэрлэхтэй холбогдох төсөлд инженерийн болон техникийн дэмжлэг үзүүлэх, үүнд нөхөн сэргээх системийн дизайныг боловсруулах, зохих хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох,
- ж) байгаль орчныг сэргээх хөтөлбөрийн явцад хяналт тавих,
- з) хүн ард, байгаль орчныг хамгаалах үүднээс бохирдсон газар нутгийг хэрхэн цэвэрлэж өөд татах дүрэм журмын талаар байгууллага, засаг захиргааныханд зөвлөгөө өгөх,
- и) байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд эрдэмтэн, төлөвлөгч, аюултай



хог хаягдлын техникч, бусад салбарын инженер, хууль, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын бохирдлын хяналтын инженер
- Байгаль орчны шинжээч
- Байгаль орчны инженер
- Байгаль орчин нөхөн сэргээх мэргэжилтэн

## **2144 МЕХАНИКЧ ИНЖЕНЕР**

Механикч инженер нь машин механизм, нисэх онгоц, усан онгоц, аж үйлдвэрийн суурь төхөөрөг, тоног төхөөрөмж, системийг шууд үйлдвэрлэх, дизайн хийх, зөвлөгөө өгөх, тэдгээрийн ажиллагаа, засвар арчилгааг зохион байгуулах буюу материал, бүтээгдэхүүн юмуу процессийн механик асуудлаар судалгаа хийх, зөвлөгөө өгөх.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлдвэр, уурхай, барилга угсралт, хөдөө аж ахуйн зэрэг аж үйлдвэрт зориулж машин механизм, багаж хэрэгслийн дизайн боловсруулах зөвлөгөө өгөх,
- б) төмөр замын зүтгүүр, зам барилгын машин механизм юмуу нисэх онгоц, жолоодлогын болон бусад машин механизмд ашиглагдах уурын, дотоод шаталтын зэрэг цахилгааны бус мотор, хөдөлгүүрийн талаар зөвлөгөө өгөх, дизайныг нь боловсруулах,
- в) онгоцны их бие, онгоцны дугуй бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг түр зогсоох систем, тормоз, их бие, бусад бүрэлдэхүүн хэсгийн талаар зөвлөгөө өгөх, дизайныг нь боловсруулах,
- г) бичвэрийн цахим процессор, компьютер, нарийн хэмжилтийн багаж хэрэгсэл, зургийн аппарат, проектор зэрэг бүтээгдэхүүн, аппарат хэрэгслийн цахилгааны биш хэсгүүдийн талаар зөвлөгөө өгөх, дизайныг нь боловсруулах,
- д) машин механизм, багаж хэрэгсэл, хөдөлгүүр, үйлдвэрийн суурь төхөөрөг, тоног төхөөрөмж юмуу системийн аюулгүй, оновчтой ажиллагааг хангахад шаардлагатай хяналтын норм стандарт, дэг журмыг тогтоох,
- е) тоног төхөөрөмж, ажиллагаа, засвар арчилгаа нь тухайн загварын зориулалт, аюулгүйн стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын тээврийн инженер
- Хөлөг онгоцны архитекторч

- Байгаль орчны инженер
- Механикч инженер
- Хэмжилзүйч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3151 Усан онгоцны инженер

## **2145 ХИМИЙН ИНЖЕНЕР**

Химийн инженер нь арилжааны зориулалттай хими процесс болон түүхий нефть, түлш орлуулагч, хүнсний болон ундааны зүйлс, эм бэлдмэл юмуу нийлэг материал зэрэг болон төрөл бүрийн бодисыг үйлдвэрлэлд судалгаа хийх, боловсруулах, энэ талаар зөвлөгөө өгөх үүрэгтэй. Тэд химийн суурь төхөөрөг, тоног төхөөрөмжийн тордолтыг шууд хариуцаж, тухайлсан материал, бүтээгдэхүүн, процессийн химийн талаар судлаж, зөвлөгөө өгдөг.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) түүхий нефть нэрэх, бусад шингэн юмуу хий боловсруулах, түлш орлуулагч, тэслэх бодис, хүнсний болон ундааны зүйл, эм бэлдмэл юмуу нийлэг материал зүйлс, төрөл бүрийн бодис үйлдвэрлэхтэй холбогдсон судалгаа явуулах, зөвлөгөө өгөх,
- б) химийн үйлдвэрлэлийн арга технологи, материал, чанарын стандарт зэргийг тодорхойлох, тэдгээр нь зохих загвар, техник нөхцөлтэй нийцэж байгаа эсэхэд хяналт тавих,
- в) химийн үйлдвэрлэл эрхэлдэг үйлдвэрийн аюулгүй, үр ашигтай ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг ажиллуулдаг юмуу химийн реакторын ойролцоо ажиллаж буй ажилчдын аюулгүй ажиллагааг хангах үүднээс хяналтын стандарт, дүрэм журмыг боловсруулж сахин мөрдүүлэх,
- г) химийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн дизайн боловсруулах, химийн бодис, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцыг зохиож боловсруулах,
- д) дулааны хэм, нягтшил, тусгай таталцал, даралт зэрэг хувьсах хүчин зүйлст тавих хяналтын зэргэмж тогтоох үүднээс үйлдвэрлэлийн бүх шатыг хамарсан сорилт, туршилт хийх,
- е) аюулгүй ажиллагааны заавар журам боловсруулж мөрдүүлэх,
- ж) удирдлагад танилцуулах үйлдвэрлэлийн зардлын тооцоо, үйлдвэрлэлийн явц байдлын тайлан бэлтгэх,
- з) шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх шатанд лабораторийн судалгаа хийх, туршилтын төхөөрөг дээр бага оврын технологи процесс сорьж турших.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Химийн инженер
- Түлшний технологич
- Хуванцарын технологич
- Нэрэх процессын инженер

**2146 УУЛ УУРХАЙН ИНЖЕНЕР, МЕТАЛЛУРГИЧ, ХОЛБОГДОХ  
БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Уул уурхайн инженер, металлургич, холбогдох бусад мэргэжилтэн нь арилжааны зориулалтаар хүдрээс металл, бусад эрдэс баялаг, ус, тос, хийг газраас олборлох, хайлш, керамик, бусад материал шинээр бий болгохтой холбоотой судалгаа хийж, дизайн боловсруулж, тодорхой материал, бүтээгдэхүүн болон процессийн уур уурхай, металлургитай холбоотой асуудлыг судлаж, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нүүрс, төмрийн хүдэр, металл биш эрдэс баялаг, барилгын материал чулуу, хайргын байршлыг тогтоох, төлөвлөх,
- б) уул уурхай, олборлолтын хамгийн үр ашигтай аргачлал, машин механизмыг тодорхойлох, үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалтыг төлөвлөх, уурхайн цооног, нүхэн гарц барих ажлыг удирдах,
- в) өрөмдлөг хийх талбай тодорхойлох, цооногоос гарах ус, тос, хийн урсгалыг хянах аргачлал боловсруулах,
- г) ус, тос, хий агуулах, анхан шатны боловсруулалт хийх, тээвэрлэх ажлыг төлөвлөх, удирдан чиглүүлэх,
- д) аюулгүй ажиллагааны стандарт тогтоох, ялангуяа газар доор анхны тусламж үзүүлэх нөхцөл бүрдүүлэх,
- е) металлыг хүдрээс ялгах аргачлал судлах, боловсруулах, тэдгээрийг хэрэглэх талаар зөвлөгөө өгөх,
- ж) металл, металлын хайлшны шинж чанарыг судлах, шинэ хайлш гаргаж авах, металл, металл хайлш боловсруулах, үйлдвэрлэлийн явцад гарах техникийн асуудлаар зөвлөгөө өгөх, үйлдвэрлэлийн явцад хяналт тавих,
- з) геологич, геофизикч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүстэй техникийн талаар хамтран ажиллах, зөвлөлдөж байх,
- и) орд, уурхайг судлан ашигт байдлыг нь үнэлэн тооцоолох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Олборлолтын металлургич

- Уул уурхайн инженер
- Газрын тос, байгалийн хийн инженер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2114 Геологич
- 2114 Геофизикч

**2149 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ИНЖЕНЕР МЭРГЭЖИЛТЭН**

Энэ ангилалд ороогүй инженер мэргэжилтэн гэдэг нь бага бүлэг 214 “Инженер мэргэжилтэн” (цахилгаан технологиос бусад), бага бүлэг 215 “Цахилгаан технологийн мэргэжилэн” гэсэн ангилалд тус тус ороогүй мэргэжилтнийг хэлнэ. Үйлдвэрлэлийн байрны аюулгүй байдал, биоанагаахын инженерчлэл, оптик, материал зүйлс, цөмийн энерги үйлдвэрлэл болон тэсрэх бодистой холбогдох шийдэл, аргачлал боловсруулдаг, зөвлөгөө өгдөг, судалгаа хийдэг мэргэжилтэн энэхүү бүлэгт орох жишээтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) биологи, эрүүл мэндийн систем ба бүтээгдэхүүн тухайлбал хиймэл эрхтэн, протез зэрэг хэрэгслийн дизайн боловсруулах, төгөлдөршүүлэх, үнэлж дүгнэхэд инженерийн мэдлэгээ ашиглах,
- б) соронзон хэлбэлзлийн зураглал, инсулин тарилгын автомат хэрэгсэл, бие эрхтэний функц хянах, төрөл бүрийн эмчилгээний явцад хэрэглэгдэх багаж хэрэгслийг зохион бүтээх,
- в) линз, микроскоп, телескоп, лазер, оптик диск зэрэг гэрлийн шинж чанарыг ашигладаг тоног төхөөрөмжийн бүрдэл хэсгийг зохион бүтээх,
- г) цөмийн реактор, цахилгаан станц, цөмийн түлш дахин боловсруулах, нөхөн сэргээх системийн барилга угсралт, ажиллагааг зохион бүтээх, хянан удирдах,
- д) реакторын цөм, цацраг туяаны хамгаалалт зэрэг холбогдох хэрэгсэл, хяналтын механизмыг зохион бүтээх, боловсруулах,
- е) нуур голын хаягдлын хор хохирлыг үнэлэх, тооцоолох,
- ж) шил, керамик, арьс шир, модон бүтээгдэхүүн, хэвлэл зэрэг үйлдвэрлэх явцад гарах инеженерийн холбогдолтой асуудлыг судлах, түүгээр зөвлөгөө өгөх,
- з) аюул ослыг урьдчилан тооцох, аюулгүй ажиллагаа болон аюулгүйн хэрэгслийг нэвтрүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бионагаахын инженер
- Тэсрэх зэр зэвсгийн инженер
- Нуур мөрний хог хаягдлын инженер
- Барилгын материалын инженер
- Оптик инженер
- Аюулгүй ажиллагааны инженер
- Хугацаа, хөдөлгөөний инженер
- Тоон үзүүлэлт судлагч инженер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                   |
|------|-----------------------------------|
| 2141 | Аж үйлдвэр, үйлдвэрлэлийн инженер |
| 2143 | Байгаль орчны инженер             |
| 2165 | Байр зүйч                         |

**БАГА БҮЛЭГ 215  
ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР**

Цахилгааны инженер нь цахим, цахилгааны болон телехолбооны систем, бүрдэл хэсэг, мотор, тоног төхөөрөмжийн угсралт болон үйл явцыг судлах, зохион бүтээх, зөвлөх, төлөвлөх, чиглүүлэх үүрэгтэй. Цахилгаан, цахим цогцолбор, системийн ажиллагаа, аюулгүй байдлыг хянах зорилгоор шалгах системийг бүрдүүлж, зохион байгуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Цахим, цахилгаан, телехолбооны бүтээгдэхүүн, системийг арчлан тордохтой холбоотой судалгаа хийх, зөвлөх, удирдан чиглүүлэх, цахилгаан энерги үүсгэдэг, дамжуулдаг, түгээдэг эрчмийн станц, системийн талаар зөвлөх, эдгээрийн зураг төслийг боловсруулах, цахилгаан, цахим, телехолбооны системийн, тоног төхөөрөмжийн ажиллагаа, аюулгүй байдлыг хянан шинжлэх стандартыг тогтоох.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2151 Цахилгааны инженер**

**2152 Цахим зүйн инженер**

**2153 Телехолбооны инженер**

## 2151 ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР

Цахилгааны инженер нь цахилгаан систем, бүрдэл хэсэг, мотор, тоног төхөөрөмжийн угсралт ажиллагаатай холбогдох судалгаа хийх, зохион бүтээх, зөвлөх, төлөвлөх, чиглүүлэх, тэдгээрийн үүрэг ажиллагаа, засвар арчилгааны талаар зөвлөгөө өгөх, удирдах юмуу цахилгаан инженерчлэлийн материал, бүтээгдэхүүн процессийн технологийн асуудлыг судлах, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) цахилгаан хүч үүсгэдэг, дамжуулдаг, түгээдэг станц, системийн талаар зөвлөх, зураг төсөл боловсруулах,
- б) цахилгаан үүсгүүр, дамжуулалт, түгээлтийн ажиллагааг удирдах, хяналт тавих,
- в) цахилгаан мотор, зүтгүүр зэрэг тоног төхөөрөмж юмуу ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслийн талаар зөвлөгөө өгөх, зураг төсөл боловсруулах,
- г) аж үйлдвэр зэрэг барилга, объектын цахилгааны холболт, хэрэглээний техник нөхцлийг загварчлах,
- д) цахилгаан үүсгүүр, түгээх систем, мотор, тоног төхөөрөмжийн ажиллагаа, аюулгүй байдлын хяналт шинжилгээ хийх хяналтын стандарт, дүрэм журам тогтоох,
- е) цахилгаан системийн үйлдвэрлэлийн арга техник, ашиглаж буй цахилгаан систем, мотор, тоног төхөөрөмжийн засвар тордолгоог тодорхойлох.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Цахилгаан хүч үүсгүүрийн инженер
- Цахилгааны инженер
- Цахилгаан механикч инженер

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                                     |
|------|-------------------------------------|
| 2149 | Цөмийн эрчим хүч үүсгүүрийн инженер |
| 2152 | Цахим зүйн инженер                  |
| 2153 | Телехолбооны инженер                |
| 2153 | Өргөн нэвтрүүлгийн инженер          |

## 2152 ЦАХИМ ЗҮЙН ИНЖЕНЕР

Цахим зүйн инженер нь цахим системийн угсралтын үүрэгт ажиллагаа, засвар арчилгааг судлах, зураг төсөл боловсруулах, удирдан чиглүүлэх,

цахим инженерчлэлийн материал, бүтээгдэхүүн, процесс технологитой холбоотой асуудлыг судлах, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахим хэрэгсэл юмуу бүрдэл хэсэг, хэлхээ, хагас дамжуулагч, системийн талаар зөвлөгөө өгөх, зураг төсөл боловсруулах,
- б) үйлдвэрлэл, холболтын арга техник, материал, чанарын стандартын техник нөхцлийг тогтоох, цахим бүтээгдэхүүн, системийн үйлдвэрлэл, холболтыг удирдах,
- в) цахим систем, мотор, тоног төхөөрөмжийн үр ашигт ажиллагаа, аюулгүй байдлыг хангахын тулд хяналтын стандарт, дүрэм журмыг тогтоох,
- г) цахим систем, тоног төхөөрөмжийн засвар арчилгааг зохион байгуулж, чиглэл өгнө,
- д) агаарын чиглэл, хөдөлгөх хүчний хяналт акустик юмуу хянах багаж хэрэгсэл зэрэг талбайд ашиглагдах цахим хэлхээ, бүрдэл хэсгийн зураг төсөл боловсруулах,
- е) радар, алсаас хэмжих болон удирдах систем, бичил долгион зуух, бусад цахим хэрэгслийг судлах, зөвлөгөө өгөх,
- ж) дохиололтын процессийн алгоритмыг загварлах боловсруулах, тэдгээрийг зохих техник ба програм хангамжийг сонгон хэрэглээнд оруулах,
- з) цахим бүрдэл хэсэг, хэлхээ, системийг сорих шалгах үүднээс аппарат хэрэгсэл, дүрэм журмыг боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Компьютерийн техник хангамжийн инженер
- Цахим зүйн инженер
- Багаж хэрэгслийн инженер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2153      Телехолбооны инженер

**2153 ТЕЛЕХОЛБООНЫ ИНЖЕНЕР**

Телехолбооны инженер нь телехолбооны систем, тоног төхөөрөмжийн угсралтын ажиллагаа, засвар арчилгааг судлах, зөвлөх, зураг төсөл боловсруулах, удирдах үүрэгтэй. Тэд теле холбооны инженерчлэлийн материал, бүтээгдэхүүн юмуу процессийн технологи асуудлуудыг судлаж, зөвлөнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) телехолбооны хэрэгсэл юмуу бүрдэл хэсэг, систем, тоног төхөөрөмж хуваарилах төвд зөвлөгөө өгөх, зураг төсөл боловсруулах,
- б) үйлдвэрлэл суурилуулалтын арга барил, материал, чанар, аюулгүйн стандартын техник нөхцлийг тогтоох, теле холбооны бүтээгдэхүүн, системийн үйлдвэрлэл, суурилуулалтыг удирдах,
- в) ашиглаж буй теле холбооны систем, мотор, тоног төхөөрөмжийн засвар арчилгааг удирдан зохион байгуулах,
- г) телехолбооны тоног төхөөрөмжийг судлах, зөвлөх,
- д) утастай, шилэн кабель, утасгүй харилцаа холбооны хэрэгсэлд суурилсан холбооны сүлжээг төлөвлөх, дизайныг нь боловсруулах,
- е) дохиолох процессийн алгоритмыг загварчлах боловсруулах, тэдгээрийг зохих техник ба програм хангамжийг сонгон хэрэглээнд оруулах,
- ж) телехолбооны сүлжээ, радио, телевизийн түгээлтийн систем үүнд кабель, агаарт цацах схемийн дизайн боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өргөн нэвтрүүлгийн инженер
- Телехолбооны инженер
- Телехолбооны инженерийн технологич

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2152 Цахим зүйн инженер

**БАГА БҮЛЭГ 216****АРХИТЕКТОРЧ, ТӨЛӨВЛӨГЧ, ЗУРАГЗҮЙЧ, БАЙРЗҮЙЧ, ДИЗАЙНЧ**

---

Архитекторч, төлөвлөгч, зурагзүйч, байрзүйч, дизайнч нь газар тохижуулалт, барилга байгууламжийн гадна ба дотор талын төлөвлөлт, үйлдвэрийн бүтээгдхүүнийг төлөвлөх, зохион бүтээх, хэвлэн нийтлэх, үзүүлэн таниулах зэрэг гоо зүйн мэдрэмжид хүргэх мэдээллийг зохиож бүтээнэ. Газрын тохижуулалт, ашиглалтыг хянах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байр зүйн онцлогийг нарийн нягт тогтоож газрын зураг бэлтгэх, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Захиалагч болон оролцогчдод зөвлөн зураг төслийн зорилго, түүний хязгаарлах нөхцөлийг тогтоох, зураг төслийн санааг томъёолох, гоо зүйн болон техникийн шаардлага, экологийн ба бүтээгдэхүүний стандарт шаардлагатай цогцоор нийцүүлэх, бүдүүвч зураг, үзүүлэн, төлөвлөгөө,



газрын зураг, график, загваруудыг хиймэл дагуулын зурагт дүн шинжилгээ хийх, судалгааны баримт, өгөгдөл, тайлан, статистик мэдээлэл зэргийг ашиглан бэлтгэх, харилцан хамаарал бүхий орон зайн болон арилжааны, соёлын, аюулгүй байдлын, хүрээлэн буй орчны, гоо зүйн техникийн шаардлагыг судлах, зөвлөгөө өгөх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2161 Барилгын архитекторч**

**2162 Газар тохижилтийн архитекторч**

**2163 Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч**

**2164 Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч**

**2165 Зурагзүйч, байрзүйч**

**2166 График, мультимедиа зохиомжийн дизайнч**

## **2161 БАРИЛГЫН АРХИТЕКТОРЧ**

Худалдааны, үйлчилгээний, үйлдвэрийн, орон сууцны, амралт, аялал жуулчлалын барилга байгууламжуудыг төлөвлөж, барилгын угсралтын болоод ашиглалт, засварын ажлын үед хянах ажлыг гүйцэтгэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) архитектурын шинэ онол, хэрэглээний арга зүйг боловсронгуй болгох, сайжруулах,
- б) санал болгож буй барилгын төрөл, хэв маяг, хэмжээг тогтоох зорилгоор барилгын талбайг судлах, захиалагч, удирдлага бусад оролцогчдод зөвлөх,
- в) зураг төсөл, материал, тооцоолол, ашиглалтад өгөх хугацааны талаарх мэдээллээр хангах,
- г) төслийн баримт бичиг, таталбар зураг, жижигрүүлсэн зураг бэлтгэх, бүтээцийн, тоног төхөөрөмжийн, гоо зүйн элементүүдийг зураг төсөлд тусгах,
- д) барилга угсралтын ажилд хэрэглэх, захиалагч тендер зарлахад ашиглах техникийн тодорхойлолт, гэрээний баримт бичгийг бэлтгэх, зөвлөх,
- е) төсөл нь хэв маяг, өртөг, хугацааны хувьд хэрэгжих боломжтой эсэх, хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн эсэх талаар судалгаа, дүгнэлт гаргах,
- ж) барилгын дотоод орчны чанар, бусад инженерийн байгууламжтай холбоотой асуудлыг шийдвэрлэх оновчтой аргыг тогтоох,

шаардлагатай зураг төсөл бэлтгэх, төлөвлөх, ажлын зураг гаргах, зөвөлгөө өгөх,

- з) норм, норматив, чанарын стандартын шаардлагад нийцүүлэх явдлыг хангах, барилга угсралтын болон засварын ажлыг хянах,
- и) бусад холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх.
- к) иргэний үйлдвэрлэл, тусгай болон зам гүүрийн барилгын архитектур, дизайныг төлөвлж эцсийн шийдэл гаргах
- л) барилга объектийн бүхий л ажлуудыг удирдаж зураг төсөл хийлгэх
- м) зураг төсөл, норм нормативын дагуу барилга объектийн баригдаж байгаа эсэхийг шалгаж зааварлах
- н) барилга байгууламжийн төлөвлөлтийг дэлхийн болон өөрийн орны уламжлалт архитектур дизайн хослуулах аргыг судалж эрдэм шинжилгээний ажил явуулна.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Барилгын архитекторч
- Дотоод засал, чимэглэлийн архитекторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2162 Архитекторч, газар тохижуулалтын
- 2161 Архитекторч, дотоод засал чимэглэлийн
- 3432 Дизайнерч, дотоод засал чимэглэлийн

### **2162 ГАЗАР ТОХИЖУУЛАЛТЫН АРХИТЕКТОРЧ**

Газар тохижуулалтын архитекторч нь цэцэрлэгт хүрээлэн, сургууль, аж ахуйн нэгж байгууллага, зам, худалдаа үйлчилгээ, орон сууцны барилгын гадна талбайн газрын тохижуулалт, задгай орон зайн тохижуулалтыг төлөвлөх, барилга угсралт, ашиглалт, засвар арчилалтын явцад хяналт тавих ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) газар тохижуулалтын архитектурын шинэ онол, хэрэглээний арга зүйг боловсронгуй болгох, сайжруулах,
- б) санал болгож буй барилга, цэцэрлэгт хүрээлэн, зам, бусад задгай орон зайн төрөл, хэв маяг, хэмжээг тогтоох зорилгоор тухайн орон зайг судлах, захиалагч, удирдлага бусад оролцогчдод зөвлөх,
- в) тухайн газарт оршин суугчдын хүсэлт, газар зүйн болоод экологийн онцлог, газрын тогтоц, хөрс, ургамал зүй, гидрологи, харагдах шинж, хүний гараар бүтээн байгуулсан бүтээц зэргийн мэдээллийг судлах, газрыг хэрхэн ашиглах боломж, барьж байгуулахад анхаарах асуудал, хүрээлэн буй орчинд учруулах нөлөөллийн талаарх судалгаа дүгнэлт гаргах,

- г) газар ашиглах тайлан бэлтгэх, түүнд талбайн төлөвлөлт, ажлын зураг, тодорхойлолт, үнэлгээг бэлтгэх, байршлыг тусгасан нарийвчилсан мэдээлэл тухайлбал газрын загварчлал, барилгын, гадна тохижилт, зүлэгжүүлэлт, орц, гарц зэргийг тусгах,
- д) барилга угсралтын ажилд хэрэглэх, эсхүл тендер зарлахад ашиглах техникийн тодорхойлолт, гэрээний баримт бичгийг бэлтгэх,
- е) төсөл нь хэв маяг, өртөг, хугацааны хувьд хэрэгжих боломж, хууль тогтоомжийн шаардлагад нийцэх эсэх талаар дүгнэлт гаргах,
- ж) гадна орчны байдал, бусад хамааралтай барилга байгууламжтай холбоотой асуудлыг шийдвэрлэх оновчтой аргыг тогтоох, шаардлагатай зураг төсөл, төлөвлөлт, ажлын зургийг гаргах, зөвөлгөө өгөх,
- з) техникийн норм, нормативийн шаардлага, чанарын стандартад нийцүүлэн барилга угсралтын болон засварын ажлыг хянах,
- и) бусад холбогдох мэргэжилтнүүдтэй газар тохижилтын асуудлаар зөвлөлдөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Газар тохижуулалтийн архитекторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2161 Барилгын архитекторч
- 2164 Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч

**2163 БҮТЭЭГДЭХҮҮН, ХУВЦАСНЫ ДИЗАЙНЧ**

Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч нь үйлдвэрийн бүтээгдэхүүний загвар зохион бүтээх, бүтээгдэхүүнийг бөөнөөр, багцаар, захиалгаар үйлдвэрлэх зураг төсөл, тодорхойлолтыг бэлтгэх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зураг төслийн зорилго, хязгаарлах хүчин зүйлсийг тодорхойлон захиалагч, оролцогчдод танилцуулах,
- б) хувцасны, нэхмэлийн, үйлдвэрийн, борлуулалтын болон хэрэглэгчийн бүтээгдэхүүн, үнэт эдлэлийн загварыг зохион бүтээх,
- в) гоо зүйн болон техникийн шаардлагуудыг экологийн, бүтээгдэхүүний шаардлагатай иж бүрнээр нийцүүлэх,
- г) загварын бүдүүвч зураг, диаграмм, үзүүлэн, төлөвлөгөө, загвар, сорьцуудыг бэлтгэх,
- д) загварын шийдлийг захиалагч, борлуулалтын, үйлдвэрлэлийн ажилтантай зөвшилцөх,
- е) материалын зориулалт, үзэмж, үйлдвэрлэлийн арга, эцсийн боловсруулалтын талаарх сонголт, зөвлөмж, тодорхойлолтыг гаргах,

- ж) үйлдвэрлэлд зориулан сонгогдсон загварыг задлан нарийвчилан гаргах, баримтжуулах,
- з) загвар, сорьцыг бэлтгэх, үзүүлэх,
- и) загвар, хөтөлбөр төлөвлөгөө, хэрэглэх багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийн процессийг төлөвлөж бэлтгэх ажлыг хянах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дизайнч, хувцасны
- Дизайнч, бүтээгдэхүүний
- Дизайнч, үйлдвэрийн
- Дизайнч, үнэт эрдэнэсийн

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2144	Дизайнч, хөдөлгүүрийн
2161	Барилгын архитекторч
2162	Газар тохижуулалтийн архитекторч
3432	Дизайнч, дотоод засал чимэглэлийн

### **2164 ХОТ БАЙГУУЛАЛТ, ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨН ТӨЛӨВЛӨГЧ**

Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч нь хот, хөдөөгийн тээврийн хөдөлгөөнийг хяналттай ашиглах, зохицуулах бодлого, төлөвлөлтийг боловруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хотын байгуулалтын төлөвлөгөө, зохицуулалтыг хийх,
- б) газар ашиглалтад нөлөөлөх эдийн засгийн, хууль эрх зүйн, соёлын, хүн ам зүйн, нийгмийн, эрүүл ахуйн, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг судлах, нэгдсэн дүгнэлт гаргах,
- в) архитектур, төлөвлөлт, нийгмийн болон хүрээлэх орчин, хууль эрх зүйн мэргэжилтэн, оршин суугч, аж ахуйн нэгж байгууллага, засаг захиргааны ажилтантай хамтран судалж, төлөвлөх,
- г) газар ашиглалтын талаар зөвлөх, тайлбар, график төлөвлөгөө, хөтөлбөрүүд, зураг төслийг хувь хүн болон нийгмийн бүлэгт гаргаж өгөх,
- д) хот, бүсийн төлөвлөлтийн талаар оршин суугч, аж ахуйн нэгж байгууллага, засаг захиргааны ажилтанд зөвлөх,
- е) хүрээлэх орчинд нөлөөлөх хүчин зүйлийн талаар, шалгаж үнэлгээ хийх, тайлан гаргах,
- ж) хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг гаргах, зохицуулах,
- з) цэцэрлэгт хүрээлэн, сургууль, аж ахуйн нэгж байгууллага, нисэх онгоцны буудал, зам бусад холбогдох төсөл, худалдаа үйлчилгээ,

- үйлдвэр, орон сууцны барилгын талбайн газрыг төлөвлөх, тохижуулах,
- и) тээврийн хөдөлгөөн, нийтийн тээврийн хэрэгслийн үйл ажиллагааны тогтолцоо, үр ашиг, аюулгүй байдлыг хянах, чиглэлийг төлөвлөх, зөвлөх.
- к) хот төлөвлөлтийн норм нормативийг боловсруулна.
- л) хот төлөвлөлтийн бодлогын шинжлэх ухааны үндсийг хөгжүүлэх ажил хийх
- м) бүсчилсэн хөгжил орон нутгийн нэгжүүдийн байршлын хэтийн болон ойрын төлөвлөлт хийх
- н) эдийн засгийн бүсчлэлд хот суурин, барилгажилтыг төлөвлөнө.

**Энд ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Газар зохион байгуулагч, төлөвлөгч
- Тээврийн хөдөлгөөн төлөвлөгч
- Хот байгуулалтын төлөвлөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2161 Барилгын архитекторч
- 2162 Газар тохижуулалтийн архитекторч

**2165 ЗУРАГЗҮЙЧ, БАЙРЗҮЙЧ**

Зурагзүйч, байрзүйч нь судалгааны арга хэрэглэн газар, гол мөрөн, газрын хэвлийн байршил, тэнгэр эрхэсийн хил хязгаарыг нарийвчлан тогтоож, хүний гараар бий болгосон байгууламжийн онцлог төрх байдлыг зураглахад шинжлэх ухааны арга, математикийн зарчмуудыг ашиглах, дижитал, график, зурган илэрхийлэл хэлбэрээр зураг, бүдүүвч зэргийг боловсруулах, шинэчлэх, бэлтгэх, далд уурхайн зураг гаргах, босоо ба хөндлөн малталтын барилгын ажлыг удирдах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) газрын гадаргуу, орд, газар доорх гадаргуу, гол нуурын ёроол зэргийг судлах, хэмжих, тодорхойлон дүрслэх, уулын ажлын өрнөлтийн зураглал гаргах,
- б) төрөл бүрийн онцлог шинж байдлыг нь илэрхийлсэн дижитал хэлбэрээр судалгааны өгөгдлийг гаргах, ашиглалтын болон уурхайн эдэлбэр газрын солбицлын цэгийн координатыг тодорхойлж зурагжуулах,
- в) далай, гол нуурын барилга байгууламжийг төлөвлөх, суваг, хоолой, усны урсгалын чиглэлийг өөрчлөхтэй холбогдуулан газрын зураг, бүдүүвч схемийг гаргах,

- г) агаарын фото зураглалыг төлөвлөн, гүйцэтгэх,
- д) агаараас авсан болон бусад фото зургууд, хиймэл дагуулаас авсан зураг ашиглан дүн шинжилгээ хийх, хэрэглээний болон сэдэвчилсэн бүдүүвч зураг, газрын зураг боловсруулах, судалгааны баримт бичгүүд, өгөгдөл, одоо байгаа газрын зураг, тайлан, мэдээ, статистикийн мэдээг нэгтгэн, судлах,
- е) зураглал, фотограмметрийн хэмжилтийн систем, газрын харилцааны систем, газрын мэдээллийн системийн талаар судалгаа явуулах, боловсруулалт хийх,
- ж) газрын зургийг үйлдэхэд техникийн, гоо зүйн, эдийн засгийн асуудлуудыг судлах, зөвөлгөө өгөх,
- з) уурхайн шаардагдах бүхий л зураг төслийн ажлыг цаг тухайд нь гүйцэтгэх.

#### **Энд ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Байрзүйч, агаарын зураглалын
- Газрын харилцааны инженер
- Зурагзүйч
- Газар зохион байгуулагч
- Зурагзүйч, газрын
- Зурагзүйч, уурхайн
- Фотограмметрч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2149 Барилгын төсөвчин
- 3112 Барилгын байрзүйч
- 3115 Далай гол, мөрний зурагзүйч

### **2166 ГРАФИК, МУЛЬТИМЕДИА ЗОХИОМЖИЙН ДИЗАЙНЧ**

График, мультимедиа зохиомжийн дизайнер нь мэдээллийг хэвлэн нийтлэх, үйл ажиллагааг дуу бичлэгийн төрөл бүрийн хэлбэрт тухайлбал хальс, цахим, дижитал байдлаар үзүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) захиалагч болон оролцогчидтой зөвлөн төслийн зорилгыг тогтоож, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоох,
- б) мэдээллийн шаардлагыг судлан дүн шинжилгээ хийх,
- в) захиалагчдад зориулан төслийн санааг томъёолж, зөвлөлдөх,
- г) төслийн санааг тусгасан загвар, бүдүүвч, үзүүлэн, байгууламжийн зураг зэргийг бэлтгэх,
- д) гоо зүйн мэдрэмжийг техникийн болон бусад шаардлагуудад нийцүүлэн хөдөлгөөнт зураг, иж бүрэн графикийг дүрслэх,

- е) процессийг хөдөлгөөнд харуулахын тулд цахим төхөөрөмжийн программыг ашиглан 2 ба 3 хэмжээст дүрслэл бүтээх,
- ж) захиалагч, борлуулалт, үйлдвэрлэлийн ажилтантай төслийн шийдлийн талаар зөвшилцөх,
- з) материалын зориулалт, үзэмж, нийтлэлийн хэрэгсэл, хүргэх арга зэргийн шинэ загварыг зохион бүтээх сонголт, тодорхойлолтын талаар зөвлөх,
- и) сонгогдсон төслийг нарийвчлан боловсруулж, баримтжуулан эцэслэн үйлдвэрлэхэд бэлтгэх,
- к) сонгосон мэдээллийн хэрэгслээр бүтээгдэхүүний дамжуулалтыг хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дижитал зураач
- График дизайнч
- Зураглаач
- Мультимедиа дизайнч
- Нийтлэлийн дизайнч
- Вэб дизайнч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2161	Дотор засал, чимэглэлийн архитекторч
3432	Дотор засал, чимэглэлийн дизайнч
2513	Мультимедиа зохиогч
2651	Дүрслэх урлаач
2513	Вэб зохиогч

**ДЭД БҮЛЭГ 22**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТЭН**

Эрүүл мэндийн мэргэжилтэн нь эмчилгээ, сувилахуй, мал эмнэлэг, эм зүй, эрүүл мэндийн сурталчилгаанд анагаах ухааны мэдлэгээ хэрэглэх, үзэл баримтлал, онол, үйл ажиллагааны арга барилыг судлах, сайжруулах, хөгжүүлэх үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хүн, малын эмгэг, өвчлөл, тэдгээрийг эмчлэх арга замыг судлан шинжлэх ухааны мэдлэг олж авах, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, эдгэрүүлэх арга хэмжээ авах юмуу эрүүл энхийг сурталчлах, эрдэм шинжилгээний баримт бичиг, илтгэл, тайлан бэлтгэх, бусад ажилтныг удирдан чиглүүлэх үүрэг орно.

**Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:**

- |     |   |
|-----|---|
| 221 | Хүний их эмч                              |
| 222 | Сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн        |
| 223 | Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн |
| 224 | Яаралтай тусламжийн эмч, ажилтан          |
| 225 | Малын эмч                                 |
| 226 | Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн           |

**Тайлбар:**

Эрүүл мэндийн мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судлахад “YAMAT-08”-ыг ашиглахдаа эрүүл мэндийн хэд хэдэн ажил, мэргэжлийг дэд бүлэг 22 буюу “Эрүүл мэндийн мэргэжилтэн” гэсэн бүлгээс өөр бүлэгт ангилсан болохыг анхаараарай. Тухайлбал, мансуурал судлалын сэтгэл зүйч, био эмчилгээний инженер, клиникийн сэтгэл зүйч, эмчилгээний физикч гэх мэт.

## **БАГА БҮЛЭГ 221 ХҮНИЙ ИХ ЭМЧ**

---

Хүний их эмч нь орчин үеийн анагаахын зарчим, арга хэрэгслийг ашиглан хүний өвчин эмгэг, гэмтэл, биеийн ба сэтгэцийн бусад доройтлыг судлах, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Тэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй бусад ажилтны асаргаа, эмчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үнэлэх ба сургалт, судалгааны ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Өвчтний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох үүднээс өвчтөнийг үзэх, гэр бүлтэй нь уулзаж ярилцах, оношлогооны үүднээс шинжилгээ авах, хариуг нь судлах, эмчилгээ хийх, зааж бичих, сэргийлэх арга хэмжээ авах, мэс засал, клиникийн бусад ажиллабар үйлдэх, өвчтөний эдгэрэлт, эмчилгээний үр дүнг хянах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор эрүүл мэнд, хоол тэжээл, амьдралын хэв маягийн талаар зөвлөгөө өгөх, төрөх үеийн юмуу өмнөх, дараах хүндрэлийг зааварлах, зохицуулах, нарийн мэргэжлийн, удаан хугацааны зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай өвчтнийг зохих эмч, эрүүл мэндийн газарлуу аваачих, илгээх, үргэлжилсэн болон бүрэн эмчилгээ хийх үүднээс эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй эмчилгээний талаар харилцан мэдээлэл солилцох, засаг захиргааны байгууллагад төрөлт, нас баралт, ноцтой өвчлөлийн талаар мэдэгдэх, хүний бие эрхтний доройтол, өвчин эмгэгээс сэргийлэх, эмчлэх аргачлалын талаар судалгаа хийх.



Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2211 Ерөнхий мэргэжлийн эмч**

**2212 Нарийн мэргэжлийн эмч**

**2211 ЕРӨНХИЙ МЭРГЭЖЛИЙН ЭМЧ**

Ерөнхий мэргэжлийн эмч нь орчин үеийн анагаахын зарчим, арга хэрэгслийг ашиглан хүний өвчин эмгэг, гэмтэл, биеийн ба сэтгэцийн бусад доройтлыг судлах, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Тэд ажил үүргээ зөвхөн өвчин оношлох ба эмчилгээний аргаар хязгаарлалгүй иргэд, гэр бүл, хүн амын тодорхой бүлэгт тасралтгүй, бүх талын төгс эмчилгээ хийх хариуцлага хүлээнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өвчтний эрүүл мэндийн байдлыг тодорхойлохын тулд тэдэнд үзлэг хийх, гэр бүлтэй нь уулзаж ярилцах,
- б) лабораторийн шинжилгээ, рентген зураг, оношлогооны бусад хэрэгслийг зааж бичих, шинжилгээний хариуг судлан өвчлөл, эмгэгийн шалтгаан, үүсвэрийг тодорхойлох,
- в) өвчин, эмгэгээс сэргийлэх, эмчилгээний жор бичиг өгөх, эм тариа хийх, эмчлэх, зөвлөх, хяналт тавих зэрэг хэлбэрээр өвчтөнд тасралтгүй эмчилгээний тусламж үзүүлэх,
- г) мэс засал, клиникийн бусад ажиллабар хийх,
- д) өвчин, эмгэгээс сэргийлэх, эдгэрүүлэх зорилгоор эрүүл мэнд, хоол тэжээл, амьдралын хэв маягийн талаар зөвлөгөө өгөх,
- е) тусгайлсан эмчилгээ шаардлагатай иргэд, гэр бүлийг нарийн мэргэжлийн эмнэлэг, нөхөн сэргээх төв, бусад үйлчилгээний төврүү илгээх,
- ж) төрөхийн өмнөх, төрөх үеийн болон дараах үеийн хүндрэлийг тогтоох, зохицуулах,
- з) өвчтний, эмчилгээний мэдээлэл, түүхийг хөтлөх, үргэлжилсэн, бүрэн эмчилгээ хийхийн тулд эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй мэдээлэл солилцох,
- и) засаг захиргааны байгууллагад төрөлт, нас баралт, ноцтой өвчлөлийн талаар мэдэгдэх,
- к) хүний эрүүл мэнд, эмчилгээ-оношлогоо, үйлчилгээний талаар судалгаа хийх, болон сэргийлэх, эмчлэх аргачлалын талаар судлах, эрдэм шинжилгээний илтгэл, нийтлэлээр мэдээ баримтыг түгээх,
- л) нийтлэг өвчлөл үүсэх, тархахаас сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдэд оролцох, тэдгээрийг төлөвлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дүүргийн хүний эмч
- Өрхийн эмч
- Ерөнхий мэргэжлийн эмч
- Хүний их эмч
- Ерөнхий эмчилгээгээр мэргэшиж байгаа резидент эмч
- Дотрын эмч (ерөнхий мэргэжлийн )
- Анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч эмч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2212	Нарийн (төрөлжсөн) мэргэжлийн эмч
2212	Мэс заслын эмч
2212	Мэдрэлийн эмч
2212	Сэтгэцийн эмгэг судлалын эмч
2240	Клиникийн ажилтан

**Тайлбар:**

Энэхүү ангилалд багтсан ажил, мэргэжил нь анагаахын суурь боловсрол эзэмшсэн байх ба дараагийн шатны клиник сургалттай дүйцэхүйц чанар, стандарт буюу дээд боловсролын мэргэшлийн зэрэглэлийн шаардлагыг бүрэн хангасан байна. Мөн ийм шаардлага хангасан резидентурын сургалтыг дүүргэсэн эмч энд хамрагдана.

**2212 НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ**

Нарийн (төрөлжсөн) мэргэжлийн эмч нь орчин үеийн анагаахын зарчим, арга хэрэгслийг ашиглан хүний өвчин эмгэг, гэмтэл бэртэл, бие махбод, сэтгэцийн бусад эмгэгийг тусгай сорил, оношлогоо, анагаах, мэс засал, фикик болон сэтгэцийн арга техник судлах, оношлох, эмчлэх, сэргийлэх үүрэгтэй. Тэд тодорхой өвчин, эмчилгээний арга зэргээр дагнан мэргэшиж, сонгосон мэргэжлээрээ анагаахын сургалт, судалгаа эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өвчтөн үзэх, эрүүл мэндийн байдлыг нь тодорхойлох үүднээс тэдний гэр бүлтэй уулзаж ярилцах,
- б) зөвлөмж болгосон эмч юмуу бусад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчийн өгсөн эмчилгээтэй холбоотой мэдээллийг авч үзэх,
- в) өвчлөл, эмгэгийн шалтгаан үүсвэрийг тодорхойлох үүднээс лабораторийн тусгай шинжилгээ зааж бичих,
- г) тусгай болон ерөнхий мэс ажиллабар хийх,
- д) төрөх болон өмнөх, дараахь үеийн хүндрэлийг зохицуулах,
- е) өвчтний, эмчилгээний мэдээлэл, тэмдэглэл хөтлөх, үргэлжилсэн болон бүрэн эмчилгээний талаар бусад эрүүл мэндийн мэргэжилтэнтэй харилцан мэдээлэл солилцох,

- ж) мэргэжлийн болон хуулийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу засаг захиргааны байгууллагад төрөлт, нас баралт, ноцтой өвчлөлийн талаар мэдэгдэх,
- з) өвчтөн, гэр бүл, хүн амын тодорхой бүлэгт тодорхой өвчнөөс сэргийлэх, эмчилгээний талаар мэдээлэл өгөх,
- и) үхлийн шалтгааныг тогтоох задлан шинжилгээ хийх,
- к) хүний эрүүл мэнд, анагаах, үйлчилгээний талаар судалгаа хийх, болон сэргийлэх, эмчлэх аргачлалын талаар судлах, эрдэм шинжилгээний илтгэл, нийтлэлээр мэдээ баримтыг түгээх,
- л) нийтлэг өвчлөл үүсэх, тархахаас сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдэд оролцох, тэдгээрийг төлөвлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч
- Зүрх судасны эмч
- Эмнэлгийн яаралтай тусламжийн эмч
- Эмэгтэйчүүдийн эмч
- Эх барихын эмч
- Нүдний эмч
- Хүүхдийн эмч
- Эмгэг судлалын эмч
- Дүрс оношлогооны эмч
- Нарийн (төрөлжсөн) мэргэжлээр мэргэшиж байгаа резидент эмч
- Мэс заслын эмч
- Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2131	Биоанагаахын судлаач
2211	Ерөнхий мэргэжлийн эмч
2261	Нүүр амны эмч (шүдний эмч)
2261	Нүүр амны мэс засалч
2634	Клиникийн сэтгэл зүйч

**Тайлбар:**

Энэхүү ангилалд багтсан ажил, мэргэжил нь анагаахын суурь боловсрол дээр анагаахын төрөлжсөн мэргэжлийн (ерөнхий мэргэжлийн эмчээс бусад) эмчтэй дүйцэхүйц мэргэжлийн дараах шатны болон резидентурын сургалтыг оруулаад дээд түвшний шаардлагыг хангасан байна.

Амьд байгалийг ашиглан биоанагаахын судалгаа явуулдаг буюу клиникийн үйл ажиллагаа эрхэлдэггүй анагаахын судлаач мэргэжилтэнг нэгж бүлэг 2131 буюу “Биологич, ботаникч, амьтан судлаач, холбогдох мэргэжилтэн” гэсэн ангилалд багтана.

**БАГА БҮЛЭГ 222****СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН МЭРГЭЖИЛТЭН**

---

Сувилахуй, эх барихуйн мэргэжилтэн нь бие махбодь, сэтгэцийн эмгэгтэй, тахир дутуу, доройтсон, эрүүл мэндийн хувьд асаргаа сувилгаа шаардлагатай юмуу төрөх үеийн, өмнө ба дараахь үеийн эрсдэлтэй хүмүүст эмчилгээ, асаргаа хийнэ. Тэд өвчтөний асаргааг зохицуулах, үнэлэх, бие даан юмуу их эмч, сэргийлэх, эмчлэх ажилтай бусад мэргэжилтний багт орж ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Орчин үеийн сувилахуй, эх барихуйн практик, стандартын дагуу өвчтөнд сувилахуй, эх барихуйн үйлчилгээ үзүүлэх, туслах, төлөвлөх, үнэлэх, эрүүл мэндийн мэргэжилтэн, багийн гишүүдтэй зөвлөлдөн өвчтөний асаргаа сувилгааг зохицуулах, эм эмчилгээ хийх зэргээр асран сувилах төлөвлөгөө, эм засал боловсруулах, хэрэгжүүлэх, өвчтөний өвчин, зовиурыг намдаах эм өгөх зэрэг төрөл бүрийн хяналтанд авах, намдаах, жирэмслэлтийн явц, эмчилгээний үр дүнг хянах, өвчтөн, гэр бүл, хүн амын тодорхой бүлэгт эрүүл мэндийн холбогдолтой асуудлаар буюу тодорхой өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээ, жирэмслэлт, төрөлттэй холбоотой мэдээлэл өгөх, эрүүл мэндийн бусад ажилтнуудын ажил үүргийг хянах, сувилахуй, эх барихын асуудлаар судалгаа шинжилгээ хийх, эрдэм шинжилгээний баримт бичиг, тайланг бэлтгэн боловсруулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2221 Сувилахуйн мэргэжилтэн****2212 Эх барихуйн мэргэжилтэн****2221 СУВИЛАХУЙН МЭРГЭЖИЛТЭН**

Сувилахуйн мэргэжилтэн нь насжилтын дарамт, гэмтэл бэртэл, өвчлөл болон бусад бие махбодь, сэтгэцийн эмгэгтэй, тахир дутуу, доройтсон, эрүүл мэндийн хувьд асаргаа сувилгаа шаардлагатай эрсдэлтэй хүмүүст эмчилгээ, асаргаа хийнэ. Тэд өвчтөний асаргааг төлөвлөх, зохицуулах, үнэлэх юмуу бие даах эсвэл эмч, эмчилгээний мэргэжилтний багтай хамтран ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) орчин үеийн сувилахуйн практик, стандартын дагуу өвчтөнд сувилахуйн үйлчилгээ хийх, түүнд үнэлгээ, дүгнэлт хийх,

- б) эрүүл мэндийн мэргэжилтэн, тэдний багтай зөвлөлдөн өвчтөний асаргаа сувилгааг зохицуулах,
- в) эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран өвчтөний биологи, нийгэм, сэтгэл зүйн эмчилгээ, сувилгааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх,
- г) өвчтөнд хийх эмчилгээ, асаргаа сувиллыг төлөвлөх, эм бэлдмэл өгөх, эмчилгээ, асаргааны үр дүнд хяналт тавих,
- д) шарх цэвэрлэх, мэс заслын боолт хийх,
- е) өвчтөнд өвчин, зовиурыг нь намдаах эм өгөх зэрэг эмчилгээний олон аргаар хяналтандаа байлгах,
- ж) эмнэлэг, нийгэм бүлэгийн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр, эрүүл мэндийг сурталчлан таниулах, сувилахуйн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, түүнд оролцох,
- з) үйлчлүүлэгч, түүний асуултад хариулах, эрүүл мэнд муудах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэн эмчлэх талаар мэдээлэл өгөх,
- и) сувилахуйн, эрүүл мэнд, асаргааны бусад ажилтны ажил үүргийг хянах,
- к) сувилахуйн асуудлаар судалгаа шинжилгээ хийх, өөрийн судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний сурталчилгааны баримт бичиг, тайлангаар түгээх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Клиникийн сувилахуйн мэргэжилтэн
- Дүүргийн сувилахуйн мэргэжилтэн
- Нойрсуулагч сувилахуйн мэргэжилтэн
- Зааварлагч сувилахуйн мэргэжилтэн
- Ерөнхий мэргэжлийн сувилахуйн мэргэжилтэн
- Төрөлжсөн мэргэжлийн сувилахуйн мэргэжилтэн
- Нийтийн эрүүл мэндийн сувилагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2222	Эх барихуйн мэргэжилтэн
2240	Яаралтай тусламжийн эмч, ажилтан
2310	Дээд боловсрол олгох багш
2310	Техник, мэргэжлийн төвийн багш
3221	Сувилахуйн туслах/дэд мэргэжилтэн
3222	Эх барихуйн туслах/дэд мэргэжилтэн
5321	Эмнэлгийн сувилгааны туслах ажилтан

**Тайлбар:**

Сувилахуйн боловсрол болон судалгаа шинжилгээний ажлыг клиникийн сувилахуйтай хослуулан эрхэлдэг сувилахуйн мэргэжилтэнг нэгж бүлэг 2221 буюу “Сувилахуйн мэргэжилтэн” гэсэн ангилалд хамааруулна. Амьд байгаль, биоанагаахын судалгаа хийхэд оролцдог, клиникийн сувилахуйн ажиллагаанд оролцдоггүй сувилахуйн

мэргэжилтэнг нэгж бүлэг 2131 буюу “Биологич, ботаникч, амьтан судлаач холбогдох мэргэжилтэн” гэсэн ангилалд хамааруулна.

## 2222 ЭХ БАРИХУЙН МЭРГЭЖИЛТЭН

Эх барихуйн мэргэжилтэн нь жирэмслэх ба төрөхөөс өмнөх, төрөх үеийн болон дараах үеийн эх барихын үйлчилгээ хийх, төлөвлөх, удирдах, үнэлэх үүрэгтэй. Тэд бие даах юмуу эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бусад байгууллагатай хамтран эмэгтэйчүүд, шинээр мэндэлсэн хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулахын төлөө ажиллана.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) орчин үеийн эх барихуйн практик, стандартын дагуу эмэгтэйчүүд болон нярай хүүхдэд төрөхөөс буюу жирэмслэхээс өмнөх, төрөх үеийн, дараа нь үзүүлэх эх барихын үйлчилгээг төлөвлөх, удирдах, үнэлэх,
- б) хоол тэжээл, ариун цэвэр, биеийн тамир, төрөлт болон гэнэтийн тохиолдол, хөхөөр тэжээх зорилт, нярайн асаргаа, гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл, амьдралын эрүүл хэв маяг зэрэг жирэмслэлт, төрөлттэй холбоотой асуудлаар эмэгтэйчүүд, гэр бүлд зөвлөгөө өгөх, хүн амын тодорхой бүлэгт эрүүл мэндийн боловсрол олгох,
- в) жирэмслэлт ба төрөлтөд үнэлгээ хийх, гарах хүндрэлийг зохицуулах, шаардлагатай үед эх барихуйн нарийн мэргэжлийн эмчид хандуулах арга хэмжээ авах,
- г) нярай хүүхдийн эрүүл мэндийн байдал, тохиолдох хүндрэлийг зохицуулах, шаардлагатай бол эх барихуйн нарийн мэргэжлийн эмчид хандах арга хэмжээ авах,
- д) төрөхийн өмнөх болон төрөх үеийн өвчин, зовиурыг ажиглах, төрөл бүрийн заслаар буюу өвчин намдаах эм өгөх зэргээр намдаах,
- е) өвчин, зовиурыг намдаах эм өгөх зэрэг төрөл бүрийн аргаар хяналтандаа байлгах,
- ж) эмнэлэг, нийгэм бүлгийн эрүүл мэндийн боловсрол хөтөлбөр, эрүүл мэндийг сурталчлан таниулах, сувилахуйн боловсролын хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох,
- з) мэргэжлийн болон хууль тогтоомжийн үүднээс засаг төрийн байгууллагуудад төрөлтийн талаар мэдэгдэх,
- и) сувилахуйн асуудлаар судалгаа шинжилгээ хийх, үр дүнг эрдэм шинжилгээний баримт бичиг, тайлангаар түгээх,
- к) эмнэлэг, нийгэм бүлгийн эх барихуйн боловсролын хөтөлбөрийг төлөвлөх, зохион байгуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эх барихуйн мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2221	Сувилахуйн мэргэжилтэн
3221	Сувилахуйн туслах мэргэжилтэн
3222	Эх барихуйн туслах мэргэжилтэн
5321	Эмнэлгийн сувилгааны туслах ажилтан
3221	Сувилахуйн туслах мэргэжилтэн
3222	Эх барихуйн туслах мэргэжилтэн
5321	Сувилахуйн мэргэжилтнийн туслах ажилтан

**Тайлбар:**

Эх барихуйн боловсрол болон судалгаа шинжилгээний ажлыг клиникийн эх барихуйтай хослуулан ажилладаг эх барихуйн мэргэжилтнийг нэгж бүлэг 2222 буюу “Эх барихуйн мэргэжилтэн” гэсэн ангилалд хамруулна.

**БАГА БҮЛЭГ 223****УЛАМЖЛАЛТ, ХАВСАРГА АНАГААХЫН МЭРГЭЖИЛТЭН**

Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн нь өвчин эмгэг, гэмтэл бие махбодь, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, бясгалал хийж засах, эсийн түвшинд хорыг тайлах, тодорхой өвөрмөц уламжлалаас үүдэлтэй онол, итгэл үнэмшил, туршлага сэлтийг өргөнөөр судласны дүнд олж авсан мэдлэг, чадвар, практикийг орчин үеийн анагаах ухаантай хослуулан ашиглаж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

Өвчтний эрүүл мэндийн байдлыг нь тодорхойлох үүднээс тэднийг үзэх, гэр бүлтэй нь уулзаж ярилцах, зүү төөнө, зөөлөн эмчилгээ, эмийн ургамал ашиглан бие, сэтгэцийн өвчин эмгэг, хууч өвчнийг эмчлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, эрүүл мэнд, хоол тэжээл болон амьдралын эрүүл хэв маяг зэрэг асуудлаар иргэд, гэр бүл, нийгэм бүлэгт зөвлөгөө өгөх, эмийн ургамал, эрдэс, малын гаралтай уламжлалт эм бэлдмэлийг бэлтгэн эмийн жор бичиж, бие эрхтний анагаах чадварыг дэмжих, үргэлжилсэн болон бүрэн эмчилгээний зорилгоор эрүүл мэндийн мэргэжилтэнтэй эмчилгээний талаар мэдээлэл солилцох, уламжлалт анагаах, хавсарга ухааны асуудлаар судалгаа шинжилгээ хийх, үр дүнг эрдэм шинжилгээний ном, өгүүлэл, тайлан болгож түгээх.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

### **2230 Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн**

#### **2230 УЛАМЖЛАЛТ, ХАВСАРГА АНАГААХЫН МЭРГЭЖИЛТЭН**

Уламжлалт, хавсарга анагаах нь эм тариа, эмчилгээний тоног төхөөрөмж шаардахгүй, олон зуун жилийн туршлагаар батлагдсан, хүн өөрөө өөрийгөө болон өрөөл бусдыг анагаан эмчлэх явдал юм. Өнө эрт үед хэрэглэж байсан уламжлалт эмчилгээний арга, тухайлбал, эмийн ургамал, зүү төөн, эллэг бариа засал, рашаан ус, нар, элсэн эмчилгээ, энергийн урсгалыг зохицуулах мутрын эмчилгээ, бясалгал, бөө, шашны зан үйл зэргийг олон жилээр судалж, мэргэшсэн байхыг шаардана.

Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн нь өвчин эмгэг, гэмтэл, бие махмодь сэтгэцийг бяслаглал хийж засах, эсийн түвшинд байгаа хорыг тайлах, уламжлалт аргыг орчин үеийн анагаах ухаантай хослуулах, сэтгэцийн эмгэгээс сэргийлэх, оношлох, эмчлэх, тодорхой өвөрмөц соёлын уламжлалаас үүдэлтэй онол, итгэл үнэмшил, туршлага сэлтийг өргөнөөр, удаан хугацаанд судласны дүнд олж авсан мэдлэг, чадвар, практикаа ашиглан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) өвчтөнг үзэх, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг нь тодорхойлох үүднээс тэдэнд үзлэг хийх, тэдэнтэй болон гэр бүлийнхэнтэй нь уулзаж ярилцах,
- б) зүү төөн, зугуухан эмчилгээ, эмийн ургамлыг ашиглан бие, сэтгэцийн өвчин эмгэг, хуучийг эмчлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
- в) өвчтнийг эмчлэх төлөвлөгөөний үр дүн, явцыг үнэлэх, баримтжуулах,
- г) эрүүл мэнд, хоол тэжээл, амьдралын эрүүл хэв маягийн асуудлаар иргэд, гэр бүл, нийгэм бүлэгт зөвлөгөө өгөх,
- д) эмийн ургамал, эрдэс, малын гаралтай бүхий уламжлалт эм бэлдмэлийг бэлтгэх, түүнийгээ жороор олгож, бие эрхтний өөрийгөө анагаах чадварыг дэмжих,
- е) үргэлжилсэн болон бүрэн эмчилгээний зорилгоор эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй эмчилгээний талаар мэдээлэл солилцох,
- ж) уламжлалт, хавсарга анагаахын асуудлаар судалгаа хийх, үр дүнг эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, тайлангаар түгээх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зүү тавигч
- Төөнч



- Зөөлөн /аюурвед/ эмчилгээний мэргэжилтэн
- Эмийн ургамлын мэргэжилтэн
- Судас баригч, цэгэн эмчилгээний мэргэжилтэн
- Эмийн бус эмчилгээний мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3230	Эмийн ургамал судлаач
3230	Домч/домногч
3230	Бумбаар эмчлэгч
3255	Био тогоор эмчлэгч
3255	Усан засалч
3259	Бариач
3259	Яс эмчлэгч
3413	Итгэл үнэмшил/сүжиг бишрэл/-ээр эдгээгч

**Тайлбар:**

Уламжлалт, хавсарга анагаахын ажил, мэргэжил нь уламжлалт анагаахын чиглэлээр ихээхэн мэдэц ойлгоцтой, хүний биеийн анатоми, орчин үеийн анагаахын элементүүдийг удаан хугацаанд суралцаж, судласан байх шаардлага тавьдаг бөгөөд эдгээрийг нэгж бүлэг 2230 буюу “Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн” гэсэн ангилалд багтаасан болно. Харин богино хугацаанд суралцан, албан бус сургалт буюу тухайн орон нутгийн уламжлал, өвөг дээдсийн практикийг өвөлсөн ажил, мэргэжил нь нэгж бүлэг 3230 буюу “Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд ажилтан” гэсэн ангилалд багтаж, хавсарга анагаахын мэргэжилтны удирдамж, зааварчлагын дор ажиллана. Эмийн ургамал, сэтгэл засал буюу гар заслын аргачлалыг ашиглан уламжлалт эмчилгээ хийгчийг нэгж бүлэг 2230-д хамаруулахгүй.

**БАГА БҮЛЭГ 224  
ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭМЧ, АЖИЛТАН**

Эмнэлгийн яаралтай тусламжийн эмч, ажилтан нь цар хүрээ, төвөгшлийн хувьд ердийн эмчийг бодвол харьцангуй хязгаарлагдмал хүрээнд зөвлөх, оношлох, сэргийлэх үйлчилгээ үзүүлдэг. Тэд бие даах юмуу эмчийн хязгаарлагдмал хяналт дор ажилладаг, өвчин эмгэг, гэмтэл, бие, сэтгэцийн нийтлэг эмгэгээс хүн амын тодорхой хэсгийг урьдчилсан сэргийлэх, эмчлэхэд клиникийн зүгширсэн үйлчилгээ үзүүлдэг.

**Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийнх нь байдлыг нь тодорхойлох үүднээс тэднийг үзэх, тэд болон гэр бүлийнхэнтэй нь уулзаж ярилцах, өвчний түүх хөтлөх, энгийн, мэс ажиллабар хийх, эм бэлдмэл өгөх, жор бичих, нийтлэг өвчин, эмгэгийг эмчлэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээ авах,

лабораторийн шинжилгээ, рентген зураг, зүрхний бичлэг, оношлогооны бусад хэрэгсэлийг зааж бичих, гүйцэтгэх, тарилга, вакцинжуулалт хийх, оёдол тавих, шарх боож цэвэрлэх, хадваргүйжүүлэлтийн бусад эмчилгээ хийх, нарийн мэс заслын үед эмчид туслах, өвчтний эмчилгээний үр дүнг хянах, нарийн мэргэжлийн эмчид хандах шаардлагыг тодорхойлох, өвчтөн, гэр бүлд хоолны дэглэм, биеийн тамир, бусад дэглэмийн талаар зөвлөгөө өгөх, ингэснээр өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хүндрэлтэй юмуу онцгой тохиолдлуудыг илрүүлэх, нарийн мэргэжлийн эмч, эмнэлэгт илгээх, мэргэжлийн болон хуулийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу төрийн байгууллагад төрөлт, нас баралт, ноцтой өвчний талаарх мэдээлэл өгөх.

Энэхүү бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

## **2240 Яаралтай тусламжийн эмч, ажилтан**

### **2240 ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭМЧ, АЖИЛТАН**

Яаралтай тусламжийн эмч, ажилтан нь цар хүрээ, төвөгшлийн хувьд ердийн эмчийг бодвол харьцангуй хязгаарлагдмал хүрээнд зөвлөх, оношлох, сэргийлэх үйлчилгээ үзүүлдэг. Тэд бие даах юмуу эмчийн хязгаарлагдмал хяналт дор ажилладаг, өвчин эмгэг, гэмтэл, бие, сэтгэцийн нийтлэг эмгэгээс хүн амын тодорхой хэсгийг урьдчилсан сэргийлэх, эмчлэхэд клиникийн зүгширсэн үйлчилгээ үзүүлдэг.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчийн эрүүл мэндийнх нь байдлыг нь тодорхойлох үүднээс тэднийг үзэх, тэд болон гэр бүлийнхэнтэй нь уулзаж ярилцах, өвчний түүх хөтлөх,
- б) энгийн, мэс ажиллабар хийх, эм бэлдмэл өгөх, жор бичих, нийтлэг өвчин, эмгэгийг эмчлэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээ авах,
- в) лабораторийн шинжилгээ, рентген зураг, зүрхний бичлэг, оношлогооны бусад хэрэгсэлийг зааж бичих, гүйцэтгэх,
- г) тарилга, вакцинжуулалт хийх, оёдол тавих, шарх боож цэвэрлэх, хадваргүйжүүлэлтийн бусад эмчилгээ хийх,
- д) нарийн мэс заслын үед эмчид туслах,
- е) өвчтний эмчилгээний үр дүнг хянах, нарийн мэргэжлийн эмчид хандах шаардлагыг тодорхойлох,
- ж) өвчтөн, гэр бүлд хоолны дэглэм, биеийн тамир, бусад дэглэмийн талаар зөвлөгөө өгөх, ингэснээр өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх,

- з) хүндрэлтэй юмуу онцгой тохиолдлуудыг илрүүлэх, нарийн мэргэжлийн эмч, эмнэлэг, тусгай газар луу илгээх,
- и) мэргэжлийн болон хуулийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу засгийн байгууллагад төрөлт, нас баралт, ноцтой өвчин гарсан талаар мэдэгдэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Клиникийн ажилтан
- Анхан шатны тусламж үзүүлэгч
- Мэс заслын техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2211	Ерөнхий мэргэжлийн эмч
2212	Мэс засалч
3256	Эмчилгээний туслах ажилтан
3258	Яаралтай тусламжийн ажилтан

**Тайлбар:**

Энэхүү ангиллын ажил үүрэг нь анагаахын онол, практикийн хувьд дээд боловсрол эзэмшсэн байхыг шаарддаг. Яаралтай тусламжаар хязгаарлагддаг ажилтанг нэгж бүлэг 3258 буюу “Яаралтай тусламжийн ажилтан” гэсэн ангилалд оруулна.

**БАГА БҮЛЭГ 225  
МАЛЫН ЭМЧ**

---

Малын эмч нь мал, амьтны өвчлөл, гэмтэл, саатлыг оношилж, сэргийлэх, эмчлэх үүрэгтэй. Тэд төрөл бүрийн амьтан юмуу тодорхой төрөл, чиглэлээр мэргэшиж, арилжааны байгууллагад биологи, эм зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбогдсон мэргэжлийн зөвлөгөө өгнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мал, амьтны биед үзлэг хийх, лабораторийн шинжилгээ, оношлогооны тусгай төхөөрөмж, рентген, хэт авианы тусламжтайгаар мал, амьтны хэвийн, бус эсэхийг тогтоох, эм бэлдмэл, өвчин намдаагч жороор бичих, бүтэн юмуу хэсэгчилсэн мэдээ алдуулагч хэрэглэн мал, амьтныг эмчилгээ, мэс заслын аргаар эмчлэх, мэс ажиллабар хийх, шарх боох, хугарсан яс хадах, төл, зулзага эх барьж авах, мал, амьтны гаралтай өвчин үүсэх, тархахаас сэрийлэх хөтөлбөрт оролцох, малыг хадварт өвчнөөс сэргийлэн вакцинжуулах, халдварт өвчнийг шижлэх, малын гаралтай ноцтой өвчин гарах үед холбогдох байгууллагад мэдэгдэх, үхлийн шалтгааныг тогтоох үүднээс задлан шинжилгээ хийх, үйлчлүүлэгчдэд мал, амьтны эрүүл

мэнд, хоол тэжээл, хооллолт, ариун цэвэр, үржүүлэг, асаргаа арчилгааны талаар зөвлөгөө өгөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлий дараах нэгж бүлэгт ангилна:

## **2250 Малын эмч**

### **2250 МАЛЫН ЭМЧ**

Малын эмч нь мал, амьтны өвчлөл, гэмтэл, саатлыг оношилж, сэргийлэх, эмчлэх үүрэгтэй. Тэд төрөл бүрийн амьтан юмуу тодорхой төрөл, чиглэлээр мэргэшиж, арилжааны байгууллагад биологи, эм зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбогдсон мэргэжлийн зөвлөгөө өгнө.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) мал, амьтны биед үзлэг хийх, лабораторийн шинжилгээ, оношлогооны тусгай төхөөрөмж, рентген, хэт авианы тусламжтайгаар мал, амьтны хэвийн, бус эсэхийг тогтоох,
- б) эм бэлдмэл, өвчин намдаагч жороор бичих, бүтэн юмуу хэсэгчилсэн мэдээ алдуулагч хэрэглэн мал, амьтныг эмчилгээ, мэс заслын аргаар эмчлэх,
- в) мэс ажиллабар хийх, шарх боох, хугарсан яс хадах,
- г) мал, амьтны гаралтай өвчин үүсэх, тархахаас сэрийлэх хөтөлбөрт оролцох,
- д) малыг хадварт өвчнөөс сэргийлэн вакцинжуулах, халдварт өвчнийг шинжлэх, малын гаралтай ноцтой өвчин гарах үед холбогдох байгууллагад мэдэгдэх,
- е) үхлийн шалтгааныг тогтоох үүднээс задлан шинжилгээ хийх,
- ж) үйлчлүүлэгчдэд мал, амьтны эрүүл мэнд, хоол тэжээл, хооллолт, ариун цэвэр, үржүүлэг, асаргаа арчилгааны талаар зөвлөгөө өгөх,
- з) арвин ашиг шимт малын үр, хөврөл үр, өндгөн эс үйлдвэрлэх /үр, хөврөл, үрийг үнэлэх, шингэлэх, ичээлэх, хөлдөөх, хадгалах,
- и) малын удмын санг хамгаалах буюу үржилд ашиглах зорилгоор үр, хөврөл үрийг стандартын дагуу хадгалж нөөцлөх,
- к) мөхөхөд хүрч буй үүлдэр, омгийн малын үрийг авч нөөцлөх,
- л) сар бүр цөм сүргийн малын ашиг шимд хяналтын хэмжилт, жигнэлт хийх, азот цехийн тоног төхөөрөмжийн байнгын хэвийн ажиллагааг хангах,
- м) технологийн дагуу малаас дээж авах, шинжилж, дүгнэлт гаргах,
- н) тухайн малын бүртгэл хөтлөх,
- о) зохиомол болон ердийн хээлтүүлэгт бүртгэл хөтлөх,

- ө) өвчилсэн үхэр байгаа эсэх, эмчилсэн тухай бүртгэл хөтлөх,
- п) худалдсан, үхсэн болон бусад шалтгаанаар сүргээс хасагдсан үхрийн бүртгэл хөтлөх,
- р) шинээр сүрэг сэлбэсэн тухай бүртгэл хөтлөх,
- с) малын амьты жинг тодорхойлох,
- т) үржлийн бүртгэлийн тухай мэдээллийг сар бүр хэрэглэгчдэд хүргэх

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мал, амьтны эмгэг зүйч
- Малын эмч
- Мал, амьтны гаралтай өвчний тархалт судлаач
- Малын эмчийн дадлагажигч
- Малын эмч, мэс заслын
- Малын нөхөн үржихүйн мэргэжилтэн
- Үрийн бактерилогич
- Азот цехийн эрхлэгч
- МАА-н үйлдвэрлэлийн технологийн мэргэжилтэн
- Малын үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч

**БАГА БҮЛЭГ 226**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Эрүүл мэндийн бусад мэргэжилтэн нь шүдний эмгэг, эм зүй, хүрээлэн буй орчны эрүүл мэнд, ариун цэвэр, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал, физик эмчилгээ, хоол тэжээл, сонсгол, хэл яриа, хараа, нөхөн сэргээх эмчилгээтэй холбоотой бүхий л эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ. Энэхүү бага бүлэгт эмч, уламжлалт, хавсарга эмчилгээний ажилтан, малын эмч, сувилагч, эх баригч болон яаралтай тусламжийн ажилтнаас бусад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнийг оруулдаг.

**Гүйцэтгэх үүрэг:**

Өвчин, эмгэг юмуу зовиурын үүсвэрийг тодорхойлох үүднээс үйлчлүүлэгчдэд үзлэг хийх, эмчилгээний төлөвлөгөө гаргах, эмчилгээ хийх, өвчтний эмчилгээний явцад үнэлгээ хийх, баримтжуулах, нүд, ам, эрүү зэрэг эд эрхтэний өвчлөл, гэмтэл, гажигийг оношлох, эмчлэх, эм бэлдмэлийг агуулж, хадгалах, химийн нэгдэлд сорилт хийх, жороор эм олгох, эм тариа зөв хэрэглэх, сөрөг үр дагаварыг хэрхэх талаар зөвлөгөө өгөх, хүний эрүүл мэндэд нөлөөлөгч хүрээлэх орчны хүчин зүйлсийг тогтоох, хянах, хүний биеийн хөдөлгөөний функцийг сэргээх, сайжруулах,

өвчин, зовиурыг намдаах, хүний эрүүл мэндэд үзүүлэх хүнс, тэжээлийн эерэг нөлөөг нэмэгдүүлэх, хүний сонсгол, хэл яриа, залгиур болон хараанд орсон өөрчлөлт, гажигийг оношлох, эмчлэх, үйлчлүүлэгчдэд үргэлжлүүлэх эмчилгээ, арчилгааны талаар зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн болон холбогдох бусад мэргэжилтэнд хандуулах.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **2261 Нүүр амны эмч**

### **2262 Эм зүйч**

### **2263 Хүрээлэх орчны болон үйлдвэрлэлийн, эрүүл мэнд, ариун цэврийн мэргэжилтэн**

### **2264 Нөхөн сэргээх эмчилгээний эмч**

### **2265 Хоолны арга зүйч, хоол тэжээлийн мэргэжилтэн**

### **2266 Сонсголын мэргэжилтэн, хэлний сосог засалч**

### **2267 Хараа зүйч, хараа хэмжигч**

### **2269 Аль нэг ангилалд ороогүй эрүүл мэндийн мэргэжилтэн**

## **2261 НҮҮР АМНЫ ЭМЧ**

Нүүр амны (шүдний) эмч нь шүдний орчин үеийн эрүүл мэндийн зарчим, арга хэрэгслийг ашиглан шүд, ам холбогдох эд эрхтний өвчин, гэмтэл, гажигийг оношлох, эмчлэх, сэргийлэх үүрэгтэй. Тэд өргөн хүрээний тусгайлсан оношлогооны, мэс заслын болон бусад технологийг амны хөндийн эрүүл мэндийг сэргээх, дэмжих зорилгоор ашигладаг.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) нүүр, ам, эрүү зэрэг холбогдох бүтцийн өвчин, гэмтэл, гажиг, шүдний эмгэгийг рентген, шүлсний шинжилгээ, өвчний түүх ашиглан оношлох,
- б) нүүр, амны хавийн эдийг эмчлэх, флорт түрхлэг хийх зэрэг амны хөндийн эрүүл мэндийн сэргийлэх эмчилгээ хийх, хөхиүлэн дэмжих,
- в) эмчилгээний явцад мэдрэгдэх өвчин, зовиурыг намдаах үүднээс хэсэгчилсэн мэдээ алдуулалт хийх,
- г) эмчилгээний дараа зовиур үргэлжлэх тохиолдолд намдаах үүднээс эмийн жор бичиж өгөх,

- д) амны хөндийн нөхөн сэргээх хэрэгсэл, хиймэл шүд, бүрээс, холбоос, шүдний аппарат зэргийг суулгах, өвчилсөн, хорхойтсон шүдийг эмчлэх,
- е) шүд авах, эсийн шинжилгээ авах, шүдний аппарат суулгах зэрэг мэс ажиллабар хийх,
- ж) хиймэл шүдний хэмжээ, хэлбэрийг тодорхойлохын тулд эрүү, шүдний хэв авах, хэмжих,
- з) хиймэл шүдний хэрэгслүүд шүдний зай хадгалагч, холбоос, тагнай бүхий хиймэл шүдний загвар гаргах, хийх, тохируулах, хиймэл шүдний техникчид өгөх жор, заавар бичих,
- и) авч болдог болон байнгын хиймэл эрхтэн суулган амны хөндийн эрүүл мэндийг сэргээх,
- к) үйлчлүүлэгч, гэр бүлд амны хөндийн эрүүл мэндийг сахих амын хөндийн ариун цэвэр, хоол хүнс бусад аргын талаар мэдлэг олгох,
- л) шүдний эрүүл ахуйч, сувилагч болон бусад ажилтныг удирдах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нүүр амны эмч, ерөнхий эмчилгээний
- Нүүр амны эмч, гажиг заслын
- Нүүр амны эмч, согог заслын
- Нүүр амны эмч, мэс заслын
- Нүүр амны эмч, хүүхдийн
- Нүүр амны өвчин судлаач

**2262 ЭМ ЗҮЙЧ**

Эм зүйч нь эмийн бүтээгдэхүүнүүдийг хадгалах, нөөцлөх, нэгдэлд хувиргах, бэлтгэх, эмчлэгч эмч болон анагаахын мэргэжилтний бичсэн жорын дагуу олгох эм тариа, эмийн зохистой хэрэглээ, сөрөг үр дагаварын талаар зөвлөгөө өгнө. Тэд хүний эрүүл мэнд, эмчилгээний арга барил судлах, турших, бэлдэх, жор бичих, хянахад хувь нэмэрээ оруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эмчлэгч эмч болон анагаах мэргэжилтний бичсэн жор хүлээж авах, эм олгохоос өмнө үйлчлүүлэгчийн өвчний түүхийг шалгах, эмийн тун зөв эсэх, эм хоорондоо харшлах эсэх, хэрэглэх зааварыг нягтлах,
- б) шингэн, тосон, нунтаг, үрэл зэрэг эм бэлдмэлийг жорын дагуу бэлтгэх, шошго наах ажлыг удирдах,
- в) эм захиалагч, үйлчлүүлэгчдэд эм тарианы үйлчилгээ, харшлал, эсрэг үйлчлэл, дагавар үзэгдэл, эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх,
- г) эрүүл мэндийн мэргэжилтний хамт тухайн өвчтөнд эмийн үзүүлэх үр нөлөө, чанар, байдлыг төлөвлөх, хянах, шалгах,

- д) мансууруулах бодис, хор, зуршил, дасал үүсгэдэг, эмийн жор бичилт, олголтын талаар хууль, мэргэжлийн үүднээс хавтаст хэрэг хөтлөх,
- е) вакцин, ийлдэс болон муудах магадлалтай бусад эм бэлдмэлийг дүрэм журмын дагуу нөөцлөх, хадгалах,
- ж) жороос гадуур олгох эм бэлдмэл, хөнгөн хэлбэрийн өвчнийг оношлох, эмчлэх анхан шатны тусламжийн талаар зөвлөгөө өгөх,
- з) эмийн сангийн техникч, дадлагажигч, борлуулагч ажилтны ажил үүргийг удирдах,
- и) эм зүй, гоо сайхны болон холбогдох химийн бүтээгдэхүүнийг бий болгох, сайжруулахад чиглэсэн судалгаа шинжилгээ хийх,
- к) химич, инженер, бусад мэргэжилтэнтэй үйлдвэрлэлийн технологи, орц, найрлагын талаар зөвлөлдөх,
- л) эм бэлдмэлийг тодорхойлж, цэвэр ариун, үйлчилгээг стандартад нийцүүлэх,
- м) эмийн бүтээгдэхүүний шошго, сав боодол, тэмдэглэгээг үнэлж дүгнэх,
- н) зарим тодорхой эм бэлдмэлтэй холбоо бүхий мэдээлэл, эрсдлийг судлах, боловсруулах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмийн химич
- Эмнэлгийн эм зүйч
- Эмийн үйлдвэрийн эм зүйч
- Эмийн сангийн (худалдааны) эм зүйч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3213 Эм зүйн техникч болон туслагч

### **2263 ХҮРЭЭЛЭХ ОРЧНЫ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРҮҮЛ АХУЙ, ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ СУДЛАЛЫН МЭРГЭЖИЛТЭН**

Хүрээлэх орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл судлалын мэргэжилтэн нь хүрээлэх орчноос хүний эрүүл мэндэд нөлөөлж болохуйц хүчин зүйлсийг илрүүлэх, ажлын нөхцлийн аюулгүй, эрүүл саруул байдлыг хангах, хими, физик, радиац, биологийн биет, эргономикийн хүчин зүйлээс учруулж болох өвчлөл юмуу ослоос сэргийлэх үүднээс үнэлгээ хийх, төлөвлөх, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) эрүүл мэнд, аюулгүй байдалд учруулах орчны болон үйлдвэрлэлийн боломжит эрсдэлийг туйлын бага болгоход чиглэсэн хөтөлбөр, бодлого боловсруулах, нэвтрүүлэх, хянан үзэх,



- б) арилжаа, аж үйлдвэр, эмнэлгийн болон гэр ахуйн хог хаягдлыг аюулгүй, хямдхан зохистойгоор устгах төлөвлөгөө, стратеги бэлтгэх, хэрэгжүүлэх,
- в) халдварт өвчин устгах, хүнсний аюулгүй байдал хангах, бохир ус цэвэршүүлэх, хаях систем, ундны усны чанар дээшлүүлэх, бохирдсон юмуу осолтой бодисоос сэргийлэхэд чиглэсэн хөтөлбөр, стратеги хэрэгжүүлэх,
- г) аюул ослыг олж тогтоох, мэдэгдэх, баримтжуулах, хүрээлэх орчны болон үйлдвэрлэлийн эрсдлийг үнэлэх, хянах, холбогдох хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх,
- д) хими, физик, биологийн осол дагуулсан орчны болон үйлдвэрлэлийн бохирдлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянан шинжлэх,
- е) ажилчин, оюутан, олон нийт, байгаль орчныг радиаци зэрэг хорт туяанд өртөхөөс сэргийлэх, бууруулах, үгүй болгох, хянах үүнд холбогдох зөвлөгөө өгөх,
- ж) машины хийц, тоног төхөөрөмж зэрэг ажлын байрны зохион байгуулалтыг ажилчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн эргономик зарчмыг ажил хэрэг болгохыг хөхүүлэн дэмжих,
- з) үйлдвэрлэлийн ариун цэвэр, хүрээлэх орчны эрүүл мэндийн асуудлаар бүх л төвшинд хүмүүст боловсрол олгох, мэдээлэх, сургалт явуулах, зөвлөгөө өгөх,
- и) осол аваар, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг бүртгэх, шалгах, аюулгүйн гүйцэтгэлийг илтгэх,
- к) осолдсон ажилчинд нөхөн олговор олгох, нөхөн сэргээлтэнд хамруулж, ажилдаа эргэж орох нөхцлийг нь бүрдүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүрээлэх орчны эрүүл ахуйн ажилтан
- Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн байцаагч, зөвлөгч
- Хөдөлмөрийн нөхцөл судлалын мэргэжилтэн
- Радиациаас хамгаалах мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2133	Байгаль хамгааллын мэргэжилтэн
2212	Нарийн мэргэжлийн эмч (олон нийтийн эрүүл мэнд)
2221	Сувилахуйн мэргэжилтэн (олон нийтийн эрүүл мэнд)
2269	Үйлдвэрлэлийн эмгэг судлаач
3257	Эрүүл мэндийн байцаагч
3257	Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын байцаагч
3257	Ариун цэврийн мэргэжилтэн
3257	Ариун цэврийн байцаагч

**Тайлбар:**

Хүрээлэх орчинд үзүүлж буй хүний үйл ажиллагаа нөлөөллийг үнэлэх, хянахтай холбогдох хөтөлбөр дээр ажилладаг мэргэжилтнийг нэгж бүлэг 2133 буюу “Байгаль хамгааллын мэргэжилтэн” гэсэн ангилалд оруулна.

**2264 НӨХӨН СЭРГЭЭХ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН**

Нөхөн сэргээх эмчилгээний эмч нь хүний биеийн хөдөлгөөний функцыг сэргээх, сайжруулах, өвчин, зовиур намдаах, биеийн гэмтэл, өвчин, бусад согогийг эмчлэх, сэргийлэхэд чиглэсэн нөхөн сэргээх хөтөлбөрийг үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэд хөдөлгөөн, хэт авиа, дулаан, лазер, бусад техник ашиглан төрөл бүрийн нөхөн сэргээх эмчилгээ хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчийн бие байдлыг үнэлэн дүгнэхийн тулд булчин, мэдрэл, холбоос хэсгийг болон функц чадавхийг сорьж шалгах ажиллагааг удирдана,
- б) биеийн өвчин намдаах, булчин хөгжүүлэх, зүрх судас, амьсгалын ажиллагааг сайжруулах, үе мөчний хөдөлгөөнийг сайжруулах, тэнцвэр, баримжааг хадгалах үүднээс үйлчлүүлэгчтэй эмчилгээний чиглэл, хөтөлбөрийг тохирох, эмчилгээг төлөвлөх,
- в) үйлчлүүлэгч дасгал хийлгэх, дулаан, хүйтэн эмчилгээ, бариа засал, ховсдолт, ус, цахилгаанаар эмчлэх, нил ягаан, хэт улаан туяагаар болон хэт авиагаар эмчлэх талаар зааж бичих, хэрэгжүүлэх, эмчилгээний явцыг хянах,
- г) эмнэлгээс гадуурх эмчилгээний талаар үйлчлүүлэгч, гэр бүлд зааварчилгаа өгөх,
- д) үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал, эмчилгээний үр дүнг эмнэлгийн бүртгэл мэдээний системд оруулах, үргэлжилсэн, бүрэн эмчилгээ хийх үүднээс эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй харилцан мэдээлэл солилцох,
- е) нийтлэг өвчин, эмгэгийг илрүүлэх, сэргийлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх,
- ж) нөхөн сэргээх эмчилгээний туслах болон бусад ажилтны ажлыг хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хөгшрөлтийг сааруулах нөхөн сэргээх эмчилгээний мэргэжилтэн
- Хүүхдийн нөхөн сэргээх эмчилгээний мэргэжилтэн
- Ортопед эмчилгээний мэргэжилтэн
- Нөхөн сэргээх эмчилгээний мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2269	Хөлний эмчилгээ, арчилгааны мэргэжилтэн
2269	Мэргэжлээс шалтгаалсан өвчний эмчилгээ, судалгааны мэргэжилтэн
3255	Зүү төөнийн мэргэжилтэн
3255	Усаар эмчлэгч мэргэжилтэн
3255	Массажчин
3255	Нөхөн сэргээх эмчилгээний техникч
3259	Бариач
3259	Үе мөчний мэргэжилтэн

**2265 ХООЛ ТЭЖЭЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН, ХООЛ ЗҮЙЧ**

Хоол зүйч, хоол тэжээлийн мэргэжилтэн нь хүний эрүүл мэндэд хоол хүнс, тэжээлийн нөлөөллийг өргөтгөх, хөтөлбөрийг үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) иргэд, гэр бүл, нийгэм бүлэгт хоол тэжээл, хүнсний зүйлсийн эрүүл мэндийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулах зорилгоор хоолны цэс дэглэм төлөвлөх, хоол бэлтгэх,
- б) хоолны дэглэм, цэс төлөвлөх, хоол бэлтгэлд хяналт тавих, хоол бэлтгэх, хоолоор үйлчилдэг газруудад зөвлөмж өгөх зорилгоор хоолны хэрэглээ, чанарыг хянах,
- в) хувь хүмүүс, гэр бүл, нийгэм бүлгийн хоол тэжээлийн хэрэглээнд үндэслэн эрүүл мэнд, хоол тэжээлийн талаар мэдээлэл цуглуулах, үнэлэх,
- г) хоол тэжээлийн үнэлгээ, оролцооны хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, иргэд, гэр бүлийн хоол тэжээлийн хэрэглээний төвшинг дээшлүүлэхтэй холбогдуулан сургалт явуулах,
- д) өвчтөний хоолны дэглэм, хэрэглээг зохицуулах үүднээс эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх,
- е) хоол тэжээлийн хэрэгцээг хангахад чиглүүлж хүнс, хоол тэжээлийн бүтээгдэхүүнийг боловсруулах, үнэлэх,
- ж) хоол тэжээлийн талаар судалгаа хийх, үр дүнг эрдэм шинжилгээний ном сэтгүүл, хурлаар түгээх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Клиникийн хоол тэжээлийн мэргэжилтэн
- Хүнс, зоогийн газрын хоол тэжээлийн ажилтан
- Хоол тэжээлийн мэргэжилтэн, хоол зүйч

- Нийтийн эрүүл мэндийн хоол тэжээлийн мэргэжилтэн
- Спортын хоол тэжээлийн мэргэжилтэн

## **2266 СОНСГОЛЫН МЭРГЭЖИЛТЭН, ХЭЛНИЙ СОСОГ ЗАСАЛЧ**

Сонсголын мэргэжилтэн, хэлний сосог засалч нь хүний сонсгол, хэл яриа, харилцаа холбооны болон залгиур хоолойтой холбогдох эмгэгийг үнэлэн зохицуулж, эмчилдэг. Сонсголгүй болох, хэл ярианы эмгэг, мэдрэхүйн болон мэдрэлийн бусад асуудлыг шийдвэрлэх зорилгоор заслын аппарат юмуу нөхөн сэргээх заслын жор бичиж, сонсголын аюулгүй байдал, харилцааг сайжруулахтай холбоотой зөвлөгөө өгнө.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) сонсгол, хэл яриа, харилцаа холбооны байдлыг үнэлэн дүгнэж сонсгол, хэл ярианы бэрхшээлийн үүсвэрийг тодорхойлох,
- б) оношлогооны төхөөрөмж ашиглан сонсгол, хэл яриа, харилцааны сорилт туршилт хийх, анагаах, нийгэм, зан төлвийн оношлогооны мэдээ баримтаар туршилтын дүнг гаргаж, зохих эмчилгээг тодорхойлох,
- в) сонсгол, хэл ярианы зөвлөгөө өгөх, туршилт сорилт явуулах, нөхөн сэргээлтийн зэрэг хөтөлбөрийг төлөвлөх, удирдах, тэдгээрт оролцох,
- г) сонсголын аппарат зэрэг туслах хэрэгслийг өвчтөний хэрэгцээнд нийцүүлэн зааж бичих, хэрхэн хэрэглэх талаар зааварчилгаа өгөх,
- д) үйлчлүүлэгчийн хэл яриа, залгиур хоолойтой холбоотой ээрэх, буруу хооллох өвчлөлүүдийг эмчлэх хөтөлбөр төлөвлөх, хэрэгжүүлэх,
- е) сонсгол, хэл ярианы эмгэгтэй хүмүүс, тэдгээрийн гэр бүлд, багш, ажил олгогчдод зөвлөгөө, зааварчилгаа өгөх,
- ж) шаардлагатай бол үйлчлүүлэгч, гэр бүлийг анагаахын болон боловсролын нэмэлт үйлчилгээнд хамрагдахыг зөвлөх.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сонсголын мэргэжилтэн
- Хэл ярианы мэргэжилтэн
- Хэл ярианы сосог засалч

## **2267 ХАРАА ЗҮЙЧ, ХАРАА ХЭМЖИГЧ**

Хараа зүйч, хараа хэмжигч нь нүд, харааны системийн эмгэгийг оношлох, зохицуулж, эмчилгээ үзүүлдэг. Тэд нүд арчлах талаар зөвлөгөө өгч, хараа балартах эмгэгийн үед нүдний шил, хараа заслын бусад зүйлсийг заан бичнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) харааны эрүүл мэнд, түүний хэвийн ба хэвийн бус байдлыг тодорхойлох үүднээс үйлчлүүлэгчийн нүдийг үзэх, оношлогоо хийх,
- б) оношлогооны төхөөрөмжөөр харааны байдал, хугарлын эмгэг, дүрслэл, нүдний хөдөлгөөн, хараа, даралтыг хэмжих,
- в) нүдний өвчлөлийг илрүүлэх, оношлох, эмчлэх, мөн эмчлэх жор бичих,
- г) нэмэлт эмчилгээ шаардлагатай үед нүдний эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтэнтэй зөвлөх, тэдэнд хандахыг зөвлөх,
- д) нүдний хөдөлгөөний болон дуран функцийг эмгэгийг илрүүлэх, оношлох, эмчилгээний хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөн нүдний хөдөлгөөн, фокусыг тогтоох үүднээс хийх дасгалыг өвчтөнд зөвлөх,
- е) харааны шил, контакт линз, бусад хэрэгслүүдийг зааж өгөх, тэдгээр хэрэгслийн ажиллагаа, аюулгүй байдал, тохиромжтой эсэхийг тайлбарлаж, амьдралын хэв маягт тохируулан хэрэгсэлийг сонгож өгөх,
- ж) контакт линз, харааны бусад хэрэгсэлийг хэрхэн арчлах, өндөр настай хүмүүс хараагаа яаж хамгаалах, үйлдвэрлэл дээр нүдний аюулгүй байдлыг хэрхэн хангах асуудлаар зөвлөгөө өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нүдний эмч
- Хараа зүйч
- Дуран зүйч мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2212 Нүдний мэс засалч
- 3254 Харааны шилний мэргэжилтэн, шил олгогч

**2269 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Аль нэг ангилалд ороогүй эрүүл мэндийн мэргэжилтэн гэдэгт дэд бүлэг 22 буюу “Эрүүл мэндийн мэргэжилтэн” гэсэн ангилалд ороогүй ажилтныг хэлнэ. Тухайлбал тавхайн эмгэг засалч, мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач зэрэг эрүүл мэндийн мэргэжилтнийг жишээлэн дурдаж болно.

**Гүйцэтгэх үүрэгт:**

- а) үйлчлүүлэгчийн бие, сэтгэцийн эмгэг болон эрүүл мэндийн бусад асуудлыг тодорхойлох үүднээс тэдэнтэй уулзах, оношлогоо, шинжилгээ хийх,

- б) гэмтэл бэртэл, өвчлөл, бие, сэтгэцийн бусад өвчин эмгэгийг эмчлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
- в) өвчтөний эдгэрэх явц, эмчилгээний үр дүнг хянах үнэлэх, баримтжуулах, шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгч, айл өрхийг мэргэжлийн эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, нөхөн сэргээх зэрэг эмчилгээ сувилгааны газруудад илгээх,
- г) гэмтэл бэртэл, өвчлөл, бусад эмгэгийн улмаас учирсан функционал хязгаарлалтыг үнэлж дүгнэх, тэдгээрийг эмчлэх,
- д) орон гэр, ажил, амралтын газар, сургуулийн орчинд хувь хүний болон бүлэг хүмүүсийн хувьд өдөр тутмын үйл ажиллагаа, ажил үүргээ гүйцэтгэхэд таатай орчинг хэрхэн бүрдүүлэх талаар зөвлөгөө өгөх,
- е) хувь хүн, бүлэг хүмүүсийн хувьд биеийн ба танин мэдэхүйн хөгжил, сэтгэл хөдлөл, нийгмийн байр суурьт чиглэсэн гар урлал, бүжиг, хөдөлгөөн, дуу хөгжим зэрэгт холбогдох эмчилгээний хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх,
- ж) гэмтэл бэртэл, өвчлөл, өвчин эмгэгийн улмаас тавхай, шагай, хөл, бусад эрхтэнд өөрчлөлтийг эмчлэх, эмчилгээ зааж өгөх, гутал сонгох талаар зөвлөгөө өгөх, хөлийн өвчнийг эмнэх, арчлах талаар зөвлөгөө өгөх,
- з) тавхай болон шагайн дээр жижиг мэс ажиллабар хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Урлагаар эмчлэгч мэргэжилтэн
- Бүжиг болон хөдөлгөөнөөр эмчлэгч мэргэжилтэн
- Үйлдвэрлэлийн эмгэг судлаач
- Хөлний мэргэжилтэн
- Чийрэгжүүлэлтийн мэргэжилтэн

---

## **ДЭД БҮЛЭГ 23 БАГШЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

---

Багшлах мэргэжилтэн нь нэг буюу түүнээс дээш шинжлэх ухааны онол, практикийг боловсролын төрөл бүрийн төвшинд зааж сургах, тухайн шинжлэх ухаантай холбоотой үзэл баримтлал, онол, ажиллагааны арга зүйг сайжруулах, хөгжүүлэх, холбогдох судалгааны болон эрдмийн ажил хийх, ном товхимол бэлтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Боловсрол, техник мэргэжлийн хувьд боловсролын тухайн төвшинд тохирсон хичээл, лекц семинар хийх, хувиараа хичээл заах, насанд

хүрэгчдэд чиглэсэн бичиг үсэг тайлах хөтөлбөр хэрэгжүүлэх, сэтгэцийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт хийх, боловсрол олгох, сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, заах арга барил, хичээлийн хэрэгслүүдийг шалгах, холбогдох зөвлөгөө өгөх, ерөнхий боловсрол, их дээд сургуулийн сургалт үйл ажиллагаатай холбогдох шийдвэр гаргахад оролцох, аж үйлдвэрийн зэрэг салбарт ашиглагдахуйц үзэл баримтлал, онол, ажиллагааны арга барилыг сайжруулах, боловсруулах зорилгоор сэдэвчилсэн тодорхой судалгаа явуулах, эрдэм шинжилгээний ажил хийх, ном товхимол бэлтгэх зэрэг ажлыг хариуцна.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 231 Их, дээд сургуулийн дээд боловсролын багш**
- 232 Техник мэргэжлийн боловсролын багш**
- 233 Дунд шатны боловсролын багш**
- 234 Анхан шатны болон сургуулийн өмнөх боловсролын багш**
- 235 Боловсролын бусад мэргэжилтэн**

## **БАГА БҮЛЭГ 231**

### **ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАГШ**

---

Их, дээд сургуулийн багш нь их, дээд сургууль болон бусад дээд боловсролын байгууллагаас өөрт ногдуулсан нэг буюу түүнээс дээш хичээлээр лекц бэлтгэж, хичээл семинар хөтөлж явуулна. Тэд судалгаа шинжилгээний ажил хийж, ном товхимол бэлтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Сургалтын хөтөлбөр төлөвлөх, шинэчлэх, тавигдах шаардлагад нийцүүлэн хичээл бэлтгэх, лекц, семинар, хичээлд бэлтгэх, лабораторийн туршилт хийх, оюутнуудыг хэлэлцүүлэгт оролцуулах, үзэл бодлоо бие даан илэрхийлж сурахад нь түлхэц өгөх, оюутнаар туршилт дадлагын ажлыг шаардлагатай бол удирдуулах, шалгалтын материал бэлтгэх, шалгалт явуулах, дүгнэх, тэнхимийн бусад гишүүдийн, оюутны дараах шатны суралцагчийн судалгааны ажлыг удирдах, аж үйлдвэр зэрэг салбарт ашиглагдахуйц үзэл зарчим, онол, үйл ажиллагааны арга барилыг сайжруулах, боловсруулах зорилгоор судалгааны ажил явуулах, эрдэм шинжилгээний ажил хийх, ном товхимол бэлтгэх, салбарын болон танхимын уулзалт, хурал, цуглаан, семинарт оролцох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **2310 Их, дээд сургуулийн дээд боловсролын багш**

#### **2310 ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ДЭЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ БАГШ**

Их, дээд сургуулийн дээд боловсрол олгох багш нь их дээд сургууль, дээд боловсролын бусад байгууллагаас хуваарилсан нэг буюу түүнээс дээш хичээлээр лекц бэлтгэж, хичээл, семинар, давтлага явуулна. Тэд судалгаа шинжилгээний ажил хийж, ном товхимол бэлтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) сургалтын хөтөлбөр төлөвлөх, шинэчлэх, тавигдах шаардлагад нийцүүлэн хичээлээ бэлтгэх,
- б) лекц, семинар, хичээлд бэлтгэх лабораторын туршилт явуулах,
- в) оюутнуудыг хэлэлцүүлэгт оролцуулах, үзэл бодлоо бие даан илэрхийлэхэд түлхэц өгөх, шаардлага гарвал оюутнуудаар туршилт дадлагын ажил удирдуулах,
- г) шалгалтын материал бэлтгэх, шалгах, дүгнэх, тэнхимийн бусад гишүүдийн болон оюутны дараах шатнаа суралцагчдын судалгааны ажлыг удирдах,
- д) аж үйлдвэр зэрэг салбарт ашиглагдахуйц үзэл баримтлал, онол үйл ажиллагааны арга барилыг сайжруулах, боловсруулах зорилгоор судалгааны ажил явуулах,
- е) эрдэм шинжилгээний ажил хийх, ном товхимол бэлтгэх,
- ж) салбарын болон танхимын уулзалт, хурал, цуглаан, семинарт оролцох.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дээд боловсролын багш
- Профессор
- Их, дээд сургуулийн багш
- Их сургуулийн туслах багш

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 1120 | Их сургуулийн захирал                          |
| 1345 | Хичээлийн эрхлэгч                              |
| 1345 | Дээд боловсролын байгууллагын тэнхимийн эхлэгч |
| 2320 | Техник мэргэжлийн сургалтын багш               |



**БАГА БҮЛЭГ 232****ТЕХНИК МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БАГШ**

---

Техник мэргэжлийн боловсролын багш нь боловсрол үргэлжлүүлэн олгодог байгууллага, дунд сургуулийн ахлах ангийн сурагчид, коллежийн оюутанд техник мэргэжлийн хичээл зааж, сургана. Тэд дээд боловсрол шаарддаггүй ажил мэргэжлээр оюутнуудыг сургаж бэлтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Сургалтын хөтөлбөр боловсруулах, курсын агуулга төлөвлөх, заах аргачлалаа тодорхойлох, оюутан, ажилчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хувь хүмүүс, аж үйлдвэр, боловсролын салбарын бусад байгууллагуудтай уялдаатай ажиллан, боловсролын болон сургалтын холбогдох хөтөлбөрөөр хангах, оюутнуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх үүднээс лекц унших, хэлэлцүүлэг явуулах, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал ашиглах явцад гэмтэл, эвдрэл гарахаас сэргийлэн хяналт тавих, зааварчилгаа өгөх, амжилт ахицыг тодорхойлох, гүйцэтгэлийг шалгах, сайжруулах санал дэвшүүлэх үүднээс оюутны ажлыг хянах, ажиглах, ам, бичгийн шалгалт авах, ажлын сорилт хийлгэх зэргээр оюутны чадвар, ахиц дэвшил, сургалтын үр өгөөжийг үнэлэн дүгнэх, оюутны дүн, ирц, сурлагын идэвхийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэж, тайлан бэлтгэх, бие даах юмуу багаар хийх үүрэг даалгавар, дадлага, лабораторийн ажил, бусад сургалтыг удирдах, ганцаарчилсан сургалт, давтлага, нэмэлт хичээл явуулах, ажил дээр сургах хэлбэрээр тухайн хичээлийн зарчим, техник, үйл явц болон аргачлалыг зааж сургах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2320 Техник мэргэжлийн боловсролын багш****2320 ТЕХНИК МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БАГШ**

Техник мэргэжлийн боловсролын багш нь боловсрол үргэлжлүүлэн олгодог байгууллага, дунд сургуулийн ахлах ангийн сурагчид, коллежийн оюутанд техник мэргэжлийн хичээл зааж, сургана. Тэд дээд боловсрол шаарддаггүй ажил мэргэжлээр оюутнуудыг сургаж бэлтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сургалтын хөтөлбөр боловсруулах, курсын агуулга төлөвлөх, заах аргачлалаа тодорхойлох,

- б) оюутнууд болон ажилчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох,
- в) хувь хүмүүс, тухайн салбарын болон боловсролын салбарын бусад байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан боловсрол, сургалтын холбогдох хөтөлбөрөөр хангах, оюутнуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх үүднээс лекц унших, хэлэлцүүлэг явуулах,
- г) багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал ашиглах явцад эвдрэл, гэмтэл гаргахаас сэргийлэн хяналт тавих, зааварчилгаа өгөх,
- д) амжилт ахицыг тодорхойлох, гүйцэтгэлийг шалгах, сайжруулах санал дэвшүүлэх, зорилгоор оюутны ажлыг хянах, ажиглах,
- е) ам, бичгээр шалгалт авах, сорилт ажил хийлгэх зэргээр оюутны чадвар, ахиц амжилт, сургалтын үр өгөөж чадварыг үнэлэх,
- ж) оюутны дүн, ирц, сурлагын идэвхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хөтлөх, тайлан бэлтгэх,
- з) бие даалгах юмуу багаар хийх үүрэг даалгавар, дадлагын болон лабораторийн ажил, бусад сургалтыг удирдах,
- и) ганцаарчилсан сургалт, давтлага, нэмэлт хичээл явуулах,
- к) ажил дээр сургах хэлбэрээр тухайн хичээлийн зарчим, техник, үйл явц болон аргачлалыг зааж сургах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тээврийн хэрэгслийн багш
- Гоо сайхны багш
- Техник мэргэжлийн багш

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2330 Дунд шатны боловсролын багш

## **БАГА БҮЛЭГ 233**

### **ДУНД ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАГШ**

---

Дунд шатны боловсролын багш нь дунд боловсролын төвшинд нэг юмуу түүнээс дээш төрлийн хичээл заана. Үүнд тусгай ажил мэргэжил эзэмшүүлэх хичээл орохгүй.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Хөтөлбөрийн удирдамжийн дагуу хичээлийн агуулга, хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх, сурагчдаар дотоод дэг журам сахиулахын тулд сахилга батын дүрэм баталж, мөрдүүлэх, нэг юмуу түүнээс дээш төрлийн хичээл бэлтгэх, хичээл заах, хэлэлцүүлэг явуулах, жишээ үзүүлэх, хичээл, нэгж, төсөл бүрийн зорилгыг тодорхойлж, сурагчдыг тэдгээр зорилгод хүргэх, хичээлийн, ангийн ажиллагааны

материал бэлтгэх, сургалтын арга барил, хэрэгслүүдийг сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх, сурагчдын хичээл сурлага, зан төлөвийг ажиглах, үнэлэх, сурагчдын сурлагын явцыг тодорхойлох үүднээс шалгалт, шүүлэг авах, даалгавар өгөх, шалгалтын материал бэлтгэх, дүн тавих, сурагчдын нэгдсэн дүн бэлтгэх, бусад багш эцэг эхтэй зөвшилцөх, сургуулийн боловсрол, зохион байгуулалтын бодлоготой холбоотой уулзалтанд оролцох, биеийн тамир, спорт, соёл урлагийн болон аялал зугаалга цэнгээний ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **2330 Дунд шатны боловсрол олгох багш**

#### **2330 ДУНД ШАТНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ БАГШ**

Дунд шатны боловсрол олгох багш нь дунд боловсролын төвшинд нэг юмуу түүнээс дээш төрлийн хичээл заана. Үүнд тусгай ажил мэргэжил эзэмшүүлэх хичээл орохгүй.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөтөлбөрийн удирдамжийн дагуу хичээлийн агуулга, хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх,
- б) сурагчдаар дотоод дэг журам сахиулахын тулд сахилга батын дүрэм баталж, мөрдүүлэх,
- в) нэг юмуу түүнээс дээш төрлийн хичээл бэлтгэх, хичээл заах, хэлэлцүүлэг явуулах, жишээ үзүүлэх,
- г) хичээл, нэгж, төсөл бүрийн зорилгыг тодорхойлж, сурагчдыг тэдгээр зорилгод хүргэх,
- д) хичээлийн, ангийн ажиллагааны материал бэлтгэх,
- е) сургалтын арга барил, хэрэгслүүдийг сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх,
- ж) сурагчдын хичээл сурлага, зан төлөвийг ажиглах, үнэлэх,
- з) сурагчдын сурлагын явцыг тодорхойлох үүднээс шалгалт, шүүлэг авах, даалгавар өгөх, шалгалтын материал бэлтгэх, дүн тавих,
- и) сурагчдын нэгдсэн дүн бэлтгэх, бусад багш эцэг эхтэй зөвшилцөх,
- к) сургуулийн боловсрол, зохион байгуулалтын бодлоготой холбоотой уулзалтанд оролцох,
- л) биеийн тамир, спорт, соёл урлагийн болон аялал зугаалга цэнгээний ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дунд шатны боловсролын багш
- Ахлах сургуулийн багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1345	Боловсролын менежер
2330	Дунд шатны боловсролын багш
2352	Тусгай сургалтын багш

**БАГА БҮЛЭГ 234****АНХАН ШАТНЫ БОЛОН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ**

Анхан шатны болон сургуулийн өмнөх боловсрол олгох багш нь бага ангийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд анхан шатны боловсрол олгож, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулдаг.

**Гүйцэтгэх үүрэг:**

Анхан шатны боловсрол олгох хичээл зааж, сургалтын хөтөлбөр боловсруулах, хүүхдүүдийн хэл яриа, бие махбодийг хөгжүүлж, нийгэм олонтой харилцах дадлага суулгахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлан бэлтгэх. Бусад ажилтныг удирдах үүрэг даалгавар орж болно.

**Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:**

2341	Анхан шатны боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч
2342	Сургуулийн өмнөх боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч

**2341 АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ**

Анхан шатны боловсрол олгох багш нь анхан шатны боловсролын төвшингийн хичээлүүдийг зааж сургана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сургалтын хөтөлбөрийн дагуу өдөр тутмын болон урт хугацааны хичээл төлөвлөх, бэлтгэх,
- б) төрөл бүрийн хичээлийн хэрэгсэл (компьютер, ном, тоглоом гэх мэт), заах арга барилыг ашиглан хүүхдийн хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан болон бүлгийн хүрээнд сургалт явуулах,

- в) анги танхимд сахилга бат, биеэ зөв авч явах дэг журам тогтоох,
- г) хүүхдүүдтэй хамтран биеийн тамир, спорт, соёл урлагийн болон аялал зугаалгын ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах,
- д) ангийн, гэрийн ажил даалгавар өгөх, дүн тавих,
- е) сурагчдын сурлагыг тодорхойлох үүднээс даалгавар өгөх, шалгалт авах, дүн тавих,
- ж) хүүхдүүдийн сурлага, сахилга батыг ажиглах, үнэлэн дүгнэх,
- з) хичээлтэй өдөр хичээл хийх юмуу завсарлах үеэр тоглох зэрэг аль ч цагт хүүхдийг бүрэн хариуцах,
- и) сургуулиас боловсролын асуудлаар зохион байгуулах уулзалтанд оролцох,
- к) эцэг эхийн хурал төлөвлөх, зохион байгуулах, эцэг эхчүүдтэй ярилцах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Анхан шатны боловсрол олгох багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 1345      Боловсролын менежер
- 2351      Боловсролын арга зүйн мэргэжилтэн

**2342 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ**

Сургуулийн өмнөх боловсролын багш нь сургалтын чанартай юмуу тоглоом тоглуулах арга хэлбэрээр сургуулийн өмнөх насны хүүхдийн бие оюуны хөгжлийг дэмжих үйл ажиллагааг мэргэшлийн төвшинд эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хүүхдийн хөдөлгөөний чадвар, хамтран ажиллах болон нийгэм олонтой харилцах дадлага итгэл, харилцан ойлгоцыг дэмжихэд чиглэсэн ганцаарчилсан, бүлгийн хэмжээнд явуулах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах,
- б) үлгэр ярих, дүрд тоглох, дуу дуулах, холбоо үгс, албан бус яриа, асуулт хариулт явуулах зэргээр хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих,
- в) хүүхдүүдийг урлаг уран сайхан, жүжиглэл, дуу хөгжим, биеийн тамирын арга хэмжээнд оролцуулж өөрийгөө илэрхийлэх ажиллагаанд дадлагажуулах,
- г) сурагчдын сурлагыг тодорхойлох, тэдний хөгжил, сэтгэл хөдөлгөөн, эрүүл мэндтэй холбоотой асуудлаар эцэг эхтэй зөвлөлдөх,
- д) хүүхдүүдийн хоол тэжээл, эрүүл мэнд, аюулгүй байдлын хэрэгцээг ажиглах, үнэлэх, хөгжлийн явцад нь тулгарах асуудлыг олж илрүүлэх,

## **2** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

- е) аюулгүй байдлыг ханган хүүхдүүдийн үйл хөдөлгөөнийг хянах, зөрчлийг нь шийдвэрлэх,
- ж) зөв хооллох, хувцаслах, ариун цэврийн дэг журамд суралцуулах,
- з) эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нартай хүүхдийн өсөлт хөгжил, асуудал бэрхшээлийн талаар ярилцах, нэмэлт сургалтанд хамруулах шаардлагыг тодорхойлох,
- и) баганасныхүүхдүүдтэй ажилладаг үйлчилгээний бусад байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сургуулийн өмнөх насны боловсролын багш, сурган хүмүүжүүлэгч
- Цэцэрлэгийн багш
- Цэцэрлэгийн туслах багш

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1341 Бага насны хүүхэд асрах төв /яслийн менежер/

## **БАГА БҮЛЭГ 235 БУСАД БАГШЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

---

Багшлах бусад мэргэжилтэн нь оюуны бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээ бүхий хүмүүст боловсрол олгох, сургалтын арга барилын талаар судалгаа хийж, зөвлөгөө өгөх, цагаач болон адилтгах зорилго бүхий хүмүүст хоёрдогч хэл заах, хувиараа хичээл заах, урлаг, мэдээллийн технологи зэрэг хичээлийг анхан, дунд шатны болон дээд боловсролын системээс гадуур заах ба нэгж дэд бүлэг 23 “Багшлах мэргэжилтэн” гэсэн ангилалд ороогүй сургалтын үйлчилгээ үзүүлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Заах арга барил, хичээл, сургалтын хэрэгслүүдийг судлах, боловсруулах, энэ талаар зөвлөгөө өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус зэрэг тусгай гачигдал бүхий хүмүүсийг зааж сургах, цагаач хүмүүст эх хэлнээс нь өөр хэл заах, хөгжим, жүжиг, бүжиг, дүрслэх урлагийн онол, практик, үзүүлбэр зааж сургах, хүмүүст мэдээллийн технологийг ашиглах талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, анги хичээллүүлэх, хичээлийн хуваарь батлах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2351 Боловсролын арга зүйн мэргэжилтэн**

**2352 Тусгай хэрэгцээт боловсролын багш**

2353 Бусад хэлний багш

2354 Дуу хөгжмийн багш

2355 Соёл урлагийн багш

2356 Мэдээллийн технологийн багш

2359 Аль нэгэн ангилалд ороогүй багшлах мэргэжилтэн

### 2351 БОЛОВСРОЛЫН АРГА ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Боловсролын арга зүйн мэргэжилтэн нь сургалтын арга барил, хичээл, хичээлийн хэрэгслийн талаар судалгаа хийх, зөвлөгөө өгөх, тэдгээрийг хөгжүүлэх үүрэгтэй. Тэд багш нар, сургалтын байгууллагын ажил, үр дүнг үнэлэх, алдаа дутагдлыг засах, өөрчлөх талаар зөвлөгөө өгнө.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) сургалтын хөтөлбөр, арга барил, боловсролын бусад арга хэрэгслийн хөгжил дэвшлийг судлах, шаардлага гарвал алдаа дутагдлыг засах, өөрчлөх зөвлөгөө өгөх,
- б) хичээлийн агуулга, шалгалт шүүлэг авах арга хэлбэрийг үнэлэн дүгнэх, энэ талаар зөвлөгөө өгөх,
- в) сургалтын үзүүлэн болон бусад хэрэгслийг судлах, боловсролын системд нэвтрүүлэх талаар зөвлөгөө өгөх, төлөвлөх зохион байгуулах,
- г) боловсорсон хичээл, курсийг баримтжуулах, шинэ хичээлийн талаар үнэлгээ дүгнэлт хийх,
- д) багш нарт мэргэжил, сургалтын ба зөвлөх үйлчилгээ үзүүлэх,
- е) багшийг шинэ арга барил, хөтөлбөрт сургах семинар, чуулга уулзалт зохион байгуулах,
- ж) боловсролын шинэ хөтөлбөр, хичээлийн агуулга, зорилго, бүтцийг тодорхойлох,
- з) сургуулиудаар тогтмол үзлэг хийх, сургалтын хөтөлбөр, заах аргачлал, тоног төхөөрөмж, бусад асуудлаар багш, захиргааны ажилтантай зөвлөлдөх,
- и) хичээл дээр сууж багшийн заах арга барилыг ажиглах, ажил үүргээ гүйцэтгэж байгаа болон эрдэм шинжилгээний ажлыг үнэлэн дүгнэх,
- к) сургалтын хөтөлбөр, арга барил, боловсролын бусад арга хэрэгслийг өөрчлөх, сайжруулах талаар боловсролын төв байгууллагад зөвлөгөө өгөх, тайлагнах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Сургалтын хөтөлбөрийн зохицуулагч

- Сургалтын хөтөлбөр боловсруулагч
- Сургалтын арга барилын мэргэжилтэн
- Сургалтын хэрэгслийн мэргэжилтэн
- Боловсролын байцаагч

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2634	Боловсролын сэтгэл зүйч
2359	Сургуулийн зөвлөх
2359	Оюутны зөвлөх

### **2352 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН БАГШ**

Тусгай хэрэгцээт боловсролын багш нь бие, сэтгэцийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгоно. Тэд сурагчийн нийгэм, сэтгэл зүй, оюуны болон биеийн хөгжлийг дэмжинэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) сурагчийн оюун сэтгэхүй, бие, бялдрын согог зэрэг бусад тодорхой гажилтыг боловсрол олгох арга зүйн талаас үнэлэн дүгнэх,
- б) сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, сурагчдын тусгай хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөр, хичээл, үйл ажиллагааг бэлтгэх, хэрэгжүүлэх,
- в) тусгай арга барил юмуу сурагчдын хэрэгцээнд нийцсэн хичээлийн хэрэгсэл ашиглан ганцаарчилсан болон бүлгийн сургалт явуулах,
- г) сургалтанд тусгай боловсролын стратеги, арга барилыг ашиглах, ингэснээр мэдрэхүй болон ойлгоц хөдөлгөөний чадвар, хэл яриа, танин мэдэхүй, ой санамжийг сайжруулах,
- д) дэг журамтай холбоотой дүрэм журам, бодлого боловсруулах, сурагчдын сахилга батыг сахиулах,
- е) багшийг шинэ аргачлал, хөтөлбөрт сургах семинар, чуулга уулзалт зохион байгуулах,
- ж) сонсгол, хараа зэрэг согогтой сурагчдад эрдмийн хичээл, практик амьдрал, өөрөө өөртөө туслах чадварын талаар зааж сургах,
- з) сурагчдын өөрийн итгэл, сонирхол, чадвар, гар ажиллагаа, баримжааг хөгжүүлэх, урамшуулах,
- и) хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан тусгай боловсролын хичээлийн хуваарь төлөвлөгөөний талаар бусад багш, сурган хүмүүжүүлэгчидтэй зөвлөлдөх,
- к) сурагчдын холбогдолтой мэдээлэл, бүртгэлийн сан ажилуулах, тайлагнах,
- л) сурагчдын дэвшлийг үнэлж дүгнэх төрөл бүрийн үнэлгээний хэлбэрийг ашиглах,



м) сурагчдын хөгжлийг ахиулахад чиглэсэн боловсролын төлөвлөгөөний талаар сурагч, эцэг эх, ахлах багш, бусад холбогдох мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тусгай хэрэгцээт боловсролын багш
- Дохионы хэлний багш
- Сургалтын арга зүйн мэргэжилтэн
- Хэл заслын багш
- Гоц авьяастай хүүхдийн багш
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн багш
- Харааны бэрхшээлтэй хүүхдийн багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2320      Техник мэргэжлийн боловсрол олгох багш
- 2330      Дунд боловсрол олгох багш
- 2341      Анхан шатны боловсрол олгох багш

**2353 ӨӨР ХЭЛНИЙ БАГШ**

Өөр /гадаад/ хэлний багш нь цагаачлах ажлын шаардлага биелүүлэх, ажилд орох боломж эрэлхийлэх зэрэг зорилго бүхий хэл сурч буй хүмүүс, хүүхдүүдэд төрөлх хэлнээс өөр хэл заах, гадаад хэлээр явагдах боловсролын хөтөлбөрт хамрагдах юмуу өөрийгөө илэрхийлэхэд туслаж хичээл заана. Тэд анхан, дунд болон дээд боловсролын системээс гадуур үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэхүү боловсролын системийн хүрээний багш, оюутныг дэмжиж ажилладаг онцлогтой.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) оюутан, сурагчдын хэлний чадвар, төвшинг үнэлэх, тэдний хэрэгцээ зорилгыг тогтоох,
- б) оюутан, сурагчдын чадвар, хэрэгцээнд нийцүүлсэн агуулга, хурдац бүхий хичээл, семинарыг төлөвлөх, бэлтгэх, бүлэг болон хувь хүмүүст хичээл заах,
- в) сургалтын материал бэлтгэх, боловсруулах, хичээлийн материалыг шинэчлэх,
- г) оюутан, сурагчдын ахиц дэвшлийг үнэлэх,
- д) оюутан, сурагчдад төрөлх хэлээс нь өөр хэлээр явагддаг хичээлийн үед туслалцаа үзүүлэх,
- е) хичээл, сургалтын гол хэлээ дөнгөж сурч байгаа сурагчдад зориулсан тусгай хөтөлбөр боловсруулах зэргээр бусад багшид дэмжлэг үзүүлэх,

- ж) даалгавар өгөх, шалгалт авах, дүнгнэх,  
з) оюутан, сурагчдын сурлагын явцыг бүртгэж тайлагнах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өөр хэлний ахисан төвшний багш
- Цагаачдын боловсролын багш
- Практик дадлагын багш
- Хоёрдогч хэлний багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 2310 | Дээд боловсрол олгох багш              |
| 2330 | Техник мэргэжлийн боловсрол олгох багш |
| 2330 | Дунд боловсрол олгох багш              |
| 2341 | Анхан шатны боловсрол олгох багш       |

**2354 ДУУ ХӨГЖМИЙН БАГШ**

Дуу хөгжмийн багш нь анхан, дунд, дээд боловсролын системээс гадуур хөгжмийн боловсрол олгодог ба оюутан, сурагчдад хөгжмийн практик, онол тоглолтоор сургалт явуулна. Гэхдээ үндсэн боловсролын байгууллагатай хамтран хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар ганцаарчилсан болон хэсэгчилсэн бүлэг хэлбэрээр төлбөртэй сургалт явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) оюутан, сурагчдын чадвар төвшнийг үнэлэн дүгнэх, сургалтын хэрэгцээ зорилгыг тодорхойлох,
- б) хичээл, семинарын хөтөлбөр төлөвлөх, бэлтгэх, бүлэг хүмүүс, хувь хүмүүст хичээл заах,
- в) дуу хөгжмийн онол, ойлголтын талаар сургалтын материал бэлтгэх, танилцуулах,
- г) дуулах юмуу тодорхой хөгжмийн зэмсгээр тоглохтой холбоотой зааварчилгаа өгөх, практикаар үзүүлэх,
- д) оюутан, сурагчдыг нот уншиж, бичиж сургах,
- е) оюутан, сурагчдын чадвар, сонирхол, авъяаст нийцүүлэн даалгавар өгөх, хөгжмийн бүтээлийн тодорхой хэсгийг зааж сургах,
- ж) оюутан, сурагчдыг үнэлэх, зөвлөгөө өгөх, шүүмжлэх, урамшуулах,
- з) сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын материал, арга барилыг шинэчлэх,
- и) хөгжмийн тоглолт үзэхтэй холбоотой аялал зохион байгуулах,
- к) тоглолт хийх болон шалгаруулалтад оролцоход нь оюутан сурагчдад туслах, тэднийг зохион байгуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гитарын багш (хувиараа заах)
- Төгөлдөр хуурын багш (хувиараа заах)
- Дууны багш (хувиараа заах)
- Хийл хөгжмийн багш (хувиараа заах)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2310	Дээд боловсрол олгох багш
2330	Техник мэргэжлийн боловсрол олгох багш
2330	Дунд боловсрол олгох багш
2341	Анхан шатны боловсрол олгох багш

**2355 СОЁЛ, УРЛАГИЙН БАГШ**

Соёл, урлагийн багш нь анхан, дунд болон дээд боловсролын системээс гадуур урлагийн боловсрол олгодог бөгөөд оюутан, сурагчдад бүжиг, жүжиг, дүрслэн үзэх болон бусад урлагийн (хөгжмөөс бусад) практик, онол, тоглолтын чиглэлээр сургалт явуулдаг, гэхдээ үндсэн боловсролын байгууллагатай хамтран хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар ганцаарчилсан, хэсэгчилсэн бүлэг хүмүүст төлбөртэй сургалт хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) оюутан, сурагчдын чадвар, төвшинг үнэлэн дүгнэх, хэрэгцээг тодорхойлох,
- б) хичээл, семинарын хөтөлбөр төлөвлөх, бэлтгэх, бүлэг ба хувь хүмүүст хичээл заах,
- в) сурч байгаа чиглэлийн онол, ухагдахууны талаар сургалтын материал бэлтгэх, танилцуулах,
- г) жүжиг, бүжиг, дүрслэн үзэх болон бусад урлагийн талаар зааварчилгаа өгөх, практик дээр үзүүлэх,
- д) оюутан, сурагчдад нот уншиж, бичиж сургах,
- е) оюутан, сурагчдын чадвар, сонирхол, авьяаст нийцүүлэн даалгавар өгөх,
- ж) оюутан, сурагчдыг үнэлэх, зөвлөгөө өгөх, шүүмжлэх, урамшуулах,
- з) сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын материал, арга барилыг шинэчлэх,
- и) эх бүтээл, үзэсгэлэн үзэхтэй холбоотой аялал зохион байгуулах,
- к) үзэсгэлэн гаргах, тоглолт хийхэд нь оюутан сурагчдад туслах, зохион байгуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бүжгийн багш (хувиараа заах)

- Жүжгийн багш (хувиараа заах)
- Зургийн багш (хувиараа заах)
- Баримлын багш (хувиараа заах)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2310	Дээд боловсрол олгох багш
2330	Техник мэргэжлийн боловсрол олгох багш
2330	Дунд боловсрол олгох багш
2341	Анхан шатны боловсрол олгох багш
2354	Дуу хөгжмийн хувийн багш

**2356 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГАГЧ**

Мэдээллийн технологийн сургагч нь анхан, дунд, дээд боловсролын системээс гадуур компьютер, мэдээллийн технологи хэрэглэгчдэд сургалтын хөтөлбөр боловсруулан, хичээл зааж, сургана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хувь хэрэглэгч юмуу байгууллагын мэдээллийн технологийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох,
- б) сургалтын материал, тусламж, үзүүлэх хэрэгсэл, интернетийн хичээл, үзүүлбэр, загвар зэргийг бэлтгэх, сургалтын гарын авлага бэлтгэх,
- в) ганцаарчилсан болон бүлгийн төвшинд хийх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, зохион байгуулах, хуваарь хийх, сургах, семинар болон чуулга уулзалт зохион байгуулах,
- г) сургалтын чанар, үр дүнг үнэлэн дүгнэх, хяналт тавих, сургалтын зорилго, аргачлал, үр өгөөжийг нягталж үзэх, шинэчлэх,
- д) зааж буй хичээл сэдвээр бүрэн дүүрэн мэдээлэл олж авахын тулд холбогдох материал цуглуулах, судлах,
- е) шинэ бүтээгдэхүүн, хувилбар, програм хангамжийн салбарт гарсан ахиц дэвшил, технологийн ерөнхий чиг хандлага, эцсийн хэрэглэгчийн бүтээгдэхүүн, материал боловсруулах, сургалтын материал, гарын авлага бэлтгэх, интернетээр онлайн тусламж үзүүлэх, засвар арчилгаа хийх зэргээр хоцрогдохгүй байх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Компьютерийн багш
- Программ хангамжийн багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2310	Дээд боловсрол олгох багш
2330	Техник мэргэжлийн боловсрол олгох багш
2330	Дунд боловсрол олгох багш

- 2341 Анхан шатны боловсрол олгох багш  
2424 Хүний хөгжлийн асуудал хариуцсан ажилтан

### **2359 АЛЬ НЭГЭН АНГИЛАЛД ОРООГҮЙ БАГШЛАХ БУСАД МЭРГЭЖИЛ**

Аль нэгэн ангилалд ороогүй багшлах бусад мэргэжилд дэд бүлэг 23 буюу “Багшлах мэргэжил” гэсэн ангилалд ороогүй мэргэжил багтана. Жишээлбэл гадаад хэл, урлагаас өөр хувиараа сургалт явуулдаг, оюутан сурагчдад боловсролын асуудлаар зөвлөгөө өгдөг багш хамаарна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) оюутан, сурагчдын чадварыг үнэлэх, хэрэгцээг тодорхойлох,
- б) хичээл, семинарын хөтөлбөр төлөвлөх, бэлтгэх, бүлэг болон хувь хүмүүст хичээл заах,
- в) сурч байгаа чиглэлийн онол, ухагдахууны талаар сургалтын материал бэлтгэх, танилцуулах,
- г) сурч байгаа чиглэлээр зааварчилгаа өгөх, практик дээр үзүүлэх,
- д) оюутан, сурагчдын чадвар, сонирхол, авьяаст нийцүүлэн даалгавар өгөх,
- е) оюутан, сурагчдыг үнэлэх, зөвлөгөө өгөх, шүүмжлэх, урамшуулах,
- ж) сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын материал, арга барилыг шинэчлэх,
- з) оюутан, сурагчдыг шалгалт, үнэлгээ өгөхөд бэлтгэх,
- и) оюутан, сурагчдад боловсролын асуудлууд болох сургалтын хөтөлбөр, хичээл сонгох, хичээлийн хуваарь тохирох, сургуульдаа дасан зохицох, сургууль завсарлах, сурах арга барил, хэтийн ажил мэргэжлээ төлөвлөх зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх,
- к) оюутан сурагчдын хичээл, сурлагад нөлөөлж буй хувийн, нийгмийн ба сахилга батын асуудлыг зохицуулах, ухамсарлахад туслалцаа үзүүлэх,
- л) оюутан сурагчдыг дараагийн шатны боловсролд бэлдэхийн тулд сургалтын цаашдын боломжуудыг судлуулах, үүрэг даалгавар өгөх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бичиг үсэг, хэлний багш (хувиараа заах)
- Тооны нэмэлт хичээлийн багш (хувиараа заах)
- Сургуулийн зөвлөх

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2310 Дээд боловсрол олгох багш  
2330 Техник мэргэжлийн боловсрол олгох багш

2330	Дунд боловсрол олгох багш
2341	Анхан шатны боловсрол олгох багш
2354	Дуу хөгжмийн багш
2353	Гадаад хэлний багш
2353	Цагаачдад боловсрол олгох багш
2354	Дуу хөгжмийн багш (хувиараа заах)
2355	Бүжгийн багш (хувиараа заах)
2355	Жүжгийн багш (хувиараа заах)
2355	Зургийн багш (хувиараа заах)
2355	Баримлын багш (хувиараа заах)
2634	Боловсролын сэтгэл зүйч
2635	Гэр бүлийн зөвлөх
2635	Нийгмийн мэргэшсэн ажилтан

---

## ДЭД БҮЛЭГ 24

### **БИЗНЕС, ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН**

---

Бизнес, захиргааны мэргэжилтэн нь техник, анагаах, мэдээлэл холбоо, технологийн салбарын санхүүгийн асуудал, хүмүүний нөөцийн хөгжил, олон нийттэй харилцах, маркетингтэй холбоотой судалгааны, схемчилсэн задлан шижилгээ, үзэл баримтлал, практик шинжтэй ажил үүрэг гүйцэтгэх, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, арга барил, тэрчлэн системийг судлан хянаж инвест хөтөлбөрт нөлөөтэй мэдээлэлд тоон дүн шинжилгээ хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Санхүүгийн боломж, байгууллагын зардлын бүтэц, худалдааны үр ашиг зэрэгтэй холбоотой мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлах, аудит хийх, байгууллагын сан хөмрөгийг хянах, санхүүгийн тайлан бэлтгэх, санхүүгийн төлөвлөгөө, стратегийг нягтлах, худалдан авах, борлуулах захиалгыг гүйцэлдүүлэх, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдан авалт, худалдааны хэлэлцээр хийх, ажилтан сонгон шалгаруулах, сургах, хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, маркетингийн болон олон нийттэй харьцах кампанит ажил зохион байгуулах, судлах, хэрэгжүүлэх, төрийн болон бизнесийн үйл ажиллагаа, түүний ашгийг дээшлүүлэх, хөхүүлэн дэмжих аргачлал, бодлогыг судлах, боловсруулах, ажил олгогч болон өрсөлдөгчийн бараа, бүтээгдэхүүн, зах зээлийн тухай мэдээ олж авах, мэдлэгээ сайжруулах, хэрэглэгчийн хэрэгцээг үнэлэх, тэдэнд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж, танилцуулах.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**241 Санхүүгийн мэргэжилтэн**

**242 Захиргааны мэргэжилтэн**

**243 Худалдаа, маркетинг болон олон нийттэй харилцах мэргэжилтэн**

## **БАГА БҮЛЭГ 241**

### **САНХҮҮГИЙН МЭРГЭЖИЛТЭН**

Санхүүгийн мэргэжилтэн нь хувь хүн, аж ахуйн нэгж, хувийн болон төрийн байгууллагын санхүү нягтлан бодох систем буюу сан хөрөнгийн төлөвлөлт, хөгжил, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, удирдлага, тоон дүн шинжилгээ зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Байгууллагуудын санхүүгийн тайлан бэлтгэх, зохицуулах, байгууллагын санхүүгийн холбогдолтой материалыг нягтлах, хувь хүн, байгууллагуудад санхүүгийн зөвлөгөө өгөх, эдийн засгийг бүхэлд нь юмуу тодорхой хэсгийг нь хамарсан нарийвчилсан шинжилгээний тайлан бэлтгэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2411 Нягтлан бодогч**

**2412 Санхүү, хөрөнгө оруулалтын зөвлөх**

**2413 Санхүүгийн шинжээч**

#### **2411 НЯГТЛАН БОДОГЧ**

Нягтлан бодогч нь хувь хүн, аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоог төлөвлөж, зохион байгуулж, захирдаг. Энэ ангилалд багтсан зарим ажил мэргэжил нь хувь хүмүүс, аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн баримтууд нягтлан бодох бүртгэлийн тогтсон стандартад нийцсэн, үнэн зөв эсэхийг нягталж шалгана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Төсөв, тооцооны хяналтын зэрэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, системийн талаар зөвлөгөө өгөх, төлөвлөх, ажиллагаанд оруулах,
- б) Удирдлага, хувьцаа эзэмшигч, холбогдох хууль ёсны албаны байгууллагуудад танилцуулах зорилгоор санхүүгийн тайлан, балансыг бэлтгэх, баталгаажуулах,

- в) Татварын тайлан бэлтгэх, татварын маргаан, татварын албаны нэхэмжлэлийн эсрэг мэдүүлэх зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх,
- г) Ашгийн урьдчилсан тооцоо, төсөв бэлтгэх, тайлагнах,
- д) Залилан хийсэн, төлбөрийн чадвараа алдсан, дампуурсан зэрэг сэжиг бүхий зүйлд санхүүгийн шалгалт хийх,
- е) Данс тооцоо нягтлан бодох бүртгэлийн аудит хийх,
- ж) Бүтээмж, хувьцаа, борлуулалт, шинэ бүтээгдэхүүн зэрэг асуудлаар удирдлагад зөвлөгөө өгөх, холбогдох чиглэлээр шалгалт хийх,
- з) Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгжийн зардлыг тооцохын тулд систем тогтоон, хяналт тавих.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нягтлан бодогч
- Аудитор
- Дээд мэргэжлийн нягтлан бодогч
- Мэргэшсэн нягтлан бодогч
- Санхүүгийн хянагч
- Удирдлагын нягтлан бодогч
- Татварын нягтлан бодогч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 1211 Санхүүгийн менежер
- 3313 Туслах нягтлан бодогч
- 3313 Нярав/ тоо бүртгэгч

## **2412 САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ**

Санхүү хөрөнгө оруулалтын зөвлөх нь хувь хүн болон байгууллагуудад өөрсдийнх нь өмнөөс нь хөрөнгө оруулалт, зарцуулалтын талаар санхүүгийн төлөвлөгөө гаргаж өгнө.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Үйлчлүүлэгчийн тухай өгөгдлийн санг байгуулах,
- б) Үйлчлүүлэгчийн санхүүгийн байдал, зорилго, эрсдэл хүлээх чадвар зэргийг тодорхойлж, санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын стратеги боловсруулахад шаардагдах мэдээлэл олж авахын тулд тэдэнтэй ярилцлага хийх,
- в) Үйлчлүүлэгчийн санхүүгийн зорилтыг тодорхойлж, түүнд хэрхэн хүрэх стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх,
- г) Үйлчлүүлэгчид зориулан хувьцаа, бонд худалдаж авах, худалдах,
- д) Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийж, зах зээлийн өөрчлөлт болон үйлчлүүлэгчийн сонирхлын өөрчлөлтөд нийцүүлэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянан үзэж, зохих өөрчлөлт хийх,



- е) Үйлчлүүлэгчийг даатгалд хамрагдахыг зөвлөх, даатгалд хамрагдахад нь туслах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үл хөдлөх хөрөнгийн зөвлөх
- Санхүүгийн зөвлөх

**2413 САНХҮҮГИЙН ШИНЖЭЭЧ**

Санхүүгийн шинжээч нь төр, хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нөлөөлж байгаа мэдээлэлд тоон дүн шинжилгээ хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад зориулж эдийн засаг, бизнес, аж үйлдвэрийн салбарын ирээдүйн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх,
- б) Ажүйдвэрийн технологи, бизнес, санхүү, эдийн засгийн онол хөгжлийн асуудлаар бүрэн мэдлэгтэй байх, шинэ гарсан мэдээллүүдтэй танилцах,
- в) Үнэ, ашиг, тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын эрсдлийн ирээдүйн төлөв байдал, эдийн засгийн нөлөөлөл зэрэг хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нөлөөлөх тоо мэдээллийг тайлбарлах,
- г) Санхүү эдийн засгийн хэвлэл, хөрөнгө оруулалтын банк, засгийн газар, худалдааны байгууллагуудаас гаргаж буй сэтгүүл, компанийн өөрийн өгөгдлийн сан, хувь хүнтэй хийсэн ярилцлага зэргээс олж авсан мэдээлэлд үнэлгээ дүгнэлт хийн эдийн засаг, аж үйлдвэр, корпорацийн хөгжлийн хяналт шинжилгээ хийх,
- д) Компани, хөрөнгө оруулагч компанийн ажилтан, олон нийтэд хөрөнгө оруулалт, түүний хугацааны талаар зөвлөгөө өгөх,
- е) Хувьцааг олон нийтэд худалдах үнийн түвшинг тодорхойлох,
- ж) Санхүүгийн дүн шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.
- з) Тухайн нэг салбарын хэд хэдэн компанийн хувьцааны харьцангуй чанарыг үнэлэх, харьцуулах,
- и) Улс орон, эсвэл тухайн салбар буюу аль нэг компанийн хөгжлийн ерөнхий чиг хандлагын талаар амаар болон бичгээр илтгэж байх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бондын шинжээч
- Хөрөнгө оруулалтын зөвлөх
- Хувьцааны зөвлөх

## **БАГА БҮЛЭГ 242**

### **ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН**

---

Захиргааны мэргэжилтэн нь тухайн байгууллага, тодорхой ажилтны ажлын үр дүнг сайжруулахтай холбоотой онолын чанартай ажил эрхлэнэ.

Тэдний ажил үүрэгт үзэл байримтлал голчлон, байгууллагын бүтцэд үнэлгээ өгөх, сайжруулах талаар зөвлөх, үйл ажиллагаа нь байгууллагынхаа зорилго бодлоготой нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, ажилтныг сонгох, сургах, хөгжүүлэх, зөвлөгөө өгөх зэрэг орно.

Энд бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2421 Удирдлага, байгууллагын шинжээч**

**2422 Бодлогын захиргааны мэргэжилтэн**

**2423 Хүмүүний нөөц, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөгч мэргэжилтэн**

**2424 Сургалтын болон боловсон хүчнийг хөгжүүлэх албаны мэргэжилтэн**

## **2421 УДИРДЛАГА, БАЙГУУЛЛАГЫН ШИНЖЭЭЧ**

Удирдлага, байгууллагын шинжээч нь байгууллагын өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр тухайн байгууллагад туслалцаа үзүүлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Байгууллагын нөөц бололцоог дүүрэн ашиглах, хэрэглэгчийг сэтгэл бүрэн ханамжтай байлгахад чиглэсэн зорилго, стратеги, төлөвлөгөө боловсруулахад нь туслах, дэмжих,
- б) Бүтцийн одоогийн тогтолцоог үнэлэх, дүн шинжилгээ хийх,
- в) Бүтцийн тогтолцоог ажилтнуудтай хамтран хэлэлцэж, байгууллагын бүх шатанд хянаж үзэх,
- г) Байгууллагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход чиглүүлэх, байгууллагын өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд тодорхой шийдэл санал болгох,
- д) Захиргааны одоогийн болон, санал болгож буй журмыг хооронд нь харьцуулах, шинжилгээ хийх,

- е) Байгууллагын үйл ажиллагааны шуурхай график, бүртгэл, тайлан, гарын авлага, ажлын байрны тодорхойлолт зэрэгт дүн шинжилгээ хийх,
- ж) Арга барил, журмыг хянах, үйл ажиллагааны схемийг өөрчлөх, бүртгэл, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх зэрэг санал боловсруулж, зөвлөх,
- з) Батлагдсан зөвлөмж, заавар, гарын авлага, бусад материалыг боловсруулах, хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх,
- и) Үйл ажиллагааны журмыг хянах, журам, стандартыг өөрчлөх талаар зөвлөгөө өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Байгууллага, арга зүйн шинжээч
- Бизнесийн зөвлөх
- Менежментийн зөвлөх

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2511 Мэдээллийн системийн шинжээч

**2422 БОДЛОГЫН ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН**

Бодлогын захиргааны мэргэжилтэн нь засгийн болон санхүүгийн үйл ажиллагаа, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, өөрчлөхөд бодлогын дүн шинжилгээ хийж, зөвлөгөө өгнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Хөтөлбөр хэрэгжүүлэгч, сонирхогч талуудыг уулзуулах, санал солилцох замаар бодлогын хэрэгцээг тодорхойлно,
- б) Хэрэгжиж буй бодлого, хууль тогтоомжийг судлан үзэж хуучирсан, эсвэл хэрэгжүүлэх боломжгүй заалтуудыг олж тодорхойлох,
- в) Эдийн засаг, нийгэм, аж үйлдвэрийн чиг хандлагын талаар болон хэрэглэгчийн зүгээс тухайн үйлчилгээ, хөтөлбөрөөс хүлээж байгаа үр дүнг судлах,
- г) Бодлогын шийдэл санал болгох, зөвлөх дүн шинжилгээ хийх, бодлогын өөрчлөлт хийх талаар зөвлөгөө өгөх, танилцуулах хуудас бэлтгэх,
- д) Гадны нөлөөлөл, санхүүгийн далд үр дагавар, бусад хөтөлбөртэй харилцан үйлчлэхүй болон бодлогын улс төр, захиргааны хэрэгжих үндэслэл зэргийг үнэлэн дүгнэх,
- ж) Аюул, эрсдлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг боловсруулах,
- з) Байгууллагын бусад бодлоготой нийцүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг хянан үзэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бодлогын шинжээч
- Улс төрийн зөвлөх

**2423 ХҮМҮҮНИЙ НӨӨЦ, АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨГЧ МЭРГЭЖИЛТЭН (КАРЬЕРЫН)**

Хүмүүний нөөц, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөгч мэргэжилтэн нь ажилтан шалгаруулж авах, хөгжүүлэх, ажил, мэргэжлийн шинжилгээ хийх, мэргэжлийн чиг олгох зөвлөгөө өгөх зэрэг хүмүүний нөөцийн бодлоготой холбоотой мэргэжлийн бизнес үйлчилгээ үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Ажилтныг шалгаруулж авах, хуваарилах, сургах, дэвшүүлэх, цалин хөлс, урамшил олгох, ажилтан-удирдлагын хоорондын харилцаа зэрэг хүмүүний нөөцийн бодлоготой холбоотой асуудлаар ажил үүрэг гүйцэтгэж, зөвлөгөө өгөх,
- б) Ажилтан болон дунд, дээд шатны удирдлагатай ярилцлага хийх зэргээр байгаа ажлын байрны үүрэг, хуваарийг судлах, шинжлэх, олж авсан мэдээлэлдээ тулгуурлан тухайн албан тушаал, ажлын байр, ажил мэргэжлийн тодорхойлолтыг боловсруулах,
- в) Ажил, мэргэжлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтын системээр ажиллах,
- г) Боловсон хүчний удирдлага, ажиллах хүчний судалгаа, төлөвлөгөө, сургалт болон ажил, мэргэжлийн мэдээлэл, мэргэжлийн баримжаа зэрэг ажлын байр, ажил, мэргэжлийн судалгааны асуудлаар ажиллах, тэрчлэн дээр дурдсан сэдвээр зөвлөгөө өгөх,
- д) Хөдөлмөр эрхлэх болон мэргэжил сонгох, алба дэвших боломж, цаашдын сургалт, боловсролын асуудал (карьер)-аар хувь хүмүүст зөвлөгөө өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ажил, мэргэжил, албан тушаалын чиглэлээр зөвлөгч
- Ажлын байрны шинжээч
- Ажил, мэргэжлийн шинжээч
- Мэргэжлийн чиг баримжаа зөвлөгч
- Хүмүүний нөөцийн мэргэжилтэн
- Ажлаас халагдсан хүмүүст зөвлөгч

**2424 СУРГАЛТЫН БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН**

Сургалтын болон боловсон хүчнийг хөгжүүлэх албаны мэргэжилтэн нь өөрийн байгууллагыг зорилтоо хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадвар

бүхий удирдах, гүйцэтгэх ажилтнаар хангах, зорилгоор сургалт, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж, үнэлэгээ хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Байгууллага, ажилтны сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох,
- б) хүмүүний нөөцийн хөгжлийн зорилгыг тодорхойлж, сургалтын үр дүнд дүн шинжилгээ хийх,
- в) Гарын авлага, видео, online-вэб хуудас, үзүүлэх загвар зэрэг, сургалтын материал, загварчилга бэлтгэж боловсруулах,
- г) Ганцаар болон бүлгээр зохион байгуулах сургалт явуулах, хөтөлбөр боловсруулах ажил зохиох, зохицуулах, хуваарь гаргах, семинар, уулзалт, үзүүлэн, хурал зохион байгуулах,
- д) Сургалтын бусад байгууллагатай холбоо тогтоож, тодорхой сэдвээр сургалт зохион байгуулах,
- е) Дотоод, гадаад сургалтын үйл ажиллагааг дэмжих, эдгээрт ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийх,
- ж) Гадаад дотоод сургалтын чанар үр ашигт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх сургалтын зорилго, арга барил, хичээлийн материалыг хянан шинэчилж байх,
- з) Заах зүйл, сэдвээр тодорхой ойлголттой байхын тулд суурь мэдээ материалыг цуглуулах, олж авах, судалж шинжих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сургалтын ажилтан
- Ажиллах хүчний хөгжлийн мэргэжилтэн

**БАГА БҮЛЭГ 243**

**БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН**

Борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн нь байгууллага, түүний үйлдвэрлэсэн бараа үйлчилгээг сурталчилан урамшуулах агуулга бүхий мэдээллийг түгээх хөтөлбөр төлөвлөх, боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх үүрэг хүлээн бүх төрлийн техник, аж үйлдвэр, эрүүл мэнд, эм, мэдээлэл холбооны технологийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад компаниа төлөөлнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн судалгаа хийх, баримт мэдээг шинжилэх, зах зээл, сурталчилгаа, олоннийттэй харилцах чиглэлээр төлөвлөгөө боловсруулах, зах зээлийн зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэх зэргээр бизнесийн өсөлт,

хөгжилд дэмжлэг үзүүлэх, сурталчилгааны компанит ажлыг төлөвлөх, зохион байгуулах, зохиолч, фото зурагчин, зураач зэрэг сурталчилгаа хийх хүмүүсийн ирүүлсэн материалыг судлах, сонгох, ажил олгогч ба өрсөлдөгчдийн бараа үйлчилгээ, зах зээлийн нөхцөл байдлын талаар мэдээлэлтэй, мэдлэгтэй байх, хэрэглэгчийн хэрэгцээг судлах, тэдэнд бараа үйлчилгээг сурталчлан таниулах, хэрэглэгчидтэй байнга уулзах, зах зээлийн шинэ боломжийг бий болгох, үнэ, зээлийн нөхцөлийг санал болгох, хэлэлцэх, гэрээг эцэслэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **2431 Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн**

### **2432 Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн**

### **2433 Техникийн болон эмнэлгийн борлуулалтын мэргэжилтэн (МХТ-иос бусад)**

### **2434 Мэдээлэл, холбооны технологи борлуулалтын мэргэжилтэн**

## **2431 ЗАР СУРТАЛЧИЛГАА, МАРКЕТИНГИЙН МЭРГЭЖИЛТЭН**

Зар сурталчилгаа, зах зээлийн мэргэжилтэн нь сурталчилгааны стратеги, компанит ажлуудыг санаачилах, зохион байгуулах, шинээр үйлдвэрлэж буй бараа үйлчилгээний зах зээлийг тодорхойлох, тэдгээрт шинэ боломжийг нээж олох чиглэлээр ажиллана.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор сурталчилгааны бодлого, компанит ажлыг төлөвлөх, боловсруулах, зохион байгуулах,
- б) Зорилтот зах зээлд хүрэх зорилгоор боловсруулсан стратеги, компанит ажлын талаар удирдлага, хэрэглэгчидтэй зөвлөлдөх, тухайн бүтээгдэхүүний талаарх хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, бараа үйлчилгээний давуу талыг идэвхитэй сурталчлах,
- в) Сурталчилгааны үг хэллэгийг зохиох, телевиз, бичлэгийн студи, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтарч ажиллах,
- г) Хэрэглэгчийн төлөв байдал, сонирхлын талаарх судалгаанд дүн шинжилгээ хийх,
- д) Хэрэглэгчийн одоо, ирээдүйн төлөв байдлыг тайлбарлах, урьдчилан таамаглах,
- е) Шинээр үйлдвэрлэх бараа үйлчилгээний зах зээлийн онцлог, үүсч болох эрэлтийн талаар судалгаа хийх, холбогдох мэдээ мэдээлэл, статистикийн тоо баримтыг цуглуулж дүн шинжилгээ хийх,

- ж) Зах зээлийн зорилт, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх зэргээр бизнесийн өсөлт, хөгжлийг дэмжих,
- з) Шинээр үйлдвэрлэх, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд шинэ боломж нээж олох,
- и) Зах зээлтэй холбоотой бүхий л асуудал, тухайлбал бүтээгдэхүүний хослол, үнэ, сурталчилгаа, борлуулалтын урамшуулал, борлуулалт, түгээлтийн сэдвээр зөвлөгөө өгнө.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зар сурталчилгааны мэргэжилтэн
- Зах зээлийн судалгааны шинжээч
- Зах зээлийн мэргэжилтэн

**2432 ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН**

Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн нь тухайн байгууллага, түүний бүтээгдэхүүн үйлчилгээ, нийгэмд эзлэх байр суурийн талаар эерэг ойлголт төрүүлэх зорилго бүхий мэдээлэл, харилцааны стратегийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Сурталчилгаа, мэдээлэл, харилцааны стратегийг боловсруулах, зохион байгуулах,
- б) Тухайн байгууллагын бодлого, хөтөлбөрт болон практик амьдралд тулгарч буй бэрхшээлийн талаар удирдлагатайгаа ярилцаж, мэдээлэл, хэвлэлийн мэдээ зэргийг бэлтгэх, түүнд хяналт тавих,
- в) Олон нийтийн санал бодлын талаар судалгаа хийж, үр дүнд нь шинжилгээ хийх, олон нийттэй харилцах, сурталчилах кампанит ажлуудыг төлөвлөх,
- г) Тусгай арга хэмжээ, семинар, хөгжөөнт хөтөлбөр, уралдаан, нийгмийн арга хэмжээ зэрэг нэр хүнд, өргөмжлөлийн арга хэмжээ зохион байгуулж тухайн байгууллагыг сурталчлах,
- д) Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байгууллагаа төлөөлөн ярилцлага өгөх,
- е) Байгууллагыг сурталчлах зорилго бүхий бизнес, нийгэм, бусад арга хэмжээнд оролцох,
- ж) Фото зураг зэрэг үзүүлэн таниулах материалыг захиалах, олж авах,
- з) Сурталчилгааг боловсруулсан зохиогч, фото зурагчин, зураач болон сурталчилгаа хийх бусад хүмүүсийн ирүүлсэн материалыг судлах, сонгох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн

**2433 ТЕХНИКИЙН БОЛОН ЭМНЭЛГИЙН БОРЛУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН (МХТ-ИОС БУСАД)**

Техникийн болон эмнэлгийн борлуулалтын мэргэжилтэн (мэдээлэл, холбооны салбар энд ороогүй) нь аж үйлдвэр, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмийн бүтээгдэхүүн, үйлчилгээг аж үйлдвэр, бизнес, мэргэжлийн зэрэг байгуулагад борлуулахад байгууллагаа төлөөлнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- Утасны жагсаалт, бусад эх үүсвэрийг ашиглан бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий компаниудын жагсаалт гаргах,
- Ажил олгогч, өрсөлдөгчдийн бараа үйлчилгээ, зах зээлийн нөхцөл байдлын талаар мэдээлэл авч, тодорхой мэдлэгтэй байх,
- Хэрэглэгч компаниудтай байнга уулзалдаж байх, зах зээлийн шинэ шинэ боломжийг бий болгох,
- Хэрэглэгчийн хэрэгцээ, нөөц бололцоог судалж, холбогдох бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох,
- Хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулахын тулд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрчлөх шаардлагатай бол мэдэгдэх, зөвлөгөө өгөх,
- Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашигтай талыг сурталчлах борлуулалтын илтгэлд өөрт холбогдох асуудлаар тайлан, саналаа боловсруулж ирүүлэх,
- Тоног төхөөрөмж, үйлчилгээг суурилуулах, засвар үйлчилгээ хийх зардлыг тооцоолох,
- Хэрэглэгчийн байнга өөрчлөгдөж байдаг хэрэгцээ, өрсөлдөгчийн үйл ажиллагааг судлах, үр дүнг борлуулалтын албанд мэдээлэх,
- Үнэ, зээлийн нөхцлийг санал болгох, хэлэлцээр хийх, борлуулалтын гэрээг боловсруулах, баталгаажуулах,
- Бүтээгдэхүүн хүргүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах, үйлчилгээ үзүүлэх асуудлыг хариуцаж зохион байгуулах,
- Борлуулалтын албанд борлуулалтын мэдээлэл өгч, тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний борлогдох чадварын талаар өөрийн саналаа хүргүүлэх,
- Бүтээгдэхүүн үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа эсэх, энэ талаар гарсан асуудлыг шийдвэрлэх, байнгын дэмжлэг үзүүлэх зорилгоор борлуулалтын дараа худалдан авагчтай уулзаж ярилцах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Борлуулалтын ажилтан (аж үйлдвэрийн бүтээгдэхүүн)



- Борлуулалтын ажилтан (эмнэлгийн тоног төхөөрөмж, эмийн бүтээгдэхүүн)
- Техникийн борлуулалтын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3322 Арилжаа, борлуулалтын төлөөлөгч

2434 Мэдээлэл холбооны технологи борлуулалтын мэргэжилтэн

**2434 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ БОРЛУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН**

Мэдээлэл, холбооны технологи борлуулалтын мэргэжилтэн нь компьютерийн эд анги, программ хангамж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг (үүнд барааг угсрах, суурилуулах, тусгай зааварчилгаа өгөх зэрэг) бөөний түвшинд худалдаа хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Захиалга олох, бүтээгдэхүүн үйлчилгээг жижиглэнгийн дэлгүүр болон аж үйлдвэр, бөөний худалдаа, бусад салбаруудад борлуулах,
- б) Техникийн тоног төхөөрөмж, эд анги, холбогдох үйлчилгээг байгууллага болон хувь хүмүүст борлуулах,
- в) Шинэ болон байнгын хэрэглэгчийн хэрэгцээг судалж, тухайн бараа үйлчилгээ тэрхүү хэрэгцээг хангах талаар тодорхой мэдээлэл өгөх,
- г) Үнэ, зээлийн нөхцлийг санал болгох, хэлэлцээр хийх, борлуулалтын гэрээг боловсруулах, баталгаажуулах, захиалгыг бүртгэх,
- д) Хэрэглэгчийн талаархи мэдээллийг шинэчлэх, борлуулалтын тайлан бэлтгэх,
- е) Бараа хүргүүлэх, тоног төхөөрөмж суурилуулах, үйлчилгээ үзүүлэх ажил зохион байгуулах,
- ж) Хэрэглэгчийн санал, шаардлагыг үйлдвэрлэгчид хүргүүлэх.

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5223 Дэлгүүрийн борлуулалтын туслах ажилтан

---

**ДЭД БҮЛЭГ 25  
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН  
МЭРГЭЖИЛТЭН**

---

Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн нь мэдээллийн технологийн систем, техник, программ хангамж болон тусгай хэрэглээнд

зориулсан ойлголтоор судалгаа явуулах, төлөвлөх, зохиох, тодорхойлж бичих, сорилт хийх, зөвлөгөө өгөх, сайжруулах, заавар, журам, бодлого, зарчим зэрэг түүнтэй холбоотой бичиг баримт боловсруулах, өгөгдлийн сан болон бусад мэдээллийн нэгдэл нууцлал, оновчлолыг хангахын тулд өгөгдлийн сан зохион, боловсруулах, хянах, хадгалах үүрэгтэй.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэж болох мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох, компьютер ашиглах үйл ажиллагааны хэлбэр, онолын асуудлыг судлах, сайжруулах аргыг тодорхойлох, интернэт, мультимедиа зэрэг тусгай зориулалтын системүүдийг ашиглахад зориулж техник болон программ хангамжийг судлах, төлөвлөх, зохиох, компьютерийн программыг зохиох, тодорхойлох, шалгах, сайжруулах, өгөгдлийн санг зохиомжлох, сангийн менежментийн системийг байгуулах, хамгаалалтын төлөвлөгөө, мэдээллийг ашиглах зарчмыг тодорхойлох, хэрэгжүүлэх, компьютерийн сүлжээ, холбогдох тооцооллын системийг ажиллуулах, компьютерийн систем боловсруулах, тохиргоо хийхэд ашиглаж байгаа системийг зохиох, тодорхой нөхцлүүдийн дагуу боловсруулах, мэдээллийн загвар, бүтцийг шинжлэх, боловсруулах, тайлбарлах, үнэлгээ хийх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**251 Программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч**

**252 Өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн**

## **БАГА БҮЛЭГ 251**

### **ПРОГРАММ ХАНГАМЖ, ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ ЗОХИОГЧ, ШИНЖЭЭЧ**

Программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч нь компьютерийн техник, программ хангамж, зарим тусгай хэрэглээний программ зэрэг мэдээлэл технологийн системийг судлах, төлөвлөх, зохиох, тодорхойлж бичих, сорилт тавих, зөвлөгөө өгөх, сайжруулах үүрэг гүйцэтгэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэж болох мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлж, хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх боллоцоотой эсэхийг судлах, компьютер ашиглах үйл ажиллагаа арга хэлбэр, онолын

асуудлаар судалгаа явуулах, хэрэглээний тусгай зориулалтаар ашиглах компьютер, түүний техник, программ хангамжийг үнэлэх, төлөвлөх, зохиох, тусгай шаардлагын дагуу программ хангамжийг зохиох, сорих, хадгалах, интернет, интранет мультимедиа системийг үнэлэн дүгэнх төлөвлөх, зохиох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2511 Мэдээллийн системийн шинжээч**

**2512 Программ хангамж зохиогч**

**2513 Вэб, мультимедиа зохиогч**

**2514 Хэрэглээний программ зохиогч**

**2519 Энэ ангилалд ороогүй бусад программ хангамж, хэрэглээний программ зохиогч, шинжээч**

**2511 МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ШИНЖЭЭЧ**

Мэдээллийн системийн шинжээч нь хэрэглэгчийн мэдээллийн технологийн хэрэгцээ шаардлага, зарчим, бэрхшээлтэй асуудлыг судалж, үнэлж дүгнэх, одоо хэрэглэж байгаа болон ирээдүйд хэрэглэх мэдээллийн системийг сайжруулах санал, зөвлөмж, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлж, түүний дагуу системд хийх өөрчлөлтүүдийн талаар компанийн удирдлагуудтай санал солилцох,
- б) бизнесийн явц, журам, ажлын үйл явцыг тодорхойлж, дүгнэх,
- в) үр ашиггүй байдлыг тодорхойлж, дүгнэх, бизнесийн оновчтой гүйцэтгэх чадамж, зан төлвийг зөвлөмж болгох,
- г) системийг шалгах төлөвлөгөө боловсруулж ашиглах, хэрэгжүүлэх зэрэг функциональ шийдлийг хэрэгжүүлэх үүднээс хариуцлагын тогтолцоо бий болгох,
- д) системийн ажиллагааны заавар боловсруулах,
- е) ажлын явц, шинээр тодорхойлсон зорилтуудыг хангах зорилгоор системийг өргөтгөх, өөрчлөх,
- ж) системийг байгууллагын үйл ажиллагаанд зохицуулах, холбох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бизнесийн шинжээч (мэдээллийн технологи)
- Цахим техникийн мэргэжилтэн (мэдээллийн технологи)

- Системийн зөвлөх
- Систем зохиогч (мэдээллийн технологи)
- Компьютерийн эрдэм шинжилгээний ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2523 Комьпютерийн сүлжээний мэргэжилтэн (мэдээллийн технологи)
- 2522 Системийн эрхлэгч

**2512 ПРОГРАММ ЗОХИОГЧ**

Программ хангамж зохиогч нь ашиглаж байгаа болон шинээр боловсруулсан программ хангамж, үйлдлийн системд тавигдах шаардлагыг судлан дүгнэх, эдгээр шаардлагад нийцүүлэн программ хангамжийн шийдэл зохиох, боловсруулах, шалгах, хадгалах үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) программ хангамж, үйлдлийн системийн шаардлагыг судлан дүгнэх, үнэлэх,
- б) компьютерийн программ хангамжаар судалгаа хийх, зохиох, боловсруулах,
- в) компьютерийн техник, программ хангамжийн хоорондын харьцааг үнэлэхдээ инженерүүдтэй хамтран ажиллах,
- г) программыг шалгах, ашиглах журмыг боловсруулж, зааварчлах,
- д) одоо ашиглаж байгаа программын алдааг засах, шинэ эд ангид тохируулах, ашиглалтыг сайжруулах,
- е) программ хангамжаар чиглэл өгөх, холбогдох баримт бичгийг боловсруулах,
- ж) үйлдлийн систем, холбооны орчин, программын хэрэглээг үнэлэх, боловсруулах, сайжруулах, үйлчилгээ хийх журам,
- з) программ хангамжийг ашиглах чиглэлээр хэрэглэгчидтэй санал бодлоо солилцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Программ хангамжийн шинжээч
- Программ хангамжийн дизайнч
- Программ зохиогч
- Программ хангамжийн инженер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2514 Хэрэглээний программ зохиогч

### 2513 ВЭБ, МУЛЬТИМЕДИА ЗОХИОГЧ

Вэб, мультимедиа зохиогч нь дизайн, техникийн мэдлэгээ ашиглан дүрс бичлэг, график, хүүхэлдэйн зураг, хөдөлгөөний дүрс, дуу, видео бүхий хэрэглээний программуудыг судлах, шинжлэх, үнэлэх, зохиох, программ бичих, өөрчлөх үүрэгтэй.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) программ хангамж, программын хэл, үйлдлийн систем ашиглан урлаг, уран санаа хослуулсан интернэт хуудсуудыг үнэлэх, зохиох, бичих,
- б) мультимедиа программ, арга хэрэгсэл, компьютер график, программын хэл зэргийг ашиглан дижитал хүүхэлдэйн зураг, хөдөлгөөнт дүрс, презентаци, тоглоом, аудио болон видео бичлэг, интернэтийн программ зэргийг зохиох, боловсруулах,
- в) интернет, вэб хуудасны нууцлал, вэбсайтад тавих мэдээллийн багтаамж, хэрэглэгчийн хүртэц, мэдээлэл шинэчлэх, вэб сайт хувиран хадгалах, сэргээх төлөвлөгөөг хянах хэрэгжүүлэх, үүний тулд байрлуулсан хаяг, нууцлал зэрэг вэбсайттай холбоотой асуудлаар сүлжээний мэргэжилтэнтэй зөвлөлдөх,
- г) вэб хуудас хийх, байнга ажиллуулах, засварлах зорилгоор зураг, дуу, хэлний зэрэг тусгай файлуудыг компьютерийн кодтой нийцүүлэх,
- е) интернетийн стратеги, вэб хуудсанд суурилсан аргачлал, төлөвлөгөө боловсруулах, дүн шинжилгээ хийх зэрэгт туслалцаа үзүүлэх.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Хүүхэлдэйн программч
- Компьютер тоглоомын программч
- Интернет зохиогч
- Мультимедиа программч
- Вэбсайтны архитектор
- Вэбсайт зохиогч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

2166	График, мультимедиа зохиомжийн дизайнерч
3514	Вэбмастер
3514	Вэбсайт захирагч
3514	Вэб техникч

### 2514 ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ ЗОХИОГЧ

Хэрэглээний программ зохиогч нь тухайн программын хэрэглээ, үйлдлийн системд зориулсан зааварчилгаа болон техникийн зааврыг программын хэлээр бичиж, засварлах үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Чанарын магадлан итгэмжлэгдсэн стандартын дагуу зааварчилгаа, техникийн зааврыг программын хэлээр бичиж, засварлах,
- б) Ашиглагдаж байгаа программын үйл ажиллагааны үрдүнг сайжруулах, шинэ шаардлагад нийцүүлэх тохиолдолд тухайн программыг хянаж үзэх, засах, юмуу өргөжүүлэх,
- в) Программыг хэрэглэснээр хүссэн үр дүндээ хүрч байгаа эсэхийг тодорхойлохын тулд программ ажиллуулж шалгах, сорих ажил гүйцэтгэх,
- г) Хөтөлбөрийн бичиг баримт бэлтгэх, боловсруулах, даган мөрдөх,
- д) Техникийн асуудал бэрхшээлийг тодорхойлж, шийдлийн санал дэвшүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хэрэглээний хангамж зохиогч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                            |
|------|----------------------------|
| 2513 | Вем, мультимедиа программч |
| 2512 | Программын шинжээч         |
| 2512 | Программ хангамж зохиогч   |

**2519 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД ПРОГРАММ ХАНГАМЖ, ХЭРЭГЛЭЭНИЙ ПРОГРАММ ЗОХИОГЧ, ШИНЖЭЭЧ**

Энэхүү хэсэг нь 251-д ороогүй бүх программ, хэрэглээний программ зохиогч, задлан шинжээчдийг багтаана. Үүнд: Бүтээгдэхүүний чанар шалгах үүрэг бүхий мэргэжлийн ажилтан буюу программ шалгагч орох жишээтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Программ турших төлөвлөгөө боловсруулж, баримтжуулах,
- б) Программ туршихад бэлтгэж компьютерийн программ эд ангийг суурилуулах, үйлдлийн системийг тохируулах,
- в) Программ хэрэглэгчийн шаардлага болон стандарт, зааврын дагуу ажиллаж байгаа эсэхийг шалгах,
- г) Мэдээлэл, холбооны систем, программын хэрэглээний үр дүнг шалгах, шинжилгээ хийх, баримтжуулах,
- д) Программ, мэдээллийн системийг турших талаар бодлого, журам, дүрэм боловсруулж, хэрэгжүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Чанар шалгагч (компьютер)

- Программ шалгагч
- Систем шалгагч

## БАГА БҮЛЭГ 252

### ӨГӨГДЛИЙН САН, СҮЛЖЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

---

Өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн нь өгөгдлийн сан, компьютерийн эд анги, сүлжээ, үйлдлийн систем зэрэг компьютерийн дэд бүтэц, мэдээллийн технологийн нууцлал, хамгийн зохистой ажиллагааг зохиомжлон, боловсруулах, хянах, хадгалах, дэмжих үүрэгтэй.

#### Гүйцэтгэх үүрэг:

Өгөгдлийн сангийн ерөнхий схем, бүтэц, хэллэгийг зохиож, мэдээллийн системийн төслүүдийг байршуулах, өгөгдлийн сангийн менежментийн системийн ерөнхий бүтцийг зохион байгуулах, өөрчлөх, нэгтгэх, хэрэгжүүлэх, турших, нууцлалын төлөвлөгөө, өгөгдлийн санг удирдах бодлого, бичиг баримт, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, компьютерийн сүлжээ болон түүнтэй төстэй тооцооллын орчныг ажиллуулах, удирдах, компьютерийн системийг боловсруулах, өөрчлөх, нэгтгэхийн тулд системийн онцлог, өгөгдлийн загвар, диаграммд шинжлэх, боловсруулах, тайлбарлах, үнэлэгээ өгөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийн дараах нэгж бүлэгт ангилна:

#### 2521 Өгөгдлийн сангийн дизайнч, эрхлэгч

#### 2522 Системийн эрхлэгч

#### 2523 Компьютерийн сүлжээний мэргэжилтэн

#### 2529 Энэ ангилалд ороогүй бусад өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн

### 2521 ӨГӨГДЛИЙН САНГИЙН ДИЗАЙНЧ, ЭРХЛЭГЧ

Өгөгдлийн сангийн дизайнч, эрхлэгч нь өгөгдлийн санг зохиох, боловсруулах, түүний нууцлал, үйл ажиллагааг хянах, засварлах, өгөгдлийн санг бүрэн үр ашигтай байдлаар ажиллуулах үүрэгтэй.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) Өгөгдлийн сангийн ерөнхий схем, бүтэц, хэллэгийг зохиож, мэдээллийн системийн төслүүдийн үзэл баримтлалыг тогтоох,

- б) Өгөгдлийн сангийн менежментийн системийн ерөнхий бүтцийг зохиох, байгуулах, өөрчлөх, нэгтгэх, хэрэгжүүлэх, турших,
- в) Өгөгдлийн сангийн менежментийн арга хэрэгслийн талаар судалгаа явуулах, сонгоход мэргэжлийн зөвлөгөө өгөх, ашиглах, хэрэгжүүлэх,
- г) Өгөгдлийн санг ажиллуулах бодлого, баримт бичиг, стандарт, загварыг боловсруулах, хэрэгжүүлэх,
- д) Өгөгдлийн санд нэвтрэх, түүнийг ашиглах журам боловсруулах, өгөгдлийн санг хувилж хадгалах,
- е) Өгөгдлийн санг хувилж хадгалах, мэдээллийг сэргээх үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэх, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн нууцлал, хяналтын нэгдмэл байдлыг хангах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Мэдээллийн эрхлэгч
- Өгөгдлийн сангийн дизайнч, эрхлэгч
- Өгөгдлийн сангийн шинжээч
- Өгөгдлийн сангийн дизайнч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

2522	Системийн эрхлэгч (компьютерийн)
2522	Сүлжээний эрхлэгч
3514	Вэбсайт эрхлэгч
3514	Вэбмастер

### 2522 СИСТЕМИЙН ЭРХЛЭГЧ

Системийн эрхлэгч нь мэдээллийн технологийн системийн нууцлал, найдвартай үйл ажиллагааг хангана.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) Компьютерийн сүлжээ, тооцооллын орчинд нөлөөлөх хүчин зүйлс болон компьютерийн эд анги, системийн программ хангамж, программын хэрэглээ, бусад холбогдох тохиргоо найдвартай ажиллагааг хариуцах,
- б) Систем, сүлжээний тохиргоог сайжруулан өөрчлөх тухай зөвлөмж гаргах, үүнтэй холбоотойгоор хийгдэх компьютерийн техник системийн программ хангамжийг хэрхэн өөрчлөх тухай санал гаргах,
- в) Компьютерийн эд анги болон системийн программ хангамжийн алдааг олох,
- г) Мэдээллийг хувилж хадгалах, мэдээллийг сэргээх,
- е) Компьютерийн систем, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хянах, компьютерийн сүлжээнд нэвтрэх, түүнийг ашиглах байдлыг зохицуулах.



**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Системийн эрхлэгч
- Сүлжээний эрхлэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2521	Өгөгдлийн сангийн эрхлэгч
2523	Компьютерийн сүлжээний мэргэжилтэн
3514	Вэбсайт эрхлэгч
3514	Вэбмастер

**2523 КОМПЬЮТЕРИЙН СҮЛЖЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН**

Компьютерийн сүлжээний мэргэжилтэн нь сүлжээний бүтэц, ажиллагааг байнга хянаж судалж, дүгнэлт гаргах ба сүлжээний техник, программ хангамжийг ажиллуулах, хариуцах, тохиргоог хийх, хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах, алдааг олж илрүүлэх, хянах үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) компьютерийн системийг боловсруулах, түүнд тохиргоо хийх, нэгдмэл байдлыг хангахын тулд системийн зохиомж, онцлог шинж, мэдээллийн загвар, диаграммд дүн шинжилгээ хийх, боловсруулах, тайлбарлах, үнэлэх,
- б) системийн хүчин чадлыг бүрэн ашиглах үүднээс сүлжээний тохиргоо хийх, улмаар дэд бүтцийг нь хянах, судлах, дүн шинжилгээ хийх, үнэлэх,
- в) сүлжээний хэвийн ажиллагаа, түүнтэй холбоотой компьютерийн техник, программ хангамж, холбоо, үйлдлийн систем зэрэгт хяналт тавьж, сайжруулах боломжийн талаар зөвлөгөө өгөх,
- г) сүлжээний алдаа засах, хэвийн ажиллагааг хангахад мэргэжлийн ур чадвараа дайчлах,
- д) шинээр сүлжээ, программ хангамж, сервер, компьютер суурилуулах болон сайжруулах тохиолдолд тохиргоо хийх, турших, үйлчилгээ үзүүлэх,
- е) сүлжээний эд ангийн бүртгэл хийх журам, баримт бичиг боловсруулах, хөтлөх, сүлжээний алдааг оношлож засварласан, сүлжээг сайжруулж, өөрчилсөн, тодорхой заавар журам мөрдсөн талаар бүртгэл хөтлөх,
- ж) сүлжээний хүчин чадлыг бүрэн ашиглах, нэгдмэл байдлыг хангах үүднээс сүлжээний ачаалал, үйл ашиглалт, хүчин чадал, хэрэглээг нь байнга хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Холбооны мэргэжилтэн (компьютерийн)
- Сүлжээний шинжээч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2511	Мэдээллийн системийн шинжээч
2522	Системийн эрхлэгч

**2529 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД ӨГӨГДЛИЙН САН, СҮЛЖЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН**

Энэ хэсэгт бага бүлэг 252-т ороогүй бусад өгөгдлийн сан, сүлжээний мэргэжилтэн орно. Тухайлбал, мэдээлэл, холбооны технологийн нууцлалын мэргэжилтэн гэх мэт.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Компьютерийн файлыг санаатай, санамсаргүй өөрчлөх, устгах, нийтэд залрахаас урьдчилан сэргийлэх, мэдээллийг нууцлах хэрэглэгчийн шаардлагад нийцэхүйц төлөвлөгөө боловсруулах,
- б) Сервер, сүлжээний хүчин чадлыг сайжруулах, системийн нууцлалыг хадгалах үүднээс нууцлалын талаарх мэдээллийг түгээх, хэрэглэгчийг сургах,
- в) Компьютерийн мэдээлэлд нэвтрэх хэрэгцээ, нууцлал, программын өөрчлөлт зэрэгээр хэрэглэгчтэй санал солилцох,
- г) Вирусээс хамгаалах системийг сайжруулан түүний талаарх мэдээллийг байнга хянаж байх,
- д) Шинэ программ суулгах, алдааг засварлах, хувь хүний нэвтрэх эрхийг өөрчлөхтэй холбоотойгоор компьютерийн системийн нууцлалын файлуудыг өөрчлөх,
- е) Мэдээлэл бүхий файлуудын ашиглалт, тэдгээрийн нууцлалын тухай мэдээлэлд нэвтрэх байдлыг хянах,
- ж) Мэдээлэл боловсруулах, нууцлалыг хангах зорилгоор мэдээлэл боловсруулах системийг шалгах, турших, эрсдлийн үнэлгээ хийх,
- з) Дамжуулсан мэдээллийн кодыг тайлах, нууц болон тоон мэдээлэл дамжуулж байгаа тохиолдолд нууцлалыг хамгаалах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шүүх эмнэлэгийн дижитал мэргэжилтэн
- Нууцлалын ажилтан (мэдээлэл, холбооны технологи)

**ДЭД БҮЛЭГ 26****ХУУЛЬ, НИЙГЭМ, СОЁЛЫН МЭРГЭЖИЛТЭН**

Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн нь эрх зүйн мэдээлэл, түүнийг хадгалах, эртний болон орчин үеийн мэдээлэл, сэтгэл судлал, нийгмийн

халамж, улс төр, эдийн засаг, түүх, шашин, хэл шинжлэл, социологи болон бусад шинжлэх ухаан түүнчлэн, урлаг, энтертайнмент зэрэгт холбогдох мэдлэгийг хэрэглэх, юмуу тэдгээрийн тухай онол, хэрэглээний арга, үзэл баримтлалыг судлах, сайжруулах, шинээр төсөл боловсруулах үүрэг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Энэхүү дэд бүлгийн ажилтны гүйцэтгэх гол үүрэг нь: хуулийн тодорхой асуудлаар судалгаа явуулах, хууль журмын төсөл боловсруулах, үйлчлүүлэгчид хуулийн зөвлөгөө өгөх, шүүхэд хэрэг өмгөөлөх, төлөөлөх, шүүн хэлэлцэх хурлыг даргалах, архивын цуглуулга хийх, номын сан ажиллуулах, нийгмийн ухааны мэдлэгийг хэрэглэх, уг асуудлаар баримтлал, онол, хэрэглээний арга хэлбэрийг судлах, боловсруулах, сайжруулах, утга зохиол урлагын бүтээл туурвих, шинэ мэдээ, үзэл санаа илэрхийлэх, баримт тайлбарлах, түгээх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 261 Эрх зүйн мэргэжилтэн**
- 262 Номын санч, архивч, музейн харгалзагч**
- 263 Нийгэм, шашны мэргэжилтэн**
- 264 Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээч**
- 265 Уран бүтээлч, жүжигчин**

#### **БАГА БҮЛЭГ 261**

#### **ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН**

---

Эрх зүйн мэргэжилтэн нь хуулийн тодорхой асуудлаар судалгаа хийх, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, шүүхэд хэрэг өмгөөлөх, юмуу яллагчаар оролцох, шүүх хурлыг даргалах, хууль, журмын төсөл боловсруулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчлүүлэгчид хуулийн зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчийг төлөөлөх, шаардлагатай бол зарга мэдүүлэх, шүүх хурлыг даргалах, шүүхийн шийдвэрийг уншиж танилцуулах. Бусад ажилтныг удирдлагаар хангаж болно.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2611 Эрх зүйч**

**2612 Шүүгч**

**2619 Аль нэг ангилалд ороогүй эрх зүйн бусад мэргэжилтэн**

### **2611 ЭРХ ЗҮЙЧ (ХУУЛЬЧ)**

Эрх зүйч нь өргөн хүрээтэй асуудлаар үйлчлүүлэгчдэд хуулийн зөвлөгөө өгөх, бичиг баримт бүрдүүлэх, үйлчлүүлэгчийг захиргааны болон бусад шүүх болон шүүх хуралд төлөөлөх, эсвэл яллагчаар оролцох, юмуу дээд шатны шүүхэд давж заалдах талаар зөвлөнө.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Үйлчлүүлэгчид өргөн хүрээтэй асуудлаар хуулийн зөвлөгөө өгөх, түүний өмнөөс хуулийн ажиллагаа хийх,
- б) Хууль зүйн зарчим, дүрэм, тухайн хэргийн асуудлаар өмнөх шатны шүүхээс гарсан шийдвэрийг судлах,
- в) Хуулийн, юмуу өмгөөллийн ямар нэг арга хэмжээ авах зорилгоор нотлох баримт бүрдүүлэх, асуудлыг тодорхой болгохын тулд үйлчлүүлэгч болон гэрчийн этгээдтэй ярилцлага хийх,
- г) Хэргийг хэлэлцэхэд бэлтгэж олж авсан мэдээллийг үнэлэх, мэтгэлцээний талаар стратеги бэлтгэх,
- д) Үйлчлүүлэгчийн хэргийг шүүх, захиргааны шүүхэд төлөөлөх, зохих шатны шүүхэд давж заалдаж болох талаар зөвлөгөө өгөх,
- е) Дээд шатны шүүхэд давж өмгөөлөл хийх,
- ж) Төрийг төлөөлж яллагчаар оролцох,
- з) Хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хэлэлцээ хийх,
- и) Хуулийн төсөл боловсруулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад үндэслэн Засгийн газрын журам боловсруулах,
- к) Гэрээ хэлэлцээр, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, гэрээслэл, хуулийн байр суурь илэрхийлэх бичиг баримт бэлтгэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эрх зүйч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                |
|------|----------------|
| 2619 | Нотариатч      |
| 3411 | Хуулийн туслах |

## 2612 ШҮҮГЧ

Шүүгч нь иргэний болон эрүүгийн холбогдолтой хэрэг шүүх ажиллагааг удирдана.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) Хэргийн материал, гэрчийн мэдүүлэгтэй танилцах,
- б) Нотлох баримтад тулгуурлан шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, тайлбарлах,
- в) Олон нийтийн шүүх хуралд оролцож байгаа талуудын эрх үүргийг тодорхойлох,
- г) Олон нийтийн төлөөлөлд тухайн хэрэгт хэрэглэж болох хуулийн заалт, журмыг танилцуулах, зааварчилгаа өгөх,
- д) Олон нийтийн төлөөлөлгүйгээр шүүх хурал хуралдах тохиолдолд буруутгагдаж байгаа этгээдийн болон шүүгдэгчийн гэм буруутайг тогтоох зорилгоор нотлох баримтыг нягтлан үзэж, ноцтой эсэхийг тодорхойлох,
- е) Эрүүгийн хэрэгт буруутай этгээдэд ял ногдуулах, хохирлыг тодорхойлох, иргэний хэргийн үед хохирлыг барагдуулах, шүүхийн шийдвэр гаргах,
- ж) Хуулийн асуудлаар судалгаа хийх, байр сууриа илэрхийлэх.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Тэргүүн шүүгч
- Шүүгч

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                   |
|------|-------------------|
| 3411 | Шүүхийн туслах    |
| 3411 | Эвлэрүүлэгч шүүгч |

## 2619 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ ЭРХ ЗҮЙН БУСАД МЭРГЭЖИЛТЭН

Энэ хэсэгт бага бүлэг 261-т ороогүй эрх зүйн бусад мэргэжилтэн багтана. Тухайлбал, энэ бүлэгт шүүхэд өмгөөлөгчөөр юмуу яллагчаар оролцдоггүй, хурал даргалдаггүй хуулийн мэргэжлийн бусад ажилтан багтана.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) Хувь хүн, бизнес, захиргааны зэрэг асуудлаар хуулийн зөвлөгөө өгөх,
- б) Гэрээ болон хуулийн бусад баримт бичгийг боловсруулах,

## **2** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

- в) Хөрөнгө шилжүүлэх харилцааг зохицуулах,
- г) Жам бусаар нас барсан тохиолдолд шинжилгээ хийх.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сэжигтэй үхлийн мөрдөн байцаагч
- Шүүх бүрэлдэхүүнд оролцогчид (хуульч, шүүгчээс бусад)
- Нотариатч

## **БАГА БҮЛЭГ 262 НОМЫН САНЧ, АРХИВЧ, МУЗЕЙН ХАРГАЛЗАГЧ**

---

Номын санч, архивч, музейн харгалзагч нь архив, номын сан, музей, урлагийн галлерей, төстэй бусад байгууллагад цуглуулга хийх, баяжуулах, ашиглах зэрэг үйлчилгээ хийнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Архивын агуулга, түүхийн баримт цуглуулаг, урлагийн бүтээлүүдийг үнэлэх, цуглуулах, тэдгээрийг найдвартай хамгаалах, хадгалах, музей, урлагийн галлерей, болон төстэй бусад байгууллагын цуглуулга, үзэсгэлэнг ангилах, бүртгэгдсэн, хэвлэгдсэн материалыг системтэйгээр цуглуулах, зохих арга хэмжээг авах, номын сангийн уншигчдад хүртээл болгох, эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих, судалгаа явуулах.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **2621 Архивч, музейн харгалзагч**

### **2622 Номын санч, холбогдох бусад мэдээллийн мэргэжилтэн**

## **2621 АРХИВЧ, МУЗЕЙН ХАРГАЛЗАГЧ**

Архивч, музейн харгалзагч нь архив, эд өмчийн зүйл, түүх, соёл болон засаг захиргаа, урлагын холбогдолтой бүтээлийн бүртгэл, бүрдэл зүйлс цуглуулах, үнэлэх, тэдгээрийг хадгалах, хамгаалах үүрэгтэй. Түүхийн үнэт баримт бичиг, бүтээлийг хадгалах төлөвлөгөө боловсруулах, хамгаалалтын системийг бүтээж хэрэгжүүлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Засаг захиргааны, түүхийн баримт бичиг хуулийн нотлох баримт, бусад баримт зүйлсийг үнэлэх, хадгалах,
- б) Цуглуулсан материалыг индексжүүлэх, номын сангийн каталог үүсгэх,

- хальсанд хуулбарлах зэрэг ажил гүйцэтгэж, материалыг олны хүртээл болгох,
- в) Урлаг, түүхийн холбогдолтой материалын гарал үүсэл, тархалт, ашиглалт зэргийг тодорхойлох,
  - г) Урлаг, шинжлэх ухаан, түүхийн үнэт бүтээлийн цуглуулгыг бүрдүүлэх, зохион байгуулах, холбогдох үйлчилгээг хийх,
  - д) Музей, урлагын галлерейн бүтээлийг ангилах, каталогт оруулах, үзэсгэлэн зохион байгуулах,
  - е) Төрийн баримт бичиг, хувийн материал, фото зураг, газрын зураг, дуу дүрстэй түүхэн гар бичмэл, үнэт материалыг судлах, хайж олох, үнэлэх, ангилж зохион байгуулах, хадгалах,
  - ж) Эрдэм шинжилгээний тайлан илтгэл бэлтгэх,
  - з) Архивын менежментийг компьютержүүлэх, цахим бүртгэл бий болгох ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх,
  - и) Музей, урлагын галлерейд үзэсгэлэн зохион байгуулах, энэ тухай, нийтэд мэдээлэх, ерөнхий, тусгайлсан, юмуу танин мэдэхүйн зорилготой үзмэрийг зохион байгуулах,
  - к) Судалгааны зорилгоор архивын цуглуулга бий болгох, арвижуулах, хадгалах, үнэлэх, архивын материал олж авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Архивч
- Урлагын галлерейн музейн харгалзагч
- Музейн харгалзагч
- Бүртгэлийн менежер

**2622 НОМЫН САНЧ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙН БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Номын санч болон мэдээллийн бусад ажилтан нь номын сангийн цуглуулга мэдээлэл хадгалагч эх үүсвэрийг цуглуулах, сонгох, зохион байгуулах үйлчилгээ эрхэлнэ. Түүнчлэн уншигчдад номын сангийн бусад үйлчилгээг хүргэж, мэдээллээр хангана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Ном, сэтгүүл болон бусад хэвлэмэл материал, дуут болон дүрст, тоон системийг ашиглаж хадгалсан материалыг эмхлэх, үйлчилгээ үзүүлэх,
- б) Ном, сэтгүүл болон бусад хэвлэмэл материал, дуут болон дүрст, тоон системийг ашиглаж хадгалсан материалыг сонгох, олж авахыг зөвлөх,
- в) Номын сангийн материалыг эмхлэх, ангилах, каталогт оруулах,

- г) Мэдээллийн сүлжээ, бусад номын сантай ном солилцох үйлчилгээ хөгжүүлэх, хэрэгжүүлэх,
- д) Өгөгдлийн сан болон сүлжээнд багтдаг бусад номын сангын фондод түшиглэн үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээ материалаар хангах,
- е) Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн номын сан, мэдээллийн үйлчилгээг өөрчлөх талаар судалгаа, шинжилгээ хийх,
- ж) Мэдээллийг хадгалах, эмхлэх, ангилах, татаж авах дараалал, загварыг боловсруулах, хэрэгжүүлэх,
- з) Эрдэм шинжилгээний мэдээ, тайлан бэлтгэх, боловсруулах,
- и) Хайлтыг гар аргаар юмуу интернетээр, медиа ашиглан хийх, номын сан хоорондын зээл хөгжүүлэх, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бусад үйлчилгээг үзүүлэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ном зүйч
- Каталогч
- Номын санч

### **БАГА БҮЛЭГ 263**

#### **НИЙГЭМ, ШАШНЫ МЭРГЭЖИЛТЭН**

---

Нийгэм, шашны мэргэжилтэн нь философи, улс төр, эдийн засаг, социологи, антропологи, түүх, хэл шинжлэл, сэтгэл судлал, нийгмийн бусад ухааны мэдлэгийг хэрэглэх, юмуу тэдгээрийн агуулга, онол, хэрэглээний арга барилыг судлах, сайжруулах, шинээр боловсруулах үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн тухайн орон нутагт оршин суугаа хувь хүн, гэр бүлд хэрэгцээ шаардлагад нь нийцсэн нийгмийн үйлчилгээ үзүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Эдийн засаг, улс төр, нийгмийн одоо болон ирээдүйн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай санал боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хүний үүсэл хөгжил, эволюци, өнгөрсөн үйл явдлыг судлах, дүн шинжилгээ хийх, хэлний үүсэл хөгжлийг судлах, хэлнээс хэлэнд орчуулах, хэлмэрчлэх, сэтгэцийн үйл явц, хувь хүн, бүлэг хүний үйл хөдлөлийг судлах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих. Зарим ажилтыг удирдлагаар хангаж болно.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2631 Эдийн засагч**

**2632 Социологич, антропологич, холбогдох бусад мэргэжилтэн**

**2633 Философич, түүхч, улс төр судлаач**



**2634 Сэтгэл зүйч****2635 Нийгмийн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн****2636 Шашны мэргэжилтэн****2631 ЭДИЙН ЗАСАГЧ**

Эдийн засагч нь мэдээллийг олжавах, хянах, дүн шинжилгээ хийх, эдийн засаг, бизнесийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө гаргах, тайлан бичих, эдийн засгийн хэв шинж, үйл хөдлөл судлах, тайлбарлах, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлохын тулд загвар боловсруулах, эдийн засаг, бизнесийн одоо ба ирээдүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар засгийн газар, бизнес эрхлэгчид, сонирхлын бүлгүүдэд зөвлөгөө өгөх үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) богино хугацааны төсөл, урт хугацааны хөрөнгө оруулалт, түүний үнэлгээнд эдийн засгийн орчны өөрчлөлтийг тооцоолох, таамаглах,
- б) эдийн засгийн төлөвлөгөө, компанийн стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө бодлого боловсруулах, зөвлөгөө өгөх, төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн үндэслэл тооцоолох,
- в) төсөв, мөнгөний бодлого эдийн засгийн үр ашиг, нөхцөл байдалд хэрхэн нийцэж байгааг судлах, түүнд холбогдох мэдээлэл цуглуулж, хянан шинжлэх,
- г) нийт эдийн засаг ба тодорхой ерөнхий байдал, өнгөрсөн үйлдвэрлэл, хэрэглээний бүртгэл, баримтыг судлан тухайн бараа, үйлчилгээний ирээдүйн эрэлт, нийлүүлэлтийг тооцоолох, таамаглах,
- д) орлого, зарлага, хүү, валютын ханшны мэдээлэлд шинжилгээ хийж, ирээдүйн төлөв байдлыг таамаглах,
- е) ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт, цалин, ажилгүйдэл болон хөдөлмөрийн зах зээлийн бусад үзүүлэлтийг тодорхойлох, хүчин зүйлсийг судлах,
- ж) эдийн засгийн онолыг турших, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ статистикийн арга хэрэгсэл математик загвар томъёолол ашиглах,
- з) эдийн засгийн онол, статистик зэрэг арга хэрэгслийг ашиглан эдийн засгийн тоо баримтыг нэгтгэх, шинжилгээ хийх, тайлбарлах,
- и) улс орны эдийн засаг, санхүүтэй холбоотой улс төрийн шийдвэр гаргахад түүний үр дүнг үнэлэх, өнгөрсөн, одоо, ирээдүйд гарч болох эдийн засгийн хүчин зүйлс, чиг хандлагад шинжилгээ хийж зөвлөгөө өгөх,
- к) эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих, боловсруулах,
- л) компанийн эдийн засгийн үйл ажиллагаа, тулгарч буй асуудалд дүн шинжилгээ хийх,

м) үнэ тогтоох, борлуулалтын хэмжээг тооцоолох болон зах зээлд нэвтрэх, ирээдүйн чиг хандлагыг тогтоох, бизнесийн стратеги тодорхойлох зорилгоор орон нутаг, бүс нутаг, улс орны хэмжээнд зах зээлийн судалгаа хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эконометрикч
- Эдийн засгийн зөвлөх
- Эдийн засгийн шинжээч
- Эдийн засагч
- Хөдөлмөрийн эдийн засагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2120      Статистикч

**2632 СОЦИОЛОГИЧ, АНТРОПОЛОГИЧ, ХОЛБОГДОХ БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Социологич, антропологич, холбогдох бусад мэргэжилтэн нь нийгмийн бүтэц, гарал үүсэл, хөгжил, байгаль орчин ба хүний үйл ажиллагааны хамаарлыг тогтоох, судлах үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн эдийн засаг, нийгэм, улс төрийн бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, практик хэрэглээнд зөвлөгөө өгнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нийгмийн бүтэц, гарал үүсэл, хөгжил, байгаль орчин ба хүний үйл ажиллагааны хамаарлыг судлах,
- б) нийгэм, соёлын байгууламж, түүний өөрчлөлтийг судлан хүн төрөлхтний гарал үүсэл хөгжлийг судлах,
- в) хот, суурин газар, сүм хийд, багаж зэвсэг, сав суулга, мөнгөн зоос, байлдааны зэвсэг, уран баримал гэх зэрэг өнгөрсөн үеийн түүхэн баримтыг ашиглан хүн төрөлхтний хөгжлийг судлах,
- г) тухайн газар орны байгаль орчин, физик шинж чанарыг судлах, улмаар судалгааны үр дүнг эдийн засаг, нийгэм, соёлын үйл ажиллагаатай уялдуулах,
- д) нийгмийн үзэгдлийг тодорхойлж, тайлбарлах онол, загвар, аргачлалыг боловсруулах,
- е) нийгмийн бодлогын асуудлаархи улс төрийн шийдвэрийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийх,
- ж) нийгмийн тоо баримтыг үнэлэх, дүн шинжилгээ хийх,
- з) нийгмийн бүлэг, бүс нутаг, юмуу зах зээлийн хөгжлийн асуудлаар эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход судалгааныхаа үр дүн, баримтыг ашиглах, зөвлөгөө өгөх,

и) эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих, боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Антропологич
- Археологич
- Угсаатны зүйч
- Газар зүйч
- Социологич

### **2633 ФИЛОСОФИЧ, ТҮҮХЧ, УЛС ТӨР СУДЛААЧ**

Философич, түүхч, улс төр судлаач нь хүн төрөлхтний оршин тогтнол, туршлага, хүн төрөлхтний түүхийн тодорхой үе шат, тодорхой асуудал, улс төрийн бүтэц, өөрчлөлт, үйл хөдлөлийн талаар судалгаа хийнэ. Тэд улс төр, хувийн үйл ажиллагаанд мэдээлэл лавлагаа болгох зорилгоор судалгааныхаа үр дүнг баримтжуулж тайлагнана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) газар дэлхий, хүн төрөлхтөн, түүний оршин тогтнол, үйл ажиллагаа, өнгөрсөн туршлага сэлт, түүнийг хөдөлгөж байгаа үндсэн шалтгаан, зарчим, утга учрыг судлах, ялангуяа шалтгааныг нь олох, философийн баримтлал, онолыг тайлбарлах, шинээр дэвшүүлэх,
- б) өнгөрсөн явдлын оригиналь буюу орчин цагийн тэмдэглэл зэрэг анхдагч эх үүсвэр архивын, антропологийн олдвор, баримт сэлт хоёрдогч эх үүсвэрийг харцуулж зөвлөлдөх,
- в) холбогдох материалыг цуглуулах, түүний бодит эсэхийг шалгах, түүхийн тодорхой цаг хугацаа, орон улс, бүс нутаг, юмуу эдийн засаг, нийгэм, улс төр зэрэг түүхийн тодорхой нэг талыг нарийвчлан судлах,
- г) улс төрийн систем, байгууламж, үйл ажиллагааны талаарх өмнө ба одоогийн онол практик, улс төрийн философийн талаар судалгаа явуулах,
- д) орчин үеийн улс төрийн байгууламж, үзэл бодлыг судлах, холбогдох мэдээллийг засгийн газар, улс төрийн намын ажилтан, бусад холбогдох хүмүүстэй ярилцлага хийх зэрэг төрөл бүрийн эх үүсвэрээс цуглуулах,
- е) хүн төрөлхтний туршлага, улс төр, түүхэн үйл явдал, зан төлөвийн уг чанарыг тодорхойлох, тайлбарлахад хэрэглэх онол, загвар, арга зүйг боловсруулах,
- ж) засгийн газар, улс төрийн нам, бусад байгууллага, сонирхсон хүмүүст зориулж өөрийн судалгааны үр дүн, дүгнэлтийг тайлагнах, хэвлүүлэх,
- з) эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих, боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Удам зүйч
- Түүхч
- Философич
- Улс төр судлаач

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2422 Улс төрийн зөвлөх

**2634 СЭТГЭЛ ЗҮЙЧ**

Сэтгэл зүйч нь хувь болон бүлэг хүмүүсийн үйл хөдлөл, сэтгэхүйн талаар судалгаа хийж, судалгааныхаа үр дүнг хувь хүний зан төлөв, нийгэм, боловсрол, ажил мэргэжлийн хөгжил, ахиц дэвшилд хэрэглэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бие, сэтгэц болон ухаан бодол, чадвар, авъяас билэг, чадавхи зэрэг шинж тэмдгүүдийг хэмжих сорилт хийх, үр дүнг нь үнэлэх, тайлбарлах, холбогдох зөвлөгөө өгөх,
- б) хувь хүний үзэл бодол, үйл хөдлөлд нөлөөлөх удамшлын болон нийгэм, ажил мэргэжил, бусад хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх,
- в) хувь хүн, бүлэг хүмүүст зөвлөгөө өгөх, эмчилгээний зорилгоор ярилцлага хийх, холбогдох бусад үйлчилгээг үзүүлэх,
- г) гэр бүлийн гишүүд, сургуулийн захиргаа, ажил олгогч зэрэг хүмүүстэй харилцаа тогтоох, эмчилгээний болон шийдвэрлэх бусад арга замын талаар зөвлөгөө өгөх,
- д) сэтгэцийн өвчин, сэтгэл хөдлөл, хувь хүний онцлогоос үүдэлтэй сэтгэцийн доголдол зэргийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгэцэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, мэргэжлийн бусад хүмүүстэй санал бодлоо хуваалцана,
- е) эрдэм шинжилгээний тайлан, илтгэл бичих, боловсруулах,
- ж) багш нарт сургалтын агуулга, заах арга барилаа тодорхойлоход нь зориулж судалгааныхаа ажлын үр дүн, дүн шинжилгээг бэлтгэх,
- з) ажлын байрны дизайн, хамт олон, зан төлөв, урамшуулал, хяналт, удирдлагын талаар судалгаа, шинжилгээ явуулах,
- и) хүний үйл хөдлөлийг тодорхойлох, тайлбарлах онол, загвар, арга зүйг боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмнэлгийн сэтгэл зүйч
- Боловсролын сэтгэл зүйч
- Байгууллагын сэтгэл зүйч

- Сэтгэцийн эмч
- Спортын сэтгэл зүйч
- Хүүхдийн сэтгэл зүйч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2212 Сэтгэцийн эмч

**2635 НИЙГМИЙН МЭРГЭШСЭН АЖИЛТАН, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨГЧ  
МЭРГЭЖИЛТЭН**

Нийгмийн мэргэшсэн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн нь холбогдох хууль тогтоомжийн дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг мэргэшлийн үндсэн дээр зохион байгуулж, гүйцэтгэнэ.

Гэр бүл, нийгмийн бүлэг, иргэн амьжиргааны чадавхыг дээшлүүлэхэд нь тохиолдож буй бэрхшээлийг даван туулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

Үйлчлүүлэгчиддээ ажилгүйдэл, ядуурал, хөгжлийн бэрхшээл, донтолт, эрүүгийн хэрэг, гэр бүлийн болон бусад бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд нь сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, санхүүгийн эх үүсвэртэй холбож өгөх, бие эрхтний болон оюуны чадавхыг хөгжүүлэхэд нь туслалцаа үзүүлнэ.

Нийгмийн хамгааллын туслах ажилтны ажлыг мэргэжил арга зүйн удирдамжаар хангаж, хянан.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хувь хүн, гэр бүл, хамт олонтой ярилцлага хийж, тэдний нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, улмаар ямар төрлийн үйлчилгээ шаардлагатай болохыг өрх, иргэнээр тогтоох,
- б) үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг судалж үзэх, улмаар асуудлыг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох, шийдвэрлүүлэх,
- в) шүүх, хууль журмын дагуу хэргийн бүртгэл тайланг бэлтгэх, нэгтгэх,
- г) зөвлөгөө өгөх, эмчилгээ хийх, зуучлах үйлчилгээ үзүүлэх, нийгэм хувь хүний бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай чадвар, сэтгэлийн тэнхээ олоход нь туслах зорилгоор бүлгээр ярилцлага зохион байгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- д) үйлчлүүлэгчдээ зориулж хямралаас гарахад нь туслах, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, санхүү, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, орон байр, эмнэлгийн зэрэг үйлчилгээг санал болгож буй бусад байгууллагуудтай холбож өгөх,
- е) хүүхэд болон бусад эрсдэлт бүлгийн хүмүүсийг хүчирхийлэл, хараа хяналтгүй байдлаас сэргийлэх, тэднийг хамгаалах арга хэмжээ авах,

- ж) ялантай ял эдэлж байгаа хугацаанд болон дууссаны дараа хамтран ажиллах, нийгэмшихэд нь туслах, дахин хэрэгт холбогдохгүй байлгахын тулд зан чанарыг нь өөрчлөхөд туслах,
- з) шоронгийн удирдлага, тэнсэн, магадлан итгэмжлэлийн хурлын гишүүдэд ямар нөхцөлд яллагдагчийг хорих, суллах, эсвэл хүмүүжлийн өөр арга хэлбэрийг сонгож болох талаар зөвлөгөө өгөх,
- и) нийгмийн бүлгүүдэд зөвлөгөө өгөх, тэднийг төлөөлөн тэдэнд нөлөөлж болохуйц асуудлаар лобби хийх, сургалт зохион байгуулах,
- к) олон нийтийн хэрэгцээнд зориулан урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хөтөлбөрүүдийг боловсруулах,
- л) үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, ахиц дэвшлээр мэдээлэл авах, мэдээлэл өгөх, нийгмийн үйлчилгээ үзүүлэгч болон боловсрол, эрүүл мэнд, бусад төрийн ба төрийн бус байгууллагатай харилцаа холбоотой, хамтран ажиллах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Донтох өвчин судлаач, мэргэшсэн зөвлөх
- Буяны /гашуудлын/ зөвлөх
- Хүүхэд, залуучуудын зөвлөх
- Гэр бүлийн зөвлөх
- Гэрлэлтийн зөвлөх
- Магадлангийн ажилтан
- Тэнсэн харгалзагч
- Нийгмийн мэргэшсэн ажилтан
- Эмэгтэйчүүдийн ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3412 Нийгмийн хамгааллын туслах ажилтан

### **2636 ШАШНЫ МЭРГЭЖИЛТЭН**

Шашны мэргэжилтэн нь ариун уламжлал, туршлага, итгэл үнэмшлийг үргэлжлүүлэн дамжуулна. Тэд шашны зан үйл үйлдэх, итгэл үнэмшлийг тэмдэглэх, сэтгэл санаа, зөн төлөвийг чиглүүлэх, уриалах, шашны зан үйлтэй холбоотой бусад үйлийг хийж гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) ариун уламжлал, туршлага, итгэл үнэмшлийг тасалдуулахгүйгээр үргэлжлүүлэн дамжуулах,
- б) шашны үйл, ёс жаяг сахих, баяр ёслолыг тэмдэглэх,
- в) шашны хурал, мөргөл үйлдэхэд захиргааны болон нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх,

- г) өөрсдийн итгэл үнэмшил бүхий шашны номлол ёс жаягийн дагуу хүмүүсийн сэтгэл санаа, зан төлөвийг чиглүүлэх,
- д) дотоод, гадаадад шашныхаа ёс журмыг сурталчлах,
- е) шашны уншлага, мөргөлд бэлтгэх,
- ж) шашны боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулах, чиглүүлэх,
- з) Хүмүүс хоорондын болон эрүүл мэнд, санхүү, шашны тулгамдсан асуудлаар хувь хүнд зөвлөгөө өгөх,
- и) хурал, семинар зэрэг тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулах, оролцох.

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3413	Мөргөлтөн
3413	Лам, бөө, удган
3413	Гэлэнмаа

**Тайлбар:**

Шашны бүлгийн хүмүүс бусад ажил,мэргэжлийг гүйцэтгэж болно. Тухайлбал, багш, сувилагч, нийгмийн хамгааллын ажилтан. Эдгээр ажил, мэргэжлийн хүмүүсийг тэдний эрхэлж буй голлох ажлаар нь ангилалд хамруулна.

**БАГА БҮЛЭГ 264**

**ЗОХИОЛЧ, СЭТГҮҮЛЧ, ХЭЛ ШИНЖЭЭЧ**

Зохиолч, сэтгүүлч, хэл шинжээч нь утга зохиол бичих, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн үйл явдал, сонин мэдээг тайлбарлах, түгээх, нэг хэлнээс нөгөө хэл рүү аман болон бичгийн орчуулга хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Утга зохиол бичих, урлаг утга зохиол, болон бусад бүтээлд шүүмж бичих, одоогийн нөхцөл байдлаар мэдээ цуглуулах, тэр сэдвээрээ уран бүтээл туурвих, сонин, телевиз, радио, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтийн үйл явдал, мэдээ мэдээллийг хайх, олох, тайлбарлах, түгээх, нэг хэлнээс нөгөө хэл рүү материал орчуулах, нэг хэлнээс нөгөө хэл рүү шууд хэлмэрчлэх.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2641 Зохиолч, холбогдох бусад нийтлэлч**

**2642 Сэтгүүлч**

**2643 Орчуулагч, хэлмэрч, хэл шинжээч**

## 2641 ЗОХИОЛЧ, ХОЛБОГДОХ БУСАД НИЙТЛЭЛЧ

Зохиолч, холбогдох бусад нийтлэлч нь ном, жүжиг, өгүүлэл, эссэ, хэлэх үг, гарын авлага болон тусгай сэдвээр сэтгүүл зүйн бус өгүүлэл төлөвлөх, судалгаа хийх, бичиж хэвлэн нийтлүүлнэ. (Үүнд сонин, сэтгүүл, бусад тогтмол хэвлэлийн материал хамаарахгүй.)

### Гүйцэтгэх үүрэг:

- а) үргэлжилсэн үгийн зохиол, кино, жүжиг, зохиомж яруу найраг зэрэг материалыг хэвлэн нийтлэх зорилгоор сэдэх, бичих, засварлах,
- б) баримтат материал бэлтгэх, шаардлагатай мэдээлэл олох, судалгаа хийх,
- в) тайз, кино, радио, телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бичих, зохиол бүтээх, завсарлагагүй үргэлжлүүлэх,
- г) гарын авлага тэмдэглэл, заавар зэргийг хянах, программ хангамж, цахилгаан болон механик хэрэгсэл, бусад төхөөрөмжийг суурилуулах, ашиглах, үйлчилгээ үзүүлэх талаар гарын авлага, хэрэглэгчийн заавар сэлт бичих,
- д) гарын авлага, товхимол, техникийн зориулалттай бусад материалыг бичиж боловсруулах,
- е) хэвлэлийн материалыг сонгох, загвар, үг үсгийн болон агуулгын алдааг шалгах, хэвлэлтэд өгөхөөс өмнөх хянах, засварлах ажлыг гүйцэтгэх.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Зохиолч
- Номын редактор
- Өгүүлэгч
- Интерактив зохиолч
- Үргэлжилсэн үгийн зохиолч
- Жүжгийн зохиолч
- Яруу найрагч
- Кино зохиолч
- Үг, илтгэл бичигч
- Зохиогч техникч
- Зохиолч, бичигч

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

2431	Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн
2432	Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн
2642	Сэтгүүлч
2642	Сонины редактор



## 2642 СЭТГҮҮЛЧ

Сэтгүүлч нь сонин, телевиз, радио, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр мэдээ, нийтийн үйл явдлыг судлах, эрэн сурвалжлах, тайлбарлах, нэвтрүүлэх хэвлүүлэх үүрэгтэй.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) ярилцлага хийх, эрэн сурвалжлах, ажиглах зэргээр орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд мэдээлэл цуглуулах, олон нийтийн арга хэмжээнд оролцох, бүртгэл, тэмдэглэл, бичгийн зүйлс хайж олох, судлах, кино болон тайзны урлагийг үзэж сонирхох,
- б) сонин, сэтгүүл дээр гарсан материал, радио, телевиз, вэб хуудсаар дамжуулсан мэдээ, үйл явдлыг цуглуулах, нэвтрүүлэх, олны хүртээл болгох, тайлбар хийх,
- в) мэдээ хүлээж авах, дүн шинжилгээ хийх, түүний үнэн зөв байдлыг магадлах,
- г) улс төрчид болон олны танил хүмүүсийг хэвлэлийн бага хуралд урих, радио, телевиз, вэбсайтаар дамжуулан ганцаарчилсан ярилцлага хийх,
- д) эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологи зэрэг тусгай салбаруудын хөгжлийн талаар судалгаа хийж, мэдээ бэлтгэх,
- е) олон нийтийн анхаарлыг татахуйц, болон анхаарлын төвд байгаа асуудлаар тайлбар хийх, нэвтрүүлэг хийх, өөрийн болон олон нийтийн байр суурийг илэрхийлэх,
- ж) өөрийн мэдлэг, мэдрэмж, сонин сэтгүүл, телевиз, радио, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн туршлага дээр үндэслэн уран зохиол, хөгжим, бусад урлагийн бүтээлд шүүмж бичих,
- з) хэвлэх материалыг сонгох, загвар, зөв бичгийн дүрэм, агуулгын хувьд үнэн зөв, хуулийн дагуу бичигдсэн эсэхийг шалгах, шаардлагатай засвар хийх,
- и) хэвлэлтэд өгөхийн өмнөх хувилбарыг дахин шалгуулах,
- к) сонин сэтгүүл, телевиз, радио болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр бизнес, байгууллагуудын тухай хэвлэх материалыг сонгох, дараалуулах, хэвлэлтэнд бэлтгэх.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Сэтгүүлч
- Хэвлэлийн редакторч
- Сонины редакторч
- Мэдээний сэтгүүлч
- Спортын сэтгүүлч
- Орлогч редакторч
- ТВ, радиогийн мэдээний сэтгүүлч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2432	Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн
2641	Ном зохиогч, зохиолч
2641	Номны редакторч
3431	Фото сурвалжлагч
3521	Камерын зураглаач

**2643 ОРЧУУЛАГЧ, ХЭЛМЭРЧ, ХЭЛ ШИНЖЭЭЧ**

Орчуулагч, хэлмэрч, хэл шинжээч нь нэг хэлнээс нөгөө хэл рүү аман болон бичгийн орчуулга хийх, хэлний гарал үүсэл, хөгжил, бүтэц зэргийг судална.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эртний болон орчин цагийн хэлний бүлгүүдийн хамаарлыг судалж, үг, хэл зүй, хэлний хэлбэрийг мөшгин, үр дүнг тайлагнах,
- б) хэлний ангиллын систем, хэлний зүй, толь бичиг, бусад ижил төрлийн материалыг бэлтгэж боловсруулах, зөвлөгөө өгөх,
- в) нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулах, хууль эрх зүй, техник, шинжлэх ухааны материалыг уг эхийн утга санаа, донж маяг алдагдуулахгүйгээр орчуулах, нэр томъёо, хэвшмэл хэллэг, уран зохиолын хэллэгийг аль болох ойр дамжуулах,
- г) орчуулгын чанар, бүтээмжийг сайжруулахын тулд компьютер, бусад төхөөрөмж ашиглан холбогдох программ аргачлал зохиох,
- д) ярианы болон дохионы хэлийг өөр ижил төрлийн хэл рүү орчуулах, ялангуяа хурал цуглаан, уулзалт, адилтгах арга хэмжээний үед гол санааг алдагдуулалгүйгээр аль болох ойртуулан орчуулж дамжуулах,
- е) орчуулсан материалыг хянах, засварлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Судлаач, толь зүйч
- Хэл шинжээч
- Дохионы хэлний орчуулагч
- Тайлбар бичиг орчуулагч
- Аман орчуулагч
- Үгсийн санч
- Бичгийн орчуулагч
- Орчуулагч-хянагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2641	Ном зохиогч, зохиолч
------	----------------------

2641	Номны редактор
2642	Сурвалжлагч

## **БАГА БҮЛЭГ 265**

### **УРАН БҮТЭЭЛЧ, ЖҮЖИГЧИН**

---

Уран бүтээлч, жүжигчин нь тодорхой бүтээлийг бий болгохын тулд өөрсдийн уран санааг сэтгэгдэл, бичиг баримтаар дэлгэрүүлэх, найрал дуу дуулах, жүжгийн зохиол тоглох, юмуу чиглүүлэх зэргээр зохиол бүтээлийг дэлгэн тайлах, тоглолт хийх, зэрэг ижил төрлийн арга хэмжээг зохион байгуулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Уран зураг дүрслэх урлагийн зүйл сэдэх, бүтээх, хөгжим зохиох, хөгжим, бүжиг, театрчилсэн тоглолт хийх, кино зураг авах, чиглүүлэх, давтан сургуулилах, тоглох, телевизийн хөтөлбөр, кино, тайзны бүтээл санаачлах, санхүүгийн болон зохион байгуулалтын үүрэг, хариуцлага биелүүлэх, жүжгийн зохиол, ном судлах, тайлбарлахад бэлтгэх, давтан сургуулилах, хөгжим, видео бичлэг, бусад хөгжөөнт нэвтрүүлэг материалыг сонгох, танилцуулах, арилжааны зорилгоор болон төрийн үйл ажиллагааны хүрээнд зар сурталчилгаа явуулах.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**2651 Дүрслэх урлаач**

**2652 Хөгжимчин, дуучин, хөгжмийн зохиолч**

**2653 Бүжигчин болон бүжиг дэглээч**

**2654 Кино, тайз болон түүнд холбогдох найруулагч**

**2655 Жүжигчин**

**2656 Радио, телевиз, бусад мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлэгч**

**2659 Аль нэг ангилалд ороогүй бусад уран бүтээлч, жүжигчин**

#### **2651 ДҮРСЛЭХ УРЛААЧ**

Дүрслэх урлаач нь бүтээлийнхээ санааг өөрсдөө гаргаж бүтээлээ хийдэг барималч, зураач, хошин зураач, сийлбэрчид бөгөөд тодорхой техник, арга барилыг ашигладаг бусад хүмүүс орно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зураг, баримал хийх санаа олох, хөгжүүлэх, загвар гаргах,
- б) сонгосон сэдвийнхээ дагуу биетийг бэлтгэх, загварыг нь байрлуулах, газар сонгох,
- в) бүтээл урлах арга хэлбэр, хэрэгсэл, материалаа сонгох,
- г) мод, чулуу, шавар, төмөр, мөс, цаас зэргийг хэлбэрт оруулах, сийлэх, нийлүүлэх зэргээр хавтгай болон гурван хэмжээст огторгуйд хийсвэр ба бодит дүрслэлийн бүтээл урлах,
- д) харандаа, бэх, шохой, тосон будаг, усан будаг болон бусад техникийг ашиглан хийсвэр ба бодит дүрслэлийн уран зураг, зураг бүтээх,
- е) төмөр, мод, бусад материал дээр зураг зурах, сийлэх,
- ж) хүмүүс, үйл явдлыг дүрсэлсэн хошин зураг зурах,
- з) эвдэрсэн, муудсан юмуу цайрч өнгө алдсан зураг бусад төрлийн урлалыг сэргээх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хошин зураач
- Шавар барималч
- Хөлсний зураач
- Зураг сэргээгч
- Хөрөг зураач
- Барималчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

731	Гар урлалын ажилтан
2163	Бүтээгдэхүүн, хувцасны дизайнч
2166	График, мультимедиа зохиомжийн дизайнч
2355	Зургийн багш (хувиар заадаг)

**2652 ХӨГЖИМЧИН, ДУУЧИН, ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ**

Хөгжимчин, дуучин, хөгжмийн зохиолч нь ая зохиох, хөгжмийн найруулга хийх, бүтээл тоглож амилуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) уран сэтгэмж, сэтгэлийн хөдөлгөөнөө хөгжмийн хэлбэрээр илэрхийлэхийн тулд ая, яруу хөг, хэмнэлийг зохиох,
- б) өөрийн уран санаа, сэтгэлийн хөдөлгөөнийг урлагийн бүтээл болгохын тулд хөгжмийн стандарт тэмдэгээр тэмдэглэх,
- в) найрал хөгжим, найрал дуунд, юмуу хөгжмийн зэмсэг, хоолойн өнгөнд зориулж зохицуулах, хөгжмийн найруулга хийх,
- г) найрал хөгжим, найрал дууг удирдах,

- д) тоглох хөгжмийг сонгох, хөгжимчдэд хаана хэрхэн оролцох, тоглох тухай заавар өгөх,
- е) нэг, юмуу хэд хэдэн хөгжим гоцолж тоглох, эсвэл хөгжмийн хамтлаг, оркестр тоглох,
- ж) найрал хөгжим болон бусад хөгжмийн хамтлагт дуулах юмуу гоцлох,
- з) өндөр чанартай бүтээл үзүүлэхийн тулд байнга давтах, сургуулилах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хамтлагийн ахлагч
- Хөгжмийн зохиолч
- Хөгжимчин
- Хөгжмийн удирдаач
- Шөнийн баар, цэнгээний газрын хөгжимчин
- Шөнийн баар, цэнгээний газрын дуучин
- Оркестрийн удирдаач
- Дуучин
- Гудамжны хөгжимчин
- Гудамжны дуучин

**2653 БҮЖИГЧИН БОЛОН БҮЖИГ ДЭГЛЭЭЧ**

Бүжигчин болон бүжиг дэглээч нь бүжиг дэглэж, бүжиглэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) түүх, уламжлалт сэдэв, содон санаа, зан байдал зэргийг алхам, хөдөлгөөн, гарын хөдөлгөөнөөр илэрхийлэх бүжиг зохиох, дэглэх,
- б) үзэгчдийн өмнө юмуу кино, телевиз, зэрэг ижил төрлийн хэрэгслийн өмнө гоцолж бүжиглэх, хосолж бүжиглэх, хамтлагаар бүжиглэх,
- в) тодорхой дадал чадвартай байхын тулд бүжгийн хичээлд суралцах, давтах, сургуулилах,
- г) шаардлага хангахуйц арга техник, бүжгийн алхамыг давтах сургуулилтыг удирдах, түүнд оролцох,
- д) бүжгийн дүрийн төлөө юмуу бүжгийн хамтлагт ороход өрсөлдөх,
- е) хөгжмийн удирдаачтай хамтран бүтээлээ ярилцах, зохицуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бүжиг дэглээч
- Бүжигчин
- Баллетын бүжигчин
- Бүжигчин, /шөнийн баар, цэнгээний газрын/

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2355 Бүжгийн багш

**2654 КИНО, ТАЙЗ БОЛОН ТҮҮНД ХОЛБОГДОХ НАЙРУУЛАГЧ**

Кино, тайз болон түүнд холбогдох найруулагч нь кино зураг авалт, телевиз, радио, тайзны уран бүтээл хийх үедээ техникийн болон урлаг, уран сайхны асуудлыг бүрэн хариуцаж ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зохиолч сонгох, зохиолыг уран сайхны аргаар бичсэн эсэхийг тодорхойлох, жүжигчдэд хэрхэн жүжиглэх талаар зөвлөгөө өгөх,
- б) тайзны бүтээл, телевиз, радиогийн нэвтрүүлэг, кино хийхдээ жүжигчнийг сонгох, хувцас чимэглэл, тайз засалт, гэрлийн эффект зэрэг бүхий л асуудлыг удирдах зохицуулах,
- в) хэд хэдэн шатаар тайз засалтыг төлөвлөх, зохион байгуулах, хянах, тайзны бүтээл, телевиз, радиогийн нэвтрүүлэг, кино хийх хугацааны дарааллыг тогтоох,
- г) техникийн ажилтныг удирдаж ажиллах, уран бүтээл хийх төлөвлөгөө, хүрээг тодорхойлох,
- д) уран бүтээлийн архив ажиллуулах, төлбөр тооцоог тохиролцох,
- е) хөтөлбөр бичих, видеогоор бичих, засварлах зорилгоор зохиол бичих, төлөвлөх,
- ж) тайз засалт, дуу, гэрлийн тоног төхөөрөмжийн байрлалыг хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Баримтат киноны найруулагч
- Кино зургийн редактор
- Уран сайхны киноны найруулагч
- Зургийн дарга
- Тайз заслын ажилтан
- Техникийн ажилтан
- Телевиз, радиогийн техникийн асуудал хариуцсан ажилтан
- Театрын продюссер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2642 Телевизийн мэдээний продюссер  
 3521 Дамжуулах техникч  
 3521 Дууны техникч  
 3521 Дүрсний техникч  
 3435 Тайзны менежер

### 2655 ЖҮЖИГЧИН

Жүжигчин нь тайзны бүтээл, телевиз, радиогийн нэвтрүүлэг, кинонд дүр бүтээнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) тайзны бүтээл, зар сурталчилгаа, телевиз, радиогийн нэвтрүүлэг, кинонд оногдсон дүрийн үгийг цээжилж дүрд оролцон тоглох,
- б) зохиолч, жүжгийн зохиолчийн бий болгосон дүрд хувилан, үзэгчдэд хүргэх,
- в) сонсогчийг гэгээрүүлэх, хөгжөөх зорилгоор уран зохиол бүтээлийг аялгуулан унших, юмуу үлгэр зохиол дуудах,
- г) дүрийн шалгаруулалтанд оролцох,
- д) найруулагчийн заавар, удирдамжийн дагуу дүрийн сургуулилалт хийн тоглолтонд бэлтгэх,
- е) зохиолоо уншиж, тоглох гэж байгаа дүр, сэдвийн талаар судалгаа хийх,
- ж) сургуулилалтын дагуу тайзны бүтээл, телевиз, радиогийн нэвтрүүлэг, кинонд тоглох, дүр бүтээх.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Жүжигчин
- Дуугүй жүжигчин
- Үлгэрч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                   |
|------|-------------------|
| 3435 | Орлон тоглогч     |
| 3435 | Жижиг дүр бүтээгч |

### 2656 РАДИО, ТЕЛЕВИЗ, БУСАД МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛЭЭР НЭВТРҮҮЛЭГЧ

Радио, телевиз, бусад мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлэгч нь телевиз, радио, театр, бусад мэдээллийн хэрэгслээр мэдээ унших, ярилцлага хийх, бусад зар мэдээ уншина.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) радио, телевизээр мэдээ, зарлал унших,
- б) ярилцлаганд оролцож байгаа хүнийг танилцуулах, радио телевизээр юмуу, театр, шөнийн клуб, бусад газар холбогдох зарлал, мэдээллийг унших,
- в) радио телевизээр энгийн хүмүүстэй ярилцлага хийх,

- г) хөтөлбөр, ярилцлагад бэлдэхийн тулд суурь мэдээллийг олж мэдэх, судлах,  
д) цаг агаар, авто замын хөдөлгөөн зэрэг асуудлаар мэдээ өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Радиогийн нэвтрүүлэгч
- Телевизийн нэвтрүүлэгч
- Мэдээ нэвтрүүлэгч
- Спортын нэвтрүүлэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2642 Сэтгүүлч

**2659 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД УРАН БҮТЭЭЛЧ, ЖҮЖИГЧИН**

Энэ нэгж бүлэгт 265 дугаар бага бүлэгт ороогүй уран бүтээлч, жүжигчид багтана. Тухайлбал алиалагч, илбэчин, акробатчин орох жишээтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хошин явдал, зохиол ярих, алиалах,  
б) гарын хөдөлгөөн, харааны хурд ашиглан илбэ үзүүлэх, ховсдох,  
в) хүнд хэцүү, гайхамшигт акробат үзүүлэх, гимнастик юмуу жонглёр хийх,  
г) амьтан сургах, үзүүлбэр үзүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Акробатч
- Агаарын гимнастикч
- Алиалагч
- Илбэчин
- Хүүхэлдэйн театрын жүжигчин
- Хошин шогийн жүжигчин



## ҮНДСЭН БҮЛЭГ 3 ТЕХНИКЧ БОЛОН ТУСЛАХ /ДЭД МЭРГЭЖИЛТЭН

---

Техникч болон туслах/дэд мэргэжилтэн нь гол төлөв судалгаа шинжилгээ, болон хавсрага ухаан, урлаг, үйл ажиллагааны баримтлал, арга техник ашиглах, төр, бизнесийн дүрэм журамтай холбоотой техникийн шинжтэй ажил хийж гүйцэтгэнэ. Энэхүү бүлэгт багтах ажил, мэргэжил нь Олон улсын ажил, мэргэжилийн стандарт (ISCO)-ын мэргэшлийн ур чадварын 3 дугаар түвшинд хамаарна.

### Гүйцэтгэх үүрэг:

Инженер технологи зэрэг биет бодисын ухаан, эрүүл мэнд, нийгэм, хүмүүнлэгийн зэрэг амьд байгалийн ухааны салбарт онол, үзэл баримтлал, агуулагыг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийхтэй холбоотой техник ажил хийж гүйцэтгэх, худалдаа, санхүү, нийгмийн ажил болон төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зэрэг захиргааны ажилтай холбоотой төрөл бүрийн техникийн үйлчилгээ, ажил гүйцэтгэх, урлаг уран сайхан, зугаа цэнгүүнтэй холбоотой ажил гүйцэтгэх, спортын арга хэмжээнд хамрагдах, шашны зарим нэг үйл хийх зэрэг багтана.

Энэ бүлэгт багтах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 31 Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн
- 32 Эрүүл мэндийн туслах/дэд мэргэжилтэн
- 33 Бизнесийн болон удирдлагын туслах/дэд мэргэжилтэн
- 34 Хууль, нийгэм, соёл, тэдгээрт холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
- 35 Мэдээлэл холбооны техникч

### **ДЭД БҮЛЭГ 31**

## **ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРИЙН ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН**

---

Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн нь шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ. Тэд уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн арга ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулна (нисэх онгоц, усан онгоц бас орно).

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Багаж, тоног төхөөрөмжийг тохируулах, ажиллуулах, хянах, системийг турших, туршилтыг хянах, дээж цуглуулах, шалгах, ажиглалтыг тэмдэглэх, мэдээ баримтанд дүн шинжилгээ хийх, техникийн зураг, диаграмм, бүтээл бэлтгэх, хянах, тайлбарлах, бусад ажилтны ажлыг уялдуулах, хянах, зохион байгуулах, удирдлагын самбар, компьютер хяналтын систем, олон функц бүхий хяналтын төхөөрөмж ажиллуулах, хянах, усан онгоц, нисэх онгоц болон бусад төхөөрөмжийг ажиллуулахад аюулгүй, үр ашигтай байхаар техникийн зохицуулалт хийх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 311 Физик, инженерийн ухааны техникч**
- 312 Уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч**
- 313 Технологи процесс, чанар шалгагч**
- 314 Амьд ертөнц судлах ухааны техникч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн**
- 315 Усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч**

### **БАГА БҮЛЭГ 311**

## **ФИЗИК /БИЕТ БОДИС/, ИНЖЕНЕРИЙН УХААНЫ ТЕХНИКЧ**

---

Биет бодисын, инженерийн ухааны техникч нь инженер, техникийн зураг боловсруулах, үйлдвэрлэлийн процессийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн физик химийн ухааны онол, зарчим, үйл ажиллагааны арга барилыг хэрэгжүүлэх, судалгаа явуулахад техникийн туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хими, физик, геологи, цаг уур, одон орон, инженерийн ухаан болон техникийн зураг зурахтай холбоотой техник ажил хийж гүйцэтгэх, лабораторийн төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэх, ажиллуулах, туршилтыг хянах, ажиглалт хийх, үр дүнг тэмдэглэх, тооцоолох, материалыг туршилтанд бэлтгэх, системийг турших, дээж цуглуулах, шалгах, ажиглалтыг тэмдэглэх, тоо баримтад дүн шинжилгээ хийх, техникийн зураг зурах, хянах, тайлбарлах, диаграмм, цахилгаан холболт, байршлын ерөнхий зураг зурах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3111 Химийн болон физикийн ухааны техникч**

**3112 Иргэний барилгын инженерийн техникч**

**3113 Цахилгаан инженерийн техникч**

**3114 Цахим инженерийн техникч**

**3115 Механик инженерийн техникч**

**3116 Химийн инженерийн техникч**

**3117 Уурхай, металлургийн техникч**

**3118 Шугам зурагч**

**3119 Энэ ангилалд ороогүй биет бодисын болон инженерийн ухааны бусад техникч**

**3111 ХИМИ БОЛОН ФИЗИКИЙН УХААНЫ ТЕХНИКЧ**

Хими, физикийн ухааны техникч нь хими, физик, геологи, геофизик, цаг уур, одон орны чиглэлээр хийх судалгааны ажилд туслах, улмаар судалгааны ажлын үр дүнг аж үйлдвэр, эрүүл мэнд, зэвсэгт хүчин болон бусад салбарт туршиж, нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) дээж цуглуулах, материал, тоног төхөөрөмжийг турших, шинжилгээнд бэлтгэх,
- б) лабораторийн сорилт байнга хийх, химич, физикч нарын судалгаа шинжилгээ, туршилт, дүн шинжилгээ хийх ажилд техникийн туслалцаа үзүүлэх,
- в) хэрэглэсэн материал, дээжийн тооцоог тогтмол хийх зэргээр лабораторт шаардлагатай байгаа материалын чанар, тоо хэмжээг

- хянах, өгөгдсөн норм нормативын дагуу хүн хүч, материалын тоо хэмжээ, зардлын тооцоог гаргах,
- г) лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэх, ажиллуулах, үйлчилгээ хийх, туршилтыг хянах, ажиглалт хийх, үр дүнг тэмдэглэх, тооцоолох,
- д) Туршилтанд хэрэглэх материалыг хөлдөөх, зүсэх, бусад химийн бодистой холих зэрэг бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх,
- е) геологич, геофизикч нарын тусламжтайгаар хөрс, уснаас дээж авах, ажиглалт туршилт хийх, дүгнэлт гаргах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Химийн техникч
- Геологийн техникч
- Цаг уурын техникч
- Физикийн техникч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                           |
|------|---------------------------|
| 3116 | Химийн инженерийн техникч |
| 3141 | Хүмүүнлэгийн техникч      |

### **3112 ИРГЭНИЙ БАРИЛГЫН ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Иргэний барилгын инженерийн техникч нь барилга байгууламж, усан хангамж, ариутгах татуургын шугам, зам, гүүр, далан, нисэх буудлын барилга, байгууламжийн төслийн эрэл хайгуул, зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, арчлалт ба засварын ажлын техникийн асуудлыг шийдэхэд туслах ажлыг гүйцэтгэнэ. Гал түймэрийн аюулаас урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, журам, стандарт бусад техникийн нормативын биелэлтийг хангуулах ажлыг бас эрхэлнэ. /Энд гал түймэрийн улсын хяналтын байцаагч хамаарна/

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилгын материал, хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээ-туршилтыг гүйцэтгэхэд туслах,
- б) барилга, бусад инженерийн байгууламжийг барьж байгуулахтай холбоотой техникийн асуудал, талбайн зурагзүйн судалгааг явуулах, тайланг бэлтгэхэд туслах,
- в) зураг төслийн стандарт шаардлага, холбогдох хууль тогтоомжийг биелүүлэх, барилгын ажил, барилгын материалын стандартыг мөрдөн ажиллах явдлыг хангах,
- г) тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд барилгын онол, практикийн арга зарчмууд, техникийн мэдлэгийг хэрэглэх,

- д) зураг төслийн дагуу барилгын ажилд шаардлагатай ажиллах хүчний болон материалын тоо хэмжээ, өртгийг нарийвчлан тооцож үнэлгээг бэлтгэхэд туслах,
- е) барилгын урсгал болон их засварын ажлыг зохион байгуулах,
- ж) барилга, газрын бүсчлэл, зэрэглэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж болон стандарт, ажлын зураг, бусад төлөвлөгөөний шаардлагыг хангаж буй эсэх, барилгын чанар аюулгүй ажиллагааны бусад хууль тогтоомжийг барилга болон түүний бүтээц хийц хангаж буй эсэхийг барилгын ажлын явцад болон дараа нь хянаж шалгах,
- з) үйлдвэрийн барилга, зочид буудал, кинотеатр болон бусад барилга, байгууламжийг шалгах, галд нэрвэгдсэн шалтгаан нөхцөлийг нь тогтоолгох, үүнийг хэрхэн буулгаж зайлуулах талаар зөвлөх,
- и) барилгын зураг, төсөл боловсруулах шатанд гал мэдрэгч болон усаар цацаж унтраах системийг суурилуулах, барилга дахь галын аюулын зэргийг бууруулах, галд тэсвэртэй материал, хэрэгслийг сонгох талаар болон хэрэв гал гарвал учирч болох аюул, хохирол хир байх тухайд зөвлөгөө өгөх,
- к) гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомж, журам, стандарт бусад техникийн нормативын биелэлтийг хангуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Барилгын байцаагч
- Барилга угсралтын техникч
- Гал түймэрийн улсын хяналтын байцаагч
- Хөрс, суурийн техникч
- Зурагзүйн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2149 Барилга байгууламжийн материалын мэргэжилтэн
- 3115 Ажлын тоо хэмжээ бүртгэгч

**3113 ЦАХИЛГААН ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Цахилгаан инженерийн техникч нь цахилгаан инженерийн чиглэлээр шинжилгээний ажил, цахилгаан төхөөрөмж, цахилгаан байгууламж, түгээлтийн системийг байгуулах, үйлдвэрлэх, угсрах, барих, ажиллуулах, үйлчилгээ хийх, засварлах зэрэг ажилд техникийн туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахилгаан тоног төхөөрөмж, байгууламж бүтээх, судалгаа хийхэд техникийн туслалцаа үзүүлэх, туршилт хийх,

- б) өгөгдсөн норм нормативын дагуу цахилгаан монтаж хийх, суурилуулах зураг төсөл гаргах,
- в) өгөгдсөн норм нормативын дагуу үйлдвэрлэх, суурилуулахад шаардагдах хүн хүч материалын тоо хэмжээ, зардлын тооцоог нарийвчлан гаргах,
- г) өгөгдсөн норм норматив, дүрэм журмын дагуу цахилгаан тоног төхөөрөмж, бусад цахилгаан эд зүйлсийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэх, суурилуулах, ашиглах, хэрэглэх, үйлчилгээ үзүүлэх, засварлахтай холбоотой техникийн асуудалд хяналт тавих,
- д) шинээр авсан цахилгаан төхөөрөмжийг хэрхэн суурилуулах талаар төлөвлөгөө боловсруулах, бүрэн суурилуулсны дараа аюулгүй байдлыг нь шалгах, туршилт болгон тухайн төхөөрөмжийг эхэлж ажилуулах,
- е) цахилгаан тоног төхөөрөмжийг холбогдох дүрэм журам, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн угсрах, суурилуулах, шалгах, тохируулах, өөрчлөх, засварлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цахилгааны техникч
- Цахилгаан эрчим хүч дамжуулах техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3114	Цахим техникч
3131	Цахилгаан станцын операторч
7241	Цахим механикч

**3114 ЦАХИМ ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Цахим инженерийн техникч нь цахим төхөөрөмжийн чиглэлээр судалгаа хийхэд туслах, цахим төхөөрөмжийн загвар гаргах, үйлдвэрлэх, угсрах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахим тоног төхөөрөмж бүтээх, судалгаа явуулахад техникийн туслалцаа үзүүлэх, туршилт хийх,
- б) өгөгдсөн норм нормативын дагуу цахим монтаж хийх, суурилуулах зураг төслийг гаргах,
- в) өгөгдсөн норм нормативын дагуу цахим төхөөрөмж үйлдвэрлэх, суурилуулахад шаардагдах материал, хүн хүчний тоо хэмжээ, зардлын тооцоог нарийвчлан гаргах,
- г) өгөгдсөн норм норматив, дүрэм журмын дагуу цахим төхөөрөмжийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэх, суурилуулах, ашиглах, хэрэглэх,

үйлчилгээ үзүүлэх, засварлахтай холбоотой техникийн асуудалд хяналт тавих,

- д) цахим төхөөрөмжийг зохион бүтээх, суурилуулах, ажиллуулахад оролцох, үйлчилгээ хийх,
- е) шинээр авсан цахим төхөөрөмжийг суурилуулах төлөвлөгөө боловсруулах, бүрэн суурилуулсны дараа аюулгүй байдлыг нь шалгах, туршилт болгон тухайн төхөөрөмжийг эхэлж ажилуулах,
- ж) цахим төхөөрөмжийг шалгах, тоо мэдээг цуглуулах, дүн шинжилгээ хийх, инженерийн тусламжтайгаар угсралт хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цахим инженерийн техникч
- Хэмжүүрийн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3113	Иргэний барилга инженерийн техникч
3522	Телехолбооны инженерийн техникч
7421	Цахим механикч
8212	Цахим төхөөрөмж угсрагч

**3115 МЕХАНИК ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Механик инженерийн техникч нь механик инженерийн чиглэлээр судалгаа хийхэд туслах, механик төхөөрөмж, машин, түүний эд ангийг зохион бүтээх, үйлдвэрлэх, угсрах, барих, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) машин техник, механик тоног төхөөрөмж, байгууламж, эд анги зохион бүтээх, судалгаа хийх чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх,
- б) өгөгдсөн норм нормативын дагуу машин техник, механик тоног төхөөрөмж, байгууламж, эд ангийг зохион бүтээх, зураг төслийг гаргахад туслах,
- в) өгөгдсөн норм нормативын дагуу үйлдвэрлэх, суурилуулахад шаардагдах материал, хүн хүчий тоо хэмжээ, зардлын тооцоог нарийвчлан гаргах,
- г) норм норматив, дүрэм журмын дагуу машин техник, механик тоног төхөөрөмж, байгууламж, эд ангийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэх, суурилуулах, ашиглах, хэрэглэх, үйлчилгээ үзүүлэх, засварлахтай холбоотой техникийн асуудалд хяналт тавих,
- д) онгоцны их бие, тоног төхөөрөмж, ачаа тээвэртэй холбоотой тайлан тээврийн аюулгүй ажиллагааны стандарт, журмыг боловсруулах,

- хэрэгжилтийг хянах,
- е) шинэ болон өөрчилсөн механик төхөөрөмж, эд анги, машин техникийн эд анги, хяналтын төхөөрөмж, усаар эрчим хүч гаргах системийг угсрах, суурилуулах,
- ж) механик төхөөрөмжид туршилт хийх, тоо мэдээг цуглуулах, дүн шинжилгээ хийх, инженерийн тусламжтайгаар механик төхөөрөмжийг угсрах, суурилуулах,
- з) инженерийн зохион бүтээсэн, хийсэн ажил нь холбогдох норм норматив, дүрэм журам, гэрээний нөхцөлийг хангаж байгаа эсэхийг шалгах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нисэх онгоцны инженерийн техникч
- Усан онгоцны инженерийн техникч
- Механик инженерийн техникч
- Механик инженерийн тооцоологч
- Ажлын тоо хэмжээ бүртгэгч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                        |
|------|------------------------|
| 7233 | Аж үйлдвэрийн механикч |
| 8211 | Машин механизм угсрагч |

### **3116 ХИМИЙН ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Химийн инженерийн техникч нь химийн инженерийн чиглэлээр судалгаа хийх болон химийн үйлдвэр байгуулах, зураг төсөл гаргах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд нь туслалцаа үзүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) химийн үйлдвэрийн процесс суурь төхөөрөг угсрах, тоног төхөөрөмж зохион бүтээх, судалгааны ажил явуулахад туслалцаа үзүүлэх, туршилт хийх,
- б) өгөгдсөн норм нормативын дагуу химийн суурь төхөөрөг зохион бүтээх, зураг төсөл гаргахад туслах,
- в) өгөгдсөн норм нормативын дагуу үйлдвэрлэх, суурилуулахад шаардагдах материал, хүн хүчний тоо хэмжээ, зардлын тооцоог нарийвчлан гаргах,
- г) норм норматив, дүрэм журмын дагуу химийн суурь төхөөрөг чанарын өндөр түвшинд байгуулах, тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой техникийн асуудалд хяналт тавих,
- д) судлаач, инженер нарт хатуу, шингэн, хийн материалд лабораторийн сорил хийж, тоон болон чанарын дүн шинжилгээ хийхэд нь туслалцаа үзүүлнэ.



**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Химийн инженерийн техникч
- Химийн инженерийн тооцоологч
- Газрын тосны инженерийн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3111 Химийн техникч

**3117 УУРХАЙ, МЕТАЛЛУРГИЙН ТЕХНИКЧ**

Уурхай, металлургийн техникч нь төмөрлөг, түүнтэй холбоотой судалгаа туршилтад оролцох, хатуу эрдэс, газрын тос, байгалийн хий зэргийг боловсруулах арга, уурхай, уурхайн тоног төхөөрөмж, газрын тос байгалийн хийг хадгалах төхөөрөмж, төмөрлөгийг баяжмалаас ангижруулах, газрын тос, байгалийн хий хадгалах, тээвэрлэх систем, уурхайн тоног төхөөрөмжийг зохион бүтээхэд туслах, ажиллуулах, засварлах үүрэг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) металл болон металлын хайлшийн шинж чанарыг тодорхойлох судалгаа, туршилтын ажилд техникийн туслалцаа үзүүлэх,
- б) геологи, газар зүйн байдлын судалгаа хийх, газрын тос, байгалийн хий, ашигт малтмал олборлох, тээвэрлэх систем болон ашигт малтмал, металл боловсруулах, баяжуулах үйлдвэр, суурь төхөөрөг, зохион бүтээх, зураг төсөл хийх,
- в) ашигт малтмал, газрын тос, байгалийн хийг хайх, олборлох, боловсруулах, тээвэрлэхэд шаардагдах хүн хүч, материалын тоо хэмжээ, зардлын тооцоог нарийвчлан гаргах,
- г) ашигт малтмал, газрын тос, байгалийн хий хайх, олборлох, тээвэрлэх, хадгалахад болон боловсруулах үйлдвэрт ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг бүтээх, суурилуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийхэд баримтлах техникийн дүрэм, аюулгүй ажиллагааны журам, зохицуулалтын журам зэргийг хянах,
- д) уурхай, гүний уурхай, туннель, цооног, газар доорх анхны тусламж үзүүлэх байгууламжуудыг төлөвлөх, зураг төслийг нь гаргахад туслах,
- е) эрдэс, чулуу, ашигт малтмал, төмөрлөгийн дээж бэлтгэх, цуглуулах, лабораторийн туршилт хийж, тэдгээрийн шинж чанарыг тодорхойлох, туршилтын үр дүнг тэмдэглэх, дүн шинжилгээ хийх, тайлагнах, лабораторийн шалгах төхөөрөмжүүдэд үйлчилгээ хийх,
- ж) микроскоп, цахилгаан соронзон туяаны машин, спектрометр, спектрограф, нягтшил хэмжигч, бусад хэмжигч машинуудыг ашиглах,

- з) судлаачдад төмөрлөгийн баяжмал, хий, газрын тосны нөөцийг тодорхойлох мэдээллийг олж авахад нь цахилгаан, дуу, цөмийн хэмжигч төхөөрөмжүүдийг лабораторид болон үйлдвэрлэлийн нөхцөлд ашиглахад нь туслалцаа үзүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Уурхайн байцаагч
- Уурхайн инженерийн техникч
- Металлургийн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8111	Уурхайн операторч
8111	Уурхайчин
8111	Олборлогч
3111	Геологийн чиглэлийн техник ажилтан

**3118 ШУГАМ ЗУРАГЧ**

Шугам зурагч нь карт, гар зураг, бүдүүвч, хэмжилтийн дагуу техникийн зураг, газрын зураг, бусад материалыг бэлтгэх, өнгөтөөр хуулах, хувилах, эцсийн хувилбараар хэвлэлтэнд бэлэн болгох үүрэг хүлээнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) байшин барилга, далан хаалт, гүүр, зам, бусад архитекторын болон инженерийн байгууламжуудыг байгуулах, өөрчлөх, засвар үйлчилгээ хийх, эсвэл машин тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, суурилуулах зориулалтаар инженер, дизайнч нарын гар зурагт тулгуурлан ажлын зураг бэлтгэх, хянах,
- б) ажлын зураг зурах, хувилган шинэчлэх, хатуу хуулбар хэвлэх, дижитал танилцуулга хийх зорилгоор тоног төхөөрөмж, компьютерээр зохиомжлох,
- в) ажлын зураг, газрын зураг, бусад зургуудыг дижитал зураг болгон хөрвүүлэх компьютержсэн болон түүнтэй адилтгах төхөөрөмжүүдийг ажиллуулах,
- г) машин тоног төхөөрөмж, бусад бараа бүтээгдэхүүнийг угсрах, суурилуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх тухай гарын авлага материалд орсон зургийг зурж бэлтгэх, хянах,
- д) зургийг чулуу, юмуу төмөр хуудсан дээр буулгах, хувилах,
- е) барилга байгууламж, цахилгаан станц, үйлдвэрийн газар суурь төхөөрөмжийн цахилгаан төхөөрөмжийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлахад шаардагдах диаграмм, цахилгаан монтажны зураг, ерөнхий тойм зураг зэргийг бэлтгэх,

- ж) машин болон механик төхөөрөмжийн хэмжээс, бэхлэх арга, инженерийн бусад мэдээллийг тодорхой зурж бэлтгэх,  
 з) бэлэн болсон зургийг ажлын зураг болгон хэвлүүлэх ажлыг зохион байгуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шугам зурагч
- Техникийн шугам зурагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |           |
|------|-----------|
| 2165 | Зурагзүйч |
| 2165 | Байрзүйч  |

**3119 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ФИЗИК ИНЖЕНЕРИЙН УХААНЫ  
 БУСАД ТЕХНИКЧ**

Энэ хэсэгт бага бүлэг 311-т ороогүй физик инженерийн чиглэлийн бусад техникч орно. Тухайлбал, аюулгүй байдал, био эмчилгээ, байгаль орчин, үйлдвэрийн инженер зэрэг асуудлаар судалгаа шинжилгээ хийдэг, журам боловсруулдаг судлаач, инженерийн ажилд туслах үүрэгтэй ажилтан багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хүний нөөц, түүхий эд, тоног төхөөрөмжийг эдийн засгийн хувьд ашигтай, үр дүнтэй, аюулгүй байдлаар ашиглах, үйлдвэрлэлийн процесс, технологийн дараалал, түүний хэрэгжилтийг хянах, үйлдвэр суурь төхөөрөмжийг үр ашигтайгаар байгуулах зэрэг асуудлуудаар тоо мэдээлэл цуглуулах, техникийн туслалцаа үзүүлэх,
- б) учирч болзошгүй аюулыг тодорхойлоход туслах, аюулгүй ажиллагааны журам, төхөөрөмжүүдийг танилцуулах,
- в) байгаль орчины бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, нөхөн сэргээх, газар талбайг нөхөн сэргээх зэрэг ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгслийг шалгах, шаардлагатай бол өөрчлөх,
- г) инженерийн удирдлага, зааврын дагуу байгаль орчны бохирдлыг нөхөн сэргээх төхөөрөмж зохион бүтээхэд туслалцаа үзүүлэх,
- д) инженерүүдэд робот, түүнтэй төстэй төхөөрөмж бүтээх, туршихад нь туслалцаа үзүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Инженер техникч (аж үйлдвэр)
- Хугацаа, хөдөлгөөний техникч
- Тоон үзүүлэлтийн техникч
- Робот, автомат төхөөрөмжийн техникч

- Шүүх эмнэлгийн техникч
- Галын байцаагч

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2149	Үйлдвэрлэлийн инженер
2149	Хугацаа, хөдөлгөөнийн инженер
2149	Тоон үзүүлэлт судлагч инженер
3115	Аэронавтик техникч

## **БАГА БҮЛЭГ 312**

### **УУРХАЙ, ҮЙЛДВЭР БОЛОН БАРИЛГА УГСРАЛТЫН БАЙЦААГЧ**

Уурхай, үйлдвэр болон барилга угсралтын байцаагч нь уурхай, үйлдвэр, барилга угсралтын ажилтны ажлын хуваарийг гаргах, хяналт тавих, удирдан чиглүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Операторч, техникч зэрэг ажилтныг удирдан чиглүүлэх, өдөр тутмын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, зардлыг тооцоолох, тайлан бэлтгэх, шаардлагатай түүхий эд материал, хүн хүчийг тогтоох, аюулгүй ажиллагааны стандартыг мөрдүүлэх, шинэ ажилтныг сургах, дадлагажуулах зэрэг үүрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **3121 Уурхайн байцаагч, хянагч**

#### **3122 Үйлдвэрийн байцаагч**

#### **3123 Барилга угсралтын байцаагч**

#### **Тайлбар:**

Энэ бага бүлэгт ангилсан уурхайн, барилга угсралтын байцаагч нь ихэвчлэн ажилтны өдөр тутмын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, удирдан чиглүүлэх, хяналт тавих зэрэг ажлыг хийнэ. Гэхдээ зарим тохиолдолд тэдний ажлыг хянах бус өөрөө уг ажлыг гүйцэтгэж байдаг. Түүнчлэн чанар шалгагч нарыг ч энэ бүлэгт хамруулах нь зүйтэй. Чанар шалгагчийг ихэвчлэн “багын ахлагч” гэж нэрлэдэг.

Үндсэн бүлэгт ангилсан менежер нь ажилтны өдөр тутмын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, удирдан чиглүүлэх үүрэгтэй. Харин байцаагч, чанар шалгагчийн үүрэг нь менежерийн ажилтай энэ талаараа төстэй боловч ялгаатай ажил, мэргэжил юм. Менежер нь бизнесийн ерөнхий стратеги, бодлого чиглэлийг тодорхойлох, байгууллагын төсвийг гаргах, ажилтан сонгон шалгаруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах зэрэг асуудлаар шийдвэр гаргадаг бол байцаагч, чанар шалгагч нь дээрх шийдвэрүүдийг гаргахад өөрт нь хамаарах чиглэлээр санал гаргана.

### 3121 УУРХАЙН БАЙЦААГЧ, ХЯНАГЧ

Уурхайн байцаагч, хянагч нь газрын гүнийн, ил уурхайн болон карьерийн ажилтны ажлыг шууд удирдан чиглүүлэх, хянах үүргийг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) ил уурхай болон карьер дээр хүнд машин механизм хэрэглэж, газрын гүнд малтлага, эсвэл газрын гүнээс эрдэс бодисийг гаргаж байгаа ажилтны ажлыг шууд удирдан чиглүүлэх, хянах,
- б) ажил үүргийн хуваарьт нийцсэн шинэ арга санаачлах, бүтээмжийг нэмэгдүүлэх санаачлага гарган удирдлагад танилцуулах,
- в) үйл ажиллагааны доголдлыг арилгах талаар удирдлага, техник ажилтан болон бусад нэгж, захиалагч, ханган нийлүүлэгч нартай зөвлөлдөх,
- г) уурхайн олборлох үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайлан мэдээллийг уурхайн удирдлагад гаргаж өгөх,
- д) ажиллах хүч, материал хангамжийн хэрэгцээг тодорхойлох зэрэг багтана.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Уурхайн байцаагч, хянагч
- Карьерын хянагч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

1322	Уурхайн менежер
3117	Уурхай, металлургийн техникч
8111	Далд, ил уурхайчин
8111	Карьерчин

### 3122 ҮЙЛДВЭРИЙН БАЙЦААГЧ

Үйлдвэрийн байцаагч нь операторч, техникч зэрэг үйлдвэрийн ажилтны ажлыг удирдан чиглүүлэх, хянан шалгах ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) операторч, техникч зэрэг үйлдвэрийн ажилтны ажлыг удирдан чиглүүлэх, хянан шалгах,
- б) ерөнхий төлөвлөгөө, ажиллах хүчний болон түүхий эд материалын нөөцийг харгалзан өдөр тутмын ажлыг төлөвлөх, зохион байгуулах,
- в) зардлыг тооцоолох, тайлан бэлтгэх,
- г) шаардлагатай байгаа түүхий эд материал, хүн хүчийг тогтоох,

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

- д) аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх,
- е) шинэ ажилтныг сургах, дадлагажуулах зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үйлдвэрлэлийн байцаагч
- Талбайн зохицуулагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1321 Үйлдвэрийн менежер

### **3123 БАРИЛГА УГСРАЛТЫН БАЙЦААГЧ**

Барилга угсралтын байцаагч нь барилга байгууламжийг барих, засварын ажлыг гүйцэтгэхэд ажилтны ажлыг төлөвлөж, зохион байгуулан, ажилд нь хяналт тавина.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) норм дүрмийн шаардлагад нийцүүлэн барилга угсралтын ажилд тавигдах стандарт шаардлага, ажлын графикийг боловсруулж, мөрдүүлэх,
- б) ажлыг гүйцэтгэхэд шаардагдахад ажиллах хүч, материалын нөөцийг оновчтой зохицуулж, зохион байгуулах,
- в) ажлын явцыг үзэж шалгах, чанарын үнэлгээ өгөх,
- г) барилгын талбайд аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангах, талбайд байрлах машин механизм бусад объектуудыг шалгаж, технологийн дагуу байршуулах,
- д) барилгын бусад төслийн ажилтай өөрийн барилгын ажлыг уялдуулах,
- е) ажилтныг удирдаж хяналт тавих.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Иргэний барилга угсралтын байцаагч
- Барилгын байцаагч
- Барилгын даамал

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1323 Барилга угсралтын менежер  
3112 Иргэний барилгын инженерийн техникч

**БАГА БҮЛЭГ 313  
ТЕХНОЛОГИ ПРОЦЕСС, ЧАНАР ШАЛГАГЧ ТЕХНИКЧ**

Технологи процесс, чанар шалгагч техникч нь автомат хяналтын систем, хянах самбар болон олон ажиллагаатай машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, цахилгаан станцын ба дамжуулалтын, хаягдал, бохир усыг цэвэршүүлэх, хаягдал устгах машин тоног төхөөрөмж, химийн, нефтийн болон шатдаг хийн дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүнчлэн метал боловсруулах зэрэг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, засварлах ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Удирдлагын төв өрөөний автомат, компьютержсэн удирдлагын самбараас үйл ажиллагааг хянах, зохицуулах, үйл ажиллагааг эхлүүлэх, зогсоох, хянах самбар болон бусад тоног төхөөрөмжийг ажиллуулах хянах, даралт, багтаамж зэргийг хэмжих заалтын норматив хэтэрсэн тохиолдолд тохиргоо хийх, бусад ажилтнаас тоног төхөөрөмжийн ажиллагааны мэдээлэл авах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээ хийх, машин, тоног төхөөрөмж дээр ажиллаж байгаа болон холбогдох бусад ажилтны ажилд хяналт тавих зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3131 Цахилгаан үйлдвэрлэлийн төхөөргийн операторч**

**3132 шатаагч зуух, ус цэвэрлэх байгууламжийн операторч**

**3133 Химийн үйлдвэрийн операторч**

**3134 Нефть, байгалийн хий цэвэрлэх төхөөрөмжийн операторч**

**3135 Металл үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хянагч**

**3139 Энэ ангилалд ороогүй үйл ажиллагааны хяналтын техникч**

**3131 ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Цахилгаан үйлдвэрлэлийн төхөөргийн операторч нь цахилгаан эрчим хүч гаргаж авах машин тоног төхөөрөмжийг ажиллуулж хянах, засварлах, эрчим хүчийг дамжуулах сүлжээнд хяналт тавих ажлыг хийнэ. Уурын турбин, генератор, цөмийн реактор зэрэг эрчим хүчний тоног төхөөрөмж дээр ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

а) эрчим хүч гаргах төрөл бүрийн тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

- б) буцалгагч, уурын турбин, генератор, конденсатор, нүүрсний, нефтийн, байгалийн шатдаг хийн, болон цөмийн цахилгаан станцын реактор зэрэг системийг хянах,
- в) усны төвшинг хянах, системийн операторчтай холбогдон хүчдэл, давтамж зэрэгт хяналт тавих, цахилгаан станцын тоног төхөөрөмжийг унтраах болон асаах,
- г) хэмжих төхөөрөмжийн заалт байвал зохих хэвийн хэмжээнд байгаа эсэхийг хянах, шаардлагатай тохиолдолд шуурхай арга хэмжээ авч үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх,
- д) ээлжийн болон бусад операторчтай холбоотой ажиллаж тоног төхөөрөмжийн ажиллагааны талаар мэдээлэл авах, ээлжийн ажил хүлээлцэх, илтгэх хуудас, бүртгэл зэрэг бичиг баримтыг хөтлөх,
- е) генератор, тогоо, турбин, компресор, насос зэрэг тоног төхөөрөмжийг цэвэрлэх, засварлах зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цахилгаан эрчим хүчний төхөөрөмжийн операторч
- Усан цахилгаан станцын эрчим хүчний тоног төхөөрөмжийн операторч
- Цөмийн эрчим хүч үйлдвэрлэх төхөөрөмжийн операторч
- Нарны эрчим хүчний төхөөрөмжийн операторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8182 Уурын хөдөлгүүр болон уурын тогтооны операторч

### **3132 ШАТААГЧ ЗУУХ, УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ОПЕРАТОРЧ**

Хог хаягдал устгах, ус цэвэршүүлэх байгууламжийн операторч нь шингэн болон хатуу хаягдлыг устгах төвийн бохирыг зайлуулах, ус цэвэршүүлэх, дамжуулах, шатаах зэрэг үйл ажиллагааны автомат тоног төхөөрөмжийг ажиллуулах, үйл ажиллагааг нь хянах ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) бохирыг зайлуулах, ус цэвэршүүлэх, дамжуулах автомат тоног төхөөрөмжийг ажиллуулах, үйл ажиллагааг нь хянах, хүн амын хэрэгцээний болон байгалийн усны системд очих усыг цэвэрлэх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- б) хатуу хог хаягдлыг шатаах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- в) даралт, температур, урсгал зэргийн заалтыг төв хянах самбарт хянах,



- г) үндсэн тоног төхөөрөмж, дагалдах болон нэмэлт тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах,
- д) бохирын усанд химийн, бактерийн шинжилгээ хийж цэвэршүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, өнгө болон бусад стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах,
- е) бусад шингэнийг халдваргүйжүүлэн ариутгаж байгаа эсэхийг шалгах,
- ж) цэвэршүүлэх байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах, харуул хамгаалалтыг шалгах,
- з) ажлын тайлан бэлтгэх, усны найрлагын тэмдэглэл, бүртгэл хөтлөх зэрэг ажил багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хог шатаах төхөөрөмжийн операторч
- Ус шахуургын станцын операторч
- Ус цэвэрлэх төхөөрөмжийн операторч

**3133 ХИМИ ПРОЦЕССИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ОПЕРАТОРЧ**

Хими процессийн төхөөрөмжийн операторч нь нэрэх, задлах, холих, халаах, шүүх, цэвэрлэх зэрэг химийн аргаар боловсруулалт хийх тоног төхөөрөмжид тохиргоо, засвар хийж ажиллуулах үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Төв хяналтын цахилгаан болон компьютерийн дэлгэц дээрх тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах,
- б) Тоног төхөөрөмж, гэрэл, насосыг засах,
- в) Түүхий эдийг хэмжих, хангах, задлах, шүүх тоног төхөөрөмжид угсрах,
- г) Тоног төхөөрөмжийн ажиллагааг хянах, гэмтлийг олж тогтоох,
- д) Тоног төхөөрөмжийг шалгах, засвар үйлчилгээ хийх,
- е) Бүтээгдэхүүний дээжид туршилт явуулах, мэдээллийг баримтжуулах, дүгнэлт хийх, бүртгэл хөтлөх.

**Энэ бүлэгт хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Химийн аргаар халааж, боловсруулах тоног төхөөрөмжийн операторч
- Химийн аргаар шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмжийн операторч
- Химийн аргаар нэрэгч тоног төхөөрөмжийн операторч
- Химийн тоног төхөөрөмжийн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3134 Нефть, байгалийн хий цэвэрлэх төхөөргийн операторч
- 8131 Химийн бүтээгдэхүүний машины операторч

**3134 НЕФТЬ, ХИЙ ЦЭВЭРЛЭХ ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Нефть, хий цэвэрлэх төхөөржийн операторч нь нефть болон дайвар бүтээгдэхүүн, байгалийн хий цэвэрлэх, нэрэх, боловсруулах тоног төхөөрөмжийг ажиллуулж хянана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) төв удирдлагын өрөөнд байрлах автомат, цахим хянах самбарын заалтыг хянах,
- б) тохируулгыг өөрчлөн боловсруулах төхөөрөмжийн ажиллагааг удирдах,
- в) тоног төхөөрөмжийг ажиллуулах, зогсоох, доголдолыг арилгах зэргийг хянах, боловсруулах төхөөрөмжийн гадна талд хяналт тавих,
- г) тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, засвар үйлчилгээг хийлгэх,
- д) бүтээгдэхүүнд шинжилгээ хийх, найрлагыг нь тэмдэглэх, бүртгэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Лааны тос үйлдвэрлэх төхөөрөмжийн операторч
- Нэрэх төхөөрөмжийн операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |  |
|------|--|
| 8131 | Химийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор |
| 3133 | Химийн боловсруулах тоног төхөөрөмжийн хянагч    |

**3135 МЕТАЛЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕСС ХЯНАГЧ**

Металл үйлдвэрлэлийн процесс хянагч нь хүдэр хайлуулах, цэвэрлэх, метал халааж боловсруулах, цувьж ороомог хийх, металл сунгах, шахах тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Металл боловсруулах үйл ажиллагааг хяналтын самбар, компьютер, болон бусад хяналтын системээр, голчлон төв хянах өрөөнөөс хянах,
- б) Металл бутлах, шүүх, цэвэрлэх, хайлуулах, шахах зэрэг тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) Шаардлагатай ажиллагааны үед дүрсийг хэвлэн гаргах тохиргоог хийх,
- г) Бусад ажилтанд тоног төхөөрөмжийн ажиллагааны талаар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах,
- д) Тоног төхөөрөмжийн ажиллагааны талаар мэдээ, тайлан бэлдэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүдэр хайлуулах зуухны операторч
- Металл хайлуулах, цутгах машины хянагч
- Металл халааж боловсруулах зуухны операторч
- Металл сунгах, шахах машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 8121 | Металл цутгагч                                  |
| 8121 | Ган ороогч                                      |
| 8122 | Металл өнгөлөх, цайрдах, бүрэх машины операторч |

**3139 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГУЙ ПРОЦЕСС ХЯНАЛТЫН ТЕХНИКЧ**

Процесс хяналтын техникч нь төрөл бүрийн шугамын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд хяналт тавина.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Автомат шугамын операторч
- Үйлдвэрлэлийн автомат төхөөрөмжийн хяналтын техникч
- Цаас жижиглэх төхөөрөмжийн операторч

**БАГА БҮЛЭГ 314****АМЬД БАЙГАЛЬ СУДЛАХ УХААНЫ ТЕХНИКЧ, ХОЛБОГДОХ  
БУСАД АЖИЛТАН**

Амьд байгаль судлах ухааны техникч, холбогдох бусад туслах мэргэжилтэн нь биологи, ургамал, амьтан судлал, биотехнологи, биохими, газар тариалан, загас агнуур, ойн аж ахуй зэрэг салбарыг судлах ухааны мэргэжилтний судалгаа, шинжилгээ, хөгжлийн менежментийн талаар хийсэн ажлын баримт материалын хадгалалт хамгаалалттай холбогдсон техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах асуудлыг хариуцна.

Эдгээр мэргэжилтэн нь голчлон төрөл бүрийн сорил, туршилт, лабораторийн дүгнэлт хийхэд зориулан шинжлэх ухааны арга зүйгээр мэдээлэл цуглуулах, баримт хадгалах, боловсруулалт, шинжилгээ хийх, мэдээ тайлан бэлдэх, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хамгаалах ажил гүйцэтгэнэ.

Энд ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3141 Амьд байгаль судлах ухааны техникч (анагаах ухаанаас бусад)**

**3142 Газар тариалангийн техникч**

**3143 Ойн аж ахуйн техникч**

**3141 АМЬД БАЙГАЛЬ СУДЛАХ УХААНЫ ТЕХНИКЧ  
(АНАГААХ УХААНААС БУСАД)**

Амьд байгаль судлах ухааны салбарын техникч нь дээрх чиглэлээр судалгаа, шинжилгээ, туршилт хийх, байгалийн нөөцийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, ургамал ан амьтан, биологи, микробиологийн ухаан, эсийн болон молекул биологийн судалгааны үр дүнг практикт ашиглах аргыг боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) туршилтын төлөвлөгөө гаргах, туршилтанд бэлтгэх, туршилт хийх,
- б) лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулах, тохиргоо хийх, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх,
- в) дээж болон сорьц цуглуулах, бэлтгэх, химийн задлагч, шилэн ялтас бэлтэх, бактерийг ургуулан туршилтанд бэлтгэх,
- г) туршилтыг ажиглах, дүн шинжилгээ, тооцоолол хийж холбогдох шинжлэх ухааны аргыг хэрэглэн туршилтын үр дүнг тайлагнах,
- д) дээж, сорьцийг хадгалах, ангилах, бүлэглэх,
- е) ашигласан болон туршилт хийсэн зүйлсийн талаар тодорхой хаяг, тэмдэглэл, бүртгэл хөтлөх,
- ж) загвар байгуулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд компьютер ашиглах,
- з) нарийн технологитой болон өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг ашиглах,
- и) судалгааны ажил, бүтээгдэхүүн хийх явцад оролцох,
- и) лабораторт шаардлагатай материалыг захиалах,
- л) өгөгдлийн санд мэдээлэл оруулах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Техникч, бактериологийн
- Техникч, биохимийн
- Техникч, цус хадгалах станцын
- Техникч, эм судлалын
- Техникч, серологийн
- Техникч, амьтан судлалын

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

3212	Эмчилгээ, эмгэг судлалын лабораторийн техникч
3213	Эм зүйн техникч
3212	Паталогийн лабораторийн техникч
3119	Крименилогийн техникч

**3142 ХӨДӨӨ АЖ АХУЙН ТЕХНИКЧ**

Хөдөө аж ахуйн техникч нь туршилт, судлагаа хийх, тухайн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, хөдөө аж ахуйн эрхлэгч нарт техникийн болон судалгаа шинжилгээний ажилд тулалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) туршилт, судалгаа шинжилгээний ажил явуулахад шаардагдах материал, тоног төхөөрөмжийг бэлтгэх,
- б) туршилт, судалгаа шинжилгээний ажилд зориулан ургамал, амьтны эд эс, хэсэг, эрхтэн зэргийн сорьц бэлтгэх,
- в) мэргэжлийн туршилт, судалгаа шинжилгээ хийх буюу үр дүнг турших, нэвтрүүлэх ажилд оролцох,
- г) ургамал, малд хор хөнөөлтэй өвчин үүсгэгч бичил биет, хорхой шавьж, шимэгч, царцаа зэргийг тогтоох, хяналтанд авах аргыг тодорхойлох,
- д) ургамал үрслүүлэх, загас үржүүлэх, малын үйлдвэрлэлийн чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих,
- е) ургамлын үрийн дээжийн чанар цэвэршил болон боловсрох хугацааг судлах,
- ж) төслийг хэрэгжүүлэх материалын болоод ажиллах хүчний тоо хэмжээ, зардлын талаар мэдээлэл цуглуулж тооцоо гаргах,
- з) судалгаа шинжилгээний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг хангах ажлыг зохион байгуулах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сүүн бүтээгдэхүүний техникч
- Агротехникч
- Хөрс судлалын техникч
- Чанар шалгагч, лаборант

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

3240	Зохиомол хээлтүүлэгч
3240	Малын техникч /бага эмч/

**3143 ОЙН АЖ АХУЙН ТЕХНИКЧ**

Ойн аж ахуйн техникч нь ойн судалгааны ажил, ойн менежмент, мод бэлтгэл, нөөц хадгалалт болон байгаль орчны хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглагдах техникийн болон хянагчийн үйл ажиллагааг хариуцна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Ойн нөхөн сэргээлт болон ойжуулахтай холбогдох судалгаа шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэх,
- б) Газрын зургийн техник, компьютер мэдээллийг ашиглан ойн менежмент, мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих,
- в) Ойд жим гаргах, зам тавих ажлын хөтөлбөрт оролцох, хяналт тавьж ажиллах,
- г) Ойжуулалтын талбай бэлтгэх, мод суулгах, мод огтлох, сонгож бэлтгэх зэрэг ажилд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг гүйцэтгэх,
- д) Ойн түймэр унтраахад оролцох, ой модны өвчлөл, шавьж идэхээс сэргийлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохицуулах,
- е) Мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавих,
- ж) Байгаль орчныг хамгаалах, нөөц ашиглалт, галын аюулгүй байдал, гэнэтийн гамшгийн үед холбогдох дүрэм, журмыг мөрдөн ажиллах,
- з) Ой цэвэрлэх, мод арчлах ажиллагааг эрхлэх,
- и) Модны үрсэлгээ хийх, хорхой шавьж, модны өвчлөлийн талаар болон туршилтын ойжуулалт, инженерийн судалгааны ажлыг хийх,
- к) Ойжуулалт, мод бэлтгэлийн ажлын төлөвлөгөө гаргах.

**Энэ бүлэгт ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ойн техникч
- Ойжуулалтын техникч

**БАГА БҮЛЭГ 315****УСАН ОНГОЦ, АГААРЫН ХӨЛГИЙН ХЯНАГЧ, ТЕХНИКЧ**

---

Усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч нь усан онгоц ба агаарын хөлгийг удирдах ба чиглүүлэх, үйл ажиллагааны ба хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд техникийн үйлчилгээг гүйцэтгэх, цахилгааны болон цахим механик ба компьютержсэн нислэгийн удирдлагын системийн найдвартай ажиллагааг хангах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Усан онгоц, агаарын хөлгийн цахилгаан ба цахим төхөөрөмжийн ажиллагааг хянах, хөлгийг удирдах, чиглүүлэх, хөлгийн хөдөлгөөнийг хянах, нислэгийн компьютержсэн ба цахилгаан, механик удирдлагын системийн ажиллагааг хянана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3151 Усан онгоцны инженер**

**3152 Усан онгоцны тавцан дээрх ажилтан, чиглүүлэгч**

**3153 Агаарын хөлгийн нисэгч ба түүнд хамаарах бусад мэргэжилтэн**

**3154 Агаарын хөдөлгөөн хянагч, удирдагч**

**3155 Агаарын хөдөлгөөний цахим техникч**

**3151 УСАН ОНГОЦНЫ ИНЖЕНЕР**

Усан онгоцны инженер нь хөлөг онгоцны механик, цахилгаан, цахим тоног төхөөрөмж, механизмын засвар үйлчилгээ болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд оролцох ба хянах, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн хангалтын үүргийг эрэг дээр гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Усан онгоцны механик, цахилгаан ба цахим тоног төхөөрөмж, механизмын засвар үйлчилгээ, үйл ажиллагаанд оролцох ба хянах,
- б) Түлш болон бусад хөдөлгүүр, түүний сэлбэгийн захиалга, үйл ажиллагааны бүртгэл хөтлөх,
- в) Усан онгоцны механизм ба тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ нь техникийн стандарт шаардлага болон зохих журмын дагуу гүйцэтгэснийг нотолж баталгаажуулахад техникийн үнэлгээ хийх,
- г) Хөдөлгүүр, машин механизм ба түүний туслах төхөөрөмжид засвар үйлчилгээ болон онцгой үеийн засвар үйлчилгээ хийхэд зааварчлах үүргийг гүйцэтгэх,
- д) Хөдөлгүүрийн өрөөг хянах ба хөдөлгүүр, машин механизм ба тэдгээрийн туслах төхөөрөмжийн үзүүлэлтийн талаар тэмдэглэл хөтлөх,
- е) Бусад ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Инженер, усан онгоцны

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2144      Механикч инженер

**3152 УСАН ОНГОЦНЫ ТАВЦАН ДЭЭРХ АЖИЛТАН, ЧИГЛҮҮЛЭГЧ**

Усан онгоцны тавцан дээрх ажилтан ба чиглүүлэгч нь усан онгоц, ижил төрлийн завийг удирдах, чиглүүлэх, мөн онгоцны аюулгүй байдлыг хангахтай холбоотой үүргийг эрэг дээр гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) далай эсвэл гол мөрний усан замаар усан онгоц, ижил төрлийн завийг удирдах, чиглүүлэх,
- б) Ачаа ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг хангах, хөлгий багийн гишүүд болон зорчигчийн аюулгүй байдлын дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих,
- в) Усан онгоцны засвар, үйлчилээг техникийн стандарт шаардлага холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэснийг баталгаажуулсан техникийн үнэлгээ гаргах,
- г) Усан онгоцны үйл ажиллагаа ба түүнийг чиглүүлэхтэй холбогдсон онол, практик мэдлэгийг олж авах,
- д) Усан онгоцны сэлбэгийг захиалах, шаардлагатай тохиолдолд багийн гишүүдийг шинэчлэх, үйл ажиллагааны бүртгэл хөтлөх,
- е) Бусад хөлөг онгоц, эргийн станцтай орчны болон ослын мэдээллийг нэвтрүүлэх, хүлээн авах,
- ж) Бусад ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Усан онгоцны ахмад

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8350      Далайчин

**3153 АГААРЫН ХӨЛГИЙН НИСЭГЧ, ХОЛБОГДОХ БУСАД ТУСЛАХ АЖИЛТАН**

Агаарын хөлгийн нисэгч, холбогдох бусад хамжих ажилтан нь зорчигч, шуудан ба ачаа тээврийн зориулалт бүхий агаарын хөлгийн механик, цахилгаан ба цахим төхөөрөмжийн ажиллагааг хянах. Мөн нислэгийн өмнө болон нислэгийн дараах холбогдох үүргийг гүйцэтгэнэ.



**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Хөлгийг үйл ажиллагааны тогтоосон журмын дагуу нисгэх, чиглүүлэх,
- б) Нислэгийн төлөвлөгөөг бэлтгэх, түүний стандартын хэрэгжилтийг шалгах,
- в) Механик, цахилгаан, цахим төхөөрөмжийн ажиллагааг шалгах, түүнчлэн бүх төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын системийн ажиллагаа үнэн зөв ажиллаж буй эсэхийг баталгаажуулах,
- г) Нислэгийн явцад хөлөгт гарсан гэмтлийг тодорхойлж шийдвэр гаргахад нислэгийн үйл ажиллагааны талаарх онолын болон практик мэдлэгийг олж авах,
- д) Нисэх онгоцны тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ бүрэн хийгдэж тэдгээрийн хэвийн ажиллагааг баталгаажуулах зорилгоор биечлэн зааварчлах, нормативт засвар, үйлчилгээний бүртгэлийг тогтмол шалгах,
- е) Гэрчилгээнд гарын үсэг зурж баталгаажуулан нислэгийн бүртгэлийг хөтлөх,
- ж) Нислэгийн өмнөх үзлэгийн тайланг авах ба нислэгийн үед нислэгийн удирдагчтай байнгын холбоо тогтоох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын хөлгийн инженер
- Багш нисэгч
- Штурман
- Нисэгч

**3154 АГААРЫН ХӨДӨЛГӨӨН ХЯНАГЧ**

Агаарын хөдөлгөөн хянагч нь радио холбоо, радио локатор ба гэрэлтүүлгийн системийн тусламжтайгаар агаарын зайд болон газарт байгаа агаарын хөлгийн хөдөлгөөнийг чиглүүлэх мөн агаарын хөлгийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нисэх буудалд ойртож байгаа болон нисэх буудлаас хөөрч байгаа агаарын хөлгийн нислэгийг удирдах, түүнчлэн тэдний газар дээрх хөдөлгөөнийг удирдаж хянах,
- б) тогтоогдсон агаарын зайд нислэг үйлдэж буй онгоцыг удирдаж хянах
- в) нислэгийн төлөвлөгөөг зөвшөөрөх, шалгах,
- г) цаг уурын мэдээлэл, ажиллаж буй тоног төхөөрөмж, нислэгийн төлөвлөгөө ба нислэгийн ачаалал зэрэг шаардлагатай мэдээллээр нисэх бүрэлдэхүүнийг хангах,

- д) ажлын явцад урган гарсан асуудлыг тодорхойлж шийдвэр гаргахад нислэгийн үйл ажиллагаатай холбоотой онолын ба практик мэдлэгийг олж авах,
- е) эрж хайх, авран хамгаалах ажиллагааг эхлүүлэх, зохион байгуулах,
- ж) хөөрөх буух зурваст болон түүний ойр орчмын бүх онгоц, өөрөө явагчийн хөдөлгөөнийг чиглүүлж удирдах,
- з) ойролцоо орших цамхагийн нислэгийн удирдагч, аэродромын нислэгийн удирдагч, бусад удирдлагын төвүүдтэй радио болон телефон холбоог байнга тогтоох, мөн зэргэлдээх агаарын бүсээс орж ирэх, өөрийн агаарын бүсээс гарч буй онгоцны мэдээллийг харилцан солилцох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын хөдөлгөөн хянагч

### **3155 АГААРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙН ЦАХИМ ТЕХНИКЧ**

Нислэгийн хөдөлгөөний аюулгүйн цахим техникч нь нислэгийн хөдөлгөөний удирдлагын ба агаарын навигацийн системүүдийг загварчлах, угсрах, хэвийн ажиллагааг хангах мөн тэдгээрийн засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) агаарын навигацийн систем дэх цахим, цахилгаан, механик ба компьютержсэн төхөөрөмж болон тэдгээрийг шалгах ажиллагааг боловсронгуй болгох техникийн бодлогыг хэрэгжүүлэх,
- б) агаарын навигацийн болон нисэх онгоцны байрлалыг тодорхойлох системийн интерфэйсүүдийн хэлхээг загварчлахад техникийн туслалцаа үзүүлэх,
- в) нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглах төхөөрөмжүүдийн техникийн стандарт, шаардлага, сургалтын хөтөлбөрийн шаардлагыг бэлтгэх,
- г) газрын навигацийн төхөөрөмжүүдийн угсралт, түүний ажиллагаа, засвар үйлчилгээ нь стандарт, шаардлагын дагуу хийгдсэн эсэхийг баталгаажуулахад техникийн шинжилгээ, дүгнэлт гаргах,
- д) ажлын явцад урган гарсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлын иженерчлэлтэй холбоотой онол, практикийн мэдлэг, ур чадварыг олж авах,
- е) нислэгийн хөдөлгөөний удирдлагын ачааллын багтаамж, найдваржилт, интегралчлал, мөн тоног төхөөрөмжийг сайжруулахын тулд ашиглагдаж байгаа газрын навигацийн системийг сайжруулж шинэ агаарын зайн нислэгийн удирдлагад ашиглах,

- ж) нислэгийн хөдөлгөөний холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжүүдийг хянах ба гэрчилгээжүүлэх мөн нислэгийн болон онгоцны хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд газрын навигацийн систем, тоног төхөөрөмжийн тохируулга хийх,
- з) техникийн сургалт, дадлага, мэргэшлийн ур чадвараар мэргэжлийн удирдлагаар бусад ажилтныг хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нислэгийн хөдөлгөөний аюулгүйн цахим техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7232 Агаарын хөлгийн хөдөлгүүрийн механикч, тохируулагч

**ДЭД БҮЛЭГ 32  
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТЭН**

Эрүүл мэндийн мэргэжилтэн нь хүн болон амьтны өвчин эмгэг, хууч, гэмтэл, согог зэрэг өвчнийг оношлох, эмчилгээ хийх, эмнэлэгийн тусламж үйлчилгээг хүн ба малын эмнэлэгт хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Эмнэлэгийн зураг авах төхөөрөмжийг шалгах ажиллуулах, цацраг туяа эмчилгээ хийх, биен дэх шингэн, эсээс дээж авч шижилгээнд өгөх, эм зүйчийн зааварчлагын дор эмийн жор бэлтгэх, эмнэлэгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэх, тохируулах, асаргаа, сувилахуй, эх барих үйлчилгээ үзүүлэх, тухайн нутгийн ард иргэдийн хэрэглэж заншсан, сүсэглэж ирсэн эмчилгээний уламжлалт аргаар бэлтгэсэн эмийн өвс, ургамлыг эмчилгээнд хэрэглэх зэрэг болно.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 321 Эм зүйн техникч**
- 322 Сувилахуйн болон эх барихуйн мэргэжилтэн**
- 323 Уламжлалт, хавсарга анагаахын мэргэжилтэн**
- 324 Мал эмнэлэгийн техникч, туслах ажилтан**
- 325 Эрүүл мэндийн бусад туслах мэргэжилтэн**

**БАГА БҮЛЭГ 321**  
**АНАГААХЫН БОЛОН ЭМ ЗҮЙН ТЕХНИКЧ**

---

**3211 ЭМЧИЛГЭЭ, ОНОШЛОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКЧ**

Эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжийн техникч нь рентген зураг, хэт авианы гэх мэт бусад гэмтэл, оношилгоо, эмчилгээнд шаардлагатай хүний биеийн бүтцийн зургийг авах, зураг авах төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцан ажиллана. Техникч нь цацраг туяаны эмч, мэргэжилтний хяналтан дор туяа эмчилгээг өвчтөнд хийж болно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) оношлогооны рентген зураг авах, хэт авианы болон соронзон бичлэг хийх тоног төхөөрөмжийг ажиллуулах, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах,
- б) зураг авах болон эмчилгээнийн явцад өвчтөнд тайлбарлах, өвчтөний аюулгүй, ая тухтай байдлыг хангах,
- в) зураг авах, эмчилгээ хийх тоног төхөөрөмжийн байрлал, дэлгэцэн дээрх дүрсийг хянах, тоног төхөөрөмжийн тохиргоог хийх, техникийн үйл ажиллагаанд хяналт тавих,
- г) боловсруулсан рентген зураг, дурс бичлэг, компьютерийн мэдээллийг шалгаж, бичлэг чанарын шаардлагад хяналт тавих,
- д) зураг авалтын явцад өвчтний биеийн байдалд хяналт тавьж, ямар нэгэн харшлах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмчид мэдэгдэх,
- е) өвчтөнд хэрэглэж байгаа цацраг туяа, рентген туяаны хэмжээг хянаж, тохируулан өөрчлөлт гарсан тохиолдолд эмчид мэдээлэх,
- ж) рентген аппарат, зургийн дуран ашиглан өвчтний биен дэх цацраг идэвхжилтийн хэмжээг гаргаж, хүнийг эмчлэх, оношлоход ашиглах,
- з) цацраг идэвхит материалыг устгах, бүртгэх, цацраг идэвхит бодисыг аюулгүй зориулалтын хамгаалалттай газар хадгалах.

**Энэ ангилалд хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Цацраг туяаны оношлогооны техникч
- Рентген зургийн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                      |
|------|--------------------------------------|
| 2111 | Физикч, одон орон судлаач            |
| 2212 | Рентген шинжээч                      |
| 2263 | Цацраг туяа хамгаалалтын мэргэжилтэн |

**3212 ЭМЧИЛГЭЭ, ЭМГЭГ СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН ТЕХНИКЧ**

Эмчилгээ, эмгэг судлалын лабораторийн техникч нь хүний цус, шээс болон бусад эд эсийн дээжид шинжилгээ хийж, өвчтний биеийн эрүүл мэнд, өвчний онош болон үхлийн шалтгааныг тодорхойлно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цус, шээс, нугасны ус зэрэг биеийн шингэнээс дээж авч, химийн шинжилгээ хийж, бүтцийн хэвийн болон хэвийн бус байдлыг тодорхойлох,
- б) дуран, дулаан хэмжигч, гэрэл хэмжигч, компьютер зэрэг тоног төхөөрөмжийг ажиллуулах, тэдгээрийн ажиллагааг хэвийн байлгах, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах,
- в) лабораторийн шинжилгээний хариуг баримт хадгалалт, мэдээллийн цахим санд хадгалах,
- г) биологийн материалын дээжид химийн шинж чанар болон урвалын шинжилгээ хийх,
- д) лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулах, цэвэрлэх, засвар үйлчилгээ хийх,
- е) лабораторийн шинэ нээлтийг шинжилгээнд ашиглан дүгнэлт гаргах,
- ж) лабораторийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг хангах, боловсронгуй болгох,
- з) бичил биетний дээжийг нь ялган авч тодорхойлон шинжилгээнд ашиглах,
- к) хэвийн бус пигменттэй эсийг шинжлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цус хадгалах техникч
- Цитологийн техникч
- Эмгэг судлалын лабораторийн техникч
- Паталогийн техникч
- Мал эмнэлгийн техникч

**3213 ЭМ ЗҮЙН ТЕХНИКЧ, ТУСЛАГЧ**

Эм зүйн техникч, туслагч нь эм зүйчийн удирдлага, зааварчлагын дор эм, эмийн бүтээгдэхүүнийг бэлтгэх, түгээх, худалдаалах үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эм зүйч мэргэжилтний удирдамжийн дор холбогдох журам, зааврын дагуу эм, эмийн бусад бэлдмэлийг бэлтгэх, найруулах,

- б) хүн, малын эмч, мэргэжилтний бичсэн эмийн жорын дагуу үйлчлүүлэгчдэд эм түгээх, худалдаалах, эмийн хэрэглэх зааврыг амаар болон бичгээр тайлбарлаж өгөх,
- в) эмч, мэргэжилтний бичсэн эмийн жорыг хүлээн авч, эм, эмийн бусад бэлдмэлийг бэлтгэх стандартад нийцэж буй эсэхийг шалгах, стандарт шаардлагын дагуу хадгалах,
- г) эмийн зөв хадгалалт аюулгүй байдлыг хангах, шалгах,
- д) эм хадгалах савыг дүүргэх, хаяглах,
- е) үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, эрэлт, хүсэлтийг хүлээн авах, хариулах, тэднийг эм зүйч, мэргэжилтэнтэй уулзуулах,
- ж) эм, химийн бодис, түүний нөөцөд тооллого хийх, нөхөн хангалт хийх эм, бүтээгдэхүүний жагсаалт гаргаж, мэдээллийг цахим бүртгэлийн санд оруулах,
- з) эм найруулах, түгээх тоног төхөөрөмж, савыг бэлтгэх, цэвэрлэх, ариутгалд өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эм зүйн техникч
- Эм зүйн туслах техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2262 Эм зүйч

**3214 ЭМЧИЛГЭЭ, ХИЙМЭЛ ШҮДНИЙ ТЕХНИКЧ**

Эмчилгээ, хиймэл шүдний техникч нь хиймэл шүдний хэв гаргах, цутгах, тааруулах, түүнчлэн бусад протез, ортопедын хэрэгслийн засвар, үйлчилгээ хийх зэрэг ажлыг эмч, эмнэлгийн мэргэжилтний заавраар стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өвчтөн эмчийн үзлэгт ороход нь туслах, шаардлагатай багаж хэрэгслэлийг тодорхойлох, хэмжээ авч, тааруулах,
- б) биеийн болон шүдний гэмтэл, согогыг засах, олон төрлийн протез, ортопед хэрэгслэл хийх, засах,
- в) өвчтөнд тохирох протезыг эмч, эмнэлэгийн мэргэжилтэнтэй ярилцаж, зөвлөлдөх, эмчид туслах,
- г) протез, ортопедын үйлдвэрлэсэн газар, ашиглаж хийсэн материал, тусгай зориулалт, хэрэглэх зааврын талаар үйлчлүүлэгч нарт тайлбар, зөвлөгөө өгөх,
- д) өвчтний их бие, үе мөч, ам, шүд зэргээс хэмжээ авч, эмчилгээнд хэрэглэгдэх материал, багаж хэрэгслэлийг бэлтгэх, хэв цутгах,

- е) хуванцар, төмөр, савх зэрэг материал ашиглан эмчийн заавар, холбогдох стандарт шаардлагын дагуу протезын загвар гаргах, хийх,
- ж) протез, ортопедыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тааруулж, протез таарсан эсэх, ая тухтай байдлыг шалгах, зохих хэмжээнд хөдөлгөөнд орж, биед зохицож байгаа эсэхийг шалгах,
- з) протез, ортопедыг зааврын дагуу засварлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хиймэл шүдний техникч
- Хиймэл шүд хийгч
- Протезын техникч
- Ортопедын техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5329 Шүдний туслах ажилтан

**БАГА БҮЛЭГ 322**

**СУВИЛАХУЙ БОЛОН ЭХ БАРИХУЙН ТУСЛАХ АЖИЛТАН**

Асаргаа, сувилахуй болон эх барихуйн туслах ажилтан нь бие бялдарын болон сэтгэцийн хувьд өвчтэй, гэмтэж бэртсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, амаржсан болон амаржсаны дараах эхчүүд, эрүүл мэндэд нь эрсдэл учирсанаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэрэгтэй болсон бусад хүмүүсийг асарч сувилан, эмнэлгийн тусламж үзүүлнэ. Туслах мэргэжилтэн нь эмчилгээний, асаргаа сувилгааны, эх барихын болон эмнэлгийн бусад мэргэжилтний удирдлаган дор, эрүүл мэндийн болон эмчилгээний холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусалж ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Эмч, мэргэжилтний гаргасан эмчилгээ, асаргааны хөтөлбөр, зааврын дагуу өвчтнүүдийг асарч сувилан, эмчилгээ хийх, зөвлөгөө өгөх, эмээр анагаах болон эмчилгээний арга хэмжээ авахад нь эмч, мэргэжлийн сувилагч, эх баригчид туслах, шарх цэвэрлэх ба мэс заслын боолт хийх, хувь хүн, гэр бүл, олон нийтэд эрүүл мэнд, жирэмслэлтээс хамгаалах, жирэмслэлт болон төрөлттэй холбогдсон асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, жирэмсэний болон төрөлтийн явцад хяналт тавих, эх барих буюу эх барихад туслах, өвчний шинж тэмдгийг илрүүлж нарийн мэргэжлийн эмчид шилжүүлэх, амаржсаны дараа эх, нярай хүүхдийг асрах зэрэг багтана.

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **3221 Сувлахуйн туслах ажилтан**

#### **3222 Эх барихуйн туслах ажилтан**

#### **3221 СУВИЛАХУЙН ТУСЛАХ АЖИЛТАН**

Сувилахуйн туслах ажилтан нь өндөр настан, бэртэл гэмтэл, өвчин, биеийн болон мэдрэлийн хувьд бусдын асаргаа, сувилгаа шаардлагатай хүнийг асарч сувилах ажлыг гүйцэтгэнэ. Тэд ихэвчлэн эмч, сувилагч нарын хяналтын дор эмчилгээ, сувилагаа, асаргааны ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) өвчтөн тус бүрд эрүүл мэндийн мэргэжилтний гаргасан асаргааны төлөвлөгөөний дагуу тэднийг асарч, сувилах,
- б) нэмэлт асаргаа шаардлагатай өвчтөн болон түүний ар гэрийн хүнийг эрүүл мэндийн мэргэжилтэнтэй уулзахыг зөвлөх, өвчтөний биеийн байдал ба эмчилгээний үр дүнг ажиглах, өвчтөнд эм уулгах, шарх цэвэрлэх, боох, сувилах,
- в) өвчтөний биеийн байдал, эмчилгээний талаар байнга тэмдэглэл хөтлөх,
- г) өвчтөний асаргаа, сувилгааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд туслах,
- д) яаралтай тусламжийн үед анхны тусламж үзүүлэхэд туслах зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сувилахуйн туслах ажилтан
- Дадлагажигч сувилагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                      |
|------|--------------------------------------|
| 2221 | Мэргэжлийн сувилагч                  |
| 5321 | Эмнэлэг ба клиникийн туслах сувилагч |
| 5322 | Гэрээр ажилладаг туслах сувилагч     |

#### **Тайлбар:**

Мэргэжлийн болон туслах ажилтны ажлын ялгаа нь тэдний гүйцэтгэж байгаа ажил үүргээс хамаарна.

#### **3222 ЭХ БАРИХУЙН ТУСЛАХ АЖИЛТАН**

Эх барихуйн туслах ажилтан нь нярай хүүхдийг эх барих буюу эмч, эх барихын мэргэжилтэнд туслах, төрөхийн өмнөх болон амаржсаны дараа



эх, нярай хүүхдэд сувилгаа хийх, нярай хүүхдийг арчлах талаар эцэг, эхэд зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Эмэгтэйчүүд, гэр бүл, олон нийтэд эрүүл мэнд, хоол тэжээл, эрүүл ахуй, дасгал хөдөлгөөн, төрөлт, хөхөөр хооллох, нярайн асаргаа, гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, амьдралын хэв маяг зэрэг жирэмслэлт, төрөлттэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх,
- б) Жирэмсний болон хүүхэд төрөх явцад хяналт тавих, хүндрэлтэй шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эх баригч, эмч, мэргэжилтэнд шилжүүлэх,
- в) Ихэнх тохиолдолд мэргэжлийн эмчийн буюу эх баригчийн зааварчилгын дагуу үйлчилгээ үзүүлэх, туслах,
- г) Эмэгтэйчүүд, төрсөн эх, нярай хүүхдэд асаргаа, дэмжлэг үзүүлж, тэдний эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, ямар нэгэн хүндрэл гарсан тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэх, эх баригч болон мэргэжилтний ажилд туслах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эх барихуйн туслах ажилтан
- Уламжлалт аргаар эх баригч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2221 Сувилахуйн мэргэжилтэн
- 2221 Сувилахуйн мэргэжилтэн
- 2221 Нарийн мэргэжлийн сувилагч
- 5321 Туслах сувилагч
- 2222 Эх барихуйн мэргэжилтэн
- 5321 Эмнэлэг, асаргааны туслах ажилтан

**БАГА БҮЛЭГ 323**

**УЛАМЖЛАЛТ, ХАВСАРГА АНАГААХЫН ТУСЛАХ/ ДЭД АЖИЛТАН**

Уламжлалт болон хавсарга анагаахын туслах/дэд ажилтан нь хүнийг бие махбодь болон сэтгэцийн өвчин эмгэгээс сэргийлэх, зөвлөгөө өгөх, асрах, өвчин эмгэгийг уламжлалт аргыг үндэслэн өвс, ургамал, эмийн бүтээгдэхүүнийг хэрэглэн анагаах, тухайн нутгийн иргэд, эртнээс хэрэглэж заншсан, сүсэглэж ирсэн эмчилгээний аргын тусламжтайгаар болон итгэл, үнэмшлийн үндсэн дээр хүний бие махмодь ба сэтгэцийн өвчнийг эмчилнэ.

Өвчтөнд үзлэг хийх, тэдэнтэй болон гэр бүлийнхэнтэй нь ярилцах замаар тухайн хүний эрүүл мэндийн байдал, биеийн болон сэтгэцийн өвчин эмгэгийн орчин, хууч өвчнийг тодорхойлох, тухайн өвчинд уламжлалт болон орчин үеийн эмчилгээний эм, тарианы жор, шаардлагатай эмчилгээний зааврыг бичиж өгөх ба эмчлэх, эмийн өвс, ургамал хэрэглэх, хорхой шавьж, амьтны гаралтай зүйлээр ханд бэлтгэх, хүний төрөл бүрийн ясны бэртэл, үе мултрах зэрэг өвчнийг уламжлалт эмчилгээний арга болох бариа заслаар эмчлэх үүрэг хүлээдэг.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна.

### **3230 Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд ажилтан**

#### **3230 УЛАМЖЛАЛТ, ХАВСАРГА АНАГААХЫН ТУСЛАХ/ДЭД АЖИЛТАН**

Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд ажилтан нь хавсарга анагаахын болон эмнэлэгийн мэргэжилтний удирдамж, зааварчлагын дагуу хүний биеийн болон сэтгэцийн өвчин эмгэг, гэмтлийг анагаах, тухайн нутгийн ард түмний хэрэглэж заншсан уламжлал, шашин шүтлэг, сүсэглэн ирсэн эмчилгээний арга дээр тулгуурлан өвс, ургамал буюу эмийн бус эмчилгээгээр зөвлөгөө өгөх, эмчлэх ажлыг эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Эмчилгээний тэмдэглэл, эмийн жорийг судалж, өвчтөнд үзлэг хийх, өвчтөнтэй болон гэр бүлийн гишүүдтэй нь ярилцах замаар тухайн хүний эрүүл мэндийн байдал, биеийн болон сэтгэцийн өвчин, эмгэгийг тодорхойлох,
- б) Тухайн өвчинд уламжлалт, хавсарга анагаах болон орчин үеийн эм, тарианы жор дээр тулгуурлан эмчлэх, биеийн тамирын дасгал хийх, судаснаас цус авах, өвс, ургамал хэрэглэх, хорхой шавьж, амьтны гаралтай зүйлээр ханд бэлтгэх,
- в) Өвчин, ясны бэртэл, үе мултрах зэрэг өвчний үед ардын уламжлалт эмчилгээний арга болох бариа засал, эмийн өвс, ургамлыг хэрэглэн эмчлэх,
- г) Эрүүлэнх амьдралын хэв маягийг бий болгох, эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах үүднээс хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэнд, хоол тэжээл, эрүүл орчин, эрүүл амьдралын хэв маягийн талаар зөвлөгөө өгөх,
- д) Өвчтөнг эмнэлэгийн мэргэжилтэнд шилжүүлэх, төрөл бүрийн эмчилгээний үр дүнг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн бусад байгууллагатай мэдээлэл солилцох.

**Энэ нэгж бүлэгт хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Бариач
- Эмийн өвс, ургамал цуглуулагч
- Домч
- Бумба тавих, хануур, зүү, төөнөөр эмчлэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 2230 | Зүү тавигч  |
| 3230 | Өвс, ургамалаар эмчлэгч                                 |
| 2230 | Уламжлалт чанар, аргаар эх баригч                       |
| 2230 | Цэгэн иллэг, эмчлэгч                                    |
| 3255 | Усан эмчилгээ, эмчлэгч                                  |
| 2230 | Нуруу, хүзүү болон биеийн бусад хэсгийн өвчнийг эмчлэгч |
| 3259 | Ясны эд эсийг засаж эмчлэгч                             |
| 3413 | Сэтгэл засал/итгэл үнэмшил, сүжиг бишрэл/-аар эмчлэгч   |
| 3259 | Бариач  |
| 3230 | Домч/домногч  |
| 3230 | Бумбаар эмчлэгч   |
| 3255 | Био тогоор эмчлэгч                                      |

**БАГА БҮЛЭГ 324**

**МАЛ ЭМНЭЛЭГИЙН ТЕХНИКЧ, ТУСЛАХ АЖИЛТАН**

Мал эмнэлэгийн техникч, туслах ажилтан нь малын онош тогтоох, урьдчилан сэргийлэх, эмчлэх үүргийг малын эмчийн зааварчлага, зөвлөгөө, хяналтын дор гүйцэтгэнэ. Мал эмнэлэгт түр байрлан эмчлүүлж байгаа мал амьтныг асарч сувилан, малын эмчид үзлэг, эмчилгээ, мэс засал хийхэд багаж хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж, материалыг бэлтгэх зэргээр тусална.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мал, амьтны өвчин, гэмтлийг анагаах талаар хувь хүн, олон нийтэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, өвчтэй мал, амьтны өвчний оношийг тогтоох зорилгоор үзлэг хийх, хүндрэлтэй зарим тохиолдлыг малын эмчид шилжүүлэх, ердийн өвчин, эмгэгээр өвчилсөн болон гэмтэж бэртсэн мал, амьтдыг эмчлэх, мал, амьтанд үзлэг, эмчилгээ хийхэд шаардагдах багаж хэрэгсэл, материалыг бэлтгэх, цэвэрлэж ариутгах, мал, амьтныг зохиомлоор хээлтүүлэхтэй холбогдсон техникийн чанартай ажил үүргийг гүйцэтгэх, үзлэг, эмчилгээ хийхэд мал амьтныг бэлтгэх, эмчилгээний үеэр тэднийг барьж өгөх, эмчилгээний үед мал амьтныг мэдээ алдуулах болон хүчил төрөгчөөр хангахад малын эмчид туслах, мал амьтныг хагалгааны

дараа мэс заслын дараах эмчилгээний тасагт шилжүүлэх, мал, амьтны биеийн байдлыг хянах зэрэг багтана.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **3240 Мал эмнэлгийн техникч, туслах ажилтан**

#### **3240 МАЛ ЭМНЭЛГИЙН ТЕХНИКЧ, ТУСЛАХ АЖИЛТАН**

Мал эмнэлгийн техникч, туслах ажилтан нь малын эмчийн зааварчлага, ажлын дүрэм журмын хүрээнд зөвлөгөө өгөх, оношилгоо хийх, урьдчилан сэргийлэх үүргийг гүйцэтгэнэ.

Мал амьтныг эмчлэх тоног төхөөрөмж, материалыг бэлтгэх, байнгын ажиллагаатай байлгах мал, амьтныг эмчилгээнд оруулах бэлтгэлийг хангаж малын эмчид туслах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаанд хяналт тавина. Иргэн, хуулийн этгээдийн малд хөврөл үр шилжүүлэн суулгах болон зохиомол хээл түүлгийг технологийн дагуу хийж үйлчлэх, малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) олон нийт, хувь хүнд мал, амьтны өвчин гэмтлийг эмчлэх талаар зөвлөгөө өгөх,
- б) мал, амьтанд үзлэг хийх, оношлох, өвчний хүнд хэлбэр болон шаардлагатай тохиолдолд малын эмч рүү шилжүүлэх,
- в) мал амьтны ердийн өвчин болон гэмтлийг ялангуяа олныг хамарсан өвчнийг эмчлэх,
- г) мал, амьтанд үзлэг, эмчилгээ хийсний дараа үзлэгийн ширээ, багаж хэрэгслийг цэвэрлэх ариутгах,
- д) мал, амьтныг зохиомлоор хээлтүүлэхтэй холбоотой техникийн чанартай ажлыг гүйцэтгэх,
- е) мал, амьтныг үзлэгт бэлтгэх, үзлэг, эмчилгээ хийхэд бэлтгэх,
- ж) малын эмчид амьтныг эмчлэх, эмчилгээний үед мэдээ алдуулах, хүчилтөрөгчжүүлэх ажилд туслах,
- з) мал, амьтны биеийг сайжруулах зорилгоор эмчилгээ хийгдсэн малыг хашаа, саравчинд оруулах, биеийн байдлыг хянах,
- и) рентгэн зураг авах, эд, эсийг шинжилгээнд цуглуулах, малын өвчнийг оношлох, эмчлэх ажилд шаардлагатай судалгаа, туршилт хийх.
- к) үйлчлүүлэгч-иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан тэдгээрийн цөм сүргийн малд зохиомол хээлтүүлэг хийх
- л) малын зохиомол хээлтүүлэг, ширгэлт, төллөлтийн график гарган хээлтүүлгийг технологийн дагуу явуулах

м) зохиомол хээлтүүлэг хийсэн малд хээлийн шалгалт хийж, ажлын үр дүнг цаг тухайд нь тооцож байх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зохиомол үр суулгагч
- Малын эмчийн туслах
- Малын сувилагч
- Мал, амьтныг вакцинжуулагч
- Малын үржлийн ажлын тоо бүртгэгч
- Биотехнологийн үйлдвэрлэлийн нарийн тоног төхөөрөмжийн инженер, техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2250	Малын эмч
5164	Гэрийн тэжээвэр амьтан маллагч
5164	Малын эмчийн туслагч

**БАГА БҮЛЭГ 325**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БУСАД ТУСЛАХ/ДЭД АЖИЛТАН**

Эрүүл мэндийн бусад туслах/дэд ажилтан нь эмнэлгийн эмчилгээний тэмдэглэл, баримт бичгийг бүртгэлийн системд оруулах, хамт олны эрүүл ахуй, шүдний болон физик эмчилгээ, хүрээлэн буй орчны эрүүл ахуй, эмнэлэгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд тусална. \_

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) урьдчилан сэргийлэх, шүд амны өвчнийг эмчлэх, эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх,
- б) хамт олон, хувь хүнд эрүүл ахуй, хоолны дэглэмийн талаар болон бусад эрүүл мэндийн эрсдэлтэй байдлыг багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
- в) өвчтний эрүүл мэндийн түүх, эмчилгээний тэмдэглэл хөтлөх, эрүүл мэндийн байдал, үзлэгийн хуваарь гаргах,
- г) үйлчилгээний төлбөр тооцоонд хяналт тавих, үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн байдлаа сайжруулах талаар зайлшгүй мэдэх шаардлагатай зааврыг гэр бүлд өгөх,
- д) ариун цэвэр, эрүүл ахуй, халдварт өвчний тархалтын талаар зөвлөгөө өгч, энэ талаар боловсрол олгох,
- е) харааны шил тааруулах, олгох,
- ж) хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх орчны болон ажлын байрны хэвийн бус нөхцлийн талаар гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавих,

- з) хүний биеийн зөөлөн эдэд иллэг хийх,
- к) өвчтөнд үзлэгийн өрөөг зааж өгөх, тэднийг үзлэгт бэлтгэх,
- л) аваар, осолд өртсөн тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна.

**3251 Шүдний эмчилгээний туслах эмчлэгч**

**3252 Эмчилгээний тэмдэглэл, эрүүл мэндийн мэдээллийн техникч**

**3253 Өрхийн ба бүлгийн эрүүл мэндийн ажилтан**

**3254 Харааны шилний мэргэжилтэн, шил олгогч**

**3255 Нөхөн сэргээх эмчилгээний техникч, туслах ажилтан**

**3256 Эмнэлэгийн туслах ажилтан**

**3257 Хүрээлэх орчны болон аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагч, туслагч**

**3258 Яаралтай тусламжийн ажилтан**

**3259 Энэ ангилалд ороогүй эрүүл мэндийн туслах мэргэжилтэн**

### **3251 НҮҮР АМНЫ ЭМЧИЛГЭЭНИЙ ТУСЛАХ, ЭМЧЛЭГЧ**

Нүүр амны эмчилгээний туслах, эмчлэгч нь шүдний өвчний анхан шатны эмчилгээний үйлчилгээг үзүүлэх, шүд амны гажигийг шүдний эмч, болон амны эрүүл ахуйн эмчийн зааварчилгааны дагуу хийж гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Олон нийт, хувь хүнд шүдний эрүүл ахуй, амны хөндийн эрүүл ахуйн талаар зөвлөгөө өгөх,
- б) Өвчтөний шүд, амны хөндийн эрүүл ахуйн үзлэг хийх,
- в) Өвчтөний амны хөндийн эрүүл ахуйн байдал сул, амны хөндийн өвчнийг шаардлагатай тохиолдолд шүдний эмч болон холбогдох бусад эмчид шилжүүлэх,
- г) Шүдний иж бүрэн эмчилгээний үед эмчид туслах,
- д) Шүдэнд фторжуулах эмчилгээ хийх, цэвэрлэх, шүдний ломбо бэлтгэх, хэсэгчилэн мэдээ алдуулах зэрэг эмчилгээний анхан шатны эмчилгээг хийх,
- е) Шүд эмчилгээний болон үзлэгийн үеэр хэрэглэгдэх багаж хэрэгслийг ариутгаж, цэвэрлэж, халдваргүйжүүлэх,
- ж) Өвчтөнийг үзлэгт бэлтгэх, эмчилгээг тайлбарлах, өвчтөнийг зөв байрлалд суулгах,

- з) Шүдний болон амны хөндийн рентген зураг авах, хиймэл шүд хийх, оношлоход шүдний эмчид туслах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нүүр амны эмчийн туслах ажилтан
- Нүүр амны эрүүл ахуйч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2261	Нүүр амны эмч /шүдний эмч/
3214	Эмчилгээ, хиймэл шүдний техникч
3214	Хиймэл шүд хийгч

**3252 ЭМЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНИКЧ**

Эмчилгээний тэмдэглэл, эрүүл мэндийн мэдээллийн техникч нь өвчтөний эмчилгээний болон эрүүл мэндийн талаарх бичиг баримт, тэмдэглэлийг хууль болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх ёс зүйн үндсэн дээр бүрдүүлэх, эмнэлгийн бичиг баримт хадгалах төхөөрөмжид хадгалах, лавлагаа өгөх үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Эрүүл мэндийн талаарх эмчилгээний тэмдэглэл, бусад бичиг баримтыг эмнэлэгийн бичиг баримт хадгалах системд оруулж кодлох, баяжуулах, ангилах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх,
- б) Өвчтөний эмчилгээний тэмдэглэл, төлбөрийн баримт, эргэн үзүүлэх хуваарь, эмчилгээний явц зэрэг мэдээллийг бичиг хэрэг, архивын заавар журмын дагуу хадгалах, мэдээлэх,
- в) Баримтыг нөхөн бүрдүүлэх,
- г) Эмчийн амаар хэлсэн зөвлөгөө, эмчилгээг тэмдэглэн өвчний түүх болон бусад эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээний тэмдэглэл хөтлөх,
- д) Эмнэлгийн бичиг баримт боловсруулах, бүрдүүлэх, хадгалах ажлын талаар бусад ажилтанд зөвлөгөө өгөх, хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмнэлгийн бичиг баримтыг кодлогч
- Өвчний бүртгэл, мэдээллийн техникч
- Эрүүл мэндийн мэдээллийн техникч
- Эмчилгээний тэмдэглэлийн шинжээч
- Эмнэлгийн бичиг баримтын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

4132	Баримт, мэдээлэл оруулах операторч
4132	Баримт, мэдээлэл бүрдүүлэх ажилтан
3344	Анагаахын нарийн бичгийн дарга

**3253 ӨРХИЙН БА БҮЛГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН**

Өрхийн ба бүлгийн эрүүл мэндийн ажилтан нь хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндээ хамгаалах, анхан шатны тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар өрхийн болон бүлгийн сургалт зохион байгуулна. Эрүүл мэндийн ажилтан нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний тогтолцооны талаар хувь хүн хамт олонд зөвлөгөө, туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Өрхийн болон хамт олны хүрээнд хоол хүнс, эрүүл ахуй, нярай хүүхдийн асаргаа, дархлаажуулалт, гэр бүл төлөвлөлт, нийтийг хамарсан халдварт өвчнөөс сэргийлэх, эрсдэлтэй хүчин зүйлүүд, хордлогоос урьдчилан сэргийлэх, энгийн болон нийтийг хамарсан өвчний үед хэрхэн анхан шатны тусламж үзүүлэх, уусмал хэрэглэх, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг сэдвээр мэдээлэл, зөвлөгөө өгөх,
- б) Айл өрхөөр очиж эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл хийж, зөвлөгөө өгөх,
- в) Өрхийн жирэмсэн эх, нярай хүүхдийн өсөлт хөгжилт, орчны эрүүл ахуйн байдлын талаар зөвлөгөө өгөх,
- г) Сүрьеэ, гэдэсний суулгах өвчин зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эмнэлгийн тусламжийн эм болон эмийн барааг өрхөд тараах, тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар зааварчилгаа өгөх,
- д) ДОХ, бэлгийн замын халдварт өвчин тусах өндөр магадлал бүхий иргэдэд өвчний талаар мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх анхан шатны хэрэгсэл тараах,
- е) Эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаггүй өрх, хамт олны тоог гаргаж, эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулж, эрүүл мэндийн байдлыг тогтоох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Олон нийтийн эрүүл мэндийн тусламжийн ажилтан
- Олон нийтийн эрүүл мэндийг дэмжигч
- Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан
- Баг, хорооны эрүүл ахуйн ажилтан



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3230	Уламжлалт, хавсарга анагаахын туслах/дэд ажилтан
3222	Уламжлалт аргаар эх баригч
5322	Гэрээр асрах үйлчилгээний ажилтан

**3254 ХАРААНЫ ШИЛНИЙ МЭРГЭЖИЛТЭН, ШИЛ ОЛГОГЧ**

Харааны шилний мэргэжилтэн нь нүдний эмч, хараа зүйн мэргэжилтний бичсэн зааврын дагуу нүдний шил тааруулж, шилний загвар гаргах ба зөвлөгөө өгнө. Үйлчлүүлэгчид таарсан харааны шил, контакт линзийг хийж үйлчилнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Үйлчлүүлэгчийн харааг шалгах, харааны шил тааруулах болон бусад үйлчилгээг үзүүлэх,
- б) Үйлчлүүлэгчийн нүүрнээс хэмжээ авч, харааны шил, шилний хүрээ сонгох, контакт линзний төрөл болон шилний бусад үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх,
- в) Харааны шилний лабораторийн ажил, шил хүрээнд тааруулах, контакт линз бэлтгэх зэрэг ажилбарт туслах,
- г) Харааны шилний бүтэн байдлыг шалгах, эмчийн бичсэн заавартай тохирч байгаа эсэхийг шалгаж үйлчлүүлэгчид тааруулах, шил олгох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Харааны шилний мэргэжилтэн
- Харааны шил олгогч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2212	Нүдний эмч
2267	Нүдний хараа зүйч, хараа хэмжигч
2267	Нүдний харааны шил олгогч

**3255 НӨХӨН СЭРГЭЭХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКЧ, ТУСЛАХ АЖИЛТАН**

Нөхөн сэргээх эмчилгээний техникч, туслах ажилтан нь өвчтөнд өвчин эмгэг болон гэмтлийн үед гараар болон ультра авиа, шарлага, лазер ба бусад аргаар анагаах эмчилгээг хийнэ. Эмчилгээг нөхөн сэргээх эмчилгээний эмч, эрүүл мэндийн ажилтны зааврын дагуу нөхөн сэргээх ажилбарыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Иллэг, цэгэн барианы эмчилгээ зэргийг гар ажиллагаагаар хийж эмчлэх,
- б) Цахилгаан, хэт авианы эмчилгээг хэт улаан гэрэл зэрэг тусгай техник, тоног төхөөрөмжийг ашиглан, уусмалын нойтон жин тавих, өвс ургамал, эрдэс бодисоор эмчлэх,
- в) Өвчтөнд биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг заах, аюлгүй байдлыг хангах, дасгал хөдөлгөөн хийх арга зүй, хөдөлгөөний идэвхтэй байдлын талаар зааварчилгаа өгөх,
- г) нөхөн сэргээх эмчилгээний эмч, эрүүл мэндийн ажилтны зааварчилгааны дагуу эмчилгээг төлөвлөж, зохион байгуулах,
- д) Эмчилгээний явцад өвчтөний биеийн байдал сайжирч байгаа талаар хяналт тавьж мэдээлэх, зөвлөх,
- е) Өвчтөнд булчин чангалах бүс, протез хэрэглэж дасах, түүнчлэн таяг зэрэг төхөөрөмжийг хэрэглэхэд туслах, зааварчилгаа өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цэгэн бариа, иллэгийн ажилтан
- Цахилгаан эмчилгээний ажилтан
- Усан засалч
- Нөхөн сэргээх эмчилгээний ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 2269 | Нөхөн сэргээх эмчилгээний эмч                   |
| 3259 | Нуруу, хүзүү болон биеийн бусад хэсгийг эмчлэгч |

**3256 ЭМЧИЛГЭЭНИЙ ТУСЛАХ АЖИЛТАН**

Эмчилгээний туслах ажилтан нь эмчилгээний үндсэн үүргийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтний шууд удирдлага дор өвчтөнийг асарна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Өвчтөний биеийн байдал, өвчний эмчилгээний тэмдэглэлийн талаар өвчтөн болон ар гэр гэрийнхэнтэй ярилцах,
- б) Эмч, эмнэлэгийн мэргэжилтэн өвчтөнд үзлэг хийх, тариа хийх, хагалгааны оёдол авах зэрэг эмчилгээний ажилбарт туслах,
- в) Өвчтөнд үзлэгийн өрөөг зааж өгөх, үзлэгийг тайлбарлах зэргээр өвчтөнийг үзлэг, эмчилгээнд бэлтгэх,
- г) Эмнэлэгийн үзлэгт шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг суурилуулах, бэлдэх, ариутгах, устгах,
- д) Лабораторийн шинжилгээнд зориулж цус авах, эд эсийн дээж авах,

- е) Эмч, мэргэжилтний зааварчилгааны дагуу өвчтөн, түүний гэр бүлийнхэнд өвчин, эмчилгээний талаар мэдээлэл өгөх,
- ж) Эмчийн бичсэний дагуу эм олгох, эмийн санг шаардлагатай эмээр хангах,
- з) Өвчтөн, үзлэгийн өрөөг үзлэгт бэлтгэж, ариун цэврийг хангах,
- к) Өвчтөний өвчний түүх, онош, шинжилгээний хариу, эмчилгээний явц, үр дүн, тэмдэглэл болон бусад мэдээллийг эмнэлгийн баримт хадгалалтын системд оруулан хадгалах,
- л) Өвчтөнд үзлэг хийх хуваарийг гаргах, тооцооны хуудас, эрүүл мэндийн даатгал зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэх, бүрдүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмнэлэгийн туслах ажилтан
- Эрүүл мэндийн туслагч
- Нүдний эмчилгээний туслах ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2240	Яаралтай тусламжийн туслах ажилтан
3214	Эмчилгээ, хиймэл шүдний техникч
3251	Шүдний эмчилгээний туслах ажилтан
3255	Нөхөн сэргээх эмчилгээний туслах ажилтан
5329	Эмнэлэгийн хараа зүйн туслах ажилтан

**3257 ХҮРЭЭЛЭХ ОРЧНЫ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРҮҮЛ АХУЙН БАЙЦААГЧ, ТУСЛАХ АЖИЛТАН**

Хүрээлэх орчны, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн байцаагч, туслагч нь орчны болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс, ажлын байр, үйлдвэрлэл үйлчилгээний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбогдсон дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана. Мөн эмнэлгийн мэргэжилтний шууд удирдлага, зааварчлагын дор орчны аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд оролцож болно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Ажил олгогч болон ажилтан, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээн ажиллаж байгаа ажилтанд зөвлөгөө өгөх,
- б) Хөдөлмөрийн нөхцөл, машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй болон хүрээлэн буй орчны эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах,
- в) Орчны болон техникийн эрүүл ахуйн талаар зөвлөгөө өгөх,
- г) Ажлын нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын байрны болзошгүй

- ослын талаар ажил олгогч, ажилтантай ярилцах, олон нийтийн дунд судалгаа явуулах, ажлын байранд гарсан ослыг шалгах, холбогдох арга хэмжээ авч, мэдээлэл хөтлөх,
- д) Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, тээвэрлэлт, хадгалалын нөхцөл, борлуулалт болон орчны аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг шалгах,
- е) Хүн амын гол хэрэглээний бараа, хоол хүнс, эм, гоо сайхны бараа зэрэг бүтээгдэхүүний эрүүл ахуйн стандарт, аюулгүй байдлын талаарх хууль, дүрэм журмыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх, сурталчлах,
- ж) Стандарт, шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүнийг устгах ажлыг зохион байгуулах, устгалд хяналт тавих, тайлагнах,
- з) Эрүүл ахуйн нөхцөл байдал, ус, агаар, хүнс, хөрсний бохирдолоос сэргийлэх эрүүл ахуйн байдлыг сайжруулах ажлыг санаачлан зохион байгуулах,
- к) Хүний бие махбодь, агаарын бохирдол, хог хаягдлыг зүй зохистой устгах, хүнсний аюулгүй байдал, орчны цэвэрлэгээ, ариутгал, гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан үүсэх төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах,
- л) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хэргэжүүлэхэд шаардлагатай хэрэгслийн тоо, хэмжээ, зардлыг гаргах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын байцаагч
- Эрүүл мэндийн байцаагч
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагч
- Эрүүл ахуйч
- Эрүүл ахуйн байцаагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 2263 | Орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн мэргэжилтэн |
| 2263 | Хөдөлмөрийн эрүүл ахуйч   |
| 2263 | Туяаны хамгаалалтын мэргэжилтэн                                 |

### **3258 ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН АЖИЛТАН**

Яаралтай тусламжийн ажилтан нь бэртэж гэмтсэн хүн, өвчтэй, өндөр настан, хэвтрийн болон эмнэлгийн үйлчилгээ авахаас өмнө бие бялдар, ухаан санааны хувьд муудахаар нөхцөлд байгаа хүмүүст эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) осолд болон байгалийн гамшигт өртсөн, өвчин эмгэг тусч яаралтай тусламж шаардлагатай өвчтний биеийн байдлыг үзэж эмнэлэгийн яаралтай тусламжийн төрөл хэлбэрийг тогтоох,
- б) яаралтай тусламж үзүүлэх журмын дагуу шаардлагатай эм тариаг өвчтөнд хийх, амьсгалын аппарат зэрэг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) тээвэрлэх явцад өвчтөний биеийн байдал, гарч байгаа өөрчлөлтийг ажиглах,
- г) өвчтэй болон гэмтэж бэртсэн хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламжийн талаар үйлчилгээний ажилтан, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх,
- д) өвчтөний биеийн байдал, түүнд үзүүлсэн яаралтай тусламжийн талаар бүртгэл хөтлөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Яаралтай тусламжийн ажилтан
- Яаралтай тусламжийн техникч
- Яаралтай тусламжийн асрагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8322 Яаралтай тусламжийн автомашины жолооч

**Тайлбар:**

Энэ нэгж бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг яаралтай тусламж үзүүлэх арга зарчим, өвчтөнийг эмнэлэгт хүргэх үеийн тээвэр зөөврийн ажил, тусламж үзүүлэх, тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглах, эм тариа зэрэг чиглэлээр эмнэлгийн ажилтны зохих шатны сургалтанд хамрагдаж эзэмшинэ. Яаралтай тусламжийн машины жолооч нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхгүй тул “8322. Машин, такси, болон битүү тэрэгний жолооч” гэсэн нэгж бүлэгт хамаарна.

**3259 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАХ/ДЭД АЖИЛТАН**

Бага бүлэг 325 буюу “Эрүүл мэндийн бусад туслах/дэд ажилтан” гэсэн эрүүл мэндийн үйлчилгээний бусад туслах ажилтан орно.

Эрүүл мэндийн орчин үеийн салбарын /сувилгаанаас бусад/ мэргэжилтэн нь анагаах ухаан, мал эмнэлэг, шүдний эмчилгээ, эм зүй, ариун цэвэр, эрүүл мэндийг сайжруулах болон бусад салбарт судалгаа шинжилгээний ажил хийх, эдгээр салбарын онол, үзэл баримтлал, зарчмыг хэрэгжүүлэх техникийн шинжтэй ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Анагаах ухаан, шүдний эмчилгээ болон мал эмнэлгийн хүрээнд урьдчилан сэргийлэх болон эмчлэх талаар зөвлөх, оношлох тодорхой хэмжээний үүргийг гүйцэтгэх, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах арга хэмжээний талаар зөвлөгөө өгөх, хооллох арга ба хоолны дэгийг боловсруулах мөрдүүлэх, нүдний харааг шалгах, шаардлагатай нүдний шил, контакт линзийг бичиж өгөх, яс булчингийн системийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх талаар зөвлөгөө өгөх, эм, эмийн бүтээгдэхүүнийг бэлтгэх, түгээхэд туслах, гомеопатик эмчилгээ, хэл ярианы болон бусад гажгийг засах эмчилгээ хийх зэрэг орно. Эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн/сувилагчаас бусад/-ээс ажлын удирдамж авч үйл ажиллагаа явуулж болно. Мөн бусад ажиллагчдад хяналт тавих үүрэг гүйцэтгэж болох юм.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

- Хоол судлалын мэргэжилтэн
- Оптометрч ба харааны шилний мэргэжилтэн
- Шүдний эмнэлгийн туслах
- Нөхөн сэргээх эмчилгээний болон бусад холбогдох мэргэжилтэн
- Мал эмнэлгийн туслах ажилтан
- Эм зүйн туслах ажилтан

---

**ДЭД БҮЛЭГ 33****БИЗНЕС, УДИРДЛАГЫН ТУСЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

---

Бизнес, удирдлагын туслах мэргэжилтэн нь ихэвчлэн санхүүгийн нягтлан бодох бүртгэл, гүйлгээтэй холбоотой асуудлууд, математик тооцоолол, хүний нөөцийг хөгжүүлэх, санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр өөрийн мэдлэгт тулгуурлан ажиллана. Гаалийн бүрдүүлэлт хийх, хурал зохион байгуулах, ажлын байранд зуучлах, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхлэгч, биеийн тамир, спортын болон урлагийн тоглолтыг зохион байгуулагч агент энэ дэд бүлэгт бас хамаарна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хөрөнгийн зах зээлд үнэт цаас, хувьцаа, бонд болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах болон худалдан авах, захиалгыг хүлээн авах, шилжүүлэг хийх, валют арилжаалах, зээлийн өргөдлийг удирдлагад өгч

шийвэрлүүлэх, зээл олгох шаардлагыг хангасан байгууллагад зээлийн хэмжээг нь харгалзан олгох эс олгохыг шийдэх, нягтлан бодогчийн заавраар данс хөтлөлтийн зарчмын дагуу санхүүгийн гүйлгээний бүх баримт бичгийг хөтлөх, математик тооцооллын эрсдлийн болон статистик тооцоо төлөвлөлт хийхэд туслах, санхүүгийн хэрэгслийг худалдах болон худалдан авах зэрэг багтана.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 331 Санхүү, математик тооцооллын мэргэжилтэн**
- 332 Борлуулалт, худалдан авалтын агент, брокер**
- 333 Бизнес үйлчилгээний агент**
- 334 Удирдлагын болон төрөл мэргэжлийн нарийн бичгийн дарга**
- 335 Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтэн**

#### БАГА БҮЛЭГ 331

#### **САНХҮҮ, МАТЕМАТИК ТООЦООЛЛЫН МЭРГЭЖИЛТЭН**

Санхүү, математик тооцооллын мэргэжилтэн нь өмч хөрөнгө, худалдан авахад мөнгө байршуулах, санхүүгийн гүйлгээний бүх баримтыг хөтлөх, зээл хүсэгчийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэрлүүлэхээр удирдлагад шилжүүлэх, санхүүгийн хэрэгслийг худалдан авах, худалдах болон холбогдох математик тооцооллыг хийх зэрэг ажлыг хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Хөрөнгийн зах зээлд үнэт цаас, хувьцаа, бонд болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдан авах, худалдах захиалгыг хүлээн авах, шилжүүлэг хийх, валют арилжаалах, зээл хүссэн өргөдлийг удирдлагад өгч шийвэрлүүлэх, зээл олгох шаардлагыг хангасан байгууллагад зээлийн хэмжээг харгалзан олгох эсэхийг шийдэх, нягтлан бодогчийн заавраар данс хөтлөлтийн зарчмын дагуу санхүүгийн гүйлгээний бүх баримт бичгийг хөтлөх, математикийн, даатгалын эрсдлийн болон статистик тооцоо төлөвлөн хийж гаргахад туслах, санхүүгийн хэрэгслүүдийг худалдах болон худалдан авах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

- 3311 Үнэт цаас, санхүүгийн диллэр, брокер**
- 3312 Зээлийн мэргэжилтэн**

**3313 Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн**

**3314 Статистик, математик тооцооллын болон түүнтэй адилтгах мэргэжилтэн**

**3315 Эд, хөрөнгийн болон хохирлын үнэлгээ хийгч**

### **3311 ҮНЭТ ЦААС, САНХҮҮГИЙН ДИЛЕР, БРОКЕР**

Үнэт цаас, санхүүгийн дилер, брокер нь зохих шимтгэл авсны үндсэн дээр өөрийн компани ба худалдан авагчийн өмнөөс үнэт цаас, хувьцаа, бонд болон санхүүгийн бусад хэрэгслийг хөрөнгийн зах зээл дээр худалдах, худалдан авах, валютын арилжаа эрхлэх, хувьцаа, үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах талаар үйлчлүүлэгч болон удирдлагад зөвөлгөө өгөх ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөрөнгө оруулах боломжтой худалдан авагч болон компанийн санхүүгийн байдлын талаар мэдээлэл олж авах,
- б) үнэт цаас, бонд, хувьцаа болон валютын зах зээлийн чиг хандлагыг судлан дүн шинжилгээ хийх,
- в) мэдээлэл хүссэн үйлчлүүлэгчид зах зээлийн нөхцөл байдал болон чиг хандлагын талаар мэдээлэл өгөх,
- г) үйлчлүүлэгчийн хөрөнгийг өсгөхийн тулд хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бонд гарган байршуулах, санхүүгийн гэрээ хэлэлцэл зохион байгуулах, гэрээний нөхцөл дээр зөвөлгөө өгөх,
- д) ирээдүйд болон ойрын үед худалдах, худалдан авах үнэт цаас, хувьцаа, бонд болон санхүүгийн бусад хэрэгсэл мөн валютын захиалгыг бүртгэх, шилжүүлэх зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Валютын брокер
- Үнэт цаасны брокер
- Хувьцааны брокер

#### **Өөр газар ангилсан зарим холбогдох ажил, мэргэжил:**

- |      |                                  |
|------|----------------------------------|
| 2413 | Санхүүгийн шинжээч               |
| 3324 | Худалдааны брокер                |
| 3324 | Зах зээлийн бүтээгдэхүүний дилер |
| 4312 | Үнэт цаасны клерк                |



### 3312 ЗЭЭЛЛЭГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Зээлийн мэргэжилтэн нь зээл хүсэгчийн мэдүүлэгт үнэлгээ дүгнэлт, шинжилгээ хийж, зээл олгох эсэх талаар санал боловсруулан удирдлагад танилцуулна.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) төлбөрийн, орон сууцны, хэрэглээний, бизнесийн зэрэг чиглэлээр зээл хүсэгчтэй уулзах,
- б) зээл хүсэгчийн санхүүгийн болон зээлээ эргэн төлөх чадвар, зээл түүх зэргийг нь судлах, үнэлэх,
- в) зээл олгох эсэх талаар удирдлагад санал оруулах,
- г) зээлийн тогтоосон хязгаарын хүрээнд зохих шаардлагыг харгалзан зээл олгох эсэх талаар шийдвэр гаргах,
- д) зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавих, хугацаа хэтэрсэн тохиолдолд төлбөр хийхийг шаардах, зээлдэгч зээл төлөхгүй бол хүлээх хариуцлага, холбогдох хуулийн зохицуулалтыг мэдэгдсэн захидал илгээх, захидлыг бэлтгэх,
- е) зээлийн баримтыг бүрэн бүрдүүлэх зэрэг багтана.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Зээлийн мэргэжилтэн
- Орон сууцны зээлийн эдийн засагч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

1346 Санхүү, даатгалын үйлчилгээний менежер

### 3313 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУСЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Нягтлан бодох бүртгэлийн туслах мэргэжилтэн нь санхүүгийн бүх гүйлгээний төлбөр, тооцоо, тайлан, бүртгэлийг хийж санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох бичиг баримтыг үнэн зөв, нягт нямбай хөтөлнө.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) нягтлан бодогчийн заавар, данс хөтлөлтийн ерөнхий зарчмын дагуу санхүүгийн гүйлгээний бүх баримт материалыг хөтлөх,
- б) төлбөр, тооцоо, санхүүгийн бусад гүйлгээтэй холбоотой баримт бичиг, тайлангийн үнэн зөв байдлыг хангах,
- в) санхүүгийн мэдэгдэл болон тодорхой хугацааны тайланг бэлтгэх,
- г) тэдний ажлын явцад гарч болзошгүй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхийн тулд данс хөтлөлтийн зарчим, хэрэглэх арга барилын талаарх мэдлэгийг ашиглах,

- д) нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, түүнтэй холбоотой тооцооллыг хийхэд зориулагдсан компьютерийн стандарт программ хангамжийг ашиглах,
- е) үнэт цаасны ажилтан болон нягтлан бодогчийн ажилд туслах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Данс хөтлөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 2411 | Нягтлан бодогч  |
| 3314 | Статистик, математик тооцооллын мэргэжилтэн /эрсдлийн удирдлагын менежер/ |
| 4311 | Данс хөтлөлтийн туслах ажилтан  |

**3314 СТАТИСТИК, МАТЕМАТИК ТООЦООЛОЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ТУСЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

Статистик, математик тооцоолол болон түүнтэй адилтгах туслах мэргэжилтэн нь математик, статистик, даатгалын эрсдлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэхэд туслах үйл ажиллагааг математикч, статистикч болон холбогдох мэргэжилтэн нарын удирдамжийн дагуу хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) математик, даатгалын эрсдлийн болон статистик тооцоо төлөвлөн хийж гаргахад туслах,
- б) статистик тооллого, түүвэр судалгаанд шаардагдах материалын болоод хүн хүчний тоо хэмжээ, зардлын нарийвчилсан тооцоог гаргах,
- в) тооллого, түүвэр судалгаанд хэрэглэгдэх бүртгэл, түүврийг хийх, хөтлөх, ашиглахтай холбогдсон техникийн чанартай үүргийг гүйцэтгэх,
- г) математик, даатгалын эрсдэл, статистикийн болон бусад тооцоог гаргахад компьютерийн стандарт программ хангамжийг ашиглах,
- д) математик, даатгалын эрсдэл, статистикийн болон бусад тооцооны үр дүнг хүснэгт болон график хэлбэрээр гаргахад бэлтгэх,
- е) ажлын явцад гарч болзошгүй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэхэд математик, даатгалын эрсдэл, статистикийн болон бусад тооцоо, нягтлан бодох бүртгэлийн зарчим, арга барилын талаарх мэдлэгийг ашиглах,
- ж) статистик клеркийн ажилд хяналт тавих зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Даатгалын эрсдлийн туслах тооцоочин /эрсдлийн удирдлагын туслах менежер/
- Математик тооцооллын туслах ажилтан
- Статистикийн туслах ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2120	Математикч
2120	Статистикч
3313	Туслах нягтлан
4312	Статистикийн клерк

**3315 ЭД БАЯЛАГИЙН ҮНЭЛГЭЭЧИН, ХОХИРОЛ ТОГТООГЧ**

Эд баялагийн үнэлгээчин, хохирол тогтоогч нь өмч хөрөнгө болон төрөл бүрийн эд баялагийг үнэлэх, даатгалд хамрагдсан хөрөнгийн хохирлыг тогтоох ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) түүхий эд, үл хөдлөх хөрөнгө, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хувийн хэрэглээний болон ахуйн бараа, урлагийн бүтээл, гоёл чимэглэлийн зүйлс бусад эд баялагийн чанар, үнийг тодорхойлох,
- б) хохирлын хэмжээ болон даатгалын компаниас олговол зохих нөхөн олговрын хэмжээг тодорхойлох,
- в) ижил төстэй эд зүйлс болон хөрөнгийн худалдааны болон үнийн талаар мэдээлэл цуглуулах,
- г) эд зүйлс, хөрөнгийн хийц, хэмжээ, нөхцөл, байдлыг тандан судлах,
- д) үнэлгээнд хэрэглэсэн арга, хүчин зүйлсийг тусгасан үнийн тайлан бэлтгэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил мэргэжлийн, жишээ:**

- Үнэлгээчин, хохирол тогтоогч
- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээчин
- Нэхэмжлэлийн үнэлгээчин
- Даатгалын үнэлгээчин
- Нэхэмжлэлийн байцаагч
- Хохирол тогтоогч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3339	Дуудлага худалдаа зохион байгуулагч
------	-------------------------------------

**БАГА БҮЛЭГ 332****БОРЛУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАЛТЫН АГЕНТ, БРОКЕР**

---

Борлуулалт, худалдан авалтын агент, брокер нь компани, төрийн болон бусад байгууллагыг төлөөлж үйлдвэрийн, мэргэжлийн, худалдааны байгууллагаас бараа бүтээгдэхүүн, хөрөнгө, даатгал зэргийг худалдан авах, тэдэнд борлуулах, мөн тээврийн зэрэг бусад үйлчилгээг үзүүлэх, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулагч, худалдан авагчидтай бие даасан төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж хамтран ажиллах зэрэг үйл ажиллагаа явуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн чиг хандлага болон нөхцөл байдалд шинжилгээ хийх, ажил олгогч, өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээлэл цуглуулах ба тохирсон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох, үйлчлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг тайлбарлах, таниулах, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, худалдан авах гэрээ хэлцлийн үнэ, ерөнхий нөхцөл, тээврийн талаар тохиролцох зэрэг орно.

Энэ бага бүлэгт ангилсан, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3321 Актуарч****3322 Арилжаа, борлуулалтын төлөөлөгч****3323 Худалдан авагч****3324 Борлуулалтын брокер****Тайлбар:**

Борлуулалтын менежерийг 122 дугаар бага бүлэг буюу “Борлуулалт, маркетинг, судалгаа, хөгжлийн менежер” гэсэн бага бүлэгт, Техникийн, анагаах ухааны, МХТ-ийн борлуулалтын мэргэжилтэнг 243 дугаар бага бүлэг буюу “Борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах мэргэжилтэн” гэсэн бүлэгт, Үнэт цаасны, санхүүгийн дилерийг 331 дугаар бага бүлэг буюу “Санхүүгийн болон математик тооцооллын туслах мэргэжилтэн” гэсэн бүлэгт тус тус ангилсан болно.

**3321 Актуарч**

Даатгалын төлөөлөгч нь хүний амь нас, гэнэтийн осол, автомашин, хариуцлагын, галын, хөлөг онгоцны болон бусад төрлийн даатгалын талаар шинэ үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх, худалдах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

а) даатгалын зохистой төрөл, нөхцөлийг тодорхойлох зорилгоор үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын талаар мэдээлэл олж авах,

- б) даатгалын төрөл, эрсдлийн түвшин, даатгалын хамрах хүрээг тодорхойлох талаар даатгуулагчтай хэлэлцээр хийх,
- в) даатгалын нөхцөл, даатгалын шимтгэлийн хэмжээ болон даатгуулсны ач холбогдлын талаар үйлчлүүлэгчид тайлбарлах, зөвлөгөө өгөх,
- г) даатгалын төрөл, эрсдлээс хамгаалах түвшинг нь сонгох, даатгалын шимтгэлийн хэмжээг тодорхойлж төлбөрийн нөхцөлөө тохиролцоход нь үйлчлүүлэгчид туслах,
- д) дахин даатгалын гэрээ хийх,
- е) томоохон хэмжээний эсвэл тусгай төрлийн төсөл, суурилуулах ажил, эрсдэлд даатгалын гэрээ байгуулах нөхцөлийг хэлэлцэх, зөвөлгөө өгөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Даатгалын агент
- Даатгалын брокер
- Даатгалын гэрээ байгуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1346	Даатгалын менежер
3315	Даатгалын үнэлгээчин
3311	Үнэт цаасны дилер
4312	Даатгалын ажилтан

**3322 Арилжаа, борлуулалтын төлөөлөгч**

Арилжаа, борлуулалтын төлөөлөгч нь бизнес эрхлэгчид болон бусад байгууллагад төрөл бүрийн бараа, үйлчилгээг худалдаалах бөгөөд шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүнтэй холбогдолтой мэдээлэлээр хангана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) барааны захиалгыг авч бөөний болон жижиглэнгийн худалдааны байгууллага, үйлдвэрийн газар болон бусад байгууллагад худалдах,
- б) техник тоног төхөөрөмж, сэлбэг болон холбогдох үйлчилгээг хувь хүн, аж ахуйн нэгжид үзүүлэх,
- в) захзээлийн нөхцөл байдал, ажил олгогч, өрсөлдөгч нарын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл олж авах, түүнийгээ шинэчлэж байх,
- г) тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний үзүүлэлт, ажиллагааны талаар тодорхой мэдээллийг худалдан авагчид өгөх, уг бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглахыг зааж өгөх,
- д) захиалга авч хүргэх, үнэ болон зээлийн нөхцөлийг тогтоох,
- е) хэрэглэгчийн хүсэл сонирхолыг үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчид мэдээлэх,

ж) хэрэглэгч болон худалдан авагчийн сэтгэл ханамжийг судлах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Борлуулалтын дараахь үйлчилгээний зөвлөх
- Ухуулга зар сурталчилгааны ажилтан
- Хөдөлгөөнт /явуулын/ худалдаачин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1221	Борлуулалт, маркетингийн менежер
2433	Эмийн борлуулалтын мэргэжилтэн
2433	Техникийн борлуулалтын мэргэжилтэн
2434	Мэдээлэл, харилцаа холбооны текнилоги борлуулалтын мэргэжилтэн
5223	Дэлгүүрийн худалдагч

**3323 ХУДАЛДАН АВАГЧ**

Худалдан авагч нь төрийн болон, үйлдвэр, аж ахуйн газар, худалдааны бусад байгууллагын өмнөөс тэдний хэрэгцээнд эсвэл эргүүлэн зарах зорилгод нь нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлдвэр, аж ахуйн газар, төрийн болон бусад байгууллагад зориулан тоног төхөөрөмж, материал түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах талаар гэрээ хийх, үнэ хэлэлцэх, дахин худалдах зорилгоор бараа худалдан авах,
- б) хэрэгцээ, нөөцийн талаар мэдээлэл олж авах, худалдан авах барааны чанар, тоо хэмжээ, үнэ, нийлүүлэх хугацаа зэрэг гэрээний бусад нөхцөлүүдийг тодорхойлох,
- в) ерөнхий болон тусгай зориулалтын хэрэгсэл, материал болон үйлчилгээг тухайн байгууллагын хэрэглээнд, эсвэл нэмэлт боловсруулалт хийх зорилгод нь нийцүүлэн худалдан авах,
- г) тендер зарлах, нийлүүлэгч нартай зөвлөлдөх, худалдааны нөхцөлийг хэлэлцэх,
- д) бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллагын дахин борлуулах зорилгоор захиалсан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах,
- е) бүтээгдэхүүн танилцуулах арга хэмжээний хүрээнд, загвар, үзэсгэлэн худалдаа, яармаг, зохион байгуулах үйлдвэрийн газруудаар явж үзэх, зах зээлийг судлах, арилжаа наймааны улирал, давтамж, урамшууллыг судлах,

- ж) захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагад илүүтэй тохирох бүтээгдэхүүнийг сонгох,
- з) нийлүүлэгчтэй бүтээгдэхүүний үнийн хямдрал, тээвэр болон зээлийн нөхцөлийг тохирох,
- и) барааг нийлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, захиалагч болон нийлүүлэгчийн хоорондын харилцааг зохицуулах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Худалдаачин
- Худалдан авагч агент
- Нийлүүлэгч ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3324 Худалдааны брокер

**3324 БОРЛУУЛАЛТЫН БРОКЕР**

Худалдааны брокер нь үйлчилгээний зохих шимтгэл авч өөрийн компани эсвэл үйлчлүүлэгчийн өмнөөс бараа, бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах болон тээврийн үйлчилгээг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бараа бүтээгдэхүүнийг худалдах болон худалдан авах талуудтай холбоо тогтоох,
- б) худалдах болон худалдан авах талуудын тавьж байгаа шаардлагын талаар зөвшилцөх, зөвөлгөө өгөх,
- в) бараа бүтээгдэхүүнийг тодорхой хугацааны дараа нийлүүлэх хэлбэрээр зарах буюу худалдан авах гэрээ байгуулах,
- г) ачаа тээвэрлэх захиалга өгөх, тээврийн үнийг тохиролцох,
- д) бараа, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт болон тээвэрлэлтэнд нөлөөлөх хүчин зүйлс, зах зээлийн чиг хандлагыг ажиглах, дүн шинжилгээ хийх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Худалдааны брокер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3311 Санхүүгийн брокер  
 3311 Санхүүгийн дилер  
 3311 Үнэт цаасны брокер  
 3311 Үнэт цаасны дилер  
 3321 Даатгалын дилер

**БАГА БҮЛЭГ 333****333 БИЗНЕС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АГЕНТ**

---

Бизнесүйлчилгээний агент нь төрөл бүрийн бизнесийн үйл ажиллагаанд холбоо тогтоож өгдөг. Жишээлбэл: хэвлэл мэдээлэлд зар сурталчилгаа тавих орон зай олж өгөх, гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн эсэх талаар зөвлөгөө өгөх, ажил хайгчийг ажлын байранд зуучлах, соёл, урлаг, спортын тоглолт зохион байгуулах, ном хэвлүүлэх, цомог гаргах, тэдгээрийг худалдаалах, хурал цуглаан гэх мэт арга хэмжээг зохион байгуулах, зэрэг ажилд талуудад зуучлан үйлчилдэг.

**Гүйцэтгэх үүрэг:**

Экспорт, импортын бичиг баримтыг бүрдүүлэх, хурал, тэмдэглэлт үйл явдлыг зохион байгуулах, удирдан явуулах, хурлын үйлчилгээ, хоол, цайны үйлчилгээ, дэлгэцийн дуу дүрсний болон компьютер тоног төхөөрөмж, байрлах газар, унааг зохицуулах, арга хэмжээнд оролцогч нарт зориулсан олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, ажил хайгчид тохирох ажлын байрыг олох, үл хөдлөх хөрөнгийг зарах болон хөлслүүлэх талаар харилцагчид танилцуулах, төлбөрийн нөхцөл болон хөлслүүлэх нөхцөлийг танилцуулах, үл хөдлөх хөрөнгийг үзүүлэх, дуудлага худалдаагаар автомашин, мал, үнэт эдлэл, урлагийн бүтээл зэрэг хөрөнгийг худалдаалах, тоглолт хийх хүссэн тохиолдолд тэдний өмнөөс гэрээ хийх зэрэг багтана.

Энэ бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3331 Клирингийн болон илгээмжийн агент**

**3332 Хурал зөвлөгөөн болон тэмдэглэлт үйл явдлыг зохион байгуулагч**

**3333 Хөдөлмөр эрхлэлтийн агент, ажилд зуучлагч**

**3334 Үл хөдлөх хөрөнгийн менежер**

**3339 Энэ ангилалд ороогүй бизнес үйлчилгээний агент**

**3331 КЛИРИНГИЙН, ИЛГЭЭМЖИЙН АГЕНТ**

Клирингийн болон илгээмжийн агент нь гаалийн клирингийн үйл ажиллагааг эрхлэх, даатгал, экспорт, импортын тусгай зөвшөөрөл болон бусад бичиг баримтыг бүрдүүлэх ажлыг эрхэлнэ.



**Гүйцэтгэх үүрэг:**

- а) экспорт, импортын барааны гаалийн клирингийн үйл ажиллагаа явуулах,
- б) шаардлагатай даатгалуудыг хийлгүүлэх,
- в) экспорт, импортын тусгай зөвшөөрөл болон бусад бичиг баримтуудыг зохих хууль журмийн дагуу бүрдүүлэх ажлыг хариуцах,
- г) тээвэрлэгдэж байгаа барааны жагсаалтыг гаргах, гарын үсэг зурах,
- д) экспорт, импортын бичиг баримтыг тулган ачаанд байгаа барааны тарифийг тогтоох, тарифийн кодыг хэрэглэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Клирингийн агент
- Илгээмжийн агент

**3332 ХУРАЛ, ЗӨВЛӨГӨӨН ЗЭРЭГ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨГЧ /  
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ/**

Хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээ төлөвлөгч /зохион байгуулагч/ нь хурал, тэмдэглэлт үйл явдал, хүлээн авалт, сургалт семинарыг төлөвлөн зохион байгуулах, зохицуулах ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчдэд үзэсгэлэн худалдаа гаргаж сурталчилах,
- б) үйлчилгээ болон өрөө тасалгаа, техник хэрэгслэлийг хөлслүүлэх, хоол ундны үйлчилгээний үнийн талаар мэдээлэл түгээх, хариу өгөх,
- в) үйлчлүүлэгчтэй уулзаж хүсэлтийг сонсох, үйлчилгээний талаар харилцан санал солилцох,
- г) хурлын үйлчилгээ, хоол, ундны үйлчилгээ, дэлгэцийн болон дуу дүрсийн болон компьютер тоног төхөөрөмж, байрлах газар, унааг зохицуулах, арга хэмжээнд оролцогч нарт зориулсан олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, гэрээг хийх,
- д) оролцогчийн бүртгэлийг хөтлөх,
- е) төсөвт багтаан үзүүлж болох бусад үйлчилгээний төрөл, үнийн талаар хэлэлцэн тохиролцох,
- ж) зохион байгуулах үйл явцын талаар захиалагчдад мэдээлэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хурал, зөвлөгөөн болон тэмдэглэлт үйл явдлыг төлөвлөгч, зохион байгуулагч
- Хурим зохион байгуулагч

**3333 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН АГЕНТ, АЖИЛД ЗУУЧЛАГЧ**

Хөдөлмөр эрхлэлтийн агент, ажилд зуучлагч нь ажил хайгчдад ажлын сул байр, ажил олгогчид тохирох ажилтныг олж өгөх, үйлдвэр аж ахуйн газар, төрийн байгууллагын хүсэлтээр тодорхой төсөл дээр ажиллах гэрээт ажилтныг сонгох, зэрэг ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөлмөр эрхлэлтийн албаны мэдээлж байгаа ажлын байрыг ажил хайгчдад олж өгөх,
- б) ажил олгогч болон ажилчнаас ямар нэгэн шимтгэл авахгүйгээр ажлын сул орон тоонд тохирох ажилтныг сонгох,
- в) үйлдвэр, албан байгууллагад шаардлагатай мэргэжлээр гэрээгээр ажиллах ажилтны мэргэшлийн болон бусад асуудлаар ярилцах,
- г) тодорхой шаардлагыг хангасан мэргэжлийн ур чадвар бүхий ажилтныг хайж олох, үндэсний болон олон улсын хууль тогтоомжийн шаардлагын дагуу зохих үйл ажиллагаа явуулах,
- д) хөдөлмөрийн гэрээ нь хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж зөвлөгөө өгөх,
- е) сургалтын тогтолцооны талаар зөвлөгөө өгөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хөдөлмөр эрхлэлтийн агент
- Ажил зуучлагч
- Хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3339 Утга зохиолын агент
- 3339 Хөгжмийн тоглолтын агент
- 3339 Спортын агент

**3334 ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АГЕНТ, МЕНЕЖЕР**

Үл хөдлөх хөрөнгийн агент, менежер нь ихэвчлэн зохих шимтгэл авсны үндсэн дээр өөрийн үйлчлүүлэгчийн өмнөөс үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх ба түрээслүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) худалдах ба түрээслүүлэх өмчийн талаар болон тэдгээрийг эзэмшигчийн нөхцөл байдал, худалдан авах, түрээслэх гэж буй хүмүүсийн хэрэгцээ шаардлагын талаар мэдээлэл олж авах,
- б) худалдах ба түрээслэх өмчийг худалдан авах, түрээслэх хүмүүст үзүүлэх, худалдах ба түрээслүүлэх болзол, нөхцөлийг тайлбарлах,

- в) түрээслүүлэх гэрээнд гарын үсэг зурах, өмч эзэмших эрхийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- г) эзэмшигчийн өмнөөс түрээсийн болон хувьцааны мөнгийг цуглуулах, түрээслүүлэхээс өмнө болон түрээсийн үед ба дараа нь өмчийн байдалд шалгалт хийх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үл хөдлөх хөрөнгийн агент
- Үл хөдлөх хөрөнгийн менежер
- Өмч борлуулагч

**Өөр газар ангилсан холбогдох ажил, мэргэжлийн жишээ:**

4312 Барьцаат хөрөнгийн клерк

**3339 ӨӨР АНГИЛАЛД ОРООГҮЙ БИЗНЕС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АГЕНТ**

Бага бүлэг 333 дотор өөр аль нэг нэгж бүлэгт ороогүй бизнес үйлчилгээний бусад агент энэ нэгж бүлэгт хамаарна. Тухайлбал, бизнес харилцаа тогтоох, байгууллага иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгаа хийх санал тавих, тамирчид, жүжигчдийн тоглолтыг зохион байгуулах, ном зохиол хэвлэх, хөгжмийн бичлэг хийж худалдах, эд зүйлс, хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг эрхлэгчид энд орно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) худалдаа үйлчилгээ болон худалдан авагчийн эрэлт хэрэгцээний талаар мэдээлэл авах,
- б) худалдагч, худалдан авагчийн нэрийн өмнөөс хэлэлцээ хийх, арилжааны нөхцөл, төлбөрийн талаар үйлчлүүлэгчдэд тайлбарлах,
- в) худалдагч, худалдан авагчийн өмнөөс гэрээнд гарын үсэг зурах, гэрээг баталгаажуулах,
- г) худалдан авсан бизнес үйлчилгээг тохиролцсон хэлбэрээр, хугацаанд нь худалдан авагчдад хүргэх,
- д) төрөл бүрийн өмч хөрөнгө, авто машин, бараа, мал, урлагийн бүтээл, үнэт эдлэл болон бусад эд зүйлийг дуудлагаар худалдах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дуудлагын худалдаа зохион байгуулагч
- Зар сурталчилгаа арилжаалагч
- Утга зохиолын агент

- Хөгжмийн тоглолтын агент
- Спортын агент
- Театрын агент

### **БАГА БҮЛЭГ 334**

#### **ЗАХИРГАА, ТӨРӨЛ МЭРГЭЖЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

---

Захиргаа, төрөл мэргэжлийн нарийн бичгийн дарга нь байгууллагын бизнес үйл ажиллагаанд өөрийн мэдлэгт тулгуурлан зохион байгуулалтын, харилцаа холбооны, баримт бичгийн дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн албан байгууллагын бичиг хэргийн туслах ажилтан нарын ажлыг хянах үүрэгтэй.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Туслах ажилтны ажлыг хянах, хууль эрх зүйн бичиг баримт, гэрээ хэлцэл, товчлол, бичгээр гаргасан баталгаа зэргийг бэлтгэх, байгууллага нэгжийн ажлын уялдааг зохицуулах, зарим тохиолдолд биенес үйл ажиллагаанд мэдлэгээ ашиглах, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүлээн авах, уулзалтын цагийн хуваарийг гаргах, уулзалтыг зохион байгуулах, харилцаа холбооны асуудлыг хариуцан дэмжлэг үзүүлэх, хууль зүйн болон эрүүл мэндийн тайлан, тэмдэглэлийг гаргах, тэмдэглэл хөтлөх зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжилийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3341 Албаны зааварлагч, /зохион байгуулагч/**

**3342 Хуулийн нарийн бичгийн дарга**

**3343 Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга**

**3344 Анагаахын нарийн бичгийн дарга**

### **3341 АЛБАНЫ ЗААВАРЛАГЧ**

Албаны зааварлагч нь 4 дүгээр үндсэн бүлэг дэх “Контор, үйлчилгээний ажилтан”-ны буюу захиргаа, төрөлжсөн нарийн бичгийн дарга нарын ажлыг хянаж, үйл ажиллагааны уялдаа, холбоог нь хангаж ажиллана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) бичиг, баримт боловсруулах, тэмдэглэл хөтлөх, телефон утас болон холбоо мэдээллийн хэрэгслийг ажиллуулах, мэдээллийг оруулах,

- хэвлэх зэрэг конторын гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааг хянах, удирдан чиглүүлэх,
- б) газар, хэлтэс болон бусад нэгжтэй хамтран ажиллах журам, ажил, үүргийн хуваарийг тогтоох,
  - в) ажил төрлийн холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, гүйцэтгэлийн тайлан, мэдээ боловсруулан удирдлагад илтгэх,
  - г) гүйцэтгэх үүрэг, аюулгүй ажиллагаатай холбоотой сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр, холбогдох асуудлаар төсөл, санал боловсруулах,
  - д) ажилтны үүрэг, даалгаврын биелэлтийг үнэлэх, шагнал, урамшилд тодорхойлох,
  - е) шинээр ажилтан сонгох элсүүлэх үйл ажиллагаа болон ярилцлагад оролцох,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Конторын үндсэн ажилтан
- Конторын албаны зааварлагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3252      Эмчилгээний тэмдэглэл, эрүүл мэндийн мэдээллийн техникч

**3342 ХУУЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Хуулийн нарийн бичгийн дарга нь томоохон компани, төрийн байгууллагын хуулийн дотоод нэгжид ажиллаж холбогдох ажилтан, хуульчдад хуулийн нэр томъёо, тайлбар, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл бэлтгэж өгөх, олон нийттэй харилцах, бичиг, баримт боловсруулах, байгууллагын дотоод үйл ажиллагааны уялдааг зохицуулах зэрэг ажилд нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Эрх зүй, хэм хэмжээ тогтоож журамлан зохицуулсан бичиг, баримтыг боловсруулах, бэлтгэх,
- б) хууль, тогтоомжтой нийцүүлэн бичиг баримтыг хянах,
- в) удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу шүүхийн ажилтан, үйлчлүүлэгч, гэрч зэрэг хүмүүстэй харилцах, факс, шуудан илгээх, хүлээн авах,
- г) зочин, төлөөлөгчийн уулзалтын хүсэлтийг хүлээн авч, уулзалтын цагийн хуваарь гаргах,
- д) орлого, зарлагад хяналт тавьж төсвийг батлахад туслах,
- е) конторын туслах ажилтны ажилд хяналт тавих,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хуулийн нарийн бичгийн дарга
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах менежер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3411 Хуулийн болон холбогдох бусад мэргэжилтэн

**3343 ЗАХИРГААНЫ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь байгууллагын дотоод нэгжийн ажлыг уялдуулах, менежер болон мэргэжилтний үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, бичиг баримт, тайлан боловсруулах, тэмдэглэл хөтлөх, мэдээлэлд боловсруулалт хийх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) албан бичиг боловсруулах, уулзалт ярианы тэмдэглэл хөтлөх,
- б) үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэх, менежерээс өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавих,
- в) удирдлагатай хийх уулзалтын хүсэлтийг хүлээн авч зохион байгуулах, уулзалтын цагийн хуваарийг гаргах, удирдлагын аялал, томилолтын ажлын бэлтгэлийг хангах,
- г) удирдлагын төсөв боловсруулахад ерөнхий менежмент туслах, худалдан авах, өмчлөх гэрээ хэлцэлийн төслийг боловсруулах,
- д) байгууллагын дотоод нэгжийн үйл ажиллагааны холбоог хангах удирдлагын зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ,
- е) бизнесийн болон техник шинжтэй албан бичиг боловсруулах, ирсэн бичиг, хүсэлтэд хариу бичих,
- ж) шүүх хурал, чуулган зэрэг болон бусад газарт болсон ярилцлагыг дуу бичлэг болон гар бичмэлээс протокол бэлтгэх,
- з) конторын бусад ажилтан нарын ажилд хяналт тавих,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гүйцэтгэх захирлын нарийн бичгийн дарга
- Захидал, харилцааны туслах ажилтан
- Нарийн бичгийн дарга – Компьютерийн операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

4120 Нарийн бичгийн дарга (үндсэн)

**3344 АНАГААХЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Анагаахын нарийн бичгийн дарга нь анагаахын нэр, томъёо, ойлголт үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн түвшинд олон нийттэй харилцах, албан бичиг боловсруулах, байгууллагын ажлын уялдааг хангах, удирдлагын өдөр тутмын харилцаа зэрэг асуудлаар байгууллагын эрүүл мэндийн бүх ажилтанд туслана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) анагаах ухааны мэдээ, тайлан, бичиг, баримт зэргийг бүртгэх, нэгтгэх,
- б) өвчтөнтэй ярилцах, маягт бөглөх, өвчний түүх, баримт бичгийг бэлтгэх,
- в) даатгалын болон бусад шаардлагатай маягтыг бөглөх,
- г) өвчтөний төлбөрийн тооцооны хуудас, нэхэмжлэлийг бэлтгэх,
- д) туслах ажилтны ажилд хяналт тавих,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Анагаахын нарийн бичгийн дарга
- Өвчний баримт бичиг, тэмдэглэл хариуцсан нарийн бичгийн дарга
- Эмчиглгээний төлбөрийн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 4120 Нарийн бичгийн дарга
- 4226 Эмнэлгийн өвчтөн хүлээн авагч

**БАГА БҮЛЭГ 335****ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН**

Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын мэргэжилтэн нь улсын хил, гааль, татвар, нийгмийн хамгааллын үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, удирдан зохион байгуулах, албадах, хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх авах хүсэлт, тухайлбал, экспорт, импортийн бараа гаргах, оруулах, аж ахуйн нэгж байгуулах, барилга байгууламж барих зэрэг үйл ажиллагаанд төрөөс гаргасан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Улсын хилийг хамгаалах, улсын хилээр дамжин өнгөрч буй хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, бараа бүтээгдэхүүн нь төрийн холбогдох

хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгах, хүн, бизнес эрхлэгчийн тайланг шалгах, нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг шийдвэрлэсэн байдлыг шалгах, татвар, үнэ ханш, цалин хөлсний өөрчлөлт, хэмжээ болон холбогдох журмын хэрэгжилтэд дүн шижилгээ хийх, төрийн албаны удирдах ажилтан болон менежерээс өгсөн зааварчилгааны дагуу ажиллах зэрэг болно.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3351 Хил, гаалийн байцаагч**

**3352 Улсын татвар, онцгой татварын байцаагч**

**3353 Улсын нийгмийн халамж, даатгалын асуудал хариуцсан ажилтан**

**3354 Тусгай зөвшөөрөл хариуцсан ажилтан**

**3355 Цагдаагийн байцаагч, мөрдөн байцаагч**

**3359 Энэ ангилалд ороогүй засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан**

### **3351 ХИЛ, ГААЛИЙН БАЙЦААГЧ**

Хил, гаалийн байцаагч нь төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор улсын хилээр дамжин өнгөрч буй зорчигч, бараа, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд хяналт тавьж, гаалийн бүрдүүлэлт хийх, татвар хураамж ногдуулах ажлыг эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) иргэд улсын хилийг зөрчих болон хилээр валют, бараа, ачаа тээш материалыг хууль бусаар гаргахаас сэргийлж улсын хил, эрэг орчмыг хамгаалах,
- б) улсын хилээр дамжин өнгөрч буй иргэд нь шаардлагатай зөвшөөрөл, бичиг баримттай байгаа эсэхийг шалгах,
- в) бараа, ачаа тээш, валютыг улсын хилээр нэвтрүүлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, улсын хилээр өнгөрч буй иргэдийн ачаа тээшийг шалгаж, гаалийн бүрдүүлэлт хийх,
- г) барааг дамжин өнгөрүүлэх болон экспортлох, импортлох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахын тулд улсын хилээр өнгөрч буй тээврийн хэрэгслийн бичиг баримт, ачаа тээшинд үзлэг хийх, зохих төлбөр хийгдсэн эсэхийг шалгах,
- д) гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлаар иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийн хангуулах,



- е) гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, йгуулахад нэйтрэн орж үзлэг, тооллого хийх, тэдгээрийн данс бүртгэлийг шалгах, шаардлагатай тохиолдолд шалгалтын дүнгийн талаар шүүх хурал дээр гэрчийн мэдүүлэг өгөх,
- ж) гаалийн хяналт, шалгалтанд холбогдох баримт бичиг, тайлбар, лавлагааг иргэн, албан тушаалтнаас гаргуулан авах,
- з) гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлан авах,
- и) албан үүргээ гүйцэтгэх үед улсын хилийн хориотой зурваст нэвтрэх
- к) гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх,
- л) холбогдох бусад үүрэг гүйцэтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хилийн байцаагч
- Гаалийн байцаагч
- Паспортын албаны шалгалтын ажилтан
- Гаалийн ажилтан
- Цагаачлалын албаны ажилтан

**3352 УЛСЫН ТАТВАР, АКЦИЗЫН АЛБАНЫ АЖИЛТАН**

Улсын татвар, акцизын ажилтан нь иргэд, аж ахуйн нэгжийн төлвөл зохих татвар, хураамж зэрэг улсад төлөх төлбөрийн төрөл хэмжээг тодорхойлох зорилгоор борлуулалтын баримт болон бусад холбогдох баримтыг шалгаж, зарим онцгой тохиолдлын талаар шийдвэр гаргуулахаар удирдах албан тушаалтан болон менежерт шилжүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) татвар, хураамж зэрэг төлбөрийн тухай хууль тогтоомж, дүрэм журам, олон нийтээр дагаж мөрдөх эрх, үүргийн талаар байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэн олон нийтэд таниулах,
- б) татвар ногдуулах, төлөх, татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, төсөл болон санхүүгийн бусад баримтад хяналт, шалгалт хийх, тайлбар, лавлагаа, татвар ногдуулах орлогын болон борлуулалтын баримт, бусад холбогдох бичиг баримтыг гаргуулан авах, зөрчлийг тогтоон акт, дүгнэлт үйлдэх,
- в) хууль тогтоомжийн дагуу заавал төлөх татвар, хураамж, бусад төлбөрийн хэлбэр хэмжээг тогтоох зорилгоор шалгалтанд шаардагдах магадлагаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулгыг татвар

- төлөгчтэй харилцагч аж ахуйн нэгж, байгуулга, хувь хүн, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах,
- г) татвар ногдох зүйл нуусныг гэрчлэх баримт болон эд хөрөнгийг татвар төлөгчөөс түр хугацаагаар хураан авах, битүүмжлэх, татварын өрийг багдуулах зориулалтаар эд хөрөнгө барцаалах,
- д) татвар төлөгчийн байр, агуулахад байршлыг нь үл харгалзан нэвтрэн орж, шалгалт, тооллого, ажлын зураг авалт, шаардлагатай бол үзлэг хийх,
- е) татварын тухай хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх,
- ж) татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн татвар ногдуулах, төлөх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх,
- з) байгууллагын дотоод хяналт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нягтлан бодох бүртгэлийн болон татвар төлөлтийн баримтыг шалгах,
- и) илэрсэн зөрчилтэй холбоотой үүрэг даалгавар өгөх, тэмдэглэл хөтлөх, авсан арга хэмжээ, торгуулийн талаар тайлагнах,
- к) холбогдох бусад үүргийг гүйцэтгэнэ.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Татвар хураагч
- Татварын ажилтан
- Татварын байцаагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2411 Нягтлан бодогч  
2411 Аудиторч

### **3353 УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН**

Улсын нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн асуудал хариуцсан ажилтан нь иргэний тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулан түүний хэмжээг нь тодорхойлохын тулд тэтгэвэр, тэтгэмжийг бэлэн мөнгөөр буюу бусад хэлбэрээр олгохыг хүссэн өргөдлийг судалж, зарим тохиолдлын талаар шийдвэр гаргуулахаар удирдах албан тушаалтан болон менежерт шилжүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тэтгэвэр, тэтгэмж, тэдгээрийг тодорхойлох, нөхөн олгохтой холбоотой хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх, үүргийн талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, олон нийтэд сурталчлах,

- б) иргэнд олговол зохих тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэр, хэмжээг тодорхойлох зорилгоор өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийн бүрдүүлэлтийг шалгах,
- в) тэтгэвэр, тэтгэмж эсвэл халамжийн үйлчилгээг үргэлжлүүлэн авах шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор уулзалт хийх, бичиг баримтыг судлах,
- г) холбогдох бусад үүрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тэтгэврийн асуудал хариуцсан ажилтан
- Тэтгэмжийн асуудал хариуцсан ажилтан
- Нийгмийн даатгалын асуудал хариуцсан ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2635 Нийгмийн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн
- 3412 Нийгмийн ажилтан

**3354 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН**

Тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан ажилтан нь бараа, бүтээгдэхүүн экспортлох, импортлох, аж ахуй эрхлэх, байшин барилга барих тусгай зөвшөөрөл болон паспорт олгохыг хүссэн өргөдлийг хүлээн авч, зөвшөөрөл олгох эсэх эсвэл тодорхой болзолтой олгож болохыг тогтоож, шийдвэр гаргуулахаар удирдах албан тушаалтан болон менежерт шилжүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тусгай зөвшөөрлийн төрөл ба түүнд тавигдах шаардлага, нөхцөлтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг тайлбарлаж, олон нийтээр дагаж мөрдөх эрх, үүргийн талаар байгууллага, аж ахуйн газар, иргэнд таниулан сурталчилах,
- б) өргөдөл болон бусад холбогдох баримт бичгийг шалгаж зөвшөөрлийг олгох болзлыг тодорхойлох,
- в) гаргасан өргөдлийг судалж паспорт олгох,
- г) тусгай зөвшөөрөл олгох болзолыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт хийж, менежерт танилцуулах,
- д) холбогдох бусад үүргийг гүйцэтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тусгай зөвшөөрөлийн асуудал хариуцсан ажилтан
- Паспорт олгох асуудал хариуцсан ажилтан
- Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан ажилтан

**Өөр газар ангиласан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                   |
|------|-------------------|
| 3112 | Галын байцаагч    |
| 3112 | Барилгын байцаагч |

**3355 ЦАГДААГИЙН БАЙЦААГЧ, МӨРДӨН БАЙЦААГЧ**

Цагдаагийн байцаагч, мөрдөн байцаагч нь гэмт хэрэгтэй холбогдсон баримт, нөхцөл байдлыг судлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага, иргэний үйлдэл, эс үйлдлийн талаар мэдээлэл олох, баталж нотлох ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэгтнийг илрүүлэх зорилгоор гарсан гэмт хэргийн талаарх мэдээллийн эх сурвалжийг олох, сэжигтэн болон гэрч мөн холбогдох бусад хүмүүстэй холбоо тогтоох,
- б) нотлох баримт олох зорилгоор гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй, сэжиглэсэн үйлдэл, үйл явдал, нөхцөл байдлын талаар судалгаа явуулах,
- в) аж ахуйн нэгж байгууллагын бараа, бэлэн мөнгө, мэдээлэл болон хулгайд өртөж болзошгүй эд хөрөнгө түүнчлэн худалдан авагч, ажилтны зүгээс хууль бус үйлдэл гаргаж болзошгүй магадлал өндөртэй нөхцөл байдлыг судалж мөрдөх,
- г) хуулийн байгууллага, үйлчлүүлэгчдийн өмнөөс байгууллага, болон иргэнтэй холбоо бүхий бусад асуудлыг судлах,
  - д) албан ёсны зөвшөөрлөөр баривчлах буюу баривчлахад туслах,
- е) мөрдөх үйл ажиллагааны үр дүнгийн талаар шүүх хурал дээр гэрчийн мэдүүлэг өгөх буюу удирдлага, үйлчлүүлэгчдэд мэдээлэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цагдаагийн албаны мөрдөн байцаагч
- Цагдаагийн мөрдөн байцаагч
- Цагдаагийн эрүүгийн төлөөлөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |                           |
|------|---------------------------|
| 3411 | Хувийн мөрдөгч            |
| 5412 | Цагдаагийн албаны ажилтан |

**3359 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОХИРУУЛАГЧ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАХ/  
ДЭД МЭРГЭЖИЛТЭН**

Энэ нэгж бүлэгт 3 дугаар үндсэн бүлэгт ороогүй засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын ажилтанг хамааруулна. Жишээлбэл: хөдөө аж ахуй, загас, ойн аж ахуй, жин хэмжүүр, цалин хөлс, үнийн байцаагч гэх мэт.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) худалдаанд үнэн зөв жин хэмжүүр ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь очиж шалгах,
- б) хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс бараа, бүтээгдэхүүн үйлчилгээнд үнийн хяналт тавих,
- в) хөдөлмөрийн нөхцөлийн талаарх хууль тогтоомж болон холбогдох бусад норм, норматив, стандарт, дүрэм журамд нийцсэн цалин, хөлс олгож байгаа эсэхийг хянах,
- г) холбогдох хяналт шалгалтын хийж, үүрэг даалгавар өгөх, илэрсэн зөрчлийг баримтжуулан тайлан бэлтгэх, арилгах арга хэмжээ авах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хөдөө аж ахуйн байцаагч
- Загасны аж ахуйн байцаагч
- Ойн аж ахуйн байцаагч
- Үнийн байцаагч
- Цалин хөлсний байцаагч
- Жин, хэмжүүрийн байцаагч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3112 Галын байцаагч
- 3257 Эрүүл мэндийн байцаагч
- 3257 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагч
- 3257 Байгаль орчны байцаагч
- 3257 Эрүүл ахуйн байцаагч

### **ДЭД БҮЛЭГ 34**

## **ХУУЛЬ, НИЙГЭМ, СОЁЛ, ТЭДГЭЭРТ ХОЛБОГДОХ БУСАД ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН**

---

Хууль, нийгэм, соёлын холбогдох ажилтан нь иргэнд хуулийн үйлчилгээ, үзүүлэх, нийгмийн ажил, эмзэг бүлэг иргэдэд зориулсан хоол бэлтгэх, спорт, соёлын болон шашны холбогдолтой үйл ажиллагаанд өөрийн мэргэжил, ажил үүргийн дагуу техник туслалцаа эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Мөрдөн байцаалт болон хуулийн бусад үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, нийгмийн болон эмзэг хэсгийг хамарсан хөтөлбөрийн хэрэгжилт, тухайлбал нөхөн сэргээх хөтөлбөр бэлтгэхэд туслах, соёлын, шашны арга хэмжээнд туслах, спортын арга хэмжээнд оролцох, хоол хүнс, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, нарийн боов, хоолны цэс боловсруулах зэрэг багтана.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилана:

**341 Хууль, нийгэм, шашны ажилтан**

**342 Биеийн тамир, спорт, фитнесийн ажилтан**

**343 Соёл, урлаг, хоолны технологийн ажилтан**

### **БАГА БҮЛЭГ 341**

## **ХУУЛЬ, НИЙГЭМ, ШАШНЫ ТУСЛАХ/ДЭД МЭРГЭЖИЛТЭН**

---

Хууль, нийгэм болон шашны асуудал эрхэлсэн ажилтан нь мөрдөн байцаах болон хуулийн ажиллагаанд, нийгмийн болон эмзэг бүлэг хэсгийн хөтөлбөрүүд, шашны арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, техник үйл ажиллагааг гүйцэтгэх ажлыг хариуцна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Хуулийн, нийгэм, шашны асуудлаар ажилладаг бусад мэргэжилтэнд зөвлөгөө өгөх, дүн шинжилгээ хийхэд туслах, хууль зүйн бичиг баримтыг бүрдүүлэхэд туслах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйлчлүүлэгч нарын хувийн, нийгмийн асуудалд туслах, олон нийт болон иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулна.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

3411	Эрх зүйн болон түүнтэй адилтгах ажилтан
3412	Нийгмийн халамжийн туслах/дэд ажилтан
3413	Шашны холбогдох ажилтан

### **3411 ЭРХ ЗҮЙН БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Эрх зүйн болон холбогдох бусад ажилтан нь хуульч, мэргэжлтний зааварчлага, хяналтын дор шүүх, хууль эрх зүйн байгууллагад гэрээ, өмчлөгч шилжүүлэх, зээлийн баталгаа гаргах зэрэгтэй асуудлыг шийдэхэд оролцох, санхүүгийн гүйлгээтэй холбоотой асуудлыг үйлчлүүлэгчийн өмнөөс шалгах, мөрдөх зэрэг ажлыг хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг бичиж баримтжуулах,
- б) шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх,
- в) тогтоол, дүгнэлт, шийдвэрийг шүүхийн танхим болон сонсох өрөөнд уншиж танилцуулах,
- г) зээл, даатгалтай холбоотой маргааныг шийдвэрлэх нөхцөл, арга зам, гэрээ хэлцэл, мэдэгдэл зэрэг бичиг баримтыг бэлтгэх,
- д) үйлчлүүлэгчид хуулийн зөвлөгөө өгөх,
- е) хөрөнгийн хууль ёсны өмчлөгчийг тогтоох зорилгоор албан ёсны бүртгэлийн байгууллагаас үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн талаар асуулга лавлагаа, холбогдох бичиг баримтыг бэлтгэж авах,
- ж) хулгай, танхайн хэрэгтэй холбоотой нотлох баримтыг тогтоох талаар холбогдох байгууллага, этгээдээс мэдээлэл авах, түүний мөрөөр шалгах, судлах,
- з) үйлчлүүлэгчийн захиалгаар хувийн мөрдөгчийн ажил гүйцэтгэх,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хувийн мөрдөгч
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2611	Эрх зүйч
2612	Шүүгч
2619	Нотариатч

**3412 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУСЛАХ/ДЭД АЖИЛТАН**

Нийгмийн халамжийн туслах/дэд ажилтан нь нийгмийн халамжийн хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нийгмийн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтний удирдлага, хяналтын дор зохион байгуулах, олон нийтэд туслах, тэдэнд тулгамдсан нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчилгээ хүсэгчийн давуу ба сул тал, амьжиргаа, бие эрхтний чадавх, хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулах,
- б) өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зохих хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээнд хамрагдахад туслах, тэднийг нийгмээс тусгаарлахгүй аль болох нийгэм дотор байх боломж нөхцлийг судлах бүрдүүлэх талаар нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага холбогдох эрх бүхий этгээдэд санал гаргах,
- в) халамж, үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан халамж, үйлчилгээний төрөл, хамрагдагчийн амьжиргааны хэтийн төлөвийг харгалзах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хяналт тавих, илэрсэн зөрчил, доголдлыг арилгах,
- г) дамжин өнгөрөх байр, нийтийн байранд шаардлагатай иргэнийг байрлахыг зөвлөх, тэднийг байршуулах, дамжин өнгөрөх байр, нийтийн байрны үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох үйлчилгээ үзүүлэх,
- д) нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах иргэнийг сонгох үйл ажиллагаанд оролцох “Амьжиргааг дэмжих зөвлөл”-д санал оруулж шийдвэрлүүлэх ажлыг хариуцах,
- е) хямрал, онцгой нөхцөл байдал үүссэн үед яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах,
- ж) амьдрах арга ухааны сургалт, донтох өвчнөөс сэргийлэх эмчилгээ хийх, зан харицааны доголдлыг засах хөтөлбөр, залууст зориулсан хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн чиглэлийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны зааварчилгаа, хяналтын дор зохион байгуулах,
- з) халамж, үйлчилгээний талаар төрөөс авч буй арга хэмжээ, хөтөлбөр, тусламжийн үр дүн, нөлөөллийг судлах, үнэлгээ, дүгнэлт, тайлан, судалгаа, мэдээлэл гаргах,
- и) нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага болон сургууль, эмнэлэг, төрийн болон ТББ, олон нийттэй нягт хамтран ажиллах, мэдээлэл солилцох,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нийгмийн хөгжлийн ажилтан
- Нийгмийн халамж, үйлчилгээний ажилтан



- Залуучуудын ажилтан
- Хорооны бүртгэл, мэдээллийн зохион байгуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2635 Нийгмийн мэргэшсэн ажилтан, зөвлөгөө өгөгч мэргэжилтэн

**3413 ШАШНЫ ХОЛБОГДОХ АЖИЛТАН**

Шашны холбогдох ажилтан нь шашны хэрэг эрхлэх газар, нийгэмлэгийн ажлыг дэмжин шашны зан үйлд оролцох, өөрийн үйл ажиллагааг шашны ном бясалгалд зориулах, бурханд залбирах, шашны сургаалийг сурталчлах ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) шашны үйл ажиллагаа явуулах,
- б) аль нэг шашны урсгал, бүлгийн гишүүн байж, тухайн шашны жаяг дэгийг мөрдөн ажиллаж амьдрах,
- в) амьдралаа шашны номлол, бясалгалд зориулах,
- г) бурханд залбирах ба шашны сургаалийг сурталчлах,
- д) өглөг, буяны ажилд оролцох,
- е) олон нийтийг зөв, шудрага байхад уриалах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Номлогч
- Лам, бөө, удган
- Гэлэнмаа

**БАГА БҮЛЭГ 342**

**БИЕЙН ТАМИР, СПОРТ, ФИТНЕССИЙН АЖИЛТАН**

Спорт, фитнесийн ажилтан нь санхүүгийн ашиг сонирхолын үүднээс биеийн тамир, спортын арга хэмжээнд тамирчинг бэлтгэх, оролцох, спортод өрсөлдөх, мэргэжлийн болон сонирхогчийн түвшиний тамирчны амжилтыг ахиулах зорилгоор тэднийг дасгалжуулах, спортын болон биеийн тамирын стандартыг сайжруулах, биеийн тамир спортын арга хэмжээг зохион байгуулах, биеийн тамирын тусгайлсан дасгал, нөхөн сэргээлтийн дасгалуудыг хянаж сайжруулах, зааж сургах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Спортын арга хэмжээнд оролцох, спортод өрсөлдөх, спортын талаар мэдлэг, ур чадвараа сайжруулах хүсэл сонирхолтой иргэнийг сургалт,

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

бэлтгэлд хамруулах, спортын уралдаан тэмцээний хуваарийг гаргах, хэрэгжилтэнд хяналт тавих, төрөл бүрийн фитнесийн дасгал хөдөлгөөн, нийтийг хамарсан болон ганцаарчилсан анги бүлэг бий болгох, спортын ур чадварын хөгжил, спортыг дэмжих залуу үе спортоор хичээллэх нөхцөл боломжийг хангах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3421 Тамирчин, спортын тоглогч**

**3422 Спортын дасгалжуулагч, зааварлагч**

**3423 Фитнесс, чийрэгжүүлэлтийн зааварлагч, хөтөлбөрийн удирдагч**

#### **3421 ТАМИРЧИН, СПОРТЫН ТОГЛОГЧ**

Тамирчин, спортын тоглогч нь биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд оролцох, түүнчлэн өөрийн сонгосон спортын төрөлд багийн гишүүн эсвэл ганцаарчилсан хэлбэрээр бэлтгэл сургуулилт хийж спортод өрсөлдөнө.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) спортын тэмцээн уралдаанд оролцох,
- б) байнгын бэлтгэл сургуулилалтад оролцох, бие бялдар, ур чадварын төвшингөөс хамаарч хувийн бэлтгэл хийх,
- в) биеийн тамир спортыг дэмжих арга хэмжээнд оролцох,
- г) тухайн сонгосон спортын төрөлд өндөр амжилтанд хүрэх зорилтыг тавьж ажиллах,
- д) уралдаан, тэмцээний стратеги боловсруулж багш, дасгалжуулагчтайгаа зөвлөх,
- е) спортын тухайн төрлийн дүрэм болон бусад зохицуулалтыг дагаж мөрдөх зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хөнгөн атлетикч
- Боксчин
- Шатарчин
- Хөл бөмбөгчин
- Голфьчин
- Хоккейчин
- Уралдааны машины жолооч
- Цаначин

- Теннисчин
- Үндэсний болон бусад төрлийн мэргэжлийн бөх

### **3422 СПОРТЫН ДАСГАЛЖУУЛАГЧ, ЗААВАРЛАГЧ**

Спортын дасгалжуулагч, зааварлагч нь мэргэжлийн болон сонирхогчийн төвшингийн тамирчны амжилтыг ахиулах, спортын уралдаан тэмцээнд оролцоход нь урам зориг оруулах сэтгэл зүй, бие бялдрын хувьд бэлтгэх, спортын тоглолт арга хэмжээг стандарт дүрэм, журмын дагуу зохион байгуулах ажил гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Багийн болон тамирчны сул, давуу талыг тогтоох,
- б) дасгал, сургуулийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх,
- в) тэмцээн уралдааны хуваарийг төлөвлөн боловсруулах,
- г) тамирчныг эсвэл багийг уралдаан тэмцээнд бэлтгэх, тэднийг сэтгэл зүйн хувьд дэмжих,
- д) уралдаан тэмцээний стратеги, тактикийг боловсруулан баг юмуу тамирчинг стратеги, тактикийн дагуу удирдах,
- е) тамирчны болон багийн амжилтад дүн шинжилгээ хийж дасгал, сургуулалтыг уялдуулах,
- ж) багийн болон тамирчны ур чадварыг ажиглан, дүгнэлт хийх цаашид хэрхэн сайжруулах арга тактикийг тогтоох,
- з) спортын арга хэмжээ, уралдаан тэмцээний талаар тухайн спортын дүрэм, журам, аюулгүй байдал, стандартын талаас нь сургаж дасгалжуулах,
- и) спортын уралдаан тэмцээний явцад тамирчны оноо, үнэлгээг тэмдэглэх, тоглолтын явцын алдаа, ололтын талаар тэмдэглэл хөтлөх,
- к) өрсөлдөгчийн арга барил, амжилтыг үнэлж дүгнэх, шагнал торгууль оногдуулах, ялагчийг тогтоох.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дасгалжуулагч
- Спортын шүүгч
- Цанын дасгалжуулагч
- Спортын ажилтан
- Усан сэлэлтийн зааварлагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- 3423      Фитнессийн зааварлагч  
 3423      Морь унаж сургагч

**3423 ФИТНЕСС, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ЗААВАРЛАГЧ,  
ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ**

Фитнесс, чийрэгжүүлэлтийн зааварлагч, хөтөлбөрийн удирдагч нь бүлгээр, ганцаарчилсан хэлбэрээр хүмүүст фитнесс, нөхөн сэргээлтийн болон нийтийг хамарсан биеийн тамирын арга хэмжээг удирдах, зааварчлах, биеэр хийж үзүүлэх ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) фитнесс болон нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх,
- б) фитнесийн, нөхөн сэргээлтийн спортын дасгал хийх явцыг хянах, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх,
- в) дасгал хийгчийн биеийн байдал, ур чадварыг ажиглах, түүнд тохирох дасгалыг санал болгох, зааж сургах,
- г) нөхөн сэргээлтийн болон фитнесийн дасгал сургуулилалтын явцад биеийн хөдөлгөөн, ур чадвар, ерөнхий ойлголтын талаар заах, биечлэн үзүүлэх,
- д) дасгал хийх хэрэгслийг ашиглах зааварчилгаа өгөх, зааж үзүүлэх,
- е) дасгал сургуулилалтын явцад аюулгүй байдлыг хангах заавар журмыг тайлбарлах, түүнийг биелүүлэхийг шаардах зэрэг болно.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Аэробикийн зааварлагч
- Фитнесийн зааварлагч
- Морь унаж сургагч
- Хувийн дасгалжуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3422 Цанын дасгалжуулагч
- 3422 Усан сэлэлтийн зааварлагч

**БАГА БҮЛЭГ 343****СОЁЛ, УРЛАГИЙН БОЛОН ХООЛНЫ ТЕХНОЛОГИЙН ТУСЛАХ/ДЭД  
МЭРГЭЖИЛТЭН**

---

Соёл урлагийн болон хоолны технологийн мэргэжилтэн нь ур чадвар, техникийн, соёлын мэдлэгээ фото зураг авах болон боловсруулах, театрын засал, чимэглэл, дизайн, дэлгүүрийн цонхны үзмэр, засал, чимэглэл, номын сангийн, уран зургийн засвар, хоолны шинэ цэс бүтээх,

хоол хийж танилцуулах, кино, телевизийн ажил, урлаг соёлын бусад ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Фото зургийн аппаратаар хүн, юмс үзэгдлийн зургийг авах, урлагын арга техник ашиглан бүтээгдэхүүний дизайн, дотоод засал, худалдааны зар сурталчилгаа хийх, үзүүлэн бэлтгэх, танилцуулах, үйлчилгээний тавилгын дизайн, үзмэрийн талбай бэлтгэх, хоолны цэс бэлтгэж хоол хийж танилцуулах, театрын тоглолт, зураг авалт, телевизийн нэвтрүүлэг болон реклам зар сурталчилгаанд зургийн дарга, найруулагч, жүжигчдэд туслах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **3431 Фотозурагч**

#### **3432 Дотоод, засал чимэглэлийн дизайнер, чимэглэгч**

#### **3433 Галерей, музей, номын сангийн техникч**

#### **3434 Тогооч**

#### **3435 Урлаг, соёлын бусад мэргэжилтэн**

### **3431 ФОТОЗУРАГЧ**

Фотозурагч нь фотозургийн аппаратаар хүн, юмс үзэгдлийн зургийг зохих стандарт, шаардлагын дагуу авах ажил гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) реклам, зар сурталчилгааны болон зарж борлуулах, эсвэл судалгаа шинжилгээ, түүнчлэн сэтгүүл номын болон сонины өгүүлэг, материалд оруулах зураг авах,
- б) нэг буюу хэсэг хүмүүсийн хөрөг зургийг авах,
- в) зураг авах нөхцөл байдалдаа тохируулан хэрэглэх аппарат, хальс, гэрэлтүүлэг болон арын фонын талаар судалгаа хийх, сонгох,
- г) зургийн хослолыг тогтоож, тоног төхөөрөмжид техник өөрчлөлтүүд хийх,
- д) зургийг компьютерт шилжүүлэх, скайнер ашиглах,
- е) хүссэн фотозургаа гарган авахын тулд компьютер ашиглах,
- ж) фотозурагт өөрчлөлт хийж, өөр дижитал болон мультимедиа бүтээл болгох,
- з) зургийн харагдах байдлыг өөрчлөхийн тулд компьютер болон бусад техник хэрэгслийг ашиглах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Фотосэтгүүлч
- Судалгаа-шинжилгээний фотозурагч
- Фотозурагч
- Үйлдвэрлэлийн фотозурагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |  |
|------|--|
| 3521 | Дуу, дүрс бичлэгийн техникч              |
| 3521 | Кино зургийн операторч                   |
| 7311 | Фотозургийн тоног төхөөрөмжийн засварчин |
| 7321 | Хэвлэлийн өмнөх ажиллагааны техникч      |

**3432 ДОТООД ЗАСАЛ ЧИМЭГЛЭЛИЙН ДИЗАЙНЧ, ЧИМЭГЛЭГЧ**

Дотоод засал чимэглэлийн дизайнч, чимэглэгч нь уран сайхны аргыг хэрэглэн борлуулалтын, үйлдвэрийн, олон нийтийн, бөөний худалдааны, орон сууцны барилгын дотоод засал чимэглэлийн зориулалтад нь нийцүүлэн хүний ая тухтай амьдрах, ажиллах орчинг бүрдүүлж, арилжаа борлуулалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцон худалдааг өргөтгөх, дотоод засал чимэглэлийн зураг гаргаж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Зураг төслийн зорилго, хязгаарлах хүчин зүйлсийг захиалагч, оролцогчтой зөвшилцөн тодорхойлох,
- б) Орон зай, зориулалт, үр ашиг, аюулгүй байдал, гоо сайхны мэдрэмжийг техникийн болон бусад шаардлагуудад нийцүүлэх талаар судлан дүн шинжилгээ хийх,
- в) Барилгын дотоод засал чимэглэлийн зураг төслийн санааг томъёолох,
- г) Таталбар зураг, бүдүүвч, үзүүлэн, зураг төслийг бэлтгэн төслийн санааг ойлгуулан тайлбарлах,
- д) Захиалагч, нийлүүлэгч, барилгын ажилтантай төслийн шийдлийн талаар хэлэлцэх, зөвшилцөх,
- ж) Материалын зориулалт, үзэмж, дотоод заслын тавилга, бүтээгдэхүүний шинэ загварыг зохион бүтээх сонголт, тодорхойлолтын талаар зөвлөх,
- з) Барилгын сонгогдсон загварыг нарийвчлан задалж, дотоод заслалын зураг боловсруулах,
- и) Дотоод засал, угсралт, чимэглэлийн ажлыг зохицуулах,
- л) Театрын тайзны зураг чимэглэлийг хийх,
- м) Үзмэрийн шилэн хорго бусад үзүүлэнгийн талбайд бүтээгдэхүүн,

үйлчилгээ үзүүлэх зориулалтаар уран сайхны арга хэрэглэн чимэглэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дизайнч, дотоод заслын
- Дизайнч, засал чимэглэлийн
- Дизайнч, үзмэрийн шилэн хоргоны
- Чимэглэгч, үзүүлэнгийн
- Чимэглэгч, дотоод засал чимэглэлийн
- Чимэглэгч, баглаа боодлын
- Чимэглэгч, үзмэрийн шилэн хоргоны
- Үзүүлж борлуулагч
- Шивээс тавигч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2161 Барилгын архитекторч

**3432 ДОТООД ЗАСАЛ ЧИМЭГЛЭЛИЙН ДИЗАЙНЧ, ЧИМЭГЛЭГЧ**

Дотоод засал чимэглэлийн дизайнч, чимэглэгч нь уран сайхны аргыг хэрэглэн борлуулалтын, үйлдвэрийн, олон нийтийн, бөөний худалдааны, орон сууцны барилгын дотоод засал чимэглэлийн зориулалтад нь нийцүүлэн хүний ая тухтай амьдрах, ажиллах орчинг бүрдүүлж, арилжаа борлуулалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тооцон худалдааг өргөтгөх дотоод засал чимэглэлийн зураг гаргаж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Зураг төслийн зорилго, хязгаарлах хүчин зүйлсийг захиалагч, оролцогчтой зөвшилцөн тодорхойлох,
- б) Орон зай, зориулалт, үр ашиг, аюулгүй байдал, гоо сайхны мэдрэмжийг техникийн болон бусад шаардлагуудад нийцүүлэх талаар судлан дүн шинжилгээ хийх,
- в) Барилгын дотоод засал чимэглэлийн зураг төслийн санааг томъёолох,
- г) Таталбар зураг, бүдүүвч, үзүүлэн, зураг төслийг бэлтгэн төслийн санааг ойлгуулан тайлбарлах,
- д) Захиалагч, нийлүүлэгч, барилгын ажилтантай төслийн шийдлийн талаар хэлэлцэх, зөвшилцөх,
- ж) Материалын зориулалт, үзэмж, дотоод заслын тавилга, бүтээгдэхүүний шинэ загварыг зохион бүтээх сонголт, тодорхойлолтын талаар зөвлөх,
- з) Барилгын сонгогдсон загварыг нарийвчлан задалж дотоод заслын зураг боловсруулах,

- и) Дотоод засал, угсралт, чимэглэлийн ажлыг зохицуулах,
- л) Театрын тайзны зураг чимэглэлийг хийх,
- м) Үзмэрийн шилэн хорго бусад үзүүлэнгийн талбайд бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх зориулалтаар уран сайхны арга хэрэглэн чимэглэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дизайнч, дотоод заслын
- Дизайнч, засал чимэглэлийн
- Дизайнч, үзмэрийн шилэн хоргоны
- Чимэглэгч, үзүүлэнгийн
- Чимэглэгч, дотоод засал чимэглэлийн
- Чимэглэгч, баглаа боодлын
- Чимэглэгч, үзмэрийн шилэн хоргоны
- Үзүүлж борлуулагч
- Шивээс тавигч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2161 Барилгын архитекторч

**3433 ГАЛЛЕРЕЙ, МУЗЕЙ, НОМЫН САНГИЙН ТЕХНИКЧ**

Галлерей, музей, номын сангийн техникч нь номын санд ном авах, олгох мэдээллийг бүртгэх, үзмэрт бүртгэгдсэн материал, хавтсыг ашиглах талаар ажилтанд танилцуулах, галлерейн үзмэрийг угсрах, байрлуулах, урлагийн бүтээлийг бэлтгэх, цуглуулгын дээж болон загвар бэлтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Үзмэрийг олон нийтэд үзүүлэхэд бэлтгэх, угсрах,
- б) үзмэрийн орчин тойрон болон, үзмэрийн танхимийг тохижуулах,
- в) үзмэрийн гэрэлтүүлэг, тоноглолыг хийх, угсрах,
- г) үзмэрийг тээвэрлэхэд бэлтгэх , үзмэр хүлээн авах, сав, баглаа боодлыг нээх,
- д) номын сангийн шинэ материалыг захиалах, номын сангийн эргэлт, бичлэгийн системийг засварлах,
- е) компьютерийн бичлэгийг засварлах, өгөгдлийг мэдээллийн санд оруулах,
- ж) дүрс, дуу бичлэгийн тоног төхөөрөмжийг угсрах,
- з) номын мэдээллийг хайх, шалгах зэрэг багтана.



**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Галлерейн техникч
- Музейн техникч
- Номын сангийн техникч
- Чихмэлчин

**3434 ТОГООЧ**

Тогооч нь ресторан болон бусад нийтийн хоолны газар, усан онгоц, суудлын галт тэрэг, мөн хувийн тогоочоор ажиллаж хоолны цэс, дизайныг хийх, санаачилах, хоол бэлтгэх, бэлэн болгох, бусад ажлын ерөнхий зохион байгуулалтыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Хоол, хүнсний материал захиалах, хоолны орц зардлыг тооцох, хоолны цэс зохиох,
- б) хоол бэлтгэх болон үйлчлүүлэгчид хүргэх хүртэлх бүх шатанд хоолны амт чанарт хяналт тавих,
- в) хоол бэлтгэх асуудлаар, удирдлага, зөөгч, гал тогооны ажилтан болон бусад мэргэжилтэнтэй санал солилцох,
- г) хоол бэлтгэх ажилд оролцож байгаа ажилтан, тогооч нарын ажилд хяналт тавих, тэдний ажлыг удирдан чиглүүлэх,
- д) хоол хүнсний зүйл хадгалах, хоол хийх орчин стандарт, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгах,
- е) хоол хийх заавар болон хоол үйлчлүүлэгчид очиход ямар байх ёстойг харуулсан загвар хийж үзэгдэх газар байрлуулах,
- ж) гал тогооны ажилтныг сонгон шалгаруулах, ажилд авах талаар санал гаргах,
- з) хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын хууль тогтоомжийг ажилтанд танилцуулах, тэдгээрийг мөрдөж ажиллахыг шаардах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тогооч
- Ерөнхий тогооч
- Торт, нарийн боовны тогооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- 5120 Тогооч
- 9411 Түргэн хоол бэлтгэгч

### **3435 СОЁЛ, УРЛАГИЙН БУСАД МЭРГЭЖИЛТЭН**

Энэ нэгж бүлэгт өөр ангилалд ороогүй соёл урлаг, нийтийн хоолны ажилтан орно. Жишээлбэл, найруулагч, удирдагч, зургийн дарга, жүжигчин зэрэг бусад ажил мэргэжлийн хүмүүст театрын тоглолтын, зураг авалтын үед нь туслаж байгаа ажилтан энэ ангилалд хамаарна.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гэрэлтүүлэгийн техникч
- Тусгай эффектийн техникч
- Театрын хувцасны мэргэжилтэн
- Нүүр хувиргагч

---

## **ДЭД БҮЛЭГ 35 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНИКЧ**

---

Мэдээлэл, холбооны техникч нь өдөр тутам компьютер, холбоо, сүлжээний системийн дүрс, дууг радио телевизээр дамжуулах, эх газар, далай тэнгис, агаар мандалд цацагдаж буй холбооны бусад дохиог дамжуулах, хүлээн авах тоног төхөөрөмжийн ажиллагааг хянана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Мэдээлэл, холбооны системийг ашиглагч нарт туслалцаа үзүүлэх, программ хангамж болон тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, сүлжээ болон холбооны системийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх, веб сүлжээнд тоног төхөөрөмж, программ хангамжийг суулгах, угсрах, интернет болон интернет цахим хуудасны үйл ажиллагааг хянах, дэмжлэг үзүүлэх, цахим хуудсыг өөрчлөн сайжруулах, веб сүлжээний нөөцлөх, сэргээх үйл ажиллагааг хийх, дүрс, дуу бичлэгийг бичих, засварлах, монтаж хийх тоног төхөөрөмжийг хянах, радио, телевизийн нэвтрүүлэгт зориулсан хиймэл дагуулын болон радио холбооны дамжуулах, хүлээн авах системийг хянах, засвар үйлчилгээг нь хийх, радио холбооны болон хиймэл дагуулын систем, агаар, далай тэнгис, хуурай газрын гэхчилэн олон төрлийн системийг хянах, засвар үйлчилгээг хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, компьютер систем болон холбооны тоног төхөөрөмжийг сайжруулахад чиглэгдсэн туршилтад оролцох, туршилтын загварыг ажиллуулж турших, өгөгдсөн зааврын дагуу цахим схемийн загварыг бэлтгэх, холбооны системийн засвар үйлчилгээг хийх, үйлдвэрлэлийн алдаа байгаа эсэхийг болон ашиглалтыг хянах зэрэг багтана.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил ,мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**351 Мэдээлэл, холбооны технологи ажиллагаа болон хэрэглэгчдэд туслах техникч**

**352 Холбоо, радио телевизийн нэвтрүүлгийн техникч**

### **БАГА БҮЛЭГ 351**

### **МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГАА БОЛОН ХЭРЭГЛЭГЧДЭД ТУСЛАХ ТЕХНИКЧ**

Мэдээлэл, холбооны технологи ажиллагаа болон хэрэглэгчдэд туслах техникч нь өдөр тутам холбооны болон компьютерийн систем, сүлжээг хэрэглэгчдэд техникийн туслалцаа үзүүлэн дэмжиж ажиллана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Принтер, скайнер зэрэг тоног төхөөрөмжийг компьютерт холбох, ажиллуулах, хянах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах, программ хангамж, тоног төхөөрөмжтэй холбоотой хэрэглэгчийн асуултанд хариулах, тоног төхөөрөмж болон программ хангамжийг суулгах, таниулах, жижиг засвар үйлчилгээ хийх, холбооны систем, сүлжээг үүсгэх, ажилуулах, засвар үйлчилгээ хийх, кабель утасны зөв холбогдсон эсэхийг хянах, веб сүлжээ, тоног төхөөрөмж болон программ хангамжийг суулгах, угсрах, интернет болон интернет цахим хуудасны найдвартай ажиллагааг хангах, веб сүлжээний мэдээллийг нөөцлөх болон алдагдсан мэдээллийг сэргээх зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**3511 Мэдээлэл, холбооны технологи үйл ажиллагааны техникч**

**3512 Мэдээлэл, холбооны технологи хэрэглэгчдэд туслах техникч**

**3513 Компьютерийн сүлжээ, системийн техникч**

**3514 Веб техникч**

### **3511 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКЧ**

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйл ажиллагааны техникч нь мэдээлэл, харилцаа холбооны систем, тоног төхөөрөмж, программ

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

хангамж болон холбогдох бусад хэрэгслийг өдөр бүр ажиллуулах, хянах, хэвийн бус ажиллагааны шалтгааныг тогтоох, бүрэн хүчин чадлаар ажиллах бололцоог хангах ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- б) компьютер, тоног төхөөрөмжийн тохиргоог хийх ажиллуулахад бэлтгэх,
- в) системийн үйл ажиллагааны алдаа болон тоног төхөөрөмжийн саатлыг хянах,
- г) тоног төхөөрөмжид саатал гарсан тохиолдолд хянан шалгагчид эсвэл засвар үйлчилгээний техникчид мэдэгдэх,
- д) программ алдаа заасан тохиолдолд алдааны шалтгааныг олж засах, алдааг тархахаас сэргийлж программыг зогсоох,
- е) тоног төхөөрөмжийн заавар, хэрэглэх гарын авлага, дагалдах, диск, материалыг ашиглах,
- ж) шаардлагатай тохиолдолд программын үр дүнг сэргээх, ангилах, ялгах, мэдээллийг холбогдох хэрэглэгчид илгээх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Компьютерийн операторч
- Өндөр хурдтай компьютерийн хэвлэгчийн операторч
- Компьютерт холбогддог тоног төхөөрөмжийн операторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

3513 Компьютерийн сүлжээний техникч

### **3512 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ ХЭРЭГЛЭГЧДЭД ТУСЛАХ ТЕХНИКЧ**

Мэдээлэл, холбооны технологийг хэрэглэгчдэд туслах техникч нь компьютерийн мэргэжилтний зааварчлагын дор ажиллах ба хэрэглэгчид биеэр уулзаж эсвэл утас, цахим шуудан зэрэг бусад хэрэгслээр хэрэглэгчийн программ хангамж, интернет, мэдээллийн сан, сүлжээ, тоног төхөөрөмжид учирсан саатал гэмтлийг засах, хэвийн ажиллагаанд нь оруулах талаар туслалцаа үзүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) компьютерийн программ хангамж, тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаатай холбоотой асуудлаар хэрэглэгчдэд туслалцаа үзүүлэх,

- б) системийн үйл ажиллагааг хянах, үйл ажиллагааг нь залруулах, алдааг олж илрүүлэх,
- в) компьютерийн эд анги, дагалдах хэрэгсэл болон программын жижиг эвдрэл саатлыг засварлах,
- г) мэдээлэл, холбооны техникийн өдөр тутмын ажиллагааг хянах,
- д) хэрэглэгчийн техник хэрэгслийг угсрах, холбох,
- е) хэрэглэгчдэд учирсан бэрхшээл, доголдлыг хэрхэн засах, саатал гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар зааж зөвлөх,
- е) техникийн гэмтэл, саатлыг оношлох, засварлахын тулд гарын авлага, зааврыг ашиглах

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Техникч, холбооны технологи хэрэглэгчдэд туслах
- Техникч, мэдээллийн сангийн
- Техникч, компьютерийн инженерийн
- Техникч, программ зохиогч
- Техникч, системийн шинжээч
- Техникч, компьютертэй холбоотой туслалцаа үзүүлэх

**3513 КОМПЬЮТЕРИЙН СҮЛЖЭЭ, СИСТЕМИЙН ТЕХНИКЧ**

Компьютерийн сүлжээ, системийн техникч нь сүлжээ, мэдээлэл, өгөгдлийн системийг байгуулах, засвар үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Сүлжээний хэвийн ажиллагааг хангах, засварлах,
- б) сүлжээнээс бусад мэдээлэл болон өгөгдлийн системийг засварлах,
- в) мэдээллийн болон өгөгдлийн систем, сүлжээг ашиглагчид туслах,
- г) сайжруулах, шинэчлэх шаардлагатай болсон тоног төхөөрмж болон программ хангамжийг тогтоох, шинэчлэх,
- д) компьютерийн сүлжээ, үйлдлийн системийн программ хангамжийг суулгах, шаардлагатай эд ангийг солих, угсрах,
- е) мэдээллийг хадгалах, утсан болон гэмтсэн мэдээллийг сэргээх, сүлжээг нээх, хаах ажиллагаа зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Техникч, компьютерийн сүлжээний
- Техникч, компьютерийн системийн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- 2522 Системийн захиргааны ажилтан
- 2511 Системийн шинжээч

3511	Компьютерийн операторч
3514	Веб техникч

### 3514 ВЕБ ТЕХНИКЧ

Веб техникч нь веб сүлжээ, тоног төхөөрөмж, программ хангамж, интернет болон цахим хуудасны хэвийн ажиллагааг хангах, түүнд хяналт тавих, засвар үйлчилгээ хийх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) веб сүлжээ, тоног төхөөрөмж, программ хангамжийг суулгах, угсрах, интернет, цахим хуудасны найдвартай ажиллагааг хангах,
- б) үйл ажиллагааны болон системд нэвтрэх журам, бодлого, зааврыг боловсруулах,
- в) мэдээлэл, системийн аюулгүй байдлын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих,
- г) системийг шинэчлэн сайжруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх талаар судалгаа, шинжилгээ хийх, зөвлөмж гаргах,
- д) үйлчлүүлэгч болон хэрэглэгчээс мэдээлэл авах, тэдэнд зааварчилгаа өгөх,
- е) цахим хуудсыг өөрчлөх,
- ж) веб сүлжээний мэдээллийг нөөцлөх болон устсан мэдээллийг сэргээх зэрэг багтана.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Веб техникч
- Цахим хуудасны техникч

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:

2522	Компьютерийн системийн захиргааны ажилтан
2522	Системийн шинжээч
2512	Программ хангамжийн дизайнч
2166	Компьютерийн тоглоомын дизайнч
2166	График, мультимедиа зохиомжийн дизайнч
2513	Веб мультимедиа зохиогч

### БАГА БҮЛЭГ 352

#### ТЕЛЕХОЛБОО, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕХНИКЧ

Холбооны болон нэвтрүүлгийн техникч нь дүрс, дуу авиаг урьдчилан бичих буюу радио, телевизээр шууд нэвтрүүлэх, эх газар, далай тэнгис,

агаар мандалд цацагдаж буй цахилгаан холбооны бусад дохиог дамжуулах тоног төхөөрөмжийн ажиллагааг хянах, холбооны салбарын судалгааны ажилтай холбоотой ажлыг гүйцэтгэх, холбооны системийн засвар, үйлчилгээг хийх, угсрах, дизайн, үйлдвэрлэх зэрэг үйл ажиллагаанд оролцоно.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Дүрс, дуу бичлэгийг бичих, засварлах, монтаж хийх тоног төхөөрөмжийг хянах, радио, телевизийн нэвтрүүлэгт зориулсан хиймэл дагуулын болон радио холбооны дамжуулах, хүлээн авах системийг хянах, засвар үйлчилгээг нь хийх, радио холбооны болон хиймэл дагуулын систем, агаар, далай тэнгис, хуурай газрын гэх мэт олон төрлийн системийг хянах, засвар үйлчилгээг нь хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, компьютерийн системийн болон холбооны тоног төхөөрөмжийг сайжруулахад чиглэгдсэн туршилтад оролцох, туршилтын загварыг турших, өгөгдсөн зааврын дагуу цахим схемийн загварыг бэлтгэх, холбооны системийн засвар, үйлчилгээ үйлдвэрлэлийн алдаа байгаа эсэх, ашиглалтыг хянах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **3521 Өргөн нэвтрүүлэг, дуу дүрс бичлэгийн техникч**

#### **3522 Телехолбооны инженерийн техникч**

### **3521 ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, ДУУ, ДҮРС БИЧЛЭГИЙН ТЕХНИКЧ**

Өргөн нэвтрүүлэг, дуу, дүрс бичлэгийн техникч нь бичлэг хийх, дүрс дуу авиа засах, дуу авиаг телевиз, радиогоор нэвтрүүлэх болон алсын холбооны дохиолол зэрэг бусад тоног төхөөрөмжийн техникийн үйл ажиллагаанд хяналт тавина.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) Дуу бичлэгийн тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавих,
- б) Дүрс засах нийлүүлэх тоног төхөөрөмжид хяналт тавих, чанарын шаардлага хангасан дуу авианы бичлэг хийх, дүрс болон дууны тусгай эффект хийх,
- в) Эвдрэл, гэмтлийн шалтгааныг тодруулах, гэмтлийг засахын тулд дуу дүрс бичлэг засварлах онолын болон практик мэдлэгээ ашиглах,
- г) Радио, телевизийн нэвтрүүлгийн систем, радио телевизийн хөтөлбөрийн сансрын системийн дамжуулалтад хяналт тавих,
- д) Радио, холбооны систем, сансрын антений засвар үйлчилгээ болон бусад олон төрлийн системийн үйл ажиллагаанд хяналт тавих,

### **3** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

- е) Гэмтлийн шалтгааныг тодруулах, шийдвэрлэхийн тулд алсын холбооны станц, дамжуулах системийн талаарх онолын болон практик мэдлэгээ ашиглах,
- ж) Тоног төхөөрөмжийн гэнэтийн гэмтлийн үед засвар үйлчилгээ хийх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дуу, дүрс бичлэгийн операторч
- Өргөн нэвтрүүлгийн тоног төхөөрөмжийн операторч
- Өргөн нэвтрүүлгийн техникч
- Зураглаач /киноны/
- Зураглаач /дүрсний/
- Туслах найруулагч /мэдээллийн хэрэгслийн/

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3431 Фото зурагч

### **3522 ТЕЛЕХОЛБООНЫ ИНЖЕНЕРИЙН ТЕХНИКЧ**

Телехолбооны инженерийн техникч нь дүрс, дуу авиаг урьдчилан бичих буюу радио, телевизээр шууд нэвтрүүлэх, эх газар, далай тэнгис, агаар мандалд цацагдаж буй цахилгаан холбооны бусад дохиог дамжуулах тоног төхөөрөмжийн техник ажиллагааг хянана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) радио, телевизийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, дамжуулах станц, сансрын холбооны станцын ажиллагаанд хяналт тавих,
- б) эх газар, далай тэнгис, нисэх онгоцонд буй радио холбооны систем, сансрын холбоо болон бусад системийг хянах,
- в) кино гарах төхөөрөмжийг хянах,
- г) ажлын явцад гарч болзошгүй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлж шийдвэрлэх, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор радио нэвтрүүлэг болон цахилгаан холбооны цэг, дамжуулах станцын зарчим, арга ажиллагааны талаарх мэдлэгийг ашиглах,
- д) үйлдлийн бүртгэлийг хөтлөх,
- е) холбогдох бусад үүргийг гүйцэтгэх,
- ж) бусад ажиллагчдад хяналт тавих зэрэг багтана.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Техникч, телехолбооны тоног төхөөрөмжийн
- Техникч, дамжуулах тоног төхөөрөмжийн /телевизийн/



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 7422 | Мэдээлэл, холбооны технологийн хэрэгсэл тавигч,<br>тохируулагч |
| 3114 | Техникийн ажилтан, телехолбооны                                |

## ҮНДСЭН БҮЛЭГ 4

### КОНТОР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

---

Тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах ба мөнгөний гүйлгээ хийх, аялал жуулчлал зохион байгуулах, мэдээлэл авах, хүсэлт тавих, уулзалт товлох зэрэг туслах шинжтэй олон төрлийн үүргийг гүйцэтгэнэ. Энэ ангиллын ажил мэргэжил нь Олон улсын ажил мэргэжлийн стандарт (ISCO)-ын 2 дугаар төвшний мэргэшил шаардана.

#### Гүйцэтгэх үүрэг:

Таталган бичиж тэмдэглэл хөтлөх, бичгийн машинаар бичих, компьютер болон бичиг хэргийн бусад төхөөрөмжийг ажиллуулах, мэдээллийг компьютерт оруулах, нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэх, тоон мэдээллийг тэмдэглэх ба тооцоолон бодох, үйлдвэрлэл, тээврийн холбогдох тэмдэглэлийг хөтлөх, зорчигч ба ачаа тээврийн холбоотой бүртгэлийг хөтлөх, номын санд бичиг хэргийн ажилтны үүрэг гүйцэтгэх, шуудангийн үйлчилгээтэй холбоотой ажлыг гүйцэтгэх, хэвлэл материалыг бэлтгэж нийлэх, бичиг үсэг үл мэдэх хүнийг төлөөлөн бичих, мөнгөний гүйлгээтэй холбоотой үйл ажиллагаа явуулах, аялал жуулчлал зохион байгуулах, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, уулзалт товлох, холбооны коммутатор ажиллуулах зэрэг ажилбарууд зонхилон орно. Мөн бусад ажилтанд хяналт тавих үүргийг гүйцэтгэж болно.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 41 Компьютерийн операторч
- 42 Үйлчилгээний туслах ажилтан
- 43 Тооцоолол, материал, тоо бүртгэлийн ажилтан
- 44 Конторын бусад туслах ажилтан

---

#### ДЭД БҮЛЭГ 41

### КОНТОРЫН ҮНДСЭН БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТАН

---

Компьютерийн операторч нь тодорхой асуудалд хамаарах мэдээллийг тэмдэглэх, эмхлэх, хадгалах, тооцоолон бодох, сэргээн засварлах болон байгууллагын дотоод журмын дагуу бусад ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Котпьютерээр ажиллах, бичгийн машин болон бусад бичгийн хэрэгслээр бичих, өгөгдөл, мэдээллийг компьютерт оруулах, бичих, бичсэн зүйлсийг засварлах, тооцоолох, нэхэмжлэл бэлдэх, тулгаж шалгах, факс ба шуудан илгээх зэрэг өргөн хүрээтэй үүрэг багтана.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**411 Контторын үндсэн ажилтан**

**412 Нарийн бичгийн дарга**

**413 Компьютерийн операторч**

**БАГА БҮЛЭГ 411****КОНТОРЫН ҮНДСЭН АЖИЛТАН**

---

Контторын үндсэн ажилтан нь байгууллагын дотоод журмын дагуу бичиг хэргийн олон төрлийн ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мэдээллийг бүртгэх, бэлтгэх, ангилах, шууданг ялгах, нээх, илгээх, баримт бичгийг хувилах, олшруулах, факс илгээх, улирлын эсвэл тодорхой хугацааны тайлан бэлтгэх, цахим шуудан, телефон утас зэрэгт хариулт өгөх, холбогдох ажилтантай бусдыг холбох, санхүүгийн гүйлгээг бүртгэх, шалгах, нэхэмжлэл бэлтгэх, мэдээллийг компьютерт оруулах, бичгийн алдааг засах, нийлэх, тулгах, унших, засварлах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4110 Контторын үндсэн ажилтан**

**4110 КОНТОРЫН ҮНДСЭН АЖИЛТАН**

Контторын үндсэн ажилтан нь байгууллагын дотоод журмын дагуу бичиг хэргийн ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мэдээллийг бүртгэх, бэлтгэх, ялгах, ангилах,
- б) шуудан ялгах, нээх, илгээх,

- в) баримт бичгийг хувилах, олшруулах, факс, цахим шуудангаар илгээх,
- г) улирлын болон тодорхой хугацааны тайлан бэлтгэх,
- д) цахим шуудан, телефон утсаар иргэн, байгууллагаас тавьсан асуулт, мэдээлэлд хариулт өгөх, холбогдох ажилтантай холбох,
- е) санхүүгийн гүйлгээг бүртгэх, шалгах, нэхэмжлэл бэлтгэх,
- ж) мэдээллийг компьютерт оруулах, үг үсгийн алдааг засах зорилгоор унших, засварлах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Конторын үндсэн ажилтан

**БАГА БҮЛЭГ 412  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (ҮНДСЭН)**

---

Нарийн бичгийн дарга нь бичгийн машин болон компьютерээр захидал, тэмдэглэл, тайлан мэдээлэл зэрэг бичиг баримтыг бичих, бичгийн алдаа засварыг хийх, нийлэх, шалгах, хуулан бичих, ирсэн, явсан бичиг, шууданг хариуцах, уулзалт зохион байгуулах зэрэг удирлагад туслах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Захидал харилцааны материал, тэмдэглэл болон тайлан, илтгэл зэрэг баримт бичгийг эх хувьтай нь тулгаж, бичгийн машин ба компьютерээр бичиг хэргийн стандарт, шаардлагын түвшинд бичиж бэлтгэх, компьютерийн төрөл бүрийн программ хангамжийг ашиглах, ирэх, явах шууданг хариуцах, шуудан, захидал болон бичиг баримтыг бүртгэх, түгээх, уулзалт хийх саналыг хүлээн авч, хянан уулзалт зохион байгуулах, чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилтнуудын бичиг баримтын бүртгэл хөтлөх, орлон ажиллах эсвэл ажил үүргийг түр хариуцах талаар зохион байгуулалтыг хийх, өдөр тутмын захидал харилцааг хариуцах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4120 Нарийн бичгийн дарга (үндсэн)**

**4120 НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (ҮНДСЭН)**

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Захидал харилцааны материал, тэмдэглэл, удирдлагын шийдвэр, заавар болон тайлан, илтгэл, мэдээллийг эх хувьтай нь тулган

нийлэх, бичгийн машин ба компьютерээр бичиг хэргийн шаардлага, стандартын дагуу бичиж бэлтгэх,

- б) компьютерийн төрөл бүрийн программ хангамжийг ашиглах,
- в) ирсэн, явсан бичиг, шуудан хариуцах,
- г) шуудан, захидал болон бичиг баримтыг бүртгэх ба түгээх,
- д) уулзалт хийх саналыг хүлээн авч хянан уулзалт зохион байгуулах,
- е) чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон ажилтны бүртгэл хөтлөх,
- ж) орлон ажиллах, түр хугацаагаар ажил, үүрэг гүйцэтгэх ажилтны талаар зохион байгуулалт хийх,
- з) өдөр тутмын захидал харилцааг хариуцах зэрэг.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нарийн бичгийн дарга
- Бичээч-операторч
- Компьютерийн операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

3343      Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга

**БАГА БҮЛЭГ 413  
КОМПЬЮТЕРИЙН ОПЕРАТОРЧ**

---

Компьютерийн операторч нь бичиг, баримт хадгалах, боловсруулах, хэвлэн нийтлэх, дамжуулах зорилгоор бичиг баримт буюу өгөгдлийг компьютерт оруулах, засварлах, бичих, файл үүсгэх зэрэг ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мэдээллийг боловсруулахад шаардлагатай өгөгдөл, кодыг оруулах, хадгалагдсан мэдээллийг сэргээх, шинэчлэх, үнэн зөвийг нь шалгах, хадгалах, таталган бичгээр, компьютерийн тоног төхөөрөмж болон таталган бичгийн машинаар тэмдэглэл хөтлөх, дуу бичлэгийн хэрэгсэл, таталган бичгээс мэдээллийг хөрвүүлэн бичих, кино, телевизийн нэвтрүүлгийн яриа, дууны үг зэргийг дэлгэцийн доод талд гарган бичих зэрэг багтана.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4131 Бичээч**

**4132 Баримт, мэдээлэл оруулагч операторч**

**4131 БИЧЭЭЧ**

Бичээч нь бичгийн машин, компьютерээр бичиг бичих, засварлах, хэвлэх, яриа тэмдэглэл бичих зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бичиг баримтын боловсруулж байгаа төсөл, хянаж тулгасан хувь, дуу бичлэг болон тэмдэглэлийг бичгийн машин, компьютерээр бичих,
- б) эх бичиг, материалыг дүрмийн алдаагүй зөв бичих, найруулга, үсгийн фонд, хэмжээ зэргийг тохируулах, хянах,
- в) бичих материалыг цуглуулах, дараалал тогтоох, бичиг, баримт бичих стандарт, удирдамжийг дагаж мөрдөх,
- г) бичиж дууссан материалыг файл үүсгэн компьютерийн хатуу дискинд хадгалах, хадгалсан файлыг засварлах, шинэчлэх, сэргээх,
- д) сонсож бичих, тэмдэглэл хөтлөх,
- е) кино, телевизийн нэвтрүүлгийн яриа, дууны үг зэргийг дэлгэцийн доод хэсэгт гаргахад зориулан бичих,
- ж) дуу бичлэгийн хэрэгсэл болон гар бичмэл тэмдэглэлээс хөрвүүлэн бичих зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бичээч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3343 Захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга

**4132 БАРИМТ, МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАГЧ ОПЕРАТОРЧ**

Баримт, мэдээлэл оруулагч операторч нь компьютерийн гар, хулгана, скайнер, дууны бичлэгийн төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжийн тусламжтайгаар санхүү, статистик, кодлогдсон, бусад мэдээллийг компьютерийн цахим төхөөрөмж, мэдээллийн бааз, эксел программ зэрэг өгөгдлийн хадгалах төхөөрөмжид оруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мэдээлэл болон холбогдох материалыг хүлээж авч бүртгэх,
- б) үндсэн эх материалаас тоон хэлбэрт хувиргасан өгөгдөл, код, текстийг, компьютерийн санах төхөөрөмж рүү оруулах,
- в) өгөгдлийн чанар, үнэн зөвийг шалгах, шаардлагатай тохиолдолд оруулсан өгөгдөлд засвар, өөрчлөлт оруулах,
- г) мэдээллийн хадгалалт ба ашиглалтын бүртгэл, тооцоог хариуцах,

д) мэдээллийн сан болон программ хангамжид мэдээлэл оруулах, өгөх үйлдлийг гүйцэтгэнэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мэдээлэл оруулагч операторч

---

## **ДЭД БҮЛЭГ 42 ХЭРЭГЛЭГЧИЙГ ҮЙЛЧЛЭХ АЖИЛТАН**

---

### **БАГА БҮЛЭГ 421 ТЕЛЛЕР, МӨНГӨ ХУРААГЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

---

Теллер, мөнгө хураагч, холбогдох бусад ажилтан нь банк, шуудангийн үйлчилгээ, бооцоот болон тааварт тоглоом, мөрийтэй тоглоом, барьцаалан зээлдүүлэх болон өр барагдуулахтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын мөнгөн хөрөнгөтэй холбоотой ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мөнгөн гүйлгээ болон шуудангийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор банк, шуудангийн салбарын харилцагчидтай харилцах, спортын арга хэмжээнд мөрий, бооцоо хүлээн авах ба хожлыг олгох, мөрийтэй тоглоом явуулах, эд зүйлс, бусад хөрөнгийг барьцаалж мөнгө зээлдүүлэх, өр авлага болон бусад төлбөр барагдуулах зэрэг ажлыг эрхэлнэ.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4211 Банкны теллер, холбогдох бусад ажилтан**

**4212 Бооцоот болон тааварт тоглоом зохион байгуулагч, мөрийтэй тоглоом тоглуулагч, холбогдох бусад ажилтан**

**4213 Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч, мөнгө зээлдүүлэгч**

**4214 Өр барагдуулагч болон холбогдох бусад ажилтан**

### **4211 БАНКНЫ ТЕЛЛЕР, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Банкны теллер, холбогдох бусад ажилтан нь захидал, шууданг өгөх, мөнгө хүлээн авах, солих, бэлэн мөнгөөр төлбөр, тооцоо хийх зэргээр банкны болон шуудангийн үйлчлүүлэгчтэй шууд харьцан ажиллана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) харилцагчийн дансанд мөнгө шилжүүлэх, данснаас нь мөнгө олгох, чек, гүйлгээ, төлбөрийн даалгавар, зээлийн картны эргэн төлөлт зэрэг банкны бүх төрлийн гүйлгээг хийх,
- б) харилцагчийн дансанд холбогдох бүртгэлийг хийх,
- в) харилцагчийн даалгавраар түүний өмнөөс гүйлгээ хийх,
- г) шуудан хүлээх авах, шуудангийн бүх төрлийн үйлчилгээ болон харилцагчийн өмнөөс мөнгөн гүйлгээг хийх,
- д) харилцагчийн хүсэлтээр валют солих,
- е) гүйлгээний бүртгэлийг хөтлөх, бэлэн мөнгөн гүйлгээний тайлан гаргах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шуудангийн ажилтан
- Вальют солигч
- Банкны теллер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

5230 Кассчин, тасалбар олгогч

**4212 ДИЛЕР, ХОЛБОГДОХ ТОГЛООМЫН ГАЗРЫН АЖИЛТАН**

Дилер, холбогдох тоглоомын газрын ажилтан нь спортын уралдаан, тэмцээн болон азын тоглоомоор бооцоотой тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад бооцооны магадлалыг тогтоох, бооцоо мөнгийг цуглуулах, ялагчид хонжворыг олгох ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эрсдэл тодорхойлох, бооцооны алдах, хожих магадлалыг тодорхойлох бооцоог авахаас татгалзах, бооцоо тавих боломжийг нэмэгдүүлэх,
- б) бооцооны хожих магадлалын талаар ойролцоолсон жагсаалтыг бэлтгэн гаргах,
- в) хөзөр тараах, шоо хаях, хүрд эргүүлэх,
- г) тоглоомын газрын үйл ажиллагааны дүрмийг тайлбарлах,
- д) хожсон дугаарыг зарлах, хожсон хүнд бооцоог олгох, алдсан хүмүүсийн мөнгийг цуглуулж авах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бооцоо цуглуулагч
- Тоглоомын хожлын мөнгө олгогч



### 4213 БАРЬЦААЛАН ЗЭЭЛДЭГЧ, МӨНГӨ ЗЭЭЛДҮҮЛЭГЧ

Барьцаалан зээлдэгч болон мөнгө зээлдүүлэгч этгээд нь эд зүйлс, хөрөнгө, эсхүл бусад баталгааг барьцаалж мөнгө зээлдүүлнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) барьцаалах эд зүйлсийг үнэлж, хүүг тооцоолон, мөнгө зээлдүүлэх,
- б) зээл эргэн төлөгдсөн нөхцөлд эд зүйлсийг буцаан өгөх, зээл эргэн төлөгдөөгүй нөхцөлд барьцаа эд зүйлсийг худалдан борлуулах,
- в) ирээдүйн ашиг болон түүнтэй адилтгах бусад баталгааг барьцаалан хувийн зээл хэлбэрээр мөнгө зээлдүүлэх,
- г) ирээдүйн ашиг болон түүнтэй адилтгах бусад баталгаагаар барьцаалагдсан зээлийг төлүүлэх,
- д) барьцаанд авсан эд зүйлс болон зээлдүүлсэн ба эргэн төлөгдсөн мөнгөний бүртгэл хөтлөх зэрэг багтана.

#### Энэ ангилалд хамаарах ажил, мэргэжлийн жишээ:

- Мөнгө зээлдүүлэгч
- Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэгч

### 4214 ӨР БАРАГДУУЛАГЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН

Өр барагдуулагч болон холбогдох бусад ажилтан нь хугацаа хэтэрсэн данс болон төлөгдөх найдваргүй чекийн төлбөрийг барагдуулах ба хандивын мөнгө цуглуулах үйл ажиллагаа явуулна.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) зээлдэгчийг тогтоох, тэдний байршлыг тодорхойлох,
- б) зээлийг төлүүлэх болон дараа төлөх нөхцлийг тохирох зорилгоор харилцагчтай утсаар ярих, очиж уулзах, эсхүл захидал бичих зэргээр холбоо тогтоох,
- в) төлүүлсэн зээлийн дүнг оролцуулан тайлан бэлтгэх, өр барагдуулахтай холбоотой баримт бичиг, материалуудын бүртгэл хөтлөх,
- г) хуулийн арга хэмжээ авах талаар зөвлөх эсхүл өрийг өөр арга замаар төлөх бололцоогүй болсон тохиолдолд өр барагдуулах үйлчилгээг зогсоох,
- д) хандивын мөнгө гуйх болон цуглуулах зэрэг багтана.

#### Энэ ангилалд хамаарах ажил мэргэжлийн жишээ:

- Нэхэмжлэх болон төлбөр барагдуулагч
- Буяны хандив цуглуулагч
- Өр барагдуулагч

**БАГА БҮЛЭГ 422****ХЭРЭГЛЭГЧИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖИЛТАН**

---

Хэрэглэгчийг мэдээллээр хангах ажилтан нь аялал зохион байгуулах, байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг тайлбарлах, зочид, төлөөлөгчдийг мэндчилэн угтах, бүртгэх, уулзалт, үйлчилгээний цаг тохирох, телефон утасны дуудлагыг холбогдох ажилтны дотуур утсанд холбох, үйлчилгээ авахыг хүссэн хүмүүсийн мэдээллийг цуглуулах, мэдээллийг биечлэн, утсаар эсхүл цахим шуудан гэх мэт хэлбэрээр хүлээн авах, хувь хүн, байгууллагыг дээрх мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчлүүлэгчдэд онгоцны тийз болон аялал, зочид буудлын захиалга хийх, үйлчлүүлэгч, зочдыг тосч, хүлээж авах, зочдод байр өрөө олгох, байгууллагын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, холбогдох журам зааврын талаар мэдээлэл өгөх, уулзалт, үйлчилгээний цаг тохирох, телефон утасны гадны дуудлагыг хуваарилах, үйлчилгээ авахыг хүссэн үйлчлүүлэгчийн мэдээллийг цуглуулж ярилцах зэрэг болно.

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4221 Жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан**

**4222 Холбоо барих төвийн мэдээллийн ажилтан**

**4223 Телефон холбоочин**

**4224 Зочид буудлын хүлээн авагч**

**4225 Лавлахын ажилтан**

**4226 Хүлээн авагч ажилтан (үндсэн)**

**4227 Судлаач, зах зээлийн судлагч**

**4229 Энэ ангилалд ороогүй үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах бусад ажилтан**

**4221 Жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан**

Жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан нь аялалын тухай мэдээлэх, аялалын маршрут зохион байгуулах, аялагчдын байр захиалах, аялалын баг бүрдүүлэх, зохион байгуулах, зуучлах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчдийн хүсэл шаардлагад нийцсэн аялалын тухай мэдээлэл, буудлын захиалга, тээврийн төрөл, тэдгээрийн үнийн тухай мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгөх,
- б) аялалын чиглэл, удирдамж, танилцуулгыг бэлтгэх,
- в) аялалын захиалгыг хүлээж авах,
- г) аялалын тасалбар болон аялалын эрх олгох,
- д) аялалд оролцогчдын шаардлагатай бичиг баримт ба визын талаарх мэдээллийг аялагчдад өгөх, тайлбарлах,
- е) аялалын төлбөрийг хүлээж авах,
- ж) бизнес эсвэл жуулчдад зориулсан аялалын баг бүрдүүлэх, зохион байгуулах, зуучлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Аялалын тасалбар борлуулагч
- Авиакомпанийн аялал зохион байгуулагч
- Аялал зохион байгуулагч
- Аялалын мэргэжилтэн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 1439 Жуулчны агентлагийн менежер
- 3332 Хурал болон тэмдэглэлт үйл явдлын зохион байгуулагч

**4222 ХОЛБОО БАРИХ ТӨВИЙН МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТАН**

Холбоо барих төвийн мэдээллийн ажилтан нь телефон утас, цахим шуудан зэрэг холбооны хэрэгслээр үйлчлүүлэгч, харилцагчийн асуулга, хүсэлтэд компаний бүтээгдэхүүн үйлчилгээ, гүйлгээ шилжүүлгийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх зэрэг ажлыг хийнэ. Тус төвийн ажилтан нь компани болон үйлчлүүлэгчээс хол байрлаж байгаа тохиолдолд үйлчлүүлэгчдэд ойр байгаа өөр байгууллага, компани мэдээллээр хангаж болно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчийн цахим шуудан, телефон утасны дуудлагад хариу өгөх, санал, гомдлыг хүлээн авах, ангилах,
- б) шаардлагатай мэдээллийг олж сонгон, компьютерийн мэдээлэлд оруулах, веб сайтад тавих,
- в) компани түүний нэгжүүдэд санал гомдлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлэх,
- г) нэхэмжлэл, төлбөрийн асуудлыг зохицуулах,
- д) захидал, мэдээлэл, бичиг баримт илгээх,
- е) нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдэд зөвлөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үйлчлүүлэгчтэй харилцах төвийн мэдээллийн ажилтан

**Өөр газар ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- 4223 Телефон холбоочин
- 5244 Утсаар захиалга авч худалдаалагч

**4223 ТЕЛЕФОН ХОЛБООЧИН**

Телефонхолбоочинньхолбооныкоммутаторажиллуулах,хэрэглэгчийн утсанд хариулах, дотуур утсанд холбох, мэдээллийг ажилтан болон үйлчлүүлэгчид дамжуулах, бусад лавлагаанд хариулж мэдээлэл өгөх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) дуудлагыг холбогдох дугаарт нь холбох, салгах, хүлээлгэх, шилжүүлэх,
- б) гадагшаа хийгдэх дуудлагыг холбох,
- в) утсаар асуусан лавлагаанд хариулт өгөх, дамжуулах мэдээг тэмдэглэх,
- г) дамжуулахаар тэмдэглэсэн мэдээллийг эзэнд нь өгөх,
- д) холбооны системд гарсан гэмтлийг шалгах, засварчин дуудах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Телефоны холбоочин

**4224 ЗОЧИД БУУДЛЫН ХҮЛЭЭН АВАГЧ**

Зочид буудлын хүлээн авагч нь зочдыг угтан авч бүртгэх, өрөө, түлхүүр олгох, буудалд өрөө захиалах болон буудлын бусад үйлчилгээний талаар мэдээллээр хангах, сул байгаа өрөөний бүртгэлийг хөтлөх, буудлаас гарч байгаа зочдын төлбөрийн нэхэмжлэлийг гаргаж өгөх, төлбөрийг авах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) олгосон, захиалсан, сул байгаа өрөөний мэдээллийг байнга шинэчилж байх,
- б) ирсэн зочдыг бүртгэх, өрөө олгох, зочны төлбөрийг тооцож, өрөөг бэлэн болгож баталгаажуулан түлхүүрийг олгох,

- в) буудлын үйлчилгээний талаар мэдээлэл өгөх,
- г) буудлын өрөөний тоноглол болон өрөөний захиалгын талаар нийтэд мэдээлэл өгөх,
- д) зочны санал хүсэлт, гомдолыг хүлээн авах шийдвэрлэх,
- е) буудлын үйлчилгээний бусад ажилтантай зочны гомдол хүсэлтийн асуудлаар холбогдох,
- ж) компьютер, тооцооллын хэрэгсэл болон гараар зочны төлбөрийг тооцож гаргах,
- з) зурвас болон дамжуулах мэдээлэл хүлээн авах, гарт нь эсвэл утсаар мэдээллийг эзэнд нь өгөх,
- и) буудлаас гарч байгаа зочны төлбөрийн баримтыг өгөх, төлбөрийг авах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зочид буудлын хүлээн авагч

**4225 ЛАВЛАХ АЖИЛТАН**

Лавлахын ажилтан нь биеэр хүрэлцэн ирсэн, шуудан, цахим шуудан болон утсаар тухайн байгууллагын бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, бизнесийн бодлого, үйл ажиллагааны талаар харилцагчийн асуулт, санал, гомдолд хариу өгөх, холбогдох ажилтантай холбох, мэдээллийг авах аргыг зааж өгөх зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Тэд ихэвчлэн үйлчлүүлэгчтэй шууд нүүр тулан уулзахад тохиромжтой мөн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэгчтэй холбогдох боломжтой өрөө, танхимд байрлан ажиллах нь зохистой.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлого үнийн талаарх асуултанд хариулах,
- б) мэдээлэл, туслалцаа, зөвлөгөө хүссэн харилцагчид хариулт өгөх,
- в) санал, гомдлыг хүлээн авах, бүртгэх,
- г) хариулахад төвөгтэй асуултыг зөвлөх мэргэжилтэн, менежерт шилжүүлэх,
- д) мэдээллийн товхимол буюу гарын авлага, танилцуулгаар хэрэглэгчийг хангах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мэдээллийн асуудал хариуцсан ажилтан

**4226 ХҮЛЭЭН АВАГЧ (ҮНДСЭН)**

Хүлээн авагч нь зочин, үйлчлүүлэгч, харилцагчийг хүлээн авах, тэдний асуултанд хариулах, уулзалтын цагийг нь товлох зэрэг ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зочин, үйлчлүүлэгч болон харилцагчийг хүлээн авах,
- б) уулзалтын цагийг нь товлох,
- в) утсаар авсан асуулт, хүсэлтэд хариулах,
- г) харилцагч болон үйлчлүүлэгчийг тухайн асуудлаар холбогдох ажилтан, нэгжтэй холбож өгөх,
- д) мэдээллийн товхимол, танилцуулга, гарын авлагаар хангах зэрэг багтана.

**Энд ангилагдсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүлээн авагч, хүлээн авах байрны

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- 4224 Зочид буудлын хүлээн авагч

**4227 СУДЛААЧ, ЗАХ ЗЭЭЛИЙН СУДЛАГЧ**

Судлаач, зах зээлийн судлагч нь судалгааны сэдвийн хүрээнд оролцогчдод асуулт тавьж хариултыг тэмдэглэх, ярилцлага хийх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) удалгаанд оролцогчидтой биечлэн болон утсаар холбогдох, тэдэнд судалгааны зорилгыг тайлбарлах,
- б) урьдчилан бэлтгэсэн асуултыг асуух,
- в) хариултыг цаасан дээр тэмдэглэх эсвэл шууд компьютерийн программ хангамжийн тусламжтайгаар өгөгдлийн санд оруулах,
- г) судалгаанд оролцогчийн асуулт хариултыг дахин нягтлах, лавлах, засварлах,
- д) асуулга, ярилцлагыг хийлгэж байгаа захиалагчид мэдээллийг нэгтгэн өгөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Судлаач

#### **4229 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ БУСАД АЖИЛТАН**

Энэ нэгж бүлэгт 422 дугаар бага бүлэг буюу “Хэрэглэгчийг мэдээлэлээр хангах ажилтан” гэсэн бүлэгт ороогүй үйлчлүүлэгчийг мэдээлэлээр хангах бусад ажилтан багтана. Жишээлбэл: үйлчлүүлэгчээс мэдээллийг авч боловсруулан үйлчилгээнд хамрагдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоодог ажилтан энд хамрагдана.

##### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) эмнэлгийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг олж авахын тулд өвчтөнтэй ярилцах,
- б) нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахын тулд хүсэлт гаргасан иргэнтэй ярилцах, мэдээлэл цуглуулах,
- в) мэдээллийн үнэн, зөв байдлыг шалгах,
- г) халамжийн, үйлчилгээ, тусламж олгох, эсэх, үйлчилгээний хэлбэр төрлийг нь өөрчлөх, дуусгавар болгох зэрэг асуудлаар санал боловсруулах,
- д) нөхөн олговор, халамжийн үйлчилгээний талаар асуултанд хариулах, мэдээлэлээр хангах,
- е) үйлчилгээ үзүүлэх нөхцөл шаардлага хангаагүй үйлчлүүлэгчийг өөр холбогдох байгууллагад чиглүүлж өгөх зэрэг багтана.

##### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эмнэлгийн хүлээн авагч
- Нийгмийн халамжийн төвийн хүлээн авагч

---

### **ДЭД БҮЛЭГ 43 ТООЦООЛОЛ, МАТЕРИАЛ БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН**

---

Тооцоолол, материал бүртгэлийн ажилтан нь санхүү, статистик болон бусад тоон үзүүлэлтийг цуглуулах, тооцоолох, бүртгэх, данс хөтлөх, бизнесийн холбогдолтой шилжүүлэг, төлбөр тооцоог хийх зэрэг ажлыг хийнэ. Энэ ангилалд орсон зарим ажил, мэргэжил нь үйлдвэрлэсэн, борлуулсан, түгээсэн бараа бүтээгдэхүүн, түүхий эд материалын хэрэгцээ зэрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хөтлөх, ачаа болон зорчигч тээврийн хуваарийг гаргах, зохицуулах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх, тооцоолох зэрэг үйл ажиллагаанд туслах, үйлдвэрлэлийн нэгжийн зардлыг тооцоолох, цалин хөлсний тооцоо зарим тохиолдолд цалингийн дугтуй бэлтгэх, цалин, хөлс олгох, статистикийн болон даатгалын мэдээллийг олж авах, тооцоолох, банкны болон даатгалын төлбөр тооцоог хийх, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцоог хийх, үйлдвэрлэсэн, борлуулсан, түгээсэн бараа бүтээгдэхүүн, түүхий эд материалын хэрэгцээ зэрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хөтлөх, ачаа болон зорчигч тээврийн хуваарийг гаргах, зохицуулах зэрэг багтана.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**431 Тооцооллын ажилтан****432 Материал бүртгэл, тээврийн ажилтан****БАГА БҮЛЭГ 431  
ТООЦООЛЛЫН АЖИЛТАН**

---

Тооцооллын ажилтан нь санхүү, статистик болон бусад тоон үзүүлэлтийг цуглуулах, тооцоолох, бүртгэх, данс хөтлөх, бизнесийн холбогдолтой шилжүүлэг, төлбөр тооцоог хийх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Нягтлан бодох бүртгэл, данс хөтлөх, тооцоолох зэрэг үйл ажиллагаанд туслах, үйлдвэрлэлийн нэгжийн зардлыг тооцоолох, цалин хөлсний тооцоо хийх, зарим тохиолдолд цалингийн дугтуйг бэлтгэх, цалин хөлс олгох, статистикийн болон даатгалын талаарх мэдээлэл авах, тооцоолох, банкны болон даатгалын төлбөр тооцоог хийх, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцоог хийх зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4311 Нягтлан бодох данс бүртгэлийн ажилтан****4312 Статистик, санхүүгийн болон даатгалын ажилтан****4313 Цалингийн бүртгэлийн ажилтан****4311 НЯГТЛАН БОДОХ, ДАНС БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН**

Нягтлан бодох, данс бүртгэлийн ажилтан нь нягтлан бодох, данс бүртгэл хөтлөх, ангилах зэрэг ажлыг хийнэ. Түүнчлэн анхан шатны данс



бүртгэлийг хөтлөхөд санхүүгийн баримтыг шалгах, нягтлах, илгээх, тогтмол хийгддэг тооцооллыг хийх зэрэг ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Үнэн зөв бүртгэл хөтлөхийн тулд тоо, баримтыг нягтлан шалгах, данс, бүртгэлийн дугаарыг нь шалгах,
- б) нягтлан бодох, данс бүртгэлийн программ хангамжийг ашиглан, мэдээллийг оруулах, хадгалах, шинжилгээ хийх,
- в) санхүүгийн тоон үзүүлэлтүүдийг ангилах, бүртгэх, нэгтгэх, санхүүгийн бүртгэлийг хэвлэх, товхимол болгон хадгалах,
- г) нэхэмжлэл, төлбөр, дансны хуулга зэргийг тооцоолох, бэлтгэх,
- д) статистик, санхүү, бүртгэлийн эсвэл аудитын дүгнэлтийн, түүнчлэн төлбөрийн баримт, зарлага, өрийн данс, авлагын данс, ашиг алдагдал зэрэг үзүүлэлтүүдийг тусгасан хавтаст материал бэлтгэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нягтлан бодохын туслах ажилтан
- Данс хөтлөлтийн туслах ажилтан
- Тооцооллын туслах ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- 3313 Нягтлан бодох бүртгэлийн туслах ажилтан
- 3313 Данс хөтлөгч

**4312 СТАТИСТИК, САНХҮҮГИЙН БОЛОН ДААТГАЛЫН АЖИЛТАН**

Статистик, санхүү, даатгалын ажилтан нь статистик ба даатгалын тооцооллын мэдээлэл цуглуулах, банк буюу ижил төстэй санхүүгийн байгууллагад бичиг хэргийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) даатгалын бүртгэл, гэрээ цуцлалт, нөхөн олговор, даатгалын нөхцөл, төлбөр тооцоонд орсон өөрчлөлтүүдийг эмхлэх,
- б) тодорхой үе шаттайгаар байнга буюу цаг үеийн мэдээлэл, үйл явцын дагуу холбогдох статистикийн, мэдээллийг цуглуулж эмхлэх,
- в) нийт ба дундаж үзүүлэлтээр, хувь хэмжээгээр болон бусад аргаар тооцоолж, шаардлагын дагуу хүснэгтэн хэлбэрт оруулах,
- г) санхүүгийн баримт бэлтгэх, хүү буюу зуучилсны хөлс, тэмдэгтийн хураамж зэргийг тооцоолох,
- д) үйлчлүүлэгч буюу хөлслөгчийг төлөөлөн худалдан авсан буюу худалсан үнэт цаас, хувьцаа болон бусад үнэт цаасны бүртгэл хөтлөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Даатгалын тооцооны ажилтан
- Брокерийн ажилтан
- Санхүүгийн ажилтан
- Үнэт цаасны ажилтан
- Статистикийн ажилтан
- Татварын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |   |
|------|---|
| 3314 | Статистикийн ажилтан                    |
| 3311 | Үнэт цаасны брокер                      |
| 3324 | Борлуулалтын брокер                     |
| 3313 | Нягтлан бодох бүртгэлийн туслах ажилтан |

**4313 ЦАЛИНГИЙН БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН**

Цалингийн бүртгэлийн ажилтан нь байгуулага, аж ахуйн нэгж, тэдгээрийн нэгжийн ажилтны цалин хөлс, бусад тэтгэлэг, тусламжийг бодох, цалин хөлстэй холбоотой мэдээлэл цуглуулах, нягтлан шалгах, тулгах, үнэн зөв байдал, хууль тогтоомжид нийцүүлэн засварлах зэрэг ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цалин хөлс, бусад тэтгэлэг, тусламжийг тооцохын тулд гар аргаар, компьютерээр ажилтны ирц, илүү цаг, бусад шалтгаан зэргийг бүртгэх,
- б) ажилтны жилийн цалин хөлсийг, татвар, шимтгэл төлсний дараах олговол зохих хэсгийг тухайн үеийн байдлаар бэлтгэн гаргах, татвар, шимтгэл, хураамж зэргийг тооцоолон гаргаж өөрсдөд нь танилцуулан баталгаажуулах,
- в) ажилтны цалин хөлс, бусад төлбөрийг дансанд нь шилжүүлэхэд бэлтгэх, төлбөрийн чекийг бэлтгэх,
- г) цагийн бүртгэл, ажлын хуваарь, тооцоолсон цалин хөлс зэргийг нягталж дутуу, илүү олгосон цалин хөлс, төлбөрийн зөрүүг зохицуулах,
- д) ирц, цагийн бүртгэл, цалин хөлс зэрэг мэдээллийг зохих журмын дагуу бүртгэн албажуулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цалингийн бүртгэлийн ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 3313 | Нягтлан бодох бүртгэлийн туслах мэргэжилтэн |
|------|---|

3313	Данс бүртгэгч
4311	Нягтлан бодох, данс бүртгэлийн ажилтан

## БАГА БҮЛЭГ 432

### МАТЕРИАЛ БҮРТГЭЛ, ТЭЭВРИЙН АЖИЛТАН

Материал бүртгэл, тээврийн ажилтан нь үйлдвэрлэсэн, худалдан авсан, нөөцөлсөн, ачуулсан бараа материал болон үйлдвэрлэлд шаардагдах материалын бүртгэл хөтлөнө.

#### Гүйцэтгэх үүрэг:

Үйлдвэрлэсэн, нөөцөлсөн, захиалсан болон ачуулсан бараа материалын бүртгэл хөтлөх, хүлээн авсан, нөөцөнд оруулсан болон ашигласан үйлдвэрлэлийн бараа материалын бүртгэл хөтлөх, үйлдвэрлэлд шаардагдах түүхий эд, бараа материалын тоо хэмжээг тооцоолох ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хуваарийг бэлтгэн, шалгахад туслах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бусад бүртгэлийг хөтлөх, зорчигч ба ачаа тээврийн цагийн хуваарийг зохицуулах зэрэг багтана.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### 4321 Материал нөөцийн ажилтан

#### 4322 Үйлдвэрлэлийн ажилтан

#### 4323 Тээврийн ажилтан

### 4321 МАТЕРИАЛЛЫН НӨӨЦИЙН АЖИЛТАН

Материалын нөөцийн ажилтан нь үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, хүлээн авсан, олгосон, ачуулсан буюу нөөцөлсөн материалын бүртгэлийг хөтөлнө.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) бараа хүлээн авах, ачуулах ажлыг зохион байгуулах, хянах, холбогдох бүртгэл хөтлөх,
- б) нөөцийн бүртгэл хөтлөх, бараа бүтээгдэхүүний олголтод хяналт тавих эрэлт хэрэгцээг тодорхойлж захиалга хийх,
- в) багаж хэрэгсэл, сэлбэг буюу төрөл бүрийн төхөөрөмж хүлээн авах, хадгалах ба олгох бүртгэлийг хөтлөх,
- г) хүлээн авсан, олгосон, үйлдвэрлэсэн буюу илгээсэн барааны холбогдох бүртгэл хөтлөх,

## **4** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

д) хадгалахаар хүлээн авсан тавилга, эд хогшил болон бусад зүйлийг бүртгэн данс хөтлөх зэрэг багтана.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ачаа илгээх ажилтан
- Ачаа хүлээн авах ажилтан
- Нөөц бүртгэлийн ажилтан
- Агуулахын ажилтан
- Жигнэх, хэмжих ажилтан

### **4322 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖИЛТАН**

Үйлдвэрлэлийн ажилтан нь үйлдвэрлэлийн тодорхой хугацаанд шаардагдах материалын тоо хэмжээг тооцоолон гаргаж, үйлдвэрлэлийн хуваарь, төлөвлөгөө боловсруулан хяналт тавих ажлыг хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлдвэрлэлийн шаардлагатай материалын тоо хэмжээ, чанар, стандарт, нэр төрлийг тооцоолж гаргах,
- б) материалын хэрэгцээг төлөвлөх, шаардлагатай үед нь тэдгээрийг татан авах, бэлэн байлгах, зохих бүртгэлийг хөтлөх,
- в) үйлчлүүлэгчдийн захиалга, үйлдвэрлэлийн хүчин чадлыг үндэслэн үйлдвэрлэлийн ажлын хуваарь төлөвлөгөө боловсруулахад туслах,
- г) нөөцийг шалгах, хангалт түгээлтийн ажлыг зохицуулах, саатлын шалтгааныг олох,
- д) ажлын үйл явцын талаарх мэдээлэл авч, бусад нэгжүүдийн ажил, түүхий эд, материалын хэрэгцээг зохицуулах зэрэг багтана.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үйлдвэрлэлийн ажилтан
- Материалын төлөвлөлтийн ажилтан

### **4323 ТЭЭВРИЙН АЖИЛТАН**

Тээврийн ажилтан нь тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэх, төмөр зам, авто зам, нисэх онгоцоор зорчих ба ачаа тээвэрлэх цагийн хуваарийг зохицуулах, удирдлагад тайлан бэлтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тээврийн үйлчилгээ, хөсгийн ашиглалтанд хяналт тавих, зорчигч ба ачаа тээврийн цагийн хуваарийг зохицуулах,

- б) төмөр замын сүлжээний тодорхой хэсэг, орон нутгийн хэмжээнд галт тэрэгний замналыг тогтоон удирдах, зохих бүртгэлийг хөтлөх,
- в) төмөр замын ачааны талбайд ачаа ачих, буулгах ажлыг удирдах, хянах ба бүртгэл хөтлөх,
- г) тээврийн хэрэгсэл болон жолооч нарыг хуваарилах, ачааг ачих, буулгах, дамжин өнгөрөх барааг хадгалах зэрэг авто тээврийн ашиглалтын үйл ажиллагааг зохицуулах, бүртгэлийг хөтлөх,
- д) зорчигчдын нэрийн жагсаалт, ачааны мэдүүлэг зэрэг агаарын тээвэрт холбогдох бусад үйл ажиллагааг зохицуулах, бүртгэл хөтлөх,
- е) удирдлагад тайлан гаргаж өгөх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хянагч (тээврийн үйлчилгээ)
- Диспетчер (тээврийн үйлчилгээ)

---

## ДЭД БҮЛЭГ 44

### КОНТОРЫН БУСАД ТУСЛАХ АЖИЛТАН

---

#### БАГА БҮЛЭГ 441

#### КОНТОРЫН БУСАД ТУСЛАХ АЖИЛТАН

---

Бичиг хэргийн ажилтан нь сонин, шүүх, номын сан, шууданд бичиг хэргийн ажил хийх бөгөөд баримт бичгийг бүртгэх, ангилах, хадгалах, мэдээлэл боловсруулахад бэлтгэх, материалыг эх хувьтайгаа таарч байгаа эсэхийг шалгах, боловсон хүчний хувийн хэрэг хөтлөх, уншиж бичих боломжгүй хүмүүсийн өмнөөс уг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Номын санд ном авах, олгохтой холбогдсон мэдээллийг бүртгэх, янз бүрийн баримт бичиг, бусад тэмдэглэл хөтлөх, ялгаж ангилах, хадгалах, боловсон хүчний хувийн хэрэг хөтлөх, шуудан холбооноос ирсэн, мөн түүнчлэн байгууллагаас илгээсэн буюу дотооддоо гаргасан шууданг ялгах, бүртгэх, тараах, кодлох, засварлах, бичиг хэргийн бусад ажил гүйцэтгэх, уншиж бичиж чаддаггүй хүмүүсийн өмнөөс бичих зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**4411 Номын сангийн ажилтан**

**4412 Шуудан хүргэгч ба ялгагч**

**4413 Кодлох, бичиг хянах ба эдгээрт холбогдох бусад ажил гүйцэтгэгч**

**4414 Бичээч ба түүнд холбогдох ажил гүйцэтгэгч**

**4415 Бичиг баримт ангилах ба хувилах ажилтан**

**4416 Боловсон хүчний ажилтан**

**4419 Өөр газар ангилагдаагүй бусад албан хаагч**

#### **4411 НОМЫН САНГИЙН АЖИЛТАН**

Номын сангийн ажилтан нь ном, материал олгох, авах, ном, дуун болон дүрс бичлэг, тогтмол хэвлэл, сонин ялгаж ангилах, тавиурт байрлуулах ба номын сан ашиглагчдад ерөнхий мэдээлэл өгнө.

##### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) номын сангийн ном, бусад материалыг олгох, хүлээн авах,
- б) ном болон бусад материалыг тавиур дээр буцааж байрлуулах,
- в) гар болон цахим аргаар бүртгэх, ангилах, хадгалах, шаардлага гарвал бичиг боловсруулах, шивэх зэргээр бичиг цаасны ажил гүйцэтгэх,
- г) хэвлэлийн захиалга хөтлөх,
- д) номын сан ашиглагчдад номын сангийн үндсэн материалтай танилцах боломж олгох, номын сан хооронд ном солилцох, зээлэх ажил явуулах,
- е) номын сангийн ном, бусад материал худалдаж авах, олгох, буцааж авахтай холбогдсон бүртгэл хөтлөх.

##### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Номын санч
- Номын сангийн фондын эрхлэгч

#### **4412 ШУУДАН ЗӨӨГЧ, ЯЛГАГЧ АЖИЛТАН**

Шууданхүргэгчбаялгагчнь шуудангийн болон холбогдох байгууллагаас ирсэн, түүнчлэн тухайн байгууллагаас гаргасан буюу дотооддоо хуваарилах шуудангийн үйлчилгээнд холбогдсон ялгах, бүртгэх, тараах болон бусад ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нийтийн шуудан буюу хувийн өмчийн түгээх байгуулагад шуудантай холбогдох ажлууд гүйцэтгэх,
- б) шуудан ялгаж, айл өрх, аж ахуйн нэгжид хүргэх,
- в) үйлчлүүлэгч хүссэн үед шуудан хүргэснийг нотлох бүртгэл, баримтыг үзүүлэх,
- г) ирсэн ба явсан шууданг ялгаж, ердийн бүртгэл хөтлөх, илгээх шууданг зохих газруудад тараах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шуудан илгээгч
- Шуудан хүргэгч, зөөгч
- Шуудан ялгагч

**4413 КОДЛОГЧ, ХЯНАН ТОХИОЛДУУЛАГЧ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Энэхүү ажлыг гүйцэтгэх ажилтан нь мэдээллийг кодоод хувиргах, бичгийн алдааг хянаж засах зэрэг ажил гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мэдээлэл боловсруулах зорилгоор мэдээллийг кодоод хувиргах ба мэдээллийг кодоор ангилах,
- б) хэвлэхэд бэлтгэсэн бичиг болон холбогдох материалыг эх хувьтай нь тулгаж хянан засах, тогтсон журмын дагуу бичгийг хэвлэж гаргахад зориулж бичвэр үйлдэх,
- в) маягтуудыг ялгаж, таних тэмдэг, дугаар тавих,
- г) баримт бичиг бүртгэх, ангилан ялгах, хуудаслан эмхэтгэх,
- д) тараах бичиг, захидлын дугтуйг гараар хаяглах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Кодлогч
- Бичиг хянагч

**4414 БИЧЭЭЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Бичээч ба түүнд холбогдох бусад ажил гүйцэтгэх ажилтан нь бичиг үсэггүй хүмүүсийн өмнөөс захидал бичих ба маягт бөглөх ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бичих буюу унших боломжгүй хүмүүст захидал болон бусад бичмэл зүйлийг дуудаж өгөх ба шаардлагатай тайлбар, мэдээлэл өгөх,

- б) бусдын өмнөөс захидал бичих болон маягт бөглөх,
- в) бусад хүмүүст зөвөлгөө, тайлбар өгөх, засгийн болон бусад албан ёсны маягтуудыг бөглөхөд туслах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бичээч

#### **4415 ФАЙЛДАГЧ, ОЛШРУУЛАГЧ АЖИЛТАН**

Бичиг баримт файлдагч, хувилагч ажилтан нь албан бичиг, захидал, нэхэмжлэх, төлбөрийн баримт, бусад бичлэг, тэмдэглэлийг цагаан толгойн юмуу тоон дэс дарааллаар, эсвэл тогтсон өөр журмаар бүртгэх, ангилах, хадгалах ажил гүйцэтгэнэ. Мөн шаардлага гарвал файлаас материал олох, устгах, баримт бичиг хувилах, скайнерээр татах, факсаар илгээх ажил гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) агуулга, зорилго, ашиглах шалгуур буюу цаг хугацаа, цагаан толгойн эсвэл тоон дэс дараалал зэрэг удирдамжинд заасан журмын дагуу материал ялгах буюу ангилах,
- б) материалыг бүртгэн ангилж, шүүгээ, хайрцаг, шургуулганд хийж хадгалах,
- в) шаардлагатай үед файлаас материал олох ба устгах,
- г) бүртгэн ангилж, хадгалсан болон устгасан материалын бүртгэл хөтлөх,
- д) баримт бичгийг хувилах, скайнерээр татах, факсаар илгээх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хувилах ажилтан
- Архивын ажилтан

#### **4416 ХҮМҮҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН**

Боловсон хүчний ажилтан нь ажиллагчдын сэлгээ, албан тушаалын өөрчлөлт, үр дүнгийн үнэлгээ, албан хаагчийн амралт, чөлөө, цалин хөлс, мэргэжил, сургалтын тухай бүртгэл, мэдээллийг хадгалж шинэчилж байх үүргийг гүйцэтгэнэ

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ажил эрхэлсэн түүх, цалин, үр дүнгийн үнэлгээ, мэргэшил, сургалт, авсан болон хуримталсан амралт, чөлөөний тухай мэдээллийг шинэчлэх,
- б) шинээр томилогдсон ажилтнуудын бүртгэл, мэдээллийг хөтөлж эхлэх, бүртгэл, мэдээллийн бүрэн эсэхийг шалгах,



- в) ажилд орох болон тушаал дэвшихийг хүссэн өргөдлийг хүлээн авч боловсруулан үр дүнг нь өргөдөл гаргагчдад мэдэгдэх,
- г) ажлын нөхцөл, хангамжийн талаархи асуулт, лавлагааг хүлээн авч шийдвэрлүүлэх,
- д) ажлын өргөдлүүд, ажилд авах зарлал, шалгалтын зарлалыг гадагш илгээх,
- е) гар болон компьютержсэн хадгалалт, бүртгэл, бичлэгийн системийг ажиллуулж, шинэчилж байх, боловсон хүчний үйл ажиллагаатай холбогдсон тайлан, бичиг баримтуудыг цуглуулж эмхэтгэх,
- ж) боловсон хүчний бүртгэл, мэдээлэл, хавтаст хэргийг хадгалах, хүссэн үед гаргаж авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүмүүний нөөцийн туслах ажилтан
- Хүмүүний нөөцийн ажилтан

**4419 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ КОНТОРЫН БУСАД ТУСЛАХ/ДЭД АЖИЛТАН**

Энэ хэсэг нь “Захиргааны ажилтан” гэсэн 4 дүгээр бүлэгт ангилагдаагүй ажилтныг хамарч байна. Тухайлбал, захидал харилцааны ажилтан, хэвлэлийн хайчилбар хийгчид, хэвлэл нийтлэлийн ажилтныг энд оруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хэрэглэгчдээс зар сурталчилгааны захиалга хүлээн авах, бичих, найруулах, зар сурталчилгааны үнийг тооцох, хэрэглэгчдэд нэхэмжлэх бичих,
- б) мэдээлэл, туслалцаа хүссэн хүсэлтийн хариу, хохирол барагдуулах тухай мэдэгдэл, зээл ба нэхэмжлэлийн талаархи лавлагаа, үйлчилгээний талаархи гомдол зэрэг бизнесийн болон захиргааны бичиг захидал бичих,
- в) тогтмол хэвлэл, зар сурталчилгаа, каталоги, лавлах, бусад хэвлэл нийтлэлийн материал бэлтгэхэд туслах,
- г) сонин, сэтгүүл, хэвлэлийн мэдээ, бусад нийтлэлийг уншиж, ажилтнууд болон захиалагчдад сонирхолтой өгүүлэл олж цуглуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зар сурталчилгааны ажилтан
- Захидал харилцааны ажилтан
- Лавлах материал цуглуулж эмхэтгэгч
- Хэвлэл нийтлэлийн ажилтан
- Хэвлэлийн хайчилбар хийгч

## ҮНДСЭН БҮЛЭГ 5

# ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

---

Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах юмуу хууль бус үйлдэл, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Энэ үндсэн бүлэгт орсон ажил, мэргэжил нь Олон улсын ажил мэргэжлийн стандарт (ISCO)-ын ур чадварын 2 дугаар түвшний шаардлагыг хангасан байна.

### Гүйцэтгэх үүрэг:

Аялал зохион байгуулж үйлчлэх, гэр ахуйн ажил эрхлэх, хүнс, ундааны зүйл бэлтгэх, түүгээр үйлчлэх, хүүхэд асрах, айл өрх юмуу байгууллагад эрүүл мэндийн хувийн ба суурь үйлчилгээ үзүүлэх, мөн түүнчлэн үс засах, гоо сайхны үйлчилгээ хийх, хувь төөрөг хэлэх, шарил хайлах, занданшуулах, оршуулгын зан үйл хийх, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх, хүн болон эд хөрөнгийг гал түймэр, хууль бус үйлдлээс хамгаалах, хууль ёс, хэв журмыг сахиулах, зар сурталчилгаа, урлагийн бүтээл, барааны сурталчилгаанд загвар өмсч үзүүлэх, бөөний буюу жижиглэн худалдаалах газар, мухлаг, зах дээр бараа худалдах, хэрэглэгчдэд бараа үзүүлэн таниулах. Бусад ажилтанд хяналт тавих ажлыг энд бас оруулж болно.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 51 Хувийн үйлчилгээний ажилтан**
- 52 Худалдааны ажилтан**
- 53 Хувь хүн асрах ажилтан**
- 54 Хамгаалах үйлчилгээний ажилтан**

---

## ДЭД БҮЛЭГ 51

### ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

---

Хувийн үйлчилгээний ажилтан нь аялал, гэр ахуй, нийтийн хоол, хүүхдийн болон хувь асрамжтай холбогдсон үйлчилгээ үзүүлнэ.

Энэ үндсэн дэд бүлэгт хамаарах ажилтны ажил үүрэгт ихэвчлэн дараах зүйлийг оруулна: аялалын үед үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах, гэр ахуйн ажил эрхлэх, хоол, ундааны зүйл бэлтгэх, түүгээр үйлчлэх, айл буюу байгууллагад эрүүл мэндийн хувийн ба суурь үйлчилгээ үзүүлэх, мөн түүнчлэн үс засах, гоо сайхнаар үйлчлэх, хүнд бараа болох, хувь төөрөг хэлэх, шарил хайлах, оршуулгын зан үйл явуулах. Бусад ажилтанд хяналт тавих ажлыг энд оруулж болно.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**511 Аялалын хөтөч, улаач, тайлбарлагч**

**512 Тогооч**

### **БАГА БҮЛЭГ 511**

#### **АЯЛАЛЫН ХӨТӨЧ, УЛААЧ, ТАЙЛБАРЛАГЧ**

---

Аялалын хөтөч, улаач, тайлбарлагч нь нисэх онгоц, галт тэрэг, усан онгоц, автобус, бусад тээврээр аялахад холбогдох төрөл бүрийн хувь үйлчилгээ үзүүлэх, тойрон аялал, дурсгалт газар үзэх, танилцах аялалаар явж буй хувь хүмүүс, бүлгийг дагалдана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Зорчигчдын ая тух, аюулгүй байдлыг хангах, хоол, ундаар үйлчлэх, аялалын талаар мэдээлэл өгөх, асуултад хариулах, нийтийн тээврээр зорчих тасалбар хураах, тараах, дурсгалт газар үзэх аялал буюу экскурсээр явах хувь ба бүлэг хүмүүсийг дагалдаж, сонирхолтой зүйлүүд тайлбарлаж өгөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5111 Аялалын туслагч ба үйлчлэгч**

**5112 Тээврийн хэрэгслийн улаач**

**5113 Аялалын хөтөч**

#### **5111 АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛЧЛЭГЧ**

Агаарын хөлгийн үйлчлэгч нь ихэвчлэн зорчигчийн зааландах үйлчилгээг гүйцэтгэх ба зорчигчдын аюулгүй байдал, тав тухыг хангах, хоол ба хөнгөн зуушаар үйлчлэх үүрэгтэй. Мөн хөлөг онгоцон дээрх нийтийн арга хэмжээ ба өрөөний үйлчилгээг хариуцна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) агаарын хөлөг, усан онгоцоо зорчигчдыг угтан авах, зорчигчдын тасалбарыг шалгах ба тэдний суудал болон амрах байрыг зааж өгөх,
- б) ослын үед хэрэглэгдэх хүчилтөрөгчийн маск, суудлын даруулга, аврах хантааз зэргийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөөг өгч биеэр үзүүлэх,
- в) урьдчилан бэлтгэсэн хоол, хөнгөн зуушаар үйлчлэх,
- г) татваргүй бараа болон бусад бараагаарж үйлчлэх,
- д) аялалын явцад зорчигчдын тав тух ба тэдэнд анхаарал тавих, хүсэлтэд хариулах, зорчигчийн заалны ариун цэвэр болон эмх цэгцийг хангах,
- е) ослын буултын үед зорчигчдод туслах, тэднийг удирдаж, ослын буултын заавар, журмыг дагаж мөрдөх,
- ж) анхны тусламжийн хэрэгслийн иж бүрдэл болон аврах төхөөрөмжүүд горимын дагуу ажиллаж буй эсэхийг тодорхойлох,
- з) зорчигчдод анхны тусламж үзүүлэх,
- и) нислэгийн өмнө аялалын чиглэл, цаг агаарын байдал, нислэгийн өндөр, хурд ослын үеийн журам, нисэх багийн бүрэлдэхүүн, аялалын үргэлжлэх хугацаа, нислэгийн үед үйлчлэх хоол, хөнгөн зуушны цэс, зорчигчдын тоо зэргийг танилцуулах,
- к) агаарын хөлөг хөөрөх, газардахын өмнө зорчигчдыг бэлтгэх,
- л) хүүхэд, өндөр настан, хүнд өвчтэй зорчигчдод шаардагдах үйлчилгээ, тусалцааг урьдчилан тодорхойлох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нисэх буудлын үйлчилгээний ажилтан
- Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан

**5112 НИЙТИЙН ТЭЭВРИЙН КОНДУКТОР**

Тээврийн кондуктор нь галт тэрэг, трамвай, автобус, нийтийн тээврийн бусад хэрэгслээр зорчих тасалбарыг түгээх, төлбөрийг хураан авах буюу зорчигчийн тав тух, аюулгүй байдлыг хангах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зорчих тасалбар, зөвшөөрөл ба төлбөрийг хураан авах буюу түгээх, урьдчилан олгосон тасалбар хүчин төгөлдөр эсэхийг шалгах,
- б) галт тэрэгний зорчигчийн тасалгаанд үйлчилгээ үзүүлэх,
- в) өндөр настан, өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст галт тэргэнд суух, буух, ачаа тээшийг нь зөөхөд туслах,
- г) зорчигчдод хаалга нээх, хаахад нь туслах,
- д) хөдөлгөөнд ороцохоос өмнө тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хяналт тавих,

- е) жолоочид зогсох, хөдлөх үед дохио өгөх,
- ж) тээврийн хэрэгслээр зорчигч байгаа зорчигчдыг угтах, аялалын чиглэл, зогсоолыг зарлах,
- з) аюулгүй ажиллагааны журам, дүрмийг биелүүлэх,
- и) зорчигчдын хүсэлт, гомдлыг хүлээн авах, зогсоолын тухай мэдээлэл өгөх,
- к) осол, аюул тохиолдсон үед зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Автобусны кондуктор
- Тасалбар олгогч, уулын дүүжин тэргэнцэр(Cable car) ажиллуулагч
- Тасалбар шалгагч (нийтийн тээвэр)
- Галт тэрэгний кондуктор
- Трамвайн кондуктор
- Тролейбусны кондуктор

**5113 АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЧ**

Аялал, жуулчлалын хөтөч нь аялал, жуулчлал болон зугаалга, зочилж яваа хүмүүсийг дагалдан газарчилж түүхийн дурсгалт газар, үйлдвэрлэлийн болон тоглоомын парк зэрэг газрын сонирхол татах өвөрмөц гоц байдал, түүний өнөөгийн байдал болон өнгөрсөн түүх зэргийг нь тайлбарлах, танилцуулах ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) аялал, зугаалгаар яваа зочныг дагаж газарчлах,
- б) музей, үзэсгэлэн, тоглоомын парк, үйлдвэрийн газар зэрэг газарт зочныг дагалдах,
- в) сонирхсон асуултад хариулах, мэдээллээр хангах, тайлбарлах,
- г) сургуулийн хүүхдийн хичээлд оролцох,
- д) аялалд оролцогч болон зочдыг тосож авах бүртгэх, аюулгүй байдлыг хангах хэрэгсэл болон таних тэмдэгээр хангах,
- е) аялалын үйл ажиллагаа, зарчим, үзмэрийн талаарх дуу, дүрс бичлэг үзүүлэх, танилцуулга тараах,
- ж) аялалын багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах, анхны тусламжийг хэрхэн үзүүлэх болон аюултай нөхцөлд хэрхэн ажиллах талаар зааварчлага өгөх,
- з) үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг хүлээн авч, шийдэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Соёлын галерейн хөтөч
- Аялалын дагалдагч

**БАГА БҮЛЭГ 512**  
**ТОГООЧ**

---

Тогооч нь зочид буудал, зоогийн, нийтийн хоолны бусад газар, хөлөг онгоц, суудлын галт тэрэг болон айл өрхөд хоол хүнс бэлтгэх боловсруулах ажлыг төлөвлөн зохион байгуулж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хоол хүнсийг боловсруулан бэлтгэх, хоол бэлтгэгчийн ажлыг удирдан зохион байгуулах зэрэг орно.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5120 Тогооч****5120 ТОГООЧ**

Тогооч нь зочид буудал, зоогийн, нийтийн хоолны бусад газар, хөлөг онгоц, суудлын галт тэрэг болон айл өрхөд хоол хүнс бэлтгэх ажлыг зохион байгуулж хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хоол хүнсийг бэлтгэж, боловсруулах,
- б) хоол бэлтгэгчийн ажлыг удирдан зохион байгуулах,
- в) хоол хүнсний амт, чанарыг шалгах,
- г) тусгай жор болон өөрийн зохиосон жор, орцын дагуу хоолны орцыг жигнэж хэмжих, холих,
- д) шарах шүүгээ, шарагч, бусад хоол хийх тоног төхөөрөмжийн температурыг тохируулах, хоол хүнс бэлтгэх эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор гал тогооны өрөө, гал тогооны хэрэгсэл, тоног төхөөрөмж болон үйлчилгээний хэсгийг цэвэр байлгаж, шалгах,
- е) том шарагч, хайруулын таваг зэрэг их хэмжээтэй хоол хийх зориулалт бүхий тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тогооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |                               |
|------|-------------------------------|
| 3434 | Тогооч                        |
| 9411 | Түргэн хоолны газрын бэлтгэгч |

**БАГА БҮЛЭГ 513**  
**ЗӨӨГЧ, БАРМЕН**

Зөөгч, бармен нь нийтийн хоолны болон баар, цэнгээний газар, зоогийн, цайны газар, хөлөг онгоц, суудлын галт тэргэнд халуун, хүйтэн хоол, ундны зүйлээр үйлчилнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчилгээнд хэрэглэсэн шилэн эдлэл, аяга тавгийг угаах, баарны заалыг цэвэрлэх, согтууруулах болон бусад ундаагаар үйлчлэх, ширээний бүтээлэг, хутга, сэрээ, халбага, аяга таваг болон бусад хэрэгслийг оролцуулан ширээ засах, халуун, хүйтэн хоолоор үйлчлэх, дарс сонгоход зөвлөх ба дарсаар үйлчлэх, халуун, хүйтэн хоол/ундны зүйлсийн захиалга авах, захиалгыг гал тогоонд дамжуулах, үйлчлүүлэгчид үйлчилгээний тооцоог танилцуулж, төлбөр хүлээн авах зэрэг болно.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5131 Зөөгч****5132 Бармен****5131 ЗӨӨГЧ**

Зөөгч нь нийтийн хоолны болон баар, цэнгээний, зоогийн, цайны газар, хөлөг онгоц, суудлын галт тэргэнд халуун, хүйтэн хоол, ундны зүйлээр үйлчилнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цэвэрхэн ширээний бүтээлэг, хутга, сэрээ, халбага, аяга таваг болон шилэн эдлэлээр ширээ засах,
- б) үйлчлүүлэгчидтэй мэндэлж, тэдэнд хоолны цэс болон уух зүйлсийн цэс өгөх,
- в) үйлчлүүлэгчдэд хоол, ундны зүйл сонгоход зөвлөх,
- г) халуун, хүйтэн хоол/ундны захиалга авах, захиалгыг гал тогоо эсхүл барменд дамжуулах,
- д) үйлчлүүлэгчдийн ширээнд захиалсан хоол, уух зүйлсийг авчирч үйлчлэх,
- е) ширээг цэвэрлэж, бохир аяга, таваг болон хутга, сэрээ, халбагыг гал тогоонд буцаан өгөх,
- ж) тооцоог үйлчлүүлэгчид танилцуулж, төлбөр хүлээн авах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зөөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |                   |
|------|-------------------|
| 1412 | Рестораны менежер |
| 5132 | Бармен            |

**5132 БАРМЕН**

Бармен нь согтууруулах ундаа болон бусад ундны зүйлсээр үйлчлүүлэгчид шууд өөрөө эсвэл зөөгчөөр дамжуулан хүргүүлж үйлчилнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) халуун болон хүйтэн ундны зүйлсийн захиалгыг зөөгч, үйлчлэгч нараас эсвэл шууд үйлчлүүлэгчээс авах,
- б) согтууруулах болон бусад ундны зүйлсээр үйлчлэх,
- в) цай, кофе бэлтгэх хэсэг болон баарны заалыг цэвэр байлгах, хэрэглэсэн аяга, хундагыг угаах,
- г) үйлчлүүлэгчээс мөнгө хураах, тэмдэглэл хөтлөх, орлогын дүнг нь гаргах,
- д) баар шаардлагатай нөөцтэй байхад туслах, хундага, шилэн аяга болон бусад хэрэгслийг хангалттай байлгах,
- е) үйлчлүүлэгчийн үнэмлэх, бичиг баримтыг шалгаж согтууруулах ундаа худалдан авах насанд хүрсэн эсэхийг тогтоох,
- ж) согтууруулах ундаа хэтрүүлэн уух үйлчлүүлэгчийг болиулах арга хэмжээ авах,
- з) коктейл болон бусад ундны зүйлсийг бэлтгэхийн тулд хольж найруулах,
- и) хөнгөн зуушаар үйлчлэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бармен

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |       |
|------|-------|
| 5131 | Зөөгч |
|------|-------|

**БАГА БҮЛЭГ 514****ҮСЧИН, ГОО САЙХАНЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Үсчин, гоо сайханч, холбогдох бусад ажилтан нь хувь хүний гадаад өнгө төрхийг сайжруулах зорилгоор үс засах, тайрах, сахал хусах, засах,



гоо заслын үйлчилгээ хийх, нүүр будах болон бусад төрлийн гоо сайхны үйлчилгээ хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчийн хүсэл, сонирхолын талаар ярилцаж, зөвөлгөө өгөх,
- б) үс засах буюу тайрах,
- в) сахал хусах буюу засах,
- г) гоо заслын үйлчилгээ хийх, нүүр будалт хийх,
- д) гар, хөлийн хумс засах, будах, хөлийн эвэр, муруй ургасан хумсны согогийг засах,
- е) үйлчлүүлэгчийг ванн, массажинд ороход үйлчилж, анхан шатны иллэг массаж хийж өгөх зэрэг ажил багтана.

Энэ бүлэг дэх ажил мэргэжил нь дараах нэгж бүлэгт ангилагдана:

**5141 Үсчин**

**5142 Гоо сайханч холбогдох бусад ажилтан**

**5141 ҮСЧИН**

Үсчин нь үс тайрах, хэлбэр загвар гаргах, будах, шулуун болгох, долгион оруулах, хайчлах зэрэг үйлчилгээг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үс тайрах, угаах, буржийлгах, өнгийг нь хувиргах,
- б) сахал засах, хусах,
- в) үйлчлүүлэгчийн захиалга, хүсэлтээр хиймэл үс тохируулах,
- г) үсний засалт, үс арчилгааны болон үсний бүтээгдэхүүний талаар зөвөлгөө өгөх,
- д) үсний засалтыг хагалдаг газрыг нь өөрчлөх, уртасгах болон хөвсийлгөх зэргээр хэв загварыг өөрчлөх,
- е) үйлчлүүлэгчийн захиалга авах,
- ж) ажлын байраа цэвэрлэх, багаж хэрэгслээ ариутгах, үйлчилгээний төлбөр авах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Эрэгтэй үсчин
- Эмэгтэй үсчин
- Үс арчилгааны мэргэжилтэн

**5142 ГОО САЙХАНЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Гоо сайханч, холбогдох бусад ажилтан нь хүний нүүр, биеийн байдлыг өөрчлөн гоо сайхан болгох зорилгоор нүүр биед гоо сайхны бүтээгдэхүүн түрхэх, төрөл бүрийн арчилгаа хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нүүр болон биеийн хэсгийг цэвэрлэх, тос, чийгшүүлэгч зэрэг гоо сайхны холбогдох бүтээгдэхүүнийг түрхэх,
- б) нүүрний болон биеийн массаж хийх,
- в) гоо сайхны газраар үйлчлүүлэгч болон жүжигчин, тайзнаа гарах хүмүүсийн нүүр будалтыг хийх,
- г) хөл болон гарын хумсийг цэвэрлэх, өнгөлөх, засах, хөлний эврийг авах, хэлбэрээ алдсан хөлний хумсыг хэлбэрт оруулах,
- д) анхан шатны массаж хийх, усанд оруулах,
- е) хүний биед байгаа хүсээгүй үсийг арилгах арга техникүүдийг хэрэглэх,
- ж) жингээ хасах, турахад нь туслах зорилгоор хоолны дэглэм сахих, дасгал хийх талаар зөвлөгөө өгөх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Усанд оруулагч
- Гоо сайханч
- Хумс засаж, будагч
- Нүүр будагч
- Турах зөвлөгөө өгөгч

**БАГА БҮЛЭГ 515****БАЙР, БАЙШИН, ГЭР АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

Байр, сууцны аж ахуйн хянагч худалдаа, үйлдвэр, орон сууцны байранд ажиллаж байгаа цэвэрлэгч, үйлчлэгч, аж ахуйн бусад ажилтнуудын ажлыг уялдуулан зохицуулах, төлөвлөх, хянах үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн зочид буудал, албан ажлын байр, орон сууц, байшин, хувийн сууцанд арчилгаа, тордлогыг хариуцна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Цэвэрлэгээ, арчилгаа, засвар үйлчилгээний ажил хэр зэрэг зохистой явагдаж буйд хяналт тавин байр, талбайд үзлэг шалгалт хийх, үүрэг даалгавар өгөх, гарт бэлэн байх материал, зүйлсийг хүрэлцээтэй байлгах үүднээс материал, төхөөрөмж, хэрэгслийг нөөцөөс олгох, ажилд орох

хүсэлтийг шүүж, авах эсэхийг санал болгох, шинэ болон туршлагатай ажилтнуудыг сургах, тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, ажлаас халах талаар зөвлөмж гаргах, зарим цэвэрлэх, арчлах болон засвар үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5151 Албан газар, зочид буудал, бусад байгууллагын цэвэрлэгээ, аж ахуй хариуцсан хянагч**

**5152 Гэрийн аж ахуй хариуцагч**

**5153 Байр, сууцны арчилгаа хариуцагч**

### **5151 АЛБАН ГАЗАР, ЗОЧИД БУУДАЛ ЗЭРЭГ БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ, АЖ АХУЙ ХАРИУЦСАН ХЯНАГЧ**

Албан газар, зочид буудал зэрэг байгууллагын цэвэрлэгээ, аж ахуй хариуцсан хянагч нь эдгээр газрын дотоод эд зүйл, тавилга, төхөөрөмжийг цэвэр, эмх цэгцтэй байлгах, аж ахуйн үүрэг гүйцэтгэж, зохион байгуулж, хяналт тавина.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) туслах ажилтан, цэвэрлэгч зэрэг аж ахуйн ажилтныг ажилд оруулах, сургах, зохион байгуулах ба тэдэнд хяналт тавих,
- б) хангамж хэрэгсэл худалдаж авах буюу худалдан авалтыг хянах,
- в) хангамж хэрэгслийн хадгалалт, олголтод хяналт тавих,
- г) байгууллага дахь хувь хүмүүсийн ерөнхий байдал, зан төлөвийг анхаарч судлах,
- д) шал, тавилга, бусад төхөөрөмжийг арчиж цэвэрлэх, тоос соруулах, угаах, зүлгэх,
- е) ор засах, угаалгын өрөө цэвэрлэх, алчуур, саван, бусад зүйлээр хангах,
- ж) гал тогоо цэвэрлэх, гал тогооны ажилд, түүний дотор гал тогооны хэрэгслийг угаахад ерөнхийд нь туслах,
- з) мини-бар цэнэглэх, шилэн аяга, бусад зүйлийг нэмж тавих.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Аж ахуйн ажилтан (зочид буудлын)
- Харгалзагч эмэгтэй (байрны аж ахуйн)

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                               |
|------|-------------------------------|
| 1411 | Зочид буудлын менежер         |
| 5153 | Байшингийн арчилгаа хариуцагч |

5152	Ор дэр болон өглөөний цай зохицуулагч
5152	Гэрийн аж ахуй хариуцагч
9111	Гэрийн цэвэрлэгч

### **5152 ГЭРИЙН АЖ АХУЙ ХАРИУЦАГЧ**

Гэрийн аж ахуй хариуцагч нь хувь айл өрхөд бага тушаалын ажилтны дэмжлэгтэйгээр, эсвэл дэмжлэггүйгээр гэрийн аж ахуйг явуулах, зохион байгуулах, хянах үүрэг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) айлд ажиллаж байгаа гэрийн ажилтнуудыг хянан удирдах,
- б) хангамж хэрэгслийг худалдаж авах буюу худалдан авалтад хяналт тавих,
- в) хангамж хэрэгслийн хадгалалт, тараалтад хяналт тавих,
- г) ажил гүйцэтгэх явцад гарч болзошгүй бага зэргийн гэмтэл буюу өвчний тохиолдолд биеийн халуун хэмжих, эм уулгах, боолт хийх зэргээр туслалцаа үзүүлэх,
- д) шал, тавилга, бусад төхөөрөмжийг арчих, цэвэрлэх, тоос соруулах, угаах, зүлгэх,
- е) ор засах, угаалгын өрөө цэвэрлэх, алчуур, саван, бусад зүйлээр хангах,
- ж) гэрийн тэжээмэл амьтан, таримал ургамлыг арчлах, зочид угтах, утасны дуудлагад хариу өгөх, мессеж явуулах, хоол хүнс худалдаж авах,
- з) хоол бэлтгэх, хийх, ширээ засах, цэвэрлэх, хоол, ундааны зүйлээр үйлчлэх,
- и) гал тогоо цэвэрлэх, гал тогооны ажилд, түүний дотор гал тогооны хэрэгслийг угаахад ерөнхийд нь туслах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ор дэр болон өглөөний цай зохицуулагч
- Ахлах үйлчлэгч
- Гэрийн аж ахуй хариуцагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 1411 Зочид буудлын менежер

#### **Тайлбар:**

Удирдлага ба хяналтын ажил төдий л шаардлагагүй, ор, өглөөний цайгаар үйлчилдэг зарим газар, дэн буудал зэрэг жижиг буурчийн газар ажиллуулагчийг 5152 дугаар нэгж бүлэг буюу “Гэрийн аж ахуй хариуцагч” гэсэн бүлэгт хамруулна.

**5153 БАЙШИН АРЧЛАГЧ**

Байшин арчлагч нь орон сууц, зочид буудал, сүм хийд зэрэг байр, байшинг арчлах, тэдгээрийг болон хамаарах талбайг нь цэвэр, эмх цэгцтэй байлгах үүрэг гүйцэтгэнэ. Тухайн байшингийн хэмжээ, шинж чанараас хамаарч, тэрээр бусад ажилтан, гэрээлэгчдэд хяналт тавьж болно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цэвэрлэгч, аж ахуй, байшингийн засвар үйлчилгээ хариуцсан ажилтан ба гэрээлэгчдийн ажилд хяналт тавих,
- б) байшингийн дотор талын цэвэрлэгээ, засал, энгийн засвар, засвар үйлчилгээнд оролцох,
- в) халуун, хүйтэн ус өгөх нөхцлийг бүрдүүлэх үүднээс зуух, бойлерийг харж хандах,
- г) түрээслэгчид болон зочдыг харж, хэт дуу чимээ гаргуулахгүй, эд зүйл эвдлүүлэхгүй байх талаар анхаарч зохицуулах,
- д) түр эзгүй байгаа түрээслэгчдийн өмнөөс шуудан, илгээмж хүлээн авах, эсвэл утсаар асуусан хүмүүст мэдээлэл өгөх зэргээр жижиг тус хүргэж байх,
- е) томоохон засвар хийх шаардлага үүсвэл байшингийн эзэн болон удирдлагад мэдээлэх,
- ж) аюулгүй байдлыг хангах үүднээс байр, байшинд эргүүл хийх,
- з) бүртгэлийн маягт бөглөх, байрны дүрмийн хувийг түрээслэгчид өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Арчилгаа хариуцагч
- Жижүүр (байрны)
- Үүдний сахиул

**БАГА БҮЛЭГ 516****ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЖИЛТАН**

Хувийн үйлчилгээний бусад ажилтан хүний амьдралын өнгөрсөн үеийг хэлж, ирээдүйн үйл явдлыг таах, бараа болох зэрэг хувийн бусад үйлчилгээ үзүүлэх, гэрийн тэжээмэл амьтныг сургах, арчлах, шарил хайлах, зандаршуулах ба оршуулгын үйлчилгээ үзүүлэх, хүмүүст машин жолоодохыг зааж сургах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Зурхай татах, үйлчлүүлэгчид хөтөч буюу зарц хийх, бусад хувь үйлчилгээ үзүүлэх, шарил хайлах, зандаршуулах ба оршуулгын үйлчилгээ

## **5** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

---

үзүүлэх, гэрийн тэжээмэл амьтан хооллох, сургах, арчлах, жолоо барьж сурч байгаа хүнд зааварчлах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5161 Зурхайч, мэргэч, холбогдох ажилтан**

**5162 Бараа бологч, зарц**

**5163 Оршуулгын ажилтан, шарил занданшуулагч, хайлагч**

**5164 Гэрийн тэжээмэл амьтан харж арчлах ажилтан**

**5165 Жолооны багш**

**5169 Өөр газар ангилагдаагүй хувийн үйлчилгээний бусад ажилтан**

### **5161 ЗУРХАЙЧ, МЭРГЭЧ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Зурхайч, мэргэч, холбогдох бусад ажилтан нь зурхай татах, алганы хээ, хөзөр эсвэл өөр аргаар хүний өнгөрсөн амьдралыг хэлж, ирээдүйн үйл явдлыг таана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хувь хүний зурхайг нээж, өнгөрсөн үе ба ирээдүйн үйл явдал, амьралынх нь нөхцлийг урьдчилан таах,
- б) хүний алганы хээ, хөзрийн мод, дал, ясаар шинжих, эрих, зоос татан тайлбарлах, тайлах,
- в) баяр ёслол, гэрлэх ёслол, тэмдэглэлт өдөр, шашин мөргөлийн зүйлд ээлтэй сайн өдөр, цагийг тодорхойлох,
- г) боломжтой үйл хөдлөлийн талаар сануулга, зөвлөгөө өгөх,
- д) муу төрлийн нөлөөнөөс зайлсхийхийн тулд болгоомжлох зүйлүүдийн талаар хувь хүнд зөвлөх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зурхайч
- Мэргэч, төлөгч
- Тооны нууц судлаач
- Гарын хээ таагч, дал, зоосоор мэргэлэгч

#### **Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3230 Увидаст оточ
- 3413 Домч

### 5162 БАРАА БОЛОГЧ, ЗАРЦ

Бараа бологч, зарц нь бараа болох этгээд, ажил олгогчийн төрөл бүрийн хэрэгцээг хангахад тусална.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) ажил олгогчийг дагалдах, унших, ярилцах, спортын гэх мэт үйл ажиллагаанд оролцох хэлбэрээр төрөл бүрийн газарт бараа болох,
- б) ажил олгогчийн гэрт зочдыг нь зугаацуулахад туслах,
- в) ажил олгогчийн хувцасны шүүгээ, хувийн эд зүйлийг эмх журамтай байлгах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Бараа бологч
- Хувийн үйлчлэгч
- Зарц

#### Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                                |
|------|--------------------------------|
| 5169 | Олон нийтийн газраар дагалдагч |
| 5169 | Бүжгийн хамтрагч               |

### 5163 ОРШУУЛГА ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ЗАНДАНШУУЛАГЧ/ ШАРИЛ ЧАНДАРЛАГЧ

Эдгээр нь нас барсан хүний шарилыг оршуулахтай холбогдсон төрөл бүрийн ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) оршуулах ёслол, шарил чандарлах ба оршуулах зэрэг ажлыг зохицуулах,
- б) шарил муудах үйл явцыг удаашруулах буюу зогсоох зорилгоор шарилыг занданшуулах,
- в) занданшуулахтай холбоотой хуулийн шаардлагыг биелүүлэн эмнэлэг, эрүүл ахуйн журмыг мөрдөх,
- г) шарилын янз бүрийн хэсэгт зүсэлт хийх, зүсэлтийг битүүлэх, шаардлагатай бол хэлбэр дүрс нь алдагдсан буюу зэрэмдлэгдсэн шарилыг хэлбэржүүлэх буюу сэргээх,
- д) шарилд хувцас өмсгөх, авсанд байрлуулах,
- е) гашуудлын зар бэлтгэх, шарилын хайрцаг сонгоход туслах, оршуулах буюу чандарлах газар, цагийг тогтоох талаар уулзаж ярилцах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шарил занданшуулагч, чандарлагч
- Оршуулгын ажилтан

**5164 ГЭРИЙН ТЭЖЭЭМЭЛ АМЬТАН МАЛЛАГЧ, ТОЙГЛОГЧ**

Гэрийн тэжээмэл амьтан маллагч нь гэрийн тэжээмэл амьтан хооллох, харах, сургах, арчлах, мал эмнэлэг, амьтан хамгаалах газар, үржил, тэжээлийн газар, амьтны хүрээлэн, лаборатори, амьтны дэлгүүр, морин спортын сургууль, нохойн сургууль, амьтан арчилгааны зэрэг газарт малын эмч, амьтны сургалт, эрүүл мэндийн технологич, техникчдэд тусална.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) амьтныг усанд оруулах, хооллох,
- б) амьтныг эмчилгээний өрөөнд авчрах, эмчилгээний үед түүнийг барьж байх,
- в) мал эмнэлгийн багаж хэрэгслийг цэвэрлэх, ариутгах,
- г) эм, химийн болон бусад бэлдмэлийг хаяглах, нөөцийг гүйцээж бүрдүүлэх,
- д) угж, хошуувч, бусад хэрэгслийг ариутгах,
- е) хайс, саравч, тор, хашаа зэрэг гэрийн тэжээмэл амьтны булан, мөн эмээл, хазаар зэрэг амьтны тоноглолыг цэвэрлэх, цэгцлэх, халдваргүйжүүлэх,
- ж) амьтны жин, хэмжээ, биеийн байдал, амьтанд хийсэн эмчилгээ, өгсөн эм, тэдгээрийн идсэн хоол тэжээл гэх мэт мэдээллийг цуглуулах, тэмдэглэх,
- з) уралдаан тэмцээн, зугаа цэнгээн, хамгаалалт, уналга, бусад үйл ажиллагаанд зориулж амьтны зан төлөвийг хүссэнээрээ хөгжүүлэх, тогтоон барьж байхын тулд амьтныг сургах,
- и) угаах, самнах, ноос, үсийг нь хяргах, тайрах, хумсыг нь авах болон чихийг нь цэвэрлэх зэргээр амьтныг арчлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нохой сургагч
- Морь сургагч
- Мал эмнэлгийн туслах ажилтан
- Амьтны хүрээлэнгийн ажилтан

**5165 ЖОЛООНЫ БАГШ**

Жолооны багш нь автомашиныг хэрхэн жолоодохыг хүмүүст зааж сургана.



**Гүйцэтгэх үүрэг:**

- а) жолоодож сурч байгаа хүмүүст заавар өгөх, тоормос, араа, хурд, автомат араа, дохио, гэрэл зэргийн ажиллагааг тайлбарлаж үзүүлэх,
- б) замын хөдөлгөөний дүрэм заах,
- в) замын техник болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар зааж сургах,
- г) жолооны шалгалт авах болсон тухай сурагчдад мэдэгдэх,
- д) автомашины механик ажиллагаа, арчлан хамгаалалт, жолоодох арга техникийг самбарын диаграмм, аудио ба видео хэрэгсэл ашиглаж үзүүлэн таниулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Жолооны багш

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3153 Нислэгийн багш

**5169 ӨӨР ГАЗАР АНГИЛАГДААГҮЙ ХУВЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Энэхүү нэгж бүлэг нь дэд бүлэг 51 буюу “Хувийн үйлчилгээний ажилтан” гэсэн хэсэгт ангилагдаагүй ажилтныг хамарна. Тухайлбал, бүжгийн хамтрагч, олон нийтийн газар дагалдан үйлчлэгч, шөнийн клубийн ажилтан зэрэг үйлчлэх, бараа болох үйлчилгээ үзүүлэгчдийг энд хамруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчийг ресторан, бусад газарт дагалдаж бараа болох,
- б) бүжгийн хамтрагч болох,
- в) үйлчлүүлэгчийг шөнийн клубт хүлээн авах ба тэднийг сайн зугаацах нөхцөлийг нь бүрдүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Олон нийтийн газар дагалдагч
- Клубийн зохион байгуулагч, эрэгтэй
- Клубийн зохион байгуулагч, эмэгтэй
- Бүжгийн хамтрагч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5162 Бараа бологч

## **ДЭД БҮЛЭГ 52**

### **БОРЛУУЛАЛТЫН АЖИЛТАН**

---

Борлуулалтын ажилтан бөөний буюу жижиглэн худалдааны дэлгүүр, мухлагт, зах дээр, хаалганаас-хаалганд явж, утсаар эсвэл хэрэглэгчтэй холбоо барих төвөөр дамжуулж бараагаа сурталчилж, худалдана. Тэрээр худалдсан бараа, үйлчилгээний төлбөрийг хүлээн авч бүртгэх ба жижиглэнгийн худалдааны жижиг цэг ажиллуулж болно.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Бөөний буюу жижиглэнгийн худалдааны дэлгүүр, мухлагт, зах дээр, хаалганаас-хаалганд, утсаар эсвэл хэрэглэгчтэй холбоо барих төвөөр дамжуулж бараа худалдах, хэрэглэгчдэд барааг дэлгэж танилцуулах, шууд хэрэглэх хоол хүнсийг лангуун дээр болон гудамжинд худалдаж үйлчлэх, худалдах бараа бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэх талаар гэрээлэх буюу худалдан авах, худалдах барааг өрөх, дэлгэж тавих, худалдсан барааг ороох, боох, худалдах бүтээгдэхүүний нэр төрөл, нөөц, үнийн түвшинг тогтоох, бэлэн мөнгөний бүртгэл хөтлөх, үнэ унших оптик спаннер ажиллуулах, худалдсан бараа, үйлчилгээний төлбөрийг хүлээн авч бүртгэх компьютер, бусад тоног төхөөрөмжийг ажиллуулах. Бусад ажилтны ажилд тавих хяналт энэ ангиллын зарим ажил мэргэжилд шаардагдаж болно.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**521 Гудамж, захын худалдааны ажилтан**

**522 Дэлгүүрийн худалдагч**

**523 Кассчин ба тасалбарын ажилтан**

**524 Худалдааны бусад ажилтан**

#### **Тайлбар:**

Дэлгүүрийн болон борлуулалтын менежерийг Үндсэн бүлэг 1 буюу “Менежер” гэсэн бүлэгт хамруулна. Техник, эмнэлгийн болон мэдээлэл, харилцааны технологийн (МХТ) худалдааны мэргэжилтнийг Үндсэн бүлэг 2 буюу “Мэргэжилтэн” гэсэн ангилалд, арилжаа, даатгалын төлөөлөгч, санхүү, худалдааны брокерыг Үндсэн бүлэг 3 буюу “Техникч ба туслах мэргэжилтэн” гэсэн ангилалд, гудамжинд худалдаа, үйлчилгээ хийгчийг (хүнс орохгүй) Үндсэн бүлэг 9 буюу “Энгийн ажил, мэргэжил” гэсэн ангилалд тус тус хамруулна.

**БАГА БҮЛЭГ 521****ГУДАМЖ, ЗАХЫН ХУДАЛДААЧИН**

---

Гудамж, захын худалдаачин зах дээр юмуу гудамжин дахь мухлагт бараа худалдах, гудамж, олон нийтийн газарт шууд хэрэглэх халуун, хүйтэн бэлэн хоол, ундаа бэлтгэж худалдана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Гудамж, зах, эсвэл задгай талбайд тодорхой газарт жижиг худалдааны цэг нээх буюу гудамжинд хоол хүнс, ундаа зарах зөвшөөрөл авах, худалдах бараа бүтээгдэхүүний тогтмол хангалтыг гэрээлэх, худалдан авах, мухлаг ба худалдааны цэг, лангуу барих, буулгах, худалдах бараа бүтээгдэхүүнийг зөөх, хадгалах, ачих, буулгах, бараа, хүнс, ундааны зүйлийг өрж тавих, дэлгэж тавих, худалдах, төлбөр хүлээн авах, худалдсан барааг ороох, боох, худалдах хүнс, ундааг бэлтгэх, хоол хүнс, ундааг гудамжны хүссэн газарт эсвэл галт тэрэгний буудал, кинотеатр зэрэг олон нийтийн газарт аваачихын тулд тэрэг түрэх, унах, гар тэрэг, сагс авч явах, данс хөтлөх, нөөц барааны хэмжээг тооцоолох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5211 Мухлаг, захын худалдаачин****5212 Гудамжинд хүнс худалдаалагч****Тайлбар:**

Гудамж, олон нийтийн газарт түрдэг тэрэг, гар тэрэг, тэвш буюу сагснаас хүнсний бус зүйл (эсвэл чихэр зэрэг савлагаатай, мууддаггүй хүнсний зүйл) борлуулагч худалдаачдыг бага бүлэг 952 буюу “Гудамжинд мухлаг, лангуу ажиллуулагч”(хүнс орохгүй) гэсэн ангилалд оруулна.

**5211 Мухлаг, захын худалдаачин**

Мухлаг, захын худалдаачин нь задгай буюу битүү зах дээр лангуунаас, эсвэл гудамж буюу бусад задгай талбай дахь лангуунаас төрөл бүрийн бараа худалдана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гудамж, зах, задгай талбайн тодорхой газарт жижиг худалдааны цэг, лангуу нээх зөвшөөрөл авах,
- б) худалдах бүтээгдэхүүний нэр төрөл, нөөц, үнийн түвшинг тогтоох,

- в) худалдах бараа бүтээгдэхүүний тогтмол нийлүүлэлтийг бөөний худалдаачин юмуу шууд үйлдвэрлэгчтэй гэрээлэх, тэднээс худалдан авах,
- г) мухлаг, худалдааны цэг, лангууг барих, буулгах, худалдах бараа бүтээгдэхүүнийг зөөх, хадгалах, ачиж буулгах,
- д) бараа үзүүлэх, худалдах, төлбөр хүлээн авах,
- е) худалдах барааг өрөх, дэлгэх, худалдсан барааг ороох, боох,
- ж) данс хөтлөх, нөөцийн хэмжээг тооцоолох.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мухлаг /лангууны худалдаачин
- Захын худалдаачин
- Үүргийн худалдаачин
- Гудамжны мухлагийн худалдааны туслах ажилтан
- Зах дээр лангуу эзэмшигч

#### **Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил мэргэжил:**

- 5212 Гудамжинд хүнс худалдаалагч
- 9520 Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч (хүнс орохгүй)
- 5221 Дэлгүүрийн худалдаачин
- 5223 Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан
- 5246 Лангуугаар худалдаалагч

#### **Тайлбар:**

Шууд хэрэглэхэд зориулаагүй шинэ бүтээгдхүүн (жимс, ногоо, мах, цагаан идээ гэх мэт)-ийг гудамж, захын лангуугаар худалдаалагчийг нэгж бүлэг 5211 буюу “Мухлаг, захад худалдаалагч” гэсэн ангилалд, шууд хэрэглэх төрөл бүрийн бэлэн хоол, хүнсний зүйлийг гудамж, захын лангуугаар худалдаалагчийг нэгж бүлэг 5246 буюу “Хүнсний лангуугаар худалдаалагч” гэсэн ангилалд, гудамж болон нийтийн газарт шууд хэрэглэх хоол, ундааг түрдэг тэргэнцэр, гар тэрэг, тэвш, сагснаас борлуулагчдыг нэгж бүлэг 5212, буюу” Гудамжинд хоол хүнс худалдаалагч” гэсэн ангилалд, гудамж, нийтийн газарт түрдэг тэргэнцэр, тэвш, сагснаас хүнсний бус зүйл (эсвэл чихэр зэрэг савлагаатай, мууддаггүй хүнсний зүйл байж болно) борлуулагч худалдаачдыг нэгж бүлэг 9520 буюу “Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч (хүнс орохгүй)” гэсэн ангилалд, хамбургер хийгч зэрэг шууд хэрэглэх энгийн хоол хүнсний зүйл бэлтгэдэг, гэхдээ үйлчлүүлэгчтэй шууд харилцах нь хязгаартай ажилтнуудыг нэгж бүлэг 9411 буюу “Түргэн хоол бэлтгэгч” гэсэн ангилалд тус тус хамруулна. Мухлаг/лангуунаа хоол хүнс худалдаалагч нь гудамжинд хоол хүнс худалдаалагчийг бодвол илүү өргөн хүрээний боловсронгуй сав, баглаа боодол бүхий бүтээгдэхүүн, хоолоор үйлчлэх тул гар тэрэг, сагсаар хоол зөөж явдаггүйгээрээ онцлог болохыг анхаарууштай.

**5212 ГУДАМЖИНД ХООЛ ХҮНС ХУДАЛДААЛАГЧ**

Гудамжинд хоол хүнс худалдаалагч нь хоол хүнс бэлтгэн галт тэрэгний буудал, кинотеатр, театр зэрэг олон нийтийн газарт болон гудамжинд урьдчилан бэлтгэсэн бэлэн халуун буюу хүйтэн хоол хүнс, ундаа худалдана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гудамж, олон нийтийн газарт хоол хүнс, ундаа худалдах тусгай зөвшөөрөл авах,
- б) худалдах хоол хүнс, ундааны зүйлийг олж бэлтгэх,
- в) урьдчилан юмуу газар дээр нь хоол хүнс, ундааг бэлтгэж худалдах,
- г) хоол хүнс, ундааг гудамжинд дуртай газартаа, галт тэрэгний буудал, кинотеатр зэрэг олон нийтийн газарт аваачихын тулд тэрэг түрэх, унах, гар тэрэг, сагс авч явах, ачих, буулгах,
- д) хоол хүнс, ундааг дэлгэн үзүүлэх ба худалдах, төлбөр хүлээн авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гудамжинд хүнс худалдагч
- Зөөврийн худалдагч (хүнс)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5120	Тогооч
9411	Түргэн хоол бэлтгэгч
5246	Лангуугаар хоол хүнс худалдаалагч
9520	Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч(хүнс орохгүй)

**Тайлбар:**

5211 нэгж бүлэг буюу “Мухлаг,захын худалдаачин” гэсэн бүлгийн тайлбар үзнэ үү.

**БАГА БҮЛЭГ 522****ДЭЛГҮҮРИЙН ХУДАЛДААНЫ АЖИЛТАН**

Дэлгүүрийн худалдааны ажилтан нь олон нийтэд шууд, эсвэл жижиглэн болон бөөний газрын өмнөөс бараа, үйлчилгээ зарж борлуулна. Тэд эдгээр бараа, үйлчилгээний чанар, хэрэглэх арга ажиллагааг тайлбарлах, жижиг дэлгүүр ажиллуулах юмуу худалдааны туслахууд, кассчдын ажилд хяналт тавина.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, бараа бүтээгдэхүүний нэр төрөл, үнэ, баталгаа, бүтээгдэхүүний ашиглалт, арчилгааны болон

бараа хүргэлтийн талаар мэдээлэл өгөх, хэрэглэгчдэд бараа, үйлчилгээг үзүүлэн таниулах, тайлбарлах, худалдах, төрөл бүрийн төлбөр хүлээн авах, төлбөрийн нэхэмжлэх бэлтгэх, бүтээгдэхүүний нөөц зэрэг нөөцийн менежментийг хийх буюу хийхэд туслах, нөөц бараа татахад оролцох, худалдах барааг өрж дэлгэх, худалдагдсан барааг ороох, боох, бүтээгдэхүүний нэр төрөл, барааны нөөц, үнийн түвшинг тодорхойлох, дэлгүүрийн худалдааны туслахууд, хянагчид, өөртөө үйлчлэх дэлгүүр, их дэлгүүрийн бусад ажилтнуудын ажлыг хянан зохицуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5221 Дэлгүүр ажиллуулагч**

**5222 Дэлгүүрийн эрхлэгч (ахлах ажилтан, хянагч)**

**5223 Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан**

### **5221 ДЭЛГҮҮР АЖИЛЛУУЛАГЧ**

Дэлгүүр ажиллуулагч нь жижиглэнгийн худалдааны багавтар дэлгүүрийг тусдаа буюу цөөн хүний тусламжтайгаар ажиллуулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) бүтээгдэхүүний нэр төрөл, нөөц, худалдах барааны үнийн түвшинг тодорхойлох,
- б) худалдах барааг зах, бөөний болон бусад нийлүүлэгчээс худалдан авах ба захиалах,
- в) барааны нөөцийн хэмжээ, санхүүгийн ажиллагааг төсөвлөх ба бүртгэл хөтлөх,
- г) үнэ тогтоох, худалдах барааг дэлгэж тавих,
- д) хэрэглэгчдэд бараа худалдах, тэдэнд бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгөх,
- е) буцаагдсан барааг шалгах, зохих арга хэмжээ авах,
- ж) нөөцийн барааны жагсаалт гаргах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дэлгүүр ажиллуулагч
- Хүнс, гэр ахуйн барааны худалдагч
- Сонин борлуулагч
- Өөртөө үйлчлэх дэлгүүрийн эрхлэгч

#### **Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжн:**

- |      |                          |
|------|--------------------------|
| 1420 | Дэлгүүрийн менежер       |
| 5211 | Зах дээр лангуу эзэмшигч |

**Тайлбар:**

Удирдах болон хяналтын олон ажилтан үл шаардах жижиг дэлгүүр ажиллуулагчийг нэгж бүлэг 5221 буюу “Дэлгүүр ажиллуулагч” гэсэн ангилалд, удирдах болон хяналтын ажилтан чухал шаардлагатай дэлгүүр ажиллуулагчийг нэгж бүлэг 1420 буюу “Жижиглэн ба бөөний худалдааны менежер” гэсэн ангилалд, дэлгүүрийн худалдааны туслах, хянагч болон бусад ажилтныг хянаж, удирдлагаар хангадаг боловч бүтээгдэхүүний нэр төрөл, төсөв, ажилтны чадвар, тэдний сонголт, элсүүлэлтийг хариуцдаггүй ажилтныг нэгж бүлэг 5222 “Дэлгүүрийн эрхлэгч” гэсэн ангилалд тус тус хамруулна.

**5222 ДЭЛГҮҮРИЙН ЭРХЛЭГЧ**

Дэлгүүрийн эрхлэгч нь өөртөө үйлчлэх болон их дэлгүүр зэрэг жижиглэнгийн ба бөөний худалдааны дэлгүүрт худалдааны туслах, хянагч, бусад ажилтнуудын үйл ажиллагааг хянан зохицуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ажлын хуваарь гаргах, төлөвлөх, ажилтнуудад тодорхой үүрэг хүлээлгэх,
- б) худалдаа, борлуулалтын журмын талаар, түүний дотор бэрх, ээдрээтэй тохиолдлуудыг давах талаар зааж сургах,
- в) хэрэглэгчид хурдан шуурхай үйлчлэх нөхцлийг хангах,
- г) ажилтнаас ярилцлага авах, ажилд авах, сургах, үр дүнг нь үнэлэх, тушаал дэвшүүлэх, халах болон ажилтны гомдлыг барагдуулахад оролцох, менежерүүдэд зөвлөгөө өгөх,
- д) буцаагдсан барааг үзэж шалгах, зохих шийдвэр гаргах,
- е) борлуулах барааны бүртгэл, жагсаалт гаргах, шинэ нөөц захиалах,
- ж) бараа, үйлчилгээний үнийг үнэн зөв гаргаж ил тавьсан байх нөхцлийг хангах,
- з) аюулгүй байдлын дүрэм журмыг сахиулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дэлгүүрийн эрхлэгч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1420	Дэлгүүрийн менежер
5211	Дэлгүүр ажиллуулагч
5211	Гудамжинд лангуу ажиллуулагч

**5223 ДЭЛГҮҮРИЙН ХУДАЛДААНЫ ТУСЛАХ АЖИЛТАН**

Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан нь олон нийтэд шууд, эсвэл жижиглэн ба бөөний худалдааны байгууллагын өмнөөс олон төрлийн бараа, үйлчилгээ худалдах бөгөөд эдгээр бараа, үйлчилгээний чанар, хэрэглээний арга, ажиллагааг тайлбарлана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хэрэглэгчийн тавих шаардлагуудыг тодорхойлж, бүтээгдэхүүний нэр төрөл, үнэ, баталгаа, хүргэлт, ашиглалт, арчилгааны талаар мэдээлэл өгөх,
- б) хэрэглэгчдэд байгууллагынхаа бараа, үйлчилгээг үзүүлэн тайлбарлах,
- в) бараа, бүтээгдэхүүнийг худалдах, төлбөрийг янз бүрийн хэрэгслээр хүлээн авах, нэхэмжлэх бэлтгэх, бэлэн мөнгө бүртгэгчийг ашиглан борлуулалт бүртгэх,
- г) бүтээгдэхүүний нөөцийн бүртгэл зэрэг нөөцийн менежментийн ажилд туслах, барааны нөөц татан авалтад оролцох,
- д) худалдах барааг өрөх, дэлгэх, худалдагдсан барааг ороох, боох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Худалдаачин (жижиглэнгийн)
- Худалдаачин (бөөний)
- Дэлгүүрийн туслах ажилтан
- Гарах хаалганы хянагч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1420	Дэлгүүрийн менежер
5211	Мухлаг, лангууны худалдаачин
5211	Захын худалдаачин
5211	Гудамжинд лангуу ажиллуулагч
5212	Гудамжинд хүнс худалдаалагч
5221	Дэлгүүрийн эрхлэгч
5230	Гарах цэгийн хянагч
5246	Лангуугаар хоол хүнс худалдаалагч

**БАГА БҮЛЭГ 523****КАССЧИН, ТАСАЛБАР ОЛГОГЧ**

Кассчин, тасалбар олгогч нь дэлгүүр, ресторан болон тасалбар түгээгүүрийн газарт компьютер, бусад тоног төхөөрөмж ажиллуулж, бараа, үйлчилгээний төлбөр, хураамж хүлээн авч тасалбар олгоно.

**Гүйцэтгэх үүрэг:**

Дэлгүүр, тасалбар түгээгүүр зэрэг газарт бэлнээр болон зээлийн картаар хийх төлбөрийг хүлээн авч шалгах, мөнгөний хариулт өгөх ба тасалбар олгох, тасалбар түгээгүүрт тасалбар олгох, зохих төлбөрийг авах, хүлээн авсан мөнгийг тоолох, бүртгэх, борлуулалтын дүнг гаргах,



орж ирж байгаа бэлэн мөнгийг хүлээн авч, борлуулалтын хуудас, бусад баримт бичигтэй тулган шалгах, банкинд хийхэд бэлтгэх, үйлчлүүлэгчээс авах буюу түүнд төлөх мөнгөний дүнг гаргахын тулд бэлэн мөнгө бүртгэгчийг ажиллуулах, үнэ уншигчаар скайнердах, жигнэх, барааны үнийг бүртгэх, барааг боох, тор, цүнхэнд хийж өгөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **5230 Кассчин ба тасалбарын ажилтан**

#### **5230 КАССЧИН, ТАСАЛБАР ОЛГОГЧ**

Кассчин, тасалбар олгогч нь дэлгүүр, ресторан болон тасалбар түгээгүүр зэрэг газруудад бараа, үйлчилгээний төлбөр, хураамжийг хүлээн авч, бүртгэхийн тулд бэлэн мөнгө бүртгэгч, үнэ уншигч, компьютер, бусад тоног төхөөрөмжийг ажиллуулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) дэлгүүр, тасалбар түгээгүүр зэрэг газарт бэлнээр болон зээлийн картаар хийх төлбөрийг хүлээн авч шалгах,
- б) мөнгөний хариулт өгөх ба тасалбар олгох,
- в) спортын болон соёлын арга хэмжээнд оролцогчдод тасалбар олгох,
- г) хүлээн авсан буюу төлсөн мөнгийг тоолох, бүртгэх, борлуулалтын дүнг мөнгө бүртгэгчээр дүгнэх,
- д) үйлчлүүлэгчээс авсан буюу түүнд төлсөн мөнгөний дүнг гаргахын тулд мөнгө бүртгэгчийг ажиллуулах,
- е) үнэ уншигчаар скайнердах, жигнэх, барааны үнийг бүртгэх,
- ж) барааг боох, цүнх, торонд хийж өгөх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дэлгүүрийн кассчин
- Тасалбар олгогч (цэнгүүн болон спортын арга хэмжээ)
- Гарах хаалганы хянагч
- Үйлчилгээний автомат машин ажиллуулагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                |
|------|--------------------------------|
| 4221 | Тасалбар олгогч (аялал)        |
| 5223 | Дэлгүүрийн худалдааны туслах   |
| 5245 | Үйлчилгээний автоматын ажилтан |
| 5222 | Гарах цэгийн хянагч            |

**БАГА БҮЛЭГ 524**  
**ХУДАЛДААНЫ БУСАД АЖИЛТАН**

---

Худалдааны бусад ажилтан гэдэг нь зах, гудамж, дэлгүүрт борлуулахаас өөр нөхцөлд ихэвчлэн олон нийтэд бараа, хүнс, үйлчилгээг дэлгэж, үзүүлж, худалдана. Энэ бүлэгт 521 буюу “Гудамж, захад худалдаалагч”, 522 буюу “Дэлгүүрийн худалдаачин”, 523 буюу “Кассчин, тасалбар олгогч” гэсэн бага бүлгүүдэд ороогүй худалдааны бусад ажилтныг хамруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Худалдах зүйлийг дэлгэн тавих, үзүүлэн таниулах, гэрэл зураг, видео клип, сурталчилгаа, урлагийн бүтээлд зориулж жишээ загвар болж өгөх, бараа, үйлчилгээний ашиглалтын талаархи асуултад хариулах, зөвлөгөө өгөх, захиалга авах, төлбөрийг зохицуулах, бараа, үйлчилгээ хүргэж өгөх, хаалганаас хаалганд очих, телефон утас, бусад цахим холбооны хэрэгсэл ашиглах зэргээр боломжийн хэрэглэгчдэд хандах, бараа, үйлчилгээ худалдах, үйлчилгээний цэг дээр шатахуун, тос, автомашины бүтээгдэхүүн худалдах, шатахуун хийх, цэвэрлэх, тослох зэрэг үйлчилгээ үзүүлэх ба автомашинд жижиг засвар хийх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5241 Загвар өмсөгч ба бусад жишиг үзүүлэгч**

**5242 Худалдааны үзүүлэн таниулагч**

**5243 Хаалганаас хаалганд худалдаалагч**

**5244 Холбоо барих төвийн худалдаачин**

**5245 Үйлчилгээний цэгийн худалдаачин**

**5246 Лангуугаар худалдаалагч**

**5249 Өөр газар ангилагдаагүй худалдааны ажилтан**

**Тайлбар:**

Худалдааны менежерийг үндсэн бүлэг 122, буюу “Борлуулалт, маркетинг, судалгаа хөгжлийн менежер” гэсэн ангилалд, техникийн, анагаахын болон Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтнийг бага бүлэг 243 буюу “Борлуулалт, маркетинг, олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн” гэсэн ангилалд, арилжаа, борлуулалт, даатгалын мэргэжилтнийг бага бүлэг 332, “Борлуулалт, худалдан авалтын агент, брокер” гэсэн ангилалд тус тус оруулна.

**5241 ЗАГВАР ӨМСӨГЧ, ЖИШИГ ҮЗҮҮЛЭГЧ**

Загвар өмсөгч ба бусад жишиг үзүүлэгч нь хувцас болон жижиг хэрэгслүүдийг өмсөж, зүүж үзүүлэх ба гэрэл зураг, кино, видео клип, сурталчилгаа, урлагийн бүтээлд загвар болж өгнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) шинэ болон хэрэглэгдэж байгаа хэв маягийн, эсвэл хэрэглэгчийн хүссэн хэв маягийн загвар хувцсыг өмсөх,
- б) хувцас, шинэ маягийн хэрэгсэл, бусад барааны хэв маяг, шинж чанаруудыг хамгийн сайнаар үзүүлж таниулахын тулд алхах, эргэлдэх, зогсох, суух зэрэг үйлдэл хийх,
- в) уран баримал, уран зураг, урлагийн бусад төрлийн сэдэв болж суух, зогсох,
- г) сэтгүүл, бусад сурталчилгааны хэрэгсэлд зориулж гэрэл зургийн загвар болж өгөх,
- д) телевиз, видео, бусад бүтээлд загвар болж өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сурталчилгааны загвар
- Зураачийн загвар
- Загвар өмсөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2655 Жүжигчин

**5242 БАРАА ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАГЧ**

Бараа үзүүлэн таниулагч нь худалдааны газар, үзэсгэлэн болон хувийн байранд бараа үзүүлэн таниулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) үзүүлэн, дэлгэц байрлуулах, худалдах зүйлсийг үзүүлэн тайлбарлах, хэрэглэгчдэд тэдгээрийн шинж чанар, ашиглах зааврыг мэдээлэх, худалдан авах хүсэл сонирхлыг төрүүлэх, нэмэгдүүлэх,
- б) бараа бүтээгдэхүүнийг хэрхэн ашиглах тухай асуултад хариулах, зөвлөгөө өгөх,
- в) бараагаа худалдахын хамт хэрэглэгчийг худалдааны ажилтан руу хандуулах,
- г) захиалга авах, төлбөр хийх, бараа хүргэх, хүлээлгэн өгөх ажлыг зохицуулах,

д) загвар бараа үзүүлэх, каталоги болон сурталчилгааны материал тараах.

**Энэ ангилалд орох ажил, мэргэжлийн жишээ:**

- Үзүүлэн таниулагч
- Борлуулалт хариуцагч

**Өөр газар ангилагдсан зарим холбогдох ажил, мэргэжил:**

- |      |                                  |
|------|----------------------------------|
| 5211 | Мухлаг, захын худалдаачин        |
| 5211 | Гудамжны лангууны худалдаачин    |
| 5243 | Хаалганаас хаалганд худалдаалагч |

**5243 ХААЛГАНААС ХААЛГАНД ХУДАЛДААЛАГЧ**

Хаалганаас хаалганд худалдаалагч нь боломжийн хэрэглэгчдэд, ихэвчлэн хувийн байрны оршин суугчдад хандах, гэрээр нь орох буюу хаалганаас хаалганд очиж, айлчилж, бараа, үйлчилгээ худалдах ба байгууллагын саналыг хүргэдэг.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хаалганаас хаалганд үйлчлүүлэгч болон боломжийн хэрэглэгчдэд айлчлан очиж, төрөл бүрийн бараа, үйлчилгээ, худалдааны нөхцлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх,
- б) санал болгож буй бараа, үйлчилгээг үзүүлэн таниулах буюу дүрслэн тайлбарлах,
- в) захиалга болон гүйлгээг тэмдэглэх, авсан захиалгаа нийлүүлэгчид өгөх,
- г) нэхэмжлэх болон худалдааны гэрээ бэлтгэх, төлбөр хүлээн авах,
- д) захидал, мэдээллийн хуудас, бусад баримт бичгүүдийг үйлчлүүлэгчдэд тараах,
- е) боломжийн үйлчлүүлэгчдийн жагсаалт гаргах, шинээр элсүүлэхийн тулд тэдэнтэй очиж уулзах,
- ж) худалдааны талбай болон үйлчлүүлэгчдийн хооронд зорчих, худалдах бараа буюу загварыг зөөж тээвэрлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хаалганаас хаалганд худалдаалагч
- Үдэшлэг төлөвлөх, борлуулах худалдаачин

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                      |
|------|----------------------|
| 3322 | Худалдааны төлөөлөгч |
| 9520 | Гудамжнаа худалдагч  |

**5244 УТСААР ЗАХИАЛГА АВЧ ХУДАЛДААЛАГЧ**

Бараа, үйлчилгээг сурталчлахын тулд телефон утас болон цахим холбооны хэрэгсэл ашиглаж байгаа болон боломжийн хэрэглэгчидтэй холбоо барьж, бараа, үйлчилгээ борлуулах ба эл зорилгоор уулзалт зохион байгуулна. Худалдаачин хэрэглэгчтэй холбоо барих төвөөс, эсвэл төвлөрсөн бус байрнаас ажлаа явуулж болно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гар бичвэр болон харилцагчдын жагсаалтын дагуу бараа, үйлчилгээг утсаар буюу цахим шуудангаар сурталчлах,
- б) хэрэглэгчдэд бараа, үйлчилгээний сонирхол төрүүлэх, тэднээр худалдан авалт хийлгэхийг эрэлхийлэх, тэднийг худалдааны төлөөлөгчтэй аль болохоор уулзуулахыг хичээж ажиллах,
- в) бараа, үйлчилгээ, мэдээллийн цомог, товхимолыг боловсруулах ажлыг зохицуулж, хэрэглэгчдэд тараах,
- г) худалдааны төлөөлөгчдийн уулзалтуудыг зохицуулах,
- д) мөрөөр нь үргэлжлүүлэн авах арга хэмжээний талаар тэмдэглэл хөтлөх, хэрэглэгч бүрийн байдалд гарсан өөрчлөлтүүдийг тусгаж маркетингийн мэдээллийн санг шинэчилж байх,
- е) өрсөлдөгчдийн үйл ажиллагаа, холбоо барьсан хүмүүсээс тавьсан асуудлуудыг менежерүүдийн анхааралд хүргэн мэдээлж байх,
- ж) хийсэн утасны дуудлагын тоо болон олсон амжилтуудын талаар статистик мэдээ гаргаж, хөтөлж байх,
- ж) телемаркетингийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар тогтмол мэдээ, тайлан гаргаж байх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Телемаркетингийн худалдаачин
- Дуудлагын төвийн худалдаачин
- Хэргэлэгчтэй холбоо барих төвийн худалдаачин
- Интернэт худалдаачин
- Телемаркетчин

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

4222 Холбоо барих төвийн мэдээллийн ажилтан

**5245 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН АЖИЛТАН**

Үйлчилгээний цэгийн ажилтан нь шатахуун, тос, автомашины болон бусад бүтээгдэхүүн борлуулах, шатахуун хийх, автомашин цэвэрлэх, тослох зэргээр үйлчилж, автомашинд жижиг засвар хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) банк, саванд нь хэрэглэгчийн хүссэн хэмжээнд шатахуун шахаж өгөх,
- б) машины дугуйны хий, бусад тос, шингэний түвшинг шалгаж гүйцээх,
- в) автомашины салхины шил, цонхыг угаах,
- г) автомашины дугуй, чийдэнгийн шил, шил арчигч солих зэрэг жижиг засварын ажил хийх,
- д) машины автомат угаалгын техник төхөөрөмж ажиллуулах, арчлах,
- е) худалдан авалт хийсэн хэрэглэгчдээс төлбөр авч цуглуулах,
- ж) бензин шахагч, түүний эргэн тойрны зам, талбай, дэлгүүр, төхөөрөмжийг цэвэр байлгах,
- з) бараа, материалын нөөцийг хянах, зарж борлуулсан шатахуун, тос, жижиг хэрэгсэл, бусад зүйлийн талаар тайлан бүртгэл хөтлөх,
- и) аюулгүй байдлыг хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шатахуун түгээгч
- Үйлчилгээний цэгийн худалдаачин

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                      |
|------|--------------------------------------|
| 5230 | Үйлчилгээний цэгийн кассчин          |
| 5223 | Дэлгүүрийн худалдааны туслах ажилтан |
| 5246 | Хүнсний лангуугаар худалдаалагч      |

**Тайлбар:**

Төлбөр шууд хүлээн авдаг эсхүл үйлчилгээний цэгүүд дэх дэлгүүр, мухлагт бараа борлуулдаг боловч шатахуун, тос, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хийх зэрэг гадаа талбайд үйлчилгээ үзүүлдэггүй ажилтныг нэгж бүлэг 5245 буюу “Үйлчилгээний цэгийн ажилтан” гэсэн ангилалд оруулахгүй.

**5246 ХҮНСНИЙ ЛАНГУУГААР ХУДАЛДААЛАГЧ**

Хүнсний зүйл лангуугаар худалдаалагч нь хүнсний лангуунаас хэрэглэгчдэд үйлчлэх ба ресторан, кафе, зочид буудал, түргэн хоолны цэг, кафетерий, эмнэлэг зэрэг газарт бэлтгэсэн ердийн хоол, хүнсний зүйлсээр үйлчилнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) лангуун дээрээс хэрэглэгчдийг хоол хүнсээр үйлчлэх,
- б) хэрэглэгч ямар бүтээгдэхүүн хүсч байгааг магадлан тодруулах, сонголт хийхэд нь туслах, захиалга авах,

- в) гар буюу цахилгаан хэрэгсэл ашиглан хоол хүнсний зүйлийг цэвэрлэх, хальслах, зүсэх, арилгах,
- г) ердийн хоол хүнсний зүйлс бэлтгэх, бэлэн хоол халаах,
- д) хоол хүнсийг аягалах, ороож боох, эсвэл шууд тавган дээр тавьж үйлчлэх,
- е) авч явах хоол хүнсийг саванд хийх, боох,
- ж) хөргөгч дүүргэх, өөртөө үйлчлэх баарыг салат, зуушаар цэнэглэх, хэрэглэгдсэн хоол хүнсний зүйлийн тоо хэмжээг бүртгэж, бүртгэл хөтлөх,
- з) хэрэглэсэн хоол хүнсний зүйлийн төлбөр хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Кафетерийн лангууны худалдагч
- Зуушны баарны үйлчлэгч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5120	Тогооч
5211	ТҮЦ-ийн худалдаачин
5211	Захын худалдаачин
5211	Гудамж, талбайн мухлагийн худалдаачин
5131	Зөөгч үйлчлэгч
5132	Бармен
9411	Түргэн хоол бэлтгэгч

**Тайлбар:**

Шууд хэрэглэхэд зориулаагүй шинэ бүтээгдхүүн(жимс, ногоо, мах, цагаан идээ гэх мэт)-ийг гудамж, захын лангуунаа худалдаалагчийг нэгж бүлэг 5211 буюу “Мухлаг, захад худалдаалагч” гэсэн ангилалд, шууд хэрэглэх төрөл бүрийн бэлэн хоол, хүнсний зүйлийг гудамж, захын лангуунаа худалдаалагчийг нэгж бүлэг 5246 буюу “Хүнсний лангууны худалдаачин” гэсэн ангилалд, гудамж болон нийтийн газарт шууд хэрэглэх хоол, ундааг түрдэг тэргэнцэр, гар тэрэг, тэвш, сагснаас борлуулагчдыг нэгж бүлэг 5212, буюу “Гудамжинд хоол хүнс худалдаалагч” гэсэн ангилалд, гудамж, нийтийн газарт түрдэг тэргэнцэр, тэвш, сагснаас хүнсний бус зүйл (эсвэл чихэр зэрэг савлагаатай, мууддаггүй хүнсний зүйл байж болно) борлуулагч худалдаачдыг нэгж бүлэг 9520 буюу “Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч (хүнс орохгүй)” гэсэн ангилалд, Хамбургер хийгч зэрэг шууд хэрэглэх энгийн хоол хүнсний зүйл бэлтгэдэг, гэхдээ үйлчлүүлэгчтэй шууд харилцах нь хязгаартай ажилтнуудыг нэгж бүлэг 9411 буюу “Түргэн хоол бэлтгэгч” гэсэн ангилалд тус тус хамруулна. Мухлаг/лангуунаа хоол хүнс худалдаалагч нь гудамжинд хоол хүнс худалдаалагчийг бодвол илүү өргөн хүрээний боловсронгуй сав, баглаа боодол бүхий бүтээгдэхүүн, хоолоор үйлчлэх тул гар тэрэг, сагсаар хоол зөөж явдаггүйгээрээ онцлог болохыг анхааруштай.

**5249 ӨӨР ГАЗАР АНГИЛАГДААГҮЙ ХУДАЛДААНЫ АЖИЛТАН**

Энэ нэгж бүлэгт дэд бүлэг 52 буюу “Борлуулалтын ажилтан” гэсэн ангилалын хаана ч ороогүй худалдааны ажилтныг хамруулна.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Түрээсийн худалдаачин

---

**ДЭД БҮЛЭГ 53**  
**ХУВЬ ХҮН АСРАМЖЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

---

Хувь хүн асрамжлах ажилтан нь байгууллага, орон сууц, гэрийн нөхцөлд хүүхэд, өвчтөн, настайчууд, эдгэрч байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асарч, хараа хяналт тавьж, туслалцаа үзүүлнэ.

Энэхүү үндсэн дэд бүлгийн ажилтан ихэвчлэн дараах ажил үүргийг гүйцэтгэнэ: бос суух, явах хөдлөх, угаал үйлдэх зэрэг хувийн хэрэгцээнд нь туслах, нийгмийн дадалд бие даан суралцахад нь хүүхдэд туслалцаа үзүүлэх, сургуульд болон сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагад хүүхдийн бие, социал болон сэтгэл хөдлөл, оюун ухааны хөгжлийг сайжруулах үйл ажиллагаанд оролцох ба энэ төрлийн үйл ажиллагааг хянах, санаа зовоосон асуудлуудаар ажиглалт хийх, зохих эмнэлгийн буюу нийгмийн үйлчилгээний ажилтанд мэдээлэх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**531 Хүүхэд асрамжлах ажилтан, багшийн туслах**

**532 Эрүүл мэндийн үйлчилгээнд хувь хүн асрамжлах ажилтан**

---

**БАГА БҮЛЭГ 531**  
**ХҮҮХЭД АСРАМЖЛАХ АЖИЛТАН, БАГШИЙН ТУСЛАХ**

---

Хүүхэд асрамжлах ажилтан, багшийн туслах нь сургууль, орон сууц, гэр, хүүхэд асрамжийн байгууллагад хүүхдэд асрамжлах ба тэдэнд хараа хяналт тавина.



**Гүйцэтгэх үүрэг:**

Нийгмийн дадалд бие даан суралцахад нь хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх, сургуульд болон сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагад хүүхдийн бие, социал болон сэтгэл хөдлөл, оюун ухааны хөгжлийг сайжруулах ажиллагаанд оролцох, түүнд хяналт тавих, түүнийг тайлбарлан таниулах, хүүхдийн боловсрол, сургуулийн өмнөх болон дараах үйл ажиллагаа, амралтын үед болон өдрийн асрамжийн төвүүд дэх хүүхдүүдийн амралт, чөлөөт цагт зориулсан материал, тоног хэрэгслийг бэлтгэхэд туслалцаа үзүүлэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5311 Хүүхэд асрамжлах ажилтан****5312 Багшийн туслах****5311 ХҮҮХЭД АСРАМЖЛАХ АЖИЛТАН**

Хүүхэд асрамжлах ажилтан нь орон сууц, гэр, сургуулийн өмнөх, болон хичээлийн дараах боловсролын байгууллага, амралт болон өдрийн асрамжийн төвд хүүхэд асрамжлах ба тэдэнд хараа хяналт тавина.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өөрөө бие дааж угаал үйлдэх, хувцаслах, хооллоход нь хүүхдэд туслах,
- б) хүүхдийг сургуульд нь хүргэх, сургуулиас нь авах, амралт, зугаалга, чөлөөт цагаар гадагш авч гарах,
- в) хүүхдүүдтэй тоглоом тоглох, юм уншиж өгөх, үлгэр ярьж өгч тэднийг зугаацуулах,
- г) хүүхдийн боловсрол, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд зориулсан материал, тоног төхөөрөмж олж бэлтгэхэд туслалцаа үзүүлэх,
- д) хүүхдүүдийн зан төлөвийг удирдах, тэдний социал хөгжлийг чиглүүлэх,
- е) хүүхдүүдэд дэг журамтай, хувцсандаа анхаардаг, ном тоглоомоо өөд татах зэрэг зан төлөв суулгахад чиглэсэн арга хэмжээг зөвлөмж болгох, санаачлах,
- ж) хүүхдүүдийн тоглоомын үйл ажиллагааг ажиглах, хяналт тавих,
- з) хувь хүүхдийн тухайд, түүний дотор өдөр тутмын үйл ажиллагаа, идсэн хоол, уусан эмийнх нь талаар ажиглалт хийж, мэдээлэл, тэмдэглэл хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хүүхэд харагч
- Хүүхэд асрамжлах ажилтан
- Яслийн асрагч
- Гэрт нь өдрөөр хүүхэд асрах ажилтан
- Хүүхэд асрагч
- Хичээлийн бус цагаар асрамжлах ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2342 Бага насны хүүхэд сурган хүмүүжүүлэгч

**5312 БАГШИЙН ТУСЛАХ**

Багшийн туслах нь багшид туслалцаа үзүүлэх ба сургууль, сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагад хүүхдүүдэд асрамж үзүүлж, хараа хяналт тавина.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сургуулийн болон сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагад хүүхдийн бие махбодь, социал болон сэтгэл хөдлөл, оюун ухааны хөгжлийг сайжруулах үйл ажиллагаанд оролцох, тэдгээр үйл ажиллагааг хянах, сурталчлах,
- б) сурлага, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд зориулж байрын дотор болон гадна талбай бэлтгэх,
- в) суралцахад тулгарч байгаа оюун ухаан, бие махбодь, зан төлөвийн зэрэг саад бэрхшээлийг даван туулахад нь хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх,
- г) нийгмийн дадлагад суралцахад нь хүүхдүүдэд хувь хувьд нь туслах,
- д) сургалтын материал бэлтгэх, хувилах, бичмэл болон хэвлэмэл материалыг жишиж тулгах, эмхэтгэхэд туслах,
- е) аудио-видео тоног төхөөрөмж, компьютер, сургалтын бусад туслах хэрэгслийг ажиллуулах,
- ж) хичээлийн материалыг тараах, хураах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сургуулийн өмнөх байгууллагын туслах
- Багшийн туслах

## **БАГА БҮЛЭГ 532 ЭМНЭЛГИЙН СУВИЛГААНЫ АЖИЛТАН**

Энэхүү ангиллын ажилтан нь эмнэлгийн болон гэрийн нөхцөлд өвчтөн, настан, өвдөөд эдгэрч байгаа хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлгөөний болон өдөр тутмын аж амьдралынх нь үйл ажилд хувь хувийн асрамж, туслалцаа үзүүлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Өвчтөнд хөдөлгөөн хийх, биеэ асруулах, бусадтай харилцах, холбоо барих хэрэгцээнд нь туслах, мэс заслын болон бусад багаж, төхөөрөмжийг ариутгах, эмнэлгийн болон нийгмийн үйлчилгээний холбогдох ажилтнуудад хамаатай асуудлаар ажиглалт явуулах, мэдээлэх, өвчтөнүүдийг үзлэг, эмчилгээнд бэлтгэх, хувь хүмүүсийн асаргааг төлөвлөхөд оролцох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**5321 Эрүүл мэндийн туслах ажилтан**

**5322 Гэрээр асрамжлах үйлчилгээний ажилтан**

**5329 Өөр газарт ангилагдаагүй эрүүл мэндийн үйлчилгээн дэх хувь хүмүүсийг асрамжлах ажилтан**

## **5321 ЭМНЭЛГИЙН СУВИЛГААНЫ ТУСЛАХ АЖИЛТАН**

Эмнэлгийн сувилгааны туслах ажилтан нь эмнэлэг, клиник, асрамжийн газар зэрэг эрүүл мэндийн төрөл бүрийн байгууллагад өвчтөн ба оршин суугчдын өдөр тутмын аж амьдралд хувийн шууд туслалцаа үзүүлнэ. Тэдгээр нь ерөнхийдөө асаргааны тогтсон төлөвлөгөө, практикийг эмчилгээ сувилгааны болон эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, туслах мэргэжилтний шууд хяналтын дор хэрэгжүүлж ажилладаг.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) эмнэлэг, нөхөн сэргээх болон суурин асрамжийн газарт өвчтөн болон оршин суугчдад эмчлэн сувилгах болон эрүүл мэндийн бусад мэргэжилтний тогтоосон эмчилгээний төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлж, асаргаа, эмчилгээ хийх,
- б) хувийн ариун цэвэр сахих, хооллох, хувцаслах, биеийн хөдөлгөөн, дасгал хийх, холбоо барих, эм уух, хувцсаа солих зэрэг хувийн болон эмчилгээ, асаргааны хэрэгцээнд нь туслах,
- в) өвчтөний байрлалыг өөрчлөх, өргөх, эргүүлэх, түүнийг тэргэнцрээр буюу хөдөлдөг орон дээр тавьж зөөх,

- г) өвчтөний өрөөг цэвэрлэх, орны даавууг солих зэргээр өвчтөний орчны эрүүл ахуйн стандартуудыг хангах,
- д) жирэмсэн болон ажилтай үед нь иллэг хийх, өвчин намдаах эмийн бус арга хэмжээ авах,
- е) өвчтөний байдал, эмчилгээний үр нөлөө, зан төлөвийг ажиглаж, гарч буй өөрчлөлтийн талаар эрүүл мэндийн мэргэжилтэнд илтгэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эх баригчийн туслах (клиник буюу эмнэлгийн)
- Сувилахуйн туслах (клиник буюу эмнэлгийн)
- Өвчтөн асрагч
- Сэтгэл зүйн туслагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2221	Сувилагч (мэргэжлийн)
3221	Сувилагч (туслах мэргэжлийн)
3258	Түргэн тусламжийн ажилтан
5322	Сувилгааны туслах (гэрийн)

#### **Тайлбар:**

Эмнэлэг, сувилахуйн байнгын үйл ажиллагаа, хяналт бүхий байгууллага, суурин, газрууд (эмнэлэг, нөхөн сэргээх төв, суурин сувилгаа, сувиллын газар гэх мэт) оршин суугчдад хувийн асаргаа үзүүлдэг бөгөөд сувилагч, их эмч, бусад мэргэжилтэн, туслах мэргэжилтний шууд хяналтын дор ажилладаг ажилтныг нэгж бүлэг 5321 буюу “Эрүүл мэндийн туслах ажилтан” гэсэн ангилалд, харин оршин суугчдад тэдний гэрээр болон бие даасан эмнэлгийн нэгжүүдэд хувийн асаргаа үзүүлдэг, ерөнхийдөө эмнэлэг, сувилахуйн байнгын хяналттай ажилладаггүй ажилтныг нэгж бүлэг 5322 буюу “Гэрээр асрамжлах үйлчилгээний ажилтан” гэсэн ангилалд тус тус оруулна.

### **5322 ГЭРЭЭР АСРАМЖЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Энэ ангиллын ажилтнууд айл өрх, орон байр зэрэг газарт насжилт, өвчлөл, гэмтэл, биеийн болон оюун ухааны бусад нөхцлийн улмаас асаргаа шаардлагатай болсон хүмүүст өдөр тутмынх нь аж амьдралд хувь хувийн ердийн, хэвшмэл асаргаа, туслалцаа үзүүлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчлүүлэгчдэд хувийн ариун цэвэр сахих, хооллох, хувцаслах, биеийн хөдөлгөөн, дасгал хийх, хүмүүстэй харилцах, холбоо барих, эм уух, хувцсаа солих зэрэг хувийн болон эмчилгээ, асаргааны хэрэгцээнд нь эрүүл мэндийн мэргэжилтний тогтоосон төлөвлөгөөний дагуу туслах,

- б) өвчтөнд үзүүлсэн асаргаа, биеийн байдалд нь гарсан өөрчлөлт, асаргаа эмчилгээний үр нөлөөг тэмдэглэж, бүртгэл хөтлөх, анхаарах асуудлын талаар эрүүл мэндийн буюу нийгмийн үйлчилгээний мэргэжилтэнд мэдээлэх,
- в) хөдөлгөөний бэрхшээлтэй өвчтөний байрлалыг өөрчлөх, өргөх, түүнийг тэргэнцрээр буюу машинаар зөөхөд туслах,
- г) хоол тэжээл, эрүүл ахуй, биеийн дасгал, нярайн асаргаа, тахир дутуу буюу өвчний нөхцөлд дасан зохицох зэрэг асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, үйлчлүүлэгчдэд болон тэдний гэр бүлийнхэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх,
- д) орны даавуу солих, хувцас, хоолны сав суулга угаах, амьдарч байгаа орчныг цэвэрлэх ариутгах зэргээр үйлчлүүлэгчдийн орчны эрүүл ахуйн стандартуудыг хангах,
- е) харилцан ярилцах, унших зүйл дуудаж өгөх зэргээр үйлчлүүлэгчдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх,
- ж) хоол тэжээлийн шаардлага, эмчийн бичсэн тусгай хоолоор хангах үүднээс төлөвлөх, худалдан авах, бэлтгэх, хоолоор үйлчлэх,
- з) шинээр төрсөн нярай хүүхдийг асрах, эцэг эхэд нь дэмжлэг үзүүлэх,
- и) эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүд үйлчлүүлэгчдийг хүлээн авч уулзах хуваарийг гаргах, үйлчлүүлэгчдийг хөтөлж хүргэх, захисан зүйлийг нь биелүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гэрийн асрамжийн туслах
- Гэрийн эх баригчийн туслах
- Сувилгааны туслах (гэрийн)
- Хувийн асаргаа үзүүлэгч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

2221	Сувилагч (мэргэжлийн)
2635	Нийгмийн ажилтан (мэргэжлийн)
3221	Сувилагч (туслах мэргэжлийн)
3412	Нийгмийн ажилтан (туслах мэргэжлийн)
5321	Сувилгааны туслах (клиник буюу эмнэлгийн)

**Тайлбар:**

Гэрээр болон асрамжийн төвд хүүхдэд зориулсан асаргаа, хараа хяналтын үйлчилгээ үзүүлдэг асрамжийн ажилтныг нэгж бүлэг 5311 буюу “Хүүхэд асрамжлах ажилтан” гэсэн ангилалд оруулна.

### **5329 ӨӨР ГАЗАРТ АНГИЛАГДААГҮЙ ЭМНЭЛГИЙН СУВИЛГААНЫ АЖИЛТАН**

Энэ бүлэг нь бага бүлэг 532 буюу “Эмнэлгийн сувилгааны ажилтан” гэсэн ангилалд ороогүй эрүүл мэндийн үйлчилгээнд хувь хүнийг асрамжлах ажилтныг хамарна. Тухайлбал, шүдний эмчийн туслах, ариутгалын туслах, эмнэлгийн асрагч, эмнэлгийн зураг зүйн туслах, эм зүйн туслах зэрэг ажил, мэргэжлийг энэ бүлэгт оруулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) мэс засал, шүдний болон эм зүйн багаж хэрэгсэл, шил савнуудыг цэвэрлэх, ариутгах,
- б) эм, химийн бодис, эм зүйн бусад бэлдмэлийг шошголох, тавиурт нөөцийг гүйцээж дүүргэх,
- в) өвчтөнийг өргөх, хөдөлгөх, тэргэнцрээр буюу хөдөлдөг орон дээр зөөх,
- г) өвчтөнийг үзлэг буюу эмчилгээнд бэлтгэх,
- д) багаж хэрэгслийн тэвш, материал бэлтгэх, шүдний эмч буюу радиографийн эмчид ажиллабарын үед туслах,
- е) рентген зургийн хальсыг дэлгэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шүдний кабинетын туслах ажилтан
- Анхан шатны тусламжийн ажилтан
- Эмнэлгийн эмх журам хариуцсан туслах ажилтан
- Эмнэлгийн зураг зүйн туслах ажилтан
- Эмийн сангийн туслах ажилтан
- Цус авагч ажилтан
- Ариутгалын туслах ажилтан

---

## **ДЭД БҮЛЭГ 54**

### **ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

Хамгаалах үйлчилгээний ажилтан хүмүүс болон өмч хөрөнгийг гал түймэр, бусад аюулаас хамгаалж, хууль ёс, хэв журмыг хангаж, хууль тогтоомжийг сахиулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх, унтраах, шатаж байгаа байшин, ослын газраас, тэрчлэн аюултай нөхцөл байдалд орсон хүмүүсийг аврах, хууль, эмх журмыг хангах, хууль тогтоомжийг

сахиулах, олон нийтийн газраар эргүүл хийх, сэжигтэй этгээдийг зогсоон шалгах, ослын үед замын хөдөлгөөнийг удирдан эрх мэдлийг гардан хэрэгжүүлэх, шоронгийн хоригдол, засан хүмүүжүүлэх, саатуулах газрын хоригдогчдыг харгалзах, хэв журам хангуулах, өмч хөрөнгийг хулгай, эвдэн сүйтгэхээс хамгаалах, үүнд, эргүүл хийх, байр, талбайд хяналт шалгалт хийх, олон нийтийн арга хэмжээний үеэр байр, талбайд нэвтрэх, хяналт тавих, хэв журмыг хангах, дүрэм журмыг сахиулах, Бусад ажилтны ажиллагаанд хяналт тавих ажлыг энд оруулж болно.

Энэ үндсэн дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

#### **541 Хамгаалах үйлчилгээний ажилтан**

### **БАГА БҮЛЭГ 541**

### **ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

Хамгаалах үйлчилгээний ажилтан нь хүмүүс, өмч хөрөнгийг гал түймэр болон бусад аюулаас хамгаалж, хууль ёс, хэв журмыг хангаж, хууль тогтоомжийг сахиулна.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх, унтраах, шатаж байгаа байшин, ослын газраас, тэрчлэн аюултай нөхцөл байдалд орсон хүмүүсийг аврах, хууль, эмх журмыг хангах, хууль тогтоомжийг сахиулах, олон нийтийн газраар эргүүл хийх, сэжигтэй этгээдийг зогсоон шалгах, ослын үед замын хөдөлгөөнийг удирдан эрх мэдлийг гардан хэрэгжүүлэх, шоронгийн хоригдол, засан хүмүүжүүлэх, саатуулах газрын хоригдогчдыг харгалзах, хэв журам хангуулах, өмч хөрөнгийг хулгай, эвдэн сүйтгэхээс хамгаалах, үүнд, эргүүл хийх, байр, талбайд хяналт шалгалт хийх, олон нийтийн арга хэмжээний үеэр байр, талбайд нэвтрэх, хяналт тавих, хэв журмыг хангах, дүрэм журмыг сахиулах, Бусад ажилтны ажиллагаанд хяналт тавих ажлыг энд оруулж болно.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **5411 Аврагч**

#### **5412 Цагдаагийн ажилтан**

#### **5413 Шоронгийн харуул**

#### **5414 Харуул**

#### **5419 Өөр газар ангилагдаагүй хамгаалах үйлчилгээний ажилтан**

**5411 АВРАГЧ**

Аврагч нь түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраах, түймрийн гэнэтийн аюулын үед болон дараа нь хүний ам нас болон аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгийг авран хамгаалах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд оролцох үүрэг гүйцэтгэнэ.

Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, түүнчлэн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үзэл онол, хэрэглээний арга зүйг боловсруулах, шинжлэх ухааны мэдлэгийг гамшиг хамгаалах практикт хэрэгжүүлэх ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зам тээврийн ба үйлдвэрлэлийн осол, тэсрэх бөмбөгийн аюул заналхийлсэн зэрэг бусад онцгой нөхцөл бий болсон үед туслах зорилгоор галын дуудлагаар ажиллах,
- б) гар ажиллагаатай болон цахилгаан багаж хэрэгсэл, гал унтраах химийн бодисийг ашиглан галыг хяналтандаа авах, унтраах,
- в) онцгой төрлийн галын аюултай тэмцэх, үйлдвэрийн байгууламжид тусгай багаж ашиглах,
- г) гал түймрийн аюулаас хүний ам насыг аврах, түймрээс гаргах,
- д) гал түймэр, ослын үед хортой бодисыг тархахаас сэргийлэх ба тархалтыг зогсоох,
- е) үер усны аюулаас урдчилан сэргийлэх, аврах, хамгаалалтын рага хэмжээ авах,
- ж) цацраг, хими, хүн, малын гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, хамгаалалтад авах,
- з) аюулаас урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэл хийх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Аврагч
- Аврагч-гал сөнөөгч
- Шүхэрчин-гал сөнөөгч
- Аврагч-химичин
- Ойн түймэр унтраагч
- Гашгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
- Гамшиг судлалын эрдэм шинжилгээний ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |  |
|------|--|
| 3112 | Гал, түймэрийн улсын хяналтын байцаагч |
| 3112 | Галын аюулаас сэргийлэх мэргэжилтэн    |



**5412 ЦАГДААГИЙН АЖИЛТАН**

Цагдаагийн ажилтан нь төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дэг журам сахиулах, тодорхой газруудад эргүүл хийх, хууль тогтоомжийг зөрчсөн байж болох этгээдийг саатуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тодорхой газруудад эргүүл хийх, хэв журмыг сахиулах, хүний амь нас эрүүл мэнд, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, шуурхай дуудлагад хариулах,
- б) гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй болон үйлдсэн этгээдийг тогтоох, саатуулах,
- в) зам тээврийн ослын үед замын хөдөлгөөнийг зохицуулах, зохих арга хэмжээг авах,
- г) байгалийн гамшигт үзэгдэл, гэмт хэрэг, ослын үед шуурхай тусламж үзүүлэх зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цагдаа
- Эргүүлийн цагдаа

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

3355 Цагдаагийн мөрдөн байцаагч

**5413 ШОРОНГИЙН ХУЯГ**

Шоронгийн хуяг нь шорон, хорих ба засан хүмүүжүүлэх газар хоригдож байгаа этгээдийг харгалзан тэдний дунд дэг журмыг сахиулах үүрэгтэй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) шинээр ирсэн хоригдлыг нэгжих, түүний хувийн эд зүйлсийг хураан авч бүртгэн хадгалах ба уг хоригдлыг өрөөнд нь хүргэж цоожлох,
- б) тодорхой хугацаанд өрөөнүүдийг эргэж шалгах,
- в) ажил хийх, хооллох, салхинд гаргах үед хоригдлуудыг харгалзах, оргож зайлахаас урьдчилан сэргийлэх,
- г) шоронгийн орчинд эргүүл хийх,
- д) хүмүүжүүлэх ажлыг хэрэгжүүлэх, туслах,
- е) ялтанг шилжүүлэх, түр чөлөөгөөр гарахад нь харгалзах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шоронгийн хуяг

**5414 ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛТАН**

Хамгаалалтын албаны ажилтан нь байгууллагын өмч хөрөнгийг хулгайч, хорлон сүйтгэх явдлаас хамгаална. Тэрээр байгууллагад нэвтрэн орох, гарах хэсгийг хяналтандаа байлгаж, байгууллагын дотоодод аюулгүй байдлын талаарх нийтэд хамаарах дүрэм журмын хэрэгжилтийг хангуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) байгууллагад зөвшөөрөлгүй нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор цонх, хаалгыг шалгах, эргэж тойрч байх,
- б) байгууллагад нэвтрэх дотоодын ажилтны болон гадны хүний бичиг баримтыг шалгах, гарч, орж байгаа хүмүүст хяналт тавих,
- в) дэг журмыг сахиулах, хулгайч, хорлон сүйтгэх ажиллагаанаас байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулахын тулд, гадны зочид, иргэнд шаардлага тавих,
- г) дохиоллын ажиллагааг шалгах, дохиолол илэрмэгц шалтгааныг тогтоох, уг үйл явдлаас хамаарч хянан шалгагч, цагдаа, гал сөнөөгч зэрэг аль нэг холбогдох газарт мэдэгдэх,
- д) онгоцны буудал дээр зорчигч болон тэдний ачаа тээшинд аюулгүй байдлын шалгалт хийх,
- е) жижиглэн худалдаа эрхлэгч, автомат мөнгөний машин, банкинд мөнгө хүргэхэд аюулгүй байдлыг хангах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бие хамгаалагч
- Хаалгачин
- Музейн хамгаалагч
- Харуул хамгаалалтын ажилтан
- Төмөр замын харуул

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5411 Аврагч

**5419 АЛЬ НЭГ АНГИЛАЛД ОРООГҮЙ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД АЖИЛТАН**

Энэ нэгж бүлэгт бага бүлэг 541-т ороогүй хамгаалалтын үйлчилгээний бусад ажилтан багтана. Жишээлбэл, гол усны ослоос аврагч, зам хөндлөн гаргагч, амьтан хянагч гэх мэт.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гол, мөрөн, нуур, цөөрөм болон усан сан зэрэгт осол гарахаас урьдчилан сэргийлэх, усанд шивж байгаа хүнийг аврах,
- б) замын хөдөлгөөнийг ажиглах, явган зорчигч зам хөндлөн гарах боломжтой үед нь зам хөндлөн гаргах,
- в) эзэнгүй, алдагдсан, тэнэмэл гэрийн тэжээвэр амьтан болон зэрлэг амьтныг иргэдийн гомдолын мөрөөр цуглуулах, сэрэмжлүүлэг, зарлал гаргах,
- г) машины зогсоол тавих газарт мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор эргүүл хийх,
- д) замын хөдөлгөөнийг зохицуулах зэрэг багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Амьтан хянагч
- Гол, мөрөн, нуурын эргийн эргүүл
- Зам хөндлөн гаргагч
- Гол усны ослоос аврагч
- Замын хөдөлгөөн зохицуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлийн жишээ:**

- |      |                   |
|------|-------------------|
| 5414 | Хаалгач           |
| 5414 | Музейн хамгаалагч |
| 5414 | Харгалзагч        |

## ҮНДСЭН БҮЛЭГ 6

# ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС

# АГНУУРЫН МЭРГЭШСЭН АЖИЛТАН

---

Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж, үржүүлнэ. Энэ үндсэн бүлгийн ихэнх ажил мэргэжил нь Олон улсын ажил, мэргэжилийн стандарт (ISCO)-ын 2 дугаар түвшний ур чадвар, мэргэжил шаардана.

### Гүйцэтгэх үүрэг:

Хөрс бэлтгэх, үр, ургамал суулгах, арчлах, бордох, хурааж авах, жимсний болон бусад мод, бут, цэцэрлэгийн ургамал, малын тэжээл тарьж ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, мах, сүү, үс, ноос, арьс, бал, бусад бүтээгдэхүүн авах зорилгоор амьтан өсгөх, арчлах, ойжуулах, арчлан хамгаалах, ашиглах, загас үржүүлэх буюу барих, хөдөө аж ахуйн төрөл бүрийн бүтээгдэхүүнийг хадгалж нөөцлөх, анхан шатны боловсруулалт хийх, худалдан авагчид, худалдааны байгууллагад буюу зах дээр зарж борлуулах. Бусад ажилтанд хяналт тавих ажил энд орж болно.

Энэ үндсэн бүлгийн ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 61 Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан**
- 62 Зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан**
- 63 Өрхийн хэрэгцээний шинжтэй фермч, загасчин, анчин болон түүн цуглуулагч**

---

### ДЭД БҮЛЭГ 61

## ЗАХ ЗЭЭЛИЙН БАРИМЖААТАЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН

## МЭРГЭШСЭН АЖИЛТАН

---

Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэжсэн ажилтан нь бөөний худалдаачид, худалдааны байгууллагад буюу зах дээр байнга

нийлүүлэх, борлуулах зорилгоор үр тариа, мод, бут ургуулах, хурааж авах, амьтан өсгөх болон амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Хөрс бэлтгэх, үр, талбайн ургамал суулгах, арчлах, бордох, хурааж авах, мод, бут ургуулах, хүнсний ногоо болон цэцэрлэгийн ургамал, малын тэжээл тарьж ургуулах, мах, сүү, үс, ноос, арьс, бал, бусад бүтээгдэхүүн авахын тулд амьтан өсгөн үржүүлэх, арчлах, бүтээгдэхүүнийг хадгалж нөөцлөх, анхан шатны зарим боловсруулалт хийх, худалдан авагчид, худалдааны байгууллага буюу зах дээр борлуулах. Бусад ажилтанд хяналт тавих ажлыг энд оруулж болно.

Энэ дэд бүлгийн ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**611 Зах зээлд чиглэсэн цэцэрлэгч ба газар тариаланч**

**612 Амьтан маллагч**

**613 Мал амьтан, газар тариалангийн холимог аж ахуй эрхлэгч**

### **БАГА БҮЛЭГ 611**

#### **ЗАХ ЗЭЭЛД ЧИГЛЭСЭН ЦЭЦЭРЛЭГЧ БА ГАЗАР ТАРИАЛАНЧ**

---

Зах зээлд чиглэсэн цэцэрлэгч ба газар тариаланч нь бөөний худалдааны маркетингийн байгууллага буюу зах зээлд тогтмол зарж борлуулах, нийлүүлэх зорилгоор үр тариа тарих, жимс, мод, бутны үр тарьж ургуулах, хүнсний ногоо, эмийн болон малын тэжээл, бусад ургамал тарьж ургуулах, цэцэрлэгийн болон хүлэмжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, тарьж ургуулах үр тарианы төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах, үр, булцуу, бордоо худалдаж авах, газрын хөрсний чанарыг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хөрс бэлтгэх, төрөл бүрийн үр, ургац суулгах, ургуулах, хураан авах, ажлын мал арчлах, фермийн барилга, машин, тоног төхөөрөмжийг арчлах, засварлах, зулзган мод, булцуу, үр үйлдвэрлэн гаргах, гаргасан бүтээгдэхүүнийг нөөцлөн хадгалах, зарим боловсруулалт хийх, бүтээгдэхүүн нийлүүлэх буюу зах зээлд гаргах. Бусад ажилтанд хяналт тавих ажлыг энд оруулж болно.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6111 Талбайд үр тариа, хүнсний ногоо тариалагч**

**6112 Мод, бутны үр тарьж ургуулагч**

**6113 Цэцэрлэгч, цэцэрлэгийн ба хүлэмжийн ургамал ургуулагч**

**6114 Төрөл бүрийн ургамал хольж ургуулагч**

### **6111 ТАРИАЛАНЧ, НОГООЧИН**

Талбайд үр тариа болон хүнсний ногоо тариалагч нь бөөний худалдаа, маркетингийн байгууллага буюу зохион байгуулалтай зах зээл дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор эрдэнэ шиш, бусад амуу тариа, улаан манжин, малын тэжээл, бусад үр тариа, төмс, хүнсний ногоо зэргийг тарьж ургуулах, хураан авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцлийг ажиглаж судлах, тарьж ургуулах үр тарианы төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) хөрсийг гараар болон машинаар боловсруулах, бордоо ба өтөг цацаж тараах,
- в) үр сонгох, үрслэгч суулгах,
- г) хөрс боловсруулах, шилжүүлэн суулгах, ургамлыг цэвэрлэх, услагааны тоног төхөөрөмж байгуулах, ажиллуулах замаар тарьцыг тэтгэх,
- д) ургамал сүйтгэгч, хортон шавьжийг устгагч хэрэглэж зэрлэг өвс, хогийн ургамал, хортон шавьж, өвчнийг хянах,
- е) малын тэжээлийн ургамал тариалж, ургац хураах,
- ж) үр тариаг зарж борлуулах буюу зах зээлд нийлүүлэх зорилгоор үзэж шалгах, цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах, ачих,
- з) ажлын мал арчлах, фермийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, усан хангамжийн системийг арчлан хамгаалах,
- и) бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулалт хийх,
- к) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд борлуулах, бүтээгдэхүүн, материалын худалдаа, худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, фермийн үйл ажиллагаа, гүйлгээний бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,
- л) үр тарианы үйлдвэрлэл, засвар үйлчилгээний ажил, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журмын талаар ажилтныг сургах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тарианы фермч
- Фермийн мэргэшсэн ажилтан (талбайн үр тарианы)
- Хүнсний ногоо тариалагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                      |
|------|--------------------------------------|
| 1311 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн менежер |
| 9211 | Үр тарианы фермийн ажилтан           |

**6112 МОД, БУТ ТАРЬЖ УРГУУЛАГЧ**

Мод, бут тарьж ургуулагч нь бөөний худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор жимсний мод, самрын мод, чацаргана, жимсний бут зэрэг мод, бутыг тарьж ургуулах, хураан авах, ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцлийг ажиглаж судлах, тарьж ургуулах үр тарианы төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) хөрсийг гараар болон машинаар боловсруулах, бордоо ба өтөг цацах, тараах,
- в) үр сонгох, үрслэгч суулгах,
- г) хөрс боловсруулах, шилжүүлэн суулгах, ургамлыг цэвэрлэх, шигүүслийг багасгах, услагааны тоног төхөөрөмж байгуулах, ажиллуулах замаар үр тарьцыг тэтгэх,
- д) ургамал сүйтгэгч, хортон шавьж устгагч хэрэглэж зэрлэг өвс, хогийн ургамал, хортон шавьж, өвчнийг судлах, хянах,
- е) мод, бутыг арчлах, ургац хураах,
- ж) үр тариаг зарж борлуулах буюу зах зээлд нийлүүлэх зорилгоор үзэж шалгах, цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах, ачих,
- з) ажлын мал арчлах, фермийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, усан хангамжийн системийг арчлан хамгаалах,
- и) бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх,
- к) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд борлуулах, бүтээгдэхүүн, материалын худалдаа, худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, фермийн үйл ажиллагааны болон гүйлгээний бүртгэлийг хөтлөх, үнэлгээ хийх,
- л) үр тарианы үйлдвэрлэл, засвар үйлчилгээний ажил, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журмын талаар ажилтанд сургалт явуулах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Жимсний фермч
- Чацарганы фермч
- Мод, ургамал арчлагч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжлүүд:**

- |      |                               |
|------|-------------------------------|
| 1311 | Тариалангийн аж ахуйн менежер |
| 9211 | Жимс хураагч                  |

**6113 ЦЭЦЭРЛЭГЧ, ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, ХҮЛЭМЖИД ТАРИАЛАГЧ**

Цэцэрлэгч, цэцэрлэгт хүрээлэн, хүлэмжид тариалагч нь бөөний худалдаа, маркетингийн байгууллага буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэнд мод, бут, цэцэг, бусад ургамал тариалж, арчлан хамгаалах, зулзаган мод, булцуу, үр гаргаж авах, эсвэл эрчимжсэн арга, техник хэрэглэж хүнсний ногоо, цэцэг ургуулах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулан гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, тарьж ургуулах хүнсний ногоо, цэцэрлэгийн ба хүлэмжийн бүтээгдхүүний төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) хөрс бэлтгэх, газар тэгшлэх, усжуулалтын болон ус зайлуултын систем суурилуулах, ажиллуулах,
- в) мод, цэцэрлэгийн ургамал, өвс суулгах, хашаа хатгах,
- г) мод, бут, шивээг ялгаж цэвэрлэх, тайрах, ургамалыг босгох гадас хатгах, хамгаалалт суурилуулах, хөвөө, хязгаарын зүлгийг хадах,
- д) цэцэрлэгийн дотор явган хүний зурвас, цардмал талбай, хана, чулуун байгууламж, цэцэрлэгийн хиймэл нуурын суурь, усан байгууламж, сүүдрэвч, хашаа зэрэг байгууламжийг барих,
- е) мод, ургамлын эрүүл мэндийн байдлыг шалгах, хортон шавьж, хорлон сүйтгэгч, өвчнийг олж тогтоох, устгах, модны үндэс хамгаалах түрхэц болон бордоо хэрэглэх,
- ж) зулзган мод, булцуу, үр гаргаж авах, үр буюу тасдацыг үрслүүлэн тарьж ургуулах,
- з) үр тариа хураах, бүтээгдэхүүнийг зарж борлуулах буюу зах зээлд нийлүүлэх зорилгоор үзэж шалгах, цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах, ачих,
- и) барилга, хүлэмж, бусад бүтээц, тоног төхөөрөмж, усан хангамжийн системийг арчлах, хамгаалах,



- к) бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх,
- л) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд борлуулах, бүтээгдэхүүн, материалын худалдаа, худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, фермийн үйл ажиллагааны болон гүйлгээний бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,
- м) үр тарианы үйлдвэрлэл, засвар үйлчилгээний ажил, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журмын талаар сургалт явуулах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цэцэрлэгийн ургамал тариалагч
- Газар тохижуулалтын цэцэрлэгчин
- Зах зээлд чиглэсэн цэцэрлэгчин
- Мөөг таригч

**Өөр газар ангилсан холбогдох ажил, мэргэжил:**

- 2132 Цэцэрлэгийн тариалангийн эрдэм шинжилгээний ажилтан
- 9214 Цэцэрлэгийн ажилтан
- 9214 Цэцэрлэгийн тариалангийн ажилтан

**6114 ХОЛИМОГ УРГАМАЛ ТАРИАЛАГЧ**

Холимог ургамал тариалагч нь худалдан авагчид, маркетингийн байгууллага буюу зах дээр зарж борлуулах, нийлүүлэх зорилгоор үр тариа, хүнсний ногоо, мод, бутны үр, цэцэрлэгийн тариалангийн болон хүлэмжийн бүтээгдэхүүн зэрэг холимог ургамалыг тарьж ургуулан хурааж авах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, тарьж ургуулах үр тарианы төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) хөрсийг гараар болон машинаар боловсруулах, бордоо ба өтөг бууц цацах, тараах,
- в) үр сонгох, суулгах,
- г) мод, бутны үр шилжүүлэн суулгах, цэвэрлэх, усалгааны тоног төхөөрөмж байрлуулах, ажиллуулах замаар тарьцыг тэтгэх,
- д) цэцэг, хүнсний ногоог эрчимжсэн аргаар тарьж ургуулах,
- е) үр тариаг хураах, зарж борлуулах буюу зах зээлд нийлүүлэх зорилгоор үзэж шалгах, цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах, ачих,
- ж) ажлын мал арчлах, фермийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, усан хангамжийн системийг арчлан хамгаалах,

- з) бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх,
- и) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд бүтээгдэхүүн, материалын худалдаа явуулах, худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, фермийн үйл ажиллагааны болон гүйлгээний бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,
- к) үр тарианы үйлдвэрлэл, засвар үйлчилгээний ажил, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журмын талаар сургалт явуулах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Холимог ургамал тариалагч, фермч
- Фермийн мэргэшсэн ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

1311	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн менежер
1311	Газар тариалангийн менежер
9211	Үр тарианы фермийн ажилтан
9211	Жимс хураагч

## **БАГА БҮЛЭГ 612**

### **МАЛ, АМЬТАН МАЛЛАГЧ**

Мал, амьтан маллагч нь мах, цагаан идээ, зөгийн бал, арьс, нэхмэл болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, малыг унлага, тээврийн ажил, спорт, аялалд хэрэглэх, худалдан авагчид, маркетингийн байгууллага буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор мал, гэрийн тэжээмэл амьтан, шувуу, гэрийн тэжээмэл бус амьтдыг өсгөж үржүүлэх ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйл ажиллагаагаа төлөвлөх, уялдуулан зохицуулах, мал амьтан тэжээх, маллах, өсгөх, арчлах, мал амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд зориулан бэлтгэх, өвчлөлт, гэмтэл, өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, жин, тарга хүчний хэмжээ зэрэг мал амьтны биеийн байдлыг хянах, үзэж шалгах, үржүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх, мал, амьтны нөхөн үржихүйтэй холбоотой ажил явуулах, байшин барилга, машин, тоног төхөөрөмж, бүтээц хэсгийг түрээслэх, хөрөнгө оруулах, тэдгээрийг цэвэрлэх, арчлах, бүтээгдэхүүн хадгалах, зарим боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг сурталчлах, бүтээгдэхүүн, материалын худалдаа,

худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, үйл ажиллагааны болон гүйлгээний бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх, мал, амьтан арчлах арга ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын горим, журмын талаар ажилтныг сургаж бэлтгэх, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6121 Мал маллагч, цагаан идээ үйлдвэрлэгч**

**6122 Шувуу өсгөгч**

**6123 Зөгий үржүүлэгч**

**6129 Өөр газар ангилаагүй амьтан маллагч**

### **6121 МАЛ МАЛЛАГЧ БА СҮҮ, ЦАГААН ИДЭЭ ҮЙЛДВЭРЛЭГЧ**

Мал маллагч ба сүү, цагаан идээ үйлдвэрлэгч нь мах, сүү, бусад цагаан идээ, арьс, ноос авах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ачлага, уналагийн ажил, спорт, аялалд хэрэглэх, худалдан авагчид, маркетингийн байгууллага буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор үхэр, хонь, ямаа, адуу, тэмээ, гахай, зэрэг мал, амьтныг (шувууг оруулахгүй) өсгөн үржүүлэх ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) хоол тэжээлийн зохих түвшин, мал сүргийн зохистой маллагааг хангахын тулд бэлчээр сэлгэж сайжруулах, тэжээл, усаар хангах, тэдгээрт хяналт тавих,
- в) өвчлөлт, гэмтэл, өвчнийг илрүүлэх, жин нэмэлтийн хэмжээ зэрэг мал амьтны биеийн байдлыг шалгахын тулд тэдгээрийг хянах, үзэж шалгах,
- г) амьтныг угааж цэвэрлэх, тэмдэг тавих, эм уулгах, засах, үс, ноосыг нь хайчилж авах,
- д) малыг идээшлүүлэхийн тулд бэлчээрт гаргах, жигнэх, машинд ачих, саравч, хайс руу оруулах,
- е) малыг гараар буюу автомат саалтуураар саах,
- ж) малд тэжээл, нэмэлт бүтээгдэхүүн, эмийг тогтоосон хэмжээгээр найруулж гараар юмуу дунд нь тарааж өгөх,
- з) үржүүлэг хээлтүүлэг хийх, мал төрөхөд туслах зэрэг амьтны нөхөн үржихүйтэй холбоотой ажил явуулах,

- и) фермийн барилга байшин, машин, тоног төхөөрөмж, бүтэц хэсгийг цэвэрлэх, арчилж тордох,
- к) мал нядлах, өвчих, зах зээлд гаргахаар бэлтгэх,
- л) малын гаралтай бүтээгдэхүүн болон цагаан идээг хадгалах, зарим боловсруулалт хийх,
- м) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд борлуулах, мал, бүтээгдэхүүн, материалын худалдаа, худалдан авалт, тээвэрлэлтийг зохицуулах, фермийн үйл ажиллагааны болон гүйлгээний бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,
- н) мал маллагааны арга ажиллагаа, арчлан хамгаалах үүрэг, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны дүрэм журмын талаар ажилтнуудыг сургах, хяналт тавих, ажилчид, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Малын фермч
- Цагаан идээний фермч
- Мал, амьтан маллагч
- Малчин

#### **Өөр газар газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                      |
|------|--------------------------------------|
| 1311 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн менежер |
| 1311 | Эдлэн газрын менежер                 |

#### **Тайлбар:**

Төрөл бүрийн мал, шувуу, шавьж, гэрийн тэжээмэл бус амьтдыг өсгөн үржүүлэгчийг ангилахдаа чухам аль төрлийг нь илүү давуутай өсгөж байгааг харгалзана. Өвс, тэжээл бэлтгэж хадгалагчдыг Нэгж бүлэг 6121 буюу “Мал маллагч, сүү, цагаан идээ үйлдвэрлэгч” гэсэн ангилалд оруулна.

### **6122 ШУВУУ АЖ АХУЙ АЖИЛТАН**

Шувуу аж ахуй ажилтан нь худалдан авагч, маркетингийн байгууллага буюу зах дээр бүтээгдэхүүн тогтмол зарж борлуулах, нийлүүлэх зорилгоор мах, өндөг, үржлийн шувуу маллах, тахиа, хяруул, галуу, нугас, бусад шувуу өсгөх, үржүүлэх фермийн ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагаа, нөхцөлийг ажиглаж судлах, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах, фермийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,

- б) шувууны хоол тэжээл, амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зүйлийг тарьж ургуулах ба худалдаж авах,
- в) өвчлөлт, гэмтэл, өвчнийг илрүүлэх, жин нэмэлтийн хэмжээ зэрэг шувууны биеийн байдлыг хянах,
- г) холимогтэжээлбэлтгэх, тэжээлийн ба усны савыг дүүргэх, ус, тариагаар дамжуулан, эсвэл агаарт цацах аргаар шувууг вакцинжуулах,
- д) өндөг хураах, хадгалах, зах зээлд нийлүүлж борлуулахад тохируулж савлах,
- е) ангаахайны хүйсийг тодорхойлох, үржил, зохиомол хээлтүүлэг, өндөг даралтыг хөнгөвчлөх, дэмжих,
- ж) фермийн барилга байшин, машин, тоног төхөөрөмжийг түрээслэх, хөрөнгө оруулах, тэдгээрийг арчлах, цэвэрлэх,
- з) зарж борлуулах буюу зах зээлд нийлүүлэхээр шувуу нядлах, эвдэж бэлтгэх,
- и) бүтээгдэхүүн хадгалах,
- к) туслах бүтээгдэхүүн, хангамжийн зүйлс худалдах, худалдан авах, тээвэрлэх ажлыг зохицуулах,
- л) шувууны үйлдвэрлэлийн арга ажиллагаа, арчлан хамгаалах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын горим, журмын талаар ажилтныг сургах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шувуучин
- Шувуу фермч
- Шувуу аж ахуй эрхлэгч

**Тайлбар:**

Мал болон шувуу, шавьж, гэрийн тэжээмэл бус зэрэг бусад амьтныг өсгөн үржүүлэгч ажилтныг давуутай эрхэлж байгаа үйл ажиллагааны төрлөөр нь ангилбал зохино.

**6123 ЗӨГИЙ ҮРЖҮҮЛЭГЧ**

Зөгий үржүүлэгч нь худалдан авагч, маркетингийн байгууллага буюу зах дээр тогтмол зарж борлуулах, нийлүүлэх зорилгоор зөгийн бал, зөгийн лав тос, бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Балт зөгий, үржүүлэх, арчлах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээл судлах, үйлдвэрлэн гаргах зөгийн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,

- б) тэжээл, бусад хангамжийн зүйлийг ургуулах буюу худалдаж авах,
- в) хорхой, шавьжийг өсгөх, үржүүлэх, арчлах, бүтээгдэхүүнийг нь хурааж авах,
- г) барилга байшин, машин, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийх, тэдгээрийг арчлах, цэвэрлэх,
- д) бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх,
- е) нөөц, бүтээгдэхүүн, хангамж, фермийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,
- ж) хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журамд ажилтныг сургах, хяналт тавих, гэрээлэгчдийг ажилд авах, халах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зөгий үржүүлэгч

**6129 ӨӨР ГАЗАР АНГИЛАЛД ОРООГҮЙ АМЬТАН МАЛЛАГЧ**

Энэхүү нэгж бүлэг нь бага бүлэг 612 бүлэг буюу “Амьтан маллагч” гэсэн ангилалд ороогүй бөгөөд зах зээлд зориулсан амьтан маллагчийг хамарна. Тухайлбал, энэ бүлэгт лабораторийн шинжилгээнд ашиглах, бөөний худалдагч, маркетингийн байгууллага, амьтны хүрээлэн, циркэд болон зах дээр зарж борлуулах буюу нийлүүлэхэд зориулагдсан гэрийн тэжээмэл бус сүүн тэжээлтэн, ан амьтан, бусад шувуу (шувууны аж ахуйг оруулахгүй), эмгэн хумс, могой, бусад мөлхөгч амьтад, мөн түүнчлэн төрөл бүрийн хорхой, шавьж, амьтдыг өсгөх, үржүүлэх, арчлан маллах ажил эрхлэгчдийг оруулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагааг судлах, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг тодорхойлж, төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) амьтад өсгөх, тэжээх, арчлах,
- в) амьтны гаралтай төрөл бүрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах,
- г) өвчлөлт, гэмтэл, өвчнийг илрүүлэх, жин нэмэлтийн хэмжээ зэрэг амьтны биеийн байдлыг шалгахын тулд амьтныг хянах, үзэж шалгах,
- д) үржүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх, амьтан төллөхөд туслах, амьтны нөхөн үржихүйтэй холбоотой ажил явуулах,
- е) барилга байшин, машин, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах, тэдгээрийг арчлах, цэвэрлэх,
- ж) амьтдыг нядлах, өвчих, зах зээлд борлуулахаар бэлтгэх,
- з) бүтээгдэхүүн хадгалах, зарим боловсруулалт хийх,

- и) бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд гаргах, нөөц, бүтээгдэхүүн, хангамжийн зүйлс худалдах, худалдан авах, тээвэрлэх ажлыг зохицуулах, үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, түүнд үнэлгээ хийх,
- к) амьтан арчлах арга ажиллагаа, хамгаалах үүрэг, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журмын талаар ажилтныг сургах, хяналт тавих.

**Энэ ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үс, арьсны фермч (гэрийн тэжээмэл бус амьтдын)
- Ангийн шувуу үржүүлэгч
- Тэмээн хяруулын фермч
- Мал эмнэлэг, биотехнологийн үйлдвэрлэлийн /мэргэшсэн/ ариутгагч, биобэлдмэлч, ферментёрч, лаборант, лабораторийн жижиг амьтан үржүүлэгч, амьтан маллагч
- Хөдөө аж ахуй, мал эмнэлэг, биотехнологийн үйлдвэрлэлийн ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 5164 Гэрийн тэжээвэр амьтан маллагч
- 5164 Амьтны хүрээлэнгийн ажилтан
- 5419 Ан гөрөөс харгалзагч
- 6122 Шувуу үржүүлэгч

**БАГА БҮЛЭГ 613**

**МАЛ АМЬТАН, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХОЛИМОГ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ**

Мал амьтан, газар тариалангийн холимог аж ахуй эрхлэгч нь худалдан авагч, маркетингийн байгууллагад түүнчлэн зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор мод, төрөл бүрийн ургамал, үр тариа тарьж ургуулах, хураан авах, мөн амьтан үржүүлэх, өсгөх, арчлан маллах, төрөл бүрийн амьтны аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх фермийн ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Зах зээлийн төлөв, байдлыг ажиглаж судлах, тарих үр тариа, өсгөх амьтны нэр төрөл, хэмжээг тодорхойлох, төлөвлөх, уялдуулан зохицуулах, үр, бордоо, бусад материал худалдан авах, газар бэлтгэх, үр суулгах, үр тариа суулгах, ургуулах, хураан авах, тэжээл, бусад хүнсний материалыг үйлдвэрлэх эсвэл худалдан авах, амьтан үржүүлэх, өсгөх, арчлах, амьтан төхөөрөх, өвчих, амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг

зах зээлд бэлтгэх, барилга байшин, машин, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах, тэдгээрийг арчлах, цэвэрлэх, бүтээгдэхүүнийг хадгалах, зарим боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд гаргах, мал, бүтээгдэхүүн, хангамжийн зүйлс худалдах, худалданавах, тээвэрлэх ажлыг зохицуулах, фермийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх, амьтан маллах арга ажиллагаа, арчлан хамгаалах үүрэг, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, хэвийн ажиллагааны дүрэм журмын талаар ажилтанд зааж сургах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **6130 Мал амьтан, газар тариалангийн холимог аж ахуй эрхлэгч**

#### **6130 МАЛ, АМЬТАН, ТАРИАЛАН ХОЛИМОГ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ**

Мал, амьтан, газар тариалан холимог аж ахуй эрхлэгч нь худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах, нийлүүлэх зорилгоор төрөл бүрийн ургамал, бусад үр тариа тарьж ургуулах, хураан авах, мөн түүнчлэн амьтан үржүүлэх, өсгөх, арчлан маллах, төрөл бүрийн амьтны аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) зах зээлийн үйл ажиллагааг ажиглаж судлах, тарих үр тариа, өсгөх амьтны нэр төрөл, хэмжээг тодорхойлох, үүний дагуу үйлдвэрлэлээ төлөвлөх, уялдуулан зохицуулах,
- б) үр, бордоо, бусад материал худалдан авах, газар бэлтгэх, үр суулгах, үр тариа суулгах, ургуулах, хураан авах ажиллагаа явуулах,
- в) тэжээл, бусад хүнсний материалыг үйлдвэрлэх эсвэл худалдан авах,
- г) амьтан үржүүлэх, өсгөх, арчлах,
- д) амьтныг төхөөрөх, өвчих, амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд бэлтгэх,
- е) барилга байшин, машин, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, хөрөнгө оруулах, тэдгээрийг арчлах, цэвэрлэх,
- ж) бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх,
- з) бүтээгдэхүүн сурталчлах, зах зээлд гаргах, мал, бүтээгдэхүүн, хангамжийн зүйлс худалдах, худалдан авах, тээвэрлэх ажлыг зохицуулах, фермийн үйл ажиллагааны бүртгэл хөтлөх, үнэлгээ хийх,



и) амьтан маллах арга ажиллагаа, арчлан хамгаалах үүрэг хариуцлага, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, ажиллагааны дүрэм журмын талаар ажилтныг сургах, хяналт тавих, ажилтан, гэрээлэгчдийг ажилд авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Фермч (холимог фермийн)
- Фермийн мэргэжсэн ажилтан (холимог фермийн)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжлүүд:**

1311	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн менежер
1311	Тариалангийн талбайн менежер
9213	Холимог фермийн ажилчин

---

## ДЭД БҮЛЭГ 62

### **ЗАХ ЗЭЭЛИЙН БАРИМЖААТАЙ ОЙ, ЗАГАС АГНУУРЫН АЖ АХУЙН МЭРГЭШСЭН АЖИЛТАН**

---

Эдгээр аж ахуйн мэргэшсэн ажилтан нь худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор байгалийн болон таримал модыг ургуулах, хамгаалах, ашиглах, загас үржүүлэх, өсгөх, барих, амьтан агнах, урхидах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Машин, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах, материал худалдан авах, ой, усны амьтан, ургамал, загас, агнуурын зэрэг аж ахуйн ажиллагааг төлөвлөх, явуулах, барилга, цистерн сав, машин, бусад тоног төхөөрөмжийг арчлах, бүтээгдэхүүн нийлүүлэх, зах зээлд гаргах, бусад ажилтанг сургах.

Энэ үндсэн дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**621 Ойн аж ахуйн болон түүнд холбогдох ажилтан**

**622 Загасны аж ахуйн ажилтан, анчин, урхичин**

**БАГА БҮЛЭГ 621**  
**ОЙН АЖ АХУЙ, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

---

Ойн аж ахуй, холбогдох бусад ажилтан нь байгалийн болон таримал ой модыг ургуулах, хамгаалах, ашиглах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Ойжуулах газарт үнэлгээ хийх, үрслэгч сонгох, гар багаж хэрэглэж мод суулгах, үрсэлж байгаа хэсгийг суулгах, хамгаалах, таслан унагаах модны байршлыг тогтоох, бэлтгэх гуалингийн хэмжээг тооцоолон гаргах, залуу ургацыг сийрүүлэх, мод мөчирлөх, тайрах, таслах, гуалин болгож хөрөөдөхийн тулд гинжит хөрөө, бусад цахилгаан хөрөө ажиллуулах, мод унагаах газарт гуалингаас бүдүүн модон бүтээгдэхүүн гаргаж авах, гуалинг багцлах, налуу руу гулсуулах, голд хөвүүлэн урсгах, ойн гал түймрийг илрүүлэхийн тулд хараа хяналт тавих, гал унтраах ажиллагаанд оролцох, гал унтраасан тухай тайлан гаргах, гал унтраах тоног төхөөрөмжийг арчлан хамгаалах, гар багаж, химийн бодис ашиглаж таримал ойг сэргээх, хогийн ургамал, бутыг хяналтанд авах, нөхөн сэргээх талбайг самнах буюу талбай цэвэрлэх тоног төхөөрөмжийг чирэх бульдозер, бусад хөдлөх механизмыг ажиллуулах, үрийн боргоцой хураах, модыг илүүц зүйлээс салгаж цэвэрлэх, мод суулгах тойм судалгаанд туслалцаа үзүүлэх, цаашдын ажиллагаанд зориулж модонд тэмдэг тавих, ойн аж ахуйн арга ажиллагаанд бусад ажилтнуудыг, түүний дотор ой аж ахуйн ажилтан, операторчийг сургах, хяналт тавих.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6210 Ойн аж ахуйн болон түүнд холбогдох ажилтан****6210 ОЙН АЖ АХУЙ, БОЛОН ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛТАН**

Ойн аж ахуй, түүнд холбогдох ажилтан нь байгалийн болон таримал ой модыг ургуулах, хамгаалах, ашиглах ажиллагааг төлөвлөж, зохион байгуулж, гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ойжуулах газарт үнэлгээ хийх, үрслэгч сонгох, гар багаж хэрэглэж мод суулгах, ургаж байгаа хэсгийг байгуулах, хайрлан хамгаалах,
- б) таслан унагаах моднуудын байршлыг тогтоох, гарах гуалингийн хэмжээг тооцоолон гаргах,

- в) ойн залуу ургацыг сийрүүлэх, мод мөчирлөх, тайрах, таслах, гуалин болгож хөрөөдөхийн тулд гинжит хөрөө, бусад цахилгаан хөрөө ажиллуулах,
- г) мод унагаах газарт гуалингаас бүдүүн тоймын модон бүтээгдэхүүн гаргаж авах,
- д) гуалинг багцлах, налуу руу гулсуулах, голд хөвүүлэн урсгах,
- е) ойн гал түймрийг илрүүлэхийн тулд хараа хяналт тавих, гал унтраах ажиллагаанд оролцох, гал унтраасан тухай тайлан бичих, гал унтраах тоног төхөөрөмжийг арчлан хамгаалах,
- ж) гар багаж, химийн бодис ашиглаж таримал ойг сэргээх, хогийн ургамал, бутыг хяналтанд авах,
- з) нөхөн сэргээх талбай дээгүүр төрөл бүрийн самнах буюу талбай янзлах тоног төхөөрөмжийг чирэх бульдозер, бусад хөдлөх механизмыг ажиллуулах, арчлах,
- и) үрийн боргоцой хураах, модыг илүүц зүйлээс салгаж цэвэрлэх, мод суулгах тойм судалгаанд туслалцаа үзүүлэх, цаашдын ажиллагаанд зориулж модонд тэмдэг тавих,
- к) ойн аж ахуйн арга ажиллагаанд бусад ажилтнуудыг, түүний дотор ой аж ахуйн туслах ажилтан, операторчийг сургах, хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Модны нүүрс шатаагч
- Гуалин бэлтгэгч
- Ойн аж ахуйн мэргэшсэн ажилтан
- Мод урсгагч
- Мод унагаагч
- Мод огтлогч хөрөөчин
- Модыг мөчирлөгч
- Огтолж бэлтгэсэн модыг цагаалагч,
- Цагаалах модыг оосорлогч
- Мод саалагч /хэмжигч/
- Модны давирхай гаргагч
- Мод боловсруулах тоног төхөөрөмжийн засварчин, тохиргоочин
- Модон эдлэлийн эд ангийн хэвчин
- Мод боловсруулах тоног төхөөрөмжин багаж ирлэгч
- Операторч, хавтан шахах төхөөрөмжийн
- Операторч, зүлгүүрийн төхөөрөмжийн
- Мод хатаалгын зуухны галч
- Чаананд мод чанагч
- Модон эдлэлийн эд ангийн гар засалчин

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 2132 Мод үржүүлэгч
- 3143 Ойн техникч

8341 Мод унагаах операторч  
9215 Ойн ажилтан

## **БАГА БҮЛЭГ 622**

### **ЗАГАСНЫ АЖ АХУЙН АЖИЛТАН, АНЧИН, УРХИЧИН**

---

Загасны аж ахуйн ажилтан, анчин, урхичин нь худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор загас үржүүлэх, өсгөх, хурааж авах, амьтан агнах, урхидах ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Бэлэн мөнгө болгох буюу цэвэр ус, давстай усанд буцааж тавих зорилгоор загас, дун, хясаа, усны бусад амьтдыг үржүүлэх, өсгөх, усны ургамал, амьтны зохистой нөхцөл байдлыг хангахын тулд орчны хяналт шинжилгээ хийх, барьсан загасыг усан дээр эсвэл эрэг дээр цэвэрлэх, царцаах, мөстүүлэх, давслах, загас болон бусад бүтээгдэхүүнийг ачиж тээвэрлэхэд бэлтгэх, барилга, цистерн, машин, загасчлах онгоц, бусад тоног төхөөрөмжийг түрээслэх, хөрөнгө оруулах, арчлах, тор болон загасны бусад хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, засах, загасчлах онгоцыг жолоодох, ажиллуулах, загасчлах хэрэгслийг өгөөшлөх, тавих, ажиллуулах, засах, сүүн тэжээлтэн, шувуу эсвэл мөлхөгч амьтан барихын тулд урхи тавих, бүтээгдэхүүн нийлүүлэх, зах зээлд гаргах, бусад ажилтнуудыг сургах, хяналт тавих.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6221 Усны ургамал, амьтны аж ахуйн ажилтан**

**6222 Газрын болон эргийн усны загасны аж ахуйн ажилтан**

**6223 Далайн загасны аж ахуйн ажилтан**

**6224 Анчин, урхичин**

#### **6221 УСНЫ УРГАМАЛ УРГУУЛАГЧ, АМЬТАН ҮРЖҮҮЛЭГЧ**

Усны ургамал ургуулагч, загасны аж ахуйн ажилтан нь худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор загас, дун, усны бусад амьтан, ургамлыг, ургуулах, өсгөх ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бэлэн мөнгө болгох буюу цэвэр болон давстай усанд буцааж тавих зорилгоор загас, дун, хясаа, усны бусад амьтныг үржүүлэх, өсгөх,
- б) өсөлт, үйлдвэрлэл, орчны мэдээлэл, тоо баримтыг цуглуулах, бүртгэх,
- в) өвчин илрүүлэх буюу шимэгч хорхойг тодорхойлохын тулд хураасан бүтээгдэхүүнд үзлэг шалгалт хийх, хяналт тавих,
- г) усны амьтан, ургамлын амьдралын зохистой нөхцөлийг хангахын тулд орчны хяналт, шинжилгээ хийх,
- д) загас урхидах, түрслүүлэх, өндөг дарах зэргийг хянаж байх, чиглүүлэх, жижиг загас өсгөх болон загас үржүүлэх арга техник, менежментийн ухаан хэрэглэх,
- е) барьсан загасыг усан дээр эсвэл эрэг дээр цэвэрлэх, царцаах, мөстүүлэх, давслах, загас болон бусад бүтээгдэхүүнийг ачиж тээвэрлэхэд бэлтгэх,
- ж) барилга, цистерн, машин, завь, бусад тоног төхөөрөмжийг арчлах,
- з) бүтээгдэхүүн нийлүүлэх, зах зээлд гаргах,
- и) барилга, тоног төхөөрөмж, машин түрээслэх, хөрөнгө оруулах, хүнс болон бусад материал худалдан авах,
- к) усны ургамал, амьтны аж ахуй, загас үржүүлэх аж ахуйн туслах ажилтныг сургах, хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Замаг ургуулагч
- Загасны фермч
- Загасны фермийн мэргэжилтэй ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 1312 | Усны ургамал ургуулагч, засасны аж ахуйн үйлдвэрлэлийн менежер |
| 9216 | Усны амьтан, ургамлын аж ахуйн ажилтан                         |

**6222 ГАЗРЫН БОЛОН ЭРГИЙН УСНЫ ЗАГАСНЫ АЖ АХУЙН АЖИЛТАН**

Газрын болон эргийн усны загасны аж ахуйн ажилтан нь дангаараа эсвэл загас агнуурын онгоцны багийн гишүүн болж худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах дээр тогтмол зарж борлуулах буюу нийлүүлэх зорилгоор газрын буюу эргийн усанд загас барих, бусад хэлбэрийн усны амьтан, ургамал түүх ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тор, загасны бусад хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, засах,
- б) загасчлах газрыг сонгох, замын зураг гаргах, луужин, газрын зураг, бусад туслах материал ашиглан усаар зорчих байршлуудыг тооцоолох,
- в) загасчлах газарт очих, тэндээс буцахад болон уг газарт загас агнуурын онгоц ажиллуулах,
- г) гараар буюу тусгай тоног төхөөрөмж ашиглан загасчлах хэрэгслийг өгөөшлөх, тавих, ажиллуулах, засах,
- д) төрөл бүрийн усны амьтан буюу ургамлыг эргээс болон гүехэн уснаас түүх,
- е) загас агнуурын хөдөлгүүрт хэрэгсэл, усан онгоцон дээрх бусад тоног төхөөрөмжийг арчлах,
- ж) санхүүгийн гүйлгээ, загас агнуурын үйл ажиллагаа, цаг уур болон далайн нөхцлийн талаар бүртгэл хөтлөх, өртөг зардал болон төсвийг тооцоолох,
- з) барьсан загасыг ангилан ялгах, давс, мөсөнд хийж хадгалах,
- и) барьсан загасыг агнуурын тоног төхөөрөмжөөс салгах, зөвшөөрөгдсөн хэмжээг баримтлахын тулд хэмжих, хэрэггүй буюу хуулинд таарахгүй загасыг усанд буцааж тавих,
- к) загас агнуурын ажиллагааг удирдан чиглүүлэх, агнуурын багийн гишүүдийн ажилд хяналт тавих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Эргийн загас агнуурын тор татагч
- Загасчин (эргийн усны)
- Загасчин (нуурын усны)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                    |
|------|------------------------------------|
| 1312 | Загас агнуурын ажиллагааны менежер |
| 9216 | Загас агнуурын ажилтан             |

**6224 АНЧИН, УРХИЧИН**

Анчин нь худалдан авагчид, маркетингийн байгууллагад буюу зах зээлд тогтмол зарж борлуулах, бэлтгэн нийлүүлэх зорилгоор мах, арьс, өд сөд, бусад бүтээгдэхүүнийг бэлтгэхийн тулд сүүн тэжээлтэн амьтан, шувуу, мөлхөгч амьтдыг барих, агнах ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сүүн тэжээлтэн болон шувуу, мөлхөгч амьтныг барихын тулд урхи тавих,

- б) сүүн тэжээлтэн амьтад, шувуу, мөлхөгч амьтныг галт зэвсэг буюу бусад зэвсгээр агнах,
- в) зарж борлуулах буюу нийлүүлэх бүтээгдэхүүн гаргаж авахын тулд агнасан сүүн тэжээлтэн амьтад, шувуу, мөлхөгч амьтныг өвчих, мах, арьс, үс, өд зэрэг бүтээгдэхүүнийг боловсруулах, янзлах,
- г) урхинд орсон амьд сүүн тэжээлтэн, шувуу, мөлхөгч амьтдыг ханган нийлүүлэх, зарж борлуулах,
- д) тоног төхөөрөмж засварлах.

**Энэ ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ан амьтны арьс, үс, мах зэрэг бүтээгдэхүүн борлуулагч

---

**ДЭД БҮЛЭГ 63**

**ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭТ АМЬ ЗУУЛГЫН ФЕРМЧ,  
ЗАГАСЧИН, АНЧИН, ТҮҮГЧ, ХУРААГЧ**

---

Өрхийн хэрэгцээний шинжтэй фермч, загасчин, анчин болон түүгч нь өөрийнхөө болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд тал хээрийн үр тариа, мод, бут, хүнсний ногоо, жимс ургуулж, хурааж авах, зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, амьтан маллах буюу агнах, загас барих ба төрөл бүрийн усны амьтан, ургамал түүнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хөрс бэлтгэх, үр суулгах, тал хээрийн үр тариа суулгах, арчлах, хурааж авах, хүнсний ногоо, жимс, бусад мод, бутны үр тарьж ургуулах, зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, мах, өндөг, сүү, үс, арьс, бусад бүтээгдэхүүн гаргаж авахын тулд амьтан, мал, шувуу үржүүлэх, арчлах, тэжээх, амьтан агнах, урхидах, загас барих ба усны амьтан, ургамал түүх, ус зөөх, түлээ түүх, бүтээгдэхүүн нөөж хадгалах, зарим боловсруулалт хийх, байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах, өрхөд хэрэглэхэд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх, орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах эсвэл бартерийн худалдаа хийх.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 631 Өрхийн хэрэгцээт үр тарианы фермч**
- 632 Өрхийн хэрэгцээт мал аж ахуйн фермч**
- 633 Өрхийн хэрэгцээт үр тариа, мал аж ахуйн холимог фермч**
- 634 Өрхийн хэрэгцээт загасчин, анчин, урхичин ба түүгч**

**БАГА БҮЛЭГ 631****ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭТ ҮР ТАРИАНЫ ФЕРМЧ**

---

Өрхийн хэрэгцээт үр тарианы фермч нь өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд тал хээрийн болон мод, бутны үр тариа, хүнсний ногоо, жимс ургуулж, хурааж авна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хөрс бэлтгэх, үр суулгах, тал хээрийн үр тариа суулгах, арчлах, хурааж авах, хүнсний ногоо, жимс, бусад мод, бутны үр тариа ургуулах, ус зөөх, түлээ түүх, бүтээгдэхүүн нөөж хадгалах, зарим боловсруулалт хийх, байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах, өрхөд хэрэглэхэд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх, орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

Энэхүү бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6310 Газар тариалангаар амь зуугч****6310 ГАЗАР ТАРИАЛАНГААР АМЬ ЗУУГЧ**

Амьжиргааныхаа хэрэгцээг хангагч үр тарианы фермч өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд тал хээрийн үр тариа, мод, бут, хүнсний ногоо, жимс ургуулж, хурааж авна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөрс бэлтгэх, үр суулгах, тал хээрийн үр тариа суулгах, арчлах, хурааж авах,
- б) хүнсний ногоо, жимс, бусад мод, бутны үр тарьж ургуулах,
- в) ус зөөх, түлээ түүх,
- г) бүтээгдэхүүн нөөж хадгалах, зарим боловсруулалт хийх,
- д) байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах,
- е) өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх,
- ж) орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

**Энэ бүлэгт хамаарах ажил, мэргэжлийн жишээ:**

- Өрхийн хэрэгцээт үр тарианы фермч



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

9211	Фермийн ажилтан
9624	Түлээ түүгч
9624	Ус зөөгч

**Тайлбар:**

Ус зөөх, түлээ түүх гол ажилтай өрхийн хэрэгцээний шинжтэй ажилтныг нэгж бүлэг 9624 буюу “Ус зөөгч, түлээ түүгч” гэсэн ангилалд, голдуу өөр хүний удирдлаган дор цөөн энгийн ба урсгал ажил хийдэг хөдөө аж ахуйн ажилтныг дэд бүлэг 92 буюу “Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн ажилтан” гэсэн бүлгийн холбогдох нэгж бүлэгт тус тус оруулна.

**БАГА БҮЛЭГ 632****ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭТ МАЛ АЖ АХУЙН ФЕРМЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй мал аж ахуйн фермч өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд мал маллаж, өсгөн үржүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Бэлчээр сайжруулах, мал идээшлэх газрыг зохицуулах, малд тохиромжтой нөхцөл байдлыг хангахад шаардагдах тэжээл, усан хангамжид хяналт тавих, өвчлөлт, гэмтэл, өвчин илрүүлэх, биеийн байдлыг нь шалгахын тулд малд үзлэг хийх, хяналт хийх, мал арчлах, тэмдэг тавих, үс, ноосыг нь авахаар хяргах, малыг бэлчээрт гаргах, идээшлүүлэх, услах, малыг өсгөх, арчлах, тэжээх, саах, цусыг нь авах, мал үржүүлэх, төллөхөд туслах, мал нядлах, өвчих, мал, түүний бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх буюу зарж борлуулахад бэлтгэх, малын бүтээгдэхүүнд зарим боловсруулалт хийх, байшин, бусад оромжийг барих, арчлах, өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх, ус зөөх, түлээ түүх, мал, зарим бүтээгдэхүүнийг худалдаж авах, бартерийн солилцоо хийх, зарж борлуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6320 Мал аж ахуйгаар амь зуугч****6320 МАЛ АЖ АХУЙГААР АМЬ ЗУУГЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй мал аж ахуйн фермч өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгө, орлогын наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд мал маллаж, өсгөн үржүүлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бэлчээр тордож сайжруулах, мал идээшлэх газрыг зохицуулах, малд тохиромжтой нөхцөл байдлыг хангахад шаардагдах тэжээл, усны хангамжид хяналт тавих,
- б) өвчлөлт, гэмтэл, өвчин илрүүлэх, биеийн байдлыг нь шалгахын тулд малд үзлэг хийх, хянаж байх,
- в) мал арчлах, тэмдэг тавих, үс, ноосыг нь авахаар хяргах,
- г) малыг бэлчээрт гаргах, идээшлүүлэх, услах,
- д) малыг өсгөх, арчлах, тэжээх, саах, цусыг нь авах,
- е) мал үржүүлэх, төллөх үеийн бэлтгэл хангах,
- ж) мал нядлах, өвчих, мал, түүний бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх буюу зарж борлуулахад бэлтгэх,
- з) малын бүтээгдэхүүнд зарим боловсруулалт хийх,
- и) байшин, бусад оромж барих, арчлах,
- к) өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх,
- л) ус зөөх, түлээ түүх,
- м) мал, зарим бүтээгдэхүүнийг худалдаж авах, бартерийн солилцоо хийх, зарж борлуулах,
- н) малын тэжээл бэтлгэх, тариалах.

**Энэ ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өрхийн хэрэгцээний шинжтэй үхрийн аж ахуйн фермер

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 9212 | Мал аж ахуйн фермийн ажилтан                   |
| 9213 | Үр тариа, мал аж ахуйн холимог фермийн ажилтан |
| 9624 | Ус зөөгч, түлээ түүгч                          |

**БАГА БҮЛЭГ 633****ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭТ ТАРИАЛАН, МАЛ АЖ АХУЙН  
ХОСОЛСОН ФЕРМЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй үр тариа, мал аж ахуйн холимог фермч нь өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд тал хээрийн үр тариа, мод, бут, хүнсний ногоо, жимс ургуулж, хурааж авах, зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, мал амьтан маллах буюу агнах, загас барих ба ургамал түүнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөрс бэлтгэх, үр суулгах, арчлах, хурааж авах,
- б) хүнсний ногоо, жимс, бусад мод, бут ургуулах,
- в) зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх,
- г) мах, өндөг, сүү, үс, арьс, бусад бүтээгдэхүүн гаргаж авахын тулд амьтан, мал, шувуу үржүүлэх, арчлах, тэжээх, маллах,
- д) ус зөөх, түлээ түүх,
- е) бүтээгдэхүүн нөөцлөн хадгалах, зарим боловсруулалт хийх,
- ж) байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах,
- з) өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх,
- и) орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6330 Тариалан , мал аж ахуй хослон эрхлэгч**

**6330 ТАРИАЛАН , МАЛ АЖ АХУЙ ХОСОЛСОН ФЕРМЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй үр тариа, мал аж ахуйн холимог фермч нь өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд тал хээрийн үр тариа, мод, бут, хүнсний ногоо, жимс ургуулж, хурааж авах, зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, амьтан маллах, арчлах буюу агнах, загас барих ба төрөл бүрийн усны амьтан үржүүлэх ба ургамал түүнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөрс бэлтгэх, үр суулгах, арчлах, хурааж авах,
- б) хүнсний ногоо, жимс, бусад мод, бут ургуулах,
- в) зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх,
- г) мах, өндөг, сүү, үс, арьс, бусад бүтээгдэхүүн гаргаж авахын тулд амьтан, мал, шувуу үржүүлэх, арчлах, тэжээх,
- д) ус зөөх, түлээ түүх,
- е) бүтээгдэхүүн нөөцлөн хадгалах, зарим боловсруулалт хийх,
- ж) байр, хашаа саравч барих, арчлан хамгаалах,
- з) өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх,
- и) орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

**БАГА БҮЛЭГ 634****ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭТ ЗАГАСЧИН, АНЧИН, УРХИЧИН, ТҮҮГЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй загасчин, анчин, урхичин, түүгч нь өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, амьтан агнах, урхидах, загас барих ба ургамал түүнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Зэрлэг жимс, үндэс, эмийн болон бусад ургамал түүх, мах, өндөг, сүү, үс, арьс, бусад бүтээгдэхүүн гаргаж авахын тулд амьтан агнах, урхидах, ус зөөх, түлээ түүх, загас барих ба усны амьтан, ургамал түүх, бүтээгдэхүүн нөөж хадгалах буюу зарим боловсруулалт хийх, байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах, өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх, орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**6340 Загасчин, анчин, урхичин, түүгч****6340 ЗАГАСЧИН, АНЧИН, УРХИЧИН, ТҮҮГЧ**

Өрхийн хэрэгцээний шинжтэй загасчин, анчин, урхичин, түүгч нь өөрийн болон гэр бүлийнхээ хоол хүнс, орон байр, бэлэн мөнгөний наад захын хэрэгцээг хангах, орлого олохын тулд зэрлэг жимс, эмийн болон бусад ургамал түүх, амьтан агнах, урхидах, загас барих ба ургамал түүнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зэрлэг жимс, үндэс, эмийн болон бусад ургамал түүх,
- б) мах, өндөг, сүү, үс, арьс, бусад бүтээгдэхүүн гаргаж авахын тулд амьтан агнах, урхидах,
- в) ус зөөх, түлээ түүх,
- г) загас барих ба ургамал түүх,
- д) бүтээгдэхүүн нөөж хадгалах буюу зарим боловсруулалт хийх,
- е) байшин, бусад оромж барих, арчлан хамгаалах,
- ж) өрхийн хэрэгцээнд зориулж багаж хэрэгсэл, хувцас, сав суулга хийх,
- з) орон нутгийн зах дээр зарим бүтээгдэхүүн зарж борлуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Анчин-түүгч
- Өрхийн хэрэгцээний шинжтэй түүгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 6310 | Өрхийн хэрэгцээний шинжтэй үр тарианы фермч   |
| 6320 | Өрхийн хэрэгцээний шинжтэй мал аж ахуйн фермч |
| 9212 | Мал аж ахуйн фермч                            |
| 9624 | Ус зөөгч, түлээ түүгч                         |

## ҮНДСЭН БҮЛЭГ 7

# ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА, ГАР УРЛАЛ, ХОЛБОГДОХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

---

Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх салбарт мэдлэг, ур чадвараа хэрэглэнэ.

Ажлыг гараар болон ажилд шаардагдах биеийн хүч, цаг хугацааг багасгах, түүнчлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зориулалттай гар багаж, бусад хэрэгслийг ашиглаж хийнэ. Ажлыг гүйцэтгэхэд үйлдвэрлэлийн процессийн бүх үе шат, хэрэглэгддэг материал, багаж хэрэгслүүд, эцсийн бүтээгдэхүүний мөн чанар, зориулалтыг мэдэж байх шаардлагатай. Энэ үндсэн бүлгийн ихэнх ажил мэргэжил нь Олон улсын ажил, мэргэжилийн стандарт (ISCO)-ын мэргэшлийн 2 дахь түвшний ур чадварыг шаардана.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Барилга барих, бусад бүтээц хийх, засварлах, үйлчилгээ хийх, металл цутгах, гагнах, хэлбэр оруулах, хүнд жинтэй металл бүтцийг суурилуулах, босгох, холбогдох тоног төхөөрөмжийг ажиллуулах, машин механизм, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад металл эд зүйлийг хийх, төрөл бүрийн машин, багаж хэрэгслийг тохируулах, ажиллуулах, операторт тохируулж өгөх, үйлдвэрийн машин, механизм, түүний дотор хөдөлгүүр, автомашин, цахилгаан болон цахим багаж хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийг тохируулах, засварлах, үйлчилгээ хийх, нарийн багаж хэрэгсэл, үнэт эдлэл, гэр ахуйн болон бусад үнэт металл эд зүйл, шавар, шилэн ба бусад эдлэл хийх, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэвлэлийн ажил гүйцэтгэх, хүнсний бүтээгдэхүүн, төрөл бүрийн мод, нэхмэл, арьс, бусад материалаар хийсэн эдлэл үйлдвэрлэх. Бусад ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг энд оруулж болно.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 71 Барилга, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан (цахилгаанчныг оруулахгүй)
- 72 Металл, машин, механизм, түүнтэй холбогдох бусад мэргэжлийн ажилтан
- 73 Гар урлал, хэвлэлийн ажилтан
- 74 Цахилгаан болон цахим техникч
- 75 Хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч

---

## ДЭД БҮЛЭГ 71

### **БАРИЛГА, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ БУСАД МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН (ЦАХИЛГААНЧИН ОРОХГҮЙ)**

---

Барилга, холбогдох бусад мэргэжлийн ажилтан нь барилга угсралт, барилгын ашиглалт ба засварыг гүйцэтгэх, тоосго, чулуу түүнтэй ижил, төстэй материалаар барилгын суурь, хана, бусад бүтээцийг барих, засварлах, барилгын болон бусад зориулалтаар чулууг засч өнгөлөн хэлбэржүүлэх, уурхай болон карьераас хатуу эрдэс түүхий эдийг олзворлох, боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

Ажлыг гараар, гар багажаар гүйцэтгэх болон биеийн хүчний ажлын хэмжээг багасгах, хугацааг хэмнэж, улмаар ажлын чанарыг сайжруулахад анхаарна. Ажлыг гүйцэтгэхийн тулд ажлын зохион байгуулалт, хэрэглэгдэх материал, багаж хэрэгсэл, эцсийн бүтээгдэхүүний мөн чанарын талаар мэдлэг олж авсан байвал зохино.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Уламжлалт болон орчин үеийн арга технологиор барилга ба бүтээцийг барих, засварлах, тоосго, чулуу, ижил, төстэй материалаар барилгын суурь, хана, бусад бүтээцийг угсрах, засварлах, олзворлосон карьерийн чулууг хэлбэрлэн бутлах, барилгын, чимэглэлийн, хөшөө, баримал бусад зориулалтаар чулууг зүсэх, өнгөлж хэлбэржүүлэх, төмөр бетон рам ба бүтээцийг угсрах, бетон гадаргууг засварлах, өнгөлөх, модон бүтээц, тоноглолыг эсгэх, угсрах, төрөл бүрийн барилгын угсралт, барилгын ашиглалтын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 711 Барилгын араг бүтээц угсрагч, түүнтэй адилтгах бусад ажилтан
- 712 Барилгын засалчин, түүнтэй адилтгах бусад ажилтан
- 713 Будагчин, барилгын бүтээц цэвэрлэгч, түүнтэй адилтгах бусад ажилтан

## БАГА БҮЛЭГ 711

### БАРИЛГЫН АРАГ БҮТЭЭЦ УГСРАГЧ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН

---

Барилгын араг бүтээц усрагч, холбогдох ажилтан нь барилга угсралт, барилгын ашиглалт, засвар, тоосго, чулуу болон ижил төстэй материалаар барилгын суурь, хана болон бусад бүтээцийг угсрах, засварлах, барилгын болон бусад зориулалтаар чулууг засч өнгөлж, хэлбэржүүлэх, бусад төрөл бүрийн барилга угсралт, барилгын ашиглалттай холбоотой ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

Уламжлалт эсхүл орчин үеийн арга технологиор барилга, араг бүтээцийг барих, засварлах, тоосго, чулуу болон ижил төстэй материалаар барилгын суурь, хана болон бусад бүтээцийг угсрах, засварлах, олзворлосон карьерийн чулууг хавтан, блок болгон бутлах, барилгын, чимэглэлийн, хөшөө баримал болон бусад зориулалтаар чулууг зүсэх, өнгөлж хэлбэржүүлэх, төмөр бетон рам, бүтээцийг угсрах, бетон гадаргууг засварлах, өнгөлөх, модон бүтээц, тоноглолыг эсгэх, угсрах, арчилах, төрөл бүрийн барилга угсралт, барилгын ашиглалтын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

- 7111 Барилгачин
- 7112 Өрөгч, угсрагч, түүнтэй адилтгах бусад ажилтан
- 7113 Чулуу өрөгч, чулуу зүсэгч, хагалагч, сийлбэрч
- 7114 Бетончин, бетон гадаргуу өнгөлөгч, түүнтэй адилтгах бусад ажилтан
- 7115 Барилга угсралтын мужаан
- 7119 Барилгын араг бүтээц угсрагч, түүнтэй адилтгах бусад ажилтан



## 7111 БАРИЛГАЧИН

Барилгачин нь орон сууц барих, арчлах, засварлах болон ижил төстэй жижиг барилгуудыг уламжлалт болон орчин үеийн арга технологи, материалаар барина.

Барилгын бүх төрлийн угсармал болон цутгамал төмөр бетон бүтээцийн ажлыг гүйцэтгэх мэргэшил эзэмшсэн байна.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) барилга ба байгууламжийг барих газрыг бэлтгэх,
- б) арматурыг тээвэрлэх, ачиж буулгах, хураах, арматур бэлдэх (нугалах, таслах, сунгах), арматурыг зургийн дагуу угсрах, боох, гагнах, дээврийн бүтээц хүртэлх араг бүтээцийг угсрах, тохирох материалаар ханыг угсрах,
- в) бетон хольц бэлдэх, зуурах, бетон цутгах, чигжиж нягтруулах, тэгшлэх, услах, арчиж хамгаалах,
- г) өвлийн нөхцөлд бетоныг цахилгаанаар халаах, химийн нэмэлт бетон хольцонд хийх, бетоноос сорьц авч чанарыг шалгахад бэлтгэх
- д) өндөр болон олон давхар барилгын төмөр бетон бүтээц цутгах, арматур бэлдэх, угсрах,
- е) шувуу нурууг босгох, дээврийн хашлага бүтээцийг угсрах,
- ж) шалыг тэгшлэх, засвар үйлчилгээ авахуйц байлгах,
- з) одоо байгаа бүтээцийг арчилж, засварлах,
- и) өрөг, будаг, сантехник, цахилгааны ажлуудыг зохион байгуулж хийлгэх,
- к) холбогдох ажлыг гүйцэтгэнэ,
- л) туслан гүйцэтгэгч, гэрээт ажилтан болон бусад ажилтны ажлыг зохицуулан хяналт тавих.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Барилгачин, үйлдвэрийн
- Барилгачин, иргэний барилга инженерийн

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                           |
|------|---------------------------|
| 1323 | Барилга угсралтын менежер |
| 3123 | Барилгын хянагч           |

## 7112 ӨРӨГЧ, УГСРАГЧ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН

Өрөгч, угсрагч, холбогдох бусад ажилтан нь тоосго, урьдчилан зүсч бэлтгэсэн чулуу, бусад төрлийн барилгын гулдмайгаар өргийн зуурмаг

ашиглан хана, хамар хана болон бусад бүтээцийг өрөх, угсрах, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

Барилгын даацын болон даацын бус тоосго, төрөл бүрийн гулдмайн өргийн ажил гүйцэтгэх мэргэшил эзэмшсэн байна.

Түүнчлэн бетон-арматурчин, өрөгч, угсрагч мэргэжлийн ажилтан нь барилгын суурь болон сувгийн газар ухах, нягтруулах, тэгшлэх, суурийн хажуугаар шороо хийж чигжих, хөрсний ус зайлуулах, хөрсийг хөлдөлтөөс хамгаалах, хөрс солих, хөрсийг нуралтаас хамгаалах, хөрсийг зохиомол аргаар бэхжүүлэх ажлуудыг гүйцэтгэх мэргэшсэн байна.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) чулуу, тоосго, бусад ижил төстэй барилгын гулдмайгаар хана, хамар хана, пийшин, яндан, камин зуух, зуухны хөндий, утааны яндан, шарах, хатаах камер, уурын зуух, гүүрийн тулгуур, тулаасыг өрөх,
- б) өнгөлгөөтэй өрөг өрөх, төрөл бүрийн системээр тоосгон хана өрөх, янз бүрийн гулдмайгаар (блок) хана өрөх, ханын өрөг арматурчлах
- в) гадна хананд дулаалга хийх, дулаалга бүхий олон үет гадна хана арматурчилж өрөх, дуу тусгаарлах үе бүхий дотор хана өрөх
- г) төрөл бүрийн ялуу угсрах, суурийн болон ханын гулдмай (блок) угсрах, тагт болон саравчны хавтан угсрах
- д) хучилтын хавтан угсрах, бэхлэх, төмөр бетон татанги (ферм), дам нуруу, багана угсрах, бэхлэх
- е) явган зам, замын хашлага, болон явган замын хучилгыг тавих,
- ж) сүүдрэвч, цэцэрлэгийн хана бусад чимэглэлийн зориулалттай өргийг өрөх.
- з) зуурмаг зуурч бэлтгэх
- и) бүс болон зүрхэвч бетон цутгах
- к) угсармал хучилтын завсрыг арматурчилж бетоноор чигжих
- л) угсармал төмөр бетон, бүтээц эдэлхүүн тээвэрлэх, ачиж буулгах, хураах
- м) ган бүтээц угсралтанд бэлтгэх, угсрах, тээвэрлэх, өргөх буулгах, хураах
- н) өндөр болон олон давхар барилгын угсралтын ажил гүйцэтгэх
- о) дулаалгатай худагт өрлөг өрөх

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- өрөгч, угсрагч
- гулдмай угсрагч,
- галд тэсвэртэй өрөг гүйцэтгэгч
- пийшин ба яндан өрөгч,

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7113 Чулуучин

### **7113 ЧУЛУУЧИН, ЧУЛУУ ЗҮСЭГЧ, БУТЛАГЧ, СИЙЛБЭРЧИН**

Чулуучин, чулуу зүсэгч, бутлагч, сийлбэрчин нь хатуу болон зөөлөн чулуун гулдмайг зүсч, хэлбэржүүлэн өнгөлөхөөс гадна барилгын чулуун бүтээц, чимэглэлийн өрөгийг гүйцэтгэх, арчилах ба чулуун дээрх сийлбэрийн загварыг гарган, гүйцэтгэх ажлыг хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) карьерийн олзворлосон чулууг шаантаглан хагалж хавтгай, талст хэлбэрт оруулах,
- б) боржин, гантиг болон бусад төрлийн хагалагдсан чулууг ангилах,
- в) барилга болон чимэглэлийн зориулалтаар боржин, гантиг чулууг гараар эсхүл гар багажаар зүсэх, хэлбэржүүлэх, өнгөлөх,
- г) чулууг хөрөөдөх, хавтгайлах, өрөмдөх, чимэглэх болон бусад аргаар хэлбэр гаргах, хүрээлэх,
- д) чимэглэл, хөшөө дурсгалын зориулалтаар чулуун гулдмай дээр хэлбэр, дүрс, биет үүсгэн сийлэх, зүсэх,
- е) хөшөө дурсгал, сүм хийд, хуучин барилгын чулууны ажлыг гүйцэтгэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- чулуун сийлбэрчин
- чулуу зүсэгч,
- боржин зүсэгч,

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7122 шалчин, өнгөлгөөний хавтан наагч
- 8112 төхөөргийн операторч (хэрчигч, зүсэгч)

### **7114 БЕТОНЧИН, БЕТОН ГАДАРГУУ ӨНГӨЛӨГЧ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

Бетончин, бетон гадаргуу өнгөлөгч, түүнтэй адилтгах бусад ажилтан нь төмөр бетон араг бүтээцийг цутгах, угсрах, хэв барих, бетон гадаргууг өнгөлөх, хана болон худгийн ханын нээлхийг бетондох, бетон гадаргууг засах, өнгөлөх, шал цутгах, торкрет бетоны ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) төмөр бетон шал, хана, резервуар, силос болон бусад бетон бүтээцийг цутгах, засварлах,
- б) бетон цутгахад зориулан бэлтгэсэн хэвийг угсрах, задлах,
- в) ханын болон худгийн ханын нээлхийг бетондох,

- г) бетон бүтээцийн гадаргууг өнгөлөх, гөлийлгөх,
- д) торкрет өнгөлгөө, элс, гантигийн үйрмэгэн хольцтой цутгамал шал хийх, толийлгох зэргээр эдэлгээний хугацааг уртасгах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цементэн гадаргуу өнгөлөгч,
- бетончин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8114 бетон өнгөлөгч машины операторч
- 8342 зам засварын машины операторч

**7115 БАРИЛГА УГСРАЛТЫН МУЖААН**

Барилга угсралтын мужаан нь төрөл бүрийн модон болон бусад материалаар бүтээц, эдлэхүүн түүний тоноглол, эд ангийг эсгэж, угсрах ба засварлана.

Барилга угсралтын мужаан нь барилгын үндсэн ажилд хамаарагдах даацын болон даацын бус модон бүтээц, эдлэхүүнийг хийх мэргэжилтэй байна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цутгамал төмөр бетон барилгын том самбарт хэв хашмал угсрах, задлах, каркасан ба цутгамал төмөр бетон барилгын жижиг самбарт хэв хашмал угсрах, задлах, модон бүтээц болон модны бусад ажлыг гүйцэтгэх, өөрчлөх, засах ажлыг барилгын талбайд болон цехэд гүйцэтгэх,
- б) цом хэв угсрах ба ашиглах, өндөр болон олон давхар барилгын хэв хашмал угсрах задлах,
- в) барилгын талбайд том овор бүхий модон бүтээцийг хийж угсрах, суурилуулах, барьж босгох, модон шувуун нуруу эсгэх, бэлдэх, угсрах, дүнзийг олон хувилбараар эсгэж, бэлдэх, төрөл бүрийн дизайнаар дүнзэн барилга барих, цоож, хаалга цонхны хэрэглэл суулгах, цонхны тавиур суулгах, шалны хөвөө, хаалганы янз угсрах,
- г) төрөл бүрийн хэлбэртэй эдэлхүүнээр дүүжин таазын жааз (рам) зангидаж төслийн түвшинд дүүжин тааз угсрах, жааз (рам) зангидаж ханын доторлогоо болон хамар ханыг гипс болон бусад төрлийн материалаар хийх,
- д) гадна талын заслал хийхэд зориулсан шат угсрах, буулгах, шатны бариул бэлдэх, угсрах, өнгөлөх, ажлын түр шат модоор хийх, төрөл бүрийн тууш модыг зүсэж бэлдэх,

- е) модон материал, бүтээцийг үжил болон галаас хамгаалах уусмалаар нэвчлэг хийх,
- ж) барилгын гадна болон дотор хана, хаалга, хаалга ба цонхны хүрээ, нүүр, хаалтыг хийх, угсрах, тохируулах, өөрчлөх,
- з) театр, кино, телевизийн тайзны тоног төхөөрөмжийг угсрах, тохируулах, өөрчлөх,
- и) галт тэрэг, нисэх онгоц, хөлөг онгоц, завь, хөвүүр, бусад тээврийн хэрэгслийн модон тоноглолуудыг хийх, угсрах, өөрчлөх, засварлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- барилга угсралтын мужаан
- өнгөлгөөний мужаан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7522 Нарийн мужаан
- 7522 Мод боловсруулагч

**7119 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ БАРИЛГЫН АРАГ БҮТЭЭЦ, ЯС  
МОД УГСРАГЧ, ТҮҮНД АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

Бага бүлэг 711 буюу “Барилгын араг бүтээц угсрагч, түүнд адилтгах бусад ажилтан” гэсэн ангилалд ороогүй ч араг бүтээц барихад хамтрах ажилтныг мэргэжлийн энэ ангилалд хамруулна. Тухайлбал энэ бүлэгт барилга байгууламжийг буулгах ажилтан, өндөрт угсрагч, шат вандан засагч зэрэг мэргэжлийн ажилтан багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цамхаг, яндан, барилгын шовх орой зэрэг өндөр барилга байгууламжид авиран төрөл бүрийн барилгын ажлыг гүйцэтгэх, арчлах, засварлах,
- б) барилгын талбайд түр байрлах металл эсхүл модон шат, вандан угсрах,
- в) барилга болон бусад байгууламжийг буулгах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- шат, вандан засагч
- өндөрт угсрагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 9313 Барилгын ажилтан
- 9313 Барилга, байгууламж буулгах ажилтан

## **БАГА БҮЛЭГ 712 БАРИЛГЫН ЗАСАЛЧИН, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

---

Барилгын засалчин, түүнтэй адилтгах бусад ажилтан нь барилгын дээвэр, шал, хана, дулаалгын систем, сантехникийн, шугам сүлжээний ажил, цахилгааны монтажийг өнгөлөн бүрэх, хучих, угсрах, арчлах, засварлах, цонх болон бусад хүрээг шиллэх ажлыг гүйцэтгэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Дээврийн араг бүтээц, яс модыг нэгэн төрлийн эсхүл олон төрлийн материалаар хучих, паркет болон бусад төрлийн шалны материалаар шаллах, шал, ханыг керамик, мозайкан хавтанцараар өнгөлөх, хана ба таазыг шавардах, хана, шал, таазанд дулаалгын үеийг хийх, цонх түүнтэй ижил төстэй нүх нээлхийг шиллэх, тааруулах, угсрах, сантехник, шугам хоолойн системийг угсрах, цахилгааны гэрэлтүүлгийн утсыг холбогдох тоног төхөөрөмжийн хамт угсрах. Бусад ажилтныг удирдах ажил хамаарч болно.

Энд ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7121 дээвэрчин**

**7122 шалчин, өнгөлгөөний хавтан наагч**

**7123 шаварчин**

**7124 тусгаарлагч**

**7125 шилчин/шиллэгч**

**7126 сантехникч, хоолой угсрагч**

**7127 агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч**

### **7121 ДЭЭВЭРЧИН**

Бүх төрлийн барилгын дээврийг нэг болон түүнээс олон төрлийн материалаар хийх, засварлах ажлыг гүйцэтгэнэ. Төрөл бүрийн хуулимал материалаар дээврийн хучлага хийх мэргэшил эзэмшсэн байна.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) ажлын зураг, тодорхойлолтыг судлах, барилгын талбайтай танилцан шаардлагатай материалыг тогтоох,
- б) шувуу нуруутай дээврийн араг бүтээц (яс мод)-ийг занар хавтанцараар болон угсармал хавтанцараар хучих,

- в) барилгын үндсэн араг бүтээц (яс мод)-ийг усанд тэсвэртэй металл болон синтетик материалаар ус тусгаарлах өнгө тавих,
- г) дээврийн өнцөг булан, яндан зэрэг нэмэлт, тоног хэрэгслийг тооцон орох материалыг хэмжиж, эсгэх,
- д) дээврийн өнгөн үед байгалийн гаралтай материалаар буюу зэгс, сүрлийг хэрэглэх,
- е) түр шат, ванданг засах.
- ж) хучилтан дээр уур тусгаарлагч хийх, дээврийн дулаалга хийх
- з) дээврийн тэгшилгээ бетон хийх, ердийн рубройдоор дээврийн хучлага хийх
- и) битум-полимероор дээврийн хучлага хийх
- к) дээврийн дагалдах эд анги, гөлмөн төмрөөр эдлэл хийж угсрах

**Энэ ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дээвэрчин, асфальт
- Дээвэрчин, металл
- Дээвэрчин, занар (шифер)
- Дээвэрчин, хавтан (плита)
- Дээвэр засагч
- Зэгс, сүрэл бэлтгэгч

**7122 ШАЛЧИН, ӨНГӨЛГӨӨЧИН**

Шалчин, өнгөлгөөчин, хавтан наагч нь шалыг угсрах, арчлах, засварлах, шал, хана болон бусад гадаргууг керамик, байгалийн болон хиймэл чулуун хавтангаар гоёлын болон өөр зориулалтаар өнгөлөн бүрэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) янз бүрийн материалаар шалыг хучиж бүрэхийн тулд гадаргууг бэлтгэх,
- б) зураг төсөл, нормын дагуу хивсэнцэр, керамик хавтанцар, болон бусад материалыг шаланд угсрах,
- в) гоёлын эсхүл бусад зориулалтаар тухайлбал дуу чимээ тусгаарлах зориулалтаар хавтанцар болон бусад материалаар өнгөлөхөд ханыг бэлтгэх,
- г) мозайкан хавтангаар хана, шал болон бусад бүтээцэд угсрах.
- д) хиймэл чулуун хавтангаар барилгын гадна, дотор талд өнгөлгөө хийх
- е) байгалийн чулуугаар хана өнгөлөх, шал хийх
- ж) байгалийн чулууг зүсэх, бэлдэх, өнгөлөх

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- паркетчин
- гантиг суулгагч
- байгалийн болон хиймэл чулуун хавтан суулгагч
- хивсэнцэр наагч

**7123 ШАВАРЧИН, ЗАСАЛЧИН**

Шаварчин, засалчин нь барилгад хуурай өнгөлгөөний хуудас ба хавтанцаруудыг угсрах, арчлах, засварлах, гоёлын болон хамгаалалтын зориулалтаар шавардлага, цемент, ижил төстэй материалаар барилгын гадна болон дотор талд шавардлагын ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилгын дотор хана, таазыг нэг болон түүнээс олон үеэр шавардан эцсийн өнгөлсөн гадаргууг бэлэн болгох,
- б) чимэглэлийн хуурай хавтангуудыг хэмжих, тэмдэглэх, угсрах болон чимэглэлийн хуурай шавардалгын хүрээг цутган, зүсч бэлтгэх,
- в) барилгын гадна хананд хамгаалалтын болон чимэглэлийн өнгөлгөөг цемент, гипс, бусад төстэй материалаар хийх,
- г) асбестцементэн (шөрмөсөн) шавардлагын хавтангуудыг хийх, угсрах,
- д) гадна болон дотор хананд шавардлага хийх, тааз шавардах
- е) амалгаа шавардлага хийх (багана, дам нуруу, хаалга цонхны амалгаа), хана таазанд замаск хийх, хана таазанд тосон будаг хийх
- ж) эмульс болон тусгай зориулалтын будгаар хана тааз будах, хана цааслах, хана торгоор өнгөлөх, хананд плита наах
- з) Төрөл бүрийн дизайнтай чулуутай болон хуурай шавардлага хийх
- и) Хулдаасан шал наах, плитагаар шал хийх
- к) Хүчилд тэсвэртэй плитагаар шал хийх, хана өнгөлөх
- л) Гоёлын шавардлага, будаг хийх
- м) Шавардлагын зуурмаг бэлтгэх

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- шаварчин, засалчин
- шаварчин-засалчин, засал, чимэглэлийн
- шаварчин, гадна
- шаварчин, шөрмөсөн
- шаварчин, чанаржуулсан



### 7124 ТУСГААРЛАГЧ

Тусгаарлагч нь барилга, бойлер, шугам хоолой, хөргөх ба агааржуулах тоног төхөөрөмжийн тусгаарлалтын ажлыг гүйцэтгэх, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) Тусгаарлах материалыг шаардлагатай хэмжээ, хэлбэрээр эсгэх,
- б) Тусгаарлах болон дуу чимээг шингээх материалыг барилгын хана, шал, таазанд хийх,
- в) Тусгаарлах болон дуу чимээг шингээх материалыг барилгын хана, шалны зай завсар хөндий, хучилтын хөндийд цахилгаан техник хэрэгслээр үлээлгэх, хийх,
- г) Шаардлагатай тусгаарлах материалын төрөл, чанар, хэмжээг тогтоохын тулд төлөвлөгөө, байгууламж, стандарт шаардлагыг судлах,
- д) Бойлер, шугам хоолой, резервуарын ил гадаргууг тусгаарлах,
- е) Хөргөх болон агааржуулалтын тоног төхөөрөмжийг тусгаарлах,

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- тусгаарлагч
- дуу чимээ тусгаарлагч
- бойлер, шугам хоолой тусгаарлагч
- хөргөх болон агааржуулах тоног төхөөрөмж тусгаарлагч
- угсрагч тусгаарлагч

### 7125 ШИЛЧИН, ШИЛЛЭГЧ

Шилчин, шиллэгч нь хавтгай шил болон толийг хэмжих, зүсэх, тааруулах, угсрах ажлыг гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) Хэрэглэгдэх шилний төрлийг сонгох, хэмжээ, хэлбэрийг зөв гарган зүсэх, барилгын цонх, хаалга, шүршүүр, хамар хананд угсрах,
- б) Тотго, дотор хана, тааз, шилэн хорго зэргийг шиллэх, толь угсрах,
- в) Усан онгоц, тээврийн хэрэгслийн урд шилийг угсрах, солих,
- г) Шилээр хана, шат, хашлагыг хийх, гоёж чимэглэх, цонхыг өнгөт шилээр шиллэх,

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- шилчин
- шиллэгч
- дээвэр шиллэгч
- тээврийн хэрэгсэл шиллэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |              |
|------|--------------|
| 7315 | шил зүсэгч   |
| 7315 | шил өнгөлөгч |

**7126 САНТЕХНИКЧ, ХООЛОЙ УГСРАГЧ**

Сантехникч, хоолой угсрагч нь ус, хий, бохирын болон ус зайлуулах шугам хоолой, холбогдох хэрэгсэл, усан болон хийн хөдөлгүүр зэрэг тоног төхөөрөмжүүдийг угсрах, суурилуулах, засварлах, арчлах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) халаалт, цэвэр, бохир усны системийн хоолой, дагалдах хэрэгслүүдийг хэмжих, тайрах, матах, нугалах, холбох, угсрах, суурилуулах, арчлах, засварлах,
- б) сантехникийн эдлэл, хэсгийг угсралтанд бэлтгэх
- в) гар багаж ашиглан хий дамжуулах, аяга таваг, сав угаах, ус халаах хэрэгсэл, усны тосгуур, угаалтуур, суултуурыг угсрах,
- г) барилгын дотор, гадна талд сантехникийн шугам хоолойн угсралт хийх, сантехникийн хэрэгсэл угсрах
- д) дулаан, цэвэр усны шугамыг ус болон хийгээр шалгах, дулааны төрөл бүрийн узель, воллер дулааны станц бэлдэх, угсрах, турших
- е) сантехникийн гадна шугамыг дулаалах, сувгийн хана таг, худаг угсрах
- ж) орчин үеийн нийлэг болон хуванцар яндан хоолойг угсрах, наах, түүнд хэрэглэх жийргэвч цавуу, багаж хэрэгслэлийг эзэмшиж, ажиллуулах
- з) шалан дор халаалт болон цэвэр усны системийг угсрах орчин үеийн арга хэрэглэн угсрах
- и) бохирын болон ус зайлуулах, ус хангамжийн төв шугам, бусад зориулалтаар ухсан шуудуунд шавар, бетон, ширэмэн хоолойг угсрах,
- к) угсарсан шугам хоолойг шалгаж, турших зорилгоор даралт хэмжигч, гидростатик тест, ажиглалтын арга болон бусад аргыг хэрэглэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- салхивчийн хоолой угсрагч
- хоолойн засварчин
- сантехникч, хоолой угсрагч
- ус зайлуулах шугам хоолойн техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 7127 | Агааржуулалтын болон агаар сэлгэлтийн механикч |
|------|--|

## 7127 АГААРЖУУЛАЛТ, АГААР СЭЛГЭЛТИЙН МЕХАНИКЧ

Агааржуулалт, агаар сэлгэлтийн механикч нь агааржуулалтын болон агаар сэлгэлтийн систем, түүний тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, арчлах, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) ажлын зураг, тодорхойлолтуудын нэр ба нэгж үзүүлэлтүүдийг судлах,
- б) агааржуулалтын болон агаар сэлгэлтийн системийн бүрдэл хэсгүүдийг угсрах, суурилуулах, засварлах,
- в) тоног төхөөрөмж ба хоолойг боолт, хадаас, гагнуур, ширээх зэргээр холбох,
- г) согог гэмтлийг оношлох, шалгах, байнгын арчилгааг хийж, засаж тордох,
- д) Үйлдвэрийн барилгын агааржуулалт, агаар сэлгэлтийн тусгай төхөөрөмжийг угсрах.

### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- агааржуулалтын тоног төхөөрөмжийн механикч
- агаар сэлгэлтийн механикч

### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

- |      |                                       |
|------|---------------------------------------|
| 7126 | сантехникч, салхивчийн хоолой угсрагч |
| 7126 | сантехникч, хоолой угсрагч            |

## БАГА БҮЛЭГ 713

### БУДАГЧИН, БАРИЛГЫН БҮТЭЭЦ ЦЭВЭРЛЭГЧ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН

Будагчин, барилгын бүтээцийн цэвэрлэгээний болон түүнтэй адилтгах бусад ажилтан нь барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, бусад үйлдвэрлэгдсэн эдлэлийн гадаргууг бэлтгэн, будаг, түүнтэй ижил төстэй материалаар будна. Дотор хана, таазыг цааслах, барилга, бусад байгууламжийн гадна хана болон янданг цэвэрлэнэ.

### Гүйцэтгэх үүрэг:

Барилга ба бусад байгууламж, тээврийн хэрэгсэл болон бусад үйлдвэрлэгдсэн эдлэлийн гадаргууг бэлтгэн, будаг ба түүнтэй ижил төстэй материалаар будах, тээврийн хэрэгсэл болон бусад үйлдвэрлэгдсэн эдлэлийг ихэвчилэн будаг шүршигчээр будах, лагдах, дотор хана, таазыг

обойн цаас, торго болон ижил төстэй материалаар цааслах, янданг цэвэрлэх, барилга, байгууламжийн гадна ханыг цэвэрлэх ажил багтана.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7131 Будагчин, түүнтэй адилтгах бусад ажилтан**

**7132 Будаг шүршигч, лакдакч**

**7133 Барилгын бүтээцийн цэвэрлэгч**

### **7131 БУДАГЧИН, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

Будагчин, түүнтэй адилтгах бусад ажилтан нь барилга, бусад байгууламжийн гадаргууг будахад бэлтгэх, будаг ба түүнтэй ижил төстэй материалаар хамгаалалтын болон заслалын будгийн ажлыг гүйцэтгэх, дотор хана, таазыг цааслах болон бусад өнгөлгөөний материалаар бүрэх ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилгын хана болон бусад гадаргууг будах эсхүл цааслахад зориулан цэвэрлэж бэлтгэх,
- б) шаардлагатай өнгийг гарган авахын тулд пигмент ба нэмэлтийг зохистой сонгон найруулж будгийг бэлтгэх,
- в) барилгын гадаргуу, тоноглолуудыг шүршиж, лакдаж, бусад ижил төстэй материалаар будах,
- г) дотор хана, таазыг ханын цаас, бусад бөс материалаар бүрэх, материалын хэмжээг гаргах,
- д) багс, өнхрүүлэг, шүршигчээр будаг, лакаар гадаргууг будах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- барилгын будагчин
- цааслагч

### **7132 БУДАГ ШҮРШИГЧ, ЛАКДАГЧ**

Будаг шүршигч, лакдагч нь үйлдвэрлэсэн бүтээц, эдлэхүүний гадаргууг шүршдэг будаг ба лакаар будаж хамгаална.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) будагдах гадаргуугийн бохирдол, тоос, шороог янз бүрийн аргаар цэвэрлэн бэлтгэх,

- б) машин, автобус, ачааны тэрэг, бусад тээврийн хэрэгслийн гадаргууг тэгшлэх, будах, лак бусад материалаар будаж хамгаалах,
- в) ихэвчлэн гар шүршигчээр эмаль, лак зэргээр металл, мод, бусад хийцээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гадаргууг будах, хамгаалалтын будаг хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг будагч,
- тээврийн хэрэгсэл будагч
- лакдагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8122 металл будагч машины операторч
- 7521 мод будагч машины операторч
- 7131 барилгын будагчин
- 7131 чимэглэлийн будагчин
- 7316 тэмдэг зурагч, хээ гаргагч

**7133 БАРИЛГЫН БҮТЭЭЦИЙН ЦЭВЭРЛЭГЧ**

Барилгын бүтээцийн цэвэрлэгч нь барилгын гадна гадаргуу, бусад бүтээцийг цэвэрлэх, яндангийн хөө тортогийг цэвэрлэж зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) чулуу, тоосго, металл бусад ижил төстэй гадна гадаргууг химийн бодисоор, даралтат уураар, даралтат элс, усаар цэвэрлэх,
- б) яндан, шугам, дамжуулах хоолойн тортог, лагийг цэвэрлэх,
- в) галд өртсөн хэсэг, мөөгөнцөр, асбест зэргийг барилгаас зайлуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- яндан хөөлөгч
- барилгын гадна тал цэвэрлэгч
- барилгын гадна тал элсээр үлээлгэж цэвэрлэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 9129 ханын зураг цэвэрлэгч
- 9129 усаар шүршиж цэвэрлэгч

## **ДЭД БҮЛЭГ 72**

### **МЕТАЛЛ, МАШИН МЕХАНИЗМ, ТЭДГЭЭРТ ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

Металл, машин, механизм, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтан нь цутгах, гагнах, давтах болон бусад аргаар металлыг хэлбэрт оруулах, хүнд жинтэй металл хийцийг босгох, суурьлуулах, засах, засвар үйлчилгээ хийх, механик багаж хэрэгслийг тохируулах, машин, механизм, хөдөлгүүр, автомашин, цахилгаан ба цахим тоног төхөөрөмжийг тохируулах, засах, засвар үйлчилгээ хийх болон төрөл бүрийн багаж, үнэт бус металл эдлэл хийх ажил эрхэлнэ.

Ажлыг гараар болон тухайн ажилд шаардагдах биеийн хүч, цаг хугацааг багасгах, түүнчлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зориулалттай гар багаж, бусад багаж хэрэгслийг ашиглаж явуулна. Ажлыг гүйцэтгэхэд үйлдвэрлэлийн процессийн бүх үе шат, хэрэглэгддэг материал, багаж хэрэгслүүд, эцсийн бүтээгдэхүүний мөн чанар, зориулалтыг мэдэж байх шаардлагатай.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Металл хайлш цутгах хэв, голлуурыг бэлтгэх, металл цутгах, гагнах ба металлд хэв оруулах, хүнд жинтэй металл бүтцийг суурилуулах, босгох, засвар үйлчилгээ хийх, засах, холбогдох тоног төхөөрөмжийг ажиллуулах, машин механизм, багаж, тоног төхөөрөмж, бусад эд зүйлийг хийхийн тулд ган ба бусад үнэт бус металлыг давтах ба хэв оруулах, төрөл бүрийн машин, тоног төхөөрөмжийг тохируулах, ажиллуулах, операторт тохируулж өгөх, аж үйлдвэрийн машин, механизм, түүний дотор хөдөлгүүр, моторт тээврийн хэрэгслийг тохируулах, засварлах, засвар үйлчилгээ хийх. Бусад ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг энд оруулж болно.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлүүдийг дараах бага бүлэгт ангилна:

- 721 Нимгэн төмөрчин, металл хийц бэлтгэгч, хэв цутгагч, гагнуурчин, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтан**
- 722 Төмрийн дархан, багаж хийгч ба холбогдох мэргэжлийн ажилтан**
- 723 Машин, механизмын механикч, засварчин**

**БАГА БҮЛЭГ 721**

**НИМГЭН ТӨМӨРЧИН, МЕТАЛЛ ХИЙЦ БЭЛТГЭГЧ, ХЭВ ЦУТГАГЧ, ГАГНУУРЧИН, ТЭДГЭЭРТ ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

Нимгэн төмөрчин, металл хийц бэлтгэгч, хэв цутгагч, гагнуурчин, тэдгээрт холбогдох мэргэжлийн ажилтан нь металл цутгах хэв, голлуурыг бэлтгэх, металл хэсгийг гагнах, таслах, нимгэн төмөр эдлэлийг хийх ба засварлах, хүнд жинтэй металл бүтцийг суурилуулах, босгох, засварлах, засвар үйлчилгээ хийх бөгөөд тросст кабин болон бусад холбогдох тоног төхөөрөмжийг ажиллуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

Металл цутгах хэв, голлуурыг бэлтгэх, металл хэсгийг цутгах, гагнах, хэвэнд оруулах, ган, зэс, тугалга, гууль зэрэг нимгэн металлаар эдлэл хийх, засварлах, тросст кабин болон бусад холбогдох тоног төхөөрөмжийг ажиллуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7211 Металл хэв, голлуур бэлтгэгч**

**7212 Гагнуурчин**

**7213 Нимгэн төмөрчин**

**7214 Төмөр хийц бэлтгэгч ба угсрагч**

**7215 Тоноглогч ба кабель холбогч**

**7211 ХЭВ ЦУТГАГЧ**

Металл хэв, голлуур бэлтгэгч нь металл хайлш цутгах хэв болон голлуурыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гараар буюу зориулалтын багаж ашиглан цутгуурын хэв хийх,
- б) металл цутгах хэвэнд ашиглах голлуурыг бэлтгэх,
- в) металлын хэв, голлуурын хайрцгийг цэвэрлэх, тэгш гөлгөр болгох, гадаргууг тэгшлэн засах,
- г) хэвийн хэсэг, хээ, суурь хавтан зэрэг ажлын эд ангиудыг хөдөлгөж зөөх, байршуулах, өргөгч кран ашиглах, ажлын эд ангиудыг зөөж хөдөлгөхөд дохио өгч, бусдад туслах,
- д) хэвийн хэсгүүдэд хээний загваруудыг байрлуулж, нийлүүлэн шахах,

- е) хэвнээс хальж гарсан хэсгүүдийг таслах, хэвэн дотор гарсан нүхийг дүүргэх,
- ж) хэвний дээд талын хэсгүүдийг доод талынхаас салгаж өргөх, хэвлэгдсэн загваруудыг салгаж авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Металл хайлшийн гол бэлтгэгч
- Металл хайлшийн хэв цутгагч

## 7212 ГАГНУУРЧИН

Гагнуурчин нь хийн ба цахилгаан гагнуурын төрөл бүрийн гагнуурын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан металл хэсгүүдийг гагнах ба таслах бүх төрлийн гагнуурын ажил хийж гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хийн ба цахилгаан бусад төрлийн гагнуурын багаж хэрэгсэл ашиглаж, эсвэл өөр аргаар металл хэсгүүдийг гагнах,
- б) гагнуурын аппарат болон бусад багаж хэрэгслийг ажиллуулах,
- в) гагнуур хийх үед хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, журмыг мөрдөж ажиллах,
- г) металл хэсгүүдийн эвийг нийлүүлэн гагнах,
- д) хийн ба цахилгаан, бусад төрөл бүрийн гагнуурын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан металл хэсгийг зүсэх, огтлох,
- е) металлын хайлш ашиглан төмөр хэсгүүдийг холбох,
- ж) хэсгүүд хэт халах, материал үрчийх, хорчийх, эвдрэх, сунах зэрэг гэмтэл согог гаргахгүйн тулд бэлтгэх, төөнөх, гагнах үйл ажиллагааг хянах,
- з) гагнасан хэсгүүдэд гологдол, дутагдал гарсан эсэхийг үзэж шалгах, ирмэгүүдийг хэмжиж үзэх, техникийн шаардлага, зааварт нийцсэн эсэхийг магадлах,
- и) даацын хийц бүтээц, өргөх, зөөх байгууламж болон угсармал төмөр бетон хийц бүтээц, гүүр гагнах, бэхлэх,
- к) барилгын хайс, хашааг гагнах, арматур таслах, гагнах,
- л) даралттай ажиллах сав, зуух, шугам хоолой гагнах,
- м) төмөр хаалга, цонх хийх, суулгаж гагнах, төмөр хийц эдэлхүүнийг эсгэх, зүсэх,
- н) сантехникийн холболт, эдэлхүүн хийц хэсгийг гагнах,
- о) аргон гагнуураар зэвэрдэггүй ган болон хайлш гагнах,
- ө) өнгөт металл гагнах, зүсэх,
- п) металл хэсгүүдэд нөхөөс, шаваас тавих.



**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хийн гагнуурчин
- Цахилгаан гагнуурчин

**7213 НИМГЭН ТӨМӨРЧИН**

Нимгэн төмөрчин нь нимгэн ган, зэс, тугалга, гууль, хөнгөн цагаан, цайр, төмөр зэрэг металлаар төрөл бүрийн бүтээгдэхүүн, эд анги хийх, угсрах ажил хийнэ.

Түүнчлэн барилгын бүх төрлийн нимгэн төмрөөр эдлэл хийх, угсрах мэргэшилтэй байна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нимгэн төмрийг зүсэх, хэлбэр гаргахаар зурж тэмдэглэх,
- б) тугалга, зэс, бусад зөөлөн хайлшаар ахуйн хэрэглээний ба гоёл чимэглэлийн зүйлс хийх, засах,
- в) бойлер, цистерн, тогоо болон бусад сав хийх, засах,
- г) тээврийн хэрэгсэл, нисэх онгоцны нимгэн металл хэсгүүдийг суурилуулах ба засварлах,
- д) зургийг нимгэн металл эд зүйлийг бүтээх ба угсрахад ашиглах загвар болгож хувиргах,
- е) хамрах хүрээ, угсралтын дараалал, мөн түүнчлэн загвар, зураг, бичгээр буюу амаар өгсөн зааврын дагуу шаардагдах арга техник, материал зэргийг багтаасан төслийн шаардлагыг тодорхойлох,
- ж) техникийн үзүүлэлтийг хангахын тулд бүтээгдэхүүний чанар, угсралтыг үзэж шалгах.
- з) дээврийн төмрийг эсгэх, нугалж эмхэрдэх, бэхлэх хэрэгслийг бэлдэх, төрөл бүрийн хэлбэрээр бэлдсэн төмрөөр дээврийн хучлага хийх
- и) борооны усны яндан, дээврийн бусад төмөр эдлэл хийж угсрах
- з) дээврийн зориулалтаар хийгдсэн сэндвичээр дээврийн хучлага хийх
- л) цонхонд усны хаялга хийж угсрах
- м) ариун цэвэр, гал тогооны өрөөний агааржуулалтын эдлэл бэлдэж угсрах
- н) дээврийн төрөл бүрийн төмрийг эсгэх, нугалах, имхэрдэх, угсрах, бэхлэх ажлыг хийнэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бойлерийн дархан
- Зэс төмрийн дархан
- Нимгэн төмөрчин
- Тугалгын дархан

**7214 МЕТАЛЛ ХИЙЦ БЭЛТГЭГЧ, УГСРАГЧ**

Металл хийц бэлтгэгч, угсрагч нь барилга болон бусад байгууламжийн хүнд төмөр гулдмай, хавтанг хэвэнд оруулах ба угсрах, задлах, босгох ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилга, бусад байгууламжийн металл рамыг өрөмдөх, эсгэх, хэлбэр гаргахад зориулан тэмдэглэх,
- б) цехэд бүтээцийн металлыг өрөмдөх, эсгэх, хэвэнд оруулж хэлбэр гаргах,
- в) барилга, гүүр, болон бусад барилгын металл бүтээцийг угсрах, босгох,
- г) араг бүтээц, бүтээцийн металл хэсгийг нэгтгэх, угсрах,
- д) төмөр хийцийн барилга байгууламжийг барих, засварлах үед бүтээцийн металл хавтангуудыг хэлбэр гаргах, нийцүүлж тааруулах,
- е) гар, машин, хийн хадагчаар металл бүтээцийн элементүүдийг хадах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- угсрагч, металл бүтээц
- бэлтгэгч, металл бүтээц
- хадагч, тавлагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7223 хадаасны үйлдвэрлэлийн машины операторч

**7215 ХҮНД, ОВОРТОЙ ЭДЛЭХҮҮН ЗӨӨГЧ, ООСОРЛОГЧ**

Хүнд, овортой эдлэхүүн зөөгч, оосорлогч нь эдлэхүүн, тоног төхөөрөмжийг зөөх, бүтээц, хэсгүүдийг байрлуулахын тулд тороос, олс, дүүжин уяаг оосорлох, барилгын талбай, барилга болон бусад байгууламжид угсрах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зөөх биетийн овор хэмжээ, хэлбэр, жинг тооцоолон ямар хэрэгслээр түүнийг зөөхийг шийдэх,
- б) оосор, тороос, олс бусад энгийн өргөх хэрэгслийг угсрах, засах,
- в) оосор, тороос, дүүжин уяагаар эд зүйлийг бэхлэх, холбох, угсрах, засах,
- г) ус, хий, тосны цооног өрөмдөхөд зориулан кран болон бусад хэрэгслийг угсарч, ажилд бэлтгэх, засварлахад багаар ажиллах,

- д) холбооны шон, агаарын кабелийн шугам, таталган /агаарын/ төмөр зам, дүүжин зам /цанын агаарын зам/ болон бусад ижил төстэй дэд бүтцийн байгууламжийг угсрах,  
 г) театр, зургийн талбайд тайз засах, хөдөлгөх, өргөх, гэрэлтүүлэх, бусад тоног төхөөрөмжийг угсрах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- оосорлогч
- кабель холбогч
- цамхаг оосорлогч
- театрын тайз засагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8189      кабель, дүүжин уяа холбох машины операторч  
 8343      кранч, өргөгч зэрэг бусад адилтгах машины операторч

**БАГА БҮЛЭГ 722**

**ДАРХАН, ГАРААР ДАВТАХ БОЛОН ШАХУУРГЫН ДАРХАН,  
 ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

Дархан, гараар давтах болон шахуургын дархан, холбогдох бусад ажил, мэргэжлийн ажилтан нь төмөр, ган болон бусад металл хавтан, саваа буюу гулдмайг давтах, халааж хэвэнд оруулах зэргээр төрөл бүрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад зүйлс хийх, засах, машин, тоног төхөөрөмжийг тохируулах, ажиллуулах, операторт тохируулга хийж өгөх, металл гадаргууг зүлгэх, ирлэх ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Төмөр, ган болон бусад төрлийн металлыг давтах, халааж хэвэнд оруулах зэргээр төрөл бүрийн багаж, тоног төхөөрөмж, бусад эд зүйлийг хийх ба засварлах, машин тоног төхөөрөмжийг операторт тохируулж өгөх, төрөл бүрийн машин, тоног төхөөрөмжийг жигдрүүлэхийн тулд тохируулах буюу ажиллуулах, металл гадаргуу, багажийг зүлгэх ба ирлэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7221 Дархан, гараар давтах болон шахуургын дархан**

**7222 Багажны дархан, түүнтэй адилтгах бусад ажилтан**

**7223 Металл, машин механизм суурилуулагч, операторч**

**7224 Металл зүлгэгч, өнгөлөгч, багаж ирлэгч**

**7221 ДАРХАН, ГАРААР ДАВТАХ БОЛОН ШАХУУРГЫН ДАРХАН**

Төмрийн дархан, гараар давтах болон шахуургын дархан нь төмөр, ган болон бусад металл хавтан, саваа, хавтгай буюу гулдмайг давтах, халааж хэвэнд оруулах, утас цувих зэргээр төрөл бүрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эд анги, хөдөө аж ахуйн болон холбогдох бусад эд зүйлийг хийх ба засварлана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) металлыг зууханд хайлуулж, сунгах, муруйлгах, зүсэх, алхаар давтах, цоолох, тайрах, гагнах, хатаах, ширээх зэрэг аргаар төрөл бүрийн эд зүйлс хийх ба засах,
- б) хайлуулж зөөлрүүлсэн металлыг лантуугаар цохиж задгай хэвэнд оруулах,
- в) металлыг битүү хэвэнд лантуугаар цохиж оруулан эд зүйл хийх,
- г) металл эд зүйлийг шахуургаар битүү хэвэнд оруулах,
- д) төмөр утас цувих,
- е) ажлын захиалга, зураглалыг уншиж, машин суурилуулах ажиллагааны дараалал, техникийн нөхцлийг тодорхойлох,
- ж) бүтээгдэхүүний техникийн үзүүлэлтийг хангахын тулд машины эд ангиудыг хэмжих, үзэж шалгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Төмрийн дархан
- Лантуу буулгах ажилтан
- Шахуургын дархан
- Гараар давтах дархан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7223 Металл цутгах машины оператор  
7223 Механикч, багаж хэрэгслийн оператор

**7222 БАГАЖНЫ ДАРХАН, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

Багаж хийгч ба түүнд холбогдох мэргэжлийн ажилтан нь гараар ба механик багаж ашиглан захиалагчийн хүссэн болон төрөлжсөн багаж хэрэгсэл, спортын буу, түлхүүр, цоож, хэв, машин, механизмын эд анги болон бусад металл эдлэлийг хийх ба засварлана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) инженерийн зураг, багаж, хэв, туршилтын загвар, загварын техникийн үзүүлэлтүүдийг унших, тайлбарлах,

- б) эх болон үлгэр зураг бэлтгэх, ажлын процессуудыг тодорхойлох,
- в) техникийн үзүүлэлт дээр үндэслэж угсармалын овор, хэмжээ, дүрсийг тооцоолох, бодож төсөөлөх, ,
- г) машинаар ажиллахад зориулж металлын нөөц буюу цутгамалуудыг байрлуулах, хэмжих, баталгаатай болгох,
- д) урьдчилан заасан хэмжээ, өнгөлгөөнд тааруулж ажлын материалыг зүсэх, эргүүлэх, бутлах, харуулдах, өрөмдөх, цоолох, зүлгэх буюу бусад аргаар дүрс оруулах энгийн болон компьютерийн удирдлагатай механик багаж хэрэгсэл суурилуулах, ажиллуулах ба засвар үйлчилгээ хийх,
- е) хавчигч багаж, гэр ахуйн эд зүйлс, хэмжигч багаж хийх, засахын тулд эд ангиуд тааруулах ба угсрах,
- ж) спортын болон бусад жижиг бууг засах, сайжруулах,
- з) цоож, түлхүүр болон түүний эд ангийг хийх, тохируулах, угсрах ба засах,
- и) цутгуурын хэвийн загвар бэлтгэх, түүнийг засах,
- к) зүсэх, эргүүлэх, цувих, зүлгэх буюу өөр аргаар металл хэлбэр оруулж байгаа бусад ажилтны ажлыг чиглүүлэх үүднээс металл материалд шугам татах, цэг тавих зэргээр тэмдэглэгээ хийх,
- л) хийж дуусгасан эд ангиудыг техникийн үзүүлэлтэнд нийцүүлэхийн тулд тэдгээрийн хэмжээ, жигдрэлт, цэвэрлэгээг нарийн хэмжүүрийн багажаар шалгах, ажиллуулж үзэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хэв хийгч
- Бууны дархан
- Хавчигч багаж хийгч (тиски)
- Цоож, түлхүүрийн дархан
- Хэвний загвар хийгч
- Багаж хийгч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7223      Металл бүтээгдэхүүний машин механизм суурилуулагч, операторч

**7223 МЕТАЛЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИН МЕХАНИЗМ  
СУУРИЛУУЛАГЧ, ОПЕРАТОРЧ**

Металл дээр ажиллах машин, тоног төхөөрөмж суурилуулагч, операторч нь төрөл бүрийн механик багаж хэрэгслийг суурилуулж, ажиллуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) металл эдлэлийг олноор үйлдвэрлэхэд зориулан нэг буюу олон төрлийн машин суурилуулах,
- б) зорох, хайлуулах, хавтгайлах, өрөмдөх, цоолох, өнгөлөх, ирлэх зэрэг металл дээр ажиллах машинууд, түүний дотор олон зориулалттай дижитал удирдлагатай машин ажиллуулах ба хянах,
- в) хуванцар болон металлыг орлох материалыг машинаар боловсруулахад дээрхтэй ижил төстэй ажлууд гүйцэтгэх,
- г) ажлын материалын гологдол, машины доголдлыг илрүүлэхийн тулд машины ажиллагааг ажиглах, шаардлагатай бол машиныг засаж тохируулах,
- д) шугам, эх загвар, бусад хэмжих багаж ашиглан ажлын материалд гологдол байгаа эсэхийг үзэж шалгах, машины ажиллагаанд таарч байгаа эсэхийг магадлахын тулд ажлын материалыг хэмжих,
- е) зүсэх багаж, сойз зэрэг машины элэгдсэн хэрэгслүүдийг солих, гар багаж ашиглах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өрмийн машины операторч
- Механик багаж суурилуулагч
- Механик багажны операторч
- Механик багаж суурилуулагч - операторч
- Металл зорогч
- Металл зүсэгч
- Хадаасны үйлдвэрлэлийн операторч

**7224 МЕТАЛЛ ЗҮЛГЭГЧ, ӨНГӨЛӨГЧ, БАГАЖ ИРЛЭГЧ**

Металл зүлгэгч, өнгөлөгч, багаж ирлэгч нь металл гадаргууг зүлгэх, өнгөлөх ба багаж ирлэх ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) зүлгэх ба өнгөлөх зориулалттай зөөврийн болон суурь машиныг ажиллуулах,
- б) билүүгээр эсвэл механик ажиллагаатай токарийн машинаар зүсэх багаж, хэрэгслийг ирлэх,
- в) хөрөөний шүд, нэхмэлийн самнах машины цилиндрийн төмөр шүдийг ирлэх, тохируулах ба засах,
- г) эргэдэг зүлгүүрийн гадаргууг зааврын дагуу тэгшлэх,
- д) тохиргоо хэрэгтэй эсэхийг тогтоохын тулд машины ажиллагааг ажиглаж хянах, асуудал гарвал машиныг зогсоох,

- е) гадаргуу ба хэмжээс нь техникийн өгсөн үзүүлэлтэд тохирч байх нөхцлийг хангахын тулд ажлын материалыг үзэж шалгах, барьж үзэх, хэмжих,
- ж) гар багаж болон үрэгч хэрэгсэл, зүлгэх арга ажиллагааны тухай мэдлэгээ ашиглаж токарийн хүрдийг техникийн үзүүлэлтийн дагуу сонгох, суурилуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Металл өнгөлөгч
- Багаж төхөөрөмж зүлгэгч
- Металл зүлгэгч
- Хутга ирлэгч

**Өөр газар ангилагдсан холбогдох ажил, мэргэжил:**

- 8122 Металл өнгөлөх машины оператор
- 8122 Металл зүлгэх машины оператор

**БАГА БҮЛЭГ 723**

**МАШИН, МЕХАНИЗМЫН МЕХАНИКЧ, ЗАСВАРЧИН**

Машин, механизмын механикч, засварчин нь хөдөлгүүр, тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрийн машин, механизм, бусад механик тоног төхөөрөмжийг тохируулах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх, засах ажил хийнэ.

Ажил үүрэгт нь ихэвчлэн дараах зүйлс орно: хөдөлгүүр, тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрийн машин, механизм, бусад механик тоног төхөөрөмжийг тохируулах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх, засах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7231 Моторт тээврийн хэрэгслийн механикч, тохируулагч**

**7232 Агаарын хөлгийн хөдөлгүүрийн механикч, тохируулагч**

**7233 Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн машин, механизмын механикч, тохируулагч**

**7234 Унадаг дугуйн засварчин**

**Тайлбар:**

Хэрэв гүйцэтгэх ажил, үүрэг нь ажиллуулах болон хянах машин, механизмын талаар туршлага, мэдлэгтэй байхыг шаардаж байвал, тухайн ажил, мэргэжлийг үндсэн бүлэг 8 буюу “Төхөөрөг, машин, механизмын операторч, угсрагч” гэсэн ангилалд оруулна.

Хэрэв гүйцэтгэх ажил үүрэг нь энгийн ба урсгал шинж чанартай, ихэнхдээ гар багаж, заримдаа биеийн хүч шаарддаг, ажлын талаар бага зэрэг туршлагатай, эсвэл туршлагагүй ч байж болохыг зөвшөөрч байгаа бол, тухайн ажил, мэргэжлийг үндсэн бүлэг 9 буюу “Энгийн ажил, мэргэжил” гэсэн ангилалд оруулна.

## **7231 МОТОРТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЕХАНИКЧ, ТОХИРУУЛАГЧ**

Моторт тээврийн хэрэгслийн механикч, тохируулагч нь суудлын болон ачааны машин, мотоцикл, тээврийн бусад хэрэгслийн хөдөлгүүр, механик ба бусад тоног төхөөрөмжийг тохируулах, суурилуулах, засвар үйлчилгээ хийх, үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөлгүүр болон эд энгийн алдаа доголдлыг илрүүлэх, оношлох,
- б) моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн хөдөлгүүрийг тохируулах, үзэж шалгах, турших, үйлчилгээ хийх,
- в) хөдөлгүүрийн эд энгийг, эсвэл хөдөлгүүрийг бүхэлд нь шинээр сольж тавих,
- г) моторт тээврийн хэрэгслийн гэмтсэн эд энгийг шалгах, тохиргоо хийх, задлах, дахин шинээр суурилуулах, солих,
- д) хөдөлгүүр ба тоормосыг суурилуулах, тохиргоо хийх, моторт тээврийн хэрэгслийн жолоо, бусад эд энгийн тохиргоо хийх,
- е) моторт тээврийн хэрэгслийн механик, цахилгаан, цахим эд энгийг суурилуулах, тохиргоо хийх, үйлчилгээ хийх, сольж тавих,
- ж) хөдөлгүүрийн жигд ажиллагааг хангах, агаарын бохирдлын эсрэг журмыг хэрэгжүүлэхийн тулд тос солих, тосолгооны болон хөдөлгүүрийн тохиргоо хийх зэрэг хуваарьт засвар үйлчилгээ хийх,
- з) засвар хийсний дараа хөдөлгүүр ба эд энгийг буцааж угсрах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Автомашины тоормосны системийн үйлчилгээний техникч
- Дизелийн тохируулагч (хуурай замын тээврийн)
- Хөдөлгүүр тохируулагч (моторт тээврийн хэрэгслийн)
- Гараашийн механикч
- Мотоциклийн механикч
- Моторт тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, шатахууны системийн үйлчилгээний техникч
- Моторт тээврийн хэрэгслийн механикч



- Моторт тээврийн хэрэгслийн механик, цахилгаан болон цахим эд ангийн үйлчилгээний техникч
- Моторт тээврийн хэрэгслийн засварчин
- Моторт тээврийн хэрэгслийн үйлчилгээний техникч
- Жижиг хөдөлгүүрийн механикч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 7234 | Мотоциклийн засварчин                        |
| 8211 | Моторт тээврийн хэрэгслийн хөдөлгүүр угсрагч |

**7232 АГААРЫН ХӨЛГИЙН ХӨДӨЛГҮҮРИЙН МЕХАНИКЧ, ТОХИРУУЛАГЧ**

Агаарын хөлгийн хөдөлгүүрийн механикч, тохируулагч нь агаарын хөлгийн хөдөлгүүрийг угсрах, үйлчилгээ хийх, засварлах мөн урьдчилан сэргийлэх зорилгоор шалгалт, тохируулгыг хийх ба хийн шахуургын системийг угсрах үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) агаарын хөлгийн хөдөлгүүрт үйлчилгээ, шалгалт, тохируулгыг хийх,
- б) хөдөлгүүрийн зарим эд ангийг хэсэгчлэн эсвэл бүтнээр нь солих,
- в) онгоцны эд ангиуд цуурах, хугарах, эвдрэх, зэврэх эсвэл бусад гэмтлийг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн бүрэлдэхүүн хэсгүүд болон дагалдах эд анги, шингэний шахуургын систем, агаарын хөлгийн их биеийг шалгах,
- г) агаарын хөлгийн угсралтын бүтэц, механик ба шингэний системүүдийн хэвийн ажиллагааг хангах, засварлах, үзлэг хийх, шалгах,
- д) гэмтсэн хэсгүүд эсвэл үзлэгийн явцад илэрсэн гэмтэлтэй хэсгүүдийг солих ба засварлах туршлага ба аргыг тодорхойлох зорилгоор гарын авлага, үйлчилгээний аргачлал, бусад стандарт шаардлагыг боловсруулах,
- е) агаарын хөлгийн угсралтын бүтэц, бусад хэсгүүд буюу далавч, агаарын хөлгийн их бие, шингэний хэсгүүд, агааржуулалтын болон түлшний, цахилгааны систем, дулаалга, доторлогоо зэргийн бүрэн бүтэн байдлыг хангах, засварлах, дахин угсрах,
- ж) техник үйлчилгээ нь стандартын дагуу хийгдэж агаарын хөлөг нислэг үйлдэхэд бэлэн болсоныг баталгаажуулахын тулд шалгалтын ажлыг гүйцэтгэх,
- з) агаарын хөлөгт урьдчилан сэргийлэх үзлэг болон засвар үйлчилгээний дараах үзлэг ба засвар үйлчилгээг баримтжуулж, бүртгэлийг тогтмол хөтлөх,

- и) агаарын хөлөг дэхь цахилгаан болон цахим тоног төхөөрөмжүүдийг шалгах, угсрах ба суурилуулах,
- к) радио холбооны систем, хэрэслүүд, цахилгаан хөдөлгүүр, хувиргагч ба түлшний системийн хэсгүүдийг холбох, угсрах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агаарын хөлгийн хөдөлгүүрийн инженер
- Агаарын хөлгийн хөдөлгүүрийн техникч
- Агаарын хөлгийн хөдөлгүүрийн засварчин
- Агаарын хөлгийн авионик инженер
- Агаарын хөлгийн авионик техникч
- Агаарын хөлгийн авионик механикч
- Нисдэг тэрэгний техникч
- Нисдэг тэрэгний механикч
- Тийрэлтэт хөдөлгүүрийн техникч
- Тийрэлтэт хөдөлгүүрийн механикч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8211 Агаарын хөлгийн хөдөлгүүрийг угсрагч

**7233 ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЖ ҮЙЛДВЭРИЙН МАШИН, МЕХАНИЗМЫН МЕХАНИКЧ, ТОХИРУУЛАГЧ**

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн машин, механизмын механикч, засварчин нь хөдөлгүүр, хөдөө аж ахуй ба аж үйлдвэрийн машин, механизм, механик тоног төхөөрөмжийг (автомашин, нисэх онгоцны болон цахилгаан хөдөлгүүрээс бусад) тохируулах, суурилуулах, шалгах, тэдгээрт үйлчилгээ хийх болон засварлах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөлгүүр, машин, механизм, механик тоног төхөөрөмжийг тохируулах, суурилуулах, шалгах, тэдгээрт үйлчилгээ хийх, засварлах,
- б) суурин хөдөлгүүр, машин механизмыг тослох, тосолгоо хийх,
- в) шинэ машин, механизм, механик тоног төхөөрөмжийг стандарт болон техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг шалгах, турших,
- г) эд ангиудыг салгаж, засвар хийхийн тулд машин, механизм, тоног төхөөрөмжийг задлах,
- д) тоормосны барилт, эд ангийн хэт элэгдэл зэргийг шалгах,
- е) шинээр засвар хийсэн машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулж, засвар хэр болсныг шалгах,
- ж) хийсэн засвар, засвар үйлчилгээг тэмдэглэж бүртгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Агааржуулах тоног төхөөрөмжийн механикч
- Барилгын машин, механизмын механикч
- Барилгын машин, механизмын засварчин
- Фермийн машин, механизмын засварчин
- Уул уурхайн машин, механизмын тохируулагч
- Уул уурхайн машин, механизмын засварчин
- Суурин хөдөлгүүрийн тохируулагч
- Суурин хөдөлгүүрийн засварчин
- Галт тэрэгний хөдөлгүүрийн тохируулагч
- Галт тэрэгний хөдөлгүүрийн засварчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                 |
|------|---------------------------------|
| 7412 | Цахилгааны механикч             |
| 8211 | Механик тоног төхөөрөмж угсрагч |

**7234 УНАДАГ ДУГУЙН ЗАСВАРЧИН**

Унадаг дугуйн засварчин нь унадаг дугуйн механик болон холбогдох тоног төхөөрөмж, хоёр дугуйтай түрдэг тэрэг, хүүхдийн тэрэг, хөлгүй хүний тэргэнцэр болон тэдгээртэй төстэй тээврийн тоног төхөөрөмжийг тохируулах, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, засварлана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) унадаг дугуй, моторгүй бусад тээврийн тоног төхөөрөмжийг үзэж шалгах, үйлчилгээ хийх, засварлах,
- б) холхивч болон бусад хөдлөх эд ангийг цэвэрлэх, тослох,
- в) эд ангиуд болон тоормос, хөтлөгч гинжний механизм, дугуй, гар гэх мэт хэрэгслийг солих, засах,
- г) дугуйны хаймер солих, хийний даралт хянах,
- д) дугуйны рамыг шүршдэг будгаар будах,
- е) шинэ унадаг дугуй, хөлгүй хүний тэргэнцэр, ижил төстэй моторгүй тоног төхөөрөмжийг угсрах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Унадаг дугуйны механикч
- Унадаг дугуйны засварчин
- Явуулын засварчин
- Хөлгүй хүний тэргэнцэрийн засварчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 7231 | Мопедийн засварчин                        |
| 7231 | Моторжсон хоёр дугуйтай тэрэгний механикч |

## **ДЭД БҮЛЭГ 73**

### **ГАР УРЛАЛ БА ХЭВЛЭЛИЙН АЖИЛТАН**

---

Гар урлал ба хэвлэлийн ажилтан нь нарийн багаж хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, гоёл чимэглэлийн зүйл, үнэт металл, ваар, шаазан болон шилэн эдлэл зэрэг төрөл бүрийн эд зүйл, түүнчлэн мод, нэхмэл, арьс, эсгий, бусад материалаар гар урлалын зүйл хийх, засварлах, хэвлэх ба хавтаслах ажил хийж гүйцэтгэнэ.

Дээрх ажлыг гараар болон ажилд шаардагдах биеийн хүч, цаг хугацааг багасгах, түүнчлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зориулалттай гар багаж, бусад хэрэгслийг ашиглаж хийнэ. Ажлыг гүйцэтгэхэд үйлдвэрлэлийн процессийн бүх үе шат, ашиглах материал, багаж хэрэгслүүд, эцсийн бүтээгдэхүүний мөн чанар, зориулалтыг мэдэж байх шаардлагатай.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Усан онгоц, цаг уурын, хараа, дуран авайн болон бусад нарийн багаж, тоног төхөөрөмжийг хийх ба засах, хөгжмийн зэмсэг хийх ба засах, үнэт гоёл чимэглэл ба үнэт металл эдлэл хийх, шавар, шаазан, ваар, шилэн эдлэл хийх, төрөл бүрийн эд зүйлийг зурах, чимэглэх, мод, нэхмэл, арьс, эсгий, бусад материалаар гар урлалын зүйл хийх, хэвлэлийн ажил буюу ном хавтаслах ажлыг гүйцэтгэх. Энд бусад ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг бас оруулж болно.

Энэ үндсэн дэд бүлгийн ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**731 Гар урлалын ажилтан**

**732 Хэвлэлийн ажилтан**

## **БАГА БҮЛЭГ 731**

### **ГАР УРЛАЛЫН АЖИЛТАН**

---

Гар урлалын ажилтан нь нарийн багаж, хөгжмийн зэмсэг, үнэт гоёл чимэглэлийн зүйл, бусад үнэт металл, вааран болон шаазан эдлэлийг зохиох, хийх, засах, тохируулах, засвар үйлчилгээ хийх, чимэглэхэд урлаг ба гарын ур чадварыг хослуулан хэрэглэнэ. Тэд уламжлалт ба/буюу сүүлд сурсан арга техникээ хэрэглэж, төрөл бүрийн шил, керамик, нэхмэл, сүрэл, чулуу, мод болон арьсан эд зүйлийг сийлэх, хэвэнд оруулах, угсрах, сүлжих, нэхэх ба чимэглэх ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хөгжмийн болон нарийн багаж хэрэгслийг хийх, хөглөх, засах, засвар үйлчилгээ хийх, суурилуулах, үнэт эдлэл, ёслолын буюу шашны эд зүйл, алт, мөнгө, бусад үнэт металл, үнэт чулуу үйлдвэрлэх, тохируулах, засах, үнэлэх, үнэт болон хагас үнэт чулуу, түүний дотор үнэт эрдэнийн чулуу болон очир алмас зэргийг зүсэх, зүлгэх, өнгөлөх ба бэлэн болгох, үнэт эдлэл ба үнэт металл эд зүйл дээр бичиг болон дүрс сийлэх, ваар, шаазан эдлэл, ариун цэврийн хэрэгсэл, тоосго, царууц болон зүлгүүр зэргийг гараар буюу машинаар хийж бэлтгэх, шингэн шилийг үлээх, хэвэнд оруулах, шахах, зүсэх, тайрах, зүлгэх, өнгөлөх, хайлсан шилийг хэвэнд оруулж дүрстэй болгох, мод, металл, нэхмэл, шил, керамик, бусад материалаар хийсэн эд зүйлийг чимэглэх, янз бүрийн тэмдэг хийхийн тулд үсэг, тоо, монограмм, дизайныг төлөвлөх, зурах, будах, мод, сүрэл, хулс, зэгс, чулуу, лаг шавар, дун болон бусад материал бэлтгэхэд уламжлалт арга техник хэрэглэх, хувийн буюу гэрийн хэрэгцээ, эсвэл чимэглэлд зориулж төрөл бүрийн эд зүйлийг сийлэх, хэв оруулах, угсрах, нэхэх, сүлжих, будах, чимэглэх, хулсан тавилга, сойз, шүүр хийхэд зориулж материал бэлтгэх, төрөл бүрийн сагс сүлжих, нэхмэл даавуу, сүлжмэл, хатгамал болон бусад материалаар хувцас, гэр ахуйн эд зүйл хийхэд уламжлалт арга техник, загвар хэрэглэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7311 Нарийн багаж хийгч, засварчин**

**7312 Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч**

**7313 Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан**

**7314 Ваар, шавар эдлэл хийгч ба холбогдох мэргэжлийн ажилтан**

**7315 Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч**

**7316 Тэмдэг бичигч, гоёл чимэглэлийн будагчин, сийлэгч ба хорын сийлбэрч**

**7317 Мод, сүлжээс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан**

**7318 Нэхмэл, арьс, бусад материалаар эд зүйл хийх гар урлалын ажилтан**

**7319 Өөр газар ангилагдаагүй гар урлалын ажилтан**

**7311 НАРИЙН ХИЙЦТЭЙ БАГАЖ ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЗАСВАРЧИН**

Нарийн хийцтэй багаж үйлдвэрлэгч, засварчин нь механик бугуйн цаг, ширээний ба ханын цаг, усан онгоцны, цаг уурын, хараа, дуран авайн, мэс заслын болон бусад нарийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хийх, тохиргоо хийх, засах, засвар үйлчилгээ хийх, тохируулах, суурилуулах ба тэдгээрийг зөв ажилладаг болгох ажлыг хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бугуйн, ширээний, ханын цаг зэрэг цаг хугацаа заагч багаж, хэрэгслийн механизмыг засах, цэвэрлэх, тохируулах,
- б) тойрог хэмжих багаж, цагийн хэмнэл үзэгч, чимхүүр зэргийг ашиглаж цаг тохируулах,
- в) уусгагч бодис, цаг цэвэрлэгч хэт авианы буюу механик машин хэрэглэж, цагны эд ангийг цэвэрлэх, зайлах, хатаах,
- г) цахим багаж ашиглаж цагны заалт, ажиллагааг турших,
- д) гэмтэлтэй эд ангийг олох болон стандартад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд метр, хэмжигч багаж, заалт, бусад бичих буюу хянах багаж хэрэгслийн заалтыг туршиж үзэх,
- е) гар багаж, компьютер, цахим тоног төхөөрөмж ашиглаж багаж хэрэгсэл буюу жинлүүрийн заалтыг шалгаж, тохируулах,
- ж) гэмтлийг олж тогтоохын тулд эд ангиуд болон холбоосыг үзэж шалгах, механизмыг ажиллуулж үзэх,
- з) барометр, хяналтын хавхлаг, гироскоп, чийг хэмжигч, хурд хэмжигч, эргэлт хэмжигч, температур баригч зэрэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг угсрах,
- и) хүчдэл хэмжигч, үелзлэл хэмжигч, гуурсан шалгагч болон бусад шалгалт, шинжилгээний багаж, хэрэгслийг ашиглаж электрон, цаг уурын меркуриал, анероид болон бусад төрлийн багаж, хэрэгслийг шалгах,
- к) шураг, антенн, тавиур, дохионы гэрэл, удирдлагын самбар, удирдлагын кабель, цахилгааны утас, бусад цахилгаан болон механик тоног төхөөрөмжийг тохируулах, засах,
- л) микроскоп, телескоп, теодолит, секстант зэрэг хараа зүй, дуран авайн багаж, хэрэгслийг засах, тохируулах, бэлэн болгох,
- м) угсарсан багаж хэрэгслүүд нь заасан техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг шалгах, тэдгээрийн ажиллагааны стандартыг хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цаг уурын багаж хэрэгсэл хийгч
- Мэс заслын багаж хийгч
- Цаг хийгч

**Өөр газар ангилагдсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3214	Мэс заслын багаж хийгч
7222	Цоож, түлхүүрийн дархан
7223	Механик багажны машины оператор
8212	Цаг угсрагч

**7312 ХӨГЖМИЙН ЗЭМСЭГ ХИЙГЧ, ХӨГЛӨГЧ**

Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч нь хөгжмийн зэмсэг хийх, угсрах, засах, тохируулах, сэргээх ба гараар буюу багаж ашиглаж хөгжмийн зэмсгийг шаардагдах хэмжээнд хүртэл хөглөнө. Тэрээр чавхдаст, үлээвэр хөгжим, төгөлдөр хуур, цохиурт хөгжим зэрэг хөгжмийн аль нэгэн төрлөөр мэргэшинэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөгжмийн зэмсэг болон мод, хатуу мод, төмөр, арьс ба бусад материалаар хөгжмийн эд ангиудыг хийх, угсрах,
- б) гар болон механик багаж ашиглаж утас, ивүүр, зөөлөвч, түлхүүр гэх мэт хөгжмийн зэмсгийн хэсэг, эд ангийг засах, солих,
- в) дууны чанарыг үнэлэх, аливаа гэмтлийг олж тогтоохын тулд хөгжмийн зэмсгийг үзэж шалгах, хөгжим тоглох,
- г) чавхдаст хөгжмийн хөг, дууг зөв тааруулахын тулд чавхдасын хөвчрөлтийг тохируулах,
- д) гар багаж хэрэглэж тохиргоо хийх, агаарын урсгал, дууны өндөр намыг тааруулах,
- е) органийн хоолойнуудыг хөглөх, үйлчилгээ хийх,
- ж) цохиурт хөгжмийн зэмсэгт шинэ хэнгэргэн хальс тавих,
- з) аккордион хөгжим хөглөх,
- и) модон буюу үлээвэр хөгжмийн зөөлөвч ба түлхүүрийг тэгшлэх,
- к) зэмсгийн арьсан хэсгийг дээд талд нь бэхэлж чангалах буюу зэмсгийн хоёр талд байх утсуудыг чангалж, эсвэл сулруулж цохиурт хөгжмийг хөглөх,
- л) шинэ гуурст орган болон төгөлдөр хуур хөгжмийг байшин дотор угсрах, суурилуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үлээвэр хөгжмийн засварчин
- Төгөлдөр хуур хөглөгч
- Чавхдаст хөгжим хийгч
- Модон үлээвэр хөгжим хийгч

**7313 ЭРДЭНИЙН ЧУЛУУ, ҮНЭТ МЕТАЛЛЫН АЖИЛТАН**

Эрдэнийн чулуу ба үнэт металлын ажилтан нь эрдэнийн чулуу, үнэт эдлэл, ёслолын буюу шашны эд зүйл, алт, мөнгө, бусад үнэт металл, үнэт чулуун эд зүйлийг үйлдвэрлэх ажлыг хийнэ. Тэрээр үнэт болон хагас үнэт чулуу, түүний дотор үнэт эрдэнийн чулуу болон очир алмас зэргийг зүсэх, зүлгэх, өнгөлөх, суулгах ажил гүйцэтгэнэ. Мөн очир алмасыг аж үйлдвэрийн зорилгоор зүсэж, өнгөлнө.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гоёл чимэглэлийн зүйл, өнгөт металл эдлэлийг гараар цутгах,
- б) хэрэв шаардлагатай бол компьютер ашиглаж шинэ гоёл чимэглэлийн зүйлийн зохиомж бүтээх, байгаа хийцийг өөрчлөх,
- в) металл ба эрдэнийн чулуун эдлэлийн загварыг хэвлэх, эсвэл бусад материалаар зүсэж хийх,
- г) үнэт чулууг буцааж суурилуулах буюу суултыг тохируулахын тулд тухайн гоёл чимэглэлийн зүйлийн суулгацыг өөрчлөх,
- д) хуучин гоёл чимэглэлийн зүйл буюу үнэт металл эдлэлийг зохиомж буюу зааврын дагуу засах, өөр дүрстэй болгох, хийцийг өөрчлөх,
- е) бөгж, хүзүүний зүүлт, энгэрийн зүү, бугуйвч зэрэг гоёл чимэглэлийн зүйлийг алт, мөнгө, цагаан алт, үнэт чулуу, хагас үнэт чулуу зэрэг материалаар хийх,
- ж) чулууны хоорондын ялгааг тогтоох, ховор загварыг тодорхойлох, аливаа гэмтэл, доголдлыг, эсвэл үнэт чулууны үнэ цэнд нөлөөлөх шинж чанарыг илрүүлэхийн тулд поларископ, рефрактометр, микроскоп болон бусад оптик багаж ашиглан үнэт чулууны гадаргуу, дотоод бүтцийг үзэж шалгах,
- з) үнэт чулууг зүсэх, өнгөлөх, гоёл чимэглэлийн зүйлд суулгах,
- и) эрдэнийн чулуу ба үнэт металл эдлэл дээр үсэг, дүрс эсвэл гоёлын зураас сийлэх буюу товойлгон гаргах,
- к) луужин, хронометр зэрэг нарийн багаж хэрэгсэлд ашиглахын тулд үнэт чулуун холхивчийг зүлгэх, цоолох, өнгөлөх,
- л) угсарсан буюу дуусгасан бүтээгдэхүүнийг техникийн үзүүлэлтэд нийцүүлэхийн тулд өсгөгч шил буюу нарийн хэмжигч багаж ашиглан үзэж шалгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гоёл чимэглэлийн зүйл пааландагч
- Алтны дархан
- Эрдэнийн чулуучин
- Үнэт чулуу суулгагч
- Мөнгөний дархан



**7314 ВААР, ШАВАР ЭДЛЭЛИЙН АЖИЛТАН**

Ваар, шавар эдлэл хийгч, түүнд холбогдох мэргэжлийн ажилтан нь шавар, шаазан эдлэл, ариун цэврийн эдлэл, тоосго, керамик эдлэл, зүлгэх хүрд зэргийг гараар буюу машинаар хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ваар, шавар сав ба шаазан эд зүйл хийх,
- б) шавар буюу пластор хэв хийх,
- в) хэрэглэгчийн шаардлагыг мэдэхийн тулд техникийн зургийг унших,
- г) эргэгч хүрдэн дээр шаварыг гараар дунд нь болон гадна, дотор талд нь дарах замаар дурын дүрс ба хэмжээтэй шавар эдлэл үүсгэж хийх,
- д) шавар материал өргөсөх болон хана нь нимгэрэхийг мэдрэхийн хэрээр хүрдний эргэх хурдыг тааруулах,
- е) аяга, жижиг аяга, таваг, дийз зэрэг керамик эдлэл хийхийн тулд зориулалтын машин ажиллуулах,
- ж) ваар ба шаврыг хэвэн дээр буюу хэвэн дотор хийх, холих, шахах, зүсэх тээрмийн удирдлагыг тохируулж тавих,
- з) резинэн зүлгүүр, нойтон резин ашиглаж хийж дууссан эдлэлийн гадаргууг жигд болгож өнгөлөх,
- и) арзгар хольцыг гараар буюу машинаар шахан хэв оруулж, хүрдэн зүлгүүр хийх,
- к) хийж дуусгасан эдлэлийг шалгаж, гологдол байгаа эсэхийг харах, хэмжигч багаж, эх загвар ашиглан эдлэлийн дүрс, хэмжээ таарч байгаа эсэхийг шалгах,
- л) хийсэн эдлэлийг борлуулах буюу үзэсгэлэнд тавихаар бэлтгэх, бүтээгдэхүүний борлуулалт, үзэсгэлэнгийн ажлыг хөнгөвчлөхийн тулд жижиглэнгийн худалдаа, ваар, шавар эдлэл, урлагийн болон бусад сүлжээний хүмүүстэй харилцаа холбоотой байх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шавар, шаазан эдлэл цутгагч
- Шавар, шаазан эдлэл хэвлэгч
- Ваарчин
- Хүрдэн зүлгүүрийн хэвчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8181 Тоосго ба царууцын зуухны операторч
- 8181 Шавар ба шаазангийн зуухны операторч

**7315 ШИЛЭН ЭДЛЭЛ ХИЙГЧ, ЗҮСЭГЧ, ЗҮЛГЭГЧ, ӨНГӨЛӨГЧ**

Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч нь шингэн шилийг үлээх, хэвэнд цутгах, дарах, зүсэх, тайрах, зүлгэх, өнгөлөх зэргээр хэлбэрт оруулах ажил хийнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хийн буюу халаагч зуух ашиглаж, шилийг нугарах шатанд очтол нь халаах, шилийг жигд халаахын тулд эргүүлэх,
- б) шилэн сав, тахир хоолой, хуруун шил зэрэг лабораторийн аппарат, хэрэгсэл хийхийн тулд шилийг үлээх ба тахийлгах, тодорхой хэлбэрт оруулах,
- в) шилэн эдлэлийн ирмэгийг засах, гадаргууг өнгөлөх, зарим илүү гарсан булцуу, хэсгийг тайрч засахын тулд зүлгүүр буюу хүрдэн өнгөлөгчөөр зүлгэх, өнгөлөх,
- г) шилэн эдлэл, эцсийн бүтээгдэхүүнийг үзэж шалгах, гологдолтой бүтээгдэхүүнийг тэмдэглэх, хаях,
- д) ажлын захиалгыг уншиж, хэмжээс, зүсэх хэсэг болон зүсэх тоо хэмжээг тодорхойлох,
- е) хэмжих багаж, компьютерийн хэвлэл, видео дэлгэцийг харж, тусгайлсан боловсруулалтын нөхцлийг шалгах, шаардлагатай засвар өөрчлөлтийг хийх,
- ж) шилэн дээр хэв буюу зураг байрлуулах, хэмжээсийг шалгах, зүсэх шугамуудыг тэмдэглэх, шил зүсэх багаж хэрэглэх, тэмдэглэсэн шугамыг дагуулж буюу хэвийг тойруулж шилийг зүсэх,
- з) компьютержсэн буюу роботжсон шил зүсэх тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах ба тохируулах,
- и) гаргасан бүтээгдэхүүн нь техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд микрометр, штангенциркул, өсгөгч, шугам зэрэг багаж ашиглаж үзэж шалгах, жигнэх ба хэмжилт хийх,
- к) боловсруулах шилний төрлөөс хамааруулан халаах зуухны температурыг тохируулах,
- л) зураг, хээ суулгах шил тус бүрийн хээг бүрэн хэмжээний зургаас авч хэвийн цаасанд буулгах, зурагны мөр гаргахад стилус хэрэглэх,
- м) тольжсон гадаргуу гаргаж авахын тулд шүрших буу ашиглаж мөнгөний уусмалаар шилэн дээр шүрших,
- н) оптик болон бусад шилийг тусгайлсан хэмжээс, жинд тааруулан линз ба цагны кристалл шил цутгахын тулд зүсэх ба өнгөлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шил үлээгч
- Шил зүсэгч

- Шил өнгөлөгч
- Шил зүлгэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8181 Шил үйлдвэрлэх зуухны операторч

**7316 ХАЯГ, ЗАРЛАЛ, ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН ЗУРААЧ, БУДАГЧ, СИЙЛБЭРЧ, ЗУРАГ ХЭЭ ГАРГАГЧ**

Хаяг, зарлал, гоёл чимэглэлийн будагч, сийлбэрч, зураг хээ гаргагч нь мод, металл, даавуу, шил, керамик болон бусад материалаар хийсэн эд зүйл дээрх чимэглэлийн ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) шил, шавар, вааран эдлэл, бэлэг дурсгалын зүйлийн хайрцаг, гэрэл чийдэнгийн бүрхүүл зэрэг эд зүйл дээрх гоёл чимэглэлийг гараар дизайн гаргаж зурах, будах,
- б) гоёл чимэглэлийн зураг хээ угалзны дизайныг цаасан хэвнээс төрөл бүрийн эд зүйл дээр буулгах,
- в) тоон болон үсгэн тэмдэгт гаргах, нэг ба хэд хэдэн улсын хэлээр үсэг бичих, дүрсний бусад дизайныг зурах, будах,
- г) хэв, цоолтуур бэлтгэх зорилгоор үсэг, бичвэр, дүрсний дизайн, хар зургийг зурах, түүнийг ажлын болон хэв гаргах материал дээр буулгах,
- д) тэмдэг, шил вааран эдлэл, төмөр цайран таваг мэтийн эдлэлийг чимэглэх зорилгоор хээ угалз, үсэг дүрсний дизайныг гаргах,
- е) хайчилж зүссэн, эсвэл хулдаасаар нааж хийсэн материалаар хаяг, зарлал болон бэлэн зүсэгдсэн үсгээр бичвэрийг хийх, дизайн гаргах, цахим программ хангамж, хэв гаргагчийг ашиглан том хэмжээний зар, сурталчилгаа, бичвэр болон 3 хэмжээст зураг дүрслэл хийх,
- ж) үзүүлэн, плакат, материал бэлтгэх, тоо, үсэг бичих, зурах, будах, хэвлэх,
- з) гараар болон цахилгаан туузан хөрөө, уран хөрөө зэрэг тоног төхөөрөмж ашиглан картон, фанер, бусад материалаас үсэг, бусад бичвэр, дүрсийг хөрөөдөх, хайчлах,
- и) тухайн загвар дизайн нь ажиллах материал дээр хэрхэн сийлэгдэх, хээлэгдэх, хайчлагдах, дүрслэгдэх зэргийг тодорхойлох зорилгоор хар зураг, эх зураг, төсөл, диаграмм болон фото зурганд судалгаа, шинжилгээ хийх,
- к) сийлэх хээ, дизайн болон үсэг, дүрсний хэмжээсийг тооцоолох, хэмжих,

- л) зураг хээ, чимэглэлийн дизайн, загвар, тодорхойлолтын дагуу тоо, үсгэн тэмдэгтийг хавтгай болон төрөл бүрийн хэлбэрийн металл, шил, хуванцар, керамик гадаргуу дээр болон эдлэл дээр бичих, сийлэх, хэвлэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- шилэн эдлэлийн сийлбэрч
- шилэн эдлэлийн зураг, хээ гаргагч
- шилэн эдлэл өнгөлөгч, пааландагч
- чимэглэлийн зураач

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8181	шил болон керамикийн зуухны операторч
7131	будагчин
7132	будаг шүршигч, лацдагч
7132	тээврийн хэрэгсэл будагч

**7317 МОДООР ГАР УРЛАЛЫН ЗҮЙЛ, САГС ЗЭРГИЙГ ХИЙГЧ**

Модоор гар урлалын зүйл, сүлжмэл эдлэл, сагс зэргийг хийгч нь уламжлалт аргыг хэрэглэн хатаах, чийглэх зэргээр мод, сүрэл, бургас, дэрс, шавар, чулуу бусад материалыг бэлтгэн боловсруулж, хувийн ба гэр ахуйн хэрэгцээнд болон гоёл чимэглэлийн зориулалтаар төрөл бүрийн эд зүйлийг сийлэх, зүсэх, цутгах, хэв гаргах, угсрах, сүлжих, будах, чимэглэх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мод, сүрэл, бургас, дэрс, шавар, чулуу бусад материалыг бэлтгэх,
- б) чимэглэлийн зориулалтаар модон гадаргуунд цэцгэн болон бусад уран сайхны дизайнаар сийлбэр гаргах,
- в) шил, шавар, шаазан эд зүйл дээр гар аргаар чимэглэлийн дизайн зурах,
- г) хүнсний бүтээгдэхүүн хэрчих хавтгай мод, зуушны сав, халбага, ваар, тавиур, дэвш, сагс, домбо, сүрлэн малгай, дэвсгэр зэргийг хувийн ба гэр ахуйн хэрэгцээнд болон гоёл чимэглэлийн зориулалтаар төрөл бүрийн эд зүйлийг сийлэх, зүсэх, цутгах, хэв гаргах, угсрах, сүлжих, будах, чимэглэх,
- д) баримал, хөшөө, шатрын хөлөг, гоёл чимэглэлийн эд зүйл болон бусад ижил төстэй эд зүйлийг сийлэх, угсрах, сүлжих, будах,
- е) зөөлрүүлж чийглэсэн зүсмэл хулс, дэрс, зэгс, сүрэл, бургас зэрэг ижил төстэй материалаар сүлжмэл тавилга, эд зүйл хийх,

- ж) сүлжих, торлон нэхэх зэргээр мод, бургас, хулс, дэрс, зэгс, сүрэл зэрэг ижил төстэй материалаар төрөл бүрийн сүлжмэл эдлэл, сагс хийх,
- з) үс, хялгас, утас, нарийн олс зэргийг сонгон материалыг бэлтгэн сууринд суулгаж багс, сойз, шүүр хийх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- зэгс, бургас сүлжих гар урлалын ажилтан
- чулуун эд зүйлийн гар урлалын ажилтан
- модон эдлэлийн гар урлалын ажилтан
- сагс хийгч, сүлжигч
- сойз, багс, шүүр хийгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8114      Машины операторч (чулуун бүтээгдэхүүн)
- 7523      Машины операторч (модон бүтээгдэхүүн)

**7318 ДААВУУ, АРС, БУСАД МАТЕРИАЛААР ГАР УРЛАЛЫН ЗҮЙЛ ХИЙГЧ**

Даавуу, арьс бусад материалаар гар урлалын зүйл хийгч нь уламжлалт гар урлалын аргаар сүлжмэл, нэхмэл, хатгамал болон бусад төрлийн хувцас, гэр ахуйн хэрэглээний зүйл, үндэсний шаахай, гар цүнх, бүс бусад эд зүйлийг хийх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөвөн, ноос, бусад материалыг ээрэх, байгалийн будгаар будах,
- б) төрөл бүрийн хувцас, гэр ахуйн хэрэглээний эд зүйлийг сүлжих, нэхэх, хатгамлаар чимэглэх,
- в) арьс, нэхий, шириг боловсруулан байгалийн будгаар будан үндэсний шаахай, гар цүнх, бүс, бусад эд зүйлийг урлах,
- г) гар аргаар нэхмэлийн утас ээрэх,
- д) нэхмэлийн машинд утас сулгах, сүвлэх, чиглүүлэх,
- е) нэхмэлийн гар машинаар цулгай болон хээтэй хувцас, хивс, хивсэнцэр, хөшиг болон бусад эд зүйл нэхэх,
- ж) зангилах аргаар хивс нэхэх,
- з) гар аргаар болон гараар ажилладаг машин ашиглан төрөл бүрийн хувцас болон бусад зүйл нэхэх,
- и) гар аргаар, дэгээ зүү ашиглан эд зүйл нэхэх, сүлжих,
- к) гараар тор хийх,
- л) ноосон утас угаах,
- м) даавууны утасыг угаах, хөвсийлгэх,
- н) утсаар даавуу хийх, цэвэрлэх, самнах, ээрэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гар хивсчин
- арьс ширэн эдлэл урлагч
- сүлжмэл эдлэл урлагч
- нэхмэл даавуу самнагч
- нэхмэлчин
- ээрмэлчин
- сүвлэгч
- хивс нэхэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8151 утас самнагч машины операторч
- 8152 сүлжих машины операторч
- 8152 нэхэх машины операторч

**7319 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ГАР УРЛАЛЫН ЗҮЙЛ ХИЙГЧ**

Энэ нэгж бүлэгт ороогүй уламжлалт аргаар гар урлал, эд зүйл хийгчийг хамруулна. Жишээлбэл уламжлалт аргаар үнэт бус металл, чулуугаар эд зүйл хийгч хамаарна.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- төмөр тоглоом хийгч

**БАГА БҮЛЭГ 732  
ХЭВЛЭЛИЙН АЖИЛТАН**

---

Хэвлэлийн ажилтан нь хэвлэхийн өмнөх үсэг өрөх, бар бэлтгэх, хэвлэх, хавтаслах, хэвлэмэл бүтээгдэхүүн хийж дуусгах, цоолтуур бэлтгэх, торгон хэвлэлийн тоног төхөөрөмж ажиллуулах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хальс, хэвлэлийн бар, бусад дижитал бүтээгдэхүүн, дүрс гаргах төхөөрөмжид камераас шууд дүрс буулгах, хуулбарлан оруулах камер болон бусад гэрэл зургийн тоног төхөөрөмжийг ажиллуулах, компьютерийн дэлгэцэнд хуулбарлах, өнгө, будаг ялгах, засварлах, хуулбарыг хальсанд буулгах, хальснаас бар бэлтгэх, дижитал дүрс гаргах бусад тоног төхөөрөмжийг ажиллуулах, үсэг өрөх, гэрэл зургийн хуулбар хийх, хэвлэх, таслах, хайчлах, хэвлэсэн материалыг хавтаслах, дэвтэрлэх, нуруулдах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, хэвлэлийн ажиллагааг

төгс болгох, байнга давтагддаг, өдөр тутмын ажил, үүргийг гүйцэтгэх, машин, тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийх, цоолтуур бэлтгэх болон торгон хэвлэлийн тоног төхөөрөмжийг ажиллуулах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7321 Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч**

**7322 Хэвлэгч**

**7323 Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан**

**7321 ХЭВЛЭХИЙН ӨМНӨХ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКЧ**

Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч нь бичвэр өрөх, /текст/ бичвэрийг бичих, хэв, загвар, хэмжээнд оруулах, зураг, графикийн эхийг бэлтгэж, төрөл бүрийн хэвлэлийн ажиллагаа болон бусад дүрс бүхий хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлд тохирох хэлбэрт оруулан бэлтгэх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хальс, бар, бусад дижитал бүтээгдэхүүн, дүрс гаргах төхөөрөмжид камераас дүрс буулгах, хуулбарлан оруулах камер болон бусад гэрэл зургийн тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- б) хэвлэлтэнд буюу дүрс бүхий хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлд зориулан компьютер ашиглан зураг, дүрс, текст, төсөл, ерөнхий зураглал бэлтгэх,
- в) зураг, дүрсийг хальснаас хэвлэлийн дижитал бүтээгдэхүүн, дүрс гаргах төхөөрөмж, хэвлэлд буулгах, бар бэлтгэх тоног төхөөрөмж ажиллуулах,
- г) компьютерээр өнгө ялгах, өнгө засварлах, хадгалах, загвар оруулах, болон хуулбарыг хальсанд буулгах, дижитал дүрс гаргах бусад төхөөрөмжид оруулах тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- д) дижитал системээс боловсруулалт, баталгаажуулалт хийх, позитив, негатив гэрэл зургийн хальснаас химийн аргаар боловсруулалт хийж зураг буулгах,
- е) хэвлэгдсэн материалын чанарыг шалгах, үнэлгээ өгөх, хянах, засварлах,
- ж) шилжүүлэх аргаар зураг хөрвүүлэх хор, цаасыг бэлтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хэвлэлийн дизайнч
- компьютерийн хэвлэлийн программын операторч

- цахим хэвлэлийн хэвлэлтийн өмнөх техникч
- хэвлэлийн бар угсрагч (торгон хэвлэл)
- хэвлэлийн бар хийгч (хэвлэл)
- дэлгэц хийгч (торгон хэвлэл)
- бичвэр өрөгч
- Хэвлэлийн үйлдвэрийн бусад ажилтан
- Зураг боловсруулагч
- Нүүр тавигч

### 7322 ХЭВЛЭГЧ

Хэвлэгч нь дижитал болон хөөмөл хэвлэл, чулуун бар, уян бар, сийлбэр, сонин хэвлэл, бусад хэвлэлийн машин, тоног төхөөрөмжийг суурилуулж, ажиллуулна.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) хэвлэх машины холбогдох төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг тохируулах, хянах,
- б) бэх болон уусгагчийн тунг стандартад тохируулан холих, хэвлэх үйл явцын үед цаас болон бэхний нийлүүлэлтийг тохируулах,
- в) хэвлэлийн чанарын стандартыг хангах, туршилтын хувийг тулган шалгах, үнэлгээ өгөх, доголдолыг илрүүлэх,
- г) хөөмөл, чулуун бар, уян бар, сийлбэр хэвлэл болон шугаман хэвлэлийн системийг ашиглан төрөл бүрийн хэвлэмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- д) бага оврын офсет хэвлэлийн чулуун бар, хэв буулгах бул бэлтгэх,
- е) хэвлэлийн чанар болон хэвлэлийн машины үйл ажиллагааг хянах,
- ж) хэвлэлийн машиныг засах, цэвэрлэх, үйлчилгээ хийх, тохируулах,
- з) дижитал хэвлэлийн зураг үйлдвэрлэх, зураг хөрвүүлэх.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- модон бар хэвлэгч
- дижитал хэвлэлийн хэвлэгч
- уян бар/флексиграфик/ хэвлэлийн хэвлэгч
- сийлбэр хэвлэлийн операторч
- том оврын цаасан хэвлэлийн машины операторч
- торгон хэвлэлийн хэвлэгч
- торгон хэвлэлийн машины операторч
- жижиг хэвлэгч машины операторч
- веб хэвлэлийн операторч
- Операторч, өнгө ялгах машины



- Хэвлэлийн хэв бэлтгэгч
- Хэвлэлийн хэв бэлтгэгч
- Офсет хэвлэлийн хэвлэгч
- Өндөр хэвлэлийн хэвлэгч
- Өндөр хэвлэлийн хэвлэгч
- Флексо хэвлэлийн хэвлэгч
- Торон хэвлэлийн хэвлэгч
- Тоон хэвлэлийн операторч

### **7323 ХЭВЛЭЛТИЙГ ТӨГС БОЛГОХ, ДЭВТЭРЛЭХ АЖИЛТАН**

Хэвлэлтийг төгс болгох, дэвтэрлэх ажилтан нь ном, хэвлэлийг гараар болон машинаар төгс болгох, дэвтэрлэх ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) автомат, болон хэвлэлтийг төгс болгох тоног төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг хянах,
- б) бүрэн болон хагас хавтаслах, зөөлөн хавтас хийх, хавтас засах,
- в) эвхэх, нугалах, тэгшлэх, номын хавтсан дээрх бичвэрийг гараар болон машинаар дарж буулгах, оёх, хатгах,
- г) хэвлэлтийн өмнөх тайрагч болон хэвлэлтийн дараах тайрах, эмжих машиныг ажиллуулах, цахим нэгжүүдийг програмчлах,
- д) хэвлэмэл бүтээгдэхүүн, материалыг сонин, сэтгүүл, дугтуйд оруулах төхөөрөмжийг ажиллуулах,
- е) гараар болон машинаар хэвлэмэл бүтээгдэхүүнийг чимэглэх,
- ж) гэрэл зургийн болон засварлах цахим тоног төхөөрөмжийг ажиллуулах,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- ном хавтаслагч,
- тэгшлэгч машины операторч,
- тайрагч машины операторч,
- тугалган тамга/дардас хийх машины операторч,
- хавтаслагч машины операторч,
- нийлүүлэгч машины операторч,
- олон төрлөөр хавтаслагч машины операторч,
- хэвлэлтийг төгс болгох машины операторч,
- хавж оёх, ширэх машины операторч,
- хавтаслах бага оврын машины операторч.

## **ДЭД БҮЛЭГ 74**

### **ЦАХИЛГААН, ЦАХИМ ТЕХНИКЧ**

---

Цахилгаан болон цахим техникч нь цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад цахилгаан багаж, хэрэглэл, цахилгаан дамжуулах, нийлүүлэх шугам, кабель, цахим ба цахилгаан харилцаа холбооны тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

Эрхлэх ажлын хүрээнд гар аргаар болон гараар ажиллуулдаг, багаж хэрэгсэл ашиглах нь тодорхой ажил гүйцэтгэхэд шаардагдах цаг хугацаа болон биеийн хүчний хэмнэлтээс гадна бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад чиглэнэ. Тухайн ажлын зохион байгуулалт, материал, багаж хэрэгсэл, эцсийн бүтээгдэхүүний мөн чанар, зорилгыг сайтар ойлгож ажиллах шаардлагатай.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Цахилгаан болон цахим шугам, сүлжээ, машин, механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, тохируулах, үйл ажиллагааны арга зарчим, хэмнэлийг тодорхойлох зорилгоор зураг төсөл, диаграм, техникийн үзүүлэлтүүдийг судлаж, хянах, осол аюул, доголдолоос урьдчилан сэргийлэх, тохируулга, засвар, үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор цахилгаан, цахим систем, тоног төхөөрөмж, кабель утас, машин, механизмын ажиллагааг хянах, турших, цахим болон цахилгаан харилцаа холбоо дамжуулах шугамыг суулгах, засварлах, арчлан тордох, засвар үйлчилгээ хийх, цахим, цахилгаан харилцаа холбооны болон мэдээллийн кабелиудыг холбох, албан тасалгааны машин, цахим тоноглол, удирдлагын систем, компьютер, цахилгаан харилцаа холбоо, мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**741 Цахилгаан төхөөрөмж суурилуулагч, тохируулагч**

**742 Цахим техникч, телехолбооны механикч, тохируулагч**

## **БАГА БҮЛЭГ 741**

### **ЦАХИЛГААН ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАГЧ, ТОХИРУУЛАГЧ**

---

Цахилгаан төхөөрөмж суурилуулагч болон тохируулагч нь цахилгааны шугам сүлжээ болон холбогдох тоног төхөөрөмж, цахилгаан машин,

механизм, цахилгаан аппарат, тоноглол, цахилгаан дамжуулах, нийлүүлэх шугам, кабель суурилуулах, угсрах, тохируулах, засвар, үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ

**Гүйцэтгэх үүрэг:**

Цахилгааны шугам сүлжээ, машин, механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх, үйл ажиллагааны арга зарчим, хэмнэлийг тодорхойлох зорилгоор цахилгаан шугамын зураг, төсөл, техникийн үзүүлэлтүүдийг судалж, хянан шалгах, осол аюул, доголдлоос сэргийлэх, тохируулга, засвар үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор цахилгааны систем, тоног төхөөрөмж, кабель, машин, механизмыг шалгах, турших, цахилгаан дамжуулах шугамыг суулгах, засварлах, үйлчилгээ хийх, цахилгааны кабель холбох,

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7411 Барилгын болон бусад цахилгаанчин**

**7412 Цахилгаан төхөөрөмжийн механикч,тохируулагч**

**7413 Цахилгааны шугам тавигч, тохируулагч**

**7411 БАРИЛГЫН БОЛОН БУСАД ЦАХИЛГААНЧИН**

Барилгын болон бусад цахилгаанчин нь барилга байгууламжийн бүх төрлийн цахилгааны шугам сүлжээ, бусад тоног төхөөрөмж, бэхлэх, тогтоох хэрэгслэлийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сургууль, эмнэлэг, дэлгүүр, хувийн эдлэнгийн байр, орон сууц, бусад төрөл бүрийн барилга байгууламжид цахилгааны шугам сүлжээ болон холбогдох тоноглолыг тавих, суурилуулах, угсрах, тохируулах, засвар үйлчилгээ хийх,
- б) барилгын гадна дотор талын цахилгааны утас кабелийг сунгах, угсрах, бэхлэх,
- в) үйл ажиллагааны арга зарчим, хэмнэлийг тодорхойлох зорилгоор цахилгааны шугамын зураг төсөл, техникийн үзүүлэлтүүдийг судалж хянах, шалгах,
- г) ажлын тодорхойлолт, холбогдох стандартад нийцүүлэн цахилгааны шугамын зураг, төсөл төлөвлөх, цахилгааны шугамын утас, тоног төхөөрөмж, бэхлэх, тогтоох хэрэгслийг суурилуулах, угсрах, тогтоох,

- д) осол аюул, доголдлоос урьдчилан сэргийлэх, тохируулга, засвар, үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор цахилгаан систем, тоног төхөөрөмж, бусад бүрэлдэхүүн хэсгийг шалгах, хянах, турших,
- е) цахилгааны кабель, утас сонгох, хэмжих, таслах холболтын байгууламжтай холбох,
- ж) цахилгааны шугам тавих цэгүүдийг тогтоох, зураг төсөл гаргах,
- з) цахилгаан хуваарилах самбарыг суурилуулах,
- и) Трансформатор, залгуур, шит угсрах, цахилгааны дэд өртөөг угсрах
- к) Өндөр хүчдэлийн агаарын шугам угсрах
- л) Сип төрлийн кабельнуудыг угсрах, залгах, засварлах
- м) Хүчитгэсэн цутгамал төмөр бетон тулгуур болон газардуулга, тоног төхөөрөмжийг угсрах
- н) Сэргээгдэх эрчим хүчний тоноглолыг угсрах ажилд мэргэшсэн байна.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цахилгаанчин
- барилгын цахилгаанчин

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7412 цахилгаан төхөөрөмжийн механикч, тохируулагч
- 7413 цахилгааны шугам тавигч, тохируулагч

### **7412 ЦАХИЛГААН ТӨХӨӨРӨМЖИЙН МЕХАНИКЧ, ТОХИРУУЛАГЧ**

Цахилгаан төхөөрөмжийн механикч, тохируулагч нь цахилгаан машин, механизм болон бусад цахилгаан аппарат, тоног төхөөрөмжийг барилга байгууламж, орон сууц, үйлдвэр, цех, бусад газарт суурилуулах, угсрах, тохируулах, засварлах ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) төрөл бүрийн цахилгаан машин, механизм, цахилгаан мотор буюу цахилгаан үүсгүүр, хуваарилах төхөөрөмж, удирдлагын аппарат, тоног хэрэглэл, өргөгч хэрэгсэл, цахилгаан өргүүрийн хэсгүүд, бусад тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тохируулах, засварлах,
- б) гэр ахуйн хэрэгсэл, үйлдвэрийн машин, механизм, бусад цахилгаан хэрэгсэл, болон тэдгээрийн эд ангийг суурилуулах, угсрах, тохируулах, засварлах,
- в) үйлдвэрээс ирсэн цахилгаан тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах,
- г) цахилгаан тоног төхөөрөмж, удирдлагын аппарат хэрэгслийг суурилуулах, шалгах, ашиглалтанд оруулах, засвар үйлчилгээ хийх,

- д) зорчигчийн болон ачаа тээврийн цахилгаан шат, цахилгаан урсдаг зам, шат, бусад өргөх тоног төхөөрөмжийг суурилуулах, засвар үйлчилгээ хийх,
- е) цахилгаан төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэрт холбох, гэмтэл, доголдолтой эд, ангийг солих, засварлах.
- ж) лифт угсрах, засах, ажиллуулах ажлыг зураг төсөл, норм дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цахилгаан үүсгүүрийн техникч
- цахилгааны механикч
- өргүүрийн механикч
- цахилгаан шатны тохируулагч /лифтчин/

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7421 Цахим механикч, засварчин
- 8212 Цахилгаан, цахим төхөөрөмж угсрагч

**7413 ЦАХИЛГААНЫ ШУГАМ ТАВИГЧ, ТОХИРУУЛАГЧ**

Цахилгааны шугам тавигч тохируулагч нь цахилгаан дамжуулах, түгээх кабель утас болон холбогдох тоног төхөөрөмжийг суурилуулах, засварлах, холбох ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахилгааны шугамыг газар дээгүүр болон доогуур тавих, засвар үйлчилгээ хийх,
- б) газар дээрхи болон доорхи цахилгааны кабельд холболт хийх,
- в) суурилуулсан тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж байх, цахилгааны шугам тавих ажил явагдаж буй газарт хашаа, саад барих зэрэг аюулгүй байдлын дүрэм, журмыг баримтлах, зөрчигдөхөөс сэргийлж хяналт тавих,
- г) осол аюулаас сэргийлэх, хамгаалах зорилгоор гэмтэлтэй буюу тасарч унасан шугаманд газардуулах төхөөрөмж суулгах эсвэл өөр шугаманд шилжүүлэх зэрэг арга хэмжээ авах,
- д) өндөрт байрласан тоног төхөөрөмжид хүрэх зорилгоор цахилгааны шонд стандарт хэрэгсэл ашиглан авирах эсвэл машинд суулгасан өргөгч ашиглах,
- е) гүйдэл, хүчдэл хэмжих, шалгах төхөөрөмж ашиглан цахилгаан шугамны доголдолтой, эвдрэлтэй хэсэг, төхөөрөмж, цахилгааны эргэлтийг тасалдуулагч хэсгүүд, гал хамгаалагч, хүчдэл тохируулагч (трансформатор), шилжүүлэгч (релей), цахилгааны кабель, шугамын гэмтлийг олж тодорхойлох

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цахилгаан шугам тавигч, холбогч
- цахилгаан хүчдэл, шугамын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7422 Мэдээлэл, холбооны технологийн хэрэгсэл тавигч, тохируулагч
- 7422 Цахилгаан холбооны шугамын ажилтан

**БАГА БҮЛЭГ 742****ЦАХИМ ТЕХНИК, ТЕЛЕХОЛБООНЫ МЕХАНИКЧ, ТОХИРУУЛАГЧ**

Цахим техник, телехолбооны механикч, тохируулагч нь цахим төхөөрөмж, удирдлагын систем зэрэг цахим тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, тохируулах, засвар, үйлчилгээ хийх, цахим болон телехолбооны техник, мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмж, кабель, антеннийг суурилуулах, засвар үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Гэмтэл, алдаа, доголдлыг илрүүлэх зорилгоор машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон удирдлагын системийн ажиллагааг хянах, оношлох, шалгах, элэгдэж хуучирсан, доголдолтой эд анги, утсыг солих, засах, тохируулах, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, цахим багаж хэрэгсэл, удирдлагын системийг суурилуулах, цахим тоног төхөөрөмжийг суулгах, угсрах, тохируулах, компьютер, түүний мэдээлэл дамжуулах нэмэлт тоног төхөөрөмжийг тохируулах, засвар үйлчилгээ хийх, шалгах, богино долгион, алсаас хэмжих хэрэгсэл, олон сувгийг нэгтгэж нэвтрүүлэх хэрэгсэл, хиймэл дагуул бусад радио болон цахилгаан соронзон долгионы телехолбооны системийг угсрах, засвар үйлчилгээ хийх, алдаа, гэмтэл, доголдлыг оношлох, цахим, телехолбооны сүлжээ, иж бүрэн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах, техникийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, компьютер, радио, телефон утас, теле дүрс дамжуулагчийн кабелийг холбох, засварлах, теле холбооны антен суурилуулах, засварлах, үйлчилгээ хийх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7421 Цахим механикч, засварчин, тохируулагч****7422 Мэдээлэл, холбооны технологийн хэрэгсэл тавигч, тохируулагч**

**7421 ЦАХИМ МЕХАНИКЧ, ЗАСВАРЧИН, ТОХИРУУЛАГЧ**

Цахим механикч, засварчин, тохируулагч нь машин, багаж хэрэгсэл, цахим төхөөрөмж болон удирдлагын системийг суурилуулах, тохируулах, засвар, үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) алдаа, гэмтэл, доголдлыг илрүүлэх оношлох зорилгоор машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд анги болон бусад тоног төхөөрөмж, удирдлагын системийн ажиллагааг хянах, шалгах,
- б) элэгдэж хуучирсан, доголдолтой эд ангийг тохируулах, засварлах, холболтын утсыг солих, машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийх,
- в) тоног төхөөрөмжийг угсрах, үйл ажиллагааг шалгах, турших, тохируулах,
- г) цахим багаж хэрэгсэл, удирдлагын системийг суурилуулах,
- д) инженер, техникийн болон бусад засвар үйлчилгээний ажилтны үйл ажиллагаатай ажлаа уялдуулах,
- е) системийн үйл ажиллагааны доголдлыг илрүүлэх, оношлох зорилгоор шалгалтын үр дүн, мэдээллийн дагуу холбогдох арга хэмжээ авах,
- ж) цахилгаан, цахим эд анги, бүрэлдэхүүн хэсэг, бусад эд ангийг цахилгаан, гар багаж хэрэгсэл ашиглан суурилуулах, тохируулах, засварлах, шинээр солих,
- з) радио систем, багаж хэрэгсэл, агаарын хөлгийн түлш хангах систем зэрэг иж бүрдлийн эд анги, бүрэлдэхүүн хэсгийг угсрах, холбох,
- и) засварын болон үйлчилгээний ажлын бүртгэл, тэмдэглэл хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- агаарын хөлгийн засвар, үйлчилгээний инженер (нисэхийн цахим төхөөрөмж)
- нисэхийн цахим төхөөрөмжийн техникч
- автомат теллерийн машин (АТМ)-ны механикч
- цахим механикч
- цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан
- хувилах, олшруулах машины техникч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- агаарын замын аюулгүй ажиллагааны техникч

**7422 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУЛ ХҮЧНИЙ ШУГАМЫН ХЭРЭГСЭЛ ТАВИГЧ, ТОХИРУУЛАГЧ**

Мэдээлэл, холбооны технологийн хэрэгсэл тавигч, тохируулагч нь мэдээлэл, холбооны технологийн тоног төхөөрөмж, мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмж, кабель, антен, шугам суурилуулах, тохируулах, засвар, үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) компьютер болон мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмж, компьютерийн нэмэлт тоноглолын засвар, үйлчилгээ хийх, доголдлыг засварлах, шалгах,
- б) компьютерийн техник хангамжийг хариуцах,
- в) богино долгион, алсаас хэмжих хэрэгсэл, олон сувгийг нэгтгэж нэвтрүүлэх хэрэгсэл, хиймэл дагуул бусад радио, цахилгаан соронзон долгионы холбооны системийг угсрах, засвар үйлчилгээ хийх, алдаа, гэмтэл, доголдлыг оношлох,
- г) мэдээлэл, холбооны иж бүрэн сүлжээ, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах, техникийн зөвлөлгөө, мэдээлэл өгөх,
- д) компьютер, радио, телефон утас, теле дүрс дамжуулагчийн кабель холбох, засварлах,
- е) холбооны болон мэдээлэл дамжуулах кабель холбох, битүүмжлэх,
- ж) антен суурилуулах, засвар, үйлчилгээ хийх,
- з) мэдээлэл, холбооны гадна шугамын холболт хийх, дотоод сүлжээний холболт хийх, тоног хэрэгсэл угсрах, ажиллуулах
- и) төрөл бүрийн зориулалттай дохиоллын шугам, хэрэгсэл угсрах, радио интернэт өндөр хурдны кабелийн угсралт хийх, үүнтэй холбогдсон тоног хэрэгсэл угсрах
- к) өндөр хурдны шилэн кабель угсрах, холбох ажлыг хийнэ.
- л) утастай, утасгүй холбооны шугам хэрэгслийг угсрах, засварлах ажлыг хийх

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- мэдээлэл, холбооны кабель тавигч
- мэдээлэл, холбоо, сул хүчний шугамын цахилгаанчин
- компьютерийн тоног төхөөрөмж тохируулагч, угсрагч
- холбооны техникч
- компьютерийн техник хангамжийн техникч
- холбооны техникч
- телефон утас тавигч



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3522 Телехолбооны инженерийн техникч (харилцаа холбоо)

---

## **ДЭД БҮЛЭГ 75**

### **ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ, МОД БОЛОВСРУУЛАГЧ, ХУВЦАС БУСАД ХИЙЦИЙН ЗҮЙЛ ХИЙГЧ, ТҮҮНД ХОЛБОГДОХ МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

---

Хоол, хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч нь хөдөө аж ахуй, загасны аж ахуйн түүхий эдийг боловсруулан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мод, модон бүтээгдэхүүн хийх, даавуу, арьс, шир, үс ноос болон бусад материалаар бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, засварлах ажил эрхэлнэ.

Эрхлэх ажил нь гараар болон гараар ажиллуулдаг багаж хэрэгслэл ашиглах нь тодорхой ажил гүйцэтгэхэд шаардагдах цаг хугацааны болон биеийн хүчний хэмнэлтээс гадна бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад чиглэнэ. Тухайн ажлын зохион байгуулалт, материал, багаж хэрэгсэл болон эцсийн бүтээгдэхүүний мөн чанар, зорилгыг сайтар мэдэж ажиллах шаардлагатай.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Мах, загас, үр тариа, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо болон холбогдох материалыг боловсруулж хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг амтлах, зэрэглэл тогтоох, арьс, нэхий, даавуу боловсруулах, засварлах, нэхий, арьс, шир, үс ноосыг дахин боловсруулах зориулалтаар бэлтгэх, даавуу, хувцас, малгай, өмсгөл, гутал болон бусад холбогдох бүтээгдэхүүн хийх, засварлах, мод боловсруулах, модон тавилга бусад бараа бүтээгдэхүүн хийх, засварлах, бусад ажилтанд хяналт тавих зэрэг үүргийг хамааруулна.

Энэ дэд бүлгийн ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

- 751 Хоол, хүнс үйлдвэрлэгч, түүнд холбогдох ажил, мэргэжлийн ажилтан**
- 752 Мод боловсруулагч, нарийн мужаан түүнд холбогдох ажил, мэргэжлийн ажилтан**
- 753 Хувцас оёх болон түүнд холбогдох ажил, мэргэжлийн ажилтан**
- 754 Бусад үйлдвэрлэл, үйлчилгээ, урлалын зүйл хийгч, түүнд холбогдох ажилтан**

**БАГА БҮЛЭГ 751****ХООЛ, ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ, ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛ,  
МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

---

Хоол, хүнс үйлдвэрлэгч бусад адилтгах зүйл хийгч нь мал, амьтан нядлах, холбогдох хүнсний зүйлийг хүн ба амьтаны хоол, тэжээлд зориулан бэлтгэх, боловсруулах, төрөл бүрийн талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн хийх, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон холбогдох хүнсний зүйл боловсруулах, хадгалах, нөөцлөх, төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг амтлах, зэрэглэл тогтоох болон тамхи үйлдвэрлэх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Мал, амьтан нядлах, мах, загас болон бусад хүнсний зүйлийг бэлтгэх, боловсруулах, төрөл бүрийн талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн хийх, хүнсний ногоо, жимс, жимсгэнээр холбогдох хүнсний зүйлийг боловсруулах, хадгалах, нөөцлөх, төрөл бүрийн хүнсний бүтээгдэхүүнийг амтлах, зэрэглэл тогтоох, тамхи үйлдвэрлэх, бусад ажилчдад хяналт тавих.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7511 Мах, загасны худалдаачин, холбогдох бусад хоол, хүнс бэлтгэгч**

**7512 Гурилан бүтээгдэхүүн, бал бурам, бусад амттан үйлдвэрлэгч**

**7513 Сүү, цагаан идээ боловсруулагч**

**7514 Жимс, жимсгэнэ, ногоо, хүнсний бусад зүйл даршлагч**

**7515 Хүнс, ундаа амтлагч, зэрэглэл тогтоогч**

**7516 Тамхи үйлдвэрлэгч**

**7511 МАХ, ЗАГАСНЫ ХУДАЛДААЧИН, ХОЛБОГДОХ БУСАД ХООЛ,  
ХҮНС БЭЛТГЭГЧ**

Мах, загасны худалдаачин, холбогдох бусад хоол, хүнс бэлтгэгч нь мал, амьтан нядлах, цэвэрлэх, мах, загасыг эвдэх, шулах, (яс, өөх, дотор эрхтэнээс салгах) холбогдох хүнсний зүйл бэлтгэх, мах, загас бусад хоол, хүнсний зүйлийг хатаах, давслах, утах аргаар нөөцлөх, даршлах ажил эрхэлнэ.

Малчдаас мал худалдан авч, гарал үүслийн баримт бичгийг бүрдүүлж, суурь зохион байгуулан тууварлах буюу эсвэл автомашин, төмөр замаар тээвэрлэх ажлыг зохион байгуулна.

Нуурын болон уурхайн давсны ордоос хүнсний, техникийн ба тэжээлийн зориулалтаар давс, хужир, шүүг ялгаж олборлох ажлыг гүйцэтгэнэ.

### Гүйцэтгэх үүрэг:

- а) хүнсний хэрэгцээнд зориулан малчдаас мал худалдан авч, гарал үүслийн баримт бичгийг бүрдүүлж, суурь зохион байгуулан тууварлах буюу эсвэл автомашин, төмөр замаар тээвэрлэх,
- б) малд эрүүл мэнд, тарга хүчний үзлэг, хяналтыг явуулж, хүлээн авах, малын амьдын жин, тоо толгойг тогтоож, хүлээн авсан падаан баримтыг бүрдүүлэх,
- в) мал, амьтан нядлах, малыг муужруулах, нядалгааны дүүжин замд өлгөх, цусалгаа хийж нядлах,
- г) толгой, шийрийг салгах, дотор эрхтэн, гэдэс дотрыг салгаж авч мал эмнэлгийн үзлэгт оруулах,
- д) махыг загсаасны дараа технологийн дагуу булчин махыг яснаас нь шулж салгах,
- е) махыг булчингийн бүтцээр нь ангилж, (үндэсний болон олон улсын стандартын дагуу) хэрэглэгч, худалдан борлуулагчийн захиалга, хэрэглээнд тохируулж савлах,
- ж) хиам, бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс хамааруулан ясгүй махыг жижиглэн татах, давслах, хиамын орц жорын дагуу таташ бэлтгэж холих, бүрхүүлд савлаж, шарж чанах, утах, хөргөх, хатаах, савлаж хаяглах, худалдаанд тээвэрлэж хүргэх зэрэг ажиллагаануудыг зохих технологийн заавар, эрүүл ахуйн дүрмийн дагуу гүйцэтгэх,
- з) Бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн лабораторит дээж авч шинжлэх,
- и) өвчих, арьсыг хуулах, махыг шулах, цэвэрлэх,
- к) худалдах, дахин боловсруулах зорилгоор бэлтгэх,
- л) орц, амтлагчийг бэлтгэн хэмжих, холих, хэвэнд оруулах машин, тоног төхөөрөмж ашиглан хиам, зайдас ба ижил төрлийн бүтээгдэхүүн хийх,
- м) мах, загас болон бусад хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, нөөцлөх, дахин боловсруулалт хийх (хатаах, давслах зэрэг),
- н) мах, загас болон бусад хүнсний зүйлийг утах зуухыг ажиллуулах,
- о) мах, загас болон бусад холбогдох хүнсний зүйлийг худалдахад зориулан чанах бусад аргаар бэлтгэх, боловсруулах,
- е) мах болон загасыг хэрэглэгчдэд худалдах зориулалтаар боох, баглах, савлах, жигнэх, ангилах, шошго тавих, худалдаалах, төлбөрийг авах,

- п) давсыг ханасан уусмалаар угааж цэвэрлэн бутлах, хатаагчийн параметруудийг тохируулах, бэлэн болсон давсыг жижиглэн савлаж, наах, бөөнөөр баглах,
- р) нуурын болон уурхайн давсны ордоос хүнсний, техникийн тэжээлийн зориулалтаар давс, хужир, шүүг ялгаж олборлох,
- с) бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн лабораторит дээж авч шинжлэх, чанарын баталгаа гаргах ажил энэ хэсэгт хамаарна.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мах, загас бэлтгэгч, махны худалдаачин
- Загас цэвэрлэгч, эвдэгч,
- Загасны худалдаачин
- Нядлагч
- Мах бэлтгэгч
- Мал худалдан авч бэлтгэх, үйлдвэрт нийлүүлэх (брокер, дилер)
- Мал худалдан авах, тууварлах, тээвэрлэх ажилтан
- Мал пүүлэгч
- Давс олборлогч
- Хүнсний давс угааж, бутлагч, савлагч
- Давс хатааж иоджуулагч/давс хатаагч
- Хүнсний үйлдвэрлэлийн бусад ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5221	Дэлгүүр ажиллуулагч
8160	Мах боловсруулах машины операторч
8160	Загас боловсруулах машины операторч

### **7512 ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН, БАЛ БУРАМ, БУСАД АМТТАН ҮЙЛДВЭРЛЭГЧ**

Гурилан бүтээгдэхүүн, бал бурам бусад амттан үйлдвэрлэгч нь төрөл бүрийн талх, нарийн боов болон бусад гурилан бүтээгдэхүүн хийх болон гар аргаар чихэр, шоколад хийх зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) талх, бялуу, жигнэмэг болон бусад төрлийн гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,
- б) машин ба гар багаж ашиглан чихэр, шоколад, элсэн чихрийн холимог болон бусад зүйлээр чихрийн төрлийн бүтээгдэхүүн хийх,
- в) холих, хутгах эсвэл жигнэх, шарах машин, саванд хэмжиж тааруулсан орцыг найруулан хийх, холих,
- г) стандарт болон бусад шинж чанар, үзүүлэлт, шаардлагыг хангаж

- байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор түүхий эдийн чанарыг шалгах,
- д) бялууны чимэг, өнгөлгөө болон бусад жигнэсэн бүтээгдэхүүнд чимэглэлийг нарийн боовны багаж хэрэгсэл ашиглан хийх,
- е) ажлын байран дах аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм журам, шаардлагыг хангах зорилгоор үйлдвэрлэл эхлэхээс өмнө үйлдвэрийн газар, тоног төхөөрөмжийн ариун цэвэрийг шалгах, хангах,
- ж) жигнэх, шарах хугацааг тодорхойлох зорилгоор бүтээгдэхүүний гадаад байдлыг хянах, шарах шүүгээний халууны хэмийг хянах, тохируулах,
- з) талх, ороомог бусад гурилан бүтээгдэхүүн болон чихэр, амттаныг хэв оруулах, жигнэх, шарах шүүгээнд хийх, гаргах, хөргөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
- чихэр, амттан хийгч
- шоколад хийгч
- гурилан бүтээгдэхүүн жигнэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5120	Тогооч
8160	Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн жигнэх, шарах машины операторч
8160	Талх барих, үйлдвэрлэх машины операторч
8160	Шоколад үйлдвэрлэх машины операторч

**7513 СҮҮ, ЦАГААН ИДЭЭ БОЛОВСРУУЛАГЧ**

Сүү, цагаан идээ боловсруулагч нь цөцгийн тос, төрөл бүрийн бяслаг, цөцгий болон бусад төрлийн сүү, цагаан идээг боловсруулах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цөцгийн тос гаргаж авах зорилгоор сүү буцалгах, ферментжүүлэх,
- б) сүүнээс цөцгийг ялгаж, түүнээс тос гаргаж авах,
- в) тодорхой хэмжээний эздүүлэгч болон бусад найрлагыг орцын дагуу сүүнд холих,
- г) сүү эздүүлж, ээдмийг стандарт хэмжээнд хүргэн өтгөрүүлж хэвэнд хийж бяслаг болгон шахах,
- д) бяслаг давслах, нүхлэх, тавиур дээр хатаах, эргүүлэх,
- е) хяналтын дээж авах, шаардлагатай үед бүтээгдэхүүний орчинг тохируулах зэргээр бүтээгдэхүүний чанарыг савлаж баглахаас өмнө шалгах, хянах,

## **7** ҮНДЭСНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ (ХАВСРАЛТ-1)

- ж) орц, найрлагын хэмжээ, чанар болон үйлдвэрлэсэн хугацааны тухай тэмдэглэл хөтлөх,
- з) хүлээн авч буй сүүнд анхан шатны шинэжилгээг хийлгүүлж, дүгнэлт гарсны дараа сүүг хэмжиж хүлээн авна.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цөцгийн тос боловсруулагч
- Бяслаг шахагч
- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч болон бусад ажилтан
- Сүү хүлээн авагч

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8160 Цагаан идээ боловсруулах машины операторч
- 8160 Сүү боловсруулах машины операторч

## **7514 ЖИМС, ЖИМСГЭНЭ, НОГОО, ХҮНСНИЙ БУСАД ЗҮЙЛ ДАРШЛАГЧ**

Жимс, жимсгэнэ, ногоо, хүнсний бусад зүйл даршлагч нь жимс, жимсгэнэ, самар зэрэг бусад хүнсний зүйлийг чанах, хатаах, давслах, шүүс, тос гаргаж авах ажлыг төрөл бүрийн аргаар боловсруулах, хадгалах, нөөцлөх ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) төрөл бүрийн жимс, жимсгэнээс шүүс гаргаж авах,
- б) тос агуулагч үр, самар, болон жимснээс тос гаргаж авах,
- в) жимс, жимсгэнэ, хүнсний ногоо болон бусад хүнсний зүйлийг чанах, давслах, хатаах, даршлах,
- г) гадаад үзэмж, амт шимийг сайжруулах, удаан хугацаагаар хадгалах зорилгоор амтлагч, хольц хийх, холих,
- д) хадгалах хүнсний зүйлийг ариутгасан сав, лааз, шил болон бусад саванд хийх.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Жимстэй халуун сүмс хийгч
- Жимс хадгалагч
- Жимсний чанамал хийгч
- Тос гаргагч
- Жимс, ногоо давслагч, даршлагч
- Жимс жимсгэнэ, хүнсний ногоо, самар боловсруулах үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8160 Лаазлах машины операторч

**7515 ХҮНС, УНДАА АМТЛАГЧ, ЗЭРЭГЛЭЛ ТОГТООГЧ**

Хүнс, ундаа амтлагч, зэрэглэл тогтоогч нь хөдөө аж ахуйн төрөл бүрийн бүтээгдэхүүн, хүнсний зүйл, бүх төрлийн ундааг хянан, шалгах, амтлах, зэрэглэл тогтоох ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөө аж ахуйн төрөл бүрийн бүтээгдэхүүн, хүнсний зүйл болон бүх төрлийн ундааг боловсруулалтын шатанд амтлах, үнэрлэх шалгах, турших,
- б) чанар болон хэрэглэгчийн хэрэгцээнд нийцэх эсэхийг тодорхойлж, бүтээгдэхүүний үнэлгээ өгөх, зохих ангилал, зэрэглэл тогтоох,
- в) чанар стандарт хангаагүй бүтээгдэхүүнийг устгах,
- г) зэрэглэл тодорхойлох, шошго наах, бүтээгдэхүүн хүлээн авах, худалдах баримтанд тэмдэглэл хийх,
- д) бүтээгдэхүүнийг хэмжих, жигнэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хүнсний зүйлийн зэрэглэл тогтоогч
- хүнсний зүйл амтлагч

**7516 ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧ**

Тамхи үйлдвэрлэгч нь тамхины навчийг бэлтгэн төрөл бүрийн тамхи үйлдвэрлэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тамхины навчийг ургасан газар, чанар, төрлөөр нь ангилан зэрэг тогтоох,
- б) тодорхой төрлийн тамхи болон ялгагдах чанар бий болгохын тулд зохих жорын дагуу тамхины навч холих,
- в) тамхийг дахин боловсруулах зорилгоор тусгай битүү саванд хийж чийглэх,
- г) навчийг иш, гол зэргээс цэвэрлэж нунтаглах,
- д) гараар болон энгийн ажиллагаатай машинаар навчин тамхи, янжуур, хамрын тамхи болон бусад төрлийн тамхи хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Навчин тамхи хийгч, ороогч

- Янжуур тамхи хийгч
- Тамхины зэрэглэл тогтоогч

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8160 Навчин тамхи хийгч машины операторч
- 8160 Янжуур тамхины машины операторч

### **БАГА БҮЛЭГ 752**

### **МОД БОЛОВСРУУЛАГЧ, НАРИЙН МУЖААН, ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

---

Мод боловсруулагч, нарийн мужаан бусад адилтгах ажилтан нь модоор шахмал хавтан, үртсэн хавтан, хатуу модон хавтан, тусгаарлагч хавтан, фанер, наамал банз болон бусад ижил төстэй модон бүтээгдэхүүн хийх, модон тавилга, тээврийн хөсгийн хэрэгсэл бусад модон бүтээгдэхүүн хийх, чимэглэх, засварлах, тусгай гар багаж, мод боловсруулах машин, механизм, багаж хэрэгслийг ажиллуулах, засвар, үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэгт:**

Мод боловсруулах, бэлтгэсэн модыг байгалийн болон бусад аргаар хатаах, мод боловсруулах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар, үйлчилгээ хийх, химийн болон тусгай бодис мод, модон бүтээгдэхүүнд шингээж гадны нөлөөллөөс модыг хамгаалах, мод тайрах, хэв загвар оруулах, эд анги хийх машин ажиллуулах, модоор хийх эдлэл, зүйлийн загвар, технологийн зургийг судлах, хэмжээг баталгаажуулах, иж бүрэн зүйл хийхийн тулд эд анги, хэсгүүдийг хооронд нь тааруулж, суулгах, чанарыг шалгах, заасан хэмжээ, техникийн үзүүлэлт, заалтанд тохируулах, төрөл бүрийн машин, механизмыг суурилуулах, тохируулах, тавилгын модон хэсгүүд, тогтоогч, бэхлэгч болон бусад модон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, засварлах, дахин боловсруулах, хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа бүхий мод боловсруулах машиныг суурилуулах, ажиллуулах, хяналт тавих, загвар, хэмжээ, техникийн үзүүлэлтүүд болон холбогдох зааврыг судалж технологи, зарчим, аргачлалыг холбогдох ажилтанд тайлбарлах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7521 Мод боловсруулагч**

**7522 Нарийн мужаан, холбогдох бусад ажилтан**

**7523 Мод боловсруулах машин суурилуулагч, операторч**



**7521 МОД БОЛОВСРУУЛАГЧ**

Мод боловсруулагч нь модны холтсыг салгах, банз бэлтгэх, байгалийн аргаар болон хатаах зууханд мод хатаах, хадгалах, хамгаалах, мод боловсруулах тоног төхөөрөмж, машиныг ажиллуулах, засвар, үйлчилгээ хийх болон шахмал хавтан, үртсэн хавтан, хатуу модон хавтан, тусгаарлагч хавтан, фанер, наамал банз болон бусад ижил төстэй модон бүтээгдэхүүн хийх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хатаах зуух, мод боловсруулах машин болон бусад мод, банз, модон бүтээгдэхүүнийг хатаах, бэлтгэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, үйлчилгээ хийх, химийн аргаар болон тусгай бодис мод, модон бүтээгдэхүүнд шингээж гадны нөлөөллөөс хамгаалах,
- б) боловсруулах үйл ажиллагаа техник үзүүлэлт, технологийн шаардлагын дагуу явагдаж байгаа эсэхийг хянах, стандарт зөрчиж байгаа эсэхийг олж тогтоох, илрүүлэх зорилгоор тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон хянах самбарын гэрэл, дохиог хянах,
- в) шаардлагын дагуу боловсруулах машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, туслах,
- г) тоног төхөөрөмжийг цэвэрлэх, тослох, тохируулах,
- д) гараар болон түрдэг тэрэг, гар тэрэг, өргөгч ашиглан бүтээгдэхүүн болон материалыг ажлын байрнаас болон ажлын байранд тээвэрлэх,
- е) үйлдвэрлэл, үйл ажиллаганы тайлан, мэдээ бичих, холбогдох бүртгэл хөтлөх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Мод боловсруулагч
- Мод боловсруулах тоног төхөөрөмжийн засварчин, тохиргоочин
- Модон эдлэлийн эд ангийн хэвчин
- Мод боловсруулах тоног төхөөрөмжин багаж ирлэгч
- Мод хатаагч
- Мод хатаалгын зуухны галч
- Чаананд мод чанагч
- Модон эдлэлийн эд ангийн гар засалчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8172 Мод боловсруулах төхөөргийн операторч

**7522 НАРИЙН МУЖААН, ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Нарийн мужаан, холбогдох бусад ажилтан нь мод боловсруулах машин, тоног төхөөрөмж болон тусгай багаж хэрэгсэл ашиглан модон эдлэл, тавилга, гар тэрэг бусад тээврийн хөсөг, хэрэгсэл, дугуй, эд анги, хэв загвар, модон хээ болон бусад модон бүтээгдэхүүн хийх, чимэглэх, засах зэрэг ажил эрхэлнэ.

Барилгын төрөл бүрийн модон болон түүнтэй адилтгах материалаар барилгын гоёл чимэглэл, өнгөлгөөний ажлыг хийх нарийн мэргэшилтэй байна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахилгаан хөрөө, холбогч угсрагч машин, цоолох, ухах машин, хэв, сийлбэрийн машин зэрэг мод боловсруулах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, гар багаж хэрэгслэлээр тайрах, хэв оруулах, эд анги хийх,
- б) ханын мебель угсрах, хана, таазны гоёл чимэглэл угсрах, гэр ахуйн модон тавилга ба эдлэлийг модоор хийх, угсрах,
- в) ханын мебель угсрах, хана, таазны гоёл чимэглэл угсрах, гэр ахуйн модон тавилга ба эдлэлийг модоор хийх, угсрах,
- г) төрөл бүрийн хуулимал материалаар шал хийх, архитектур дизайны чимэглэлийн жижиг эдлэл хэсгийг хийх, угсрах, хуванцар болон модон материалаар вакуум хаалга цонх хийх угсрах, модон болон төрөл бүрийн зүймэл шал шахах, өнгөлөх,
- д) эд, зүйлийн төсөл, загвар, зургийг судлах, хэмжээг баталгаажуулах, техник, технологийн үзүүлэлтийг бэлтгэх чанарыг шалгах, стандарт хэмжээ, техникийн үзүүлэлтэд нийцүүлэх,
- е) уулзвар, нийлж буй газруудыг эмжих, бүрэн бүтэн нэгж зүйл хийхийн тулд цавуу, хавчаар зэргийг ашиглан эд анги, хэсгүүдийг хооронд нь тааруулж, суулгах, нийлүүлэх, хадаас, шаантаг болон бусад бэхлэгчийг ашиглан уулзвар, нийлж буй газруудыг бат бөх болгох,
- ж) ажлын ширээ, тавилга, тэрэг хөсөг, жинлүүрийн загвар, спортын тоног төхөөрөмж, хэрэгсэл, бусад эд анги, бүтээгдэхүүн зэрэг төрөл бүрийн модон эд зүйлийг хийх, дахин хэв загвар оруулах, засварлах,
- з) мод суулгах, шигтгэх, фанер наах, модон хээ, загвар, сийлэх зэргээр тавилга хэрэгслийг чимэглэх, уран сайхны модон эдлэлд хээ угалз тавих зургийг талбайдаа тохируулан зурах, загвар бэлтгэх, ухаж товойлгон сийлэх,
- и) модон тавилга, эд зүйлийн гадаргууг өнгөлөх, хавтгай гадаргуу дээр байгалийн байдал, уул, ус, тэнгис далайн давалгаа, түүний долгио үелзлэл, огторгуйн гүнд байх үүлэн сүлжээ, гэрэл туяаны цацраг, ан амьтны дүрс зэрэг нарийн төвөгтэй эрээн зургийг тааруулж зурах,

- к) угалз хээ хошоо хүрээлж зурах, уран зургийн шинэ загвар гаргаж зурах, захиалгатай зүйл, үзэсгэлэн чимэглэлд зориулж тусгай дагнаас гаргаж, хээ угалз зурах, хээ зургийн өнгөнд тохируулж будаг найруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- тавилга хийгч
- сүйх тэрэг хийгч
- дугуй хийгч
- модон хээ, угалз хийгч
- Сийлбэрчин
- Сийлбэрийн зүмбэрчин
- Будган зүмбэрчин
- Лак, будаг найруулагч
- Будагчин, өнгөлгөөчин
- Модонд идээлэгч бодис нэвчүүлэгч
- Зүлгүүрийн хавтгай эсгэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7115	мужаан, угсрагч
7549	өөр газар ороогүй ажил, мэргэжил
8219	модон болон бусад бүтээгдэхүүн угсрагч
7316	модоор гар гар урлалын зүйл сийлбэрчин, зураг, хээ гаргагч

**7523 МОД БОЛОВСРУУЛАХ МАШИН СУУРИЛУУЛАГЧ, ОПЕРАТОРЧ**

Мод боловсруулах машин суурилуулагч, операторч нь тавилга, модон эдлэл, эд хэсэг, бусад модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, засварлах, бэхлэх, хөрөөдөх, хэвэнд оруулах, өрөмдөх, зорох, харуулдах зэрэг зориулалтын бүрэн болон хагас автомат мод боловсруулах машин, тоног төхөөрөмж, багжийг суурилуулах, ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тавилга, модон эдлэл, эд хэсэг болон бусад модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, засварлахад ашиглах төрөл бүрийн бэхлэх, хөрөөдөх, хэв оруулах, өрөмдөх, зорох, харуулдах, зүлгүүрдэх мод боловсруулах машин, тоног төхөөрөмж, багажийг суурилуулах, үйл ажиллагааг програмчлах, тохируулах, ажиллуулах, хянах,
- б) хувцасны өлгүүр, шалны модны иш, хавчаар зэрэг төрөл бүрийн модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, урьдчилан эвлүүлэх тусгай зориулалтын мод боловсруулах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) бүтээгдэхүүний техник үзүүлэлт, стандарт шаардлага, машин тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, чадамж, ашиглах материал зэрэгт

тохируулан, хутга, хөрөө, зүсэгч, бул, хасуур, өрөм, зүлгүүр зэргийг сонгох,

- г) хутга, зүсэгч, хасуур, өрөм, зүлгүүр зэргийг энгийн гар багжаар болон бусад багаж ашиглан холбогдох машин, төхөөрөмжид суурилуулах, тохируулах,
- д) бусад ажилтан ажиллах төрөл бүрийн мод боловсруулах машин, тоног төхөөрөмж суурилуулах, тохируулах,
- е) техникийн үзүүлэлт, стандарт болон бусад дагалдах зааврыг уншиж, судлах, тайлбарлах,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Сийлбэрийн машины операторч (мод)
- Тавилга үйлдвэрлэх машины операторч
- Модны нарийн хөрөөчин
- Модон бүтээгдэхүүний машины операторч
- Мод зорогч
- Мод боловсруулах, зорох машины операторч (токарь)
- Мод боловсруулах машин суурилуулагч
- Мод боловсруулах машин суурилуулагч, операторч
- Мод боловсруулах машин тохируулагч, операторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8219 Модон болон бусад бүтээгдэхүүн угсрагч

### **БАГА БҮЛЭГ 753**

#### **ХУВЦАС ОЁХ БОЛОН ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АЖИЛТАН**

Хувцас болон холбогдох ажил, мэргэжлийн ажилтан нь эсгэж оёсон хувцсыг засах, янзлах, таруулах, даавуу болон үслэг арьс, нэхийгээр хувцас, үслэг эдлэл оёх, дизайн гаргах, үслэг эдлэг, арьс ширэн бүтээгдэхүүн хийх, хувцас, бээлий болон бусад даавуун эдлэлийг засах, янзлах, чимэглэх, шинэчлэх, хувцасны хээ, зураг гаргах, хийх, тавилга, бэхэлгээ, ортопед тоноглол, машины бүрээс, доторлогоо оёх, засварлах, солих, амьтны арьс шир, нэхий өөлөх, идээлэх, борлуулах, зүлгэх, элдэх, будах, гутал болон арьсан эдлэлийг шинэчлэх, засварлах зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Эсгэж оёсон хувцсыг засах, тааруулах, сүлжмэл, даавуу, арьс шир, савхи, үслэг арьсаар болон бусад материалаар тусгай хэмжээ, захиалгаар хувцас, үслэг эдлэл хийх, дизайн гаргах болон бусад бүтээгдэхүүн,

малгай, хиймэл үс хийх, хувцас болон бусад эдлэлийн загварыг өөрчлөх, даавуу, сүлжмэл, арьс шир, савхин болон үслэг эдлэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нарийн хээ, загварыг гаргах, даавуу болон бусад материалаар хувцас, бээлий бусад бүтээгдэхүүн хийх, залгаж оёх, холбох, засварлах, нөхөөс тавих, шинэчлэх, чимэглэх, далбаа, бүхээг, саравч хийх, залгаж оёх, тавилга, чимэглэл, бүрээс, бэхэлгээ, ортопед гутал, тоноглол хийх, суулгах, засварлах, солих, суудал болон машин, гал тэрэг, нисэх онгоц, усан онгоцны бүрээс, доторлогоо бусад зүйл хийх, засварлах, солих, арьс, савхи, үслэг арьсаар эцсийн бүтээгдэхүүн хийх зорилгоор амьтны арьс шир, нэхий боловсруулах, цэвэрлэх, өөлөх, идээлэх, зүлгэх, элдэх, будах, стандарт болон тусгай захиалгын ортопед гутал, тоноглол болон хиймэл арьсан эдлэл хийх, шинэчлэх, засварлах зэрэг ажил эрхэлнэ.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7531 Оёдолчин, загварчин, эсгүүрчин, үслэг эдлэл хийгч**

**7532 Хувцасны болон бусад төрлийн үлгэр гаргагч/эсгүүрчин**

**7533 Оёдолчин, хатгамалчин бусад ажилтан**

**7534 Тавилганы бүрээс хийгч болон бусад ажилтан**

**7535 Ангийн үс, арьс шир элдэж боловсруулагч,**

**7536 Гуталчин, бусад ажилтан**

### **7531 ЗАГВАРЧИН, ЭСГҮҮРЧИН, ҮСЛЭГ ЭДЛЭЛ ХИЙГЧ**

Загварчин, эсгүүрчин, үслэг эдлэл хийгч нь захиалгаар хувцас эсгэж оёх, засах болон үйлдвэрлэх, даавуу, савхи, үслэг болон бусад материалаар костюм, цув, даашинз зэрэг бүтээгдэхүүнийг хэмжээ, захиалгаар оёх, хэрэглэгч болон захиалагч, үйлдвэрлэгчийн хэмжээ, стандарт, үзүүлэлт, шаардлагын дагуу үслэг эдлэл, малгай, хиймэл үс хийх зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) ихэвчлэн үйлчлүүлэгчийн хувийн тусгай шаардлага, хэрэгцээний дагуу гоёлын болон ердийн, ажлын хослол, костюм, эрэгтэй, эмэгтэй өмд, цамц, дотуур хувцас оёх, цув, малгай, хиймэл үс болон бусад ижил төстэй бусад хувцас хийх,
- б) даавуу, арьс, савхи, үслэг материалыг тухайн бүтээгдэхүүнд нийцүүлэн, шаардлагатай хэмжээ, өнгө, нимгэн, зузаан хэлбэрээр,

- бүтэц, чанарын дагуу сонгох, хээ, ширхэг болон загвар, дизайны дагуу зүсэх, эсгэх, нийлүүлж оёх,
- в) өмдний хөл, хувцасны зах хасах, нарийсгах, доторлогоо хийх, хасах, тайрах зэргээр хувцас, бусад элдэлийн загварыг өөрчлөх,
- г) хэрэглэгч болон хувцас үйлдвэрлэгчийн үзүүлэлт, хэмжээний дагуу хээ, загварыг сонгох, хийх,
- д) оёсон хувцас, даашинз, цув болон бусад тусгай захиалгаар хийсэн хувцсыг хэрэглэгч, үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу тохируулах, засах, өөрчлөх,
- е) театр, телевиз болон кино зураглал үйлдвэрлэлийн тусгай хувцас, костюм хийх, оёх,
- ж) сатин, торго болон нэхмэлийн тууз, бусад материалыг нугалах, эргүүлэх зэргээр хиймэл цэцэг хийх, эмжих зэргээр малгайны орой, саравчийг чимэглэх,
- з) хиймэл үс хийх зориулалтаар үсний ширхэг болон бусад материалыг оёх, шидэх, холбох,
- и) хиймэл үсэнд байгалийн өнгө үзэмж оруулж будах, сүлжмэл, хиймэл үсийг тусгай хэлбэр, байрлалд оруулах хиймэл үс хийх зориулалтаар үсийг хооронд нь холбох,
- к) үслэг эдлэл, хувцас бусад үслэг зүйлийг хийх, засах, хийц загварыг өөрчлөх,
- л) хуучин үслэг эдлэлийн үсийг сэргээх, засварлах, дотор талд нь даавуу наах болон үслэг эдлэлийг тэгшлэх, тайрах, өөлөх, засварлах, захлах,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үслэг эдлэл хийгч
- Малгай хийгч
- Загварчин, эсгүүрчин

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 7318 | Даавуу, арьс бусад материалаар гар урлалын зүйл хийгч |
| 8153 | Оёдлын машины операторч                               |

### **7532 ХУВЦАСНЫ БОЛОН БУСАД ТӨРЛИЙН ҮЛГЭР ГАРГАГЧ, ХУВИЛАГЧ/ЭСГҮҮРЧИН**

Хувцасны болон бусад төрлийн үлгэр гаргагч, хувилагч/эсгүүрчин нь хувцас бусад даавуу, арьс, савхи, үслэг эдлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар үндсэн, нарийн хээ, үлгэр зохион бүтээх. Хувцас, малгай, бээлий болон бусад төрөл бүрийн өмсгөл болон бусад бүтээгдэхүүний стандарт үзүүлэлт, хэмжээ, үлгэрийн дагуу хийх, даавуу, арьс, савхи

болон бусад материалд үлгэр гаргаж эсгэх, огтолох, хэлбэрт оруулах, тайрах, өөлөх зэрэг ажил эрхэлнэ. Үлгэр гаргагчийн гаргаж, эсгүүр хийхэд бэлэн болгосон үлгэр, эсгүүрийн хэвийг хувилна.

Бусад материалаар төрөл бүрийн хувцас, хамгаалах хэрэгсэл, техникийн болон гэр ахуйн өргөн хэрэглээний эд зүйлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үлгэр гаргаж түүний дагуу нэг бүрчлэн буюу олноор эсгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тодорхой бүдүүвч, хүснэгтлэсэн тооцоо, тухайн бүтээгдэхүүний үлгэр гаргах багаж, хэрэгсэл, компьютер болон зэрэглэл тогтоох хэрэгсэл ашиглан бүтээгдэхүүний өгөгдсөн хэмжээ бүрт нь тохируулан үндсэн хээ, хар зураг гаргах, үлгэр хувилгах,
- б) компьютер ашиглан тодорхой хувцасны зүйл, өмсгөлийн үлгэр гаргах,
- в) материалын суналтыг тооцон бүтээгдэхүүн, үлгэрийн хэмжээнд нийцүүлэн хэмжээс тооцон гаргах,
- г) үлгэр дээр хэсгүүдийг хэрхэн, хаана залгаж оёх болон халаас, нугалаа, хуниас, товч, товчны нүх зэргийн байрлалыг зурах, тэмдэглэх, гутлын хэсгүүд болон даавуу дээр нүхлэх, чимэглэлийн оёдол, шидэлт, хэрэх оёдол гаргах зургийг компьютер болон бусад багаж ашиглан хийх,
- д) бүтээмж нэмэгдүүлэх зорилгоор материал дээр үлгэрийг зөв байрлуулах, хэмжих, тайрах, хайчлах хэмжээсийг нарийвчлан зурах, тэмдэглэх, материалын татлага хийх /шалгах/, татлаган дээр хар зураг байрлуулах, материалын хээ, онцлог материал дээр нэг бүрчлэн хар зураг гаргах, татлаганд хар зурагаа бөхлөх, хавчих, татлагыг хар зургын дагуу эсгүүрийн машинаар огтлох,
- е) үндсэн үлгэрийг даавуу, материал дээр байрлуулж туршилтын үлгэрийг гаргах,
- ж) үлгэрийг турших туршилтын бүтээгдэхүүн хийж шалгах,
- з) давхарласан материал, даавуун дээр үлгэрийг байрлуулж, үлгэрийн дагуу цахилгаан болон гарааражилладаг хутга, зүсэгч эсвэл компьютер болон тоон удирдлагатай тайрах, хайчлах тоног төхөөрөмж ашиглан тайрах, хайчлах ,
- и) хувцасны үслэг хэсгүүд болон үслэг эдлэл хийх зориулалтаар даавуу болон үслэг материалыг зүсэх, хайчлах,
- к) илүүдэл материалыг өөлөх, бэлэн бүтээгдэхүүний илүүдэл, сул утасыг хайчлах өөлөх,
- л) хайчлах, тайрах машинд арьс, шир, савхийг байрлуулах, ингэхдээ тухайн арьс, савхины ширхэг, төрөл, сунах чанарыг тооцон дээд зэргээр ашиглах, бүтээмжийг дээшлүүлэх,
- м) зотон даавуун эдлэл, зөөлөн тавилга хийх зэрэг бусад үйлдвэрлэлийн үлгэр загвар гаргах, тэмдэглэл хийх, тайрах, хайчлах зэрэг ажил гүйцэтгэх,

- н) Материалын хээ, онцлогоос шалтгаалах бүтээгдэхүүнийг нэг бүрчлэн гараар хайчлах эсгэх, өөллөг хийх,
- о) Эсгэсэн хэсгүүдийг номерлох, иж бүрдүүлж боох,
- ө) Эсгүүрийн үйл ажиллагаанд холбогдох бусад үүргийг гүйцэтгэх,
- п) Эсгэх материалын болон эсгэсэн деталь хэсгүүдийн чанар, иж бүрдэлд хяналт тавих.

#### **Ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Номерлогч, иж бүрдүүлэгч, боогч,
- Цаваг хатуулга наагч,
- Шалгагч
- Даавуу, савхин, үслэг арьсаар үлгэр/загвар гаргагч
- Үлгэр хувилагч, савхин эдлэлийн

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8159      Даавуунд үлгэр гаргагч машины операторч

#### **Тайлбар:**

Эдлэл бүрээр биш, харин материалын төрлөөр нь ангилах нь зүйтэй

### **7533 ОЁДОЛЧИН, ХАТГАМАЛЧИН, БУСАД АЖИЛТАН**

Оёдолчин, хатгамалчин бусад холбогдох ажилтан нь хувцас, бээлий, бусад даавуу, үслэг эдлэл, арьс, савхи болон бусад материалаар хийсэн бүтээгдэхүүнийг нийлүүлж оёх, засварлах, шинэчлэх, чимэглэх, майхан, асар, далбаа, бүхээг, саравч хийх зэрэг ажил эрхэлнэ. Зүү, утас ашиглан ихэвчлэн гараар ажиллах бөгөөд зарим ажлыг оёдлын машин ашиглан хийнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хувцас болон бусад зүйлийн гэмтсэн, эвдэрсэн хэсгүүдийг тохирсон утас, зүү ашиглан гараар засварлах,
- б) засах, өөрчлөх хувцас, бүтээгдэхүүний оёдол, утсыг хутга болон зүсэх, таслах багаж ашиглан ханзлах,
- в) өгөдсөн үзүүлэлт, өнгө, шаардлагын дагуу тохирох утас сонгох, эсвэл нөхөж засах хувцас бүтээгдэхүүний өнгөнд тохируулж утсыг өнгөнд оруулах,
- г) утас зүү ашиглан бүтээгдэхүүний гэмтэлтэй хэсгийг нөхөх, засах, нүхлэгдсэн, урагдсан, цоорсон хэсгийг нөхөх,
- д) дэгээ ашиглан зангилааг хувцасны дотор талруу нь татаж оруулах
- е) нөхсөн, сэлбэсэн хэсгийг хувцасны хээ, загвартай нийцүүлэн хайчаар зах, эмжээрийг өөлөх,



- ж) зүү, өнгийн утас ашиглан хэвлэж буулгасан хээ, дардасын хүрээгээр чимэглэлийн хээ, дизайн оруулан оёх,
- з) зүү, өнгийн утас ашиглан хувцсан дээр гараар болон машинаар чимэглэлийн хатгамал хатгах,
- и) арьс, шир, савхи, гутлын материалыг оёдол хийхэд зориулан усаар зөөллөх, дэвтээх,
- к) малгай, бусад төрлийн өмсгөлд чимэглэлийн оёдол оёх, наах,
- л) шүхрийн араг, мөчирт бүрхүүлийг гараар оёх, араг мөчир болон төгсгөл хэсэгт нь бэхлэж оёх, эвхсэн үеэд нь баглах туузыг оёх,
- м) зузаан материал, зотон даавуу зэрэг ижил төстэй материалыг нийлүүлж оёх зэргээр майхан, асар, далбаа, бүхээг, бүрээс, саравч зэргийг хийх,
- н) Нэхмэл, сүлжмэл даавуу, нэхээсгүй нэхмэл, савхи бусад материалаар төрөл бүрийн хувцас, хамгаалах хэрэгсэл, малгай, техникийн болон ахуйн өргөн хэрэглээний эд зүйлс бүтээгдэхүүнийг хийж үйлдвэрлэх, өөрчлөх, засахтай холбоотой оёх, шидэх, товч шилбэ, кноп хадах, товчны нүх хэрэх зэрэг төрөл бүрийн ажил хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хатгамалчин
- Оёдолчин
- Шүхэр хийгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7531 Оёдолчин, хувцас хийгч
- 7318 Даавуу материалаар гар урлалын зүйл хийгч
- 8153 Оёдлын машины операторч

**7534 ТАВИЛГЫН БҮРЭЭС ХИЙГЧ, БУСАД ХОЛБОГДОХ АЖИЛТАН**

Тавилгын бүрээс хийгч бусад ажилтан нь тавилгын бүрээс, бэхэлгээ болон ортопед гутал, тоноглол хийх, засварлах, солих, суудал, эвхэгддэг хулдаасан дээвэр, бүрээс, доторлогоо бусад тоноглолыг машин, галт тэрэгний, нисэх онгоц, усан онгоцонд даавуу, арьс, савхи, хиймэл болон бусад материалаар хийх, бүрэх, засварлах, солих зэрэг ажил эрхэлнэ. Түүнчлэн гудас, хөнжил, дэр зэргийг хийх, засварлах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тавилга болон бусад зүйлийг бүрэх материал, өнгө, үлгэр зэргийг үйлчлүүлэгчтэй тохиролцож, өртөг, үнэлгээний урьдчилсан тооцоо гаргах,
- б) хар зураг, төсөл, үйлчлүүлэгчийн хүсэлт зэргийг харгалзан бүрээсийн үлгэрийг гаргах,

- в) үлгэр, хар зураг болон дизайн үзүүлэлтийн дагуу бүрээсийн материалд эсгүүр хийж, хэмжих, хайчлах, тайрах,
- г) тавилгад доторлогоо, зөөлөвч хийх болон бүрээсээр бүрэх, бэхлэх, байрлуулах,
- д) бүрээсийн материал, хэсгүүдийг гараар нийлүүлж, шаглаж оёх,
- ж) моторт тэрэг, нисэх онгоц, завь, усан онгоц, галт тэрэг зэргийн доторлогоог тааруулж тайрах, эсгэх, оёх, бүрэх,
- з) хиймэл хөл, мөч, эрхтэний арьсан бүрээсийг хийх, засварлах,
- и) төрөл бүрийн багаж ашиглан (таслагч, цүүц, соронзон алх, урт зүү зэрэг) хуучны эдлэл, тавилгыг сэргээн засварлах,
- к) доторлогоо, дотор засвар чимэглэлийн үлгэр гаргагчтай хамтран ажиллаж өрөө тасалгаа чимэглэх, засварлах, тохижуулахад шаардагдах материал зэргийн загвар хийцийг тохиролцох,
- л) гудас, хөнжил, дэр зэрэг зөөлөн эдлэл хийх,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Гудас хийгч
- Тавилга бүрэгч, бүрээс хийгч
- Машин тэрэгний доторлогоо, бүрээс хийгч
- Ортопед гутал, тоноглол бүрэгч
- Зөөлөн тавилгын бүрээсчин

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8153 Оёдлын машины операторч

### **7535 АНГИЙН ҮС, АРЬС, ШИР БОЛОВСРУУЛАГЧ**

Ангийн үс, арьс, шир боловсруулагч нь мал, амьтны арьс шир, нэхийг ариутгах, тайрах, хусах, цэвэрлэх, элдэх, идээлэх, өнгө оруулах, зүлгэх, өнгөлөх зэргээр боловсруулж, хувцас болон бусад бүтээгдэхүүн хийх зориулалтаар савхи, нэхий, үслэг эдлэл хийх зэрэг ажил эрхэлнэ. Арьс ширийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах шатуудад мэргэшлийн “ур чадвар” ихээр шаардана.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) арьс, шир нэхийг өнгө, зүс, хэмжээ, талбайн гарцаар нь арьс ширэн түүхий эдийг стандартын дагуу ангилан ялгаж, жин болон талбайг тодорхойлж, чанар байдлыг шалгаж, зэрэглэл зэрэглэл тогтоох,
- б) технологийн дагуу арьс ширийг цэвэрлээд, стандартын дагуу чанар хамгаалалт болон халдваргүйтгэл, ариутгалыг хийх, арьс, шир, нэхий цэвэрлэх, зөөлрүүлэх зорилгоор мах, өөх, шар мах, хальснаас нь салгах, хусах,

- в) мал, амьтны арьс ширийг төрөл бүрийн бүтээгдэхүүн хийхэд зориулж, зориулалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан угааж дэвтээх, кальцийн исэлтэй усанд дэвтээсэн арьс, шир, нэхийг үс, ноосноос нь салгах,
- г) арьс шир, нэхийг давслаж боловсруулах, чийглэх,
- д) арьс, шир, нэхийн урт үсийг тэгшлэх, хайчлах, тайрах, арлах, үлдсэн үсийг өөлөх,
- е) арьс, шир, нэхийг боловсруулан өнгө, зүсийг сайжруулах, байгалийн өнгө зүсийг нь сэргээх,
- ж) арьс, шир, нэхий боловсруулах зориулалтын уусмал, хандыг бэлтгэх,
- з) идээлэх уусмалаар арьс, шир, нэхийг боловсруулж савхи хийх,
- и) үслэг материал, ноосыг будах, байгалийн өнгө зүсийг сэргээх,
- к) нойтон арьс, шир, савхийг дэлгэх үрчлээ хуниасыг арилгах, арьс, савхины зэрэглэлийг тогтоох,
- л) савхи будах, хээлэх,
- м) боловсруулсан арьсыг татах, сунгах, тэлэх, тэгшлэх,
- н) савхийг тосон болон химийн аргаар боловсруулж хатаах, тос химийн бодисыг багсаар жигд түрхэж байгалийн аргаар хатаах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Арьс, шир, нэхий, үслэг эдлэл боловсруулагч
- Арьс, нэхий, үс, үслэг эдлэлийн зэрэглэл тогтоогч, ангилагч
- Арьс, шир, нэхий идээлэгч, элдэгч
- Арьс ширэн түүхий эд ариутгагч
- Арьс ширэн түүхий эд шалгагч
- Арьс ширэн түүхий эд дэвтээгч, угаагч
- Уусмал түрхэгч
- Захлагч, годлогч
- Өрөөлдөгч, шир
- Шахах машинч, арьс шир
- Будаж, тослогч, арьс шир
- Шүршигч буу, төхөөрөмжөөр будагч
- Баглаа боодол хийгч
- Индүүдэгч машинч, арьс шир
- Арьс шир будаж, тослогч машины операторч
- Хатаагч, вакуум хатаалгаар
- Зүлгэх машины операторч
- Сунгах машины операторч
- Чийглэх машины операторч
- Арлах машины операторч
- Шүршиж будах машины операторч

- Хээ тавих компьютер удирдлагатай машины операторч
- Үйлдвэрийн робот машины операторч

### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8155 үслэг эдлэл, арьс, шир элдэгч машины операторч

### **7536 ГУТАЛЧИН ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Гуталчин холбогдох бусад ажилтан нь тусгай, стандарт, захиалгын ортопед гутал, тоноглол, өмсгөл болон байгалийн болон хиймэл арьсан эдлэл, цүнх, гар цүнх, тэлээ (арьсан хувцас, малгай, бэлий нь гуталчны ажилд үл хамаарна) хийх, шинэчлэх, засварлах ажил эрхлэх, гутал болон бусад холбогдох зүйлийн үйлдвэрлэлд оролцоно. Гутал, цүнх, гар цүнх, тэлээ зэргийг чимэглэх, бэхлэх, сайжруулах, үйлдвэрлэлийг төгс болгох ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тусгай, стандарт, захиалгын гутал, өмсгөлийг хийх, тусгай хэрэгцээ, шаардлагыг хангаж шинэчлэх, засварлах,
- б) ортопед болон эмчилгээний тусгай зориулалтын гутал, өмсгөлийг эмчийн зааврын дагуу хийх, шинэчлэх, засварлах,
- в) тэлээ, цүнх, гар цүнх болон бусад ижил төстэй бүтээгдэхүүнийг хийх, засварлах,
- г) зураг, үлгэр гаргах зорилгоор гажилттай хөл, тавхайн хэв авах,
- д) оруулга, өсгийн дэвсгэр, өндөрлөх, өргөх хэрэгслийг үйлчлүүлэгчийн хөл, тавхайн хэвнээс авч хийх ,
- е) үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ортопед гутал, өмсгөл хийх стандарт, зориулалтын зураг, үлгэр бусад үзүүлэлтийг судлах,
- ж) гутлын эд хэсгүүдийн үлгэр, зааврыг судлаж ажлын үзүүлэлтүүд, ачаалал, дараалал болон ашиглах тоноглол, материалыг тодорхойлох,
- з) арьс, шир, савхины бүтэц, өнгө, бат бөх чанарыг шалгаж тодорхой зориулалтад нийцэх эсэхийг баталгаажуулах,
- и) арьс, шир, савхин эдлэл хийх материал болон доторлогоо хийх хэсгүүдийг зүсэх, тайрах, эсгэх, хэвэнд оруулах,
- к) цүнх, тэлээ, гутал, гар цүнх зэрэг эдлэлийг засварлах, уранхай цоорхойг нөхөх, оёх,

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гуталчин
- гутал хийгч
- ортопед гутал хийгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7531	Оёдолчин, загварчин, үслэг эдлэл хийгч
7531	Малгай хийгч
8156	Гутлын машины операторч

**БАГА БҮЛЭГ 754**

**БУСАД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, УРЛАЛЫН ЗҮЙЛ ХИЙГЧ, ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛТАН**

Бусад үйлдвэрлэл, үйлчилгээ, урлалын зүйл хийгч холбогдох ажилтан нь усан доор амьсгалах төхөөрөмж, тоноглол ашиглан усан доор ажиллана. Түүхий эд, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эд анги болон чанарыг шалгах, хянах, турших, тэсэрч дэлбэрэх бодис байрлуулах, угсрах, тэслэх, тариалан болон барилга байгууламжийн эвдрэл, гэмтэл түүнд хор, хөнөөл учруулдаг амьтан, шавьжийг усгах, зайлуулах зэрэг ажил эрхэлнэ. Энэ бага бүлэгт 7 дугаар үндсэн бүлэгт ороогүй бусад үйлдвэрлэл, барилга, ур чадварын ажил, мэргэжил багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Аюулгүй ажиллагааны стандарт, шаардлага хангах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх үйл ажиллагааг хариуцах, төрөл бүрийн усан доорхи ажиллагаа, ажилбар, тэсрэх бодисыг тэслэх цооног, нүхэнд хийж, байрлуулах, заавар, журмын дагуу химийн бодис холих, найруулах, хортон шавьж, ургамлыг устгах хор цацах тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**7541 Усан доорх төхөөрөмж дээр ажиллагч**

**7542 Тэсэлгээний ажилтан/тэсэлгээчин**

**7543 Бүтээгдэхүүн зэрэглэгч, шалгагч (хоол, хүнс, ундаанаас бусад)**

**7544 Ариутгагч, хортон шавьж, хогийн ургамал устгагч**

**7549 Энэ ангилалд ороогүй холбогдох бусад ажилтан**

**7541 УСАН ДООРХ ТӨХӨӨРӨМЖ ДЭЭР АЖИЛЛАГЧ**

Усан доорх төхөөрөмж дээр ажиллагч нь усан доор амьсгалах төхөөрөмж, тоноглол ашиглан усан доор ажилладаг бөгөөд усан доорх тоног төхөөрөмж, байгууламжийг шалгах, суурилуулах, засварлах, зайлуулах, шалгалт, туршилт хийх, тэсрэх бодис суулгах, усан байгууламж,

усан доорх амьдралын зураг авалт хийх, усанд живсэн хүн, эд зүйлийг олох зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) багажийн тусламжаар шумбах хугацаа, гүнийг хянах, шумбах үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох байгууллагад бүртгүүлэх, аюулгүй байдлын дүрэм, журмыг сахих, урьдчилан сэргийлэх, зааварчилгаа, зөвлөгөө авах, өгөх,
- б) дуулга, баг, хүчил төрөгчийн сав, шумбах хувцас, шумбах хоолой, хэмжих багаж зэрэг тоноглол, төхөөрөмжийг шалгах, засвар үйлчилгээ хийх,
- в) усанд орохдоо усан доор амьсгалах төхөөрөмж, шумбах хувцас зэрэг иж бүрэн тоноглолтой орох,
- г) гүүр, усан зогсоол, далан, эргийн хана, суурийг гол мөрний усан доор тавих, засварлах,
- д) усан доорхи байгууламжийн байж болзошгүй эвдрэл, гэмтлийг шалгах, илрүүлэх, бага хэмжээний засвар хийх,
- е) сүйрсэн усан онгоцны шалтгаан, нөхцөл байдлыг талаар мэдээлэл, акт, тайлан гаргах,
- ж) усан доорхи саад тотгорыг арилгах,
- з) усан доорх тэсэлгээний цооног, нүх ухах,
- и) аврах ажиллагаа болон цогцос гаргах зэрэг үйл ажиллагаатай холбогдолтой төрөл бүрийн ажил гүйцэтгэх,
- к) усан доор ажиллахдаа дохио болон утас, холбоо ашиглан газар дээрх ажилтантай холбоотой тогтоох,
- л) шумбах үйл ажиллагаа болон тухайн орчны нөхцөл, байдлын талаар мэдээлэл авах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- аврах ажиллагааны шумбагч
- усан доорхи ажилтан

**7542 ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН/ТЭСЭЛГЭЭЧИН**

Тэсэлгээчин нь уурхай, карьер, ил олборлолтын болон байгууламж нураах, буулгах газар, талбайд тэслэх бодис байрлуулах, угсрах, тэслэгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ажлын байран дахь аюулгүй байдал, тэсрэх бодистой харьцах, хадгалах, тээвэрлэх дүрэм, журмыг баримтлах, чанд сахих нөхцөлийг хангах,
- б) тэслэх цооногийн гүн, хэмжээг тогтоох талаар мэргэжлийн зөвлөгөө, удирдамж өгөх,

- в) тэслэх цооногийн гүн, дотор талд элдэв биет, чулуу, шороогүй байх, цэвэр байдлыг шалгах,
- г) тэсэлгээнд ашиглах тэсрэх бодисын хэмжээ, төрөл, чанарыг тогтоох, тодорхойлох,
- д) тэслэх цооногт тэсрэх бодис байрлуулах,
- е) тэсрэх бодис, тэсрэх сум зэргийг ашиглан гал авалцуулах хэрэгслийг угсрах, цахилгаан утас, асаах, дэлбэлэгч утас зэргийг гал авалцуулах хэрэгсэлд залгах, угсрах, бусад тэслэгээ хийгчид зааварчилгаа өгөх,
- ж) утас, асаах шижим, дэлбэлэгч утсыг гинжин холбоонд залгах, цахилгаан тойрог, холбоосыг шалгах, доголдол, алдаатай ажиллагааг засах, гинжин холбоосыг тэслэх машинд холбох,
- з) тэсрэх цэнэг бүхий цооног, нүхийг элс, шороо болон бусад материалаар таглах, битүүлэх,
- и) тэсрэх бодис бүрэн тэсрэх, дэлбэрэх нөхцөл шаардлагыг хангах, тэсрэлт үүсэхгүй байх, гацах тохиолдлыг анхаарах, тэслэгээ төгс дууссан эсэх тухай тайлагнах,
- к) тэсэлгээ эхлэхийн өмнө хамгаалалт гаргах, тэслэгээ эхлэх, дуусах мөч, хугацааг зарлах, тэслэгээ бүрэн дууссан тухай болон тухайн газар аюулгүй болсоныг зарлах, мэдээлэх,
- л) тэслэх, дэлбэлэх бодисыг хууль журмын дагуу хэрэглэж ашигласан тухай бүртгэл, тэмдэглэл хөтлөх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- тэсэлгээчин
- тэсрэх бодисын мэргэжилтэн
- тэсрэх бодис зөөгч/тээвэрлэгч
- тэсэлгээний ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8111 Өрөмдөгч (далд ба ил уурхайн)
- 8113 Өрөмдөгч (газрын тос, хийн цооног, худаг)
- 3121 Уурхайн байцаагч, хянагч
- 9311 Далд ба ил уурхайн ажилтан

**7543 БҮТЭЭГДЭХҮҮН ЗЭРЭГЛЭГЧ, ШАЛГАГЧ (ХООЛ ХҮНС, УНДААНААС БУСАД)**

Бүтээгдэхүүн зэрэглэгч, шалгагч (хоол хүнс, ундаанаас бусад) нь дээж, түүхий эд, хоол хүнсний бус зориулалтаар үйлдвэрлэсэн болон худалдах бүтээгдэхүүн, түүний бүрэлдэхүүн хэсэг зэргийг чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг хянах, шалгах, турших, доголдол, эвдрэл, элэгдэл, хуучралт, болон техникийн үзүүлэлтээс гажсан эсэхийг олж илрүүлэх, стандарт, чанарын дагуу зэрэглэл тогтоох, ангилах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бүтээгдэхүүн, эд анги, хэсэг, материалыг чанар, стандартын үзүүлэлт шаардлагад нийцэж буй эсэхийг шалгах, хянах, турших,
- б) даавууны бат бөх чанар, бүтцээр ангилах, зэрэглэл тогтоох ,
- в) стандарт, шаардлага хангахгүй байгаа бүтээгдэхүүн, материалыг устгах, үйлдвэрлэлд хэрэглэхгүй байх,
- г) төсөл, загвар, удирдамж, заавар болон чанар, стандартыг тогтоосон бусад баримт бичиг, материалд судалгаа, шинжилгээ хийх, тайлбар, дүгнэлт гаргах, шалгах, турших үзүүлэлтийг тодорхойлох,
- д) бүтээгдэхүүн шалгагч, удирдлага болон бусад ажилтанд үйлдвэрлэлд гарсан доголдол, дутагдлын талаар мэдэгдэж, түүний учир шалтгааныг тодорхойлох, засч, залруулахад туслалцаа үзүүлэх,
- е) зэрэглэл тогтоосон бүтээгдэхүүний тоо хэмжээ, хяналт, шалгалт, туршилтын тухай мэдээлэл, тэмдэглэл хөтлөх,
- ж) бүтээгдэхүүн, эд зүйлд тогтоосон зэрэглэлийг зөвшөөрсөн, татгалзсан эсэх тухай тэмдэглэл хийх,
- з) жин хэмжүүр бусад нарийн хэмжих багажаар бүтээгдэхүүнийг хэмжих,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Чанар шалгагч
- Бүтээгдэхүүн зэрэглэгч
- Ноос ангилагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3257	Хүрээлэх орчин, хөдөлмөрийн хяналт, эрүүл мэндийн байцаагч, туслагч
7515	Жимсний зэрэглэл тогтоогч
7515	Хүнсний ногооны зэрэглэл тогтоогч
7531	Ангийн үс, ноосны зэрэглэл тогтоогч
7535	Арьс, үс, нэхийний зэрэглэл тогтоогч

**7544 АРИУТГАГЧ, ХОРТОН ШАВЬЖ, ХОГИЙН УРГАМАЛ УСТГАГЧ**

Ариутгагч, хортон шавьж, хогийн ургамал устгагч нь хүнсний эрүүл мэндэд аюултай эрсдлээс урьдчилан сэргийлэх, ургамал болон барилга байгууламж, орчныг сүйтгэх, хор хөнөөл учруулах хортон шавьж, жижиг амьтан, хогийн ургамал бусад сөрөг нөлөө үзүүлдэг организмыг химийн бодис ашиглан устгах, зайлуулах, орчныг ариутгах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хортон, шавьж, хогийн ургамал устгах хор, бодис цацах тоног төхөөрөмжийг ажиллуулах,



- б) заавар, журмыг баримтлан, зохих орцын дагуу химийн бодис холих, найруулах,
- в) хортон шавьж, ургамал устгах хор хэрэглэхдээ стандарт, шаардлагад заасан гүнд, тодорхой газар нутгийг хамруулах, ингэхдээ байгаль цаг уурын нөхцөл байдал, цацах хорын тун хэмжээ, орон зайд дэгдэх, тархах явц, сөрөг нөлөө зэргийн талаархи мэдлэг, ухааныг ашиглах, тооцох,
- г) оготно, шоргоолж, жоом зэрэг хортон шавьж, мэрэгч амьтныг урхи, хорт хий, химийн бодис хэрэглэн устгах,
- д) тодорхой заасан цэгт хорыг шууд цацах зорилгоор хаалт саадыг зайлуулах, ариутгал хийх,
- е) хор цацах тоног төхөөрөмжийн хор, шингэн агуулах савыг зохих найрлага бүхий химийн бодис, усаар дүүргэх, цэнэглэх,
- ж) жигд ажиллагааг хангах үүднээс ариутгалын тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэх, засвар, үйлчилгээ хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ариутгагч
- Хортон шавьж устгагч
- Хортон, хогийн ургамал устгагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3153 Агаараас химийн бодис, хор цацагч (газар тариалан)

**7549 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ АДИЛТГАХ БУСАД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Энэ нэгж бүлэгт “Гар урлал, холбогдох бусад ажил, үйлчилгээний ажилтан” гэсэн 7 дугаар үндсэн бүлэгт ороогүй бусад худалдаа, үйлдвэрлэл, урлалын зүйл хийгч ажил, мэргэжил багтана. Тухайлбал энэ нэгж бүлэгт дуран, харааны шил хийх, хэв оруулах, цутгах, өнгөлөх, зүлгэх зэрэг ажил эрхлэгчид багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) линз, шилний хавтгай хийх зориулалтаар дуран, харааны шилийг халаах, хэв оруулах, шахах,
- б) линз, шилний хавтгайг өнгөлөх, зүлгэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Дуран, харааны линз шилний үйлдвэрлэлийн бэлэн бүтээгдэхүүн гаргагч
- Дуран харааны линз шил өнгөлөгч

## ҮНДСЭН БҮЛЭГ 8

# МАШИН МЕХАНИЗМ, ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ, УГСРАГЧ

---

Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч нь үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биечлэн жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах, галт тэрэг, хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, эд анги, хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт, шаардлагын дагуу угсрах ажил эрхэлнэ.

Тэдгээрийн ажил үүрэг нь үйлдвэр, хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийн ажиллагааны горим, зарчим, онолын талаарх мэдлэг, ажлын туршлага, машинтай ажиллах ур чадвар, нөгөө талаар техник технологийн шинэчлэлтэй зохицох, суралцах, өндөр ур чадвар эзэмших бөгөөд Олон улсын ажил мэргэжлийн стандарт (ISCO)-ын 2 дугаар төвшний мэргэшлийн ур чадвар, шаардлага тавигдана.

### Гүйцэтгэх үүрэг:

Төмөр, бусад металл, эрдэс бодис, шил, керамик, шаазан, мод, цаас болон химийн бодис, уурхайн, үйлдвэрийн машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, металл, төмөр, эрдэс, химийн бодис, резин, хуванцар, мод, цаас, даавуу, ангийн болон мал, амьтны үс, ноос, арьс шир, савхиар хийсэн эд зүйл, хоол хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, галт тэрэг болон хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл жолоодох, ажиллуулах, үйлдвэр, хөдөө аж ахуйн хөдөлгөөнт машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, ажиллуулах, хянах, эд анги, бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн бүтээгдэхүүнийг заавар, журам, стандарт шаардлагын дагуу угсрах, бусад ажилтныг хянах үүрэгтэй.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

**81 Төхөөрөг, машин механизмын операторч**

**82 Угсрагч**

**83 Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч**

## **ДЭД БҮЛЭГ 81 ТӨХӨӨРӨГ, МАШИН МЕХАНИЗМЫН ОПЕРАТОРЧ**

---

Суурин төхөөрөг, машин, механизмын операторч нь хөдөлгөөнгүй суурилуулсан эсвэл хөдөлгөөнтэй байх нь тэдгээрийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэгт ордоггүй үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийг биеэр жолоодох эсвэл зайнаас буюу алсын удирдлагаар удирдаж ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөлгөөнгүй суурилуулсан төрөл бүрийн үйлдвэрлэлийн машин, механизмыг суурилуулах, ажиллуулах, хянах,
- б) ажиллагааны горим доголдох, буруу үйлдлийг илрүүлэх, засч залруулах арга хэмжээ авах,
- в) бүтээгдэхүүний гологдол түүний шалтгааныг тогтоох, үйлдвэрлэж гаргасан бүтээгдэхүүн стандарт, техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянаж машин, механизмын тохиргоог хийж тааруулах,
- г) засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ хийх,
- д) үйлдвэрлэлтэй холбогдсон мэдээллийн тэмдэглэл хөтлөх,
- е) бусад ажилчдыг хянах.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

### **811 Уурхай, эрдэс боловсруулах суурь машины операторч**

## **БАГА БҮЛЭГ 811 УУРХАЙ, ЭРДЭС БОЛОВСРУУЛАХ СУУРЬ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

---

Уурхай, эрдэс боловсруулах суурь машины операторч нь газрын хөрснөөс чулуу, ашигт малтмал, эрдэс олборлох, чулуу, ашигт малтмал, эрдэс боловсруулах, цооног ухах, өрөмдөх, цемент болон чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах зэрэг машин, механизмыг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) өрөмдлөгийн болон бусад тоног төхөөрөмж, уурхайн байнгын ажиллагаатай машин, механизм болон таслах, тайрах, бутлах, нунтаглах, шахах, холих, найруулах зэрэг төрөл бүрийн ашигт

малтмал, эрдэс боловсруулах машин, механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах, хянах,

- б) ашигт малтмал, эрдэсийг бусад хольцоос ангижруулах угаах, тунгаах, ялгах, холих тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) цемент, бетон, хиймэл чулуу хийх үйлдвэр, машин, механизмыг ажиллуулах, цутгамал угсармал бетон болон чулуун бүтээгдэхүүн хийх,
- г) төрөл бүрийн машин, механизмын үйл ажиллагааг хянах, шалгах, доголдлыг илрүүлж засч, залруулах арга хэмжээ авах,
- д) машин, механизмын засвар үйлчилгээ, цэвэрлэгээ хийх,
- е) үйлдвэрлэлийн бүртгэл, тэмдэглэл хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ашигт малтмал, эрдэс боловсруулах үйлдвэрийн машин, механизмын операторч
- Худаг, цооног ухагч, өрөмдөгч, холбогдох бусад ажилтан
- Цемент, чулуу бусад эрдэс бүтээгдэхүүний машин, механизмын операторч
- Уурхайчин, карьерийн ажилтан

Энэ бага бүлэгт хамаарах ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8111 Далд ба ил уурхайчин**

**8112 Эрдэс, чулуулаг боловсруулах төхөөргийн операторч**

**8113 Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан**

**8114 Цемент, бусад эрдэс бүтээгдэхүүний машины операторч**

**Тайлбар:**

Уурхайн байцаагч, хянагчийг 3121 дүгээр нэгж бүлэгт ангилсан.

**8111 ДАЛД БА ИЛ УУРХАЙЧИН**

Далд ба ил уурхайн уурхайчин нь уурхайн машин, механизм, гар багаж ашиглан гүний болон ил уурхай, карьераас чулуу, ашигт малтмал, эрдэс бодис болон баялагийг олборлох ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) далд ба ил уурхайн байнгын ажиллагаатай төрөл бүрийн тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах, үйл ажиллагаа, гүйцэтгэлийг хянах,

- б) далд ба ил уурхайд өрөмдөх, цооног гаргах тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах, ханын бэхэлгээ, угсралтын ажил хийх,
- в) чулуу, хүдэр, нүүрс болон бусад олборлолтыг гаргах машин, механизм, багаж тоноглолыг ажиллуулах,
- г) гүний уурхайн бэхэлгээ бэлтгэх, тохируулах, угсрах,
- д) агааржуулалтын хоолой, цооног, зам, өгсүүр хоолой зэргийг нээх, ухах машин, механизмыг ажиллуулах,
- е) агаар сэлгэлтийн болон ус, шавар, лаг зайлуулах татуурга зэрэг нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- ж) машин, механизм, багаж хэрэгслийн бага хэмжээний гэмтэл, эвдрэлийг засварлах, засвар үйлчилгээ, тосолгоог хийх, цэвэрлэх,
- з) ээлж, гарааны үеэр гүйцэтгэсэн ажил, үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөх,
- и) лабораторийн шинжилгээнд өгөх дээж авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- уурхайгаас олборлолтыг гаргах машины (вагон, тэргэнцэр зэрэг) операторч
- уурхайн байнгын ажиллагаатай машины операторч
- ил уурхайн том оврын экскаваторын операторч
- уурхайн үйлдвэрийн, цехийн операторч
- Уурхайчин
- Карьерийн ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7542	Тэсэлгээний ажилтан, тэсэлгээ хийгч
8113	Өрөмдөгч (газрын тос, хийн хоолой, худаг)
9311	Уурхайн ажилтан
3121	Уурхайн байцаагч, хянагч
9311	Карьерийн туслах ажилтан

**8112 ЭРДЭС, ЧУЛУУЛАГ БОЛОВСРУУЛАХ ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Эрдэс, чулуулаг боловсруулах төхөөрөмжийн операторч нь шууд ашиглах болон дахин боловсруулах зориулалтаар чулуу, ашигт малтмал, эрдэсийг цэвэршүүлэх, боловсруулах машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ажлын техникийн стандарт үзүүлэлтийн дагуу чулуу, ашигт малтмал, эрдэсийг бутлах, нунтаглах, тайрах, таслах, хөрөөдөх, зүсэх

- зориулалтын машин, механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулах,
- б) дахин боловсруулах зорилгоор чулуун том хавтан, хэсгүүдийг таслах, тайрах, хөрөөдөх машинд оруулах, байрлуулах,
- в) туузан дамжуулагчаар боловсруулах машинд орж буй буталсан чулуу, эрдсийн урсгалыг хянах,
- г) эрдсийг хог хаягдлаас нь салгаж цэвэршүүлэх зорилгоор угаах, салгах, ангижруулах, шүлтжүүлэх, тунадасжуулах, шүүх, тунгаах, нийлүүлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- д) дахин боловсруулалтыг хөнгөвчлөх зорилгоор эрдэс хүдрийг уусгагчтай холих,
- е) металл болон эрдсийн баяжмалыг хүдэр, шороо тоосноос нь өтгөрүүлэх, хөвүүлэх, салгагч, шүүлтүүр, соронзон цахилгаан орны сепаратор болон бусад аргаар салгах,
- ж) тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах үүднээс хэмжигчийн хянах самбарыг ажиглан удирдлагыг таруулах, доголдлыг илрүүлж, машин, механизм, тоног төхөөрөмжийг засвар хийх,
- з) боловсруулалт нь стандарт, ажлын үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг харагдах байдлаар нь болон гараар шалгах, лабораторийн шинжилгээнд дээж авах,
- и) ээлж, гарааны туршид гүйцэтгэсэн ажил, боловсруулалтын талаархи мэдээлэл, тэмдэглэл хөтлөх. Үүнд: гаргасан бүтээгдэхүүний тоо, төрөл, хэмжээ ,
- к) боловсруулсан эрдэс, чулууг баглах, боох болон дахин боловсруулах зориулалтаар ангилах, хураах, зөөх, тээвэрлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нүүрс угаагч
- Бутлагч машины операторч (эрдэс боловсруулалт)
- Хөвүүлэгч машины операторч (эрдэс боловсруулалт)
- Алт тунгаагч
- Тээрэмдэгч машины операторч (эрдэс)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7113 Чулуучин, чулуу зүсэгч (гар багажаар, гараар ажилладаг төхөөрөмжөөр)
- 7113 Чулуучин
- 7113 Чулуу өнгөлөгч (гар багажаар, гараар ажилладаг төхөөрөмжөөр)
- 7113 Чулуу салгагч (гар багажаар, гараар ажилладаг төхөөрөмжөөр)
- 8114 Машины операторч (чулуун үйлдвэрлэл)
- 8114 Цемент, бусад эрдэс бүтээгдэхүүн үйлдвэрлэгч машины операторч

**8113 ЦООНОГ ӨРӨМДӨГЧ, АДИЛТГАХ БУСАД АЖИЛТАН**

Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан нь худаг, цооногт хана суулгах, хүдэр, шингэн, хий зэргийг гаргаж авах, бусад зорилгоор өрөмдөгч машин, механизм болон холбогдох тоног, төхөөрөмжийг байрлуулах, угсрах, ажиллуулах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өрөмдөгч тоног төхөөрөмж, бусад тоноглолыг буулгах, зөөвөрлөх, угсрах,
- б) хоолой, өрмийг угсрах, буулгах ажиллагаагүй болсон тоног төхөөрөмжийг солих,
- в) өрөм, хоолойг дээш, доош болгох, цооногт оруулах, гаргах механизмг ажиллуулах, даралтыг тохируулах, тоног төхөөрөмжийн ажиллах хурдыг тохируулах,
- г) өрөм хоолой, цооног дахь шингэний зохистой эргэлтийг хангах үүднээс шингэнийг бэлтгэх, шахуургын үйл ажиллагааг шалгах,
- д) хэмжих багажны болон бусад хэмжүүрийн заалтыг хянах, тоног төхөөрөмжийн ажиллагааны доголдол, хэвийн бус ажиллагааг илрүүлэх, өрөм болон бусад тоног төхөөрөмжийг солих хэрэгцээ шаардлагыг тодорхойлох,
- е) өрмийн тоног төхөөрөмж, өргөх цамхаг болон бусад машин, механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, тохируулах, засварлах, цэвэрлэх,
- ж) өрөмдлөгийн болон үйлчилгээний үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөх,
- з) шороо, тоос, өрөмдөх тоног төхөөрөмжийн эвдэрсэн хэсгүүд, өөдөс, хэлтэрхийг цооног, нүхнээс гаргах зориулалт бүхий машин, тоног төхөөрөмж, багажийг ажиллуулах,
- и) ашиглахгүй болсон нүх, цооногыг таглах, битүүмжлэх,
- к) багын гишүүдийг сургалтанд хамруулах, хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өрмийн тоног төхөөрөмжийн машинч
- Өрмийн цамхагны операторч
- Гүний хайгуулын өрөмдөгч
- Чиглэлийн өрмийн ажилтан (босоо бус тэнхлэгээр өрөмдөнө)
- Өрмийн машинч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                |
|------|----------------|
| 7542 | Тэсэлгээ хийгч |
| 8111 | Уурхайчин      |

**8114 ЦЕМЕНТ, БУСАД ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Цемент, бусад эрдэс бүтээгдэхүүний машины операторч нь барилга угсралтын зориулалтаар хэвлэж бэлтгэсэн, цутгамал бетон, битүм болон чулуун бүтээгдэхүүн, барилгын чулуу үйлдвэрлэх, бэлэн болгох машин, механизмыг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хэвэнд шахах, цутгах, холих, шахуурагдах, жижигрүүлэх, бяцлах, тайрах, таслах болон бэлэн бүтээгдэхүүн буюу бетон, чулуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх машин, механизмыг ажиллуулах,
- б) цемент, шохойн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, орц материалыг тоног төхөөрөмжид хийх шахуурга, туузан дамжуулагч зэрэг материал, түүхий эдээр тасралтгүй хангах машин, механизмыг ажиллуулах,
- в) элс, хайрга, цемент, ус болон бусад орц материалыг хэмжих, жигнэх, холих зэрэг бетон хийх машин, механизмыг ажиллуулах,
- г) хэв угсрах, бетон болон хиймэл чулууны холимогийг цутгах, хэвнээс бэлэнцутгасан бүтээгдэхүүнийг гаргах, бэлэнцутгамал бүтээгдэхүүний гадаргууг өнгөлөх, тэгшлэх зэрэг боловсруулах машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- д) бетон, чулуун бүтээгдэхүүн, хавтан, бусад бүтээгдэхүүнийг стандарт, шаардлага, техникийн үзүүлэлтэд нийцүүлэн зүсэх тайрах, бутлах, нунтаглах, өрөмдөх, даралтай элс болон бусад аргаар зүлгэх, өнгөлөх,
- е) үйлдвэрийн норм, үзүүлэлтийг шалган, тохирох материал, орцыг сонгох, үйлдвэрлэлийн горим, дараалал, бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох, хэвэнд шахах, цутгах, холих, шахуурагдах машин, механизмын тохиргоог хийх,
- ж) машин, механизмын ажиллагаа, үйлдвэрлэлийн явцад хяналт тавих, даралт, дулааны хэмжүүрийг хянаж, тохируулах, алдаа доголдлыг мэдэгдэх, тайлагнах,
- з) холимог болон бэлэн болсон бүтээгдэхүүний дээжийг авах, техникийн стандарт үзүүлэлт, шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж, машин, тоног төхөөрөмжийг тохируулах, тааруулах,
- и) машин, механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулах, туслалцаа үзүүлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Цутгамал бетоны машины операторч
- Цутгамал чулууны машины операторч



- Бетон үйлдвэрлэлийн машины операторч
- Үйлдвэрийн алмаз, очир эрдэнэ өнгөлөгч, зүлгэгч машины операторч
- Чулуу өнгөлөгч, зүлгэгч машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7113	Чулуу өнгөлөгч (гар эсвэл гараар ажиллуулдаг багажаар)
8181	Тоосго, шил, керамик шатаах зуухны операторч
8114	Шатаах зуухны операторч (цемент үйлдвэрлэл)
8112	Чулуу боловсруулах машины операторч

**Тайлбар:**

Энэ нэгж бүлгийн машин, механизмын операторчийн үйлдвэрлэх бүтээгдэхүүний жишээ: иргэний инженерийн барилга байгууламжинд хэрэглэх холимог бетон, бетон, тоосго, хатанцар, чулуун хавтан, хашаа саравчны багана, шон, хоолой, цутгамал хэсгүүд, төмөр замын бетон дэр, хана, зааглах хэсгүүд, барилгын хэсгүүд, шавар, бетон хоолой гэх мэт.

**БАГА БҮЛЭГ 812****МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ СУУРЬ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Метал боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний суурь машины операторч нь эрдэс хүдэр, металл боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох машины ажиллагааг хянах, удирдах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хүдэр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах машин, тоног төхөөрөмжийг суурилуулах, бэлтгэх, тохируулах,
- б) металл боловсруулж эцсийн бүтээгдэхүүн гаргах үе шат, явцыг хянах, удирдах,
- в) тоног төхөөрөмжийн доголдол, саатал, гэмтлийг тогтоох, шалгах, хэмжих багажийг хянах, өдөр тутмын үйл ажиллагааны хяналт шалгалт хийх, засвар үйлчилгээг хийх, зохион байгуулах,
- г) дээж бүтээгдэхүүнийг шалгах, турших, дүгнэлт хийх,
- д) мэдээллийг бүртгэх, үйлдвэрлэлийн явцын тэмдэглэл хөтлөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8121 Металл боловсруулах төхөөрөмжийн операторч****8122 Металл өнгөлөх, цайрдах, бүрэх машины операторч**

**8121 МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Металл боловсруулах төхөөргийн операторч нь эрдэс, хүдрийг боловсруулах, баяжуулах, хатууруулах, хоёр болон түүнээс дээш буланд оруулж ган хавтас хийх, металлийг хэвэнд оруулах үйлдэлтэй машин, механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, тохируулах, засвар үйлчилгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эрдэс, хүдэр, металл боловсруулах машин, механизмыг суурилуулах, бэлтгэх, тохируулах, \_
- б) эрдэс, хүдэр, металл боловсруулах, бутлах, салгах, шүүх, холих, хэвэнд оруулах, хэвэнд цутгах, хуйлах, баяжуулах зэрэг ажиллагаатай машин, механизмыг ажиллуулах,
- в) машин, механизм, багаж төхөөрөмжийн жигд ажиллагааг хангах, боловсруулалтын стандарт, технологийн нөхцөлийг баримтлах, хэмжих, багаж хэрэгслийн заалт, болон компьютерийн мэдээлэл, дүрс бичлэгийн хяналтын дэлгэцээр бүтээгдэхүүний боловсруулалтын явцыг сайтар ажиглан хянах,
- г) тоног төхөөрөмж, түүний удирдлага, шахуурга, болон бусад тоног төхөөрөмжийг тохируулах,
- д) машин, тоног төхөөрөмжийн сэлбэг, материал, түүхий эдийн нийлүүлэлтийг хянах, удирдах,
- е) үйл ажиллагааг эхлэх, дуусгах, гологдол, саатал бусад асуудлыг зохицуулах, залруулах, тоног төхөөрөмжийн ажиллагааг хянах,
- ж) алдаа доголдлын учир шалгааныг олох, өдөр тутмын үйл ажиллагааг шалгах, засвар үйлчилгээг хийх,
- з) дээж бүтээгдэхүүнд шинжилгээ, туршилт хийх болон холбогдох мэдээлэл, тэмдэглэл хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- төмрийн хайлмаг зөөх, хэвэнд цутгагч шанага ажиллуулагч
- ган хавтас хийгч (хоёр булны дундуур оруулан)
- металлийг халуунаар боловсруулах машины операторч
- металл төмрийг хэвэнд оруулах машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 3135 | Хөөрөгдөж халаах зуухны операторч               |
| 3135 | Булаар хавтсан төмөр хийх машины операторч      |
| 8122 | Металл бүрэх, өнгөлөх, цайрдах машины операторч |

**8122 МЕТАЛЛ ӨНГӨЛӨХ, ЦАЙРДАХ, БҮРЭХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Металл өнгөлөх, цайрдах, бүрэх машины операторч нь металл хийц, эд зүйл, эд ангийг зэврэх, элэгдэхээс хамгаалах, гоёл чимэглэлийн зориулалттай болгож цахилгаанаар өнгөлөх, бүрэх, цайрдах тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цахилгаан соронзонгоор бүрэх, цайрдах зэрэг ижил төстэй боловсруулалт хийх, үүний тулд метал эдлэлийг цэвэрлэж бэлтгэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- б) цахилгаанар бүрэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- в) метал, ган бүтээгдэхүүнийг бүрэх халуун уусмал бүхий тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- г) хайлш болсон холимог метал бүхий утсыг автоматаар бүрэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- д) гадаргууг сэргээж бүрэх зорилгоор хайлсан төмөр болон бусад найрлагатай шингэнийг метал бүтээгдэхүүн дээр шүрших тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- е) металл эд зүйлийг зэврэлтээс хамгаалах зорилгоор химийн бодисоор болон халуун аргаар боловсруулалт хийх, бүрэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- ж) хэмжилтийн гар багажаар бүрээс давхаргын зузааныг хэмжиж шалгах, үйлдвэрлэлийн мэдээлэл, тэмдэглэл хөтлөх,
- з) техникийн үзүүлэлт, стандарт шаардлагын дагуу төмөржүүлэх, металжуулах ажиллагааг бэлтгэх, холих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Металл бүрэх машины операторч
- Металл боловсруулах суурь машины операторч
- Металл өнгөлөх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3135 Металл боловсруулах үйл ажиллагааны хянагч

**БАГА БҮЛЭГ 813****ХИМИЙН БОЛОН ФОТО ЗУРГИЙН МАШИН, ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Хими, фото зургийн машин, төхөөргийн операторч нь ариун цэврийн болон гоо сайхны бүтээгдэхүүн, гэрэл зургийн болон бусад химийн

бүтээгдэхүүн, төрөл бүрийн найрлагатай бодис үйлдвэрлэх зориулалттай машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Химийн бодис болон химийн бүтээгдэхүүнийг зохих орцоор холих, найруулах, савлах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, үйлдвэрийн зориулалтаар ашиглах захиалгад нийцүүлэн найрлага, чанар бүхий химийн бодис болон химийн бүтээгдэхүүнийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн гаргах, бусад ажилчдыг хянах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **8131 Химийн бүтээгдэхүүний машины операторч**

#### **8132 Фото зургийн машин ажиллуулагч**

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 3133 Химийн бодис боловсруулах үйл ажиллаганы төхөөргийн операторч
- 3134 Нефть, байгалийн хий цэвэрлэх төхөөргийн операторч

#### **8131 ХИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Химийн бүтээгдэхүүний машины операторч нь олон төрлийн химийн бодис, химийн бүтээгдэхүүнийг зохих найрлагаар холих, найруулах, боловсруулах, савлах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, ажлыг эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) машин, тоног төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг эхлэх, удирдах, тохируулах, зогсоох,
- б) аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу бүтээгдэхүүний химийн урвал, өөрчлөлтийг хянах,
- в) холигч, хатаагч, нунтаглагч, үрэл хийгч болон бүрэх машин, тоног төхөөрөмж зэрэг нэг ба түүнээс олон химийн бодис, тогтоосон нэгж, норм, орц, сав, багажны хэмжүүр, тусгайлсан хэмжих багажны болон цахим багажны заалтыг хянах,
- г) тогтоосон нэгж, норм, орцын дагуу химийн бодисны найрлага, орцыг хэмжих, жигнэх, машин, тоног төхөөрөмжинд хийх,
- д) бүтээгдэхүүний дээж авах, өдөр тутмын химийн болон физикийн туршилтыг хийх, үйлдвэрлэлийн тэмдэглэл, мэдээллийг хөтлөх,
- е) машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, бага зэргийн эвдрэл гэмтлийг засах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- нефть, байгалийн хий боловсруулах, цэвэрлэх төхөөрөгийн операторч
- нефть, байгалийн хий, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх машин, тоног төхөөрөмжийн операторч
- Эмийн зүйл, гоо сайхан, ариун цэврийн бүтээгдэхүүн хийгч машины операторч
- Лаа үйлдвэрлэх машины операторч
- Тэсрэх бүтээгдэхүүн хийх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 3133 | Химийн бүтээгдэхүүний төхөөрөгийн операторч         |
| 3134 | Нефть, байгалийн хий цэвэрлэх төхөөрөгийн операторч |

**8132 ФОТО ЗУРГИЙН МАШИН АЖИЛЛУУЛАГЧ**

Фото зургийн машин ажиллуулагч нь фото зургийн хальс, цаас хийх, зургийн хальс боловсруулах, хэвлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Фото зургийн хальс, цаас үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- б) фото зураг боловсруулах, буулгах, хэвлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, шалгах, үйл ажиллагааны стандартыг сахих,
- в) фото зургийн хальсыг боловсруулах харанхуй нөхцөл, өрөөг бэлтгэх,
- г) фото зургийн хальс, цаас зэргийг шалгах, шаардлагатай өнгө, гэрэл, тоо, хэмжээ, төрлийг тогтоож хэвлэх тоног төхөөрөмжинд тохируулах,
- д) автомат тоног төхөөрөмжийн тохиргоог хийх, өнгөт негатив, бусад хальс хэвлэх, үйлдвэрлэх,
- е) фото зургийн хальсыг дүрс бичлэгийн хальс болон бусад цахим төхөөрөмжинд шилжүүлэх, буулгах тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- ж) фото зураг боловсруулахтай холбогдолтой бусад ажил үүргийг гүйцэтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Харанхуй өрөөний техникч
- Фото зургийн хальс боловсруулагч
- Фото зургийн хальс хэвлэгч
- Фото зураг буулгах машины операторч
- Өнгөт фото зураг хэвлэх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3431 Фото зурагч

**БАГА БҮЛЭГ 814****РЕЗИН, ХУВАНЦАР, ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

---

Резин, хуванцар, цаасан бүтээгдэхүүний машины операторч нь резин болон резиний холимогийг холих, зуурах мөн байгалийн болон нийлмэл резин, хуванцраар бүтээгдэхүүн хийх, цаас, картон болон ижил төстэй материалаар төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) резин болон резиний холимогийг холих, зуурах мөн байгалийн болон нийлмэл резин, хуванцраар төрөл бүрийн бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэх,
- б) төрөл бүрийн цаасан бүтээгдэхүүн хийх машиныг ажиллуулах, хянах,
- в) бүтээгдэхүүн, гарцыг өгөгдсөн стандарт шаардлага, техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, илэрсэн доголдол, алдаа, эвдрэл, гэмтлийг шалган тогтоож машин, тоног төхөөрөмжийг тохируулах, засварлах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8141 Резин бүтээгдэхүүний машины операторч****8142 Хуванцар бүтээгдэхүүний машины операторч****8143 Цаасан бүтээгдэхүүний машины операторч****8141 РЕЗИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Резин бүтээгдэхүүний машины операторч нь резин, резиний холимогийг холих, зуурах мөн байгалийн болон нийлэг резинээр хэвлэсэн гутал, гэр ахуйн эд зүйл, тусгаарлах материал, үйлдвэрийн тоног хэрэгсэл эсвэл машины дугуй зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүн, эд анги үйлдвэрлэх машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) дахин боловсруулах, үйлдвэрлэлд зориулан резин болон резиний холимогийг холих, зуурах машиныг ажиллуулах, хянах,
- б) резин хавтас болон резин (сунадаг) даавуу үйлдвэрлэх машиныг ажиллуулах, хянах,
- в) резин холимог гаргах, хэвэнд цутгах аргаар хүхэржүүлсэн резинийг хэвлэх машиныг ажиллуулах, хянах,
- г) машины дугуй хэвлэх, дугуйг хүхэржүүлэх, ашигласан хуучин дугуйг нөхөж хэвлэх зориулалтын нөхөн хэвлэх машиныг ажиллуулах, хянах,
- д) бүтээгдэхүүний гарцыг өгөгдсөн стандарт, шаардлага, техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа болон доголдол, алдаа, гажуудал байгаа эсэхийг шалгах,
- е) дугуй, резин бүтээгдэхүүнд гарсан доголдол, алдаа, гажуудлыг илрүүлэх стандарт, шаардлага хангаагүй хэсгийг хүхэржүүлэх болон бусад аргаар засварлах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- резин шахах машины операторч
- резин тээрэмдэх, бутлах машины операторч
- резин хэвлэгч
- резин бүтээгдэхүүний машины операторч
- дугуй хийгч
- дугуй засварчин
- хүхэржүүлэгч

**8142 ХУВАНЦАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Хуванцар бүтээгдэхүүний машины операторч нь хуванцар материал, холимогийг орц, нормын дагуу холих, зуурах болон төрөл бүрийн хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэх машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хуванцрын бүрэлдэхүүн материал, холимогийг холих, зуурах машиныг ажиллуулах, хянах,
- б) хэвлэх, цутгах, шахах, үлээх, зүсэх болон бусад аргаар хуванцар материалыг хэвэнд оруулах машиныг ажиллуулах, хянах,
- в) хуванцар болон хуванцарын холимог материалыг үелүүлэн наах болон шилэн хуванцар хийх машиныг ажиллуулах, хянах,
- г) бүрээсгүй утас, цахилгааны утас, кабель болон бусад дамжуулагч утсыг хуванцараар бүрэх,

- д) бүтээгдэхүүн, гарцыг өгөгдсөн шаардлага, техникийн үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, доголдол, алдаа, гажуудлыг шалгах,
- е) хаягдал хуванцар материалыг дахин боловсруулах,
- ж) хиймэл нүд, харааны линз (контакт линз)-ний диск, раам болон хиймэл хуванцар ортопед хэрэглэлийн хуванцар эд анги, бүрээс, гадаргуу, хүрээ хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хуванцар сав үлээх машины операторч
- үелэн наах машины операторч
- хуванцар шахаж гаргах машины операторч
- хуванцар бүтээгдэхүүний машины операторч
- кабелийн хуванцар бүрээсний машины операторч
- хуванцар хэвлэгч

### **8143 ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Цаасан бүтээгдэхүүний машины операторч нь цаасан хайрцаг, дугтуй, цүнх, уут болон бусад цаас, картон, ижил төстэй материалаар эд зүйл хийгч машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цаасыг картонд наах, шаардлагатай хэмжээгээр тайрах, цаас, картон хайрцаг хийх зориулалтаар нугалах машиныг ажиллуулах, хянах,
- б) цаас, картон бусад ижил материалаар цаасан аяга болон бусад хайрцаг савыг даралт, шахалтаар хэвлэгч машиныг ажиллуулах, хянах,
- в) цаасан дугтуй, уут хийх зориулалтаар цаас тайрах, нугалах, эвхэх, наах болон бусад ижил төстэй материалаар уут хийх машиныг ажиллуулах, хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Машины операторч (картон бүтээгдэхүүн)
- Машины операторч (дугтуй, цаасан уут үйлдвэрлэл)
- Машины операторч (цаасан хайрцаг үйлдвэрлэл)
- Цаасан бүтээгдэхүүний машины операторч
- Цаасыг даавуу болон бусад материалтай хольж зуурмаг болгон эд зүйл хийгч (хатахаар хатуурна)



**БАГА БҮЛЭГ 815**

**НЭХМЭЛ, ҮСЛЭГ ЭДЛЭЛ, АРС ШИРЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Нэхмэл, үслэг эдлэл ба арьс ширэн бүтээгдэхүүний машины операторч нь утас, нэхмэлийн утас, арьс шир, үслэг арьс, савхийг боловсруулах төрөл бүрийн машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, гутал, хувцас үйлдвэрлэх, засаж янзлах болон нэхмэл, үслэг арьс, савхин эд зүйлийг хуурай аргаар цэвэрлэх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) утас, нэхмэлийн утсыг боловсруулж нэхмэл, нэхээсгүй даавуу болон сүлжмэл бүтээгдэхүүнийг нэхэх, сүлжих машиныг ажиллуулах, хянах,
- б) байгалийн материалаар нэхмэлий утас, бэлтгэх, утас томох, ээрэх, давхарлах, эрчлэх машиныг ажиллуулах, хянах,
- в) даавуу, үслэг эдлэл, арьс, савхи болон хиймэл даавуун хувцас эдлэл хийх, хувцас болон бусад материал дээр гоёл чимэглэлийн хээ хатгамал хийх, засах, нөхөх зориулалтын оёдлын машин ажиллуулах, хянах,
- г) цайруулах, агшаах, будах машин, тоног төхөөрөмж, даавуу, нэхмэлийн утас бусад материал боловсруулах, хувцас, үслэг эдлэл, хивс хивсэнцэрт хуурай цэвэрлэгээ хийх машиныг ажиллуулах, хянах,
- д) арьс шир, үс ноос, үслэг арьс боловсруулах төрөл бүрийн машин ажиллуулах, хянах,
- е) стандарт, тусгай захилгын болон ортопед гутал, өмсгөл болон цүнх, гар цүнх зэрэг арьс шир, савхин эдлэлийг үйлдвэрлэх, засаж тордох, засварлах машиныг ажиллуулах, хянах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8151 Утас бэлтгэх, томох ээрэх машины операторч**

**8152 Сүлжих, нэхэх машины операторч**

**8153 Оёдлын машины операторч**

**8154 Цайруулах, будах, цэвэрлэх машины операторч**

**8155 Үслэг эдлэл, арьс шир боловсруулах машины операторч**

**8156 Гутлын болон бусад адилтгах төрлийн машины операторч**

**8157 Угаалгын машины операторч**

**8159 Энэ ангилалд ороогүй бусад бүтээгдэхүүний машины операторч**

**8151 УТАС БЭЛТГЭХ, ТОМОХ ЭЭРЭХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Утас бэлтгэх, томох ээрэх машины операторч нь байгалийн утсаар нэхмэлийн утас бэлтгэх, ээрэх, томох, давхарлах, эрчлэх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ. Тэд хоёр болон үүнээс олон утсыг хооронд нь ээрч, эрчилж ус нэвтэрдэггүй илүү чанга, бат бөх, даргар нэг утас болгон ээрнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ноосон хивсэнцрийг хөвж утас болгох машиныг ажиллуулах, хянах,
- б) хаягдал ноосон нэхмэлийн утсыг цэвэрлэж, хөвсийлгөн ноос болгох машиныг ажиллуулах, хянах,
- в) нэхмэлийн хэд хэдэн утсыг ээрч нэг төрлийн утас, материал болгох машиныг ажиллуулах, хянах,
- г) нэхмэлийн утсыг цэвэрлэх, хөвсийлгөх, тугаар нь ээрэх, самнах, боож ороох эсвэл тууз болгон ороох машиныг ажиллуулах, хянах,
- д) хэд хэдэн татах хэрэгсэл ашиглан туг утсыг хооронд нь нийлүүлж ижил жин, зузаантай утас болгон татаж тэгшлэх татагч суурь машиныг ажиллуулах, хянах,
- е) татаж тэгшилсэн утсыг ээрэх, томох, дамарт ороох, утасны бат бэх чанар, жигд байдлыг сайжруулах зорилгоор давхарлаж дахин эрчлэх, ээрэх, томох машиныг ажиллуулах, хянах,
- ж) нэхмэлийн утсыг татаж ороох, ээрэх машиныг ажиллуулах, хянах,
- з) татагч суурь утас ээрх машинаас гарах нэхмэлийн утсыг сулавтар татаж ээрэх машиныг ажиллуулах, хянах,
- и) цардуул, тос, давирхай, савантай усан холимог бэлтгэж тодорхой хугацаанд уурынд буцалцаж даавуу болон нэхмэлийн утсыг бэхжүүлэх, боловсруулалт хийх,
- к) ус нэвтэрдэггүй болгох зорилгоор химийн бодисоор боловсруулах,
- л) самнах машины бул, цилиндрийг үс, ноосноос цэвэрлэх,
- м) ээрэх, самнах зэрэг төрөл бүрийн татах, эргэх булны гадаргууг шинээр бүрэх, өнгөлөх, шинэ резин болон арьсан бүрээсээр бүрэх,
- н) утсыг эрчлэх, томруулан ороох, шилжүүлэн ороох, гогцоолдох нэхмэл эдлэлийн суурь утсыг голд ороох машиныг ажиллуулах
- о) томруулан ороох, шилжүүлэн ороох, суурь утас ороох, хөндлөн утас ороох,
- ө) суурь утас ороох машин, хөндлөн утас ороох машиныг ажиллуулах, кантарыг цэнэглэх, машины цэвэрлэгээ үйлчилгээ хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- утас бэлтгэх машины операторч
- утас ээрэх машины операторч
- утас томох машины операторч

- эрчлэх ороох машины операторч
- Гогцоолдогч машины операторч
- Шилжүүлэн ороогч машины операторч
- Суурь утас ба хөндлөн утас ороогч машины операторч
- Угаах машины операторч

### **8152 СҮЛЖИХ, НЭХЭХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Сүлжих, нэхэх машины операторч нь нэхмэлийн утас боловсруулж даавуу, олс, хивс, үйлдвэрийн даавуу, сүлжмэл хувцас, эд зүйл, хөнжил, бусад даавуун материал үйлдвэрлэх, нэхмэл буюу сүлжмэл бүтээгдэхүүн нэхэх, сүлжих машиныг суурилуулах, ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) тусгайлсан хээ, загварын хувцас нэхэх автомат, ажиллагаатай нэхмэлийн машин суурилуулах, ажиллуулах,
- б) нэхэх, сүлжих болон бусад машины зүү, дамар, чиг заагчид утас, нэхмэлийн утас, даавуу зэргийг сүвлэх, бэхлэх,
- в) хатуу, өөдөс зэрэг гологдол утсаар төрөл бүрийн өнгө загвартай хивс, хивсэнцэр нэхэх нэхмэлийн суурь машин ажиллуулах,
- г) тодорхой давтамжаар утсыг хооронд хэрээслэж, зангидан тор, сүлжээс үүсгэх суурь машин ажиллуулах, хянах,
- д) хатгамал хийх, чимэх, шаглаж оёх болон олон давхар материалыг эмжих, хэрж оёх, нэхмэл бараа, хөнжил, гудасны бүрээс зэрэг бүтээгдэхүүн хийх олон зүү бүхий том оврын автомат машин ажиллуулах, хянах,
- е) хээ гаргах автомат удирдлага бүхий оёдолгүй битүү хоолой гарган тойргоор нэхэх машиныг ажиллуулах,
- ж) хөл, тавхайн хэлбэр бүхий сүлжмэл оймс зэрэг бүтээгдэхүүн нэхэх машиныг ажиллуулах, хянах,
- з) оймсны өсгий, өлмий хэсгийг шилбэ болон тойргоор хоолой гаргаж нэхсэн хэсэгт залгаж оёх машин ажиллуулах,
- и) оймсны хуруу хэсгийн үзүүрийг оёх машин ажиллуулах, хянах,
- к) хүссэн хээ, загвараар гогцоо зангидах, чимэглэх зэрэг дэгээ зүүгээр нэхэх машин ажиллуулах, хянах,
- л) нэхмэлийн суурь машины механик болон бусад эвдрэл, гэмтэл, зогсолтын шалтгааныг шалгаж тогтоох,
- м) элэгдсэн, гажсан зүү болон бусад эд ангийг солих, засварлах,
- н) тосолгооны багаж ашиглан машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, тослох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нэхэх машины операторч
- Сүлжих машины операторч
- Хивс нэхэх, сүлжих машины операторч
- Сэмлэх, сэгсрэх машин операторч
- Самнах машин операторч
- Хаягдал задлагч машин операторч
- Үзүүр хэрчих машин операторч
- Нэхээсгүй эдлэлийн машины операторч
- Эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэгч
- Эсгийний машины операторч
- Нэхмэл бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулах, захлах, огтлох, хэмжих машины оператор
- Цардах машины оператор
- Хяргах, цэвэрлэгч машины оператор
- Бэлэн бүтээгдэхүүнийг шалгагч
- Нэхмэл, сүлжмэл эдлэлийн загвар зохион бүтгээч
- Цахилгаанчин, ноос, ноолуурын ээрэх, самнах, нэхэх, сүлжих, гүйцэтгэн боловсруулах тоног төхөөрөмжийн
- Агааржуулагч, ноос, ноолуурын салбарын үйлдвэрийн бичил орчныг /дулаан, чийгжилт, гэрэлтүүлэг/ технологийн
- Тоног төхөөрөмжийн засварчин, ноос, ноолуурын салбарын бүх дамжлагын
- Цахим-инженер, ноос, ноолуурын салбарын компьютерийн удирдлагатай тоног төхөөрөмжийн

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |             |
|------|-------------|
| 7318 | Нэхмэлчин   |
| 7318 | Хивс нэхэгч |

**8153 ОЁДЛЫН МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Оёдлын машины операторч нь даавуу, үслэг материал, хиймэл даавуу, арьс шир, савхин хувцас эдлэл оёх, засварлах, нөхөх, шинэчлэх, хувцас, бусад материал дээр гоёл чимэглэлийн хатгамал хийх, нэхмэл, сүлжмэл даавуу, нэхээсгүй нэхмэл, савхи, бусад материалаар бүх төрлийн хувцас, хэрэгсэл техникийн болон гэр ахуйн өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх засварлахад төрөл бүрийн болон тусгай зориулалтын оёдлын машиныг ажиллуулах, хянана.

Товчны нүх, цоорхой гаргах, нүх, цоорхойг тойруулан хавж оёх, товч хадах зэрэг бусад машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах зэрэг ажил бас эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нийлүүлж оёх, бэхлэх, нугалаа гаргах зэрэг оёдол хийх, хувцас, хувцасны зарим хэсэгт гоёл чимэглэл гаргах оёдлын машиныг ажиллуулах, чиглүүлэх,
- б) товч, дэгээ, цахилгаан товч, болон бусад хэрэгсэл, тоноглолыг хувцсанд бэхлэх, оёх хэрэглэл, багаж, тоног төхөөрөмжийг ашиглах,
- в) хээний загварын дагуу төрөл бүрийн хээ, хатгамал хийгч, олон төрлийн оёдол гаргах, хагас автомат оёдлын машиныг чиглүүлэх, ажиллуулах,
- г) автоматаар эд зүйл, материалыг нийлүүлж оёх, шаглах, чимэглэх дан болон давхар зүүтэй, хавтгай дэвсгэртэй машин ажиллуулах, хянах,
- д) арьс, савхин хувцас, эдлэл, цүнх, бээлий зэргийг оёх, хавах машин ажиллуулах, хянах,
- е) машины ажиллагааг хянах, тухайлбал, доголдол, буруу оёдол, утас тасрах зэргийг хянах,
- ж) зүү солих, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Оёдлын машины операторч
- Хатгамал хийгч машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7533	Хатгамалчин
7531	Арьс үслэг эдлэлээр эд зүйл хийгч
7318	Даавуу, арьс, шир бусад материалаар гар урлалын зүйл хийгч
7533	Оёдолчин
7531	Захиалгаар хувцас хийгч

**8154 УГААХ, ЧАНАХ, БУДАХ, ЦАЙРУУЛАХ, СЭГСРЭХ, ЦЭВЭРЛЭХ, ТОЛБО АРИЛГАХ, ХАТААХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Цайруулах, будах, цэвэрлэх, толбо арилгах, хатаах машины операторч нь нэхмэлийн утас, даавуу, бусад материалыг цайруулах, цэвэрлэх, будах машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) даавуу, утас, нэхмэлийн утас болон бусад материалыг цайруулах, будах, боловсруулах машиныг ажиллуулах, удирдах, джинсэн болон джинсэн төрлийн бүтээгдэхүүнийг чанах, цайруулах, уураар жигнэж боловсруулах машин төхөөрөмжийг ажиллуулах хянах,

- б) нэхмэл, сүлжмэл материал, хувцсыг тодорхой хэмжээнд агшаах болон нэхмэл эдлэлийн утсыг хооронд нь холбож бэхлэж бат бөх чанарыг сайжруулах машиныг чиглүүлэх, ажиллуулах,
- в) арьс, үслэг материалыг тэгшлэх, самнах үйлдэлтэй төрөл бүрийн машин ажиллуулах,
- г) Нэхмэл, сүлжмэл, даавуунхэрэгсэл, өргөнхэрэглээний бүтээгдэхүүнийг угааж цэвэрлэх, хатаах, толбо арилгагч машиныг ажиллуулах хянах,
- д) даавуу, материалыг ус нэвтэрдэггүй болгох үүднээс химийн бодисоор боловсруулалт хийх машиныг ажиллуулах, хянах,
- е) эд зүйлийг будах, өнгийг сэргээх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн явцад үүссэн илүүдэл утас, тоосонцор, хөвөнцөр, хяргадасыг сорж цэвэрлэх, машин төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- ж) даавуу, эд зүйлийг сунгах болон өнгөлөх зэрэг эцсийн боловсруулалт хийх машиныг ажиллуулах, хянах,
- з) арьс, үслэг материалаас гадны зүйлийг цэвэрлэж, зайлуулах зорилгоор утах, ариутгах тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- и) арьс, үслэг эдлэлийг хатаах, самнах, өд, сөдийг хөвсийлгөх, ариутгах, цэвэрлэх машиныг ажиллуулах, хянах,
- к) цахим тоног төхөөрөмжийг программчлах, заавар өгөх,
- л) тоног төхөөрөмж, машины удирдлагын дэлгэц бусад тоноглол дээрх материалын орц, гарцыг ажиглах, машин, тооног төхөөрөмжийн жигд ажиллагааг хангах,
- м) машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, тослох.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цайруулах машины операторч
- Хуурай хими цэвэрлэгээний машины операторч
- Нэхмэлийн утас будах машины операторч
- Угаах машины операторч
- Агшааж угаах машины операторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8157 Угаалгын машины операторч
- 9121 Гараар угаагч
- 9121 Гараар индүүдэгч

### **8155 АРЬС ШИР, ҮСЛЭГ ЭДЛЭЛ БОЛОВСРУУЛАХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Арьс шир, үслэг эдлэл боловсруулах машины операторч нь арьс шир, нэхий, үслэг эдлэлийг бэлтгэх, боловсруулах төрөл бүрийн машиныг ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ. Савхи, арьс үслэг эдлэл

үйлдвэрлэх зорилгоор амьтны арьс, шир, нэхий, үсийг өөлөх, хусах, цэвэрлэх, идээлэх, илдэх, будах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) боловсруулахаас өмнө арьс, ширнээс мах, өөхийг авах, арилгах, цэвэрлэх, зөөлрүүлэх машиныг ажиллуулах, хянах,
- б) арьс, шир, үснээс урт ширүүн үсийг авах, үсийг жигд урттай засан өөлөх, будах, сунгах, тэгшлэх машиныг ажиллуулах, хянах,
- в) арьс, ширний хөрсөн талаас арьсны гэмтэл, бохирдсон хэсэг, шохой давсыг арилгах, цэвэрлэх машиныг ажиллуулах, хянах,
- г) зузаан арьс ширийг нимгэлж, жигд хэмжээтэй болгох машин ажиллуулах, хянах,
- д) арьс ширийг өнгөлөх, гадаргууг хээ, хэлбэрт оруулах машин ажиллуулах, хянах,
- е) арьс, ширнээс үлдэгдэл үс, ноос, шар мах, өөхийг арилгах машин ажиллуулах, хянах,
- ж) арьс, ширийг цуулах, ижил зуузантай болгох машин ажиллуулах, хянах,
- з) арьс, ширийг боловсруулж савхи болгох машин ажиллуулах, хянах,
- и) савхины гадаргууг тосолж боловсруулах, өнгөлөх машин ажиллуулах,
- к) арьс савхинд будаг түрхэх машин ажиллуулах, хянах,
- л) арьс шир идээлэх торх болон бусад машин, механизмын засвар үйлчилгээ хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- арьс ширийг үснээс салгах машины операторч
- арьс, шир будах машины операторч
- арьс, шир идээлэх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 7535 арьс будагч
- 7535 арьс идээлэгч

**8156 ГУТЛЫН БОЛОН БУСАД ИЖИЛ ТӨРЛИЙН АЖЛЫН МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Гутлын болон бусад ижил төрлийн ажлын машины операторч нь ихэвчлэн стандартын болон тусгай зориулалтын гутал, өмсгөл, цүнх, гар цүнх, бусад арьс, савхин тоноглол, эдлэл үйлдвэрлэх, засварлах машиныг ажиллуулах, хянах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эсгүүр, загвар ашиглан гутлын хэсгүүдийг тэмдэглэн эсгэх, тайрах, хайчлах машиныг ажиллуулах, хянах,
- б) гутлын хэсгүүдийг нийлүүлж оёх, захлах, өнгөлөх, гоёлын хээ, чимэглэл хийх болон эцсийн бүтээгдэхүүн болгох машиныг ажиллуулах, хянах,
- в) ачаа тээшний цүнх, гар цүнх, тэлээ болон бусад арьс, савхин тоноглол, түүнчлэн эмээл, хүзүүвч, бусад тоноглол үйлдвэрлэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гутал үйлдвэрлэх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                     |
|------|-------------------------------------|
| 7536 | гуталчин                            |
| 7318 | гар урлалын зүйл хийгч (арьс савхи) |

**8157 Угаалгын машины операторч**

Угаалгын машины операторч нь угаалгын газар, хуурай цэвэрлэгээний байгууламжинд угаалгын, хуурай цэвэрлээгээний, индүүдлэгийн машин, тооног төхөөрөмжийг ажиллуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) өнгө, төрөл, материал болон цэвэрлэгээний шаардлагын дагуу угаах эд зүйлийг ангилж төрөлжүүлэх,
- б) ангилсан зүйлээ сав, туузан дамжуурганд байрлуулан угаах, цэвэрлэх, засварлах хэсэгт илгээх,
- в) хувцас эдлэлийг нэг бүрчлэн шалгаж толбо арилгах, товч авах, хадах зэрэг үйлчилгээ хийх,
- г) угаалгын болон хатаагч, мушгигч машинд хувцас, эд зүйлийг хийх, гаргаж авах,
- д) угаалгын бодис, цардуул тохируулж хийх,
- е) хувцас, эд зүйлийг угаах болон индүүдэх машинд оруулах,
- ж) машин, механизмыг ажиллуулах, зогсоох, хувцас, эд зүйлийн орооцолдоог гаргах, машинаас гаргаж авах,
- з) хувцас, эд зүйлийг тавиур, өлгүүрт өлгөх,
- и) хувцас, эд зүйлийг боож баглах, түгээх дарааллаар бэлтгэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хуурай цэвэрлэгээний машины операторч
- угаалгын машины операторч
- индүүдэх машины операторч



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

9121 гараар угаагч, индүүдэгч

**8159 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ДААВУУ, АРЬС ШИР, ҮСЛЭГ ЭДЛЭЛ БА АРЬС ШИРЭН БУСАД БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Энэ нэгж бүлэгт “Нэхмэл, үслэг эдлэл ба арьс ширэн бүтээгдэхүүний машины операторч” гэсэн 815 дугаар бага бүлэгт ороогүй бусад даавуу, арьс шир, үслэг ба савхин эдлэл үйлдвэрлэх машины операторч хамаарна. Тухайлбал малгай, майхан, гудас болон сүлжээс, чимэглэл бусад эд зүйл хийх, үйлдвэрлэх машин ажиллуулах, хянах зэрэг ажил эрхлэгч багтаана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) даавуу, арьс, савхи, үслэгээр малгай хийх, хэвлэх машин ажиллуулах, хянах,
- б) сүлжээс, чимэглэл зэрэг бусад эд зүйл хийх, үйлдвэрлэх машин ажиллуулах, хянах,
- в) даавуу материалыг зохих хэмжээ, хэлбэрийн дагуу эвхэх машин ажиллуулах, хянах,
- г) дахин боловсруулах, эсвэл тээвэрлэхэд зориулан утас, нэхмэлийн утсыг бөмбөлөг болгож ороох машин ажиллуулах, хянах,
- д) савхи, арьсны талбай, гарцыг хэмжих машин ажиллуулах, хянах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- сүлжээсний машины операторч
- малгайны машины операторч
- нэхмэл, хээний машины операторч
- майханы машины операторч

**БАГА БҮЛЭГ 816**

**ХООЛ ХҮНС, БУСАД ИЖИЛ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Хоол хүнс бусад ижил төрлийн бүтээгдэхүүний машины операторч нь мал, амьтан нядлах, мах эвдэх, шулах, махыг чанах, шарах, хөлдөөх, халаах, холих, бусад аргаар боловсруулах, хоол хүнсний зүйл, ундаа, тамхи зэргийг үйлдвэрлэх машин, тоног төхөөрөмж суурилуулах, тохируулах, хянаж ажиллуулна.

Энэ бага бүлэгт ангилсан ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **8160 Хоол хүнс бусад ижил төрлийн бүтээгдэхүүний машины операторч**

#### **8160 ХООЛ ХҮНС, БУСАД ИЖИЛ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Хоол хүнс бусад ижил төрлийн бүтээгдэхүүний машины операторч нь мал, амьтан нядлах, мах эвдэх, шулах, махыг чанах, шарах, хөлдөөх, халаах, холих, бусад аргаар боловсруулах, хоол хүнсний зүйл, ундаа, спирт, архи, тамхи зэргийг үйлдвэрлэх машин, тоног төхөөрөмж суурилуулах, тохируулах, хянах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) мал, амьтан нядлах, шулах, стандартын дагуу мах болон загасыг хэрчим болгон эвдэх, жижиглэн хуваах зэрэг үйлдэл хийх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- б) талх, нарийн боов болон гурилаар хийсэн бүтээгдэхүүнийг чанах, шарах, эсвэл өөр аргаар боловсруулах машин, тоног төхөөрөмжийг суурилуулах, тохируулах, ажиллуулах, хянах,
- в) шар айраг, дарс, спирт, архи, цуу, хөрөнгө болон бусад бүтээгдэхүүн хийх зорилгоор үр тариа, жимс, жимсгэнийг няцлах, холих, дарах, чанах, ферментжүүлэх, эсгэх зэрэг үйлдэл хийх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- г) жимсний чанамал, чихэр, бяслаг, боловсруулсан бяслаг, цөцгийн тос, ханд, гоймон, мөс, мөхөөлдөс, шоколад, цардуул, хүнсний тос зэргийг боловсруулах, үйлдвэрлэх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- д) хүнс боловсруулахад хэрэглэдэг хүнсний зүйл, шингэн баяжмал хийх хөргөх, халаах, хатаах, шарах, чанах, утах, ферментжүүлэх, ариутгах, хөлдөөх, ууршуулах зэрэг тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- е) спирт, төрөл бүрийн архи үйлдвэрлэх, түүхий эдийг хүлээж авах, хадгалах, үр тариаг цэвэрлэх, чихэрлэг түүхий эдийг ариутгах, няцлах, чихэржсэн чанамал бэлтгэх, уусмал бэлтгэх, ариутгах, хөрөнгө бэлтгэх, исгэх, нэрэх, хадгалах, савлах,
- ж) хүнсний зүйлийг холих, бутлах, зуурах, шахах, шүүх зэрэг аргаар ялгах, салгах шүүх тоног төхөөрөмж ажиллуулах,
- з) янжуур, навчин тамхи, бусад тамхин бүтээгдэхүүн хийх зорилгоор тамхины навч боловсруулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- нарийн боов боловсруулах машины операторч
- талх жигнэх машины операторч
- шоколад үйлдвэрлэх машины операторч
- янжуур тамхи үйлдвэрлэх машины операторч
- сүүн бүтээгдэхүүний машины операторч
- загас боловсруулах машины операторч
- мах боловсруулах машины операторч
- сүү боловсруулах машины операторч
- Жимс жимсгэнэ, хүнсний ногоо, самар боловсруулах машины операторч
- Шар айраг, дарс, спирт, архи, төрөл бүрийн ундаа үйлдвэрлэх машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8183 савлах, юүлэх, хаяглах машины операторч

**8161 ҮР ТАРИА БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОПЕРАТОРЧ/ АППАРАТЧИН**

Үр тариа тээрэмдэх, халуун ногоо нунтаглах машины операторч нь үр тариа, халуун ногоо, бусад бүтээгдэхүүнийг хүний болон амьтны хэрэгцээнд зориулан бутлах, цайруулах тоног төхөөрөмжийг ажиллуулж хянана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Гурил, хоол, амьтны тэжээл, будаа үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах
- б) Үр тариа болон халуун ногоог бутлахад хэрэглэдэг няцлагч машиныг ажиллуулах хянах
- в) Холбогдох үүрэг даалгаврыг биелүүлэх
- г) Бусад ажилчдыг хянах

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үр тариа боловсруулах үйлдвэрлэлийн операторч/ аппаратчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8160 Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн жигнэх, шарах машины операторч

8160 Талх барих, үйлдвэрлэх машины операторч

**БАГА БҮЛЭГ 817**  
**МОД БОЛОВСРУУЛАХ, ЦААС ҮЙЛДВЭРЛЭХ ТӨХӨӨРГИЙН**  
**ОПЕРАТОРЧ**

---

Мод боловсруулах, цаас үйлдвэрлэх төхөөргийн операторч нь мод хөрөөдөх, фанер тайрах, наамал банз хийх болон бусад аргаар модыг дахин боловсруулахад бэлтгэх, мод боловсруулах автомат тоног төхөөрөмжийг удирдах, хянах, ажиллуулах ажил эрхэлнэ. Мод бяцлах операторч нь мод бяцлах, үртэс болгох машин, тоног төхөөрөмжийг хянаж ажиллуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) чанар, стандарт хангасан банз гаргаж авах зорилгоор гуалин болон бусад модны хэмжээ, шинж чанарыг шинжлэх тоног төхөөрөмжөөр шалгах, хаягдал багатай, ашигтай байдлаар хэмжиж тайрах,
- б) гуалин, модны жижиг тайрдсыг фанер, үртэс, зомгол болгон боловсруулах зорилгоор ангилах, ялгах, хураах, туузан дамжлага, зорох машинд оруулах,
- в) цайруулах, холих, угаах болон үртэс, зомгол боловсруулах бусад машин, тоног төхөөрөмж ажиллуулах, хянах,
- г) машин, тоног төхөөрөмжийн доголдолыг засах, хэвийн ажиллагааг хангах зорилгоор заавар, журмын дагуу хянах самбар, багаж, төхөөрөмжийн заалтыг ажиглах,
- д) фанер тайрах, наамал банз боловсруулах, даралтаар шахах, дарах зэрэг үйлдэлтэй машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- е) наамал банз, фанер зэрэг боловсруулсан мод, модон бүтээгдэхүүнийг тээвэрлэх.

Энэ бага бүлгийн ажил мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8171 Модны зутан, цаас үйлдвэрлэх төхөөргийн операторч****8172 Мод боловсруулах төхөөргийн операторч****8171 МОДНЫ ЗУТАН, ЦААС ҮЙЛДВЭРЛЭХ ТӨХӨӨРГИЙН**  
**ОПЕРАТОРЧ**

Модны зутан, цаас үйлдвэрлэх төхөөргийн операторч нь модны зутан боловсруулах болон исгэх, целлюлоз материал боловсруулах үйл явц, үйлдвэрлэлийг хянах, тоног төхөөрөмжийг хянах, олон үйл ажиллагаатай машин, тоног төхөөрөмжийн ажиллагааг хариуцна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) модны зутан боловсруулах цаас, исгэх, целлюлоз боловсруулалтыг хяналтын өрөөний хянах самбараас хянах, үртэс, зомгол боловсруулах машин, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хянах, зохицуулах ,
- б) цайруулах, холих, угаах машин, тоног төхөөрөмж ба нэг болон хэд хэдэн исгэж боловсруулах дамжлага ажиллуулах,
- в) машин, тоног төхөөрөмжийн ажиллагааг эхлүүлэх, унтраах, машин, тоног төхөөрөмжийн доголдол, буруу ажиллагааг тогтоох зорилгоор тоног төхөөрөмж, машины ажиллагаа, тэдгээрийн заалт, хянах самбар, багаж болон хянах төхөөрөмжийг ажиглах,
- г) стандарт заавар, заалтын дагуу боловсруулалт явагдаж байгааг хянах, хангах,
- д) машин, тоног төхөөрөмжийн заалтад дүн шинжилгээ хийх, үйлдвэрлэлийн дээжид шалгалт, туршилт хийх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, машинд тохиргоо хийх,
- е) үйлдвэрлэлийн тайлан, мэдээ гаргах тэмдэглэл хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цаас, модны зутан үйлдвэрлэх машины операторч
- цаас, модны зутан цайруулах машины операторч
- цаас, модны зутан холих машины операторч
- цаас, модны зутан бэлдэх машины операторч
- цаас, модны зутан дахин боловсруулах машины операторч
- модны зутан, цаасны шахдас хийх машины удирдлагын операторч
- модны зутан, цаасны шахдасын техникч

**8172 МОД БОЛОВСРУУЛАХ ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Мод боловсруулах төхөөргийн операторч нь мод хөрөөдөх, фанер тайрах, наамал банз хийх, бусад аргаар дахин боловсруулах мод бэлтгэх, автомат тоног төхөөрөмжийг хянах, ажиллуулах, удирдах зэрэг ажил эрхэлнэ

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) сайн чанарын банз гаргаж авах зорилгоор гуалин модны хэмжээ, чанар бусад шинж чанарыг шинжлэх тоног төхөөрөмжөөр шалгах, хамгийн хаягдал багатай, ашигтай байдлаар хэмжиж, тайрах хэсгийг тодорхойлох,
- б) мод, гуалинг боловсруулах машинд оруулах систем, туузан дамжлагыг ажилуулах, хянах,
- в) гуалин, тайрдас, зах банз, хавтан, тайрдсыг хөрөөдөх, захлах, чанар стандарт хангасан төрөл бүрийн банз, прус бусад бүтээгдэхүүн хийх,

- г) удирдах өрөөний автомат удирдах хэрэгслээр мод боловсруулах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- д) фанер тайрах машин болон наамал банз боловсруулах шахах, дарах зэрэг үйлдэлтэй машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- е) хөрөөдөх машин, механизм, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, тосолгоо хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- дугуй хөрөөний операторч
- гуалин тайрах хөрөөний операторч
- наамал банз шахах машины операторч
- зорогч, харуулдагч машины операторч
- тайрагч машины операторч
- мод боловсруулах үйлдвэрийн хөрөөчин

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7521 мод боловсруулагч

**БАГА БҮЛЭГ 818**

**БУСАД СУУРИН МАШИН, ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

---

Энэ бага бүлэгт “Суурин, төхөөрөг, машин, механизмын операторч” гэсэн 81 дүгээр дэд бүлэгт ороогүй бусад суурин машин, тоног төхөөрөмжийн операторч багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

Шил, шаазан, керамик, тоосго шатаах зуух болон холбогдох машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, шил керамик эдлэлийг шатаах, хатууруулах, чимэглэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, уурын хөдөлгүүр, уурын тогоо, турбин, бусад нэмэлт тоноглол, машиныг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх, юүлэх, савлах, хаяглах зэрэг төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8181 Шил болон керамикийн зуухны операторч**

**8182 Уурын хөдөлгүүр, уурын тогооны операторч**

**8183 Савлах, юүлэх, хаягжуулах машины операторч**

**8189 Энэ ангилалд ороогүй суурин машин, төхөөрөг ажиллуулагч бусад операторч**

**8181 ШИЛ БОЛОН КЕРАМИКИЙН ЗУУХНЫ ОПЕРАТОРЧ**

Шил, керамикийн зуухны операторч нь шил, шаазан, керамик, тоосго шатаах зуух болон бусад машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, шил, керамик эдлэлийг шатаах, бэхжүүлэх, хатууруулах, пааландах, чимэглэх тоног төхөөрөмжийг ажиллуулах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) урьдчилан хольж бэлтгэсэн орцыг хайлуулж шил хийх зуух ажиллуулах, хянах,
- б) шилэн эдлэлийн гадаргууг хатууруулах, бэхжүүлэх, халуун, хүйтэн бодисоор шүрших тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- в) шилэн сав, шилэн аяга хийх зорилгоор хайлсан шилийг үлээх, хэвэнд шахах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- г) шаардлагатай хэвэнд оруулах зорилгоор хайлсан шилийг хэвэнд шахах тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- д) хайлмал шилийг элдэх, сунгах, хавтгай шил үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- е) хөвүүлж шил үйлдвэрлэх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- ж) шил, шилэн эдлэлийг өөлөх, цоолох, зүлгэх, ташуу тайрах чимэглэх, угаах, өнгөлөх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх,
- з) шавраар керамик эд зүйлийг хэвэнд шахах тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- и) шавар, усыг холих хагас шингэн зуурмаг бэлтгэх, зохих уян нөхцөлд оруулах замаар керамик бүтээгдэхүүн хийх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- к) шаазан, ваар, плита, тоосго шатаах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- л) паалан, бусад хэлбэрийн гадаргуу гаргах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- м) үлээх, шахах аргаар гэрэл дамжуулагч шилэн утас хийх машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- н) бэлэн бүтээгдэхүүнийг хагаралт, цууралт, өнгөний болон бусад гологдол байгаа эсэхийг шалгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- шил хийх зуухны операторч
- тоосго, плита хийх зуухны операторч
- ваар, шаазан хийх зуухны операторч
- шил үлээх машины операторч

- шавар зуурах машины операторч
- шил холих, зуурах машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

7315	шил үлээгч
7315	шил зүсэгч
7314	ваар, шавар эдлэл, тоосго хэвлэгч

**8182 УУРЫН ХӨДӨЛГҮҮР, УУРЫН ТОГООНЫ ОПЕРАТОРЧ**

Уурын хөдөлгүүр, уурын тогооны операторч нь үйлдвэр, барилга байгууламж болон хөдөлгөөнт машин, хөлгийг цахилгаан болон бусад хүчдэл, үйлчилгээгээр хангах зорилгоор төрөл бүрийн уурын хөдөлгүүр, уурын тогоо, турбин болон нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) барилга байгууламж, хий шахах төхөөрөмжийг цахилгаан, хүчдэл, уураар хангах зорилгоор шахуурга, даралт шахагч, агааржуулагч зэрэг уурын хөдөлгүүр, уурын тогоо, турбин болон нэмэлт тоног төхөөрөмжийг ажиллуулах, цэвэрлэх, тослох, хянах,
- б) тоног төхөөрөмжийн ажиллагааг хэвийн, эвдрэл, гэмтэл гаргахгүй байх зорилгоор хэмжих багаж, төхөөрөмжийн заалт, үзүүлэлтийг шалгах, дүн шинжилгээ хийх, жижиг засвар хийх,
- в) ус, химийн бодис, түлшний хэмжээ нь зохих түвшинд байгааг баталгаажуулах, ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгах, хянах,
- г) нүүрсээр ажилладаг зуухыг гараар галлах, хий, түлшээр галладаг зууханд автоматаар хий, түлш шахах шахуургыг ажиллуулах,
- д) уурын тогооны усны чанарыг шалгах, шаадлагатай арга хэмжээ авах, тохиргоо хийх болон зэврэлтээс хамгаалах химийн бодис түрхэх,
- е) уурын хөдөлгүүр, машин, механизмын хэмжигч багаж, төхөөрөмжийг шалгах, тэмдэглэл хөтлөх, илэрсэн зөрчил, доголдлыг мэдэгдэх, тайлагнах,
- ж) шахуурга, хавхлагын үйл ажиллагааг шалгах, засвар үйлчилгээ хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Уурын тогоо ажиллуулагч, операторч
- Уурын хөдөлгүүрийн операторч
- Галч
- Дулааны станцын операторч



**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3151 Усан онгоцны инженер

**8183 САВЛАХ, ЮҮЛЭХ, ХАЯГЛАХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Савлах, юүлэх, хаягжуулах машин, тоног төхөөрөмжийн операторч нь төрөл бүрийн бүтээгдэхүүнийг савлах, хаягжуулах болон төрөл бүрийн савыг бараа, бүтээгдэхүүнээр дүүргэх машин, механизмыг хянаж ажиллуулна .

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) боох, битүүмжлэх, савлах машиныг ажиллуулах хянах,
- б) шил, сав, лааз, хайрцаг, уут болон бусад савыг хүнс, ундаа, будаг, тос зэрэг бүтээгдэхүүнээр дүүргэх машиныг ажиллуулах хянах,
- в) наах, цавуудах болон бусад аргаар бүтээгдэхүүн, хайрцаг зэрэг төрөл бүрийн савыг хаягжуулах машиныг хянаж ажиллуулна.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Шил савлагч
- Хаягжуулах машины операторч
- Боох, баглах машины операторч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

9321 Гараар савлагч, баглагч

**8189 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ СУУРЬ МАШИН, ТӨХӨӨРӨГ АЖИЛЛУУЛАГЧ БУСАД ОПЕРАТОРЧ**

Энэ нэгж бүлэгт “Суурин төхөөрөг, машин, механизмын операторч” гэсэн 81 дүгээр дэд бүлэгт ороогүй бусад суурин машин, төхөөргийн операторч багтана.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- силикон хэсгүүд үйлдвэрлэх машины операторч
- кабель, олс залгах машины операторч

**ДЭД БҮЛЭГ 82  
УГСРАГЧ**

Угсрагч нь нарийн чанд дагаж мөрдөх ажиллабарын дарааллаар тоног төхөөрөмж болон дахин угсрах дэд хэсгүүдийг урьдчилан үйлдвэрлэсэн

эд анги, хэсгүүдийг нийлүүлж угсрах ажил эрхэлнэ. Бүтээгдэхүүнийг угсрах дамжлагын дагуу нэг ажилтнаас нөгөөд шилжүүлэн угсарч болно.

### **Гүйцэтгэх үүрэгт:**

Нарийн чанд дагаж мөрдөх ажиллабарын дагуу эд анги, хэсгүүдээс төрөл бүрийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж угсарна. \_

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

### **821 Угсрагч**

#### **БАГА БҮЛЭГ 821 УГСРАГЧ**

---

### **Гүйцэтгэх үүрэгт:**

- а) нарийн чанд дагаж мөрдөх ажилбарын дагуу эд анги, хэсгүүдээс төрөл бүрийн машин механизм, тоног төхөөрөмж угсрах,
- б) шаардлагатай эд анги, материал болон угсрах зааврыг тодорхойлох үүднээс ажилбарын дараалал, техник үзүүлэлт, зургийг судлах,
- в) өгөгдсөн хүснэгтийн дагуу ажилбар, үйлдвэрлэл, үйл ажиллагааны мэдээллийг тэмдэглэх,
- г) угсарч дууссан бүтээгдэхүүн, машин, механизм, эд анги, хэсгүүдийг шалгах, турших,
- д) цахилгаан болон бусад холболтыг хийж, шалгах,
- е) эвдрэл, доголдолтой, стандарт, шаардлага хангаагүй машин, механизм, бүтээгдэхүүн болон угсарсан эд анги, хэсгийг солих, хасах. \_

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **8211 Машин, механизм угсрагч**

#### **8212 Цахилгаан, цахим төхөөрөмж угсрагч**

#### **8219 Энэ ангилалд ороогүй бусад угсрагч**

### **8211 МАШИН, МЕХАНИЗМ УГСРАГЧ**

Машин, механизм угсрагч нь машин, механизм, хөдөлгүүр, хөдөлгүүр бүхий хөсөг, тээврийн хэрэгсэл, турбин, агаарын хөлөг зэрэг машин, механизмын эд анги, хэсгүүдийг нарийн чанд дагаж мөрдөх ажиллабарын дагуу угсрах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) дахин угсрах хэсгүүд, машин, механизм, хөдөлгүүр, хөдөлгүүр бүхий хөсөг, тээврийн хэрэгслийн эд анги, хэсгүүдийг угсарч суурилуулах,
- б) шаардлагатай эд анги, материал болон угсрах зааврыг тодорхойлох зорилгоор ажиллабарын дараалал, техник үзүүлэлт, зураг, зааварчлагыг судлах,
- в) өгөгдсөн хүснэгтийн дагуу ажиллабар, үйлдвэрлэл, үйл ажиллагааны мэдээллийг тэмдэглэх,
- г) угсарч дууссан машин, механизм эд анги, хэсгүүдийг шалгах, турших,
- д) эвдрэл, доголдолтой, стандарт шаардлага хангаагүй бүтээгдэхүүн болон угсарсан эд анги, хэсгийг солих хасах. \_

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хурдны хайрцаг угсрагч
- хөдөлгүүр угсрагч
- суудал угсрагч
- тээврийн хэрэгсэл (машин) угсрагч
- хөдөлгүүр суулгагч
- агаарын хөлөг угсрагч
- турбин угсрагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8219 унадаг дугуй угсрагч  
8212 цахилгаан, механик төхөөрөмж угсрагч

**8212 ЦАХИЛГААН, ЦАХИМ ТӨХӨӨРӨМЖ УГСРАГЧ**

Цахилгаан, цахим төхөөрөмж угсрагч нь цахилгаан, механик (хагас механик) болон цахим төхөөрөмжийн эд анги, хэсгүүдийг нарийн чанд дагаж мөрдөх ажиллабарын дагуу угсрах, өөрчлөх, сайжруулах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) эд анги, бүрэлдэхүүн хэсэг, цахилгаан, цахим төхөөрөмжийг гараар болон цахилгаан багаж хэрэгсэл ашиглан угсрах, дахин угсрах, бэхлэх, байршуулах, холбох ,
- б) угсрах ажиллагааны зааврыг тодорхойлох үүднээс ажиллабарын дараалал, техник үзүүлэлт, зураг төслийг судлах,
- в) өгөгдсөн хүснэгтийн дагуу ажилбар, үйлдвэрлэл, үйл ажиллагааны мэдээллийг тэмдэглэх,

- г) хувиргагч, хамгаалах утас, цахилгаан мотор, цахилгаан үүсгэгч зэрэг төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, цахилгаан ороомог, утас ороох машиныг ажиллуулах ,
- д) угсарч дууссан бүтээгдэхүүн, машин механизм, эд анги, хэсгүүдийг шалгах, турших, цахилгаан болон бусад холболтыг хийх, шалгах, эвдрэл, доголдолтой хэсэг, угсарсан эд ангийг солих, хасах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хамгаалалт арматур угсрагч
- цахим төхөөрөмж угсрагч
- цахилгаан төхөөрөмж угсрагч
- цахилгаан-механик төхөөрөмж угсрагч
- теле холбооны утас угсрагч
- телевизор угсрагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 7311 | нарийн хийцтэй багаж хэрэгсэл үйлдвэрлэгч |
| 7421 | цахим механикч                            |

**8219 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД УГСРАГЧ**

Энэ ангилалд ороогүй бусад угсрагч нь цахилгаан, цахим эд анги ороогүй төрөл бүрийн энгийн бүтээгдэхүүн, эд зүйлийг нарийн чанд дагаж мөрдөх ажиллабарын дагуу угсрах ажил эрхэлнэ.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Металл бүтээгдэхүүн угсрагч (механик бус)
- Хуванцар бүтээгдэхүүн угсрагч
- Резинэн бүтээгдэхүүн угсрагч
- Модон бүтээгдэхүүн угсрагч

---

## **ДЭД БҮЛЭГ 83 ЖОЛООЧ, ХӨДӨЛГӨӨНТ ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

---

**Гүйцэтгэх үүрэг:**

Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч нь галт тэрэг болон хөдөлгүүрт тээврийн хэрэгслийг жолоодох, үйлчилгээ хийх, үйлдвэрийн,

хөдөө аж ахуйн зориулалттай машин механизмыг жолоодох мөн зөөврийн машин, механизмыг ажиллуулах, тээврийн хэрэгсэлд ачаа, тээш ачих, буулгах, тээвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

Энэ дэд бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**831 Зүтгүүрийн инженерийн машинч, адилтгах ажилтан**

**832 Машин, фургон, мотоциклын жолооч**

**833 Хүнд даацын машин, автобусны жолооч**

**834 Зөөврийн төхөөрөмжийн операторч**

**835 Хөлөг онгоцны багийн гишүүн болон ажилтан**

### **831 ЗҮТГҮҮРИЙН МАШИНЧ, ТҮҮНД ХОЛБОГДОХ АЖИЛТАН**

**Гүйцэтгэх үүрэг:**

Зүтгүүрийн машинч болон холбогдох ажилтан нь зорчигч, ачаа тээш зөөвөрлөх зүтгүүр машиныг жолоодох, машинчид туслах, ачааны галт тэрэг жолоодох үед аюулгүй байдлыг хангах, галт тэрэгний хөдөлгөөнийг дохио өгөх журмаар хянах, төмөр замын талбайд хөдлөх бүрэлдэхүүнийг солих, галт тэрэг зохицуулах, уурхайн галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8311 Зүтгүүрийн машинч**

**8312 Төмөр замын бэхэлгээчин, дохиочин, шилжүүлэгч**

#### **8311 ЗҮТГҮҮРИЙН МАШИНЧ**

Зүтгүүрийн машинч нь зорчигч болон ачаа тээш тээвэрлэх, зүтгүүр жолоодох, жолоодоход машинчид туслах ажил гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) уурын, цахилгааны эсвэл дотоод шаталтат цахилгаан хөдөлгүүр бүхий зүтгүүрийн машиныг жолоодох, машинчид туслах,
- б) газар доогуур болон дээгүүр зорчих галт тэргийг жолоодох,
- в) газар доогуур болон ил уурхайгаас зөөвөр хийх зүтгүүр жолоодох,
- г) төмөр замын ослоос урьдчилан сэргийлэх, дохио заагч хэмжүүрүүдийг хянах,

- д) галт тэргийг цагийн хуваарийн дагуу явуулж, аюулгүй байдлыг хангах дүрэм, журмын дагуу галт тэрэгний баг, хөдөлгөөн зохицуулагч нартай холбоо, мэдээллийн сүлжээгээр харилцах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Зүтгүүрийн машинч
- Галт тэрэгний машинч

**Өөр газар ангилсан холбогдох бусад ажил, мэргэжил:**

**8331 Трамвайны жолооч**

**8312 ТӨМӨР ЗАМЫН БЭХЭЛГЭЭЧИН, ДОХИОЧИН, ШИЛЖҮҮЛЭГЧ**

Төмөр замын бэхэлгээчин, дохиочин, шилжүүлэгч нь явж байгаа зорчигч тээврийн ачааны галт тэргийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр замын хянах самбар, гэрэл дохионы тусламжтайгаар хөдөлгөөнийг хянах, уурхайн болон төмөр замын талбайд галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) явж буй зорчигч тээврийн болон ачааны галт тэргийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,
- б) хянах самбар, төмөр замын гэрэл дохионы тусламжтайгаар хянах, зохицуулах,
- в) захиалгын дагуу вагоныг замд тавих, татах, шилжүүлэх,
- г) гүний болон ил уурхайд зүтгүүрийн эсвэл татлагаар зөөвөр хийхийн тулд вагоныг замд тавих, хөдөлгөөнийг чиглэлийн замын дагуу шилжүүлэх,
- д) галт тэрэг хөдлөхөөс өмнө галт тэрэгний холбоо, мэдээллийн сүлжээний, тоног төхөөрөмж, агааржуулагч, халаагуур, бэхэлгээ болон бусад хэрэгслийн ажиллагааны бүрэн бүтэн байдлыг шалгах,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бэхэлгээчин (төмөр замын)
- Шилжүүлэгч (төмөр замын)
- Дохиочин (төмөр замын)

**БАГА БҮЛЭГ 832**

**МАШИН, ТЭРГЭНЦЭР, БҮХЭЭГТ ТЭРЭГ, МОТОЦИКЛИЙН ЖОЛООЧ**

Жолооч нь моторт дугуй, мотортой гурван дугуйт, хөнгөн тэрэг, бүхээгтэй автомашинаар зорчигч, материал, эд зүйлсийг зөөж тээвэрлэх ажлыг хийнэ.

Хийх ажлуудад ихэвчлэн моторт дугуй, мотортой гурван дугуйт, хөнгөн тэрэг, бүхээгтэй автомашинаар зорчигч, материал, эд зүйлсийг зөөж тээвэрлэх ажлууд орно.

Энэ бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8321 Мотоциклийн жолооч**

**8322 Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч**

**8321 МОТОЦИКЛИЙН ЖОЛООЧ**

Мотоциклийн жолооч нь хүн, бараа материал тээвэрлэх зориулалтын тоноглол бүхий мотоцикл, моторт гурван дугуйт жолоодох ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хүн, бараа материал тээвэрлэх зориулалтын тоноглол бүхий мотоцикл, моторт гурван дугуйт жолоодох,
- б) замын хөдөлгөөний дүрэм, тэмдгийг мөрдөх,
- в) тээврийн хэрэгслээ цэвэрлэх, засвар үйлчилгээ, жижиг засвар хийх,
- г) аялалын тэмдэглэл хөтлөх,
- д) мэдээ, мэдээлэл хүргэх,

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хүн тээвэрлэх зориулалт бүхий хөдөлгүүрт хөсгийн жолооч
- моторт гурван дугуйтын жолооч
- мотоциклын жолооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

9331 дугуй тэргэнцэр жолоодогч

**8322 МАШИН, ТАКСИ БОЛОН БҮХЭЭГТ ТЭРЭГНИЙ ЖОЛООЧ**

Машин, такси болон жижиг оврын бүхээгт тэрэгний жолооч нь зорчигч, бараа, бүтээгдэхүүн, шуудан тээвэрлэхээр машин, такси, жижиг оврын битүү тэрэг жолоодоно.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) машин, бага оврын битүү тэрэг, такси жолоодох, зорчигч тээвэрлэх,
- б) шуудан, бараа бүтээгдэхүүн хүргэх зорилгоор машин, бага оврын битүү тэрэг болон бага оврын ачааны машин жолоодох,
- в) зорчигчдын ачаа, тээшийг машинд ачиж буулгахад туслалцаа үзүүлэх,

- г) ачаа, тээврийн хөлс, төлбөр, хүргэсэн тухай баримт авах ,
- д) теле холбооны хэрэгсэл ашиглан өөрийн байрлал болон дараагийн ажил хүлээн авах боломжтой эсэхийг мэдэгдэх, төв удирдлагын зааварчилгаа удирдамжийг дагах,
- е) хамгийн зохимжтой замыг сонгох,
- ж) хөгжлийн бэрхшээлтэй иргэн, дэмжлэг шардлагатай зорчигчдод туслалца үзүүлэх(машинд суулгах, буулгахад туслах, үйлчлэх),
- з) хөгжлийн бэрхшээлтэй иргэн, дэмжлэг шардлагатай зорчигчдод дэмжлэг үзүүлэх тоноглол, төхөөрөмжийг ажиллуулах (машинд суулгах, буулгах).

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- машины жолооч
- таксины жолооч
- бага оврын бүхээгт тэрэгний жолооч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8331 автобусны жолооч
- 8332 хүнд даацын машины жолооч
- 8321 хүн тээвэрлэх зориулалт бүхий хөдөлгүүрт хөсгийн жолооч

### **БАГА БҮЛЭГ 833**

#### **ХҮНД ДААЦЫН АВТОМАШИН, АВТОБУСНЫ ЖОЛООЧ**

Хүнд даацын автомашин, автобусны жолооч нь ачаа бараа, бүтээгдэхүүн, түлш, ус зэрэг шингэн, хүнд материал болон хүн тээвэрлэх зорилгоор ачааны машин, хүнд даацын машин, автобус, бусад зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодно.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Бараа, бүтээгдэхүүн, шингэн, хүнд материал, шуудан, хүн тээвэрлэх зорилгоор ачааны машин, хүнд даацын машин, автобус, бусад хүн тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8331 Автобус, трамвай, троллейбусны жолооч**

**8332 Хүнд даацын машин, том тэрэгний жолооч**



### 8331 АВТОБУС, ТРАМВАЙ, ТРОЛЕЙБУСНЫ ЖОЛООЧ

Автобус, трамвай, троллейбусны жолооч нь зорчигч, шуудан болон ачаа тээвэрлэх зорилгоор автобус, трамвай болон троллейбус жолоодно.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) зорчигч, шуудан, ачаа барааг ойрын болон холын зайд тээвэрлэх зорилгоор автобус, троллейбус бусад хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл жолоодох,
- б) зорчигч тээвэрлэх гудамжны тээврийн хэрэгсэл жолоодох,
- в) зорчигчид суух, буух үед хаалга нээх, хаах,
- г) зорчигчийн ачаа бараа зөөхөд нь туслалцаа үзүүлэх,
- д) гэрэлтүүлэг, халаалт, агааржуулалт зэргийг удирдах, тохируулах,
- е) аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний дүрэм сахих,
- ж) тээврийн хөлс, төлбөр хураах, тасалбар байгаа эсэхийг нягтлах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Автобусны жолооч
- Трамвайны жолооч
- Хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгслийн жолооч

### 8332 ХҮНД ДААЦЫН МАШИН, ТОМ ТЭРЭГНИЙ ЖОЛООЧ

Хүнд даацын машин, том тэрэгний жолооч нь бараа, бүтээгдэхүүн, шингэн түлш, ус болон хүнд материалыг холын, ойрын зайд тээвэрлэх зорилгоор хөдөлгүүр бүхий хүнд даацын тээврийн хэрэгсэл жолоодоно.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) бараа, бүтээгдэхүүн, шингэн түлш, ус болон хүнд материалыг холын, ойрын зайд тээвэрлэх зорилгоор хүнд даацын машин, өөрөө буулгагч машин зэрэг хөдөлгүүр бүхий хүнд даацын тээврийн хэрэгслийг, чиргүүлтэй, чиргүүлгүй жолоодох,
- б) хамгийн зохимжтой замыг сонгох,
- в) гэмтэл, хорогдол, алдагдлаас сэргийлэх зорилгоор ачаа тээшийг бэхлэх, бүтээх,
- г) ачаа ачих, буулгах ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн өргөх, буулгах төхөөрөмж ажиллуулах,
- д) бага зэргийн гэмтэлийг засварлах болон хүнд гэмтэл, эвдрэлийн засварыг зохицуулах,
- е) даац тээвэрлэлтийн горим, хязгаарлалтанд нийцүүлэн ачааны жинг тааруулах, аюулгүй тээвэрлэлтийг хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хүнд даацын машины жолооч
- цемент зуурагч, тээвэрлэгч машины жолооч
- хүнд даацын тусгай машин (2-3 чиргүүл, трайлер)-ны жолооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8322 бага оврын битүү тэрэгний жолооч

**БАГА БҮЛЭГ 834****ЗӨӨВӨР ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

---

Зөөвөр төхөөргийн операторч нь газар шороо, чулуу болон бусад ижил төстэй материалыг бэлтгэх, ухах, зайлуулах, тараах болон хүнд зүйлийг өргөх тусгай зориулалтын хөдөлгүүртэй машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, чиглүүлэх, ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) төхөөрөг, машиныг ажиллуулахад бэлтгэх, суурилуулах,
- б) багаж, төхөөрөмжийн хурд, өндөр зэргийг тохируулах,
- в) хөдөлгөөнт төхөөрөг, машиныг жолоодох, ажиллуулах,
- г) мод, гуалин, чулуу, шороо зэрэг хүнд зүйл, материалыг өргөх, хураах, зайлуулах зорилгоор нэмэлт төхөөрөмж, багаж ажиллуулах,
- д) өргөх машин, хөдөлгөөнт болон суурин өргөгч цамхагийг барилгын, тээвэрлэлтийн, агуулахын үйл ажиллагаанд ашиглах, ажиллуулах, хянах,
- е) машин, механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, бага хэмжээний эвдрэл, гэмтлийг засах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8341 Зөөврийн ферм, ойн төхөөргийн операторч**

**8342 Газар, шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч**

**8343 Кранч, өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины операторч**

**8344 Бусад өргөгч төхөөрөмж ажиллуулагч**

**8341 ЗӨӨВРИЙН ФЕРМ, ОЙН ТӨХӨӨРГИЙН ОПЕРАТОРЧ**

Зөөврийн ферм, ойн төхөөргийн операторч нь хөдөө аж ахуй, цэцэрлэгийн болон ойн аж ахуйд ашигладаг тусгай зориулалтын хөдөлгүүртэй, хөдөлгөөнтэй, нэг болон түүнээс олон үйлдэлтэй машин, механизм, тоног төхөөрөмжийг жолоодох, чиглүүлэх, ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тариалангийн анжис, үр суулгагч, хадагч зэрэг трактороор чирдэг эсвэл өөрөө явагч тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- б) трактороор чирдэг эсвэл өөрөө явагч ойн болон тариалангийн хөрс цэвэрлэх, үр суулгах, хураах, суулгац мод зөөх, бусад ойн аж ахуйн тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) машин, тоног төхөөрөмжийг бэлтгэх, суурилуулах ,
- г) хадагч, суулгагч багаж, төхөөрөмжийн хурд, өндөр, гүнийг тохируулах,
- д) мод өргөх, оосорлох, тайрах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- е) мод, гуалинг ангилах, өргөх, хураах, зайлуулах болон тайрах, хэрчих зэрэг нэмэлт төхөөрөмж, багаж ажиллуулах,
- ж) тайрсан модыг боловсруулах машинд оруулах, холтосхуулах, мөчирлөх, гуалин бэлтгэх, ачааны машинд ачих болон нөөцөд хураах,
- з) машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийх, жижиг хэмжээний эвдрэлийг засах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хураагч, хадагч машины операторч
- гуалин бэлтгэх машины операторч
- мод тээвэрлэгчийн жолооч
- тракторын жолооч
- мод унагах машины жолооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8342      бульдозерийн операторч

**8342 ГАЗАР ШОРОО, ЗАМ ЗАСВАРЫН АЖИЛ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Газар шороо, зам засварын ажил, түүнтэй адилтгах машины операторч нь газар ухах, ангилах, тэгшлэх, нягтруулах ажлыг гүйцэтгэх машиныг ажиллуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) механик болон гидравлик ажиллагаатай шанагаар тоноглогдсон газар шорооны ажлын машинаар шороо, хад, элс, хайрга, бусад материалыг ухах, зайлуулах ажлыг гүйцэтгэх,
- б) бохир ус, ус зайлуулах, ус хангамж, тос, хий, бусад материалыг дамжуулах шугамын шуудууг ухах машиныг ажиллуулах,
- в) түрдэг хутгаар (металл хүнхэр хутгаар) тоноглогдсон машинаар шороо, элс, цас, бусад материалыг зөөх, шилжүүлэх ажлыг гүйцэтгэж, машины үйл ажиллагааг жолоодох,
- г) Усны ёроолоос лаг шавар, элс хайргыг гарган зайлуулах машиныг ажиллуулах,
- д) мод, бетон, ган гадасыг хөрсөнд шигтгэн суулгах машиныг ажиллуулах,
- е) замын, хучилт, ижил төстэй ажлын хучилтын үеийг нягтруулах, тэгшлэх ажлыг гүйцэтгэх машиныг ажиллуулах, замын хучилтын ажил бусад төстэй ажилд бетон, битум, давирхайг бэлтгэх, тараах, тэгшилж өнгөлөх машиныг ажиллуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- бульдозерчин
- эксковаторчин
- гадас суулгагч
- шороо индүүдэгч
- тракторч
- цас түрэгч машины жолооч

**8343 КРАНЧ, ӨРГӨГЧ ЦАМХАГ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ МАШИНЫ ОПЕРАТОРЧ**

Кранч, өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины операторч нь хөдөлгөөнт болон суурин кран бусад өргөх хэрэгслийг ажиллуулж, хянана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хөдөлгөөнт болон суурин краныг (сум, холбоосыг дээшлүүлж, доошлуулах замаар) ажиллуулан материал, тоног төхөөрөмжийг байрлуулах, өргөх, шилжүүлэх ажлыг гүйцэтгэх,
- б) барилгын талбай, зам болон уурхайд ажилтныг оруулах, гаргах, материалыг өргөх, буулгах тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- в) цанын зам /дүүжин зам/, бусад төстэй тоног төхөөрөмжийг ажиллуулах,

- г) ачаа бараа, зорчигчид, автомашин бүхий гаталга онгоц, ачааны усан онгоцыг богино гармаар гарахад татах тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- д) усан замын болон автозамын тээврийн хэрэгслийг өнгөрүүлэх зориулалтай салж, нийлдэг гүүрийн төхөөрөмжийг ажиллуулах,
- е) ус сорж зайлуулах тоног төхөөрөмжөөр тоногдосон краныг усан зам болон бусад газарт ажиллуулах,
- ж) завь, ачааны усан онгоцонд бэхэлсэн кранаар материал, тоног төхөөрөмжийг өргөх, шилжүүлэх, байрлуулах ажлыг гүйцэтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Өргөх кранч, операторч
- Хөдөлгөөнт өргөх краны операторч
- Цамхагт /байшин/ краны операторч

**8344 БУСАД ӨРГӨХ, ТАТАХ ТӨХӨӨРӨМЖИЙН ОПЕРАТОРЧ**

Өргөх, татах төхөөрөмжийн операторч нь бараа, бүтээгдэхүүн хураасан, өрсөн тавиурыг тээвэрлэх, өргөх, хураах, өргөх, татах машин болон түүнтэй адилтгах машиныг жолоодох, ажиллуулах, хянах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бараа бүтээгдэхүүн хураасан, өрсөн тавиурыг агуулах, үйлдвэр болон бусад байгууламжинд ачих, буулгах, тээвэрлэх, өргөх, татах, хураах өргөгч машин болон түүнтэй адилтгах машиныг жолоодох, ажиллуулах, хянах,
- б) өргөгч төхөөрөмжийг ачаатай ханз, тавиур, хайрцагны дор, дэргэд, дээгүүр болон эргэн тойронд нь байрлуулж бараа бүтээгдэхүүнийг заасан газарт хүргэх баталгааг хангах,
- в) тоног төхөөрөмжийн эвдрэл, элэгдлийг шалгах,
- г) машин, тоног төхөөрөмжийн өдөр тутмын засвар, үйлчилгээг хийх,
- д) хийсэн ажил, эвдрэл гэмтлийн талаар мэдээлэл, тэмдэглэлийг хөтлөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- сэрээт өргөгч машины жолооч

**БАГА БҮЛЭГ 835****УСАН ОНГОЦНЫ ТАВЦАНГИЙН БАГ, ТҮҮНД ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

---

Усан онгоцны тавцангийн баг, холбогдох бусад ажилтан нь өөрийн онгоц дээрхи ажил үүргийг гүйцэтгэхээс гадна ижил төстэй ажил, үүргийг өөр усан онгоц дээр мөн гүйцэтгэнэ.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**8350 Усан онгоцны тавцангийн багийн гишүүн, бусад ажилтан****8350 УСАН ОНГОЦНЫ ТАВЦАНГИЙН БАГИЙН ГИШҮҮН, БУСАД АЖИЛТАН**

Усан онгоцны тавцангийн багийн гишүүн бусад ажилтан нь өөрийн онгоц дээрхи ажил, үүргийг гүйцэтгэхээс гадна ижил төстэй ажил, үүргийг өөр усан онгоц дээр мөн гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) боомт зогсоолд орох, гарах үеэр харуулд гарах,
- б) дүрэм ззаврын дагуу усан онгоцыг жолоодох,
- в) олс, татлагыг татах, зангуу тавих тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- г) ачаа тээшний тоноглол, аврах ажиллагаа болон гал унтраах хэрэгслүүд зэрэг хөлөг онгоцны тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгэ хийх,
- д) шаардлагын дагуу хөлөг онгоцны давцан, их биеийг цэвэрлэх, зүлгэх, будах болон бусад засвар үйчилгээний ажил үүргийг гүйцэтгэх,
- е) хөдөлгөөнгүй тоноглол, хөдөлгөөнт араа, ачаа тээш зохицуулах, бусад тоноглолыг ажиллуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- бярвааз, гатлах онгоцны ажилтан
- татагч
- далайчин

## ҮНДСЭН БҮЛЭГ 9

### ЭНГИЙН АЖИЛ, МЭРГЭЖИЛ

---

Энгийн ажил эрхлэгч нь энэ үндсэн бүлэгт дурдсан өдөр тутмын, байнга давтагдах шинжтэй энгийн ажил, үүргийг гар багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэх бөгөөд голчилон биеийн хүчний ажил эрхэлнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) гэр, орон сууц, гал тогоо, зочид буудал, албан байр болон бусад барилга байгууламжийг цэвэрлэх, бараа бүтээгдэхүүн авах, энгийн, үндсэн өдөр тутмын засвар, үйлчилгээ хийх,
- б) машин болон цонх угаах,
- в) гал тогоо цэвэрлэх, хоол, хүнс бэлтгэх түүнтэй ижил төрлийн ажил, үүргийг гүйцэтгэх,
- г) захидал, шуудан, бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх, хүргэх,
- д) ачаа тээш зөөх, ачих, буулгах, тээвэрлэх,
- е) автомат худалдаа үйлчилгээний машиныг цэнэглэх, төрөл бүрийн тоолуурын заалтыг тэмдэглэх,
- ж) хог түүх, ангилах, гудамж талбай ижил төстэй газрыг цэвэрлэх, шүүрдэх,
- з) хөдөө аж ахуй, загас ба ан агнуурын чиглэлийн энгийн ажил үүргийг гүйцэтгэх, бараа, бүтээгдэхүүн ангилах, уурхай, барилга, үйлдвэрийн салбарт энгийн ажил үүргийг гүйцэтгэх,
- и) бараа бүтээгдэхүүнийг гараар баглах, боох болон тавиур дээр өрөх,
- к) гудамж, талбайн төрөл бүрийн үйлчилгээ, байгууламжийн цэвэрлэгээ хийх,
- л) зорчигч, ачаа, тээшийг хөл, гар жолоодлоготой дугуй, тэргэнцрээр тээвэрлэх,
- м) мал, амьтан хөллөсөн тэрэг жолоодох.

Энэ үндсэн бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах дэд бүлэгт ангилна:

- 91 Цэвэрлэгч, туслагч
- 92 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил
- 93 Уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил
- 94 Хүнс бэлтгэлийн туслах ажил
- 95 Гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил
- 96 Бусад энгийн ажил

## **ДЭД БҮЛЭГ 91 ЦЭВЭРЛЭГЧ, ТУСЛАГЧ**

---

Цэвэрлэгч, туслагч нь гэр, орон сууц, зочид буудал, албан байр, бусад барилга байгууламж, нисэх онгоц, галт тэрэг, автобус, трамвай бусад нийтийн тээврийн хэрэгсэлийн дотор тал, тавилга бусад тоноглолыг цэвэрлэх, түүнчлэн хувцас, цагаан хэрэглэлийг гараар угаах, индүүдэх зэрэг төрөл бүрийн энгийн ажил үүрэг гүйцэтгэнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Шал, тавилга болон бусад зүйлийг цэвэрлэх, шүүрдэх, тоос сорогчоор цэвэрлэх, арчих, угаах зүлгэх, өнгөлөх, өрөө тасалгааны хэрэглэлийг цэвэрлэх, засах, хоол, хүнс бэлтгэхэд туслах, гал тогоо цэвэрлэх, машин, шил цонх цэвэрлэх угаах, хувцас бусад зүйлийг гараар угаах, индүүдэх,

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**911 Гэр, зочид буудал, албан конторын цэвэрлэгээний ажил**

**912 Машин, цонх, хувцас угаалга болон бусад цэвэрлэгээний ажил**

## **БАГА БҮЛЭГ 911**

### **ГЭР, ЗОЧИД БУУДАЛ, АЛБАН КОНТОРЫН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ**

---

Гэр, зочид буудал, албан конторын цэвэрлэгээний ажилтан, туслагч нь гэр, орон байрны шал, тавилга болон бусад зүйлийг цэвэрлэх, арчих, угаах, зүлгэх, өнгөлөх, гэр ахуйн цагаан хэрэглэлийг угааж индүүдэх, хоол хүнс бусад зүйлийг бэлтгэх. Зочид буудал, албан контор бусад байгууламж болон нисэх онгоц, галт тэрэг, автобус, трамвай, бусад нийтийн тээврийн хэрэгсэлийн дотор талыг цэвэрлэх, ариун цэврийг сахих зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Зочид буудал, албан контор, бусад байгууламжийн ариун цэврийг сахих, шал, тавилга болон бусад зүйлийг гараар болон тоос сорогчоор цэвэрлэх, арчих, угаах зүлгэх, өнгөлөх, ор дэр засах, янзлах, алчуур, саван болон холбогдох зүйлийг тавих, хоол хүнс бэлтгэхэд туслах, аяга таваг угаах, цэвэрлэх, гал тогоо, угаалгын өрөө, бие засах газруудыг цэвэрлэх, ариутгах, үнэртүүлэгч цацах.



Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9111 Гэр ахуйн цэвэрлэгээний ажилтан, туслагч**

**9112 Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгээний ажилтан, туслагч**

### **9111 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛТАН, ТУСЛАГЧ**

Гэр ахуйн цэвэрлэгээний ажилтан, туслагч нь гэр ахуйн ариун цэврийг сахих, шал, тавилга болон бусад зүйлийг цэвэрлэх, гараар болон тоос сорогчоор цэвэрлэх, арчих, угаах зүлгэх, өнгөлөх болон гэр ахуйн цагаан хэрэглэлийг угааж индүүдэх, гэрийн хоол хүнс бэлтгэх, зөөх, түгээх ажлыг эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) шал, тавилга болон бусад зүйлийг цэвэрлэх, шүүрдэх, тоос сорогчоор цэвэрлэх, арчих, угаах зүлгэх, өнгөлөх болон цонх бусад зүйлийг угаах,
- б) ор дэрний хэрэглэл, хувцас бусад даавуун эдлэлийг угаах, индүүдэх,
- в) аяга таваг угаах,
- г) хоол хүнс бэлтгэх, хийх түгээх, зөөхөд туслах,
- д) хүнс болон бусад гэр ахуйн хэрэглээний зүйлийг худалдаж авах,
- е) гал тогоо, угаалгын өрөө, бие засах газрыг цэвэрлэх, ариутгах, үнэртүүлэгч цацах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- өдрийн ажилтан (гэр ахуйн)
- гэрийн цэвэрлэгч, үйлчлэгч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 9112 Зочид буудлын цэвэрлэгч, үйлчлэгч
- 5152 Гэрийн үйлчлэгч
- 9121 Гараар угаагч, индүүдэгч
- 9613 Гудамж цэвэрлэгч, шүүрдэгч

### **9112 ЗОЧИД БУУДАЛ, АЛБАН КОНТОР, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛТАН, ТУСЛАГЧ**

Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгээний ажилтан, туслагч нь төрөл бүрийн цэвэрлэгээний ажил гүйцэтгэх ба

зочид буудал, албан тасалгаа бусад байгууламж, нисэх онгоц, гал тэрэг, автобус, трамвай болон бусад нийтийн тээврийн хэрэгсэлийн дотор талыг цэвэрлэх, ариун цэврийг сахих ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нисэх онгоц, нийтийн тээврийн хэрэгсэл, галт тэрэг болон барилга байгууламжийн шал, тавилга, тоноглолыг арчих, тоос сорогчоор цэвэрлэх, угаах, зүлгэх,
- б) зочид буудлын ор, хэрэгсэлийг бэлтгэх, угаалгын өрөө цэвэрлэх, саван, алчуур болон холбоглох хэрэгсэлийг тавих,
- в) ресторан, нийтийн хоолны газрын гал тогоо цэвэрлэх, аяга таваг угаах зэрэг гал тогооны ерөнхий ажилд туслах,
- г) хог цэвэрлэх, хогийн сав султгах, төвлөрсөн цэгээс хог авах, хаях, устгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Нисэх онгоц цэвэрлэгч
- Зочид буудал цэвэрлэгч
- Албан тасалгаа цэвэрлэгч
- Угаалгын өрөө, бие засах газрын үйлчлэгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5153	Барилга, байшингийн үйлчилгээний ажилтан
9111	Гэрийн цэвэрлэгч
5152	Гэрийн үйлчлэгч
9613	Гудамж шүүрдэгч, цэвэрлэгч
9412	Гал тогооны туслах ажилтан
9412	Аяга таваг угаагч

**БАГА БҮЛЭГ 912**

**МАШИН, ЦОНХ, ХУВЦАС УГААЛГА БОЛОН БУСАД ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛТАН**

Машин, цонх, хувцас угаалга болон бусад цэвэрлэгээний ажилтан нь барилга, байгууламж, машин, тээврийн хэрэгслийн шил, цонх, үзмэрийн цонх, бусад гадаргууг цэвэрлэх ба ор дэрний хэрэглэл, хувцас, бусад даавуун эдлэлийг гараар угаах, индүүдэх, хуурай хими цэвэрлэгээ хийх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Машин, тээврийн хэрэгслийг угаах, цэвэрлэх, өнгөлөх, цонх болон бусад шилэн гадаргууг ус, цэвэрлэгээний бодисоор угаах, хатаах,

өнгөлөх, угаалгын газар болон бусад байгууламжинд ор дэрний хэрэглэл, хувцас, бусад даавуун эдлэлийг гараар угаах, индүүдэх, хуурай хими цэвэрлэгээний газар болон бусад байгууламжинд хувцас, даавуун, савхин эдлэл, бусад ижил төстэй эдлэлийг гараар угаах, химийн тусгай бодис ашиглах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9121 Гараар угаагч, индүүдэгч, хатаагч**

**9122 Тээврийн хэрэгслийн цэвэрлэгч**

**9123 Цонх цэвэрлэгч**

**9129 Бусад цэвэрлэгээний ажил эрхлэгч**

### **9121 ГАРААР УГААГЧ, ИНДҮҮДЭГЧ, ХАТААГЧ**

Гараар угаагч, индүүдэгч, хатаагч нь хувцас, ор дэрний болон бусад даавуун эдлэлийг гараар угаах, индүүдэх, хатаах, хуурай хими цэвэрлэгээ хийх, гүйцэтгэн боловсруулагч ба нэхмэл, сүлжмэл даавуун болон нэхээсгүй эдлэлээр үйлдвэрлэсэн хагас болон бэлэн бүтээгдэхүүнийг индүүдэх, гүйцэтгэн боловсруулах ажил эрхэлж гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) угаалгын газар, бусад байгууламжинд хувцас болон бусад даавуун эдлэлийг гараар угаах,
- б) бүх төрлийн хувцас, хэрэгсэл, техникийн ахуйн өргөн хэрэглээний хагас болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг уурын индүү, уурын өндөр даралттай прессеер уурлах, жигнэж индүүдэх, хатаах,
- в) зарим бүтээгдэхүүнийг тодорхой хэлбэрт оруулж хэлбэршүүлэх, цаваг, хатуулгыг наах, бүх төрлийн оёмол, нэхмэл бүтээгдэхүүнийг эцсийн гүйцэтгэн боловсруулалт хийх төхөөрөмжийг ажиллуулах, хянах,
- г) оёмол сүлжмэл бүтээгдэхүүнийг угаах, цайруулах, чанах, сэгсрэх, хатаах, агшаах, үрэх/элэгдүүлж сэмлэх/
- е) хуурай хими цэвэрлэгээний газар болон бусад байгууламжинд хувцас, даавуун, савхин эдлэл, бусад ижил төстэй эдлэлийг гараар угаах, химийн тусгай бодис ашиглах,
- ж) товч авах, хадах болон бусад жижиг засварыг хийх,
- з) эд зүйлийг тавиур дээр байрлуулах, өлгөх, тордох, түгээхэд бэлтгэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гараар хуурай хими цэвэрлэгээ хийгч

- гараар угаагч
- гараар индүүдэгч, хатаагч
- Бүх төрлийн хувцасны дамжлага дундын индүүчин /уурын гар болон пресс индүүгээр/
- Бүх төрлийн хувцасны эцсийн бэлэн бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулах индүүчин /уурын гар болон пресс, хэлбэржүүлэх пресс/
- Уурын индүүний операторч
- Өндөр даралттай уурын пресс машины операторч
- Уураар хэлбэр гаргаж хэвлэх машины операторч
- Цаваг, хатуулга наах машины операторч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 8157 | хуурай хими цэвэрлэгээний машины операторч |
| 8157 | индүүний машины операторч                  |
| 8157 | угаалгын машины операторч                  |

### **9122 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛТАН**

Тээврийн хэрэгсэл цэвэрлэгч нь машиныг угаах, цэвэрлэх, зүлгэх өнгөлөх ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) гараар болон гар ажиллагаатай угаах, өнгөлөх төхөөрөмж хэрэгслэл ашиглан машин бусад тээврийн хэрэгслийг угаах, цэвэрлэх, өнгөлөх,
- б) доторлогоо, бүрээс болон хивсэнцрийг тоос сорогчоор цэвэрлэх, хуурай хими цэвэрлэгээ хийх,
- в) машин, тээврийн хэрэгслийн гадаргуу болон доторлогооны толбо арилгах ба арилгах, цэвэрлэх бодис түрхэх,
- г) машины дугуй цэвэрлэх, дугуй өнгөлөх,
- д) машин, тээврийн хэрэгслийн цонх шилийг цэвэрлэх, угаах, өнгөлөх,
- е) машин, тээврийн хэрэгслийн дотор талыг цэвэрлэх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гараар машин угаагч
- нарийн цэвэрлэгээ, өнгөлгөө хийгч

### **9123 ЦОНХ ЦЭВЭРЛЭГЧ**

Цонх цэвэрлэгч нь цонх, шилэн хана бусад шилэн тоноглол, гадаргууг угаах, цэвэрлэх, өнгөлөх зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цонх болон шилэн хана, бусад гадаргууг ус болон цэвэрлэгээний бодисоор угаах, хатаах, өнгөлөх,
- б) шат, дүүжин сандал, тавцан, өргөгч тавцан бүхий машин, бусад тоноглол ашиглан өндөр, олон давхар бүхий байшин барилгын цонх, хана угаах, цэвэрлэх,
- в) шилэн гадаргууг угаах, өнгөлөхөд тохиромжтой багаж хэрэгсэл, бодисыг сонгох.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цонх, шилэн хана угаагч

**9129 БУСАД ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛТАН**

Бусад цэвэрлэгээний ажилтан нь хивс, хана, усан сан, хөргөх цамхаг болон бусад гадаргуу, материал, эд зүйлийг тусгай цэвэрлэгээний бодис, төхөөрөмж, хэрэгсэл ашиглан цэвэрлэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) цэвэрлэгээний машин болон нэмэлт тоноглол, хэрэгслэл ашиглан хивс, бүрмэл тавилга угаах, цэвэрлэх,
- б) хивсний толбо арилгах тусгай цэвэрлэгээний бодис ашиглах,
- в) хивсийг нэвчихгүй бодисоор арчих, цэвэрлэх, үнэртэн шингээх, гэрийн тэжээмэл амьтантай холбоотой тусгай арчилгаа хийх,
- г) чулуун хана, төмөр гадаргуу болон зурвасыг өндөр даралттай усаар цэвэрлэх, болон тусгай бодис ашиглах,
- д) усан сан, хөргөх цамхагны ус гадагшлуулах цооног бусад эд ангийг хурсан бохир, тогтоц, хог хаягдлаас цэвэрлэх зорилгоор ус сорох төхөөрөмж ашиглан цэвэрлэх. Химийн бодис, өндөр даралтын цэвэрлэгээний арга ашиглан ус болон шүүлтүүрээс хог, бичил биетийг устгах, арилгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хивс цэвэрлэгч
- хөргөх цамхаг цэвэрлэгч
- ханан дээрхи зураг, бичиг арилгагч
- усан сан цэвэрлэгч

## **ДЭД БҮЛЭГ 92**

### **ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС АГНУУРЫН АЖИЛ**

---

Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан нь ургац, үр тариа, мал аж ахуйн үйлдвэрлэл, цэцэрлэгт хүрээлэн, паркийн арчилгаа, тариалалт, ой модны ашиглалт, хамгаалалт, усны амьтан ургамлыг үржүүлэх тордох болон загас агнуурын үйл ажиллагааны энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг гүйцэтгэнэ.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

#### **921 Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан**

### **БАГА БҮЛЭГ 921**

#### **ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС АГНУУРЫН АЖИЛТАН**

---

#### **Гүйцэтгэх үүрэг:**

Гар багаж ашиглан ухах, малтах, мөр гаргах, ачих, буулгах, гараар болон гар багаж ашиглан ургац, тариалалтыг бордох, услах, зэрлэг ургамал зулгаах, гараар үр суулгах, тариалах, хураах, мал хариулах, тэжээх, услах, малын байр, хэвтэрийг цэвэр байлгах, мал амьтныг хянах, ажиглах тэдний байдлын талаар мэдээлэх, тайлагнах, тор бэлтгэх, тавих болон бусад загас агнуурын тоног төхөөрөмжийг бэлтгэх, ашиглах, бүтээгдэхүүнийг ангилах, зэрэглэл тогтоох, савлах, ачих, тоног төхөөрөмж, байшин барилга, усан онгоц, завь, тор, хашаанд засвар үйлчилгээ хийх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

#### **9211 Үр тарианы фермийн ажилтан**

#### **9212 Малын фермийн ажилтан**

#### **9213 Тариалан, мал хосолсон фермийн ажилтан**

#### **9214 Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжүүлэлтийн ажилтан**

#### **9215 Ойн аж ахуйн ажилтан**

#### **9216 Загасны болон усны аж ахуйн ажилтан (усны амьтан, ургамлын үржүүлэг, тариалалт)**

**Тайлбар:**

Хөдөө аж ахуйн хүрээний энгийн, байнга давтагддаг энгийн ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтан нь “Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан” гэсэн 921 дүгээр бага бүлэгт ангилагдах ба ус зөөх, мод түлш бэлтгэх үүрэгтэй ажилтан нь “Ус зөөгч, түлээ түүгч” гэсэн 9624 дүгээр нэгж бүлэгт ангилагдана.

**9211 ҮР ТАРИАНЫ ФЕРМИЙН АЖИЛТАН**

Үр тарианы фермийн ажилтан нь жимс, жимсгэнэ, самар, үр тариа, хүнсний ногоо тариалалт, үйлдвэрлэлийн энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) суваг шуудуу татах, тариалангийн газар ухах, малтах,
- б) бараа, бүтээгдэхүүн болон бусад материал ачих, буулгах,
- в) сүрэл, өвс болон бусад ижил төстэй материалыг бухалдах, овоолох,
- г) гараар болон гар багаж ашиглан үр тариа бордох, услах, зэрлэг ургамал зулгаах,
- д) жимс, жимсгэнэ, самар, хүнсний ногоо бусад үр тариаг гараар хураах,
- е) бүтээгдэхүүнийг ангилах, зэрэглэл тогтоох, баглах, савлах, ачих,
- ж) байшин барилга, тариалангийн болон малын хашаа, тор, хүлэмж барих, засвар хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- жимс түүгч
- хүнсний ногоо таригч, түүгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

6111	хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан(тариаланч, ногоочин)
9313	барилгын туслах ажилтан
9624	мод түлээ түүгч, хураагч
9624	Ус татагч, зөөгч

**9212 МАЛЫН ФЕРМИЙН АЖИЛТАН**

Малын фермийн ажилтан нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг гүйцэтгэнэ. Шувууны аж ахуйн болон зөгийн аж ахуйг оролцуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) суваг шуудуу татах болон газар ухах, малтах,
- б) бараа, бүтээгдэхүүн болон бусад материал ачих, буулгах,

- в) мал тэжээх, услах, малын байр, хэвтэрийг цэвэрлэх,
- г) мал амьтныг хянах, ажиглах тэдний байдлын талаар мэдээлэх, тайлагнах,
- д) мал амьтны эрүүл мэнд, хангамжийн ажилд туслах,
- е) мал маллах, хариулах, сүү сааль авах, үс, ноос, махны зориулалтаар малыг төрөлжүүлэн ангилах, салгах,
- ж) өндөг цуглуулах, инкубаторт байрлуулах,
- з) мал, амьтан тэжээх, хэвтэр бэлтгэх зорилгоор сүрэл, өвс болон бусад ижил төстэй материалыг бухалдах, овоолох, цуглуулах,
- и) бүтээгдэхүүнийг ангилах, зэрэглэл тогтоох, савлах, зөөх, ачих,
- к) тоног төхөөрөмж, байшин барилга, тор, хашаа, саравч барих засвар хийх.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Малын фермийн ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |  |
|------|--|
| 6121 | мал маллах, сүү цагаан идээ үйлдвэрлэгч        |
| 6121 | хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан (мал, амьтан) |
| 6121 | мал хариулагч, тууварчин                       |
| 9624 | түлээ түүгч                                    |
| 9624 | ус зөөгч                                       |

### **9213 МАЛ, ТАРИАЛАН ХОСОЛСОН ФЕРМИЙН АЖИЛТАН**

Мал, тариалан хосолсон фермийн ажилтан нь үр тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд тухайлбал, 9211, 9212 дугаар нэгж бүлэгт хамаарах энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг хослуулан гүйцэтгэнэ.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- фермийн ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 6121 | хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан(мал, амьтан) |
| 9624 | мод түлээ түүгч, хураагч                      |
| 9624 | ус татагч, зөөгч                              |

### **9214 ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН БОЛОН ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛТАН**

Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжүүлэлтийн ажилтан нь үр, нахиа, үндэс, суулгац, зулзаган мод зэргийг тарьж, арчилж, ургуулна. Мод, бут



сөөг, бургас, цэцэг, ургамлыг цэцэрглэгт хүрээлэн, парк, хувийн эдлэн, хүрээлэнд ургуулах, арчлах, тордох үйл ажиллагааны энгийн, байнга давтагддаг ажил үүргийг гүйцэтгэнэ. Түүнчлэн эрчимт аргаар хүнсний ногоо, цэцэг зэргийг ургуулах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) бараа, бүтээгдэхүүн болон бусад хангамж, тоног төхөөрөмжийг ачих, буулгах,
- б) гар багаж болон энгийн машин, төхөөрөмж ашиглан цэцэрлэг, талбайг бэлтгэх,
- в) цэцэг, зүлэг, бут сөөг, бургас, модыг тээвэрлэх, суулгах ажилд туслах,
- г) цэцэрлэгт хүрээлэнг услах, зэрлэг ургамал зулгаах, зүлэг арчлах,
- д) цэвэрлэх, хог хягдлыг зайлуулах,
- е) үр, үндэс, тайрдасыг үрслүүлэх, суулгахад туслах,
- ж) гараар услах, зэрлэг ургамал зуулгаах, хөрс сийрэгжүүлэх, бордоо хэрэглэх зэргээр тордох,
- з) борлуулалт, тээвэрлэлтэнд зориулан хураах, баглах,
- и) байшин барилга, тор, хашаа, хүлэмж, усалгааны тоног төхөөрөмжид засвар хийх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цэцэрлэгт хүрээлэнгийн ажилтан
- цэцэрлэгжүүлэлтийн ажилтан
- зүлэг шилжүүлэгч
- арчилгааны ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 6113 цэцэрлэгч
- 6113 цэцэрлэгжүүлэгч
- 9211 үр тарианы фермийн ажилтан

**9215 ОЙН АЖ АХУЙН АЖИЛТАН**

Ойн аж ахуйн ажилтан нь мод бэлтгэх, тайрах хөрөөдөх болон ойжуулах ба ойн суулгацын төрөл бүрийн энгийн, байнга давтагддаг ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мод суулгах, нүх ухах,
- б) гуалин болон бэлтгэсэн модыг хураах, ачих,
- в) газар доорхи ургацгыг цэвэрлэх, залуу модыг сийрэгжүүлэх,

- г) ойн түймрээс урьчилан сэргийлэх,
- д) модны орой, мөчир тайрах, гуалин бэлтгэх,
- е) мод тайрах, хөрөөдөх, мөчир тайрах гар болон гараар ажиллуулдаг хөрөө, машиныг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх,
- ж) үр цуглуулах, хураах, урсэлгээ, суулгац суулгах,
- з) ойн зам, байшин байгууламж, тоног төхөөрөмжийн бага зэргийн гэмтэл, эвдрэлийг засах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- сүхээр мөчирлэгч
- ойн аж ахуйн ажилтан
- мод суулгагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

6210 ойн аж ахуйн мэргэшсэн ажилтан

**9216 ЗАГАСНЫ БОЛОН УСНЫ АЖ АХУЙН АЖИЛТАН**

Загасны аж ахуйн ажилтан нь загас үржүүлэх, барих, усны ургамал ургуулах, хураах болон далайн хүнсний бүтээгдэхүүнийг эх газар дээр үржүүлэх, ургуулах, эрэг орчмын загас агнуурын, аж ахуйн үйл ажиллагааны энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гол, мөрний усны ёроол цэвэрлэх, үржүүлгийн загас хооллох,
- б) тор, шугам болон бусад загас агнуурын хэрэгсэл, онгоц, завины тоноглолыг бэлтгэх,
- в) загас болон бусад далайн амьтныг барих тоног төхөөрөмжийг ажиллуулах,
- г) барьсан загасыг ангилах, цэвэрлэх, савлах, баглах, давслах болон мөстэй саванд хадгалах, зооринд хийх,
- д) онгоцны тавцан, гадаргуу, зоорийг цэвэрлэх,
- е) зогсоолд орох үед зангуу, бэхэлгээний олсыг бэхлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- усны амьтан, ургамлын үржүүлэг, тариалалтын ажилтан
- загас агнуурын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

6221 загасны аж ахуйн фермч  
 6222 загас агнуурын хөлгийн ахмад  
 6222 Загасчин  
 6223 Загасны тор тавьдаг хөлгийн ахмад

---

**ДЭД БҮЛЭГ 93****УУРХАЙ, БАРИЛГА УГСРАЛТ, ҮЙЛДВЭР,  
ТЭЭВЭР, АГУУЛАХЫН АЖИЛ**

---

Уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажилтан нь уурхай, карьер, иргэний барилгын ажил болон тээвэрлэлт, хадгалалт, агуулахын үйл ажиллагааны энгийн, байнга давтагддаг гар ажиллагаатай ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Гар багаж, хэрэгсэл ашиглан нүх, суваг ухах, ухаж гаргасан материал, шороо, чулуу, хөрс зэргийг ялгах, тараах, материал тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ачаа, тээшийг гараар ангилах, ачих, буулгах, зөөх, хураах, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын байрыг цэвэрлэх, бараа, материал, бүтээгдэхүүнийг гараар баглах, савлах, задлах, тээшний сав, тавиурт өрөх, хураах, хүний гар, хөлийн хүчээр ажилладаг эсвэл амьтан хөллөсөн тэрэг, машин, механизм ажиллуулах.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**931 Уурхай, барилгын ажилтан**

**932 Үйлдвэрийн ажилтан**

**933 Тээвэр, агуулахын ажилтан**

**БАГА БҮЛЭГ 931****УУРХАЙ БОЛОН БАРИЛГЫН АЖИЛТАН**

---

Уул уурхай, барилгын ажилтан нь уурхай, карьер, иргэний барилгын энгийн, байнга давтагддаг гар ажиллагаатай ажил, үүргийг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Гар багаж, хэрэгсэл ашиглан нүх суваг ухах, ухаж гаргасан материал, шороо, чулуу, хөрс зэргийг ялгаж тараах, материал тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ачаа, тээшийг гараар ангилах, ачих, буулгах, зөөх, хураах, ажлын талбайд тээвэрлэх, тараах, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын байрыг цэвэрлэх, саад тотгорыг арилгах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9311 Уурхай, карьерийн ажилтан**

**9312 Иргэний барилгын ажилтан**

**9313 Барилга угсралтын туслах ажилтан**

### **9311 УУРХАЙ, КАРЬЕРИЙН АЖИЛТАН**

Уурхай, карьерийн ажилтан нь уурхай, карьерийн энгийн, байнга давтагддаг ажил, үүргийг гүйцэтгэнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) уурхайн тоног төхөөрөмж, машин, механизм, бусад зүйлийг суурилуулах, засвар үйлчилгээ хийхэд уурхайчин, карьерчинд туслах,
- б) уурхайн тоног төхөөрөмжийг угсрах, задлах, буулгах,
- в) ашиглаж дууссан, дахин ашиглахгүй нүх, цооногоос бэхэлгээ, тулгуурыг авах,
- г) уурхайн ажиллагаанд аюул, саад учруулах зүйлийг авах, зайлуулах,
- д) олборлолт дуусгавар болсоны дараа уурхайгаас хог хаягдал, тоног төхөөрөмж, машин, механизмыг холдуулах, чулуу, эрдэс хаягдлыг зайлуулах,
- е) тоног төхөөрөмж, машин, механизм, багаж, хэрэгсэл, замыг цэвэрлэх,
- ж) уурхайн ажилтны ашиглаж хэрэглэсэн багаж хэрэгсэл, материалыг ачих, буулгах, хураах, хадгалах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- нүүрсний дээж авагч
- уурхайн ажилтан
- карьерийн ажилтан

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                   |
|------|-----------------------------------|
| 8111 | уурхайн өрөмдөгч                  |
| 8111 | далд ба ил уурхайчин              |
| 8111 | уурхайн, машины операторч         |
| 8111 | карьерчин                         |
| 8113 | өрөмдөгч (гарын тос, хийн цооног) |
| 8113 | өрөмдөгч машины операторч         |

### 9312 ИРГЭНИЙ БАРИЛГЫН ТУСЛАХ АЖИЛТАН

Иргэний барилгын туслах ажилтан нь иргэний барилгын энгийн хялбар ажлыг өдөр тутам гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) буулгах барилгын талбайг цэвэрлэх, бусад энгийн ажлыг гүйцэтгэх,
- б) бетон, өргийн болон шавардлагын зуурмаг зэргийг зуурах, тараах,
- в) гар багажаар нүх, суваг, шуудууг ухах, дарах,
- г) Элс, хайрга, хөрс болон ижил төстэй материалыг тараах, барилгын талбайд ухсан шороо, барилгын материал, тоног төхөөрөмжийг ачих, буулгах, тээвэрлэх ажлыг түрдэг тэрэг, гар удирдлагатай тээврийн хэрэгслээр хийх,
- д) ажлын байрыг цэвэрлэх, саад тотгорыг зайлуулах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Барилгын туслах ажилтан
- Ачаа ачих, буулгах ажилтан

#### Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:

7112	Өрөгч
7111	Амины сууц барих ажилтан (барилгачин)
7119	Барилга буулгах ажилтан

### 9313 БАРИЛГА УГСРАЛТЫН ТУСЛАХ АЖИЛТАН

Барилга угсралтын туслах ажилтан нь барилга, зам, далан, ижил төстэй барилгын янз бүрийн энгийн хялбар ажлыг өдөр тутам гүйцэтгэнэ.

#### Гүйцэтгэх үүрэг:

- а) гар багажаар нүх, суваг, шуудууг ухах, дарах,
- б) хайрга бусад ижил төстэй материалыг тараах, овоолох,
- в) хийн нүдүүрээр хад чулуу, бетон, битум гадаргууг эвдлэх, тасдах,
- г) барилгын талбайд ухсан шороо, барилгын материал, тоног төхөөрөмжийг ачих, буулгах, тээвэрлэх ажлыг түрдэг тэрэг, гар удирдлагатай тээврийн хэрэгслээр хийх,
- д) барилга, байгууламж буулгах,
- е) ажлын байрыг цэвэрлэх, саад тотгорыг зайлуулах.

#### Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:

- Барилга угсралтын туслах ажилтан (иргэний барилга)
- Далан арчлах ажилтан

- Газар шорооны туслах ажилтан
- Барилга буулгах ажилтан

## **БАГА БҮЛЭГ 932 ҮЙЛДВЭРИЙН ТУСЛАХ АЖИЛТАН**

---

Үйлдвэрийн ажилтан нь үйлдвэрийн гараар гүйцэтгэдэг төрөл бүрийн ажиллабар гүйцэтгэх ба машин тоног төхөөрмжийн операторч, угсрагчид туслах, бараа бүтээгдэхүүнийг ангилах, эд ангийг гар аргаар угсрах ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Бараа материал, бүтээгдэхүүнийг гараар савлах, баглах, гараар шил, хайрцаг, уут болон бусад савыг бараа, бүтээгдэхүүнээр дүүргэх, бүтээгдэхүүн ба сав баглааг хаягжуулах, бараа, материал тоног төхөөрөмжийг ажлын байранд хүргэж өгөх, машин, механизм, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, гараар бүтээгдэхүүн, эд анги, хэсгүүдийг ангилах, гараар угсрах энгийн эд ангиудыг угсрах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **9321 Гараар савлагч, баглагч**

### **9329 Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн холбогдох бусад ажилтан**

### **9321 ГАРААР САВЛАГЧ, БАГЛАГЧ АЖИЛТАН**

Гараар савлагч, баглагч ажилтан нь бараа, бүтээгдэхүүн, материалыг гараар баглах, савлах, хаягжуулах зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) төрөл бүрийн бүтээгдэхүүн материалыг гараар жигнэх, боох, битүүмжлэх, савлах, баглах,
- б) шил, хайрцаг, уут болон бусад савыг гараар бараа, бүтээгдэхүүнээр дүүргэх, юүлэх,
- в) гараар бүтээгдэхүүн ба төрөл бүрийн сав баглааг хаягжуулах.

### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хаяглагч, шошгожуулагч(гараар)
- савлагч (гараар)
- боогч (гараар)

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8183	хаягжуулах машины операторч
8183	савлах машины операторч
8183	боох машины операторч

**9329 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ ҮЙЛДВЭРИЙН ХОЛБОГДОХ БУСАД АЖИЛТАН**

Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн бусад ажил эрхлэгч нь машин, механизмын операторч, угсрагчид туслах ба үйлдвэрлэлийн гар аргаар гүйцэтгэх төрөл бүрийн ажил, үүргийг эрхэлнэ. Үүнд бэлэн бүтээгдэхүүнийг савлах, хаягжуулах ажил хамаарахгүй.

**Гүйцэтгэх үүрэг:**

- бараа, материал тоног төхөөрөмжийг ажлын байранд хүргэж өгөх, бэлэн бүтээгдэхүүнийг авах,
- машин, тээврийн хэрэгсэлд ачаа бараа, бүтээгдэхүүнийг ачих, буулгах,
- машин, механизм, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, машины гацалт, бөглөрөлтийг арилгах,
- гар аргаар бүтээгдэхүүн, эд анги, хэсгүүдийг ангилах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- шил ангилагч
- үйлдвэрийн туслах ажилтан
- материал зохицуулагч
- хураагч, өрөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8212	угсрагч, цахилгаан тоног төхөөрөмж
8212	угсрагч, цахим тоног төхөөрөмж
8219	угсрагч, арьс, савхин бүтээгдэхүүний төхөөрөг ажиллуулагч
8219	угсрагч, резинэн бүтээгдэхүүний төхөөрөг ажиллуулагч
9321	гараар савлагч, баглагч

**БАГА БҮЛЭГ 933  
ТЭЭВЭР, АГУУЛАХЫН АЖИЛТАН**

Тээврийн болон агуулахын ачаа тээшийн ажилтан нь ачаа тээшийг дугуй ба ижил тэргэнцэр, бусад ачих зөөх төрлийн унаа, мал хөллөсөн тэрэг ба гараар зөөх ажлыг эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Ачаа тээш ба зорчигчийг дугуй, түүнтэй ижил төрлийн унаа, мал хөллөсөнтэргээрзөөх, ачааггараархүргэх, дэлгүүрийн лангуу, үзүүлэнгийн хэсгийн болон агуулахын барааг өрөх зэрэг ажил үүрэг гүйцэтгэнэ.

Энэхүү бага бүлэгт ангилсан ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9331 Дугуй, тэргэнцэр жолоодогч**

**9332 Тэрэгчин, ердийн хөсөгч**

**9333 Ачаа зөөгч**

**9334 Тавиур дүүргэгч**

**9331 ДУГУЙ, ТЭРГЭНЦЭР ЖОЛООДОГЧ**

Дугуй, тэргэнцэр жолоодогч нь унадаг дугуй түүнтэй ижил төстэй тээврийн хэрэгслээр зорчигч, эд барааг зөөж тээвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) Тээврийн хэрэгсэлд барааг ачих буулгах, зорчигчийг суух, буухад туслах,
- б) Замын хөдөлгөөний дүрмийн дагуу тээврийн хэрэгслийг өөрийн хүссэн чиглэлд жолоодох,
- в) Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах, элэгдэл, эвдрэлийг тогтоох,
- г) Тээврийн хэрэгсэлийг арчлах, жижиг засвар үйлчилгээг хийх, эд ангийг солих,
- д) Татвар хураамжийг тасалбарыг цуглуулах зэрэг болно.

**Энд ангилсан ажил мэргэжлийн жишээ:**

- Жолоодогч, дугуй, тэргэнцэр
- Жолоодогч, дугуй
- Жолоодогч, тэргэнцэр

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                                   |
|------|-----------------------------------|
| 3421 | Спортын унадаг дугуйгаар уралдагч |
| 8321 | Мотоциклийн жолооч                |

**9332 ТЭРЭГЧИН, ЕРДИЙН ХӨСӨГЧ**

Тэрэгчин, ердийн хөсөгч нь зорчигч, ачаа, бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх мал, амьтан хөлөглөсөн тэрэг, механизмыг жолоодох, хөтлөх ажил эрхэлнэ.



**Гүйцэтгэх үүрэг:**

- а) мал, амьтанд тоноглол бэхлэж, тэрэг, механизм холбох,
- б) бараа, бүтээгдэхүүнийг ачих, буулгах, зорчигчдод бууж суухад туслах,
- в) замын хөдөлгөөн болон хөдөлгөөний дүрмийн дагуу мал, амьтныг жолоодох, хөтлөх, чиглүүлэх,
- г) хөлс, төлбөр авах,
- д) уурхай, карьерийн машин, тэргийг татах, чирэх,
- е) тэрэг, машин, механизмын засвар үйлчилгээ жижиг засварыг хийх, эд, ангийг сольж суулгах,
- ж) мал, амьтаныг арчлах хооллох, тэжээх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Тэрэгчин, ердийн хөсөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3421 Уралдааны морь унагч

**9333 АЧАА ЗӨӨГЧ**

Ачаа зөөгч нь тавилга болон бусад гэр ахуйн зүйлийг зөөх, ачих, буулгах, савлах, агаарын хөлөг, усан онгоцны ачаа, тээшийг ачих, буулгах, төрөл бүрийн агуулахад хураах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ачаа, тээшийг нэг газраас нөгөөрүү зөөж тээвэрлэх, тавилга, машин, тоног төхөөрөмж, бараа, эд зүйлийг баглах, савлах,
- б) тээврийн төрөл бүрийн хэрэгслээс ачаа буулгах, зөөх, ачих,
- в) үр тариа, нүүрс, элс бусад ижил төстэй ачааг туузан дамжлага, хоолой зэрэг төхөөрөмж ашиглан ачих, буулгах,
- г) түлш, шингэн хий болон бусад шингэнийг ачааны усан онгоц болон бусад цистернд ачих, буулгах зориулалтын хоолой холбох,
- д) агуулах болон бусад ижил төстэй байгууламжинд бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх хураах,
- е) ачих, буулгах, зөөхөөс өмнө ачаа барааг ангилах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Ачаа ачигч, зөөгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

8343 Кран, өргөгч цамхагны операторч

8344 Өргөгч төхөөрөмж ажиллуулагч

**9334 ТАВИУР ДҮҮРГЭГЧ**

Тавиур дүүргэгч нь дэлгүүр, супермаркет болон бөөний худалдааны төвийн тавир, лангуу, үзүүлэнгийн тавцанд бараа, бүтээгдэхүүнийг дүүргэх, эмх цэгтэй өрөх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) тавиур, агуулах саванд бараа, бүтээгдэхүүнийг эмх цэгцтэй өрөх тавих ба овор ихтэй барааг газар байрлуулах,
- б) бараа бүтээгдэхүүнийг тавиур дээр тавих, дүүргэх ба хэрэглэх хугацаа нь хамгийн түрүүнд дуусах барааг эхний нүүрэнд тавих,
- в) хугацаа дууссан бараа бүтээгдэхүүнийг авах, зайлуулах,
- г) тусгай газар байрлах бараа, бүтээгдэхүүнийг зохих байранд нь тавьж эмх дарааллыг хангах,
- д) зарагдсан барааг тэмдэглэж, агуулахаас бараа авч тавиур дүүргэх,
- е) үйлчлүүлэгчдэд хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг агуулахаас авч ирэх,
- ж) үйлчлүүлэгч хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнээ сонгоход нь туслах,
- з) түгээгч, үйлдвэрлэгчээс ирсэн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах, онгойлгох, задлах, эвдрэл гэмтлийг шалгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Бараа бүтээгдэхүүн дүүргэгч, өрөгч
- Бараа бүтээгдэхүүн хүлээн авагч, хариуцагч

---

**ДЭД БҮЛЭГ 94****ХҮНС БЭЛТГЭЛИЙН ТУСЛАХ АЖИЛ**

---

Хүнс бэлтгэх туслах ажилтан нь төрөл бүрийн эцсийн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан хоол хүнс, ундааг бэлтгэж зааврын дагуу чанах, шарах, халаах, лангуу, ширээ сандал, цэвэрлэх, гал тогоо цэвэрлэх, аяга таваг угаах зэрэг ажил эрхэлнэ.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**941 Хүнс бэлтгэлийн туслах ажилтан**

## **БАГА БҮЛЭГ 941 ХҮНС БЭЛТГЭЛИЙН ТУСЛАХ АЖИЛТАН**

Хоол хүнс бэлтгэх туслах ажилтан нь төрөл бүрийн эцсийн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан хоол хүнс, ундааг бэлтгэж зааврын дагуу чанах, шарах, халаах, болгох, лангуу, ширээ сандал, цэвэрлэх, гал тогоо цэвэрлэх, аяга таваг угаах зэрэг ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Пицца, загас, өндөг, шарсан төмс, салат, кофе зэрэг эцэслэн болгосон хоол хүнс, ундааг бэлтгэх, чанах, шарах, халаах, болгох, хоол хүнсийг бэлтгэж угаах, хэрчих, хэмжих, холих, найруулах, шарах шүүгээ, зуух, шарагч зэрэг тоног төхөөрөмж ажиллуулах, хоол бэлтгэх, хийх газрыг цэвэрлэх, гал тогоо, үйлчилгээний газрыг цэвэрлэх, хэрэглэсэн аяга таваг, сав суулга зэргийг угаах, цэвэрлэх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **9411 Түргэн хоол бэлтгэх ажилтан**

### **9412 Гал тогооны туслах ажилтан**

## **9411 ТҮРГЭН ХООЛ БЭЛТГЭХ АЖИЛТАН**

Түргэн хоол бэлтгэгч нь цөөн орцтой, энгийн ажиллабар бүхий цөөн нэр төрлийн хоол, хүнс, ундааг бэлтгэх, бэлэн бүтээгдэхүүн болгох ажил эрхэлнэ. Тэд үйлчлүүлэгчээс захиалга авч үйлчилж болно.

### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) пицца, загас ба шарсан өндөг, төмс, салат, кофе зэрэг хялбар, энгийн эцэслэн бэлэн болгосон хоол хүнс, ундааг бэлтгэх, чанах, шарах, халаах, болгох,
- б) хоол хүнсийг чанах, болгоход бэлтгэж угаах, хэрчих, хэмжих, холих, найруулах ,
- в) шарах шүүгээ, шарагч, том хайруулын таваг зэрэг нэг дор их хэмжээгээр хоол хүнс бэлэн болгох тоног, төхөөрөмжийг ажиллуулах,
- г) урьдчилан бэлэн болгосон хоол хүнс, бэлэн бүтээгдэхүүнийг дахин халаах,
- д) хоол бэлтгэх, хоол хийх газар, гал тогоо, ресторанд хэрэглэсэн аяга таваг, сав суулгыг угаах цэвэрлэх,
- е) түргэн үйлчилгээ, авч явахад зориулагдан сав, баглаа, боодолд хоол хийж захиалгаар хүргэж өгөх, үйлчлэх,

- ж) түргэн хоолны орц захиалга хүлээн авах ,
- з) ажлын байрны ариун цэвэр, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангах,
- и) болгож бэлтгэсэн хоол хүнс нь чанар, захиалга, хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг магадлах, хангах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- түргэн хоол бэлтгэгч
- түргэн хоол захиалгын тогооч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

3434	Ахлах тогооч
5120	Тогооч
5246	Хүнсний үйлчилгээний лангууны ажилтан

**9412 ГАЛ ТОГООНЫ ТУСЛАХ АЖИЛТАН**

Гал тогооны туслагч нь ширээ сандал байрлуулж цэгцлэх, гал тогоо цэвэрлэх, аяга таваг угаах, хоолны орцыг бэлтгэх болон бусад ажилтанд хоол, ундаа хийх, үйлчлэхэд нь туслах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хоол бэлтгэх өрөө газрыг цэвэрлэх, гал тогоо болон үйлчилгээний танхим цэвэрлэх,
- б) тогоочид хоол хийхэд нь туслах хоолны материалыг угаах, хальс бусад зүйлээс салгах, арилгах, хэрчих, хэмжих, холих, найруулах ,
- в) үйлчилгээний танхимд аяга тавгийг байрлуулах,
- г) бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг зөөх, шалгах, жигнэх, хөргөгч болон бусад агуулах газар байрлуулах, хураах, хадгалах,
- д) гал тогоонд болон ресторанд хэрэглэсэн аяга таваг, сав суулгыг угаах цэвэрлэх, хураах,
- е) хоол хүнсийг халаах, шарах, бэлтгэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гараар аяга таваг угаагч
- гал тогооны туслах ажилтан
- гал тогооны бэлтгэгч
- гал тогооны зөөгч,
- гал тогооны эрхлэгч
- агуулахын ажилтан

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

5120	Тогооч
9411	Түргэн хоол бэлтгэгч

## **ДЭД БҮЛЭГ 95 ГУДАМЖИНД ХУДАЛДААЛАГЧ, ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ**

---

(5211 дэх нэгж бүлгийн тайлбарыг үзнэ үү)

Гудамжинд худалдаалагч, холбогдох үйлчилгээ хийгч нь гудамж талбай, олон нийтийн газарт бараа бүтээгдэхүүн худалдах (шууд хэрэглэх бэлэн хоол хүнс хамаарахгүй) ба төрөл бүрийн худалдаа, үйлчилгээ хийнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Дахин худалдах зорилгоор төрөл бүрийн бараа худалдаж авах, худалдах, зарах, худалдах зүйлээ тээвэрлэх, ачих буулгах, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай материал авах, гудамж талбайд явж байгаа хүмүүст өөрийн бараа, үйлчилгээг санал болгох, гутал цэвэрлэх, тослох, өнгөлөх, машины шил цонхыг цэвэрлэх, өнгөлөх, захиалгаар үйлчилгээ үзүүлэх, зогсоолд машин тавихад туслах, зогсоолд тавих үеэр харж хамгаалах, үнэгүй хэвлэл, зар сурталчилгааны материал тараах.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**951 Гудамжин дахь ажил, үйлчилгээний ажилтан**

**952 Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч (хоол, хүнсний зүйл хамаарахгүй)**

### **БАГА БҮЛЭГ 951**

#### **ГУДАМЖИН ДАХЬ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

---

Гудамжин дахь ажил, үйлчилгээ ажилтан нь гудамж талбай болон бусад олон нийтийн газар, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, гутал цэвэрлэх, тослох, өнгөлөх, үйлчлүүлэгчийн хүсэлт захиас биелүүлэх, гудамжинд байгаа машин техник, бараа эд зүйлийг эзэнтэй нь тохирч харж, хамгаалах зэрэг үйлчилгээг газар дээр нь үзүүлэх ажил эрхэлнэ.

### **Гүйцэтгэх үүрэг:**

Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай материал, түүхий эд сэлбэг, хэрэгслийг өөрөө худалдаж авах, гудамж талбайд явж байгаа хүмүүст өөрийн бараа, үйлчилгээг санал болгох, гутал цэвэрлэх, тослох, өнгөлөх, машины шил цонхыг цэвэрлэх, өнгөлөх, үйлчлүүлэгчийн хүсэлт, санал,

захиас, даалгаврыг биелүүлэх, зогсоолд машин тавихад туслах, зогсоолд тавих үеэр харж хамгаалах, үнэгүй хэвлэл, зар сурталчилгааны материал тараах.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжилийг дараах нэгж бүлэгт ангилна:

### **9510 Гудамжин дахь ажил, үйлчилгээний ажилтан**

#### **9510 ГУДАМЖИН ДАХЬ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Гудамжинд ажил, үйлчилгээ эрхлэгч, адилтгах үйлчилгээний бусад ажилтан нь гудамж талбай болон бусад олон нийтийн газар, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, гутал цэвэрлэх, тослох, өнгөлөх, үйлчлүүлэгчийн хүсэлт захиас биелүүлэх, гудамжинд байгаа машин техник, бараа эд зүйлийг эзэнтэй нь тохирч харж, хамгаалах зэрэг үйлчилгээг газар дээр нь үзүүлэх ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай материал, түүхий эд сэлбэг, хэрэгслийг өөрөө худалдаж авах,
- б) гудамж талбайд явж байгаа хүмүүст өөрийн бараа, үйлчилгээг санал болгох,
- в) гутал цэвэрлэх, тослох, өнгөлөх,
- г) машины шил цонхыг цэвэрлэх, өнгөлөх,
- д) үйлчлүүлэгчийн хүсэлт, санал, захиас, даалгаварыг биелүүлэх,
- е) зогсоолд машин тавихад туслах, зогсоолд тавих үеэр харж хамгаалах,
- ж) үнэгүй хэвлэл, зар сурталчилгааны материал тараах,
- з) тэр дороо төлбөр авах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Үйлчлүүлэгчийн хүсэлт, захиас биелүүлэгч
- Гутал тослогч, өнгөлөгч
- Машины цонх цэвэрлэгч, угаагч
- Машин харагч
- Зар, сурталчилгааны зурагт хуудас тараагч
- Үнэгүй хэвлэл, сонин тараагч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |   |
|------|---|
| 9621 | Зар, сурталчилгаа, сонин тараагч, илгээмж хүргэгч |
| 5245 | Үйлчилгээний станцын ажилтан                      |

**БАГА БҮЛЭГ 952  
ГУДАМЖИНД МУХЛАГ/ЛАНГУУ АЖИЛЛУУЛАГЧ  
(ХҮНСНИЙ ЗҮЙЛ ХАМААРАХГҮЙ)**

Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч нь гудамж талбай, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, буудал, кино театр зэрэг олон нийтийн газарт цөөн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн худалдах ажил эрхэлнэ (шууд хэрэглэх хоол хүнсийг хамруулахгүй).

**Гүйцэтгэх үүрэг:**

Дахин худалдах зорилгоор төрөл бүрийн зүйл худалдаж авах, хүлээн авах, эсвэл энгийн эд зүйл хийж борлуулах, худалдах эд зүйл, бараа бүтээгдэхүүнээ сагс, тор, тэргэнцэр, дугуй, гар тэрэг болон бусад машин, тээврийн хэрэгслээр зөөх, тээвэрлэх, ачих, буулгах, олон нийтийн газарт хүргэх, бараа бүтээгдэхүүнийг дэлгэн тавих, худалдан авагчийн анхаарлыг татах, гудамж талбайд явж байгаа хүмүүст өөрийн бараа, бүтээгдэхүүнээ санал болгох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9520 Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч (савлагаагүй, түргэн мууддаг хүнсний зүйл хамаарахгүй)****9520 ГУДАМЖИНД МУХЛАГ /ЛАНГУУ АЖИЛЛУУЛАГЧ  
(САВЛАГААГҮЙ, ТҮРГЭН МУУДДАГ ХҮНСНИЙ ЗҮЙЛ  
ХАМААРАХГҮЙ)**

Гудамжинд мухлаг/лангуу ажиллуулагч нь ихэвчлэн гудамж талбай, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, буудал, кино театр зэрэг олон нийтийн газарт цөөн төрлийн бараа, бүтээгдэхүүн түр байрлан худалдах ажил эрхэлнэ (шууд хэрэглэхэд зориулагдаагүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдаж болно).

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) дахин худалдах зорилгоор төрөл бүрийн зүйл худалдаж авах,
- б) худалдах зүйлийг сагс, тор, тэргэнцэр, дугуй, гар тэрэг болон бусад машин, тээврийн хэрэгслэлээр зөөх, тээвэрлэх, ачих буулгах, олон нийтийн газар хүргэх,
- в) бараа, бүтээгдэхүүнийг дэлгэн тавих, худалдан авагчдын анхаарлыг татах,

- г) гудамж талбайд явж байгаа хүмүүст өөрийн бараа, бүтээгдэхүүнээ санал болгох,  
 д) тэр дороо төлбөр авах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- гудамжны худалдаачин
- үүргийн худалдаачин
- сонин борлуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 5211 Мухлаг, захын худалдаачин  
 5212 Гудамжинд хоол хүнс худалдаалагч  
 9510 Үнэгүй сонин түгээгч

**Тайлбар:**

Шууд хэрэглэхэд зориулаагүй хоол хүнсний бүтээгдэхүүнийг (жимс, хүнсний ногоо, мах, сүүн бүтээгдэхүүн) гудамжинд болон захад худалдаалагч нь “Мухлаг, захад худалдаалагч” гэсэн 5211 дүгээр нэгж бүлэгт хамаарна. Шууд хэрэглэх хоол хүнсний зүйл худалдагч нь “Хүнсний үйлчилгээний лангууны ажилтан” гэсэн 5246 дугаар нэгж бүлэгт хамаарна.

Шууд хэрэглэх хоол хүнс, ундааны зүйлийг олон нийтийн газарт тэрэг тэргэнцрээс худалдагч нь “Гудамжинд хоол, хүнс худалдаалагч” гэсэн 5212 дугаар нэгж бүлэгт хамаарна. Шууд хэрэглэх хоол хүнсэнд хамаарахгүй, савлагаагүй, түргэн мууддаг хоол хүнсний зүйлд хамаарахгүй зүйлийг олон нийтийн газар, тэрэг тэргэнцрээс худалдагч нь “Гудамжинд мухлаг, лангуу ажиллуулагч” гэсэн 9520 дугаар нэгж бүлэгт хамаарна.

---

## **ДЭД БҮЛЭГ 96**

### **ХОГ ХАЯГДЛААР АЖИЛЛАГЧ, БУСАД ЭНГИЙН АЖИЛ**

---

Хог, хаягдлаар ажиллагч нь байшин, байгууламж, цэцэрлэг, гудамж болон бусад олон нийтийн газрын хог хаягдлын цуглуулах, цэвэрлэх, мод, түлш бэлтгэх, ус зөөх, хашаа, зам талбай, орон сууц, байгууллага, бусад байгууламжид түр ажил гүйцэтгэнэ.

Энэ дэд бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах бага бүлэгт ангилна:

**961 Хог хаягдлаар ажиллагч**

**962 Бусад энгийн ажил, үйлчилгээний ажилтан**



**БАГА БҮЛЭГ 961**  
**ХОГ ХАЯГДЛААР АЖИЛЛАГЧ**

Хог, хаягдлаар ажиллагч нь байшин байгууламж, цэцэрлэг, гудамж болон бусад олон нийтийн газрын хог хаягдлын цуглуулах ба гудамж талбайг цэвэр цэмцгэр байлгах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Хог хаягдал цуглуулах, ачих, буулгах, гудамж, цэцэрлэг болон бусад олон нийтийн газрыг шүүрдэх, цэвэрлэх, цаас, шил, хуванцар эсвэл хөнгөн цагаанаар хийсэн зүйл, хог хаягдлыг ялгах дахин боловсруулалтад өгөх.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9611 Хог хаягдлаар ажиллагч болон дахин боловсруулах хаягдал цуглуулагч**

**9612 Хог хаягдал ангилагч**

**9613 Хог шүүрдэгч, адилтгах ажил, үйлчилгээний ажилтан**

**9611 ХОГ ХАЯГДЛААР АЖИЛЛАГЧ БОЛОН ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАГЧ**

Хог хаягдлаар ажиллагч болон дахин боловсруулах хаягдал цуглуулагч нь байшин барилга, цэцэрлэг, гудамж болон бусад газраас хог хаягдал, дахин боловсруулах хаягдлыг цуглуулна.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хог хаягдал болон дахин боловсруулах материалыг цуглуулж хогны сав, дахин боловсруулалтын машинд ачих,
- б) хогны болон дахин боловсруулалтын машиныг жолоодох,
- в) хогийн савыг хог цуглуулах машинд султгах, авах,
- г) хог цуглуулах машинд хог ачих.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- хог хаягдал цуглуулагч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 8332 Хог цуглуулах машины жолооч

**9612 ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАГЧ**

Хог хаягдал ангилагч, ялгагч нь хог хаях газар, дахин боловсруулалтын байгууллага, эсвэл байшин, гудамж болон бусад олон нийтийн газраас дахин боловсруулж болох хаягдлыг тодорхойлж, цуглуулж, ангилах, ялгах ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) хог хаях газар, орон сууц, хувийн эдлэн, худалдаа үйлчилгээ, үйлдвэрийн болон олон нийтийн газруудаас дахин боловсруулж болох хаягдлыг хайж, цуглуулж, ялгах,
- б) картон, цаас, шил хуванцар, хөнгөн цагаан болон бусад дахин боловсруулах материалыг төрөлжүүлэн ялгах,
- в) дахин боловсруулах зүйлийг холбогдох сав, хэсэгт байрлуулж хадгалах, тээвэрлэх,
- г) засварлах ба дахин хэрэглэж болох тавилга, тоног төхөөрөмж, машин, механизм, эд ангиудыг тодорхойлон ялгах,
- д) дахин боловсруулах зүйлийг гараар болон хөдөлгүүргүй тээврийн хэрэгслээр тээвэрлэх,
- е) дахин боловсруулах, хэрэглэх зүйл, материалыг худалдах, тодорхой цэгт тушаах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хог хаягдал ангилагч, ялгагч
- хаягдал зүйл борлуулагч
- хог түүгч

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- 9611 Хог хаягдал цуглуулагч
- 9613 Хог шүүрдэгч

**9613 ХОГ ШҮҮРДЭГЧ, АДИЛТГАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Хог шүүрдэгч, адилтгах ажилтан нь гудамж талбай, цэцэрлэг, нисэх онгоцны буудал, вокзал, зогсоол болон бусад олон нийтийн газрыг шүүрдэж цэвэрлэх ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) гудамж талбай, цэцэрлэг, нисэх онгоцны буудал, вокзал, зогсоол болон бусад олон нийтийн газруудыг шүүрдэх, цэвэрлэх,
- б) цас арилгах, хусах,

- в) тоос гөвөгч ашиглан хивсний тоос гөвөх,
- г) хог, навч, цасыг зам талбай, газраас цэвэрлэх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- цэцэрлэгт хүрээлэн цэвэрлэгч
- гудамж цэвэрлэгч

**БАГА БҮЛЭГ 962  
БУСАД ЭНГИЙН АЖИЛ**

---

Бусад энгийн ажилтан нь шуудан, илгээмж, зарлага түгээх, хүргэх, автомат худалдааны машинаас мөнгө цуглуулах, бараа бүтэгдэхүүн нэмж хийх, тоолуур, хэмжүүрийг шалгах, бүртгэх, ус татах, мод түлээ хураах, татах, авто зогсоолын болон аливаа арга хэмжээний тасалбар түгээх, цуглуулах зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

Түлшний мод цавчих, хагалах, ус болон түлээ татах, шуудан, илгээмж болон бусад зүйлийг байгууллага дотор, хооронд, өөр бусад газарт түгээх, хүргэх, шуудан түгээгчийн үүрэг гүйцэтгэх, тасалбар, нэвтрэх талон зэргийг олгох, түгээх, авто зогсоолын төлбөрийг тооцох, автомат худалдааны машины бараа бүтээгдэхүүнийг нэмж, нөхөж хийх, мөнгийг цуглуулах, цахилгаан, хий, усны тоолуур зэрэг хэмжүүрийн мэдээллийг бүртгэх, хэрэглээг тооцох.

Энэ бага бүлэгт хамаарах ажил, мэргэжлийг дараах нэгж бүлэгт ангилна:

**9621 Илгээмж хүргэгч, зарлага, ачаа тээш зөөгч**

**9622 Өвөрмөц /түр ажил/ ажил эрхлэгч**

**9623 Тоолуурын заалт тэмдэглэгч, автомат худалдааны мөнгө хураагчаас мөнгө цуглуулагч, түүнд бараа, бүтээгдэхүүн нэмж хийгч**

**9624 Ус зөөгч, түлээ түүгч**

**9629 Энэ ангилалд ороогүй бусад энгийн ажил эрхлэгч**

**9621 ИЛГЭЭМЖ ХҮРГЭГЧ, ЗАРЛАГА, АЧАА ТЭЭШ ЗӨӨГЧ**

Илгээмж хүргэгч, зарлага, ачаа тээш зөөгч нь зарлага, илгээмж болон бусад зүйлийг байгууллага дотор, хооронд болон өөр бусад газар, өрх

гэрт түгээх, хүргэх, эсвэл зочид буудал, нисэх буудал, вокзал, зогсоолд ачаа тээш хүргэх зэрэг ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) илгээмж болон зарлага бусад зүйлийг байгууллага дотор, хооронд болон өрх гэрт, эсвэл өөр бусад газарт түгээх, хүргэх,
- б) шуудан түгээгчийн үүрэг гүйцэтгэх,
- в) худалдааны байгууллага, дэлгүүр, орон гэр болон бусад газраас төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн түгээх, хүргэх,
- г) зочид буудал, нисэх буудал, вокзал, зогсоолд ачаа тээш хүргэх, зөөх,
- д) ачаа бараа, тээшийг хүлээн авч, нэхэмжлэл баримтыг бөглөн хавсаргах,
- е) хамгийн дөт, үр дүнтэй зохистой замыг сонгох, төлөвлөх,
- ж) хүргэх, түгээх замын нөхцөл, тээврийн хэрэгслээс хамааруулан бараа, ачаа, эд зүйлийг ангилан ялгах.

#### **Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- сонин сэтгүүл хүргэгч
- зарлага хүргэгч
- ачаа тээш зөөгч

#### **Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- |      |                      |
|------|----------------------|
| 4412 | Шуудан зөөгч/илгээгч |
| 4412 | Шуудан ангилагч      |

### **9622 ӨВӨРМӨЦ/ТҮР АЖИЛ/ АЖИЛ ХИЙГЧ**

Өвөрмөц ажил хийгч нь байшин, барилга, байгууламжийг цэвэрлэх, будах, засвар үйлчилгээ хийх, төрөл бүрийн эд зүйл нөхөн сэргээх, засварлах зэрэг засвар, үйлчилгээний ажил эрхэлнэ.

#### **Гүйцэтгэх үүрэг:**

- а) хагарсан, гэмтсэн шил, толь, хаалга, хашаа саравч, тоноглол, ширээ сандал, тавиур, шүүгээ болон бусад эд зүйлийг байрлуулах, засварлах,
- б) гэрлийн чийдэн зэрэг эвдэрч гэмтсэн зүйлийг солих,
- в) хана, тааз, хашаа саравчны гадаргуу, дотор талыг будах, засах, тордох,
- г) хаалга, цонх суулгах, тааруулах,
- д) угаалгын цорго бусад зүйлийг засах, бэхлэх, тордох,
- е) шал болон шатны бариул бусад зүйлийг засах, шинэчлэх,

ж) хувийн байшин, гэр орон болон бусад байгууламжийг засах, шинэчлэх, зооринд хүнсний зүйл хураах, нүүрс, мод буулгах, хураах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- өвөрмөц ажилтай хүн
- гарын дүүтэй хүн
- зочид буудлын туслах ажилтан

### **9623 ТООЛУУРЫН ЗААЛТ ТЭМДЭГЛЭГЧ, ХУДАЛДААНЫ АВТОМАТ МӨНГӨ ХУРААГЧААС МӨНГӨ ЦУГЛУУЛАГЧ, ТҮҮНД БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН НЭМЖ ХИЙГЧ**

Тоолуурын заалт тэмдэглэгч, худалдааны автомат мөнгө хураагчаас мөнгө цуглуулагч, түүнд бараа, бүтээгдэхүүн нэмж хийгч нь худалдааны автомат машинд бараа, бүтээгдэхүүн нэмж хийх, мөнгө цуглуулах болон цахилгаан, хий, усны тоолуур, хэмжүүрийн заалт, мэдээллийг авах, унших зэрэг ажил эрхэлнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) худалдааны автомат машинд бараа бүтээгдэхүүн нэмж хийх, мөнгөний савнаас нь мөнгө цуглуулах,
- б) авто зогсоолын автомат болон бусад ижил төстэй зоосон мөнгө хуурагчаас мөнгө цуглуулах,
- в) хий, ус, цахилгааны тоолуур, хэмжүүрийн заалт, мэдээллийг тэмдэглэх, бүртгэх, хэрэглээг тооцох,
- г) түгээсэн бараа, бүтээгдэхүүн, хураасан, цуглуулсан мөнгөний тухай тэмдэглэл хөтлөх,
- д) тогтоосон зам, чиглэлийн дагуу явж тоолуур, хэмжүүрийн мэдээллийг авах,
- е) хэрэглээний заалт буруу, зөрчил гаргасан тохиолдолд тэмдэглэл хөтлөж, шалтгааныг тодорхойлох, холбогдох газарт мэдээлж шалгуулах,
- ж) тоолуур, хэмжүүрийн эвдрэл, гэмтэл, буруу болон зөвшөөрөлгүй холболт, лац, битүүмжлэл зэргийг шалгах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- мөнгө хураагч автомат машинаас мөнгө цуглуулагч
- тоолуурын заалт тэмдэглэгч

### **9624 УС ЗӨӨГЧ, ТҮЛЭЭ ТҮҮГЧ**

Ус зөөгч, түлээ түүгч нь ус, түлшний мод, түлээ бэлтгэж, цуглуулан гараар болон амьтан хөллөсөн хөсөг, тэргээр тээвэрлэнэ.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) ойгоос түлээ цуглуулах, тайрах ба зах дээр худалдах, эсвэл өөрийн хэрэгцээнд хэрэглэх,
- б) ойгоос хатсан, унасан мөчир, гишүү түүж цуглуулан, баглах,
- в) модны хатсан, өгөршсөн мөчир, бусад хэсгийг хөрөөдөх, сүхээр цавьчих,
- г) түүж цуглуулсан түлээ, модыг багцлаж боох, тээвэрлэх, зарах болон өөрийн хэрэгцээнд хэрэглэх,
- д) гэрорныхэрэгцээнд болон мод, ургамал, тариалануслах зориулалтаар худаг, гол, нуур, цөөрмөөс ус татах,
- е) худаг, гол, нуур, цөөрмөөс ус татаж төрөл бүрийн саванд дүүргэж ажил явагдаж байгаа газар болон гэр орон, үйлчлүүлэгчдэд хүргэж өгөх.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- түлээ түүгч
- ус зөөгч

**9629 ЭНЭ АНГИЛАЛД ОРООГҮЙ БУСАД ЭНГИЙН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН**

Энэ нэгж бүлэгт “Энгийн ажил, мэргэжил” гэсэн 9 дүгээр үндсэн бүлэгт ороогүй энгийн ажил үйлчилгээ хамаарна. Тухайлбал энэ бүлэгт манаач, сахиул, шатаах зуухны ажилтан, худгийн моторчин, уурын зуухны галч, ердийн галлагаатай орон сууц, барилгын галч, авто зогсоолын болон бусад орох тасалбар олгодог, цуглуулдаг ажилтан, хувцас өлгөх, тээш хадгалах, болон үзвэрийн үеэр үзэгчдэд битүүмжилсэн хүнсний болон эд зүйл худалдаалах, туслалцаа үзүүлэх зэрэг ажил эрхэлдэг хүмүүс багтана.

**Гүйцэтгэх үүрэг:**

- а) нэвтрэх, орох тасалбар худалдах, эсвэл тасалбар цуглуулж авах,
- б) тасалбар үнэн зөв эсэхийг өнгө, огноо зэргээр шалгаж үзэх,
- в) ослын үеэд үзэгчдэд гарц, гарах хаалгыг заах, туслах бусад зааварчилгаа өгөх,
- г) угаалгын болон амралтын өрөө, утас холбоо зэргийн байрлалыг зааж өгөх, туслах,
- д) машиныг зогсоолд тавихад зааварчилгаа өгөх, машины гэмтэл, хулгай зэргээс сэргийлэх зорилгоор зогсоолын газарт эргүүл хийх,
- е) эд, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хараж хамгаалах, халдлагад өртөх үед зааварчлагын дагуу ажиллах, холбогдох арга хэмжээ авах,
- ж) зогсоолын төлбөрийг тооцоолох, төлбөрийг үйлчлүүлэгчээс хураах,

- з) биеийн тамирын заал, нийтийн халуун усанд орох газар зэрэг үйлчилгээний газрын хувцас солих өрөө, хадгалах хайрцаг, хувцасны сав зэргийг үйлчлүүлэгчид зааж өгөх, хуваарилах,
- и) үзмэрийн үеэр үзэгчдэд битүүмжилсэн сав, баглаа, боодол бүхий хүнсний болон эд зүйлийг худалдаалах,
- к) шаардлагатай үед худгийн мотор асаах, ус юүлэх, нүүрс, мод, бусад түлш татах, бэлтгэх, зуух галлах, үнс зайлуулах.

**Энд ангилсан ажил, мэргэжлийн жишээ:**

- Хаалгач
- Авто зогсоолын ажилтан
- Үзэсгэлэн яармагийн ажилтан
- Хувцасны өрөө, өлгүүрийн ажилтан
- Тасалбар хураагч, хүнсний зүйл худалдаалагч
- Пүүлэгч
- Худгийн моторчин
- Галч
- Манаач, сахиул г.м

**Өөр газар ангилсан холбогдох зарим ажил, мэргэжил:**

- Автозогсоолын үйлчлэгч

## ҮНДСЭН БҮЛЭГ 0

### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЖИЛ, МЭРГЭЖИЛ

---

